

Урлан

Урианханы хөх чоно
Дамдины ПҮРЭВ

ЧҮНЧИГНОРОВ

РОМАН



Чүнчигноров
Зохиолч: Д. Пүрэв
Редактор: Я. Отгон, Ж. Бүжин

ISBN: 978-99962-2-730-1

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Ном дор мөргөмүй

Номын цагаан буяны садан эрхэм уншигч таны ариун мутар, тунгалаг мэлмий, гэгээн оюунд тань найм дахь роман “Чүнчигноров” – оо өргөн барьж байгаадаа баяртай байна. Хөх морин жилдээ хөх Монголынхоо хөх ухааныг магтан дуулж буйдаа ихэд билэгшээнэ.

Хөх гэдэг нь хэдийвээр өнгийг илэрхийлж байгаа ч гүн утга мөн чанартаа “Тэнгэрлэг, Хийморлиг” хэмээх үлэмжийн санааг агуулж байдаг. Мөн “Чүнчигноров” гэж нэрлэхийн учир гэвэл энэ нь эрдэнэсийн цуглуулга, эрдэнийн хаан чулуу билээ. Тиймээс Монгол эх орон минь энэ ертөнцийн, монгол хөх ухаан минь хүн төрөлхтөний эрхэм эрдэнэ хэмээн зүйрлэв.

Хан хурмаст хатан дэлхийн

Хаан шувуу хангарьд билээ

Хамаг эрдэнийн чулуун дотроос

Хаан эрдэнэ Чүнчигноров билээ

Эгээрлийн орчлонгийн эргэх хүрдний

Энгэр биед тэгш завилсан

Эх орон миний нутаг

Энэ ертөнцийн Чүнчигноров билээ

Оюун билгийн оройд гэрэлтэй

Судар шастирийн хоймор заларсан

Хөх монголын суу ухаан

Хүмүүн төрөлхтөний Чүнчигноров билээ гэж дуулав.

Хүн төрөлхтөн мартаж болохгүй байнга санаж сэрж явах ёстой нэгэн их ухааныг сануулахыг зорьлоо. Энэ бол нүүдэлчдийн соёл иргэншил, Монгол хүний хөх ухааныг хэлж буй хэрэг. Өвөг дээдсийн энэ хөх ухааныг бидний монголчууд өндөрт өргөж авч явах ёстой. Тодотговол:

Монгол хүн Мөнх тэнгэр, Этүгэн эх, газар дэлхийтэйгээ арга билгийн сургаал ёсоор уран нарийн ухаанаар холбогдон билиг чанарт нь нэвтэрч хүч тамирыг нь ашиглан амьдрал ахуйдаа хэрэглэн зөв сайхан аж төрж байсан аугаа их ухааныг хэлж байгаа юм.

Уг романд нутгийнхаа олон түмэнд “Мэргэн” гэж алдаршсан эгэл жирийн малчин Сагад нь өвөг дээдсийнхээ хөх ухааныг өвлөн авч тэнгэрийн бичээс мэдээллийг уншиж газрын

зурлагыг шинжлэн магадлаж билгийн нууцад нь нэвтэрч амьдрал ахуйдаа бодитойгоор хэрэглэж байгаа тухай өгүүлнэ.

Аливаа юмс бүхэнд тэгш орших үнэмлэхүй чанар болох хүний оюун ухааны дээд түвшингийн их цагаан тамирын эрчим хүч гайхамшигтай ид шидийн нууцаар эрдэнийн бумба энэ нутагт залаастай байгаа тухай түүний эргэн тойронд амьдарч буй хүмүүсийн үзэл бодол үйл мөрийг олон талаас нь бичихийг хичээв.

Төрсөн нутгийнхаа эрдэнэт газар шороо, уул ус, ургамал, амьтан, зон олных нь эрдэм ухааныг нь уран сэтгэмж чөлөөт сэтгэлгээгээр зурагласан болно.

Эл роман нь Монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн давтагдашгүй гайхамшигт хөх ухааны зарим нэгийг сануулах төдий хүүрнэв.

Мэргэн уншигч таны гэгээн мэлмийд тань толилуулж оюун билэгт тань шүүлгэхээр хүргэж байна. Сайн санааны үзүүрт сүү хэмээдэг билээ. Таныг номын цагаан буян ивээх болтугай.

МЗЭ-ийн шагналт, зохиолч

Дамдины Пүрэв

Нэг

Арван зургадугаар жарны гал морин жилийн зуны дунд модон морин сарын шинийн хорин гурван буюу мянга есөн зуун далан зургаан оны долоон сарын арван нэгний өдөр билээ.

Нар Улаан хайрханы зүүн биеэр уураг сүүн туяагаа цацсаар аажимхан өнгийж бүхнийг тольдсоноо ямар нэгэн сайн сайхан учралд яарах мэт түргэнээр мандан хөөрөв.

Тэнгэрт бүртийх ч үүлгүй цэлмэг байх учир бие биедээ ууссан хөх цэнхэр өнгөөр цэлийнэ. Сумын төв буйдхан ч энэ өглөө нарны туяатай сүлэлдэн аргалын цэнхэр утаа айл бүрээс зэрэг шахам суунаглана.

Хөгшид хүүхэд багачуудгүй бие хөнгөн сэтгэл өөдрөг байгаа нь жилдээ нэг тохиодог улсын баяр наадам, сумын гучин жилийн ойн эхний өдрийн өглөө учир ийнхүү баяр баясгалан дэлгэрч байгаль дэлхий таалж байгаа нь энэ билээ.

Сумын төв байрласан энэ газрыг Баян голын эх гэдэг. Энэ хонхор бас ч үгүй баян бүрд гэлтэй бахархам сайхан үзэсгэлэнтэй. Сумын төв дундуур Нарийны гол хөг эгшиг аялгуулан урсана. Бороо хур элбэгтэй үед үерлэн хүн малын хөлийг хорьж багагүй сандаргадаг байхад хүүхэд багачууд баярлан хөөрч хөвөө захаар нь хөл нүцгэн өөдөө уруугаа гүйлдэн тоглож хөх чулууг нь өшиглөснөө эс тоон наадна. Хөгшид настангуудаа хүндэтгэн хүдэр чийрэг залуус нь үүрч өргөн хөл нүцэглэн гатална. Хөөрүү зарим нэг нь үсэрч харайн дунд нь унаж өмд гутлаа норгон инээдэм болно. Нарийныхаа голыг магтан

Нарийны голын ус нь хөө

Үерлээд л байна уу даа

Насан багын түүнтэйгээ хөө

Үерхээд л байна уу даа

гэж ардын дууны аялгуугаар алиалж дуулах нэг нь ч бий.

Сумын төвийн зүүн биед нь Баян голын булгийн эх болох олон булаг оргилно. Булгийн эх нь тэр чигээрээ өргөн ногоон ширэг зулагдан богино шилбэтэй шар, цагаан цэцэг, таван салаа, зурман сүүл зэрэг навч цэцэгсээр чимэн гоёмсоглоно.

Энэхүү өргөн ногоон ширэгийг эмжин дэрсэн шугуй шуугин зөөлөн салхинд бөхөлзөн халиурна. Олон булгийнхаа эх, өргөн ногоон ширэгээ хамгаалан зэр зэвсэг агссан цэрэг дайчид аятай өндрөөс өндөр ургасан дэрсэн шугуйд тугал бяруу төөрч будилна. Морьтой хүний зөвхөн толгой нь цухуйх төдий гээд бодоход аргагүй л баян бүрдийн бас нэг бахархал мөн билээ.

Гэтэл төвийн баруун талыг нь Булангийн булаг хэмээн үзэсгэлэнт баян бүрдийг нэрлэдэг. Өндөр өндөр хөх мөргө, товгороор хүрээлэгдсэн гарын алга шиг хонхорт таван булаг оргилон

дундаа хоёр хэсэг цөөрөм мэлтэгнэн тогтсон нь сумын төвийн мэлмий гэлтэй. Энэ хонхор хөлөөрөө задгайрч хоёр цөөрмөөс хальсан ус нь горхилон урссаар майхан толгойн булгийн устай ханьсан нийлж Баян голд цутган холын хол Алаг нуурыг зорино. Булангийн булгийн дэрсэн ойд шургасан малыг ялангуяа бог малыг хоёр гурван өдөр эрэл хайгуул хийж байж л сая нэг халуун чихнээс нь атгаж авна.

Энэ хонхорт булаг цөөрмүүдийнхээ хооронд гурван том ширгэн доvon толгодтой. Түүний ёроолоос заримдаа хоёроос гурван метр ус дээшээ оргилон олгойдож Булангийн баян бүрдэд үзэмж нэмнэ.

Энэ ховорхон гайхамшигт үзэгдлийг үзсэн хүүхэд багачууд хөөрөн баярлан сэтгэлдээ дэвэрч байхад настангууд алгаа дэлгэн бэлэгшээж дотроо залбирч идээ будааныхаа дээжийг лус савдагтаа өргөж энэ зун дэлхий дэлэгнэж өвөлдөө өнөтэй болох нь хэмээн шинжинэ.

Булангийн баян бүрдийн өлмийг тулсан нэгэн гоёмсог бага уул байна. Энэ уулыг нутгийнхан Майхан толгой гэнэ. Майхан хэлбэртэй энэ уулыг тойроод долоон булаг буцалж буй тогоотой цай мэт оргилно. Эрт дээр үед нэгэн өвгөн шинжээч эрхэм энэ долоон булаг дээр долоо хоносон гэдэг. Тэр шинжээч

Сар бүрийн шинийн арван тавны гүн шөнийн үед долоон булаг тус бүрээс эгшиг эгшиглэн нийлэлдэн нэг аялгуу болон уянгалдаг юм байна.

Тэр уянгат аялгуу эгшигийг сонссон бүхний бие сэтгэл ариусаж насан хутгийг олох болно гэж айлдсан юм гэнэ лээ гэдэг домог амнаас ам дамжин яригддаг түүхтэй. Тэр өвгөн шинжээч Майхан уулыг ихэд шинжсэний дараа

Манай нутгийн усны их сан Сүж хэмээх сүүтэй ижий ууланд хадгалагдаж байдаг юм байна. Их сангийн ус газрын гүнээс оргилж гол горхи үүсгэн байхад өндөр хайрханы оройн мөнх цасны сувдан дуслууд бие биеэ хөтлөн ээждээ тэмүүлэх мэт ботгон буйлаагаар бөмбүүлэн тэмүүлсээр гол горхи, нуур цөөрмөө хүч тамираар сэлбэн хөгжим эгшигээр найралдан рашааны шимийг хамаг амьтанд бэлэглэдэг.

Нарийний булаг, булгийн эх, Булангийн булаг, Майханы булаг хэмээх энэ дөрвөн булгийн ус нь хатан хүний дөрвөөр хагалсан хилэн хар үсний сүлжих уг уулзварт донж маягийг нь тааруулсан есөн эрдэнээр чимсэн мөнгөн даруулга мэт болон тогтсон Майхан уулаа машид хүндэлж яваарай!

Энэ эрдэнийн чимэгтэй мөнгөн даруулга шиг Майхан уулаас дөрвөөр сүлжсэн гээг мэт баян голын тунгалаг усан сул асгаран урсах нь юутай үзэсгэлэнтэй вэ? гэж магтан дуулсан юм гэдэг.

Гэтэл сумын төвийн дунд нэгэн хадан толгой бүхний анхаарлыг татан содон сониноор гайхуулна. Энэ хадан уул тэнгэрээс унасан, газраас ургасан алин болохыг хэн ч мэдэхгүй. Бодвол байгаль өөрөө урлан бүтээсэн байх л гэж таамаглана. Нутгийнхан мөн л нөгөө шинжээч өвгөн эрдэмтэнд хандан

-Эрхэм та энэ хадан уулын учрыг тайлж, утгыг тайлбарлаж өгнө үү? хэмээн хүсэхэд шинжээч өвгөн сахлаа имрэн мушилзан инээмсэглээд эргэн тойрныг харснаа ийн өгүүлсэн гэнэ.

-Эрт урьдын цагт хоньшим Бодьсадва энэ ертөнцийг эргэн явахдаа өөрийнхөө орд харшийг барьж босгох нэг сайхан газар нутгийг ажиглан шинжэж явжээ. Гэтэл дөрвөн их хайрханаар хүрээлэгдсэн дөрвөн талдаа дөрвөн баянбүрд, булаг, рашаан устай. Сүж хэмээх усны их сантай. Биж хэмээх үр будааны арвин их хөмрөгтэй. Буман буян дэлгэрсэн энэ нутгийг сонгоод гэрийнхээ буйрны шав болгон саран дээрээс энэ хадан толгойг авчиран тавьсан юм. Бодьсадва мөдхөн ирж орд харшаа босгох нь магадтай гэж айлдсан гэнэ гэж ярихад нэгэн сониуч зантай хүн шинжээч эрдэмтнээс

-Тэгээд тэр Бодьсадва гэдэг хүн чинь хэзээ ирж орон гэрээ босгох юм бол оо гэж асуухад нь шинжээч их л цагаан цайлганаар агаар цалгитал инээгээд

-Тэр Бодьсадва мөдхөн ирээд та бүхний мэндийг мэдэж их эрдэнийн Чүнчигноров хөөргөөр хөөрөглөөд та бүхэнд хандан

-Энэ ертөнцийн их эрдэнийн Чүнчигноров болсон танай сайхан нутагт номын цагаан буян дэлгэрүүлж насан хутгийг бүтээн тэнгэрт тэтгэгдэн газарт ивээгдсэн хамаг амьтанд тус үйлдэж ханьсаж жаргахыг зөвшөөрнө үү! хэмээнэ гэхэд нөгөө сониуч эр эрдэмтний үгийг таслан

-Манай энэ нутаг чинь бүгдээрээ Чүнчигноров шиг их эрдэнэс болж байна уу даа гэж эргэлзэнгүй маягтай асуухад шинжээч эрдэмтэн нөгөө сониуч эрийг омогшуулан түүн рүү дөлгөөн харж

-Танай нутагт бүх эрдэнэс байхаас гадна энэ уул, нуруу, хайрханууд, хад чулуу, өвс ургамал, навч цэцэг, гол горхи, нуур цөөрөм, булаг ус, ан амьтан, мал сүрэг нутгийн уугуул зон олон тэдний ахуй амьдрал, зан заншил, ёс төр, мөс жудаг, үг хэл, бие бялдар, оюун ухаан бүгдээрээ их эрдэнэ мэт энэ нутагт цугларсан болохоор нь их Чүнчигноров хэмээн нэрлэж энэ ертөнцийн гайхамшиг гэж үнэлж буй хэрэг шүү дээ гэхэд өнөө сониуч эр

-Тэр үнэн! гэж аялгуулан хэлээд алгаа хавсран мөнх хөх тэнгэртээ сүсэглэн байв. Үе үе дамжин үлгэр домогт мөнхөрсөн энэ сайхан их эрдэнийн нутаг, зон олны тухай дараа дараагийн бүлгүүдэд давтагдашгүй гайхамшигаас өгүүлэх болно.

Хоёр

Айл бүрийн яндангаас суунаглах аргалын цэнхэр утаа агаар мандалдаа сарьниж амжаагүй байтал хөдөө хээрийн цэнгэг агаар, нарийн өвсөнд хурдан хүлэг морьдынхоо уяа сойлгыг тааруулан идэш хоолыг нь хэмжин, хурд хүчийг нь шинжэж хоносон хүдэр чийрэг эрчүүд агтын сайн армаг морьдоо унаж хурдан хүлгүүдээ хөтлөн арван зүгийн ам бүрээс аажимхан сумынхаа төврүү хөвөрнө.

Олон гол горхи, ус мөрөн нэгэн зүгт тэмүүлсээр нийлэн найралдаж их далай болдгыг санагдуулна. Бас сайн ажиглавал энэ сумын төвд бум бужигнан, түмэн олон цугларч хуран чуулсан их баяр цэнгэл болохыг илтгэнэ.

Зүс зүсмийн хурдан хүлгүүдийнхээ дэл шанхыг нь тэгшилэн засаж, согсоо сүүлийг нь гоёмсогоор боож, уяа сойлго нь таарч, өнгө зүс нь зурсан мэт байгааг харсан хүмүүний хийморь сэргэж байгаль дэлхий баясна.

Өнгө өнгийн торгоор өөртөө тааруулж урласан дээл өмсөж дурдан бүс ороож гучин хоёр угалзтай монгол гутал өшиглөн гурван үе дамжсан эгэл малгайг хазгайдуу тавин гангарсан хүдэр эрчүүдийг харсан хэн боловч омогшино. Аргагүй л засагт ханы хөх эрчүүд мөнөөс мөн дөө гэж амандаа шивнэнэ.

Энэ их баяр цэнгэлийн өглөө Алаг хайрхан, Бүс хайрхан, Буга хайрхан, Улаан хайрхануудын салбар уулс, Хөвчийн нуруу, Сүжийн уулс намсан намбайж байхад Алаг нуурын говь, хонь усны говь, хөндий хоолойнууд, хээр тал газрууд өндөлзөн баясаж байв. Морьтон олон хөврөн урсах Нарийний гол, Их өтөг, Шар хад, Боом, Могойн хоолой, Бор үзүүр, Баянгол, Улаан шанд, Хашаат, Хулгайчийн ам хөндийнүүд улам ч уужирна.

Хүлэг морьдын хүчирхэг дөрвөн туурайнд агь шаваг, хөмүүл таана исгэгдсэн ногоон шүүс цацан анхилам үнэрээр агаар сүрчиглэх нь бас л нэгэн тааламжтай мэдрэмжийг төрүүлнэ.

Гэтэл айл бүрийн гэрт аялгуут сайхан үг яриа дэлгэрч хойморийн авдар онгойж баадангийн уяа тайлагдан дэлгэгдэж төрөл бүрийн торго дурданаар урлаж оёсон ууж, ухаж зөрүүлдэж хээ хуарыг дүйлгэсэн дээл, өнгө уусгаж ижилсүүлж шагласан алчуур малгайнууд, өнгө өнгөөр алагласан цэцэг мэт гоёхон. Энэ эд бүгдийг охид бүсгүйчүүд уран гоолиг, чийрэг биедээ тааруулан өмсөж алчуур малгайгаа тэргүүндээ асаасан нь үнэхээр дэгжин зохисон гэдгийг хэлээд барамгүй.

Тэд гаднаа үзэсгэлэн гоогоороо гайхуулж байсан ч дотоод сэтгэл нь сүү хөөрөх мэт дэвэрнэ. Хэн гэгч бөх хүч чадал, уран мэх, ухаанаараа гайхуулан төрүүлэх, ямар зүсмийн морь хурд шандасаа гарган түмний манлай болох бол гэж нууцхан харц илгээн шинжиж бодол бясалгалдаа шүүнэ.

Элбэл дээл, өргөн бүсэн дээрээ зодогоо давхар бүсэлсэн өргөн цээжтэй, бахимхан биетэй бөхчүүд алив нэгийг бодолхийлнэ

Сумынхаа наадамд барилдах бөхчүүд бүгдээрээ түрүүлнэ хэмээн боддог. Хэнтэй оноо учраа таарах, хэнтэй тунах, шөвөгт үлдэх, үзүүр түрүүнд хэрхэн барилдаж түрүүлээд туг тойрох гэх зэргээр бодож бясалгана. Харин унах тухай нэг ч удаа боддоггүй нь гайхамшигтай өөдрөг сэтгэл.

Тэднийг хүүхнүүдийн хулгайн харц шилбүүрдэнэ. Хүүхэд багачууд хөөрцөглөн дагаж, хөгшид өвгөд шинжиж ажиглахыг алийг нь ч эс анзааран зөвхөн барилдах бас түрүүлэх тухайгаа боддог нь тайван амгалан мөн гэнэн цагаан цайлган хүмүүс гэлтэй. Тэдний сэтгэл нь ийм амар амгалан ажээ. Тэд хүч чадалтайгаа адилхан учир монгол түмэн бөхөөрөө бахархан хүндэлж дээдэлдгийн учир энэ бөлгөө.

Сумын төвийн баруун хойд биед тэгш тавиу хөх дэнж дээр наадмын талбай налайна. Тэр зүгрүү бүх наадамчид шинэ дээлээрээ гоёж бие, хэл, сэтгэл гурваа тэгшлэн сүлд хийморио өргөн, морьтой нь мориороо, машинтай нь машинаараа, хэсэг бүлгээрээ, хоёр гурваараа ханьсан яаранхан алхацгаана.

Гурав

Дэнж хотойлгон хотгор дүүргэсэн сумын наадам эхлэхэд бэлэн боллоо. Чанга яригчаар нарийн цээлхэн хоолойгоор нэгэн эмэгтэй

-Наадамчин олон түмэн минь өөр өөрийнхөө асар майхандаа заларна уу! Та бүхэндээ сум байгуулагдсаны гучин жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье! Сумын наадам эхлэхэд бэлэн боллоо гэв.

Наадамчид бригад баг, байгууллагын нэр бүхий асар майхандаа тухалцгааж өөр хоорондоо мэнд мэдэлцэж өнгөрснийг дурсаж өнөөдрөө магтацгаана.

Хүүхэд багачууд ч асар майхны үүдээр эргэлдэн тавьсан идээн дээрх эрээн цаастай чихрийг сонирхон энэ тэрүүгээр гүйлдэнэ.

Охид бүсгүйчүүд дөрөв таваараа бөөгнөрөн зогсоод бага нас, сургууль соёлоо санагалзан үе тэнгийн насныхаа наргиантай явдлуудаа хэлэлцэн агаар цалгитал инээд алдацгаан өнгө өнгийн өмсгөл сэлтээр гангарсан нь наадмын талбайг тойроод есөн зүйлийн цэцгийн мандал байрлуулсан мэт өнгөөр гайхуулж үзэмж нэмнэ.

Бөхийн хөлийн цэцийн асар баруун зүүн жигүүрийн майхнууд хооронд бөхчүүд хөшилдөн алхаж биеийн чилээгээ гарган хоорондоо барилдах дүр эсгэн хошин шог үг яриа хэлэлцэн хөгжилдөнө.

Харин уяачид хурдан морьдынхоо уяаг дамжин морьдыг шинжин олуулаа алхана. Тэд гаднаа намжирдан билгийн үг хэлж бие биеэ магтана. Гэсэн ч дотроо уяа сойлгын зөрүүг оноож, сайн мууг шинжиж бясалгана. Олон морь уяж наадмын түрүүг олонтоо авсан ахимаг настай Тулга баруун гарынхаа бахим алгаар том амаа арчиснаа

- Та бүхэн өглөө тэнгэр ажиглаа биз дээ. Бүртийх ч үүлгүй цэв цэлмэг байсан. Нар манддагаараа мандаж хөөрсөн. Чухам ямар зүсмийн шандаст хүлэг торгон жолоо өргүүлэхийг хэлж мэдэхгүй юм даа гэхэд Намжил хэмээх хэлэмгий эр

-Тэгвэл тод зүсмийн морь л түрүүлэх юм байна даа гэж мэдэмхийрэхэд Тулга уяач сурсан юмыг сураар боож болдоггүй гэдэг шиг мөн л том амаа баруун гарынхаа алгаар сайн гэгчээр шувтарч арчаад

-Тийм юм байхгүй. Өвгөдүүд наадмын өглөө тэнгэрт байгаа үүлний байдлаар шинждэг гэдэг юм. Өнөө өглөө нэг ч үүлгүй байсан болохоор хэлж мэдэхгүй нь байна гэхэд Галсан гэдэг эр их л бодлого болж байгаад

-Нөгөө Сагад ирээгүй юм байхдаа. Тэр хүн ч яг л хэлнэ шүү гэв. Тэд бүгдээрээ Сагадыг эрж хайж байгаа бололтой. Эргэн тойрныг нүдээ гүйлгэн хэсэг харав. Гэтэл багийн дарга Санж хэмээх шударга үнэн үгтэй, олон түмэндээ Са дарга гэж нэрлэгдэж хүндлэгддэг хүн

- Сагад мэргэн ирээгүй. Охин Хөхцэцэг нь ирсэн харагдсан. Та бүгд бөхийн цэцийн асарт

очиж морьдоо бүртгүүлээрэй гэсээр явж одов. Ямаачин Цагаан гэж явсан газар болгондоо алиа хошин үг хэлж олныг баясган омогшуулж инээд баясал бэлэглэж байдаг тэр эр

Сагад мэргэн ирээгүй нь ямай.

Сайхан төрсөн охин нь ирсэн нь гялай.

Хуц ухнаа хариулж яваа мэргэн тэнгэрийг мэднэ

Хурмаст ганцхан түүнд л үгээ хэлдэг

Цагаан би ямаагаа л мэднэ

Тулга та морьдоо л мэднэ

Сагад мэргэн тэнгэрээ л мэднэ

Төмөр хөрөө модоо л мэрнэ гэхэд бүчсэн олон нирхийтэл инээлдэхэд уян дээрээ үүрэглэж байсан морьд толгой өргөн чимээ анирдана. Хүүхдүүд ший жүжиг үзсэн аятай алга ташина. Цагаан үүдэн хоёр том шүдээ гарган инээхэд хоёр нүд нь зураас төдий болж харагдана. Тэр олны талархлыг хүлээж аваад цааш нь

Наадмын дэг алдагдуулсан гэж

Намайг нармайдаж мэднэ

Хулан зүстэй, тахин хурдтай

Хурдан хүлгүүдээ та бүхэн шинжээрэй гэсээр явлаа.

Хүмүүс Цагааны бэлэн цэцэн үгтэй, билэг оюуныг бахархан ярина. Багачууд Цагаан ахыгаа даган хошуурна.

Наадмын талбайны эргэн тойронд уулзах, учрах баяр баясгалан, инээдэм наргиа болж байхад бас далдхан гомохрол, тунирхал, аргадал, уучлалаас гадна атаа чөтөө, атгаг муу санаа хүртэл хаягдахгүйгээр газар авахгүй ч гэсэн гэтэж байлаа. Гэтэл чанга яригчаар эрэгтэй, эмэгтэй хоёр залуус ээлжлэн

Миний нутгийн тэнгэр нь хөх билээ

Мичид шүргэх уулс нь хөх билээ

Мэлтэлзэн мяралзах ус нь хөх билээ

Мэндийн хадаг шиг салхи нь хөх билээ

Хөвд борог хөхөл өвс нь хөх билээ

Хөшөө дурсгал түүх нь хөх билээ

Хүдэр чийрэг эрчүүд нь хөх билээ

Хөрслөг бор бүсгүйчүүд нь царайлаг билээ гэж эмэгтэй нь цээлхэн хоолойгоор уншсаны дараа залгаад эрдүү хонгор дуугаар

Бид Засагт ханы хөх харчуудын нэгэн үр сад билээ

Бид замилгаат Алтайн асга хадны нэгэн цохио билээ

Бид ариун хурын асгарах сувдны нэгэн дусал билээ

Бид Алаг нуурын говийн алтан элсний нэгэн ширхэг билээ хэмээн уянгалуулан дуудав.

Энэхүү дууллыг сонсож суугаа наадамчдын сэтгэл ихэд хөдлөв бололтой. Тэнгэр эцэгтээ сүсэглэн төрсөн нутгаараа бахархан бүлээн шунхаа буцалган бүтэн биеэрээ омогшин огшиж байв. Чанга яригчаар

-Одоо та бүхний өмнө сум нэгдлийн дарга Хангалыг урин залья хэмээв. Энэ өндөрдүү нуруутай, дал мөрөөрөө бага зэрэг бөгтөр хөх эрийг аймгийн намын хороо захиргаа их л итгэл хүлээлгэн энэ сум нэгдлийн даргын албанд тохоон томилсон.

Гэтэл тэр намын үүрэг даалгаврыг ягштал дагаж төлөвлөгөө нормыг биелүүлэхийг урьтал болгосонгүй. Харин сум орноо хөгжүүлэх, малаа өсгөж, аж ахуйгаа бэхжүүлэх хүн ардынхаа эрүүл мэнд, ахуй соёл амьдралыг нь дээшлүүлэхэд л анхаарч ихэд чухалчилж байлаа. Тэр өөрийн гэсэн бодол зорилгоо итгэл үнэмшил болгож чадсан болохоор удирдах хүмүүс ч түүнд элдэв шахалт шаардлага тавихаасаа жийрхэнэ.

Сумын дарга Хангал зөөлхөн сөөнгө дуу хоолойгоор сумын наадмыг нээж наадамчин олон түмэндээ баярын мэнд дэвшүүлэв.

Энэ нутгийн хөх тэнгэрт алтан соёмбот төрийн далбаа өндөрт мандав. Сумын наадмын талбайг бүтэн тойрч гурван давхар хүрээ үүссэн нь үнэхээр бэлэгшээлтэй. Хүүхэд багачууд өмнүүр сууж хөгжилдөн инээмсэглэнэ. Хөгшид настангууд дундуур нь найлж хүндэтгэл үзүүлж төрийнхөө сүлдэнд залбирна. Хүлэг морьтонгууд гадуур нь хүрээ үүсгэн хана хэрэм аятай ханхайн шивээлсэн нь энэ зон олны эв эе, сэтгэл санаа нэгдмэл болохыг илэрхийлнэ. Бөхийн засуулууд бөхөө дуудан

-Сумын заан Сүрэн зодоглоорой гэж уянгалуулан дуудаж байхад түүнтэй зэрэгцэн

-Залуу бөх Сугар зодоглоорой гэж мөн л уянгалуулан дуудаж буй нь заан, залуу бөхчүүдээ ялгалгүй хүндэтгэл үзүүлж наадамчин олноо баясгаж байгаа нь өөрийн эрхгүй эрхэм мөс жудгийг санагдуулна.

Хүчит бөхийн барилдааны эхний гурван түүз гараанд арван хоёр сумын заан манлайлан дэвж байгаа нь үнэхээр сонирхол татна. Зарим сум нутагт нэг бөх арав түрүүлсэн гэж бахархан

ярьж байгааг сонсоход тийм ч тааламжтай биш байдаг. Яагаад гэвэл бөхөөр барилдах эрчүүд цөөхөн юм уу? эсвэл эрчүүдийн зориг зүрх, бяр чадал ялгавартай болохыг хэлдэг. Гэтэл эр бяр нь ижил тэнцүү идэр бөхчүүдийнх нь хийморь сүлд нь босоо уран мэх, ухаан бодол нь улам хөгжин дэлгэрч байгаа болохоороо жил бүрийн наадамд идэр залуу бөх түрүүлэх учир сумын заанууд олноор төрдгөөрөө бас нэг онцлогтой ажээ.

Дөрөв

Сумын наадмын дэвжээг тойрсон түмэн баяр баясгалан мянган үйл үртсийг тоочоод бичиж бас өгүүлээд яахан барах билээ.

Алтайн нурууны өндөр хайрхан уулс үргэлжилсэн урт нуруу үе үе өндөрсөх хадан цохио, хавцал хөндий, асга хадан байц, салбар уулсаар хүрээлэгдсэн баян бүрдэд сумын төв байрших учир хурдан морьдын уралдаан явуулахад багагүй түвэгтэй болно. Бусад сумд гарааныхаа газрыг зайд байрлуулж сумынхаа төвд барианыхаа цагаан шугамыг татдаг бол энд сумынхаа төвөөс морьдоо гаргаж холын зайд барьдгаараа ихэд сонирхолтой ажээ.

Хурдан морьдынхоо уралдааныг үзэж сонирхохоор наадамчин олон тэр чигээрээ хөдөлнө. Сумын төвд өндөр настай өвгөд, эмгэд цөөн хэдхэн хүн л үлдэнэ.

Шар хадны уудам хоолойг машин, мотоцикл, морьтонгууд бүрхэн тоос татуулан уралдах мэт урагшилах нь ямарваа нэгэнд ихэд яарсан гэмээр бас их нүүдэл гэж эндүүрмээр санагдана.

Энэ хоолойд таана хөмүүл, нарийн өвс ургахаас гадна хааяа хааяа тэсэг, ортууз ургасан үзэгдэнэ. Машинууд зөвхөн замаараа хурдална. Харин морьтонгууд талын энгээр бүрхэж, хөгшид нас тогтсон хүмүүс голдуу жороо сайвар зөөлөн явдалтай хүлгүүдийнхээ нуруун дээр намбайж байхад, залуучууд нь ам хамраа булаан авч давхих нь холгүй толгойгоо хаялан дэл сүүлэндээ салхи наадуулж тогтож ядан дүйхэлзэх хөл хөнгөн, хөөрүү омголон, омог бардам морьдыг унасан нь үнэхээр хийморьлог харагдана. Охид бүсгүйчүүдийнх нь зүс өнгөөрөө гайхуулсан зөөлөн хөнгөн явдалтай. Хазаарын чимээ чагнан согоо хоёр чихээ солбилзуулан дөрөө харших төдийд дөмөн дөмөн алхалсан зурмал юм шиг галбир хийцтэй хүлгүүдийн нуруунд ясан хяртай, мөнгөн баавартай, монгол эмээл дээр хорин нэгэн дарьхи бурхан шиг уян зөөлөн, уран нарийхан, залуу мяраагаараа гайхуулан дүр маяг үзүүлэн суусан нь гоёмсог бас үзэсгэлэн төгс ажээ.

Морьтонгууд хоёр гурвуулаа, долоо наймуулаа хэсэг бүлгээрээ нийлэлдэн инээд баясал цалгиаж хөгжиж хөөрцөглөн явна. Энэ нь ахан дүүсээрээ, амраг сэтгэлээрээ, айл саахалтаараа ганзага нийлэн наадамлаж яваа нь энэ билээ.

Наадамчин олон морьтны дунд Сагад мэргэн хэмээхийн ганц охин Хөхцэцэг ангийнхаа найзуудтай олуулаа явна. Хөхцэцгийн дотны найз болох Нарангарав, Минжин, Сэмбэрүү, Алтанцэцэг, Жамьянмядаг, Содхүү, Намсан, Хөнхий, Далайноров болоод бусад олон нөхөд сэлтгэйгээ хурдан морьдын тоосонд хийморь сүлдээ дэлгэрүүлэхээр баяр хөөртэй яваадаа хүн бүрийн сэтгэл дэвэрч нэг дор хурна. Хөвгүүдийн харц Хөхцэцгийг тойрон эргэлдэнэ.

Энэ бүгд охидуудын гярхай харцнаас зайлж эс чадна. Нарангарав, Алтанцэцэгээ нудран анхаарлыг нь өөртөө татан дөрөөн дээр өндийгөөд түүний чихэнд

-Цаад Содхүүгээ хараач ээ! Хөхцэцэгийг гөлийтлөө ширтээд бүр балай аятай болчихжээ. Манай Минжин Содхүүгийн байдлыг ажиглаад хацар чих нь улайгаад, нүд нь гялалзаад их ууртай байна гэхэд Алтанцэцэг

-Наран минь! чимээгүй аяархан яриач. Хэрвээ сонсчихвол дэмий юм болно гэв. Гэтэл Хөнхий

- Та хоёр юугаа шивнэлдээд байгаа юм бэ? Шиврээ бороо хувцасанд халтай, шивнээ үг нөхдөд халтай гэдгийг мэдэх үү? Бас ярны муухай хатиг, ярианы муухай шивнээ ч гэдэг юм даа гэхэд Нарангарав инээд алдаад

-Хувийн нууцыг хуулиар хадгалдаг юмаа хөө! Шивнэж ярих чинь чиний хэлдэгээс шал өөрөөр ойлгодог юм.

Шивнэн шивнэн ярилцаад

Найзаа чинийхээ үгийг сонсоно гэж дуунд хүртэл дуулагддаг юм шүү гэж сөргүүлэхэд Хөнхий мөчөөгөө өгөхгүй гэсэн шиг

-Та хоёр хичнээн шивнэж ярьсан ч миний чих урт шүү дээ. Намайг сонсоогүй гэж бодоо юу! Манай Содхүү яахав дээ. Сэтгэлдээ тээж хайрлаж явдаг хүнээ л сэмхэн харж дотроо баясаж зүрхээ номхотоогоо биз гээд бусдыгаа харж хань татахыг хүссэн боловч хэн ч дуугарсангүй. Тэр арга нь барагдсан аятай

-Тийм биз дээ? Хөхцэцэгээ гэхэд бусад нь нирхийтэл инээлдэв. Гэтэл юу болов гэмээр гэнэт Минжин

- Чүү гэж чанга хэлээд дөрөөнд өндийж цоохор хондлойтой буурал мориндоо ташуур өгөн ухасхийн хурдлав. Бусад нөхөд нь бие биерүүгээ

- Энд юу болоод байна гэсэн харц солилцон ганц хором болсноо үргэсэн болжмор шиг зэрэг шахам

- Чүү хэмээн ташуур өргөж дөрөөнд босов. Залуу нас гэдэг ийм л ид хавгай, омог бардам ажээ. Харин аманцар Нарангарав бүхэнд сонсогдохоор

Сэтгэл гэдэг нь жолоогүй шүү дээ хөө

Содхүү гэдэг нь итгэлгүй шүү дээ хэмээн аялгуулахад салхи шуугин түрж улмаар шуранхайлан чихэнд чимэг болно.

Морьдын хүчирхэг дөрвөн туурай газар дэлдэн бөмбөрдөхөд таана хөмүүл хэрчигдэн будар чулууг будна. Хөх ногоон униар дэгдэнэ. Хөхцэцэг бүсгүйн хөөрсөн сэтгэл холыг мөрөөднө. Харин морины барианы газар ойрхон байгааг яалтай билээ. Хүмүүний сэтгэлийн хүсэл тэмүүллийг газраар хэмжиж болдоггүй нь юутай сайхан бэ? Үе тэнгийн залуус үерхэл нөхөрлөлийн хөгнөнд холбогдон бие биеэ түшин билэг оюундаа жаргадаг билээ.

Морьтон олон наадамчдын урсгал могойн харын Ар сүүжийн хоолойг өгсөн хөвөрсөөр байгаа нь ус гол, уул өгсөж хөтөл давах нь уу гэмээр сэтгэгдэл төрүүлнэ. Тэдний түрүү магнай хэсэг нь Ар сүүжийн амгалан давааны энгэр бэлийг түшин дөрөө мултлан нуурлан налайна.

Араас ирэх морьтонгууд нэмэгдсээр их хүрээ үүсгэн далай мэт давалгаалан баяр баясгалангийн цог жавхланг бүтээнэ.

Морь барианы цагаан зурвас шугам татан хөх улаан дарцаг хатгана.

Хээрийн задгайд хоймор байдаггүй гэдгээр хүн морь хоёроор хот мандал бүтээгдсэн мэт болоод тэдний сэтгэлүүд нийлэн хуран чуулж амгаланг оршоогоод аялгуут сайхан үг хэл, дуу хоолой нь найралдан бүхэл бүтэн найрал хөгжим эгшиглэхүй сонсголонтой ажээ.

Уяач Тулга тэргүүтэй хэсэг бүлэг хүмүүс дугуйран сууж хөөрөг зөрүүлж билгийн үг хэлэлцэнэ. Тэд орон дэлхий, нутаг нуга, ус ургамлын тухай хүүрнэнэ. Гэтэл Намжил

-Тулга ахаа! Өглөө ярьж байсан түрүү магнай морины зүс юу болсон бэ? гэж сануулахад Тулга, Намжил руу гайхан харснаа

- Аа тийм. Бид чинь хэлэлцэн сайн тогтоогоогүй билүү.

Үүл гараагүй болохоор үнэндээ ямар зүсмийн морь түрүүлэхийг хэлэхэд бэрхтэй байна. Энэ жилийн наадмын хурдан морьдын уяа сойлго жигдхэн, тун ч сайн уягдсан болохоор бас л энэ морь тэр морь гэж заахад хэцүүхэн юм билээ. Манай уяачид морь сойх эрдмийг сайн ч сурж сайн ч эзэмшиж дээ гээд бахархан ярихад Галсан

-Тулга гуай! Сагад мэргэний охиноос нь асуувал хэлэх болов уу? Тэр Хөхцэцэг бүсгүй тун ч ухаалаг нэгэн юм билээ гэхэд Тулга уяач

- Ай мэдэхгүй! Олон жил морь уячихаад тэнгэрийг ажиглаж мэдэхгүйдээ айлын жаахан охиноос асуугаад явж байх нь хаашаа ч юм бэ дээ? гэж дурамжхан хариулахад Галсан инээмсэглээд

- Ичэх нүүрэндээ илэг нааснаараа би л асуугаад орхиё! Нэрэлхээд нэрээ идэх биш дээ. Нэгийг мэдээд авбал хожим хойно хэрэг болж юуны магад гээд өндийхөд Галсангийн хүү Амархүү яарангуйгаар

- Ааваа! Та сууж л бай л даа. Би яваад асууж мэдээд ирье! гэхэд Галсан баярлан

- Тэг дээ миний хүү яваад ир! гэлээ. Амархүү дотроо баяртай байлаа. Хөхцэцэгээс юм асуухын далимд Нарангаравтайгаа ганц үг хэлэлцээд авахыг хүсэж баярлан байвч далдхан айдас түгшүүр төрнө. Ам хамар нь гүйцэгддэггүй энэ бүсгүй айж эмээх юмгүйгээр олны нүдний өмнө юу ч хэлж мэдэх учир ийнхүү түгшинэ.

Амархүү Хөхцэцэгтэй уулзан мэнд мэдээд зогсож байхдаа харцаа гүйлгэн хэн нэгнийг эрж хайна. Нарангарав түүний нүдэнд эс өртөв. Энэ нь түүнд нэг бодлын амар байгаа боловч бас сайхан төрхийг харж чадаагүйдээ харамсах сэтгэл төрнө. Нарангарав Амархүүгийн нүдний харцнаас бүхий л бодол санаа, хүсэл мөрөөдлийг уншиж чадна. Тэр өөрөө ч Амархүүд сэтгэлтэй сайн болохоо мэдэнгүүт санаа нь зовж ичингүйрч аргаа ядна. Айсан хүн адуу хөөнө. Ичсэн хүн юу гэдэг билээ. Түүнлүүгээ алиа хошин үг хэлж аятайхнаар дүйвүүлэн

болсон явдал, бодол санаагаа нууж чадна. Энэгүйлгүүр ухаан, овсгоо самбаа нь Амархүүг улам л хүчтэй татна. Хөхцэцэгээс Амархүү асуух гэсэн зүйлээ асууж сонсож байхдаа дотроо

- Нарангаравын ирэхийг хүлээгээд ч байгаа юм шиг, эсвэл хүлээхгүй ч байгаагаа огтхон ч мэдэхгүй нэг сонин сэтгэгдэл төрнө. Энэ мөчид Амархүүгийн аав Галсан, Тулга нарын уяачдын ойролцоо элдвийг сонирхон Нарангарав найз Алтанцэцэгтэйгээ алхална. Тэр нууцхан харцаар Амархүүгээ эрнэ. Түүнийгээ нуухын тулд Алтанцэцэгтээ

- Энэ ямар гоё морь вэ? Тэрийг хараач ямар ганган цоохор зүстэй юм бэ дээ хэмээнэ. Хоёр бүсгүй найзууд дээрээ дөхөж иртэл Нарангаравын эрж хайж барааг нь харах гээд байсан нөгөө Амархүү нь Хөхцэцэгийн ам руу нь орох нь холгүй ойртон нэг л чухал зүйлийг ярилцаж байгааг олж хараад гайхасхийн зог тусангаа замаа буруулаад дотроо

- Манай Хөхцэцэг рүү залуус бүгд л хошуурна шүү! Амархүү хүртэл ам руу нь орж араанд нь зажлуулах нь дээ. Ёстой эр хүнд итгэхээр эрхий хуруундаа итгэ гэдэг үг л үнэн бололтой гэж эмзэглэж байтал

- Хөхцэцэг хэнийг нь ч тоохгүй дээ гэсэн бодол толгойд нь орж ирэнгүүт түүний сэтгэл амраад явчихав. Энэ удаа Амраатай уулзахгүй ээ гэж бодсон Нарангарав бүсгүй найз Алтаагаа сугадан буруу тийш мурын хоёр гурав алхтал

- Сайн байцгаана уу? гэх Амархүүгийн хэлсэн мэндийг сонсоод бондосхийн цочив. Гэсэн ч Амархүүтэйгээ уулзсандаа Нарангаравын зүрх хүчтэй дэлдэн сэтгэлд нь баярын солонго татав. Хүний сэтгэл гэдэг барих биегүй бас суух суудалгүй ажээ.

- Амархүүг уяачид дээрээ ирэхэд Намжил ам нээж

- Цаад охинд чинь хэлэх юм байна уу? Бараг л үгүй байхаа даа гэхэд Амархүү инээмсэглээд

- Байлгүй яахав. Аль эрт л Хөхцэцэгээс асуучихсан бол болохгүй юу гэхэд эцэг Галсан нь

- Хүү минь! тэгээд юу гэж байх юм гэв.

- Наадмын өглөө тэнгэрт үүлгүй байх үед нар, тэнгэрийн өнгө хоёроор шинждэг юм гэнэ гэхэд Тулга уяач

- Тэгээд тэнгэр нар хоёрын өнгөөр яаж шинждэг болж байнаа хэмээн сонирхоход Амархүү

- Өглөөний нар гурван өнгөтэй мандсан гэнэ. Зонхилох өнгө нь шар өнгө байсан юм байна гээд түр азнахад Намжил яаран

- Тэгээд цааш нь яриач. Тэнгэрийн зонхилох өнгө нь ямар байв гэнэ гэж асуухад Амархүү

- Гүн хөх өнгөнөөсөө шингэрсэн өнгө нь дийлэнх байсан болохоор хээр өнгийг тодорхойлдог юм гэнэ гэхэд бүгдээрээ гайхан чимээгүй болов. Галсан хүүдээ хандан

- Ямар зүсмийн гэж хэлэх болж байна гэж асуухад Амархүү

- Шар хээр зүстэй л гэж хэлэх болж байна билээ гэв. Намжил уяач гайхан амандаа ус балгасан аятай чимээгүйхэн сууна. Олны харц түүн дээр тогтсон байлаа. Намжилийн шар хээр гэж сайн хурдан буян бий. Түүний зүс өнгө ийнхүү нар, тэнгэр хоёрт тодорсныг сонссон хүмүүс ийнхүү гайхан эргэлзэж бас баярлаж байв. Гэтэл

- Морьд гараад ирлээ гэсэн яриа энд тэнд тод сонсогдож байснаа хуурай өвсөнд галын дөл долоолгосон мэт түргэнээр түгэн тарж морь барианы газарт нуурлаж налайсан олон наадамчид тэр аяараа давалгаалан хөдөлгөөнд орж босож суун нэгэн зүгт анхаарлаа илгээж дурантай нь дурангаа барьж, дурангүй нь гараараа саравчилж хараагаа нарийсгана. Намжил шар хээр хэмээх зүс сонссоноосоо хойш сэтгэл нь хөдлөөд нэг л сонин. Тэр дурангаа нүдэндээ барьтал хав харанхуйлаад явчихав. Амандаа

- Энэ чинь яадаг золиг вэ? гэж шивнээд баруун нүдээ сайн гэгч арчаад дахиад харахад бас л харанхуйлаад явчихав. Гэтэл дэргэд нь суусан залуу инээмсэглэн

- Намжил ахаа! Та дурангийнхаа тагийг аваач гэхэд нь Намжил

- Өө золиг гэж хэлээд дурангийн тагийг авав. Галсан дотроо нуг нуг хөхрөөд

- Хөхөө Намжил ч хөглөх нь шив дээ гэхэд Намжил ер тоосон шинжгүй

- Галсан! ямар зүсмийн морь өнгөлж явна. Чи харав уу? гэхэд Галсан

- За байз хөө! Цагаан саарал зүстэй морь л өнгөлж байна даа. Бас ч барианы зурхай ч болоогүй л байна даа гэв. Намжил дурангаар сайн оноож харж чадахгүй байгаа бололтой будилна.

Намжил сэтгэлийн хөдлөлөөр юм юмруу оролцож болж бүтэхгүй инээдэмтэй үйл үртэс өдөөж явдагийг зүйрлэн хөхөө Намжил гэж өхөөрдөж дуудах нь олонтоо.

Үлгэр домогт алдаршсан хөхөө Намжил мөн л энэ сайхан нутагт төрж өсөн аж төрөн амьдарч байсан түүхтэй. Энэ алдартай эрхэм хүнийхээ нэрийг дурсан санаж уяач Намжилдаа хөхөө гэдэг алдрыг хайрласан нь ийм учиртай болой. Их насны хурдан морьд хэсэгхэн зуурт газрын хотгорыг туулах учир үзэгдэхээ болив. Хүн бүрийн амнаас л

- Саарал морь, саарал морь өнгөрсөн жилийн түрүү магнай саарал морь гэгцгээн шуугилдах нь хөхөө Намжилд олон хэдгэнэнд ээрүүлсэн мэт түвэгтэй санагдана. Харин Амархүү дотроо

- Хөхцэцэгийн тавьсан сум ч байнд битгий хэл банзанд ч бараадахгүй зөрлөө дөө. Түүний хэлснийг би хүмүүст хэрэггүй хэллээ. Аавын санаа бас л зовж байгаа байх даа. Намжил ах мориных нь зүс таарсанд баярлаад байсан. Одоо болохоор бараан царайлаад дуугаа хураагаад нэг л урамгүй болчихож гэж бодож байтал хэн нэгэн

- Морьд гэж чангаар хэлэхэд барианы газар тэр чигээрээ доргих шиг болж Ар сүүжийн хөтөл намсав. Үнэндээ нүдээр харсан ч морьдын зүс, унасан хүүхдийн өмссөн хувцас тод харагдаж байлаа. Хүмүүсийн аманд

- Шар хээр морь байна. Намжил ахын шар хээр байна гэх нь Намжилд тодхон сонсогдож байлаа. Тэр бас л итгэхгүй

- Худлаа байлгүй гэж амандаа хэлээд дурангаа арай ядан тогтоогоод харахад шар хээр морь, хүү хоёр нь мөн байлаа. Түүний чих шуугиад, нүд нь бүрэлзээд ирэв. Намжилын шар хээр гэж хэлэх нь улам л бүдгэрсээр холдсоор байв. Гэтэл нэг мэдсэн

- Хүүе Намжилаа босооч! морь чинь ирчихлээ гэж Галсан хэлээд түүнийг сугадан өргөхөд Намжил сая л мэдэж байгаа бололтой.

- Өө тийм үү! Хүрээд ирчихэв үү? гэж асууж байгаа нь сонссон хүнд

- Энэ Намжил нөхөр чинь сэтгэлийн ямар ч хөдлөлгүй хөлдүү толгойтой хүн үү? гэж санагдахаар байлаа. Гэтэл тийм бишээ. Харин ч сэтгэлээ барьж чадалгүй алдаж асган хоромхон зууртаа муужраад авсныг нь хэн ч мэдсэнгүй. Намжил Галсангийн гараас мултран шар хээр морио хаана байгаагаа ч мэдэхгүй мөртлөө том том алхсанаа гүйв. Тэр түрүүлсэн шар хээр мориныхоо дэргэдүүр өнгөрөөд явахад хүү нь

- Ааваа! гэж дуудахад сонссонгүй бололтой цаашлав. Амархүү хойноос нь ухасхийн гүйцээд

- Намжил ахаа! морь энд байна шүү дээ! Та чинь хажуугаар нь гараад л явчихлаа гэхэд Намжил

- Өө солиг! тэгсэн үү. Хаана байна? гэж будилан ойр байгаа хүмүүсийн хөх инээдийг хүргээд авав. Морь гэдэг молор эрдэнэ эр хүний сэтгэлд үүрсэж санасан хэрэг зорьсон газарт хүргэж холын зайд хань нөхөр нь болж, аюулт гай гамшигаас амийг нь авардаг гэдэг. Монгол эр хүнийг морьгүйгээр төсөөлөхийн аргагүй билээ. Намжил мөн л тэдний нэгэн бөлгөө.

Ар сүүжийн хөтөл даваанд саатан морилсон морьтон наадамчдын урсгал эргээд л сумынхаа төв рүү аажимхан амгаланг бүтээн урсана. Дараа дараагийн насны хурдан хүлгүүдийнхээ уралдааныг тогтсон барианых нь газарт түр саатан хүрээ үүсгэн хөгжилдөн наадаад сэтгэлдээ дүүрэн жаргалтай буцацгаах нь үлгэр мэт үнэхээр гайхамшигтай.

Бодол бодлоороо хэлхэгдэн баяр цэнгэлээр хөтлөлцөн явах наадамчдын дунд хамгийн их баярлаж яваа хүн бол Амархүү билээ. Хөхцэцэгийн нар, тэнгэрийг шинжээд хэлсэн шар хээр зүсэмийн хурдан буян түрүүлж ирсэнд ийнхүү баярлана. Хэрвээ саарал морь ирсэн бол тэр чухам яах байснаа төсөөлж чадахгүй явлаа. Тэр Хөхцэцэг бүсгүйгээр бахархан түүний аав Сагад мэргэнийг шүтэн бишэрч байв.

Тав

Сум эвшээлгэж сур элдсэн сумын наадам хоёр дахь өдрөө үргэлжилж байлаа. Наадмын торгон дэвжээг тойрсон хүмүүнээр бүтээгдэх цэцгийн мандал улам өнгө засан өргөн дэлгэрч өтгөн шигүү болсон мэт байв.

Сумынхаа их насны морьдын түрүүг авч ихэд баярласан хөхөө хэмээх Намжил Хөхцэцэг охиныг битүүхэн эрэлхийлж хэсэг бүлгээрээ цэцгийн мандал аятай хөгжилдөн цэнгэх охид хөвгүүдийг харан сэтгэлээ баясгана. Залуу насаа дурсан аажимхан алхана.

Гэтэл сумын төвд суурин ганзага хийдэг Суманхүү гэдэг намхан нуруутай, зүүн хөл нь доголлон, хэл ам нь хэнд ч гүйцэгддэггүй, хэлэлцвэл ч хэлэлцэж, дайралцвал ч дайралцахаасаа буцдаггүй хэгжүүн эр Намжилтай мэнд мэдэж морь нь түрүүлсэнд баяр хүргэхээр очоод

-Сайн байна уу? гэхэд Намжил дуулаагүй юм уу? эсвэл согтуу юм уу? гэмээр охид бүсгүйчүүдийг харан алмайрна. Суманхүү түүний эл байдлыг далимдуулан хоёр суганд нь огцомхон хүчтэй хатгахад Намжил ихэд цочин

- Ээ халаг минь! гэж хашгираад сугаа хавчин ухасхийхэд эргэн тойрны хүмүүс юу болов гэсэн шиг харцаа илгээв. Харин Суманхүү ганзага л эг маггүй хөхөрч зогсоно. Хөхөө Намжил царайгаа чинэрүүлэн муухай харснаа төдөлгүй Суманхүүтэй нийлээд инээж байлаа. Сайхан нөхөрлөлийн тоглоом хатуу ч бас инээд баясал авчирдаг ажээ. Намжил өврөөсөө хөөргөө гаргах зуураа

- За сайн байна уу? Суманхүү ээ! Сайхан наадаж байна уу? гэхэд Суманхүү баруун хөлөө эгцлэн зүүн хөлөө сул тавин өндөрсөж зогсоод

- Миний мэнд хөл дор чинь уначихлаа. Морь нь түрүүлээд ирэхээр манийгаа тоохоо болиод охид бүсгүйчүүдийг сонирхоод олны хөлнөөс зайдуухан явдаг болоо шив дээ гэж инээгээд

- Сайн сайн. Сайхан наадаж байна уу? Морь нь магнайлчихаад манай Намжил ч маадгар байх шив дээ гэхэд Намжил тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх билээ гэдэг шиг

- Морь маань ч түрүүлээд ирсэн болохоор би гэдэг баяртай байлгүй яахав. Одоо бөхөд чи минь л түрүүлчихвэл бүр давхар баяр болох гээд байна гэж муу хөлийг нь дайруулан хэлэхэд Суманхүү дотроо

- Чи бас намайгаа хөөрхөн чимхээд авч байна уу? Тэгнэ байхаа гэж бодоод

- Намайг наадамд барилдаад түрүүлбэл нар баруун хойноос гарах байлгүй. Чамайг ямаа дэлэндээд сууж байвал чивтэй чавганц гэж их л гайхах байхдаа гэж хөхөө Намжил мал саадаг бас малын гэдэс арилгадаг эмэгтэй хүний хийдэг ажлыг бүгдийг хийдгийг мэдэх учир ийн чавганц болгон дайрахыг мэдсэн Намжил дотроо

- Даанч зав алга бас олны дунд наадам цэнгэл дээр элдвийн үг хэлэлцэх нь дэмий байх гэж санаад

- За за. Чи бид хоёрын мар мархийх ч яахав. Би хөө нэг хүүхэд хайгаад явна гэхэд Суманхүү ч
- За баяр хүргэе! Уясан хүлэг нь хурдан, унасан хүүхэд нь хөнгөн, уяач эзэн нь хийморьлог байх болтугай! гэж ерөөхөд Намжил хоёр алгаа дэлгээд
- Ерөөл бат оршиг! Магтаал айлдсан та зуу наслаж зургаадай таяг тулах болтугай гэж билгийн үг айлдав. Тэд бие биедээ найр тавьж тохой тохойгоо түшилцэн нөхөрлөлөө улам бататган бие сэтгэлээ дэлгэрүүлнэ. Суманхүү
- Намжил аа! Та хэнийгээ эрж хайгаад яваа хүн бэ? гэхэд Намжил эргэн тойрноо нягтлах мэт харснаа
- Нөгөө Сагадын охин Хөхцэцэгийг л олох санаатай явна гэхэд Суманхүү загатнасан газар маань маажив гэгчээр жуумалзан инээмсэглээд аяархнаар
- Та чинь одоо бүр хүний хуруун чинээ охины хойноос явж байдаг болоо юу? гэж цаашлуулахад Намжил
- Цөг чи дуугаа аяд! Би чамд учрыг хэлье! хэмээн ихэд санаа зовж байгаа бололтой ийш тийшээгээ хялмалзан байснаа Суманхүүд ойртоод
- Наадмын өглөөний тэнгэрийг ажиглалтал бүртийх ч үүлгүй цэлмэг байлаа. Ямар зүсмийн морь түрүүлэхийг хэлэхэд бэрхтэй боллоо. Адаг сүүлд нь аргаа бараад Сагадын охин Хөхцэцэгээс асуулгавал шуудхан
- Шар хээр морь гээд л палхийтэл нь хэлчихдэг байгаадаа. Би ч бүр гайхаад баярлаад ч байгаа юм уу! Бачуураад ч байгаа юм уу! Нэг л хачин болчихлоо. Гэтэл морьд ирлээ гээд л хүмүүс шуугилдаад явчихлаа. Намайг сайн харж амжаагүй байтал
- Саарал морь өнгөлж явна гээд л хэлэлцээд хэсэг болсны дараа л
- Шар хээр морь Намжилын шар хээр гээд хэлэхийг нь тодоос тод дууллаа. Гэсэн ч үнэмшсэнгүй шүү! Амандаа л
- Худлаа байхаа гэж шивнээд дурандвал мөн байлаа. Тэгээд юу болсныг сайн мэдэхгүй. Хэсэгхэн зуур манараад авсан бололтой. Морь түрүүлж ирэх ч мөн л хэцүүхэн юм билээ дээ. Тэгээд л ашдын билгээс амны билэг гэдгийг бодоод тэр охины оюуныг нь мялааж ганц үг хэлж сэтгэлээ амраая! гэсэн төдий хэрэг гэхэд Суманхүү ганзага
- Зөв дөө хөө! Намжилаа. Хүнд чинь сэтгэл гэж нэг агуу юм байна шүү! Тэгвэл хоёулаа хамт явья гэсээр үе тэнгийн хоёр нэгэн хэрэг үйлд мөр мөрөө түшилцэн ханьсах нь тэрээ. Намжил, Суманхүү хоёр наадмын талбайгаар хууч хөөрөлдөн Хөхцэцэг охиныг нүдээрээ эрэн явтал Галсангийн хүү Амархүүтэй тааралдаад Намжил
- Юун сайн юм бэ? Сайн хүн санаагаар гэдэг биз дээ. Муу ах нь Сагадын охин Хөхцэцэгийг хайгаад л явж байна гэхэд Амархүү гайхсан царайгаар

- Намжил ах аа! Та Хөхцэцэгээс юм асуух гэсэн юм уу? гэхэд Намжил түвэгшээсэн бололтой

- Үгүй ээ үгүй. Чи надад хаана байгааг нь хэлээд өгчих! Өөр юм байхгүй гэлээ. Амархүү настай хүнийг уурлуулчихав уу? гэсэн бодолдоо ихэд гэмшин

- Ахаа хаана байгааг нь би сайн мэдэхгүй байна. Би байгаа газрыг нь мэдээд танд хэлье гэхэд Намжил

- За яах вэ хүү минь. Дайралдах биз гэсээр цааш явлаа. Амархүү дотроо

- Энэ Намжил ах Хөхцэцэгийг надаас асуугаад байдаг нь юу билээ дээ. Би чинь өчигдөр бариан дээр Хөхцэцэгээс морины зүс асуухаар явахдаа эхлээд аавыгаа бодоод тэр. Настай хүн айлын жаахан охиноос ямар морь түрүүлэх вэ? гээд асуугаад явж байх нь хаашаа ч юм бэ? гэж Тулга гуайн хэлдэг үнэн байсан. Дараа нь би энэ далимаар Нарангаравтай уулзъя гэсэн цээжний хонжоо хайсан хэрэг шүү дээ гэж бодоод дотогшоогоо инээв.

Түүний толгойд Сагад гуайн нэгэн нууц босоод ирэв. Манай нутагт энэ нууцыг хэн ч мэдэхгүй. Ганцхан би л мэднэ гэсэн омогшил Амархүүд төрсөн болохоор энэ нууцыг эргэн дурсахад хүрэв.

Зургаа

Арван зургадуур жарны модон барс жилийн зуны эхэн шарагчин могой сарын шинийн арван тавны билэгт сайн өдөр билээ. Амархүү өвөөгийн дөө хонохоор ирэхэд өвөө нь сайхан зантайгаар цагаан будаатай өрөм амттай чихрээр дайлаад

- Ач хүү минь. Өнөөдөр өвөө нь мацаг барина гэхэд Амархүү

- Тийм үү? Мацаг гэж юугаа хэлээд байгаа юм бэ гэхэд Балбар өвгөн хэсэг чимээгүй болон бодлогоширч сууснаа

- Миний хүү өнөө шөнөдөө гэртээ юм уу, өөр айлд хоног төөрүүлчих! Маргааш манайд ирж хоноорой. Өвөө нь өнөөдөр ганцаараа тайван нойрсомоор байна гэв. Амархүү авга ахындаа хэсэг байж байгаад морио бөхлөхөөр гарч ирээд өвөөгийнхөө үүдээр өнгөрч явтал гэрт алив нэгэн юм дуугарах шиг болохоор нь энэ юу билээ гэж бодоод сэмээрхэн очиж тогтоор шагайвал өвөө нь лаа барьчихсан урдаа том судар дэлгэчихсэн ном уншаад хонх дамраа дуугарган сууж байв. Тэр бүр гайхан дотроо

- Өвөө сохор шүү дээ! Юу ч юм хардаггүй гэж өөрөө ярьдаг. Гэтэл шөнө лааны гэрэлд ном уншина гэж байх уу? гэж бодож зогстол номынхоо хуудсыг эргүүлэн харж байснаа хажуу дэргэдээсээ бас нэг жижиг ном гаргаж хуудсыг сөхөн ээлжлэн харж тулган үзэж байв. Амархүү амандаа

- Ямар сонин юм бэ? Өвөө чинь худлаа сохор байх нь. Яг л тэмтрээд юмаа үздэггүй шүү дээ гэж бодоод хүрэн үрээнийхээ эмээлийг авах гэснээ болиод Их салааны эхэнд байх Дэлгэр ахынд очиж хорол тоглохоор мордов. Дэлгэрийнх арван таван хүүхэдтэй. Тэдний найм дахь охин Сэмбэрүүг нь Моломынх өргөж авсан. Үртэй хүн бүтэн жаргадаг гэж үгтэй билээ. Моломынх Сэмбэрүү охиныг үрчилж авах тухай хэлэлцэн сар өдрөө тогтоогоод шуудхан Дэлгэрийн хааяа дэрлэж бууж охиноо авсан тэр цагаас хойш тэдний хаяанаас салаагүй. Өдий болтол хаяа нийлэхийн учир хонь маллахаа болиод одоо ямаа малладаг болсон билээ. Дэлгэр нэг удаа

- Молом минь! Чи одоо өөрийн дуртай газраа бууж өөрийнхөөрөө яваач! Миний шороо шиг олон хүүхдүүдээс нэгийг нь үрчилж аваа л биз дээ гэхэд Молом

- Дэлгэр минь! Та намайгаа битгий хажиглаач. Би өөрт чинь нэг их түвэг учруулахгүй гэхэд Дэлгэр уурлангуйгаар

- Чамайг түвэг болноо гэж байгаа юм биш. Цаад урианханууд чинь намайг үр хүүхдээ хүнд өгчихөөд хаяандаа байлгаад хамжилгаа болгочих юм даа. Мөн ч айхтар хүн юм гээд л мэр сэр явган үг хэлж айлаас айл дамжин явж байна. Бодоод байх нь ээ тийм л юм даа гэв. Молом бодолхийлж сууснаа

- Би явган хэл амнаас айх юм алга. Бас тэгээд малын бэлчээр дагаж амьдрах дургүй. Охин үрийнхээ заяаг дагаж амьдаръя гэж шийдсэн хүн. Би ганц охиноо торгонд ороож, тосонд

умбуулж өсгөж чадна. Нэг үндэснээс салаалж ургасан олон жимсний нэгийг нь таслаж аваад би жаргалтай байна гэж өөрийгөө хуураад ч яах юм билээ. Охин үрээ өнчин ганц болгож өсгөөд ч яах юм билээ. Олуулаа байх ч хичнээн сайхан болохыг танай хаяа түшин элгээ дэвтгээж яваа манай хөгшин бид хоёр хоёулаа мэдэрсэн. Охиноо ах дүү нараас нь хөндийрүүлэхгүй тэдний дунд элэг бүтэн, сэтгэл дүүрэн өсгөө! гэсэн нэг муйхар бодлоороо зүтгэж яваа хүндээ гэв.

Моломын энэ үгийг сонсож суусан Дэлгэр дунд гарын харлаг манан хөөргөө хааяа хааяа үнэрлэж баруун гартаа эргүүлэн бодлогоширон сууна. Дэлгэрийн эхнэр Цэвээн сайхан алаг нүдэндээ сэтгэлийнхээ хайланг мэлтэгнүүлэн хэсэг болсноо алдаж асган мэлмэрүүлэв. Хүний сэтгэл гэгч хүлгэнд ордоггүй, хүсэлд захирагддаггүй, хүссэнээ хийдэг зоргоороо нэгэн бололтой. Молом урт гэгчээр санаа алдаад

- Ам нээвэл уушиг нээ гэдэг билээ. Ах эгч хоёр минь танай олон хүүхдүүд атга замбаа олдсон ч, алгын хичнээн ааруул байсан ч, аманд ч үгүй хамарт ч үгүй. Ганц ширхэг ёотон ч бүгд л арван тав хуваагдаж, арван таван ам хөдлөж сэтгэл нь дүүрэн жаргалтай байгааг нь хараад би амьдрахын үнэ цэнийг мэдэрч, амьдралыг хайрлаж хүндлэх болсон. Ийм аз жаргалтай амьдралын амин хэлхээнээс охиноо салгаж аваад явчихаж яахан болох билээ. Тийм амин хувиа хичээсэн арчаагүй сэтгэл надад даанч алга даа гэхэд Дэлгэр хөөрөгнийхөө толгойг сугалж нэг сайн үнэрлээд Моломд барингаа

- Дүү минь! Мунхаг ахыгаа өршөөгөөрэй. Холыг харж ойрыг сэтгэх ухаан минь дутжээ ахад нь. Чиний хэлсэн үг миний мэлмийг нээж, мунхагаас минь сэрээлээ. Энэ өдрөөс эхлэн энэ насандаа хаяа нийлж ханьсан жаргаж хамтдаа зовлон жаргалаа хуваалцаж амьдарцгааяа гэхэд Молом өвдөг сөхрөн хормой дэвсэж хөөргийг гардан аваад шүрэн толгойг нь эргүүлэн байж шимтэнгүй үнэрлээд

- Ахаа танд баярлалаа. Та охин үрээ хайрласан юм чинь сэтгэлээ юундаа харамлах билээ дээ гээд хүүхэд шиг гэнэнээр инээмсэглэхэд гал дээр буцлах гэж байсан тогоотой цай гэнэт дэврэв. Дэлгэрийн эхнэр Цэвээн сандрах болгондоо л “Буруу хойшоо “ гэж уулга алддаг хүн чинь энэ удаа яасаныг бүү мэд.

- “ Ээ Моломын үг буруу хойшоо “ гэж уулга алдав. Тэр гурав бие биерүүгээ харан гайхширч байснаа зэрэг шахам инээд алдав. Гэрт цалгисан инээд бүгдийг ариусган үрийн буяны садан улам батжин дэлгэрсэн юм гэнэ лээ гэсэн түүхтэй хүмүүс ээ.

Ийм л хоёр гэрээрээ зусах хот айлыг зорьсон Амархүү очоод тэднийг тоглоомонд уриалав. Тэд зургаа зургаагаараа гурван баг болон монголын үндэсний тоглоомын нэг Хорол наадаж хэн хамгийн олон гэр барих вэ? гэж хор шараа маажин хожигдсон нэг нь уйтайхан байхад хожсон нэг нь баярлаж хөөрсөөр байтал шөнө дөлөөр эхэлсэн шилбүүрийн сураар ороолгох мэт үе үехэн ширүүсэх шамарган бороо ч намдаж үүрийн гэгээ цайх үеэр Амархүүг гадаалахад унаж ирээд уяан дээр эмээлтэй хантайрагтай хүрэн үрээгээ цулбуураар уяж орхисон нь алга байлаа.

Тэр ихэд сандран эргэн тойрныг ажиглав. Нүдэнд торох бараа ч үгүй байлаа. Бороонд норсон цулбуурын сур суларч жихүүцсэн хүрэн үрээг нэг л зүтгэхэд уяа тайлагдан дуртай зүгтээ

явахад хялбар болсон байв. Амархүү айсандаа биш харин ичсэндээ ийнхүү тэвдэн сандарч байлаа. Үе тэнгийнхээ нөхдийн үгэн ташууранд оруулгуулахаасаа эмээсэн хэрэг билээ.

Дэлгэрийнх найман охинтой, долоон хүүтэй айл. Тэд дундаа хамгийн царайлаг,гоо үзэсгэлэнтэй төрсөн Сэмбэрүү охиноо Моломынд өргүүлсэн билээ. Амархүү дотроо ихэд эмээж элдвийг бодно. Молом тайжийн Сэмбэрүү гүнжийг зорьж очоод морьноосоо унаж явган хоцорсон Амархүү гээд шоглоод эхлэх байхдаа гэхээс яс нь хавгайна. Тэр үнэндээ тэвдэж байлаа. Хотгор газарт тогтсон борооны ус гатлан өмд гутлаа норгоно. Хорголын чинээ чулуунд бүдэрч унан өвдгөө шалбална. Налуу газрын борог өвсөнд хальтарч дээлээ шавардана. Хүрэн үрээгээ олох гэж их салааг уруудан гүйсээр баруун хамраар давж Дэлгэр салааг тэр аяар нь дурангаар нэгжив. Нүдэнд торох бараагүй. Тэр нэгэн өндөр хаданд гаран Бунханы салааг хөтлөөс нь уруудуулан нэг бүрчилэн тогтоон тольдов. Гэтэл Бунханы амны бунхан шарил байх орчимд нэг бараан юм хөдлөөд байх шиг болов. Амархүүгийн сэтгэлд горьдлого төрөв. Морио олчихвол мөн ч сайхнаа гэж амандаа шивнээд шил нь цоохортож хараа нь бүдгэрсэн муу дурангаа голон

- Надтай таарсан эд дээ. Энэ муу дуран гэж үглэн өвөртөө хийгээд бунханы зүг алхах, шогших хольж хутган чиглэв. Үүрийн гэгээ ч бүр алганы хээ үзэгдэхтэй болж ирэв. Амархүү ойртож ирээд сайн ажиглавал морь биш хүн байлаа. Түүнд дахиад муу бодол ороод ирэв.

Энэ үүр шөнөөр бунхан шарил ухаж байдаг муу ёрын хүн бас байна гэж бодоод бушуухан том хадны араар оров. Тэр нөгөө муулж голоод байгаа дурангаа гарган харав. Сайн ажиглалат хуц ухна хариулдаг Сагад мөн байлаа. Тэр дотроо мэргэн Сагад гээд байдаг хүн чинь ямар хачин нөхөр вэ? Хуучны ийм шарил бунхан ухдаг нь нэг л учиртай байх нь гэж бодсоноо сэмээрхэн дахиад харвал Сагад баруун энгэр өөд гартаа багаж юм уу? алив нэгийг барьсаар алхаж байна. Тэр удалгүй чөдөртэй мориндоо хүрээд цаашаагаа явж далд оров. Айх гайхах зэрэгцэн Амархүү хэрхэх тухайгаа бодон хэсэг суугаад босож бунхан шарил дээр очив. Бунханыг ухаж төнхсөн биш засаж сэргээгээд аятайхан болгосон байлаа. Амархүү

- Энэ хорвоо чинь эндүүрэл хуурмагаар дүүрэн болж байна уу? Хоёр нүд нь юм хардаггүй сохор гээд байдаг өвөө минь өчигдөр орой лааны гэрэлд номын үсэг үзээд сууж байсан. Гэтэл хорхойд хоргүй хуц ухна хариулдаг ядарсан амьтан гэгддэг мэргэн Сагад шөнө дөлөөр бунхан шарил сэргээж засаад явж байдаг ямар сонин юм бэ? гэж гайхаж байв. Амархүү бодсон санасан юмгүйгээр нэг л мэдсэн Бунханы өмнө сөхөрч суучихаад амандаа

-Эмээл хазаартай алдсан хүрэн үрээг минь надад үзүүлээч! Хаана байгааг нь хэлж айлдаач! гээд мөргөж байлаа. Удалгүй нар уулын оройд шар туяагаа илгээн мандав.

Амархүү Сангийн далай нуурын ар хөвөөг даган амгалан алхана. Түүний сэтгэл тайвширч хүрэн үрээгээ унаж яваа юм шиг бодол төрнө. Тэр хаашаагаа ямар хэрэг зоригоор яваагаа ч бүр мартсан байлаа. Ичиж айсандаа яахаа мэдэхээ больж тэвдэж сандарсандаа унаж босон ухаан самууран явсан хүн чинь юу болов гэмээр тайван амгалан болчихсныг өглөө эртэч бор болжморууд л гайхан шулганан жиргэж байв.

Тэр жаахан салааны ам татаалын усны хөлд байх багахан хадан толгой дээр гараад эргэн тойрныг дурандая гэж бодоод өврөө уудалтал хадан толгойн дор алив нэг чимээ гарав.

Амархүү ахин анхааран чагнавал юу ч эс сонсов. Тэр дурангаа гарган шар хөтлийн ар бие рүү хараа тавьтал хазаарын амгайн чимээ тодхон сонсогдов. Гэтэл морь амгайгаа хүлхэн хантайргаа суллах гэсэн юм шиг анир чимээ бүр тод боллоо. Амархүү ч яаран буухад хүрэн үрээ нь бороонд уруудаж ирээд нөмөрдөж зогссон ч цулбуур нь хоёр ургаа чулууны завсарт хавчуулагдан уягдсан байлаа.

Амархүүгийн толгойд олон бодол эргэлдэнэ. Тэр итгэж үнэмшиж өгөхгүй байлаа. Гэтэл яах аргагүй Сагадын засаж сэргээсэн бунханд мөргөж гуйсны учир хүрэн үрээгээ олсон нь үнэн билээ. Хоёр хоногийн дараа айлаас айлд, амнаас чих рүү нэг сонин хачин яриа явж байлаа. Манайхан хөөрөг зөрүүлж мэнд мэдэж сонин хачиныг сонсохдоо ч юм уу? эсвэл аяга цай уух зууртаа ам хуурай байлгахгүй гэсэндээ ч юм уу?

- Бунханы салааны аман дахь бурханыг сэргээгээд чулуу шороог засаад сайхан янзалчихсан байх юм. Ямар буянтай нь ингэдэг байна гэж байхад зарим нь

- Энэ нэг л учиртай шүү! Ямар гэгч хүний бунхан юм бүү мэд. Хүнд үзэгдэхгүй засаж сэргээгээд байгааг бодоход үр сад нь ирж байна даа. Хэн байж болох вэ? гэж оньсого таах мэт толгойдoo бясалгаж байхад нөгөө нэг нь

- Хэн тэгэж хар толгой, халуун амиараа дэнчин тавьдаг байна. Тэр хүн ч мэдэгдвэл маргааш баривчлагдаж нөгөөдөр цаазлагдах биз гэж шивнэлдэж байв.Өөр нэг нь

- Энэ хуучин бунхан сэргээгээд байгааг зүгээр орхиж болохгүй. Нам засгийн бодлогод нийцэхгүй байна. Дарга нарт дуулгах нь зүйтэй байх гэсэн туйлширах нэгэн ч байлаа. Хүн бүр л дотроо нэгийг бодож байхад дээд хүмүүст алтан хошуу аль хэдийнээ хүрсэн байв. Хэн нэгэнд өнгөрч баларсан юмыг сэргээж хуучинсаг үзэл бодлыг түгээх гэсэн далд санаа байгаа байх гэж үзээд хэн үүнийг үйлдэн буйг мэд! гэсэн шийдвэр гарч далдуур тандан мэдэх туршуул ч тохоон томилогдсон нь нууц байв.

Хүмүүст зөн совин гэж нэг айхтар мэдрэхүй байдаг. Бунханы салааны аман дахь булш болсон бунхан дахин сэргэсэн тухай ил цагаан яригдахаа больж зөвхөн дотроо бясалгадаг болсон билээ. Хэн энэ бунханыг сэргээснийг ганцхан Амархүү л мэднэ. Хэнийхний удам угсааны шарил бунхан болох хэн түүний үр сад вэ? гэдгийг хэн ч мэдэхгүй. Харин сохор Балбар хэмээх өндөр насыг зооглосон баруун гараасаа эрхээ салгадаггүй, нүдтэйгээ адилхан хэл нь гацчихсан юм шиг дуугардаггүй энэ өвгөнийг зөнөг залгасан гэж зарим нь үзнэ. Балбар Галсангийн эцэг Амархүүгийн өвөө нь билээ. Балбар өвөө нэг өдөр ач хүү Амархүүгээсээ

- Тэр бунханы салааны амны бунханыг сэргээсэн байна гэв үү? гэж асуухад Амархүү өвөөгөө ажигласнаа

- Тийм байна лээ. Их сайхан болгосон юм билээ гэхэд Балбар их л сонирхож байгаа бололтой

- Хэн түүнийг сэргээсэн бол гэхэд нь Амархүү аман дээрээ Сагад гэж хэлэх гэснээ болиод

- Хэн мэдэх билээ. Нэг л мэдэхэд л янзалчихсан байсан гэхэд Балбар бодолхийлж байснаа амандаа

- Бавуу гэж байсан. Ганц л хүүтэй шүү дээ гэж амандаа бувтнахад нь Амархүү

- Өвөө та Бавуу гээд юугаа яриад байгаа юм бэ дээ? гэж асуухад Балбар өвөө нь

- Тэр бунханыг Бавуу л сэргээхээс биш өөр хэн ч хүрч чадахгүй дээ гэж хэлэхэд Амархүү дотроо

- Өвөөг зөнөг залгасан гээд байдаг нь үнэн бололтой. Бавуу мавуу гээд бүр дэмий чалчаад эхэллээ. Нас өндөр болох ч үнэндээ хэцүү юм даа гэж бодсоноо хоромхон зуур дурдаад авав. Тэр өвөөтэйгээ ярилцсанаа нэг дурсаад авсан ч бодол нь бунханы салааны аман дахь бунхан шарилыг тойрон эргэлдсээр байлаа

Долоо

Амархүүгийн бодлын хэлхээ Хөхцэцэгээс эхлэн хөвөрсөөр энэ нутгийн хүмүүс мэдэхийг хүсэж байлаа ч мэдэж чадаагүй хоёр нууцыг мэдэхийн учир ийнхүү эргэн нэг санав. Хоёр жилийн өмнө болсон эл явдлыг Амархүү бүтэн хоёр жил хадгалж хааяа хааяа өөртөө дурсан битүүлэг учрыг нь олохсон гэж мөрөөднө. Тэр наадмын дэвжээг тойрч явсаар Хөхцэцэгийн ангийнхан дээр хүрээд ирэв. Амархүү тэднээс хоёр ангийн дээр хоёр насаар ах учир тэд нар

-Та сайхан наадаж байна уу? гэж мэнд мэдэн билгийн үг солилцов. Ганцхан Нарангарав л амаа үдүүлсэн аятай ганц үг ганхийсэнгүй нь тун сонин санагдана.

Тэр яхир Балдангийн ганц охин. Эрх дураараа элбэг хангалуун өссөн нэгэн. Тийм болоод заримдаа хачин авир ааш гаргана. Олон ааштай эрхийн мангар гэж өөлж байхад өөр нэг нь яхир Бааяад бурханаас заяасан ухаантай сэргэлэн, өнгө зүстэй, үзэсгэлэн гоо төрсөн охин гэж магтана. Үнэндээ ангидаа юм юмаараа Хөхцэцэгийн дараа орно. Тэр бас хор шартай, хэний ч дор орох дургүй. Тиймээс биеэ их дайчилж бүтээх чадвар өндөртэй билээ. Түүнд аавын авир ааш их нөлөөлнө.

Балданг холын нутгийнхан Балдан гуай гэнэ. Ойр орчмынхон яхир Бааяа л гэнэ. Тэднийх байнга ганц гэрээрээ өвөл зунгүй айл саахалтаас зайтайхан бууна. Ойр орчмых нь бэлчээрт хүний адуу мал ороод ирвэл чоно үзсэн аятай хөөж тууна. Хэн хаана юу хийж явна хардаж сэрдэнэ. Сэтгэлд таарахгүй үйл мөр байвал шударгаар дээд дарга нарт мэдэгдэж орхино. Тэр үүнийгээ хов зөөж байна гэж ер ойлгохгүй.

-Би хүний мууг үзэх гээгүй. Харин муу муухай явдлаас татаж авч тус хүргэж байна гэж үзнэ. Баг, сумын хурал дээр Балданг босоход хүмүүс илт эмээж зарим нэг нь бүр навтайтал нуруугаа бөхийлгөнө. Балдан

- Надад нэг хэлэх юм байна гэж хэлээд босож зогсчихоод хэсэг чимээгүй болон эргүүлж тойруулан хүмүүсийг харж шинжих мэт болно. Энэ үед чив чимээгүй болж хүмүүс зөвхөн өөр өөрийнхөө зүрхний цохилтыг л мэдэрнэ. Хааяа хар батгана дүнгэнэх нь байлдааны онгоц шиг сонсогдоно. Тиймээс яхир Балдангаас хүн бүр жийрхэнэ. Балдан нэг удаа багийн хурал дээр босож зогсчихоод бүгдийг эргүүлж тойруулж ажиглаж байснаа төвөөс ирсэн хэсгийн төлөөлөгч дээр харцаа тогтоогоод

- Манай багийн ядуухан амьдралтай олон бүлтэй айлын нэг энэ Чоймболынх мөнөөс мөн л дөө. Хөөрхий минь амьдрахын эрхээр юм байлгүй нэг янгир унагаажээ гээд Чоймболыг заахад тэр учиргүй навтайж толгойгоо бөхийлгөжээ. Тэгтэл Балдан

- Чоймбол оо чи өндийгөөд суу. Үнэний өмнө бөхийх байсан юм бол юундаа тийм хэрэг өдөөсөн юм бэ гэж зэмлээд бусдыг дахин нүдээ эргэлдүүлэн харснаа

- Хөөрхий дөө надад шорлог болгож нэг хаа махыг нь өгсөн. Би түүнийг нь аваад сумын төв рүү шогшиё доо гэж бодож байтал сайн хүн санаагаараа гэгчээр төлөөлөгч та өөрөө хүрээд ирлээ. Баримт хэрэгтэй бол тэр хаа манай бага гэрт байгаа шүү гээд суулаа. Хуралд суугаа

хүмүүс хүчтэйхэн амьсгалахаасаа ч айж байлаа. Бригадын дарга Санж дотроо

- Энэ Балдангийн учрыг олохгүй юм даа. Нэг бол шулуун шударга хүн шиг, нөгөө бол хүний ул мөр шагайсан өөдгүй золиг юм. Манай Цагааны хэлснээр царай нь бараан хар гэж бодсон чинь сэтгэл нь хөө хар юм байна гэсэн юм гэнэ лээ. Тэр л үнэний ортой боллоо гэж бодоод хоолойгоо засаж чимээ эвдээд

- Өөр санал шүүмжлэл хэлэх хүн байна уу? гэхэд хэн ч дуугарсангүй. Харин сумаас ирсэн хэсгийн төлөөлөгч

- Надад хэлэх юм байна. Бид нам засгийн бодлого шийдвэрийг маш шуурхай хүргэж бас биелүүлж байх үүрэгтэй. Нөхөр Чоймболын буруу үйлдлийг шалгаад хууль дүрмийн дагуу зохих мөнгөн торгуулыг ноогдуулах болно. Уг мөнгөн торгуулыг гуч хоногийн дотор улсын орлого болгосон байх ёстой. Эс гүйцэтгэвээс баривчлан хорих ялыг биеэр эдлүүлэх болно. Та бүхэн ийм буруу явдалд уруу татагдахгүй байхыг анхааруулья. Нам засаг Балдан шиг шударга иргэнээрээ бахархаж байдаг юм гээд суув. Хурал дахиад л нам гүмд эзлэгдэв. Гэтэл яхир Балдан

- Надад нэг хэлэх юм байна гээд босоод ирэв. Хүмүүс чимээ аниргүй болон дор бүрнээ

- Сая төлөөлөгч Балданг магтаад нам засаг бахархаж байна гээд хөөргөж сэтгэлийг нь доргиосон. Одоо юу хэлж манийгаа балладаг бол доо гэж бодож суув. Балдан мөн л эргэн тойрныг ажиглаж байснаа

- Манай Чоймбол яахаа алдсан ядруу хүн биш ээ. Ухаалаг уужимхан сайхан сэтгэлтэй нэгэн. Нэг гэм нь жаахан залхуудуухан л хүн. Төр засгийн хууль гэдэг чинь бидний төлөө л үйлчилж байдаг. Тэр торгууль шийтгэлийн мөнгийг нь даруйхан төлж барагдуулах хэрэгтэй. Би Чоймболдоо сайхан сэтгэлээсээ тусалж тугалтай үнээ нэгийг өгье. Гадаа зэлэн дээр байгаа маяг тугалтай хүрэн үнээг зүсэлж аваарай гээд суув.

Хэсэгхэн чимээгүй байснаа хурал амь орсон мэт шуугилдан хүмүүс ээлжлэн босоор Чоймболдоо туслах аян өрнөсөөр ишигтэй ямаа, нэг төлөг, байдсан гүү гэх мэтээр сайн санааны дэмжлэгээр Чоймболынх бод бог бүдүүн жижиг нийлсэн гучаад малтай болчихлоо. Яхир Балдангийн энэ өдөөсөн үйл мөрийг ухаж ойлгох, учрыг нь тайлах гэсэн бодол хүн бүрт хөвөрч байлаа.

Аймшиг айдсаар эхэлсэн бригадын хурал эцэстээ инээдэм баяр хөөрөөр дүүрч өндөрлөв. Хурал гадаалахад яхир Балдан хэсгийн төлөөлөгчид хандан

- Төлөөлөгчөө та манайхаар айлчлан ангийн мах амтлаад явна уу гэж урихад төлөөлөгч нүдээ томруулан гайхан харахад нь Балдан

- Та бид хоёр ямар нударх гэж байгаа биш дээ. Болчихсон идээ ундаанаас болгоогоод яваач гэсэн монгол хүний л ёс заншил юм даа гэхэд хэсгийн төлөөлөгч муухан инээмсэглээд хойноос нь дагасан гэдэг. Балдан хожмоо нэг удаа

- Би Чоймболдоо нэг тус болохсон гэж бодож явдаг байсан. Түүнийгээ л гүйцэлдүүлсэн төдий хэрэг гэж өгүүлсэн юм гэнэ лээ гэсэн түүх бий. Амархүү сэтгэлдээ дээдэлж хайрлаж явдаг Нарангаравыгаа мэнд мэдсэн мэдээгүй нь хамаагүй гагцхүү сайхан царай, үзэсгэлэнт төрхийг нь харваас сэтгэл нь дүүрдэг билээ.

Тэр өчигдөр морины бариан дээр уулзаж учран гарыг нь барьж чадсандаа баяртай байгаа билээ. Нарангаравараа өртөөлөн аавынх нь тухай багахан нэгэн дурсамжийг сая сөхсөн нь энэ юм.

Амархүү Хөхцэцэгт урмын үг хэлье гэж бодож байсныг бид мэднэ. Нар, тэнгэрийн өнгөөр түрүү магнайн морины зүсийг хэлсэн нь үнэхээр гайхамшиг билээ. Тэр хүний оюун ухаан юутай агуу болохыг сайтар мэдэрсэн. Бас хоёр жилийн өмнө Бунханы амны бунханд мөргөөд алдуурсан хүрэн үрээгээ унаж яваа мэт сэтгэл төрөөд тэрхэн зууртаа учирснаа ч одоо болтол ид шид мэт бодож далдуур Сагад мэргэнийг шүтэн дээдэлж явдаг Амархүү Хөхцэцэгт хандан

- Их баярласан шүү. Хөхцэцэг ээ. Түрүү морины өнгө зүс яг таарсанд гэхэд Хөхцэцэг инээмсэглээд

- Түүнд баярлаад байх юу байна. Нүдэн дээр байгаа юмыг хэлсний төлөө шүү гэхэд Хөнхий дэргэдээс нь ярианд оролцож

- Хөхцэцэг ч хөгшин хөвөөгүй хүмүүсийг соронз аятай өөр дээрээ татаад байх далдын увидастай юм аа. Сая түрүүлсэн морины эзэн Намжил ах ирчихээд толгойгоо өвдгөндөө хүртэл бөхийлгөөд

- Баярласан шүү Хөхцэцэг ээ. Ах нь дүүгээ нэг баярлуулна гээд л ам хэлээ олохгүй шахам янз бүрийн ойлгогдохгүй юм яриад байсан. Гэтэл Амархүү өдөр болгон ирээд алив нэгийг асуугаад байгаа юмуу? Алиалаад ч эргүүлээд ч байгаа юм уу ам руу нь орчих шахан баярлалаа гээд байх нь нэг сониндоо гэхэд Хөхцэцэг

- Хөнхий чи болиоч дээ. Дандаа л юмыг хэтрүүлж шоглож байх юм. Наад ам хамраа жаахан хамжааргатай байлгаач гэхэд Хөнхий инээд алдаад

- Ам хамар нь гүйцэгддэггүй, ааш зан нь олддоггүй Нарангарав маань юу болчихоо вэ? гэж Нарангарав руу үг нь муруйж ирээд өдөж хатгав. Нарангарав Амархүүгээ бодоод түүний амгалан царайг хараад алс холын амьдралыг бясалгаад зогсож байсан учир чимээгүйхэн бодолдоо нялхарч байсан юм. Гэтэл Хөнхийгийн үгийг сонсоод тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх билээ гэдэг шиг дуугаа өндөрсгөн

- Эр хүн байж эм хошуулна. Ээжийнхээ өврөөс гараагүй эрэг духт минь дуугүй байгаарай гэхэд бусад нөхөд нь нирхийтэл инээлдэв. Хөнхий, Нарангарав хоёр ах дүү хоёрын хүүхдүүд. Яхир Балдангийн дүү Балганы хүү нь Хөнхий билээ. Нас чацуу нэг ангид сурдаг, байнга л бие биенээ давах гэж явдаг хоёр. Харин өөр хоорондоо эвтэй найртай аргагүй л ах дүүсийн хүүхдүүд бүл хүмүүс гэдэг нь үе үе их тод илэрнэ. Нарангарав нэг удаа савлуураас гараа алдаж унаад цөөн хором ухаан санаа нь самуураад муужран унахад Хөнхий

- Нараа минь ээ. Би одоо яана аа гээд мэгшин уйлж байлаа. Нарангарав ч ухаан санаа нь сэргэж босч ирээд мэгшин уйлж байгаа Хөнхийгөө хараад
- Хөнхий чи яачихсан юм бэ? гээд тэвэрч аваад чангаар дуугарч уйлахад нь Хөнхий нь мөн л тэвэрч аваад дагаж чангаар уйлалдсан инээдэмтэй явдал болсныг ангийнхан нь үе үе дурсаж инээлддэг билээ. Энэ удаа Хөнхий Амархүүг гоочлон өөлж үг хаяхад Нарангарав Амархүүг өмөөрч эхлэхийг гадарласан Хөхцэцэг уран арга сэдэж ярианы сэдэвийг өөрчлөхөөр шийдэж
- Би та нарт нэг асуулт тавья. Зөв хариулсан нь шагналтай шүү гэхэд Хөнхий
- За тэгье. Бүгдээрээ анхааралтай сонсоорой. Хүүеэ чимээгээ намдаач гэж бусдыгаа уриалахад Содхүү, Минжин, Сэмбэрүү нар ч дэмжин
- Чимээгүй болоорой найзуудаа хэмээхэд тэд анхаарлаа Хөхцэцэг рүү хандуулав. Тэр бүгдийг эргүүлж тойруулан хараад
- Тэнгэр ямар өнгөтэй вэ? гэсэн асуулт тавив. Хүүхдүүд дор бүрнээ бодолхийлж байснаа дээшээгээ тэнгэр өөд харна. Хөнхий эхлээд
- Тэнгэр хөх өнгөтэй. Хааяа нарны туяанаас болоод улаан, шаргал болж харагддаг гэхэд Минжин шуудхан
- Цэнхэр гэвэл илүү сонсголонтой сонсогдоно гэхэд Содхүүд өчигдөрийн түрүүлсэн морины зүс санаанд оронгуут
- Би олчихлоо гэж баярлан хэлээд тэнгэр хээр өнгөтэй гэж тод хэлэхэд нөхөд нь нирхийтэл хөхрөлдөв. Тэр гайхан
- Та нар юундаа хөхөрсөн юм бэ, Өчигдөр өглөөний тэнгэр хээр өнгөтэй байсан шүү дээ гэхэд алив нэг юманд барагтай бол дуугардаггүй Жамьянмядаг
- Хээр гэдэг чинь өнгө биш ээ. Адууны зүс байхгүй юу гэхэд Хөнхий эвэртэй туулай үзсэн аятай нүдээ дүрлийлгээд
- Өнөөдөр чинь ямар гээчийн сайн өдөр юм бол доо. Аргагүй юм байна. Улсын баяр наадам, сумын гучин жилийн ой болж байгаа шүү дээ гээд эргэн тойрноо харан дэмжлэг авах санаатай маасайтал инээхэд Нарангарав
- Тэнгэр өнгө ч байхгүй, зүс ч байхгүй. Энэ үнэн биз дээ Хөхцэцэг ээ. Энэ нөхдөд үнэн гээд миний найз чанга хэлээд өгөөч гэв. Хөхцэцэг инээмсэглээд
- Нараагийн хариулт зөв гэж итгэлтэй хэлэхэд Амархүү ганцаараа алга ташиж байснаа гэнэт болиод ичингүйрэн тонгойв. Нарангарав ийм л адтай нэгэн билээ.

Найм

Энд үе тэнгийнхэн ийнхүү Хөхцэцэгийг тойрон хөгжилдөж байхад морьд морьдын уяаг эргэсэн уячид энэ жилийн наадмын дааган морины уралдаанд баян ходоод болсон хээр даага дээр бөөгнөрөн толгой хүзүүнээс нь эхлээд борви сүүлийг хүртэл нэгд нэгэнгүй шинжицгээж байлаа. Нас насандаа айргийн тавд давхисан хурдан хүлгүүдийг цоллох агшин хором хормоор ойртсоор байв.

Энэхүү хурдан ажнай хүлгүүдтэй ганцхан баян ходоодны даага цолуулдаг нь уралдсан бүх хурдан хүлгүүдэд хүндэтгэл үзүүлж буй сайхан ёс заншил байдаг. Баян ходоодны даагны гадна хэлбэр галбирыг нь шинжинэ. Морьдын хэлбэрийг ерөнхийд нь зургаан бүлэгт хуваана. Бүдүүн, хурдан гоо, хатан хараа, бор тураг, хулан хараа, чонон хүлэг хэмээдэг. Адуучин Лутаа хээр дааганд ойртон очоод

- За би та нөхдөөсөө асуугаад байя. Та бүхэн хариулаад байгаарай. Хээр дааганы нүдийг нь хэлээрэй гэхэд зарим нь

- Ширүүн гэж байхад нөгөө нь тийм ээ тийм ширүүн гэж байлаа. Лутаа

- Зөв өө. Одоо магнайг хэлдээ гэхэд аварга уяач Тулга том амаа алгаараа шудраад

- Ийм магнайг зузаан л гэнэ дээ гэхэд Лутаа

- Үнээн. Тулга ахаа сүвээний хавирга гээд заахад Тулга хоолойгоо засаад

- Сүвээний хавирга матаастай тэлүү юм. За тэгээд хас нь дүүрэн, салтаа уужуу, зоо нуруу нь бөхтөр сайхан галбиртай адуу юм даа гэхэд Галсан үг нэмж

- Хүзүү нь нарийн урт, сүүл нь эрчтэй, хөл эрс шулуун байгааг хараа. Энэ даага ирэх жилийн наадамд түрүү магнайд тоосоо өргөж мэднэ гэж бэлэгшээхэд Тулга уяач

- Хээр даага ч хэлбэр хийц, үнэн шинжээрээ бол хурдан ажнай мөн шүү. Энэ жилийн тухайд идэш хоолыг нь тааруулаагүй бололтой. Хоёр гурван хоногийн өмнө болов уу борзонтой шороо долоолгоод зайлуулснаас болж дээ гэхэд эзэн болох Сүх хэмээх залуу ихэд гайхан

- Тулга ах аа та яаж мэдэв ээ? би засах гээд чадаагүй юм аа гэхэд Тулга инээмсэглээд

- Тэр амаргүй. Бараг долоо хоног нухалдана шүү дээ. Харин ч суучихаагүй нь их юм гэхэд Сүх урамгүйхэн

- Тэгээд заавал баян ходоод болдог нь ч юу билээ дээ гэж голонгуй маягтай хэлэхэд Галсан

- Баян ходоод гэдэг чинь тийм ч олон тохиолдоод байдаг цол биш дээ. Ирэх жилийн түрүү магнай л гэсэн үг. Голох биш бэлэгшээж бай залуу минь. Морь уяж уралдуулна гэдэг чинь дуртай аавын хүү унтаж идэж байгаад хийчихдэг амархан ажил биш ээ. Их юм мэдэж сурах хэрэгтэй гэж сургамжлав. Гэтэл чанга яригчаар

- Хүндэт наадамчид аа. Сумын наадмын хамгийн торгон агшин ирлээ. Уяач нараа. Айргийн тавд хурдалсан хурдан морьдтойгоо төв асрын өмнө төрийн далбааны дэргэд ирнэ үү гэж урин залав.

Наадмын торгон дэвжээг наадамчин олны сэтгэл оосор бүчгүй орд харшийг бүтээнэ. Наран баруун хойшоогоо Алаг хайрхан уултай ойртон ханьсана. Сүүдэр зүүн урагшаагаа уртадсаныг хэн ч үл анзаарна.

Гагцхүү баяр наадмын хүчит бөхчүүдийн үзүүр түрүүний барилдаан, айргийн морьдын цолыг сонсох гэж ертөнцийн цаг нарыг мартана. Алаг зүсмийн морин дээр хазгайдуухан суусан морь цоллооч Цэрэндаш хэмээх нуруулаг, өндөр хамартай улаан шар царайтай хүн уянгалаг хоолойгоор

- Бүрэн эрхэт Монгол Улсын үндэсний их баяр наадам, Бугат сумын гучин жилийн ойн баяр наадамд уралдсан

Шандаст хурдан хүлгүүдийн дундаас

Шалгаран цойлон манлайлан түрүүлээд

Алдар цолоо дуудуулж буй

Агсам хурдан хүлэг болбоос

Намжил уяачийн унаган адуу

Шар хээр морь минь уу зээ гээд л цааш нь амьсгал нь зохирч аялгуулан дуудав. Наадамчин олон түмэн тун ч тааламжтай сонсголонтойёо сонсоно. Цоллооч амьсгалаа засаад шар хээр морины алтан жолоог улам өргөсхийгээд

Урт сайхан чихтэй

Уужим өргөн магнайтай

Дун бүрээ хамартай

Дуран хар нүдтэй гээд л галбир хийцийг нь гайхалтай сайхан дуудаад дөрөөндөө босож төрийнхөө алтан соёмбот далбаа өөд харж хүндэтгэл үзүүлээд

Бат төрийн сүлд

Энх төрийн манлай

Түмэн эх

Торгон жолоо гэж аялгуулан шуранхай өргөөд эмээлдээ сууж төв асар болоод наадамчин олныг нар зөв эргүүлэн алтан жолоогоор нь хурайлах маяг үзүүлээд

Баяр наадмын чимэг

Баг идэр олныг баясгагч

Хуйлран шуугигч

Хурднаас хурдан хүлэг ээ гээд цоллоход хүүхэд залуучууд алгаа нижигнэтэл ташиж хөгшид нь ханцуйдаа алгаа дэлгэрүүлж амандаа ерөөл баг оршиг гэж бэлэгшээж сэтгэлдээ хурайлж байлаа.

Үзүүр түрүүний хоёр бөх үзүүштэй уран мэхийг уралдуулан хүч бярыг шавхан барилдаж наадамчин олноо баясгаж алдар цолоо дуудуулав.

Монголчууд хүчит бөхчүүдийнхээ уран мэхэнд нь урамшиж, бяр тэнхээнд нь баясаж, сэтгэлдээ баяр цэнгэлийг олдог бол бас хурдан ажнай хүлгүүдийнхээ тоосноос хүч тамирыг авч сүлд хийморио дэлгэрүүлдэг сайхан ёс заншилтай билээ. улсын баяр наадам, сум байгуулагдсаны гучин жилийн ойн арга хэмжээ сайхан болов. Наадамчин олондоо сумын намын үүрийн дарга Намхай баяр наадмын үйл ажиллагааг дүгнэж хэлээд маргааш хүлээж байгаа ажил төрлийг дурсаж сануулаад бүх наадамчиддаа эрүүл энх, аз жаргал, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөгөөд баяр наадмын үйл ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв. Чанга яригчаар

Дэлгэсэн шагай шиг дэлгэрсэн

Дэнж хотойлгож хотгор дүүргэсэн

Сум эвшээлгэж сур элдсэн

Сумын наадам сайхан боллоо гэж эр хонгор дуугар эгшиглүүлэхэд эм цээлхэн хоолойгоор

Хөхөл даахин титэмтэй

Хүй цөглөсөн сэнтийтэй

Хүрэн алаг уул

Бидний нутгийн шүтээн

Алд биетэй уягдаж

Амин судлаар аргамжаалагдсан

Алаг хайрхан уул

Бидний төрсөн нутаг

Нар зөв эргэсэн

Нүүдлийн дөрвөн жимтэй

Хөх усан угалзтай

Хөөмий эгшигэн салхитай

Буман сүрэг налайсан

Буурал өвгөдийн өлгий

Бугат нутаг сайхан хэмээн дуулаад хоёул нийлэн

Юу санасан есөн хүсэл тань бүтэх болтугай

Аяны тань алтан шар зам өлзийтэй байх болтугай гэж билэгийн үгээр үдэв.

Бүтэн хоёр өдөр нуурлан чуулсан наадмын дэвжээ далай тэнгис давалгаалах мэт долгион хөдөлж байв. Алаг хайрхан уулын сүүдэр Улаан хайрхан руу уртдан тэмүүлнэ. Зуны халуун зохирч сэрүүвтэр зөөлөн салхи үлээнэ. Олон агт морьдын туурайд исгэгдсэн таана хүмүүл, өвс ногоо шөнөдөө тамир авч өдөртөө эдгэж сэргэнэ.

Тэнгэрийн баруун хаяанд бөөн үүлс хуралдах нь харахад хол боловч шөнөдөө бороо орж хур буухыг зөгнөнө. Баянголын эхэн болох баян бүрдтэй сумын төв рүү арван зүгээсээ урсаж ирээд хуран чуулж наадсан наадамчид дэлбээгээ дэлгэн дэлгэрч байгаа цэцэг шиг ахиад арван зүгтээ салаалан ургах мэт асгаран дэврэх аятай аажимхан одоцгооно.

Хоёр хоёроороо дөрөө харшуулан мөр шүргэлцэн яваа нь хос эгшгээр уягдсан амраг сэтгэлүүд байхад дөрөв таваараа уварч цувран хойно урдаа орон яваа нь айл гэр, ам бүл, ахан дүүс бол арав хориороо хөгжилдөн хөөрцөглөж уран үгс урсгаж, уянга дуу эгшиглүүлж завсар газар цуварч, задгай уужимд цугларах нь анги бүлэг, гол ус, баг бригадаараа баясаж яваа нь тэр бөлгөө.

Жаргах нарны шаргал туяа Улаан хайрханы оройн ирмэг илгэн улаан шовх цохионд алтран туссан нь үлгэр домогт гардаг бурхадын орны үзэсгэлэнт сүмүүдийн оройн дээд алтан ганжир эрдэнийн чимэгтэй шашир нуруу мэт гоёмсогоор зурагдана.

Амар амгалангийн билэгдэл Алаг хайрхан араараа алтан нараа нууж өврөөсөө хорин тавны сарыг мандаана. Жилдээ ганцхан удаа тохиох улсын баяр наадмынхаа тухай бүтэн жилжингээ ярьцгааж дараа жилийнхээ наадамтай золгоно. Хүмүүний амьдрал ийнхүү тасралтгүй зогсохгүй мөнхөд үргэлжлэх ажээ.

Ес

Сур элдсэн сумын наадам өндөрлөхөд наадамчид сэтгэлдээ хүч тамирыг олж сүлд хийморио сэргээн хишиг буянаа хурайлсан гэдгийг хэлэх юун билээ. Тэд хоёр гурав, хэсэг бүлгээрээ дөрөө харшуулан сэтгэлээрээ ханьсан яваа бол Хашаатын ам өлгөн гал шарга морьтой нэгэн эмэгтэй яаруухан өгсөв.

Энэ бол Сагадын охин Хөхцэцэг байлаа. Тэр ар гэрийн ажил төрөл бас аавдаа санаа тавин яваа нь энэ. Тэднийх өндөр уулын хяр Өлзийтийн дэвсэгт ганц гэрээр зусаж байгаа билээ. Хөхцэцэг гэрээсээ гараад гурван ч хоног наадамдсан болохоор ийнхүү нутаг нуга, анги, дотнын найз нөхдөөсөө салан ганцаараа яваа нь түүний яарсан сэтгэлийг илэрхийлнэ. Хэрвээ хэн нэгэнтэй ханьсвал цаг хугацаа алдана. Алив нэгэн боломжоос хоцорно гэдгийг сайн мэдээд ийнхүү түргэн шулуун шуурхайгаа бодсон хэрэг.

Энэ жилийн зун сайхан болж хамаг үндэс бүхэн амилсан учир Хашаатын хөндий ч таана хүмүүл, хар цагаан шаваг, ширэг, дэгд, агь сайн гарснаас гадна дэрс шивээлж улам ч өндөр ургасан байлаа. Хөхцэцэгийн унаж яваа гал шарга морь хааяа дэрсэн толгой шүүрдэн шувтарч хазаарын амгайд хөг аялгуу нэмж толгой хаялан алхална. Хөхцэцэг эмээл дээр тэгшхэн суугаад элдвийг бодолхийлнэ. Наадмын хоёр өдөр найз нарынхаа хамтаар өнгөрүүлсэн үйл мөр үргэлжлэн эхлэл төгсгөлгүй эргэлдэнэ.

- Минжин гэнэт мориндоо ташуур өгөн ухасхийн давхиж байснаа үймэрч гомдсон сэтгэл нь уужирч хөөрч хөгжилдөн хойноос нэхэх нөхдөө хүлээхээр шийдээд мориныхоо амыг ангайтал татан явдлыг нь хорив. Унасан морь нь зүрх нь хөөрсөн бололтой хоёр тийшээгээ ам булаан толгой хаялан тогтож ядна. Тэр цайлганаар инээд алдаад

-Энэ хөх ногооны униартай хүмүүл таанын үнэр сэнгэнэсэн халуу дүүгсэн агаарыг хүлэг морьдынхоо хурдаар зүсэх сайхан байгаа биз дээ гэхэд Нарангарав мөн инээмсэглээд

-Тийм байна. Найзынхаа буянд сайхан салхи амталчихлаа гэхэд Хөнхий духныхаа хөлсийг арчингаа

-Ямар ч их халуун өдөр вэ? Нар ч ёстой нар гэдгээ мэдрүүлж байна даа. Минжингийн буян гээд байх нь юу л бол доо. Харин Содхүүгийн минь буянаар Минжин давхиж бид дагалаа шүү дээ гээд дахиад л нөхөд рүүгээ харахад тэдний хэн нь ч түүний саналыг дэмжсэнгүй. Зөвхөн хар батгана л дүнгэнэн морьдын толгой сүүлээр эргэлдэн тохуурхана. Минжин Хөхцэцэгт ойртож ирээд

-Хөхцэцэг ээ. Цаад Содхүүдээ миний найз битгий нүүр өгөөрэй гэхэд Хөхцэцэг

-Энэ юу гэнэ вэ гэсэн аятай Минжин рүү харснаа харцаараа Содхүүг ажиглавал тэр Нарангаравын морины жолооноос бариад баруун тийш нь даялуулан хөтөлж нөхдөөсөө зайдуу гарахыг хичээж байгаа нь харагдав. Хөхцэцэг энэ бүгдийг эрэгцүүлээд Минжинд хандан

-Чи чинь юугаа яриад байгаа юм бэ? Содхүү надад ямар хамаатай юм бэ гэхэд Минжин дөрөөн дээрээ өндийгөөд

-Хөхөө чи аяархан яриач. Цаад нөхөд чинь сонсчихвол би баларна шүү дээ. Ялангуяа Хөнхий бүр аюултай гэв. Хөхцэцэг толгой дохингоо

-Мэдлээ Минжин минь. Чи хэрэггүй юманд санаагаа бүү зовоо. Цаад Содхүү чинь чамайг л элдэвлээд байгаа биз. Эрчүүд чинь барилдахдаа цөөхөн мэхтэй мөртлөө авгай хүүхэн эргүүлэхдээ арван гурван мэхтэй гэж байгаа шүү дээ гээд инээд алдахад Минжин алгаараа амыг нь таглах шахан

-Ямар чанга инээдэг юм бэ? аяархан л даа гэхэд аль хэдийнээ Хөнхий сонсчихсон

-Инээхэд нас нэмэгддэг, харин уурлавал бие сэтгэл хямарч олиг болдог гэдэг. Айсан хүнд аргал амилна гэдэг бол ичсэн хүн хар хурдаараа давхидаг юм байна гээд марсайтал инээхэд Минжингийн уур дахин дүрсхийгээд явчихлаа. Тэр ийн огцом уурладаг. Заримдаа үзэг дэвгрээ шиднэ. Бас их уян зөөлөн юм шиг уйлж хайлна. Энэ удаа хацар чих нь улайгаад

-Хамрын дор хагархай гэдэг шиг чи л ганцаараа амтай нь юм уу? Чамд надаас өөр муу харагдах хүн алга уу? Үргэлжид намайг доромжилж байх юу юм бэ чи гэж чанга хэлээд мориныхоо амыг мурьж ирээд нуруун дундуур нь богинохон яргай ташуураар ороолгоод авлаа. Зуны халуун наранд шарагдаж бүгчим халуунд бачуурсан бололтой байдаг тэнхээгээрээ хашгирав. Их халж нягтарсан бүгчим агаар цалгисангүй. Тиймээс түүний энэ хашгираан зөвхөн хамт яваа найз нөхдөө л ихэд цочроов. Тэд Минжингийнхээ занг мэдэх учир бие биенээ харснаа эцэст нь Хөнхий дээр харцаа тогтооцгоов. Хөнхий ч өөр дээр нь бүгдийн зэм ирж буйг мэдрээд дотроо

-Би Минжинг өөлж баалаад байгаа юм биш юмсан. Харин өвчүүн дорхи өмгөр бор зүрхэндээ хайрлахын учир ойртож дотносож байгаа арга ухаан минь энэ билээ гэж бодож байхад Нарангарав өөрийн үеэл Хөнхийнхээ санаа бодлыг сайн мэдэх учир

-Юм гэдэг ч мөн сонин юм даа. Манай Хөнхий Минжингийн хойноос хөөцөлдөхдөө арга эвээ олохгүй элдвийн үг хэл татлаад түүндээ ороогдон Минжинд ад үзэгдэн бусад нөхдөөсөө зэм хүртэнэ. Гэтэл Минжин Содхүүг өөрийнхөө эрхэнд оруулж эрхшээлдээ байлгах гэж үйлээ үзэж тамаа цайж үстэй толгойгоо зулгааж үнхэлцэгээ хагартал уурлана. Нөгөө Содхүү нь Хөхцэцэгийн барааг харахаараа хөшөө чулуу шиг хөшиж орхино. Хөхцэцэг нь эд нарынхаа хэнийг ч тоохгүй бурханы нүдэнд үзэгддэггүй сэтэртэй хүлэг аятай сансарыг эзэгнэх мэт дүр үзүүлнэ. Хорвоогийн амьдрал чинь ямар аймаар юм бэ гэж бодно. Харин Хөхцэцэг өөрийг сэтгэнэ.

-Манай Минжинд ямар нэг олиг өвчин байна. Түүнээс ингэж амархан уурлаж гарт байгаа юмаараа хүн цохиж бас уйлж хашгирч байгаа нь жирийн нэгэн биш. Сургуульд байхдаа ч ийм их ууртай, уйламтгай омголон байгаагүй. Аравдугаар ангиа төгссөнөөс хойш өнгөрсөн хоёр жилд л зан ааш нь ийм болчихлоо. Аваас нэг асууя даа гэж бодно. Минжин бага зэрэг тайвширсны дараа

-Би сая яачихав аа. Яагаад Хөнхийг ташуураар ороолгов. Юундаа тэгтлээ чангаар хашгирав. Би Хөнхийгөө юунд нь цохив. Найз нөхдөө яах гэж цочоов гэх зэргээр олныг эргэцүүлнэ. Үнэнийг хэлэхэд Хөнхийгийн хэлэх үг яриа бүрт Минжингийн зүрхээр хатгаж сэтгэл нь сэмэрч уур нь хүрдэг билээ. Хүмүүсийн амнаас ам дамжсан нэгэн хов жив яриаг сонссоноос хойш түүний зүрх сэтгэлийг зүссэн гүн шарх үүссэн. Үүнд Хөнхий буруугүй боловч түүний хэлэх үг яриаг сонсоод л гал дээр тос нэмэх шиг уур хилэн дүрэлзэж эцэг эхийг нь үзэн ядаж хөмхийгөө зууж гараа чанга атгаж өс зангиддаг юм. Минжин үүнийгээ мэдээд

-Би чинь яагаад байгаа юм бэ гэж амандаа шивэгнээд өөрөөсөө айх шиг болно. Тэр нэгэн хар өдөр гэрийн хаяаны цоорхойгоор урсаж ирээд зүрхийг нь шархлуулж сэтгэлийг нь сэвтээсэн муу ёрын хов жив Минжинд үе үе бодогдож түүнийг хямруулна. Энэ удаа ч дахин бодогдов. Минжин аравдугаар ангиа төгсөхдөө сурлагаараа хоёрт жагсаж дуртай сургуулиа сонгосон билээ. Тэр гадаадын сургууль авах боломжтой байсан ч ээжийгээ бодоод Монгол улсын их сургуулийн физикийн ангийг сонгосон юм. Зуны халуун наран төөнөсөн бүгчим өдөр байлаа. Гэрийн сүүдэрт гудас дэвсэн ном шагайн суугаа Минжинд гэрт байх хүмүүсийн ярилцах нь тод сонсогдоно. Ээж нь хонины ээлжтэй учир түүнийг хүлээсэн үеийн хоёр бүсгүй цай уух зуураа ярих нь

-Манай Бумаа ч залуудаа үеийнхэн дотроо л хамгийн царайлаг нь байлаа шүү дээ гэхэд нөгөө нь

-Чааваас даа одоо л гэрт орж эм, гадаа гарч эр болж яваа нь энэ Сүрэн, Балсан хоёроос л болсон хэрэг шүү дээ. Сүрэн, Бумаа хоёр ч ихэр юм шиг л бие биенээсээ салдаггүй сайхан найзууд байсан даа гэхэд нэг нь

-Балсан ч гэж Балсан. Манай Бумаагийн хойноос үхэн хатан яаж явлаа даа. Гэтэл нэгийг нөгөөгөөр нь солиод инээдэмтэй юм хийгээ биз дээ гэхэд

- Хамаг хэргийн эзэн Сүрэн шүү дээ. Найзынхаа найз залууг яаж булааж чадав аа. Ёстой шившиг биз дээ гэхэд нөгөө нь

- Бумаа маань үнэндээ их гомдсон болохоор хэнд ч итгэхээ байсан шүү дээ. Ялангуяа эрчүүдийг бүр үзэн яддаг болчихсон юм. Тэгээд ч ганцаардмал зожиг болоод шөнөд уйлж унжин нойргүй хоноод охиноо бараг сар дутуу байхад нь хээр хонины бэлчээрт гаргачихаа биз дээ. Азаар Цагаан явж байж дайралдаад хоёулангийнх нь амийг аварсан даа гэхэд нэг нь

- Тиймээ. Бунханы хөтлийн баруун биед нөгөө Минжиннагво цэцэг ихээр ургадаг хонхорт шүү дээ. Хөөрхий минь. Тэгээд л охиндоо Минжин гэдэг нэр өгсөн юм шүү дээ гэхэд нөгөөдөх нь

- Манай Бумаа ч охинтой болсноосоо хойш өөр болж ёстой өөртөө эзэн болсон шүү. Одоо бол ажилтай төрөлтэй, ааль ааштай сайхан амьдарч байна. Би хөө өвгөндөө нэг дээл оёх санаатай. Тэгээд л Бумаагаар эсгүүлэхээс болохгүй байна. Хээтэй торго болохоор өөрөө чаддаггүй гэх яриаг сонссон Минжингийн сэтгэл сэмэрч зүрх нь зүсэгдсэн нь энэ билээ.

Минжин эл яриаг дахин дахин бодож тунгаасны эцэст хайрлаж хүндлэх хүнээ мэдэж авсан

бол ээжийнхээ дааж давшгүй зовлон зүдгүүрийг туулж элгээ хатааж сэтгэлээ алдаж асгасны буруутан хэн хэн болохыг ч мөн л мэдсэн билээ. Минжин бүтэн хоёр жилийн турш нэгэн зүйлийн тухай асуух гэсэн боловч зүрхэлж асуугаагүй билээ. Ээжийнхээ зовлон зүдгүүрийн аньж илааршаагүй байгаа сэтгэлийн шархыг сэдрээчихвий гэхээс тэр. Түүнийг эмзэглүүлдэг бас нэг юм бий. Бумаагийн Минжин гэх бүрт сонссон уншсан хэн боловч

- Өө ээжээрээ овоглосон юм байна гэж бодно. Нэг удаа түүний чихэнд

- Бумаа гэзэгтэйн охин гэж байх нь тун ч эвгүй соносогдож ихэд эмзэглэсэн билээ. Тэр цагаас эхлэн

- Надад аав заавал байх ёстой. Тэр хүн хэн бэ? гэж өөрөөсөө асуугаад хариулж үл чадна. Үүнийг мэдэх цорын ганц хүн бол ээжий нь билээ. Гэтэл ээжээсээ

- Миний аав хэн бэ? одоо хаана байна гэж нэхэх нь дэндүү тэнэг хэрэг байв. Мэсээр биш үгээр хүнийг үгүй хийдэг гэж ярьдаг шиг ээжийгээ үгүй хийж ч мэдэх энэ асуултыг асууж чадаагүйн учир энэ. Өөр нэг зовлон гэвэл Хөнхийгийн үргэлжид тоглоом шоглоомоор хэлэх үг нь өдөөд ч байгаа юм шиг эсвэл үнэнээ хэлээд ч байгаа нь мэдэгдэхгүй яриа Содхүүгийн хөшөө чулуу шиг хүйтэн царай, дүлий мэт дүнхүү байдал нь байнга уурыг нь хүргэнэ. Минжин Содхүүг үргэлж бодож түүнд сайн гэдгээ элдвээр илэрхийлэх боловч Содхүү түүнийг үл ойшоож Хөхцэцэгийг ширтэх нь үнэхээр инээдэмтэй. Найз нөхөд нь үүнийг мэдэж байсан ч тэр ичих булчирхайгүй аятай эрээ цээргүй гөлөрнө. Бусад нь түүнд сануулж хэлсэн ч үл тооно. Илжигний чихэнд ус хийсэн ч сэгсэрнэ, алт хийсэн ч сэгсэрнэ гэдэгтэй адил бөлгөө.

Минжингийн унаж явсан морь алив нэгнээс бусгахад тэр золтой л уначихсангүй. Харин элдвийн бодол бясалгалаасаа салж чадав. Минжин уртаар санаа алдаад найзуудаа харав. Тэд дор бүрдээ наадмын дэвжээг тойрсон олон үйл явдлууд дунд орсон бололтой мориныхоо толгой чихийг ширтэн зөөлөн алхаанд нь бүүвэйлэгдэх шахам явна.

Ганцхан Содхүү л уулын орой тэнгэрийн хаяа ширтэх мэт дээгүүр өлийн хараад хэлж болохын аргагүй царай гаргана. Анги хамт олон дундаа тэр ганцаараа битүү хэвээрээ байгаа билээ. Айлын өргөмөл хүү гэдгийг л мэдэхээс биш аав, ээж нь хаанахын ямар хүн гэдгийг хэн ч мэдэхгүй. Бас өөрөө ч ярихгүй. Өргөмөл аав, ээж хоёр нь тууврын мал хүргээд ирэх дээ л хүүхэд өргөөд аваад ирлээ гэснээс өөр тоймтой үүх түүх байхгүй билээ. Содхүү ингээд оньсого хэвээр үлдсэн ч хожмоо хэн болох нь тайлагдах биз ээ.

Ийнхүү бодол бясалгалаа хөлөглөсөн Хөхцэцэг гэрийнхээ барааг хараад баярлан дөрөөнд өндийж гал шарга мориндоо чуу хэмээн тушааж хондлойд нь ташуурын сурыг зөөлөн буулгав.

Арав

Сур элдсэн сумын наадмын сураг чимээ сонин хачин мэдээ гол ус, айл саахалт, хот айлаас эхлээд хоёр хүний дунд аяга цай уух зуурт өрнөж байхтай зэрэгцэн нэгэн чимээ сонор дэлдэж сэтгэл түгшээн түгэж байв.

Хамаг амьтан наадамдаж байхад харин Бунханы салааны аманд байх Бунхан шарилыг дахин сэргээгээд зогсохгүй түвд үсгээр маш хичээнгүйлэн бичсэн хөшөө чулуу нэмэгдсэн байлаа. Хаанахын хэн гэгч хүний үр айж ичихгүйгээр булш шарил сэргээгээд аймшиггүйгээр хар тамхи шиг хүний оюун ухааныг мунхруулагч шарын шашныг дэлгэрүүлэх санаа өвөртлөөд яваа нууц хүнийг мэдэхийг дээр дооргүй хүсэж байлаа.

Сохор Балбар гуай энэ бүгдийг сонсоод гайхширч сууна. Тэр сумын наадмын сонинг сонсохыг ч хүсэхгүй байлаа. Хэн гэгч бөх түрүүлсэн, хэний морь тоосоо өргөсөн нь түүнд ер хамаагүй. Харин бунхан шарилыг хэн сэргээв гэдэг чухал байв. Балбар ач хүү Амархүүгээ ирэхэд

-Амархүү өвөөгийнхөө оодон буурлыг авчраад эмээллэчих. Хоёулаа яваад Бунханы амны бунхан шарилыг нэг эргээд ирье гэлээ. Амархүү ч бүгдийг хэлснээр нь болгоод тэр хоёр Их салааны амнаас хөдлөв. Хэдийгээр зуны дунд сарын халуун өдөр байсан ч баруун хойноосоо санчигны үс хөдөлгөх төдий салхи Сангийн далай нуурын мандал долоож сэрүүсээд Балбар, Амархүү хоёрыг илбэх нь нэн таатай. Балбар өвгөн оодон буурал мориныхоо алхаанд бүүвэйлэгдэн бодлогоширно. Амархүү дотроо

- Тэр бунхан шарлыг сэргээсэн хүн бол Сагад мэргэнээс өөр хэн ч биш. Үүнийг би ганцаараа мэдэж байгаа. Сая сумын наадмаар Хөхцэцэг охиноо явуулчихаад шөнө дунд ирээд л үүнийг хийсэн байх. Энэ Сагад гуай яагаад энэ бунханыг сэргээгээд байдаг юм бол. Ямар нэгэн учир шалтгаан байж л таарна. Ер нь тэнгэрийн одод нар, сар байгаль дэлхийн үзэгдлийг уншина гэдэг амаргүй хэрэг. Гэтэл Сагад гуай бүгдийг уншина. Бүгдийг мэднэ. Гурван жилийн тэртээ Сагад мэргэн хоёр хоногийн өмнө хүмүүст учир битүүлэг цуу үг тараасан.

- Онын шовгорын ар цагаан дэвсэг дээр аянга бууна. Тэнд байгаа мал ахуйгаа гаднаа хурааж аваарай гэсэн гэнэ гээд л шивэр авир хэлэлцэж билээ. Зарим нь тоомжиргүйхэн хандаж

- Сайн сайн гэхээр сахлаа будав гэдэг болох нь шүү дээ. Ойрын хэд хоногтоо бороо шороогүй гэсэн. Ийм бүгчим халуун байхад түүний хэлснээр аадар цутгаж, аянга цахилгаан буух юм гэнэ гэж басаж бас тохуурхаж байхад зарим нь хэл ам татлахгүй чимээгүйхэн

- Юмыг яаж мэдэх билээ дээ хэмээгээд мал сүргээ гэрийнхээ ойр орчимд хурааж хямгадана. Гэтэл Чоймбол анчин залхуу ч гэх юм уу, хэнэггүй ч гэх юм уу мал ахуйгаа ч эмхлэхгүй байж байгаад хоёр хоногийн дараа тэнгэр гэнэт бүрхэн аадар цутган гялбаа гялалзаж аймшигтайгаар нүргэлэн дуугарч аянга цахилгаан цахиж цэнхэр гэрэл нүд сохлом гялбаж хүн амьтангүй айж дагжин чичрэв. Аймхай нэг нь амандаа маань уншиж байхад овсгоотой зарим нь авдраа уудалж Алтангэрэл, Жадамба судраа гарган аврал даатгал одуулж байв. Бурхан минь маргааш нь тэнгэрийн дуунаас ч аймшигтай чимээ айл бүрт сонсогдон амгаланг цочоов.

- Чоймбол анчины арван дөрвөн тоотой адуу цуварч зогссон хэвээрээ аянганд нэргүүлж ганц хар зүсмийн унага амьд үлдсэн байгааг өөр хоорондоо халаглан ярьцгаав. Энэ үйл явдлаас хойш Сагад гуайг мэргэн Сагад гэх болсон билээ. Хожмоо Сагад гуайгаас лавлахад

- Би Онын шовгорын арын цахир хадтай цагаан өлгий дэвсэгт хоёр хавх зүүсэн ухаантай юм. Маргааш нь оройн гарааны үеэр очиж эргэвэл нэг хавханд маань шар хээлтэй хөхүүл орсон байв. Энэ амьтан ч амины гарз юм даа гэж бодоод хавхнаас суллах санаатай ажиглавал нөгөө хөхүүлийн үс яг л зарааны үс шиг арзайж боссон байв. Гараа дөхүүлтэл гарын аясаар үс нь хөдөлж байв. Нөгөө хөхүүлийг хавхнаас мулталж тавихад тэр нүхээ олохгүй маанагтан харсан зүг рүүгээ гүйх аядаж байв. Нөгөө хавхан дээрээ ирэхэд тарвага нь гардгаараа гараад гишгээд оньс нь мултарчихсан мөртлөө хавх босоогүй байлаа. Араанд нь чулуу орсон юм болов уу гэтэл үгүй байв. Би хавхны гарнаас бариад газраас хөндийрүүлэхэд өөрөө босов. Хүнээс сонссон, ном судраас уншсанаа бодсоор байгаад учрыг олов. Энэ цахир хадтай цагаан дэвсэгт газрын асар хүчтэй цэнэг хуралдаж соронзон орон үүссэн болохыг мэдэв. Газрын хөрс хэт хуурайшиж халснаас цэнэг хуримтлагдаж бий болдог. Унтахын өмнө одод жагссаныг ажиглавал сар мичидийн тохиол хоёр хоногийн дараа болох нь магадтай. Лит тоолвол цагаагчин хонь өдөртэй харшилдаж байв. Энэ гурав ташааралдахад тэнгэр муухай аашилдаг нь нэгэнтээ томъёологдсон үнэн. Үүрээр босоод гадаалахад барууны зөөлөн салхинаас чийг үнэртэж байсан юм. Тэгээд л дуутай шуутай хүчтэй аадар бууна. Онын шовгорын цахир хадтай цагаан дэвсэгт хуримтлагдсан хүчирхэг цэнэг тэнгэрт үүссэн аянга цахилгааныг татаж мэдэх учир хүн амьтанд аюул учруулах вий гэж сэрэмжилсэндээ л нутгийнхаа ахан дүүст анхааруулсан төдий л юм шүү дээ гэж даруухан ярьсаныг Амархүү нэхэн дурсав.

Балбар өвгөн ач хүүтэйгээ Бунханы салааны аман дахь Бунхан шарилын дэргэд ирээд мориноосоо бууцгаав. Амархүү хоёр жилийн өмнө эмээл хазаартай хантайргатай морио алдчихаад эрэлд хатаж явган нүцгэн зовж явахдаа Сагад мэргэний сэргээсэн энэ бунхан шарилд мөргөөд сэтгэлээ ариусгаж аваад Жаахан салааны ам татаалын усны цохио хадны дэргэд морьтойгоо золгосноо санан дотроо ихэд сүсэглэж байв.

Бунхан шарилыг засаж сэргээснээс гадна нэг хүн арай даамгүй дороо өргөн суурилаг хүний цээжний хэрийн хөх чулуун дээр төвд үсгээр ямар нэгэн юм нямбайлан цохисон хөшөө нэмэгдсэн байв. Балбар өвөө бунхан шарилыг нар зөв тойроод шинээр босгосон хөшөө чулууны дэргэд сууж бичсэн бичээсийг унших мэт тогтуун харж баруун гараараа тэмтэрч байлаа. Өвгөн аавынх нь эл байдал Амархүүд их л сонин санагдаж байв. Нүдээрээ хараад байх шиг болохоор сохор биш гэмээр, гэтэл гараараа тэмтрэхийг харахаар сохор юм шиг санагдана.

Амархүүгийн сэтгэлд нөгөө нэг нууц үе үе гүйж орж ирнэ. Шөнө лааны гэрэлд том жижиг хоёр судар тулгаад уншиж байсныг нь бодохоор сохор биш нүдтэй хүн гэж бодогдоно. Гэтэл гуч дөчин жил сохор хүн болж жүжиглэсэн гэхээр үнэмшихийн аргагүй. Энэ удаан хугацаанд хань, үр хүүхэд нутгийн ахан дүүс нь таг сохор болохыг нь баталж бас итгэдэг. Аль нь вэ? гэсэн оньсого ач хүүгийнх нь толгойд эргэлдэнэ. Амархүү өвөөгөө ажигласаар байлаа. Балбар нилээд хугацаагаар бодлогоширон алив нэгийг нэхэн санах мэт чимээгүй сууна. Хааяа хааяа хөх түрүү ирээд дүнгэнэж холдоно. Балбар жишим ч үгүй сууна. Харин морьд сүүлээ шарван толгойгоо хаялан хазаарын чимээ өгөх нь хөх түрүү зовоож байгааг илэрхийлнэ. Балбар

дахиад хөшөө чулууны бичээсийг гараараа илж тэмтэрснээ

- Их аграмба А.Чоймжуур гэж амандаа шивнэв. Амархүү дэргэд нь шахам байсан болохоор үүнийг сайн сонсов. Өвгөн нүдээ аньсан хэвээр.
- Бавуу л ирээд явснаас зайлахгүй. Тэр ганцаараа ч ирээгүй бололтой. Хүүхэдтэйгээ ч ирсэн байж мэдэх юм. Эднийхэн удам судраараа үе үедээ их эрдэм номтой эрхэмсэг хүмүүс. Манай Хайдавжамц хүүгээ сайн хүн болгож өсгөсөн бололтой. Хүн гэдэг чинь ийм л байх ёстой доо гэснээ Амархүүд хандан өөрийнхөө бодлыг батлах гэсэн аятай
- Амархүү. Энэ хөшөө чулууг нэг хүн арай даахгүй байлгүй дээ. Чи юу гэж бодож байна гэхэд Амархүү, Бавуу, Хайдавжамц гэсэн нэрүүд бодож зогссон болохоор шуудхан л
- Тийм ээ. Нэг хүн арай даахгүй байх аа гэхэд Балбар амандаа
- Тиймээ, тийм гэж бататган хэлэв. Балбар нүдээрээ харж ажиглаж байгаа мэт хөшөө чулууг гөлрөн ширтэнэ. Тэр олныг эргэцүүлж байгаа бололтой уртаар санаа алдаад Амархүүд хандан
- Хүү минь энэ хөшөө бунхан шарилд мөргө. Бодол санаа чинь цэгцэрч сайн хүч тамирыг олж сүлд хийморь босох учиртай. Хэн сайн санааны мөрөөс үйлдэнэ төдий чинээ тамирыг авна. Миний тамир гэж хэлээд байгаа нь биеийн бяраа чадал биш оюун ухааны эрдмийн чадлыг хэлж байгаа хэрэг шүү дээ. За одоо мөргө, мөргө гэхэд Амархүү дуртайяа хоёр өвдгөө бохирон суугаад дээлийнхээ хормойг дэвсэн их л сүжиглэнгүйгээр гурвантаа мөргөөд суусан хэвээрээ
- Өвөө ааваа. Би хоёр жилийн өмнө эмээлтэй морио алдчихаад эрж яваад энэ бунхан шарилд мөргөөд удалгүй морио олсон юм даа гэж ярихдаа хуц ухна хариулдаг Сагад энэ бунхан шарилыг сэргээсэн гэдгийг хэлэлгүй нууц хэвээр нь үлдээв. Балбар ач хүүгийнхээ үгийг сонсоод их л тааламжтайгаар инээмсэглэж байв. Чимээгүйхэн бодлогоширон суух энэ сохор өвгөн байгаа биеэрээ түмэн хуйлаас ном, түүх шастир билээ. Энэ бунхан шарилыг анхан бий болоход нь өөрийн гар биеэр оролцсон хүн бол Балбар мөн билээ. Гэтэл олон жилийн дараа дахин сэргээж бас бичээс бүхий хөшөө чулуу нэмэгдсэнд баярлаж байлаа ч гайхах сэтгэл зэрэгцэнэ. Их аграмба А.Чоймжуур гэснийг олон дахин бодож бясалгасны эцэст А гэсэн үсэгний тухай бүдгэрч баларсан домог түүхийг сөхөхөд хүргэв. Балбар амандаа
- Ганц А үсэг ч биш л дээ. Авирмэд хэмээх гавьжийн амьдралын түмэн нугачааны заримд нь шингэж, заримыг нь нууцалж байж л түүх домгийн үзүүрээс барьж хөвөх хэрэг гарч байна. Тэр утасны нэг хэсэгт Чоймжуур аграмба орж ирээд энэ бунхан шарил руу орно. Утсыг алдаж болохгүй хөвсөөр яваад үүнийг сэргээсэн энэ хөшөө чулууг авчирсан хүн хэн болохыг мэдэх болно гэж шивнээд нүдээ аньж эрхээ эргүүлэв.

Арван нэг

Арван дөрөвдүгээр жарны төмөр луу жилийн өвлийн адаг хулгана сарын хорин тавны өдөр байлаа. Тавхан хоноод хаврын урь орж сар шинээ тэмдэглэх гэж байгаа болохоор Усанзүйлийн хүрээний үүдтэй өрхтэй айл болгон цагаан сарын бэлтгэлээ базааж байгаа учир шар тостой хавсай боовны үнэр хүрээний агаарыг сүрчиглэнэ. Усанзүйлийн хүрээ нь хоёр мянга гаруй лам хуваргатай, есөн дугана хуралтай томоохонд тооцогддог хурал номын газар билээ.

Цагаан сар ойртоод ирэхээр шавь банди нарт нэр цол үгүй мөртлөө нилээд том алба ноогдоно. Тэр алба нь хавсай дугуй боовны гурил элдэх ажил, түүнийгээ бондгой элдэж бэлдэх гэж нэрийднэ. Арван гурваных нь жил орох гэж буй нэг нутгийн, нэг зиндааны хоёр шавь Манлай, Авирмэд хоёр энэ нэргүй албаны эхэн дээр шахам цоллуулж айлаас айл дамжин үе мөчнийхөө хуянг тарааж булчин шөрмөсөө хөгжүүлэн хөвчрүүлж хоёр гарынхаа алгыг цэврүүтүүлэх шахан хорстол нь алба ажлаа амжуулна.

Манлай нь Хөвчийн нурууны хүүхэд бол Авирмэд нь зүүн нуруу Цагаан бургасны унаган хүү билээ. Энэ хоёр хүү хоорондоо ихэд дотносож бага гэхгүй бие сэтгэлдээ байгаа жаргал зовлонгоо хуваалцана. Атга замба олдвол хуваана. Бяцхан ухаандаа холыг мөрөөдөж ойрыг мартаж жаргана. Өвчин эмгэг тусвал бие биенээ асарч сувилна. Оюун билэг, ном эрдэмд ч мэдэж буй болгоноо нэгэндээ харамгүй зааж сургана. Мэдэхгүй зүйлээ ичиж айхгүй асууж лавлана. Үнэнийг хэлэхэд сэтгэлдээ хүж барилцсан дээлтэй төрсөн ахан дүүс болцгоосон хүмүүс.

Гэхдээ хүн бүр л өөр өөрийн хүсэл мөрөөдөлтэй болохоор тэдний үйл мөр заяа төөрөг ч мөн л өөр байлаа. Манлай бурханы номонд суралцаж хүрээ хийд сахиж суух дургүй нэгэн. Тэр энгийн амьдралаар амьдарч, тав гэзэг тавьж, урт соруултай гаанс зууж үнэтэй хөөрөг барьж, азаргаар адуу хурааж, нэрмэлийн охь хүртэж, үзэсгэлэн гоо бүсгүйтэй дэр нэгтгэн олон хүүхэдтэй болохыг хүснэ. Тиймээс бурханы ном эрдэмд төдийлөн шамдахгүй.

Тэгвэл Авирмэд нь ном эрдэмд сайн суралцахыг ихэд чухалчилна. Тэр нэгэн судар бичгээс уншсан тэнгэр заяатай монгол хүн гэсэн үгийг байнга санаж омогшино. Эзэн богд Чингэс хаан тэнгэрийн зараалаар энэ ертөнцөд заларсан нь үнэн байх гэж итгэнэ. Баруунтаа Тэнгэр уул гэж байдаг гэнэ лээ. Тэр уул ч гэсэн Тэнгэр хэмээн нэрлэгдсэн нь ямар нэг учир жанцантай байх. Гэтэл дэргэд минь нөмөрлөж ханхайх Сутай хайрхантай минь өдөр болгон лагшин дүрээ харж шөнөд нь билэгт шингэн үнэгчилж хонодог ч Хангайн нурууны оргил болох Отгонтэнгэр хайрхан хэмээх Очирваань бурханы орших оронг би сэтгэлдээ тээж үргэлжид залбирал үйлдэж даатгал итгэл одуулан шүтэн биширч явдаг билээ. Амьд явбал алтан аяганаас ус ууна гэдэг. Амьд сэрүүн байхдаа тэнгэр заяатай эзэн богдынхоо төрсөн нутаг Бурхан халдун уул, Дэлүүн болдогт очиж мөргөхсөн. Тэртээ холын Тэнгэр уулан дээр гарч тэнгэр бурхандаа залбирал тавьж ерөөл өргөхсөн. Би тэгж байж л аав ээжийнхээ ачийг санаж сэтгэлийг нь амирлуулах байх гэж бодно.

Арга байхгүй энэ хоёр хүү бие даасан бодьгал болохын учир ийм бөлгөө. Нэг айлын хавсай боов хийхэд доод зах нь арван тав, дээд тал нь хорин бондгойчин банди сууна. Хамгийн

аманд буюу зуурсан гурилын дэргэд их санч гэгдэх хэмжигч үндсэн модон аягаар гурилыг хэмжиж өгнө. Тэр гурил дороосоо эхлэн бондгойчингуудын гарыг дамжсаар шүүгч дээр очно. Шүүгч барьж үзээд л мэднэ. Элдүүр нь ханасан гурил халж амьд аятай атирна. Алив нэгэнд наалдахгүй бие даасан шинжтэй болсон байдаг. Боловсорч гүйцээгүй нь хүйтэн наалдамхай чанартай байдаг. Хутгаар зүсэж үзэхэд нүх сүвтэй, хийтэй байна. Тодотгож хэлбэл энэ цаг үед Манжийн хааны их сангаас цагаан сарыг тохиолдуулан томоохон сүм хийдүүдэд сайн чанарын гурилаар хангаж зарим ноёд, лам нарт цол хэргэм хүртээдэг байсан нь манжийн төрийн бодлогын нэг хэсэг нь байв. Монголчуудын омогшил, уур хилэнг нь шашны нөлөөгөөр сүсэг бишрэлийг нь өдөөж барихын тулд нөгөө ихэс дээдэс, толгой лам хуврагад нь цол хэргэм хайрлаж сэтгэлийг нь хүлж жилдээ ганц удаа болдог цагаан сараар нь гурил будаа арвин өгч ходоодыг нь цатган ухааныг нь мунхруулах төрийн бодлого нь бүгдийг номхон хүлцэнгүй гар дор байлгах арга мэх байсан юм. Зарим нэг нь цагаан сар хурдхан болоосой гэж хүсэж байхад Манжийн төрийн далд муу санааг мэдэх нэг нь дотроо

-Одоохондоо та нар бидний ходоодоор толгойг минь орлуулж толгойгоор хөлийг минь хийж л бай. Бид нэгэн цаг дор толгойгоо өргөж дөрөөн дээрээ босож ташуураа далайх болно гэж бодно. Энэхэн орон зайд “ Цаг, цагт нэг цаддаг, цагаан сараар нэг цаддаг” гэсэн хоржин үг гарсан байхыг ч үгүйсгэх аргагүй.

Өвлийн адаг сарын хорин найман гэхэд бүх ажил цэгцэрч дууссан байна. Хорин есөнд дошгид буюу арван хангалыг тахиx томоохон хурал номын ёслол болно. Зүйлийн хүрээний гол хийдийг “Гааданравжайчойнхорлин” хэмээн нэрлэнэ. Энэ хийд нь Гомбо, Лхам, Жамсран гэсэн гурван сахиустай. Чогчин, Чойр, Жүд, Дүйнхэр, Манба, Ламтан, Дарь-Эх, Майдар, Нүгнээ зэрэг дуганууд өнгө үзэмж орж арц хүжийн анхилам сайхан үнэр сэнгэнэнэ.

Сутай хайрханы оройн мөнх цас мөсөн өглөөний нарны туяанд гялалзан ойсон гэрэл нь солонгорно. Зүйлийн голын ус харзлан эгшиг аялгуулан урсана. Танхил нуурын усан голдоо гүн харзлан захруугаа цайран гялтайна. Энэ Танхил нууранд усны үхрийн хоёр бух өвөлждөг гэсэн домог байдаг. Түүнээ дагаад ч тэр юм уу өвөлдөө гол дундаа гүн харлан хөлддөггүй өвөлждөг.

Нэгэн жил Танхил нуурын ойр хавийн айлуудын үхэр сүргийн өсөлт зогсож үнээнүүд нь сувайрсан юм гэдэг. Гэтэл Танхил нуураас усны үхрийн хоёр бух гарч ирээд үнээ хээл авч үхэр сүрэг үлэмжхэн өсчээ. Нутаг нугийнхан баярлаж байтал хол нутгийн хомхой сэтгэлтэн харийн дайсан хар манжууд усны үхрийн хоёр бухыг авах гэж Танхил нуур хаана байна. Аль нуурыг Танхил гэдэг юм бэ? гэж асууж сурч эрэл хайгуул болох үед нь нутгийнхан үгсэн байж нуураа, хоёр бухаа аврахын үүднээс Тонхил нуур хэмээн нэрийдсэн юм гэнэ лээ гэсэн домог яриа байдаг.

Их цогчин дуганы баруун зүүн жигүүрт цагаан лавайн уянгалаг дуу бие биенээ чагнан ээлжлэн тасралтгүйгээр эгшиглэх нь арван хангал догшидыг тахиx хурал номын их ёслол эхлэх болсныг илэрхийлнэ. Нөгөөтэйгүүр лус савдгаа баясган тэнгэр газрын хишиг буяныг хурайлан дуудах нь энэ билээ. Гол дуганы өмнөх талбайд бүх лам нар ёслолын хувцсаа өмсөн алгаа хавсран залбирал үйлдэнэ. Мэгзим хэмээх тунгаамал алт мэт айлдвар тарнийн дээдийг гурвантаа уншиж бясалгав. Энэ ёслолд Гавьж, Аграмба, Зээрэмбэ, Маарамба шашин номын томоохон цолтон, мяндагтан гурван зуу гаруй байв. Авирмэд, Манлай хоёр ч энэ олон

хуврагуудын дунд залбирал үйлдэн мэгзим хайлж байлаа. Манлай Авирмэдийн чихэнд ойртоод

-Авираа. Чи надад арван хангалаа дахиад нэг хэлээд өгөөч гэж гуйхад нь Авирмэд түүнд ойртон Очирваань, Ямандага, Гомбо, Гонгор, Дамдинчойжоо, Балданлхам, Шалши, Намсрай, Жамсран, Цамба эдгээр арав. Эхний хоёр нь Ядам, бусад нь Чойжингууд юм гэлээ. Манлай их л тогтоож авч байгаа бололтой бодолхийлж байснаа

- Хөөе Авирмэд ээ. Очирваань гэдэг чинь Ядам болж байна уу? гэхэд Авирмэд иээнсэглээд

-Тиймээ, тийм. Урд төрөлдөө Бодьсатва байгаад шашныг хамгаалах тангараг талбин Монголыг даасан Ядам болсон юм. Очирваань хангайн нурууны Отгонтэнгэр уулнаа оршдог юм шүү дээ гэв. Манлай их л ойлгож байгаа шинжтэй толгойгоо дохисноо дахиад

- Балданлхам бурхан чинь нөгөө улаан сахиус мөн биз дээ? Гэхэд Авирмэд

- Мөн байлгүй яахав. Цагаан Дарь эхийн хувилгаан шүү дээ. Арван хангал догшидын дунд байдаг ганц бүсгүй Чойжин. Тэрвээр Жанчир Мулангийн далай хэмээх газарт оршдог гээд цааш ярих гэснээ

- Манлай чимээгүй болоорой . Цаана чинь их гэсгүй ирлээ гэв. Тэд нүдээ анин залбирал үйлдэв. Арван хангалын тахилга бишрэм сайхан болж өндөрлөв. Энэ цагаан сарын ёслол бүрд Манжийн хааны төлөөний түшмэл оролцож ихэс дээдэс түүнд хөл алдан бөхөлзөж урд хойно нь хонхны хэл шиг бөнжигнөнө.

Маргааш нь битүүний билэг эхлэв. Орой нар жаргах үеэр айл бүхэн тотгон дээрээ голд нь борог өвс, хоёр талд нь атга хэрийн мөс, цас тавина. Бурхандаа зул хүжээ өргөн бууз баншаа жигнэн, аав ээж, ахмад настан, авга нагац нартаа битүүлэг хүргэхээс эхлэнэ.

Тэнгэрт одод жагсангуут хийдэд Лхам бурханы тахилга хурал хурна. Үүрээр Цэдэр Лхамыг хурж өндөрлөөд Сутай хайрханы орой магнайд өглөөний нарны цагаан туяа золгоход ихэс дээдэс суудал сэнтийдээ заларна. Айл гэрийн хойморт ахмад настан аав ээжүүд налайна. Ирж байгаа шинэ жилийн эхэн ийнхүү билэг дэмбэрэл ёс төртэйгөөр бие биедээ сайхан сэтгэлээ илгээж бүлээн тамираа дэлгэрүүлэн эв эеийн модон мэт золгох зан үйлээс эхлэдэг бөлгөө.

Манлай, Авирмэд хоёр ч жижигхэн бор гэртээ бас л цагаан сарынхаа ёс заншлыг гүйцээхээр болов. Тэр хоёр дор дороо бодоцгооно. Бид хоёрын хэн нь ах билээ. Ах нь суугаад дүү нь ирж золгоно гэж бодож байв. Манлай хавар төрж Авирмэд намар төрсөн нь үнэн билээ. Ингээд Манлай бор гэртээ богд гэгчээр хоймороо заларч Авирмэд босож очоод дор бөхийн

-Та амархан айлдаж байна уу? гээд тохойг нь түшин золгоход Манлай

- Мэндээ. Амар байна уу? гээд духан дээр нь чанга гэгчээр үнссэнээр хоёр найзын шинэ он эхлэх нь энэ. Цаг наран урсан өнгөрөхөд ертөнцийн юмс хувьсан өөрчлөгдөнө. Идэр настай залуу багачууд өсөж өндийнө. Өтөл хөгшид нь Авид бурханы таалсан цаглашгүй гэрэлт

жаргалангийн орон руу цуварч одно. Цагаан сар наймантаа болж өнгөрөхөд Манлай, Авирмэд хоёр хорин нэгэн настай золгосон байлаа. Эр өсөж эсгий сунана гэдэг энэ болой. Манлай хурал номондоо суух нь цөөрч гадуур явж хоноглох нь улам олширсоор байв. Идэр насанд хүрч эр бие нь чангарсан хүнд юу хэлэх билээ дээ. Манлай нэг өдөр Авирмэдэд

- Авираа би чамтай нэгэн зүйлийг зөвлөлдмөөр байна. Би эхнэр авч эгэл жирийн амьралаар амьдрахаар шийдээд байна гэхэд Авирмэд

- Та бүр шийдчихээ юу? Номын сахиус сахил санваараа яая гэж бодож байна гэхэд Манлай инээмсэглээд

- Надад сурч мэдээд базаасан юм байхгүй. Ер нь бурханы номыг над шиг дутуу алсан могой шиг сурахын хэрэг алга. Харин ч бүр их нүгэл хийж байгаа юм шиг санагдах юм. Түүний оронд эгэлхэн хар амьдралаар амьдарвал надад өлзийтэй юм шиг санагдлаа гэв. Авирмэд бодлогоширонгуйгаар

- Та хаанахын хэн гэдэг хүний охинтой дэр нэгтгэхээр болов гэж асуухад Манлай толгойгоо илснээ

- Бүс хайрханы нутгийн баян Цэмбэл гэдэг хүний Удвал гэдэг бүсгүйтэй учир ургуулсан. Тэр маань одоо хөл хүнд болсон .Аав ээж хоёрт хүнээр дамжуулан мөчиг тачиг хэл чимээ дуулгасан гэхэд Авирмэд

- Та чинь их юм амжуулсан байна шүү. Хөвчийн нурууны хархүү Бүс хайрхан уулын Тамчийн хүргэн болдог байжээ гэхэд Манлай их л чухалчилж байгаа бололтой

- Авирмэд ээ. Тэр сахил санваар сахиусыг чамд л даатгана. Би өөр хэндээ ч хандах билээ дээ. Манай хүрээний томчуул чамайг их тоож байгаа гэсэн шүү.

- Энэ Авирмэдийн номын чадал тун ч сайн болж байна гэж Зундуй гавьж бусдад ярьсан гэнэ лээ гэхэд Авирмэд гараа өргөөд

- Манлай наад яриа чинь яах вэ? таныг явчихаар би гэдэг хүн ганцаардаж хэцүүхэн болох нь дээ гээд санаа алдахад Манлай Авирмэдийг зөөлөн хараад

- Юундаа ганцаарддаг юм бэ? Би наашаа цаашаагаа үргэлж яваад хоол унд,түлээ түлшийг чинь базаана. Чи зав чөлөөндөө манайд очно. Тэгээд ч ном эрдэмд шамдахад ганцаараа байх нь хамаагүй дээр шүү дээ гэлээ. Авирмэд, Манлай хоёр бие биеийг харан хэн хэнийхээ санаа бодлыг дэмжиж байгаагаа бодол бясалгалаараа илэрхийлж байв.

Манлай өрх өсгөж сум сунгаад айл гэрийн эзэн, хоёр хүүхдийн эцэг болоод сайхан амьдарч байлаа. Тэр ууган хүүдээ Агваанням, удаах хүүдээ Гунгааням нэрийг хайрлав. Манлай яг өөрийн хүсэж мөрөөдөж байсан амьдралаараа амьдарч байлаа. Тэр урт цагаан соруултай гаанс зууж утааг нь уушиг амаараа аажимхан гаргана. Шимийн архины охийг шимэн ууж ам хэлээ тамшаалан халамцана. Сунадаг гуулин дурангаар бэлчээрт яваа мал сүргээ харж унаганы зэл адууныхаа өнгө зүсийг шинжинэ. Уужим дээлэндээ дурдам бүсэлж дугуй хээтэй

торгоор өмд эсгэн өмсөж, гурван давхар ширээстэй гучин хоёр угалзтай гутал /сарьстай/ өшиглөсөн нь үнэхээр сүржин зохисон гэдэг ч хэлэх үггүй байлаа.

Ертөнцийн жам юм болохоор хүмүүн төрдөг, үхдэг нь хөдөлшгүй хууль билээ. Манлайн хадам эцэг баян Цэмбэл бурханы оронд одож бас нэгэн нуган үр төрөв. Тэр гурав дахь хүүдээ Батням гэж нэр өгөв. Баян Цэмбэлийн хот бэлчээрт байгаа үрждэг хөрөнгө, авдар саванд буй хатуу үнэт хөрөнгө гээд хэлж тоолж баршгүй их буян Манлай, Удвал нарт өвлөгдөв. Энэ айлын гэрт гадаа өрнөх ажлыг хоёул яав ч дийлэхээргүй болов. Мал ахуйдаа туслуулах хамжлага болох хоёр айл гаднаа буулгаж бага зэрэг тайвширсан ч ойролцоо гарсан гурван хүүхдийг өсгөх гэдэг Удвалд амаргүй байв. Энэ бүгдийг сайтар бодсоны эцэст Манлай Хөвчийн нуруунд нутаглах өөрийн ойрын хамаатан болох Лхам хэмээх арван найман настай бүсгүйг гэртээ авчирч Удвалд туслуулахаар болов.

Манлай хамаг хэрэг санаснаар бүтэж байгаад улам омогшино. Яагаад ч юм бэ түүний сэтгэлд юм болгон багтана. Авирмэд гавьжийн дамжаа барих дөхсөн байлаа. Намрын сүүл сарын хорьд гарсан болохоор өглөө оройдоо сэрүүвгэр байв. Орой унтахын өмнөхөн Авирмэдийнд нэгэн зочин ирсэн нь Манлай байлаа. Тэд мэнд усаа мэдэлцээд хэрэг зоригоо ярьцгаав. Манлайгаас архи тамхины эхүүн муухай үнэр ханхална. Манай хүн сүүлийн үед бор дарсыг их хэрэглэж бусдад баярхаж бас агсам тавьдаг болсон гэж дуулдсан үнэн байх нь гэж Авирмэд дотроо бодов.

Бурханы шашины гүн ухаан, дотоод шалтгааны билэг чанарын ухааны хөлгөн, тарнийн хөлгөн зэрэг номлолыг шат дараалан суралцаад эцэст нь өгөх зэрэг хамгаалах шалгалтыг “дамжаа барих” гэж нэрлэдэг. Энд Домын, Гавжийн, Аграмбын, Маарамбын, Зээрэмбийн дамжаа барьдаг уламжлалт ёсон байдаг. Гавж хэмээх нь гүн ухаанд мэргэшсэн хүнд олгодог “Арван бэрхийг мэдэгч- хэмээх эрдмийн цол зэргийн нэр болой. Энэ нь билэг чанарын хөлгөний Чойрын ёсны таван ухаан, түүний үндэс болох таван ухаантай нийлээд арван ухаанд мэргэшихийг хэлдэг. Тиймээс Авирмэд өдөр шөнөгүй эрдэм номд шамдан хичээнгүйлэн бэлдэж байгаа билээ. Манлай Авирмэддээ хандан

- За миний муу нөхөр дамжаандаа сайн л бэлдэж байгаа биз дээ. Бүр нүднээс гараад турж эцэж орхиж. Манайд очиж хэд хоног амарч бие хаагаа тордон тархи толгойгоо сэргээмээр юм даа.

Би ч угийн мулгуу хүн. Энэ шашинд бас буруу зөрүү зүйл байна. За яахав алж хядах, хулгай зэлгий хийх, худлаа ярьж хууран мэхлэх, архи ууж тамхи татахыг хорьж хориглодог нь зөв байх. Харин хүн гэдэг амьтны хөгжлийг, үр үндсээ үлдээх үйл мөрийг хориглодогийг л би ойлгодоггүй юм. Нэгэн бодлын дэндүү харгис бүдүүлэг ч юм шиг санагддаг гэхэд Авирмэд чимээгүй чагнаж байснаа

- Бурханы шашины зарим ёс түүнийг дагаж мөрдөх дэг жаягийг дахин нягталж үзэж байгаа гэсэн. Таны хэлээд байгааг тань зөвхөн “Гэлэн” сахилтай хүнд хамаатуулж үздэг. Ер нь сахил санваарыг барих ёс нь зөвхөн хувь хүнээс шалтгаална гэсэн үг. Энэ нь нийтийг хамарсан ёс хориг биш шүү дээ. Гэлэн гэдэг чинь үнэндээ “Буяны гуйлгачин” гэсэн битүү утгатай санваар юм даа. Буянг гуйхын тулд тачаалыг тэвчиж бясалгалд зорьж амирлангуй сайнаар амьдрахын үлгэр дуурайл үзүүлэх ёстой юм гэхэд Манлайн нүд сэргэж

- Зөв дөө хөө. Манай нөхөр ч аргагүй л ном эрдэмд гаргуу болжээ. Эрдэм номтой хүн л ингэж сайхан ярьдаг юм билээ. Би тав хоногоос морь хөтлөөд ирье. Бие сайн бол урт насалж төдий хугацаагаар бурхандаа залбирч буян үйлдэнэ шүү гээд өндийхөд нь Авирмэд яаран

- Манлай энэ орой шөнө болчихсон байхад хоночихоод яв. Та юундаа яардаг юм. Тэгээд ч халамцуу байна шүү дээ гэхэд Манлай чангаар инээд алдаад

- Авираа минь надад санаа битгий зов. Шөнө явж чадахгүй эр хүн чинь яаж амьдарч чадах юм бэ? Тэгээд ч энэ хүрээний хог новш, утаа униар, олон золбин нохдын дуу шуунд би угаасаа дургүй. Харин одоо мордохгүй бол оройтож мэднэ гэсээр гэрээс гарлаа. Авирмэд Манлайн тухай бодсоор хоцорлоо. Тэрээр

- Манлайн хэлдэг ч үнэн үг шүү. Энэ ертөнц арга билгийн ертөнц. Амьд юм болгон арга билгийн ёсонд дулдуйдан хосоороо амьдарч үр үндсээ үлдээн үргэлжлэн хөгжиж амьдардаг жамтай. Хүн юуны учир амьдардаг юм гэвэл удам залгах үр хүүхэдтэй байх л утга учир нь шүү дээ. Үр хүүхэдгүй байх гэдэг өгөрч хувхайрсан модон мэт юутай эмгэнэлтэй вэ? Үйлийн үрээр эхнэр авч үр хүүхэдтэй болж амьдрах нь хүний ёс билээ. Хэрвээ эс чадваас Авирмэд гэдэг нэгэн бодьгал эрдэнэт хүний үр үндэс тасрах бус уу? Тэгвэл энэ ертөнцөд хүн болж төрсний учир утга юу болох билээ. Сурч мэдсэн эрдэм номоо хэндээ өвлүүлэн үлдээж, гүйцээж амжаагүй оюун ухааны минь бүтээлийг хэн эвхэж хураах билээ гэж бодож суугаа Авирмэд баруун гартаа барьж байгаа бага гарын ногоон Чүнчигноров хөөргөө алгандаа эргүүлэн хараад

- Надад сурсан жаахан эрдэм, энэ ногоон хөөрөг хоёроос өөр хөрөнгө байхгүй. Намайг бурханы оронд одоход энэ Чүнчигноров хөөрөг хүртэл эзэнгүй үлдэн хаана нэгэнтээ хөсөр хэвтэх нь дээ. Ээдээ энэ ертөнцийн жам ёс хатуу ч гэсэн үйлийн үрийг дагахаас өөр замгүй болохыг хүлээн зөвшөөрөв. Авирмэд амандаа аяархнаар

- Юутай ч гавжийн дамжаагаа л нэг мөр дүүргэж ард нь гарч байж л дараагийн асуудлын тухай бодье доо гэж шивэгнэв. Манлай амласан ёсоороо тав хоноод л морь хөтөлсөөр давхиж ирэв. Харин Авирмэдэд хумхаа өвчин тусаад тэр бараг хэвтэрт орсон байв. Эл байдлыг мэдэнгүүтээ Манлай гарч давхиад хамба ламын оточ маарамбыг авчирч үзүүлээд эм тан зөвлөлгөөг авав. Тэр

- Авирмэд минь. Би чамд хэлээ биз дээ. Наад биеэ бодож байгаач . Бие эрүүл байвал эрдэм номыг атга атгаар нь бүр хормойгоор нь сурч болно. Бие үгүй бол атга ном, хормой гүрэмийн хэрэг юу байх билээ. Намайг бодвол чи чинь эрдэм номтой ухаантай хүн шүү дээ. Оточ багш хэд хоногтоо босож болохгүй гэлээ. Тийм болохоор чамд гал түлж, хоол унд хийж өгөх хүн хэрэгтэй бололтой. Би чамд идэхийн бараа болохоос цааш хэтрэхгүй амьтан. Манайд миний бүл дүү болох бүсгүй бий. Түүнийг явуулж чамайг асруулья гэхэд Авирмэд амаа дарж цээжээ хэржигнүүлэн муухай ханиагаад

- Манлай минь хүн ирүүлэх хэрэггүй. Эм тан уугаад гайгүй болчихно. Таньд түвэг болсонд намайг өршөөгөөрэй гэхэд Манлай инээгээд

- За надад түвэг болоод би чамайг өршөөх хэрэг гаргахнаа даа. Энэ удаа өршөөж чадашгүй нь

дээ. Наад тангаа уугаад орхи. Би очоод дүүгээ явуулна. Элдэв юм яриад буцаасан байвал би ирж чамайг хүлж аваад гэртээ эмчлэх болно. Чи ер нь хаашаа янзын хүн бэ? Гучин нас хүрчихээд хүүхэд шиг аашлах нь юу билээ. Эрүүл байж эрдэм ном сурна гэдгийг одоо болтол ойлгоогүй хүн үү? гэж зэмлэнгүй аялгаар хэлээд гарч одов.

Манлайн дүү охин Лхам ирээд гурав хоноход тэдний муу бор гэрт гэрэл цацарч аяга таваг, домбо, тогоо шанага, авдар сав нь өнгө орж гялалзаад явчихлаа. Авирмэдийн бие ч илааршиж сэтгэл санаа нь сэргээд нэг л баяр баясгалантай болчихов. Гэрт сайн тамир цугларсан мэт зул гурвантаа давхарлаж бадмаалав. Тэр Манлайдаа баярлаж байв. Авирмэдийг гадаалаад орж ирэхэд гэрт халуу дүүгэж нэгэн сонин содон үнэр мэдрэгдэн сэтгэлийг гижигдэх мэт үлэмж амирлангуйг өгнө. Тэр Лхам бүсгүйг тогтуун хараад түүнд талархаж байгаагаа илэрхийлэн толгойгоо бөхийлгөхөд Лхам ихэд санаа нь зовж байгаа бололтой хоёр хацар нь улаа бутраад нүд буруулан байж

- Та дээшээ морилоод цайгаа уу гэж номхон дорой дуугаар ээрэгнэн хэлэв. Авирмэд дотроо

- Өөрийнхөө муу бор гэртээ дээшээ морил гэж уриулж залуулаад байх даа яах билээ дээ. Бие гайгүй болсон болохоор энэ бүсгүйг гэр лүү нь буцаая даа гэж бодоод

- Миний бие гайгүй сайн болчихлоо. Таньд их гялайлаа гэхэд Лхам

- Өршөөгөөрэй ламтан. Би тус хүргэж юу шалих билээ. Манлай ах маргааш ирж намайг авна гэсэн гэхэд Авирмэд яагаад ч юм бэ дотроо ихэд баярлаж

- Юун сайн хэрэг вэ? Бас нэг хонох юм байна гэж бодов. Тэр өөрийгөө бас ихэд гайхав. Энэ бүсгүйг нэг хононо гэхэд нь яагаад баярлаад сэтгэл хөвөлзөөд зүрх оволзоод байна аа. Би Гавжийн дамжаа бариагүй учир зорилгоосоо өөр юу ч хэрэггүй. Ойрын үед хүмүүний амьдралын зорилго, утга учир түүний үргэлжлэл, үр үндэс, удам угсаа гээд дэндүү ихийг бясалгасны уршиг энэ байх гээд ухаан бодлоо цэгцлэхээр тарни уншиж бясалгалд оров.

Арван хоёр

Авирмэд гавжийн дамжааг дүүргэж бусдаасаа илүүрхэж байж гавж хэмээх эрдмийн цол зэргийг хүртэв. Тэр энэ цол зэргийг авахдаа цогломд босгохдоо бусад олны амыг ангайлгаж дэндүү илүүрхсэн болохоор магтаал сайшаалын үг аадар мэт асгарч байсан ч атаархал жотоорхол мөн л далдхануур гэтэж байв. Залуу гавж үүнийг эс анзааран сэтгэлдээн дэвэрч оюун ухаандаа омогшиж байлаа. Гол дуганы Гэсгүй, Донир хоёр сэмээрхэн үгсэж тусгайлан уулзаж Авирмэдийг далдхан муулна. Их гэсгүй гэх өндөр нуруутай улаан шар хүн

-Энэ Авирмэд хэнд гайхуулж байгаа юм бэ? Цаад санаа нь биднийг л доромжилж байгаа хэрэг. Энэ зэргийн залууд тийм ч амархан бууж өгөхгүй шүү. Буруу хүмүүстэйгээ оролдлоо доо гэхэд Донир болох тэмээний үдээр шиг туранхай хөх хүн

- Гэсгүй минь. Таны хэлдэг үнэн шүү. Бидэнтэй оролдсон хүн яадаг болохыг сайн мэдэхгүй л байна даа. Ер нь юугаа ч мэдэх билээ дээ. Хэсэг ном цээжилснээс хэтрэхгүй залуу шүү дээ гэхэд Гэсгүй бодлогоширон

-Басаж болохгүй. Ном эрдмийн хувьд чадалтай золиг шүү. Энэ яваандаа улам чангарч дээшээ ч гарч мэднэ. Ном эрдэм багатай хүнд тун ч дургүй золиг юм билээ. Тиймээс эртхэн зайлуулж нүдэнд харагдахгүй далд байлгах, болдогсон бол бүрмөсөн байхгүй болгочихвол санаа минь амрахсан гээд цэнхэр хөвөөтэй ногоовтор нүдээр Донирыг шинжих маягтай ажиглан харахад Донир толгойгоо дохин алив нэгийг бясалган арга мэхийг эрж хайж байгаа бололтой бодлогоширно.

Донир туранхай хөх нүүрээ баруун гарынхаа алгаар арчаад ёжтойгоор мушилзан инээмсэглэхэд Их гэсгүй түүнийг булингартай ногоон нүдээрээ харж дотор санааг нь унших гэсэн мэт нүдээ онийлгон хараагаа нарийсгав. Энэ хоёр хүн бие биеэ, бас дотор санааг мэдэхийг хичээж байвч нэгэн зоосны хоёр тал шиг үнэхээр бэрхтэй хэцүү зүйл байлаа. Гэхдээ хэн хэндээ итгэж найдаж байгаа болохоор нэгэн биений хоёр тал мөн байв. Хоёр мянган ламтай, есөн дугантай энэ том хүрээ хийдэд хоёрхон хүний хуйвалдаан байлгүй л яахав. Тэр ч бүү хэл хорь гучаараа эвлэлдсэн бүлэг ч байгаа билээ. Гэсгүй гэдэг алба нь зохицуулагч, захирагч гэсэн утгатай сүм хийдийн лам нар болоод буяны хурлын захирагч томоохон албан тушаал юм. Харин Донир нь нарийн бичиг гэсэн утга бүхий дотоод болоод гадаад хэргийг мэдэн Хамбад айлтгаж албан бичиг хэргийг хөтлөгч болохын учир нарийн ширийн хамаг ажил албыг мэдэж түүнд оролцдог нөлөө бүхий албан тушаалтан юм. Энэ хоёр хүн сэтгэл санаагаа нэгтгээд албан тушаалуудаа аятайхан ашиглаж чадвал болохгүй бүтэхгүй ажил гэж нэгээхэн ч байхгүй билээ Донир Готов, Гэсгүй рүү нухацтайхан хараад

-Надад нэг санаа төрөөд ирлээ. Энэ хавар цагаан сарын өмнө Манжийн хааны бэлэг сайн чанарын гурил хүргэж ирсэн хүмүүсийн дөрөв нь өвлийн эхэн сарын эхээр нутаг буцах юм. Унаа хөсөг агт морьд нь бэлэн байгаа. Тэр дөрвөн хүнээр манай хийд болон Хамба ламтны сэтгэлийн бэлэг явах учир төлөөний нэг хүн дагалдан явна. Надад бэлэг хүргэх төлөөний хүнийг олж бэлтгэ гэж Хамба үүрэг болгосон. Тэр төлөөний хүнээр гавж Авирмэдийг тохоон томилбол ямар вэ? гэв. Их гэсгүй ногоон нүднийхээ нуухыг арчингаа

-Энэ Донир Готов хэцүү хүн шүү. Харахад харчгар, хатсан үдээр шиг үрчгэр ч гэсэн халдаад ирвэл юу ч сэдэж, юу ч хийхээсээ буцахгүй чөтгөр санаатай цөөвөр чоно юм шүү. Ямар сайндаа анги дамжааныхан нь цөөвөр чоно гэж нэрлэх билээ дээ гэж бодоод

-Донир оо тэр дөрвөн манж чинь заавал өвлийн эхэн сарыг сонгодог нь юу билээ дээ. Эртхэн хөдлөдөггүй юм байх даа гэхэд Донир

- Тэд баруун хоёр говьд сэрүү унахыг хүлээсэн хэрэг. Тэнгэр уулаар давах юм гэнэ лээ гэхэд Их гэсгүй

- За тэгвэл бүр ч болоод явчихлаа. Цаад Авирмэд чинь нэг удаа

- Тэр Тэнгэр нэртэй уулан дээр гарч тэнгэр бурхандаа ерөөл өргөх юмсан. Энэ миний нэг хүсэл гэж ярьж байсан шүү. Гэхдээ чи санал тавихдаа үүнийг битгий дурсаарай. Зөвхөн манжийн бэлэг хүргэх төлөөний хүн маань эрдмийн цол мяндагтай залуухан хийморьлог хүн байх ёстой. Бид ярилцаад эрдэм чадал төгс залуу гавж таныг явуулахаар шийдвэрлэсэн юм гэж хэлээрэй. Тэгээд Их гэсгүйтэй зөвлөлд гээд над руу явуулчих. Би юу ярьж хэлэхээ мэднэ гээд албан тушаалаараа гайхуулах мэт инээмсэглэв. Донир үрчгэр гараа атгалан байж

- Манжуудын ахлагч түшмэлийг би сайн танина. Сэтгэлд нь өнгөр суугаагүй золиг байгаа юм даа. Хатуухан юм харчихвал юу хийхээсээ сийхгүй хүн билээ. Тэр дахиж наашаагаа ирэхгүй байх аа даа. Сэтгэлийг нь жаахан баясгаад гарыг нь ялихгүй хүндрүүлбэл тэр аль ч юмыг зоригтой хийдэг гэж надад ярьсан шүү гэхэд Их гэсгүй

- Энэ хатсан үдээр шиг харчгар хөх золиг чинь хэнийг ч үгүй хийж мэдэх л хүн шүү дээ гэж бодохоос айх шиг болоод нуруу өөд нь хүйт оргиж даарах шиг болоход бүх бие нь чичирхийлэв. Донир цааш нь

- Тэр золигийн манжид манай энэ залууг Тэнгэр уул давуулаад тэнд нь бөх гэгчээр унтуулчихаарай. Танай манай хоёрын хэнд нь ч хал балгүй чимээ аниргүй байвал амар биш үү л гэхэд

- Жа мэдлээ. Та санаа амар бай гэх нөхөр дөө гэв. Их гэсгүй өөрөө эхэлж санаа гаргасан болохоор яах ч аргагүйд хүрч

- Би тэр хатуу юманд чинь хандив өгнө өө. Чи надад хэмжээ хэрийг нь нэг дуулгачихаарай. Ийм нууц зүйлийг гурав дахь хүн мэдвэл осол эндэл гардгийг санаарай гэхэд Донир толгой дохин суулаа. Их гэсгүй Донир хоёр хар хорон санаагаа нэгтгэн байж бодож төлөвлөсөн муухай зүйлээ амжуулж байв. Тэр хоёр дор бүрдээ баяртай байлаа. Донир анх Авирмэдэд хэлэхдээ

- Гавж аа. Таныг Манж чин улсын их хаанд хүрээ хийд болоод Хамба ламын сэтгэлийн бэлгийг хүргэх төлөөний хүнээр томилон явуулахаар бид шийдээд байгаа .Энэ их хэрэгт өвлийн эхэн сарын шинийн гурванд хөдлөх юм шүү. Та өөрөө сайн бодож үзээрэй. Их гэсгүйтэй уулзаж зөвлөлдөнө биз дээ. Тэгээд надад яаж шийдсэнээ хэлээрэй. Яаруухан байвал зүгээрсэн гэв. Авирмэд үүнийг сонсоод эхэндээ баярласангүй харин ихэд гайхаж

байв. Заавал намайг явуулдаг нь ямар учиртай юм бол. Их гэсгүйтэй уулзаж ярилцъя гээд очиход нь Их гэсгүй

- Энэ тухай би дуулсан. Эхэндээ дургүй байлаа. Манжийн их хаанд бэлэг хүргэж биеэрээ очиж уулзах хүн бол эрдэм номд төгс гэгээрсэн дээд цол мяндагтай тэр том хаантай хэдэн мөч онч мэргэн үг солилцож ярилцаж чадах чадвартай хүн явах нь зөв гэж бодлоо. Эцэс сүүлд нь Тэнгэр уулаар давж явахыг сонсоод гавж таны нэг ч гэсэн хүсэл биелэх юм болов уу гэж муйхарлан болгоов. Гэхдээ таны саналыг би сонсоогүй болохоор эцсийн шийдээ гаргаагүй л байна гээд цэхэр хөвөөтэй ногоон нүдээр Авирмэдийг ажиглан харж байлаа. Авирмэд ч Тэнгэр уул гэхийг сонсоод тэр мөчид нүд нь сэргээд царайд нь гэрэл цацрах нь хашир гэсгүйд анзаарагдахгүй өнгөрнө гэж үгүй билээ. Энэ үед Гэсгүй

- Би ч гавжийнхаа загатнасан газар нь маажгаад авчихлаа. Одоо зөөлөн илээд өгөхөд л болчихно гэж бодоод

- Тэнгэр уул ч орчлонгийн үзэсгэлэн төгс үлэмж хэтэрхий байгаль цогцолсон нутаг шүү дээ. Манай монголчууд хэдэн зуун жилээр Тэнгэр ууландаа нутаглаж ирсэн түүхтэй. Гавж та мэдэх байлгүй дээ. Аугаа их Сандаг бурхан манай хангайн нурууны оргил Отгонтэнгэр хайрханд оршиж байдаг бол их Бодьсадвагийн заларч байдаг орон дэлхий нь Тэнгэр уул юм гэнэ лээ. Тэгээд ч биднийг чинь тэнгэр заяатай монгол гэж нэрлэдэг шүү дээ гээд Авирмэд гавжийн биеийг илж сэтгэлийг нь гижигдсэн заслаа хэр зэрэг болсныг ажиглан харав. Авирмэд дотроо

- Би Отгонтэнгэр хайрхандаа өдөр бүр залбирч сэтгэлийнхээ өргөлийг өргөж байдаг. Өвөг дээдсийн минь нутаг холын тэртээх Тэнгэр ууландаа очиж мөргөх завшаан тэр болгон тохиохгүй байж мэдэх юм. Энэ удаагийн энэ боломжийг түлхээд алдаж болохгүй түшээд ашиглах нь зөв гэж шийдэв. Авирмэд

- Их гэсгүй минь. Би та бүхнийхээ шийдвэр томилолтыг яахан хүлээж авахгүй гэж зүрхлэх билээ. Та бүгдийнхээ итгэл найдварыг биелүүлэхэд бүхий л бололцоо боломжоо дайчлах болно. Би хичээнэ ээ гэхэд Их гэсгүй муухан инээмсэглээд

- Бид ч гавж тандаа итгэж найдаж байгаа билээ. Таныг яваа болохоор санаа зовох юмгүй амар боллоо гээд их ёсорхон бөхөлзөв. Тэр дотроо

- Дамжаа барихдаа их л даналзаж бусдаас илүүрхээд байсан. Давахгүй гэсэн даваагаар давах л болж дээ. Манай цөөвөр Готов ч мөн л уран мэхтэй түүнийгээ цэвэрхэн хийхийг нь яана. Болгоомжтой л байхгүй бол ийм мэх надад ч ирэхийг үгүйсгэх, үгүй гэх газаргүй шүү. Авирмэдийг өөртөө л зөв эрдэм чадалтай гэх юм билээ. Одоо л харъя гэж бодож суутал Донир Готов ч ороод ирлээ. Тэр үрчгэр хөх нүүрээ гарынхаа алгаар арчсанаа

- За Гэсгүй минь. Юу болов доо. Би ч Авирмэдийг эндээс гараад далд оронгуут л зөрөөд ороод ирлээ гэхэд Их гэсгүй ихэмсэгээр инээмсэглэх аядаад

- За, за санасан хэрэг ёсчлон бүтлээ. Би бүр хөдөлгөөнгүй болгоод өгөхөөр Гавьж үг дуугүй хүлцэнгүйгээр хүлээн зөвшөөрсөн гэж сайрхахад Готов дотроо

- Гэсгүй ч өөрийгөө л ихэд бодоод байх юм. Ийм улаан биетэй ногоон нүдтэй, алба ажлаа алдахаасаа айсан амьтан өөрөөсөө илүү болгоныг дарж үлэмж сайныг үгүй хийхийг хүсдэг өөдгүй санаатай өгөр толгойдоо. Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр гэдэг. Хэзээ нэгэн цагт тэр чулуу өөрийнх нь толгой дээр унана даа гэж бодоод
- Өө тийм үү? Гэсгүй таны мэргэн цэцэн ухаанд би биширнэм. Энэ хорвоогийн хүн бүхэн тань шиг ийм их ухаантай байвал мөн ч амгалан болно доо гэж утга учиргүй гоё мөртлөө зарааны үс барьчихаад зальжингаар хатгахад нь
- Ёо, ёо гэж орилоогүй ч дотроо дургүйцэнгүйгээр
- За Готов минь битгий золигтоод бай. Аливаа үйл хэргийг гүйцэлдүүлэхэд бид хоёр бие сэтгэлээ нэгтгэн зангидаж нэгэн хүчийг бий болгож чадсан болохоор амархан бүтлээ. Энэ бол зөвхөн эхлэл төдий байгаа болохоор баярлах болоогүй. Цаад Авирмэдийг чинь ямар нэгэн аюулаас өөрийгөө хамгаалж амиа аврах хэмжээний эрдэм чадалтай, чадвартай хүн гээд байгаа шүү дээ. Ийм болохоор бүх юманд нягт нямбай болгоомжтой ханд гэсэн үг. Тэр манж үнэхээр найдвартай биз гэхэд Донир
- Түүнд санаа зоволтгүй. Итгэж болно. Харин арван лангаар алтан ембүү гээд өндөр гурван хуруугаа гозойлгов. Гэсгүй ногоон нүдээ онийлгон
- Одоо би юу? гэж гайхан асуухад Донир
- Тийм ээ. Гэсгүй би бас гээд мөн л өндөр гурван хуруугаа гозойлгов. Тэр хоёр зэрэг шахам амандаа
- Арван лангийн алтан ембүү зургаа байх нь. Ямар ч үнэтэй амь бэ? Тэр золиг ч ёстой шуналын тулам байна даа гэж шивэгнэн хэлэв. Гэсгүй донир хоёр бие бие рүүгээ шинжих мэт харснаа толгойгоо дохин зөвшилцөв. Ийм их цэцэн мэргэн ухаантай хүмүүсийг магтан сайшаах нь нэг ч үгүй байхад тэдний муу муухай хар хорон санааг нь мэдэх хүн байхгүй болохоор хэн ч жигшиж зэвүүцэхгүй. Харин өөрсдөө бие биенээ далд утга бүхий үгээр магтах аятай дайруулан зэвүүцнэ. Хэрээ хэрээнийхээ харыг гайхав гэгчээр бие биенээ түшин ханьсаж муу үйл хийж байгаагаараа баясаж гайхуулна. Донир Готов худал инээмсэглээд
- Гавжийн амиа аврах эрдэм чадал нь юу л бол доо. Цээжнийхээ хөндийн хэмжээгээр л салхи татуулаад байхаас ч өөр ид шид ч байхгүй дээ. Хөөрхий дөө эхнэр хүүхэд ч үгүй ганц бие амьтны ар өврөөс асууж сураглаад таталтаад байх нэг ч амьд юм байхгүй л дээ. Ядахдаа нэг гөлөг байсан бол ганц удаа боловч хуцахсан. Тийм ч юм байхгүй болохоор Гэсгүй минь санаагаа бүү зовоогооч. Сэтгэлээ тайван байлга даа. Би явж манжийн түшмэлтэйгээ уулзаж учир жанцангаа олъё доо гэсээр өндийхөд нь Гэсгүй яаран
- Готов оо чи сууж байгаач. Нөгөө гурваа чамд өгөөдөхье. Чи өөрийнхийгөө нэмээд цаад хүнийхээ гарт бариулж сэтгэлийг нь шулуутга. Ажил хийвэл дуустал, давс үйвэл уустал гэдэг үгтэй. Авирмэд намайг олны дунд юу гэлээ? Чи санаж байгаа биз дээ гэхэд Донир Готов
- Бэрээ модныхоо биетэй тэнцэх билэг оюунтай байгаач Гэсгүй минь гэж тоглож хэлсэн шүү

дээ гэхэд Гэсгүй гараа өргөн

- Үгүй ээ. тэр зэргийн залуу надаар тоглох нь юу билээ. Намайг доромжилсон хэрэг. Дараа нь над руу гараа дэлгэж байгаад

Өндөр ургасан модон

Үзүүрээсэ өгөрдөг билээ

Өмх идсэн ёзоорынх нь

Үндэс суларсан байдаг

Дээшээгээ өндөрсөх нь

Унахын тэмдэг билээ

Доошоогоо уртсах нь

Ургахын үндэс билээ гэж ичгүүргүйгээр дайрч давшилсан нь одоо болтол дотрыг минь арзагнуулж байна. Хэн нь дээшээгээ өндөрсөөд унах нь вэ? хэн нь доошоогоо гүнзгийрээд ургах нь вэ гэдгээ одоо л нэг үзэх цаг нь ирлээ. Донир минь. Маш хянамгай найдвартай хийгээрэй. Бид хоёрын санааг хэн нэг нь мэдэх ёсгүй шүү.

Үүл хичнээн их хуравч бороо орохгүй байдаг

Үйл хичнээн амархан бүтэвч бүтэлгүйтэх нь бас байдаг.

Тийм болохоор хичээгээрэй гэж захив. Гэсгүй өс хонзондоо хөтлөгдөн эрэгчин эмэгчинээ нэгэнтээ үзэхээр шийдсэн учир гурван алтан ембүүндээ харамсах юм алга байлаа. Хүний сэтгэл ийнхүү зуларч зугтан нисэх нь оюун ухаан доройтсоны тэмдэг. Их доройтол хотол биеийг дардаг бол үхэл нь амь биеийг дарах аюултайг мэдэхгүй байгаа нь санаж сэрэх ухаан нь мунхарсных билээ. Донир Готов өөртөө

- Чи бүр мунширч гүйцэв үү дээ? Их гэсгүйн өс хонзонгийн хар сэтгэл нь савнаасаа сагаж асгараад ямар нэгэн хориг авахааргүй болсныг анзаарсангүй юу? Гурав байтугай арван алтан ембүү өгөхөд ч бэлэн болсныг мэдсэнгүй гэж үү? Чи мунхагаасаа сэр сэр гээд хацраа чимхэж духаа алгадав. Хүний шунал ийм л хуурай өвсөнд алдсан түймэрийн аймшигт гал мэт бие сэтгэлийг шатааж юу ч үгүй үнс болгодгийг л унал хэмээн нэрийддэг бөлгөө.

Өвлийн эхэн сарын шинийн нэгэн буюу хөх туулай өдөр байлаа. Их хамба гавж Авирмэдийг хүлээн авч хэсэг ярилцав. Тэр

- Манай Их гэсгүй Донир нарын зөвлөж шийдвэрлэснээр таныг энэ төлөөний хүнээр тохоон томиллоо. Би уг нь өөр бодолтой байсан юм. Таныг Дашлхүмбэ хийд рүү дөрвөн жилээр илгээж жаахан ч болов эрдэм номын ажилд зүтгүүлдэг юм билүү гэж төлөвлөж байлаа. Гэтэл таныг өөрөө зөвшөөрсөн гэдгийг дуулаад хориглож чадсангүй. Уг нь суусан цэцнээс

явсан тэнэг дээр л гэдэг. Хол явж газар үзэх гэдэгт буруу юу байхав. Зуу сонссоноос нэг үз гэсэн мэргэн айлдвар ч бий л дээ гэхэд Авирмэд дотроо

- Миний явахыг Гэсгүй, Донир хоёр л шийдсэн хэрэг байх нь. Би нэгэнтээ зөвшөөрсөн болохоор олон санаа хэрэггүй гэж бодоод

- Би сайн бодсон. Тэр л өвөг дээдсийн минь нутаг Тэнгэр нэртэй уулыг үзэх боломжийг алдахгүй байя гэж бодсон юм гэв. Хамба сайхан инээмсэглээд

Манай элэнц хуланц өвөг дээдэс эзэн богд хааны үед Монгол хүмүүс чинь дэлхийн талыг эзэгнэн амьдарч байсан түүхтэй. Тэр үед Тэнгэр уул чинь бидний нутгийн голд шахам байлаа. Одоо бага зэрэг хол мэт санагдаад байгаа болохоос тийм ч хол газар биш ээ. Тэнгэр уулын цаана хоёр нуур хэмээх маш үзэсгэлэн төгс байгальтай газар бий. Тэнд манай хаад ноёдууд амарч биеийн алжаалаа тайлдаг байсан юм гэнэ лээ. Тэгээд Өрөмчийн хошуу гэж бий. Тэнгэр уулнаас наана Бархөлийн хошуу гэж бас байдаг. Нас өтлөөд ирэхээр явж нүдээр үзэх чадал тэнхээ байхгүй болохоор чихээр сонсож ном судраас уншихаас цааш хэтрэхгүй юм даа.

Залуу насандаа газар үзэж нүд тайлах санаа зоригийг чинь би хүндэтгэж байгаа. Одоо л явахгүй бол хэзээ явах билээ. Манай хүрээний хамгийн залуу гавж болохоор чамд их итгэл найдвар тавьж байгаа шүү. Авирмэд ээ. Бид чинь энэ нас амь амьдралаа энэ номын хүрээлэнгийнхээ төлөө зориулсан болохоор хожим ирээдүйнх нь төлөө ч дандаа сэтгэл зовниж халуун чихийг нь боломжийн эрдэм номтой үнэнч шударгуу, сэтгэл сайтай хүнд л атгуулчих юмсан гэж бодох юм.

Аливаа ажил үйл мөрийг даалгаж болох хүмүүс байсан ч сэтгэлгүй байгаа нь даанч хэцүү юм. Тиймээс л сэтгэл зовж санаа амарч өгдөггүй дээ. Хичнээн олон шавь хуврагууд байсан ч онцлон авах нь нэг хоёроос хэтрэхгүй болохоор даанч цөөхөн. Тиймийн учир л би чамайг Өмнийн Дашлхүмбэ хийдэд хэдэн жил эрдэм номонд суулган арга барил сайтай болгон хожмынхоо ажилд бэлтгэх ухаантай юм. Чи ямар бүр явчих юм биш. Цагаан сарын өмнө хүрээд л ирэх юм чинь Би чамайг хүлээхээр шийдсэн. Гавж минь. Сайн яваад сайхан морилоод ирээрэй гэж ерөөл талбин үдэв.

Авирмэд Манлайн үлдээсэн моринд мордож тэдний рүү зөөлөн шогшуулав. Гавж Хамбын ярьсаныг олон удаа тунгаан бодсон ч Лхам бүсгүйн тухай бодол зэрэгцэн түүнийг үймрүүлнэ. Тэр бүсгүйн сайхан сэтгэл, зөөлөн ааш, эгшиглэнтэй дуу хоолойг нь санаж чадав. Түүнээс өөр сэтгэлийн ямар нэг дуудлага алга байлаа. Гэхдээ гоо үзэсгэлэн нь нэг удаа ч бодогдохгүй байгаа нь үүний баталгаа бололтой.

Арван гурав

Өвлийн тэргүүн сарын шинийн гурваны гал могой өдөр байлаа. Тэнгэр битүү бүрхэн чимээгүйхэн дүнсийнэ. Нар үүлний цаана нуугдах учир өглөөдөө жаваргүй дулаавтар мөртлөө жиндүү байв. Хоёр тэмээнд тэнгээ ачаанаас хэтрэхгүй бага шиг ачаалсан харагдаж байвч атан тэмээ ихэд зүтгэлэн босохыг бодоход тийм ч хөнгөн биш байгаа бололтой. Хөсөгтэй явах дөрвөн манж, Авирмэд гавжтай нийлээд таван хүний хоол хүнс, дээл хувцас, оромж төдийхөн болохоороо овор багатай харагдаа биз ээ. Донир Готов хоёр дэмч ламын хамт үдэж мордуулав.

Донир манжийн түшмэлийг жичид нь хүндэтгэн ямар нэгэн зүйлийг их л нууцлан ярилцаад толгойгоо дохицгоон хүндэтгэл үзүүлж ирээд Авирмэдэд хандан

-За Гавж минь. Сайн яваад ажил хэргээ бүтээгээд ирээрэй. Бид таныг баярлан угтах болно гэсээр хоцров. Манжийн хаанд бэлэг хүргэх бэсрэгхэн энэ хөсөгт алт эрдэнэсээс эхлээд амь насанд хүрэх атгаг муу хорон санаа ачигдан яваа билээ.

Хөсөг хөдөлсөн өдрөөсөө эхлээд л нэгэн түшмэлийн гарт оров. Тэр түшмэл мөнхөд халамцуу явах нь өөртөө жаргалтай ч бусдадаа яршигтай байлаа. Түүний дээрэнгүй ихэмсэг зан дээр нь хар архины дон, магадгүй амь насны үнэ цэнэтэй алт эрдэнэс нэмэгдээд омог бардам араатны хаан арслан барсын ааш араншинтай болж авирлаж аашлаад байгааг ч үгүйсгэх аргагүй билээ. Тэнгэрт бурхан залардаг, газарт чөтгөр гүйдэг гэдэг. Энэ түшмэл тэдний нэг ч байж мэднэ. Тэр монголоор хазгай муруй үг солино. Авирмэдэд

- Хай чи тийм ихээ эрдэм номтой хүн үү? гэхэд Авирмэд дотроо

- Энэ манж түшмэлийг бага зэрэг магтая. Бас өөрийгөө ч өргөө. Холын замд бодолд ороолгон замын уртыг гайхан явахаар зугаатай цэнгээнтэй явбал зам хурдан барагдаж сэтгэл амар явна гэж бодоод

-Тийм ээ. Би их эрдэм номтой хүн гээд инээмсэглэхэд түшмэл

-Тийм байх аа. Чамд хүмүүс дургүй байдаг нь аргагүй бололтой гэв. Авирмэд улам цаашлуулаад

-Би ихээ эрдэм номтой ч таныг яаж гүйцэх билээ. Та надад зааж сургаж өгөөрэй гээд мөргөх аядахад түшмэл их л сэтгэл нь ханасан бололтой

- Энэ хүнийг ээ. Бас их ухаантай байх нь. Танайханд үхэх хүнд үг хэрэггүй, унтах хүнд ус хэрэггүй гэдэг нэг сайхан үг байдаг шүү дээ гээд шар шүдээ гарган бах тав нь ханасан аятай инээхэд Авирмэд дотроо түүний хэлсэн үг бүрийг цэгнэж байлаа.

-Чамд хүмүүс дургүй байдаг нь аргагүй юм байна. Үхэх хүнд үг хэрэггүй гэх зэргийг бодоод түүнд бөхийж хүндэтгэл үзүүлэх дүр эсгээд

-Түшмэл та ухаантай цэцэн цэлмэг хүн байна. Алт мэт сургаалиа хайрлавал би амь биеэ

өргөхөд бэлэн байна гэж хошигнох маягтай хэлэхэд түшмэл хөлчүү нүдээрээ Авирмэдийг ажиглан хараад

- Ай чи ихээ хэцүү хүн байна шүү. Амь наана, там ойрхон байхад алт мөнгөөр үг худалдаж авна гээд байх юм гэж хэлснээ дотроо

- Энэ монголын чинь хэлсэн үг сэжигтэй юм шиг санагдсан ч тэнэг хүний үг бололтой гэж бодоод сэтгэл нь амарч хар архинаасаа хөнтрөв. Авирмэд хөсгийн мөр дагаж хонь усны их говийг гаталж тэнгэрийн хаяаг харж явахдаа мөн ч хол байна даа. Би явж байна, Бээжин сууж байгаа гэдэг үг л үнэн юм даа гэж санаад бодолдоо дарагдав. Тэр Сутай хайрханы бэл Усан зүйлийн хүрээнээс хөдлөхийн өмнө Манлайгийндаа очиж хонож өнжсөнөө нэхэн дурсав. Манлай

- Авирмэд ээ чиний яриаг сонсоод байхад зарим нэг юм нь сэжигтэй санагдаад байна. Чамайг явуулахыг Их гэсгүй, Донир хоёр шийдэж дээш нь айлтган Хамбад тулгадаг нь юу билээ. Яаж ч бодсон Манжийн хаанд бэлэг хүргэхэд чамайг явуулах ёсгүй л юм даа гэхэд Авирмэд цагаан цайлганаар инээгээд

- Тэр яах вэ? Надад санал тавьж би өөрөө зөвшөөрсөн хэрэг. Хамаг учир нь Тэнгэр уулыг л үзэхийг хүссэн хэрэг шүү дээ гэхэд Манлай бодлоо орхиж

-За тийм л болтугай. Гавж минь гэхдээ дотроо бодолтой дороо суурьтай байгаарай. Энэ муухай манж хятадуудад итгээд байх хүмүүс биш шүү. Бидний гэнэн цагаан сэтгэл, итгэлийг ашиглаад байгаа нь тодорхой байдаг юм гэв. Авирмэд Манлайнхаа шулуун шударга зан, бодож санаж яваагаа хэнээс ч нуулгүй бас хэнд ч хэлж чаддагт нь хүндэтгэлтэй ханддаг билээ. Хоёр найз шөнө дөл болтол хуучлав. Манлай сайхан инээд алдаад

- Би Агвааннямдаа мэддэг юмаа заагаад ойр зуурын уншлагатай, үзгэнд овоо дадуулаад байгаа. Чамайг ирэхээр албан ёсоор шавь оруулж багш шавийн барилдлагатай болгочихвол санаа минь амарна. Манай энэ хүү дүү нараа өлхөн аваад явчихна гэж бодно хэмээгээд дөрвөн алд хэрийн элдүүр гүйцэж ханасан цулбуурын сур гаргаж ирээд

- Үүнийг бүснийхээ дотуур бүслээд хоёр үзүүрийг нь сайтар бөхөлж байгаарай. Би тусгай уяа гаргачихсан. За хөө Лхам аа миний дүү нөгөө оёсон үзүүрсгэн дээлээ аваад ир. Өвөл цагт гэрт гадаа алинд нь ч биед хөнгөн, хөдөлж байхад чөлөөтэй эвтэйхэн байдаг юм. Наад үзүүрсэг чинь угтаа ахар ноолууртай болохоороо нохой дахнаас ч дулаахан. Манай Лхам л оёсон юм гэлээ. Ямааны сайн сархинагт чихсэн гурван бондгор юм гаргаж ирээд

- Энэ гурвыг богцныхоо ёроолд хийчих. Нэгд нь үхрийн борц нүдээд хийчихсэн юм. Халуун цайндаа чимхийг хийгээд л уучихаж бай. Нөгөөд нь цагаан зөөхий байгаа. Түүнийгээ идэх аргаа чи мэдэх байх гээд үлдсэн нэгийг нь гартаа бариад

- Энд шар тос байгаа юм. Аминд тулсан үедээ шагайн чинээг авч амандаа хийгээд хүлхэж идээрэй. Морь чинь тамирдаж өлдөж эхэлвэл хазаарынх нь амгайн дугуйд түрхдэг юм шүү. Биднээс чамд бэлдсэн юм үүнээс өөр үгүй билээ. Бусдыг чи өөрөө мэдэх болохоор гээд чимээгүй болов. Манлай дотроо санаа нь зовж байгаа нь илт мэдрэгдэж байлаа. Лхам бүсгүй

ч гэсэн алс холын аянд Авирмэд гавжийг явуулах дургүй байгаагаа сэтгэлийнх нь илэрхийлэл болох нүднийхээ харцаар илтгэж байлаа. Тэрээр

- Таныг хол явуулмааргүй л байна . Хэрвээ эргэж ирэхгүй хааны гүнжтэй ханилвал би яах билээ. Та бид хоёр зөрүүлдэж эсгэсэн хээ нь нийлээгүй торго шиг нас үе мултарсан, зүрх сэтгэлээ нээж хувь тавилангийн ерөөл тавиагүй нь үнэн.

Гэлээ ч би таныг хүндэтгэн хүлээн авч хайр сэтгэлийнхээ хойморт залсан. Би бүсгүй хүний зөн билгээр бүтэн төрсөн заяа тавиландаа итгэж байгаа шүү хэмээх шиг болсныг нь санаад мориныхоо амыг татаад түр саатав. Тэр амандаа аяархнаар

- Би таныг зүрх сэтгэл, бодол бясалгалдаа байнга тээж яваа билээ. Санаж явбал бүтнэ гэдэг ерөөл өргөө хэмээн шивэгнэв. Гэтэл хөлчүү түшмэл

- Хай үхэр монгол минь чи үлийгээ хийгээд нам зогсчихов. Тэртэй тэргүй Тэнгэр уул даваад тэндээ л тайван үлдээрэй гэж харааж зүхэв. Энэ үед Авирмэд

- Энэ түшмэл хөсөг хөдөлсөн өдрөөс эхлэн намайг нохой мэт үзэж юунд ингэж хэл амаар дайрч доромжлох болов? гэж өөрөөсөө асуухад хүрэв.

Түүнд Манлай, Лхам нарын захиж хэлсэн үг, сануулж өгүүлсэн бодрол хариуг нь хэлэх шиг болов. Бас Их гэсгүйгийн бах тав нь ханасан мэт булингартай ногоон нүд Донир Готовын үдээр мэт үрчгэр царай нүдэнд үзэгдээд өнгөрөв.

Таван морьтонтой хоёр тэмээ ачаатай авсаархан хөсөг хонь усны говийг гатлаад Бархөлийн наана байх Муу худаг гэж нэрлэгдэх өмхий устай говьдоо ганцаар тоологдох усыг бараадан буудаллав.

Нойр хулжиж сэтгэл гэгэлзэхийн учир Авирмэд гавж шөнө дунд ододыг ажиглан зогсоно. Одод гялалзан цэнхэр туяа цацах нь хүйтэн болохын шинж билээ. Тэр гар одыг олж шинжлээ. Нэг дэх буюу мэргэн од бүдгэрч муухан үзэгдэж байв. Өвлийн эхэн сарын хорин долооны хавирган сар зүүн хойшоогоо тонгойсон нь дээд үзүүр нь нугарч мэргэн одыг чиглэсэн байлаа. Хоёр хоногийн дараа буюу шинийн хорин есөнд мэргэн од сартай тохиох нь гарцаагүй байв.

Авирмэд толгойдоо эрхэсийн хөдөлгөөний зурлагыг зурж байлаа. Хэрвээ сар баруун урагшаа гэдийж доод үзүүр нь мэргэн одыг чиглэж шинийн эхэн хоёронд тохиовол тэнгэр газар тэврэлдэж жаргана гэж байдаг. Гэтэл дээр дурьдсан лугаа сар бөхийж дээд үзүүр нь нугарч мэргэн одтой тохиовол тэнгэр газар тэрсэлдэн хямарч амьтан хүмүүнд аймшигтай аюул ирж зовлонгийн далай давалгаалмуй хэмээснийг сайтар тунгааав.

Тэр эрдэмтэн хүний хувьд ч бас зөн совингоороо мэдэрч тохиож болох аюулыг батлаж байв. Энэ тохиол, цаг агаарын хямрал яг л Тэнгэр уулаар давах тэр цаг мөчид таарч байлаа. Өглөө эртлэн боссон барлаг зарц хоёр манж цай ундаагаа бэлэн болгоод түшмэлдээ илтгэхэд тэр босож гадаалаад ихэд уурлан

- Эрт сэрээхгүй яасан юм бэ? бушуу түргэн ачаа хөсгөө бэлд. Одоохон хөдөлнө гэж сүржигнэхэд нь Авирмэд гавж

- Эрхэм түшмэл ээ. Таньд айлтгах айлтгал байна. Хоёр хоногийн дараа Тэнгэр уулыг давах үеэр тэнгэр газар тэрсэлдэн хямралдаж хүн амьтанд аймшигтай аюул ирэх нь ээ. Бид энэ устай газраа хоёр хоног саатан морь мал, өөрсдийнхөө биеийг амраан алжаалаа тайлаад хөдөлвөл ямар вэ? Тэр үед тэнгэр газар зохирон гай гамшиг өнгөрсөн байх юм гэхэд түшмэл аягатай цайгаа шидэн байдаг тэнхээгээрээ хашгиран

- Чи чинь юугаа яриад хэнтэй арсалдаад байгаа юм бэ? Юуны чинь тэнгэр газар тэрсэлдэх гээд тэнэг юм ярьж толгой тархи эргүүлээд байгаа юм. Хоёр хоногийн наана цаана чамд ямар ялгаа байна. Хорвоод амьд явах хоногийн чинь тоо л гүйцвэл болоо биз дээ. Зовлонгоос ангижирч диваажинд очих гэж байгаа хүн чинь урд хойтохоо дэнсэлж буяныг санаж маань тоолж байвал дээр бус уу? Гавж, гавж л гэнэ. Тэнэг хүнд өгдөг цол байх даа гэснээ хэлсэн үгэндээ баясан марсайтлаа инээв. Авирмэд дотроо

- Илжигний чихэнд ус, алт хоёрын алиныг нь ч хийсэн адил гэдэг. Хүний тэнэгийг гайхаж байгаа хүн өөрийнхөө тэнэгээр бардамна гэж бас л байдаг. Хүмүүс үхэх цаг нь ойртоод ирэхээрээ зан ааш нь хувирч уурлаж уцаарлан эрлэг рүүгээ яардаг юм гэсэн. Би амаа үдүүлсэн мэт чимээгүй болъё. Харин амиа аврах арга ухаан ном бясалгалд оръё гэж бодов.

Тэр ганц ч үг амнаасаа унагалгүй ачаа бараагаа эмхлэв. Тэд хоёр хоног дээрээ Тэнгэр уулын бэл өөд өгсөв. Тэнгэр уул өвөр талдаа чимээгүй дүнсийнэ. Өндөр ургасан хар моддын мөчир хөдлөх төдийхөн намуухан байв. Энэ чимээ алдран бараан царайлах нь нэг бодлын аймшигтай нөгөө бодлын амгалан ч юм шиг санагдана. Унтаж байсан арслан сэрэнгүүтээ учрыг олох гэж түр алгуурладгийн адил аюул болохын өмнөх тайвшрал байж болох юм.

Хөсөг уулын могойн мөр шиг баруун зүүнээ мурилзан модод сүлжсэн зөрөг замаар аажимхан өгсөнө. Алив нэг амьтан хүрхрэх мэт чимээ улмаар тодрон айсуу байгааг сонордоно . Хоёр тэмээ бурантагаа чангаан явдал нь удааширна. Бодвол уулын сүрэнд дарагдаа биз гэмээр санагдана. Морьд ам булаан уруу харж зогсохыг хичээнэ. Бүдүүн ташуурын хүчнээс айж дуртай дургүйхэн гэлдэрнэ.

Уулын оройд дөхөх тусам өндөр моддын үзүүр бөхөлзөн савлаж шуугих чимээ гаргах нь салхи хүчтэй байгааг илтгэнэ. Хөлчүү түшмэл бүдүүн тэнзэн ташуураар тэмээний гуянд хүчтэй буулгахад урагшаа явах нь бүү хэл урд өвдгөө бохирон гаслан халаглах мэт орь дуу тавин хэвтээд орхив. Нөгөө тэмээ нь мөн л муухай орилоод бас хэвтчихэв. Архиндаа халамцсан түшмэлийн уур ихэд хүрч агсамнах шинжтэй болоод урд байх тэмээний толгой дундуур ташуураар хоёр сайн буулгаж аваад нөгөө гурван манждаа

- Та гурав одоохон мориноосоо бууж хоёр тэмээгээ нэг нэгээр нь хөтөл. Нэг чинь гурван морио хөтлөөд араас хүрээд ир. Бид хоёр дээшээ гарч байдлыг ажиглаад хүлээж байя гэж зарлиг буулгаад мориндоо ташуур өгч гараараа Авирмэдийг явья гэж дохив.

Морьд явах дургүй байлаа ч хүчинд автагдан аюулын өмнөөс зүтгэлнэ. Энэ согтуу түшмэлийн авир ааш, мунхаг харанхуйгаас адгуус хүртэл айж дагжин чичирч байв. Салхины хүч улам

ихсэж байгаа нь эрс мэдэгдэнэ. Морьд, тэмээ адгуус аюулыг зөнгөөрөө мэдэрч түүнээс сэргийлэн тэмээ хэвтэж, морь бөгсөө өгөн модны нөмөр бараадаад байгааг түшмэл яахин мэдэх билээ. Тэр Тэнгэр уулан дээр түргэн гарч холын бараа харж өндөр уулын салхи амтлахыг хүсэж яарах нь энэ бөлгөө. Тэнгэр уулын орой дээр маш хүчтэй салхилах учир амьд амьтан тогтож байхын аргагүй байлаа. Түшмэл хүсэж байсан салхиа амталсан бололтой

- Хай яасан хэцүү вэ? гэж хашгирах нь Авирмэдэд бүдэгхэн сонсогдов. Энэ үед маш хүчтэй хуй нөөлөг ирж тэр хоёрыг алгадав. Тэд өөрийн мэдэлгүй эмээлээсээ салж агаарт дүүлэх мэт болоод мододтой мөргөлдөн золгов. Моддын мөчир хугарч бие биеэ ороолгоно. Зарим нь бүр үндсээрээ булгаран өөр бусдыгаа хайр найргүй хугачиж нугачина. Энэ их чимээ, аймшигтай сүйрлийн нүргээнд мэгдсэн гурван манж хоёр тэмээний бөөрөнд наалдан газар хэвтэв. Морьд ч бүдүүн модны нөмөр бараадан зогсоно.

Гэтэл төмөр дөрөөний харших чимээ гаран хоёр морь хойт хөл дээрээ оцойн сууж урд хөлөө шийрлэн жийж уруу газар луу салхинд түрэгдэн гулсан орж ирэв. Авирмэдийн хүрэн морь нэгэн бүдүүн модонд тулаад хавтгайлдан унаад тогтов. Түшмэлийн морь гулссаар өндөр хөмөг рүү өнхөрч алга болов. Бичин цагийн эхээр эхэлсэн энэ хүчтэй салхин урсгал нар жаргаж бүрэнхий болох үеэс хүч нь суларсаар одод түгсэний дараа бүр номхров.

Хүн эрт дээр үеэсээ л байгалийн авир аашийг ажиглан мэдэж аюул гамшгаас урьдчилан сэргийлж амьдрал ахуйгаа хөтлөн явж ирсэн баялаг түүхтэй билээ. Ялангуяа нар, сар, оддын хөдөлгөөн, эрхэс гарагийн хамаарал, нөлөөллийг сайтар тооцоолон түүнийгээ амьдралд батлан нотлоод ном судар болгон хойч үедээ үлдээсэн байдаг. Тийм гэгээн мэргэдийнхээ үгийг дагаагүйгээс мунхаг харанхуйгаар зүтгэх нь аюул гай гамшиг руу хөтлөн аваачдаг ажээ.

Авирмэд гавжийн манарсан ухаан нь сэргэн зарим нэгийг бүдэг бадаг санаж ядна. Ямар нэгэн их хүчинд автан мориноосоо салан агаарт ниссэж ямар нэг юм хүчтэй мөргөснөө санаж байв. Тэр хөл, гараа хөдөлгөж үзэхэд бүрэн бүтэн байлаа. Харин хөл нь газраас хөндий агаарт байгаад нь гайхаж байлаа. Цээжин биеэр нь хөндүүрлэн өвдөнө. Амьсгал авах тоолонгоор хатгуулна. Толгой дүүрч баруун шанааны орчимд өвдөнө. Салхи л хүчтэй болсноос биш хүйтний эрч гайгүй байлаа. Тэр орилох гэсэн боловч дуугарч эс чадна. Гараараа сайн тэмтэрч үзвэл бүдүүн мод тэврээд бүсээрээ өлгөгдсөн байлаа. Салхи бүр намдсан нь үнэндээ сонин санагдана. Байгалийг онож мэдэхийн аргагүй юм даа. Түшмэл маань яасан бол. Нөгөө хэд ч уулын нөмөр модон дотор байсан болохоор гайгүй биз гэж бодно. Гэтэл хүний хашгирах чимээ гарлаа. Тэр дотроо

- Миний үхэх цаг арай болоогүй бололтой гэж баярлав. Дахин хашгирах чимээг сонсоод хоёр ч удаа орилох аядан чимээ өглөө. Хүмүүс хоорондоо манж хэлээр ярилцан түшмэлийнхээ нэрээр дуудна. Авирмэд тэвчээр зааж өвдөлтийг тоолгүйгээр дахин нэг хашгирав. Тэд түүний дэргэд ирэв. Авирмэд

- Би байна гэхэд нэг нь

- Хай яа энэ гавж уу байна гэхэд монгол хэлээр арай гайгүй ярьдаг нь

- Авирмэдээ чи модонд өлгөөтэй байна. Чамайг яаж авах вэ? гэж асуухад Авирмэд

- Намайг хөлөн дороос дээш нь өргө. Тэгээд түшиж аваарай гэв. Авирмэд мод мөргөөд доош гулсахад хугарсан мөчрийн унгины яранд бүсэлж явсан сур нь гогдон тээглэж түүнд өлгөгдөн амьд гарсан байв. Гурван манж, түшмэлийнхээ нэрээр дуудан хэсэг хашгирч орилолдсон боловч хариу чимээ эс сонсов. Авирмэдийн баруун шанаа нилээд халцран толгой доргиж гурван хавирга хугарч бүсэнд өлгөгдсөн мөчрийн унги хэвлий цорой руу бүлж шарх үүссэн байлаа. Тэр шагай чинээ шар тос хүлхсээр бээрсэн биеэ аажимхан бүлээцүүлж хоосон лонх үлээж нарийн илгэ шар цавуугаар хавирга дээрээ нааж ил шарханд цэцгийн ханд түрхэв. Энэ дөрвөн хүн энэ шөнө эс унтав. Дор бүрдээ алив нэгийг бодно. Манж түшмэлдээ сэтгэл зовнино. Харин Авирмэд

- Миний амь насыг Манлай минь л аварлаа. Түүний надад бүслүүлсэн цулбуурын сур тус боллоо. Осгож үхэх аюулаас Лхамын минь оёж өгсөн үзүүрсгэн дээл гэтэлгэлээ. Ямар ч байсан амьд сэрүүн байгаа болохоор амар мэнд уулзахын ерөөл өргөө гэж залбирч бясалгаж байв.

Арван дөрөв

Бунхан салааны аманд байх Бунхан шарилыг хэн нэгэн сэргээгээд нэгэн хөх чулуун хөшөө босгосон бол өнөөдөр нэмээд бас нэг амьд хөшөө босгосон юм шиг өвгөн Балбар уг хөшөөний дэргэд бараг бүтэн өдөр зэрэгцэн суув. Орой болж нар жаргах дөхөж байлаа. Балбар хөшөө чулуу хоёрын сүүдэр зүүн урагшаа уртассаар байгаад уулын сүүдэр хүүшлээд ирэхэд алга болов. Энэ үеэр Амархүү өвөө ааваа цочоох бий гэж болгоомжлон

-Өвөө аав аа. Нар жаргачихлаа. Хоёулаа явах уу? гэж зөөлөн хэлэхэд Балбар толгойгоо өргөн сохор нүдээ нээж

- Өө тэгээ юу? хүү минь. За тэгвэл явья даа. Хөөрхий Авирмэд гавж минь гэж бодол бясалгалдаа хөвж байсан домог түүхээ гүйцээгээгүй байгаагаа ийнхүү илэрхийлэв. Амархүү сохор өвөөгөө хараад айх шиг болов.

- Хүн зөнөглөөд өглөөд ирэхээрээ нялх хүүхэд шиг өтгөн шингэнээрээ тоглож элдвийн ойлгогдохгүй юм ярьж солиордог гэсэн. Өвөө өнөөдөр үл таних дөрвөн хүний нэрийг дуудсан. Авирмэд, Чоймжуур, Хайдавжамц, Бавуу гэсэн. Сая Авирмэд гавж гэхийг бодоход өнөөдөржингөө тэр Авирмэдийг дурссаар байсан байх. Түүнийгээ ч гүйцээж амжаагүй бололтой. Өндөр наслах гэдэг ч үнэндээ хэцүү бас аймаар юм даа. Өвөө хөшөө чулуун дээрхи бичгийг хараад унших шиг болсон. Тэгээд гараараа илж тэмтрээд хуруугаараа бичээсийг дагуулаад байсан үнэн худлыг бүү мэд. Тэр бичгийг Их аграмба Чоймжуур гэж уншсан. Өвөө үнэн сохор уу? худлаа сохор уу? гэж Амархүү өөрөөсөө асуугаад хариуг нь ололгүй анхаарлын тэмдэг тавиад онгорхой үлдээв. Маргааш өглөө нь Амархүү босоод алив нэгэнд яарах мэт аргамжаатай морь луугаа эмээлээ үүрээд алхав. Ээж нь хүүгийнхээ хойноос харж зогсохдоо

- Өглөө их унтдаг хүү нь цайгаа ч уулгүй эмээлээ үүрээд морь луугаа яаран алхахыг сонирхон

- Энэ хүүхэд юу болоо вэ? Уг нь нойрыг унтаж бардаггүй сэрж бардаг юм гэнэ лээ. Эр хүн чинь иймэрхүү л байдаг даа. Эрт босвол нэгийг үзнэ, орой унтвал нэгийг сонсоно гэдэг ч үнэн шүү хэмээн бодож байв. Харин Амархүү урд шөнө нойроо хугаслан байж Бунханы амны бунхан булшийг Сагад гуай юуны учир сэргээн засаж хөшөө чулуу авчирч тавив. Энэ булш түүнд ямар хамаатай болохыг мэдэхийг хүсэж хичнээн бодсон ч оньсыг нь тайлж эс чадав. Түүний оюун ухаан хорхойсон шууд биш ч гэсэн алсуур тандах, бага сагыг мэдэх, утасны үзүүрээс барихыг хичээн хуц ухна маллагч Сагадын руу очихоор зориглосон нь энэ билээ.

Сагад өглөөний сэрүүнд хуц ухнаа бэлчээрт аваад гарсан байв. Шүүдрийн устай цэцэг навч эрт идсэн мал өдөртөө тогтвор ордог сайн талтай учир Сагад түүнийг өрөмтэй хөгшин боовтой адилхан сайхан амттай өглөөний зоог гэж нэрлэнэ. Харин Хөхцэцэг гэр орноо янзлан гэртээ байлаа. Хөхцэцэгийг наадмаас буцаж ирсэн орой түүнд цай хоол өгөхдөө

- Миний охин ядрав уу? Айл амьтнаар олон найзуудтайгаа дэвэрч хөөрсөн хүн юу л олж идэв гэж. Тэгээд наадмынх нь хуушуур элбэг юм уу? гэж асуухад Хөхцэцэг инээмсэглээд

- Ааваа хуушуур элбэг байлаа. Та ядрав уу? гэхэд нь Сагад

- Би юундаа ядрах билээ. Наадамд шар хээр морь түрүүлсэн үү? гэж асуухад Хөхцэцэг аав руугаа сүрхий хараад
- Тийм ээ ааваа. Би тэр өглөө мөн л тэнгэр ажигласан. Таныг ирээгүй болохоор надаас асуухад нь шар хээр зүсмийн морь гэж хэлсэн. Гэтэл нөгөө баруун багийн Намжил гуайн шар хээр морь түрүүлж ирсэн. Намжил гуай маргааш нь надтай уулзаад
- Охин минь ах нь дүүдээ их баярласан. Амны билэг гэдэг үнэхээр сайхан. Дүүгийнхээ эрдэм ухааныг биширч байна гээд сүйд болсон. Би санаа зовоод
- Зүгээр ээ. Би нар, тэнгэрт тодорсон өнгийг л хэлсэн шүү дээ гэхэд Намжил гуай
- Тэр чинь л эрдэм чадал юм шүү дээ гэсэн гэхэд Сагад охиндоо хандан
- Хэн юу мэдэж байна түүнийгээ хэн нэгэнд боловч хэлж өгч тус хүргэвэл тэр буян болдог юм шүү дээ. Хүнийг баярлуулах гэдэг сайн буянд тооцогддог юм. Үнэн сэтгэлээсээ өдөөгдсөн үйл бүхэн буянд хамаарагддаг юм шүү дээ гэснийг бодож суутал
- Нохой хорио гэх танил дуу сонсогдов. Хөхцэцэг гэрээс яаран гарвал Амархүү ирчихсэн зогсож байлаа. Хөхцэцэг гайхан
- Ямар сонин хүн бэ? Та айл андуураад хярын орой дээр байгаа ганц гэрт хүрээд ирсэн юм биш биз гээд инээхэд Амархүү мөн л инээгээд
- Үгүй дээ. Танайх нохойгүй юм уу? гэж лавлахад Хөхцэцэг цаашлуулж
- Манайд ноцдог нохой байхгүй. Харин мөргөдөг ухна бий шүү гээд зогсож байхыг нь хараад Амархүү дотроо
- Энэ Хөхцэцэг чинь үнэхээр л өндөр хярын зэрлэг цэцэг юм гээч. Лусын дагина гэдэг л иймэрхүү үзэсгэлэн гоо үлэмж төгс бүсгүй байдаг байх даа гэж бодож байтал Хөхцэцэг
- Та чинь юугаа бодоод таг чиг болчихов оо? гэхэд Амархүү санаа нь зовоод
- Өө би дэмий юм бодоод гэсээр мориноосоо буулаа. Тэр хоёр ойр зуурыг ярилцан бас наадмын сониноос дурсаад авлаа. Амархүү Хөхцэцэгийг хүндэлж оюун ухааныг нь биширдэг. Энэ жилийн наадмын түрүү морины зүсийг яг хэлсэнд гайхаж бас биширсэн билээ. Амархүү бас л сонин болгох аясаар
- Бунханы салааны аманд байх бунхан шарилыг сая сэргээгээд нэг хөшөө нэмээд тавьчихаж гэж сонирхуулахад Хөхцэцэг анзааргагүйгээр
- Би тэр газрыг чинь оногоож сайн мэддэггүй юм шүү дээ. Аав бид хоёр чинь амьтан хүнээс зайдуухан аглаг хээрээр амьдардаг болохоор үзэж харах нь бага сонсож дуулах нь ховорхон л байна шүү гэв. Амархүү үг олох санаатай
- Аав тань тэр бунхан шарилын тухай ярьдаггүй юм уу? гэхэд Хөхцэцэг толгой сэгсрээд

- Аав маань иймэрхүү юм огтхон ч сонирхдоггүй хүн шүү дээ. Надад нар, сар, оддын тухай л байнга ярина. Эрхэс гарагийн учрал, тохиол дэлхийд нөлөөлөх нөлөөллөөс гадна үүл, бороо, хяруу, шүүдэр гээд олон зүйлийг ангилж нарийсгаж байгаа. Бас түүх их ярина. Би чинь та нар шиг их сургуульд суралцаж байгаа юм шиг л лекц сонсоно шүү дээ. Их ч сонирхолтой. Одот тэнгэрийн тухайд гэвэл нарны харагдах замыг “ Шар зам” гэдэг бол сарны замыг “ Сүүн зам” гэнэ . Сав, шим ертөнцийн хэмнэлийг таван махбодь, арван хоёр жилээр дүйлгэн жаран жилээр тодорхойлдог гэхэд Амархүү толгой сэгсрэн

- Наад яриад байгаа чинь үнэхээр гайхалтай. Танай аав бол ер бишийн эрдэмтэй хүн гэж бахархан хэлэхэд Хөхцэцэг их хөгжилтэйгээр

- Та битгий миний муу ааваар тоглоом тохуу хийгээд бай. Нэгдлийн хуц ухна малладаг жирийн нэг малчин хүн шүү дээ гэв. Амархүү даруухнаар

- Тийм биш ээ Хөхцэцэг ээ. Би хүнийг нь хэн гэдгийг огт хэлээгүй. Оюун ухаан эрдэм чадлыг нь хэлж байна. Тэр тэнгэрийг мэддэг уншдаг ухааныг нь хэлээд байгаа хэрэг гэж өөрийгөө зөвтгөн зүтгэв. Хөхцэцэг Амархүүд сонирхуулах маягаар

- Чамд сонирхуулахад үүлийг есөн янзаар ангилна. Бороог гэхэд хорин гурван зүйлээр шинждэг. Шүүдрийн усыг найм, салхийг хорин хоёр хувилбараар тодорхойлж шинжилдэг юм. Нэг бүрээр нь задруулж яривал наад зах нь бүтэн дөрвөн жил, оньсонд нь нэвтэрье гэвэл зургаагаас найман жил шаардагдана гэж ярихыг сонсож суугаа Амархүү дотроо

- Би чинь чухам юугаа хийгээд яваа хүн бэ? Ийм их хүнийг тандаж тагнана гэж байх уу? Саваагүй нохой саранд хуцна гэдгийн үлгэр болно биз дээ. Сагад гээд нэр нь хүртэл нэг сонин. Энэ хүн ч эгэл жирийн нэгэн биш байх. Би илүү харж билүү долоож явахаа больё гэж шийдэв. Гэтэл Хөхцэцэг

- Хөөе Амархүү ах аа. Та юугаа бодоод таг болчихов оо? Цай уу гэхэд Амархүү

- Одоо болно. Нэгэнтээ Алаг хайрхан уулынхаа хяр дээр гараад ирсэн юм чинь Вансэмбэрүү цэцгийг хараад авах юмсан гэхэд Хөхцэцэг инээмсэглээд

- Вансэмбэрүү цэцэг гүйцэд цэцэглээгүй байгаа. Наймдугаар сарын хорьдоор үзэхэд ёстой гоё болсон байна даа. Ер нь нэг үзэхэд сэтгэл амгалан болж нас нэмэгдэнэ шүү. Манай аав өглөө үүрээр очиж унтаж байгааг нь хараад нар дагаж дэлбээгээ дэлгэн дэлгэрэхийг үзэж ирээд надад ингэж ярьсан юм. Нарны шаргал туяатай золгоод яг инээмсэглэж байгаа юм шиг задарч дэлгэрдэг юм билээ. Охин минь. Аав нь чамд үзүүлнэ. Вансэмбэрүү цэцэг дэлгэрэхийг үзнэ гэдэг хүний нүдний баясал сэтгэлийн цэнгэл юм билээ гэсэн гэхэд Амархүү бодлоосоо салж сэтгэл нь сэргээд

- Хөхцэцэг ээ. чи тэгээд үзсэн үү? ямархуу байсан бэ? гэхэд Хөхцэцэг Амархүү рүү харж сайхан инээмсэглэхэд тэр дотроо

- Энэ бүсгүйн инээмсэглэл шиг л Вансэмбэрүү цэцэг дэлгэрдэг байх даа. Нүдээрээ үзээгүй байж сэтгэлдээ төсөөлөн ургуулах нь хэр оновчтой дүрслэл болох вэ? Тэгээд бүр амьд хүний

инээмсэглэлтэй шүү. Энэ ч арай л дэндэх байх аа. Харин Сагад гуайгаар сайхан яриулаад авахсан. Найман сарын хоринд ирж заавал үзнэ. Тэгээд л сургуульдаа явья даа. Нэгэн бунхан булшийг нэг нь сэргээгээ л биз. Нөгөө нь ирээд түүх домгийг нь дурсаж санаа л биз. Ер нь өвөө аав, Сагад гуай хоёрт л хамаатай болохоос надад ер нь хүртээл ч байхгүй зүйл шүү дээ гэж бодоод

-Хөхцэцэг ээ. Тэгээд чи үзсэн үү? гэж дахин асуухад тэр Амархүү рүү тогтуун хараад

- Үзэлгүй яахав. Бүр бүтэн хоногийнх нь амьдрал нэгэн жилийнх нь заяа төөргийг судалсан шүү. Маш гайхамшигтай, эрдэм чадалтай, хосоороо амьдардаг хорвоогийн ховорхон тохиолын нэгэн нууц юм билээ гэв. Амархүүгийн Вансэмбэрүү цэцгийг үзэхсэн гэх сонирхол хүсэл мөрөөдөл, сэрэл мэдрэмж нь улам их оргилон суудал дээрээ өндийх шахаад

- Хөхцэцэгээ надад ярьж өгөөч гэж гуйх шахам аялгаар хэлэхэд нь Хөхцэцэг уриалгахнаар

- Вансэмбэрүү цэцэг манай Алаг хайрхан уулын оройн асга хадан дунд ургадаг. Нэг үгээр энэ уулын хамгийн тансаг шүтээн мэт газар орныг сонгосон нь гайхмаар. Өглөөний нартай золгонгуугаа хүүхэд нойрноосоо сэрэх мэт дэлбээгээ дэлгэж инээмсэглэх аятай цомирлогоо нээнэ. Тэр уулын цэнгэг цэвэр агаарт наадах үзэсгэлэн гоо гүнж шиг бүжиглэх мэт зөөлөн найгаж нар даган зөв эргэж үргэлжид мишээн сайн тамирыг түгээнэ. Оройн жаргах нарыг үдэж сайны ерөөл дэвшүүлэн бөхийж хүндэтгэл үзүүлнэ. Оройн бүрэнхий болоход эр эм хосууд бие бие рүүгээ харан аз жаргалтайгаар мишээгээд харанхуйгаас эмээх мэт аажимхан дэлбээгээ хумин цэвэрхнээр цомцойн байх нь ихэс дээдсийн орд харшид ичингүйрэн хормойгоо хумхин намбалаг суух бүсгүй заяанд бүтэн төрсөн дагинасыг санагдуулна гэж ярихад Амархүү амаа ангайн оюун билэгтээ хөтлөгдөн уулын асга хадан сүмд морилж шүтээнд нь залрах Вансэмбэрүү хаан хатан хоёрт мөргөж байгаа бололтой Хөхцэцэгийг гөлрөн ширтэнэ.

Арван тав

Амархүү Хөхцэцэгийн ам руу орох шахам болж Вансэмбэрүү цэцгийн хаан хатан хоёрт мөргөх яг энэ үед сумын намын үүрийн товчооны хурал болж Улсын баяр наадам, сум байгуулагдсаны гучин жилийн ойг хэрхэн тэмлэглэн өнгөрүүлсэн тухай хэлэлцээд дараагийн асуудалд орлоо. Сумын намын үүрийн дарга Намхай их нухацтайгаар

-Биднийг баярлаж цэнгэж наадаж байх хойгуур чоно борооноор гэгчээр Бунханы хөтлийн амны бунхан булшийг сэргээгээд нэмээд нэг хөшөө босгосон байна. Тэгэхдээ бүр нам төрийн эсрэг санаатай үйл ажиллагаа явуулж төвдөөр ямар нэгэн бичиг бичээс үлдээсэн байна. Түүнийг унших хүн одоохондоо алга. Аварна гэж ч байгаа юм уу? ална гэж ч байгаа юм уу? бүү мэд. Энэ бол үзэл суртлын тэмцлийн нэг хэлбэр мөн. Үүнийг үйлдээд байгаа хүн хэн бэ? гэдгийг олох хэрэгтэй байна гэхэд гишүүн Ширмэн

- Наадамтай зэрэгцүүлж ийм зүйл хийнэ гэдэг бол зориудын санаатайгаар өдүүлж байгаа ноцтой хэрэг мөн. Тэр хүнийг олохын тулд бүхий л нөөц бололцоогоо дайчлах хэрэгтэй гэв. Гэтэл өөр нэг гишүүн

- Итгэмжлэгдсэн хүмүүсээр туршуул тавьж тандуулах хэрэгтэй. Манай хүмүүс дотор мэдэж байгаа хүн байж л байгаа. Хараад үзэгдэхгүй ч мэдэж байгаа хүн хэзээ нэгэн цагт үг алдах нь гарцаагүй. Тиймээс итгэлтэй намын гишүүдээ судлаад тэдэнд намын даалгавар болгон өгвөл зүгээр байх гэлээ. Гэтэл малын их эмч Өлзий

- Наадмын маргааш намар гэдэг үг бий. Одоо отор нүүдлийг дариухан зохион байгуулах, малын угаалга халдваргүйжүүлэлтийн үе шатны ажлыг хэрэгжүүлэх гээд ажлууд араасаа хоолойд тулчихаад байна шүү. Шал дэмий бунхан юм уу булш ч юм уу бүү мэд хэдэн хавтгай хөх чулуунд тэгтлээ анхаарах хэрэг байна уу? Тэгэж л эмзэглээд байгаа юм бол тэр хэдэн хавтгай чулууг нэг тракторт ачаад Сангийн далайн хөх энгэрийн чулуун хороонд нэмэрлэж орхино биз гээд хөхрөв. Танхимд чимээ аниргүй болов. Хэсэгтээ дор дороо бодлоо нэрж юу болохыг чимээгүй хүлээцгээв. Сум нэгдлийн дарга Хангал

- Бидэнд хийх ажил их байгаа нь үнэн. Өлзий эмчийн хэлдэг ч бас үнэн. Тэр бунхан булш болох нь үнэн бол бидний л өвөг дээдсийн нэг нь тэнд нойрсож байгаа байх. Сая сумынхаа ойд ирсэн хүмүүсээс нэг нь ойртож ирсэн дээрээ гэж олзуурхаад сэргээсэн байхыг үгүйсгэхгүй. Тиймээс отор нүүдэл, хадлан тэжээл гэх мэтийн ажилдаа илүүтэй анхаарах хэрэгтэй байна. Ер нь хиргисүүр болоод өөр бунхан шарилууд зөндөө л байдаг. Тэр болгонтой ард иргэдийгээ холбож тандаж туршаад байх нь тийм ч оновчтой бодлого биш байх аа. Харин ч нам төрдөө итгэх итгэл нь суларч мэдэх аюултай гэв. Гэтэл Ширмэн

-Бид бүгдээрээ л зөв ярьж байна. Гагцхүү тэр бичээс юу гэж байгааг л мэдэх хэрэгтэй. Одоо чинь буу шийдмээр биш үзэл суртлын дайн болж байна шүү дээ. Манай суманд тэр төвд бичгийг унших хоёрхон хүн бүртгэлтэй байдаг. Нэг нь Хөшөөтийн голын сохор Балбар нөгөө нь Хөвчийн нурууны дуугүй Хайнзан. За Балбар гуайтай юугаа ч ярих билээ. Хайнзан гуай уншсан ч уншаагүй ч юу ч хэлэхгүй. Хурууг нь тайрсан ч тэр дуугарахгүй гэдгийг бид мэднэ. Тиймээс би очоод тэр бичээсийг яг дуурайлгаад бичээд ирье. Намын үүрийн дарга та аймаг,

хот руу явахдаа мэддэг хүнд нь үзүүлээд юу болохыг мэдвэл зүгээр бус уу? гээд бусдыгаа ажиглан хэсэг зогссоноо суув. Малын их эмч Өлзий их ёжтойгоор инээмсэглээд

- Бид өнгөрснөө мартаж болохгүй. Далан хоёр оны арван нэгдүгээр сарын долоонд юу болсныг нэг санаач. Мужаан Сагадыг хятадын тагнуул туршуул болгоод хаанаас ирсэн хэн түүнийг ажилд авсан гэх зэргээр буруутанг хайсаар Хангал дарга дээр унасан шүү дээ. Энэ явдал ганцхан цагийн дотор л болсон. Гэтэл манай сумын мал сүүлийн хоёр жил өсөж арвижлаа. Сагад хуц ухныг гурван жил малласан. Мал өссөний үндсийг нь олохыг хичээхэд маш тарга хүч сайтай эрүүл чийрэг хуц, ухнын хээлтүүлэх чадвар өндөр, гарсан төл нь эрүүл, бойжилт нь сайн байв. Эцэстээ энэ чинь хуц ухна малладаг Сагадын л буян шүү дээ гэв. Тэд өнгөрч одсон нэгэн түүхийг сөхөн санах болов.

.... Тэр жилийн тэр өдөр аугаа их Октябрийн хувьсгалын баярын өдөр байлаа. Манай урд, хойд хоёр хөршийн харилцаа сайнгүй байсан болохоор бид хойд хөршийнхөө бодлого үзэл санааг ягштал баримталж байсан. Дээд удирдлагаас энэ өдөр улс төрийн сонор сэрэмжээ өндөржүүлэхийг анхааруулсан байв. Сумын нам захиргаа ч үүнийг удирдлагаа болгон хариуцлагатай жижүүр эргүүл томилон ажиллуулав.

Тэр өдөр тэнгэр бүрхэг цас орох болов уу гэмээр нэг л дүнсгэр байв. Шөнөдөө тэнгэрт одод ч үзэгдэхгүй тас харанхуй нөмөрсөн хааяа хааяа нохой хуцахаас өөр чимээ аниргүй сумын төв нам гүмхэн байлаа. Гэтэл шөнө дунд буун дуу гарч цөөхөн хүн амтай багахан сумын төвийг цочоон сэрээж түгшүүр зарлав. Нэн дариу сумын албан хаагч хариуцлагатай дарга нар цугларав. Тэд маш шуурхай зөвлөлдөн урд хөршийн аюул занал мөн гэж үзээд ангийн буу зэвсэгтэй нэг нь түүнийгээ авчирч зэвсэглэв. Саяын дуугарсан буун дуу юу болохыг мэдэх гэж олон янзын таамаг дэвшүүлнэ. Нэг нөхөр

-Энэ буун дуу дуудлага дохио байж болох юм. Энэ дохиог хэн өгөв. Манай суманд хэн нэгэн тагнуул туршуул байхыг үгүйгэхгүй. Тэр хэн бэ? гэдэг дээр хэлэлцэв. Эцэст нь нэгдлийн мужаан Сагад гэж хэн бэ? гэдэг асуулт гарч ирэв.

-Тэр хаанаас ирсэн бэ?

- Улаанбаатараас

- Хэн хэнтэйгээ ирэв?

- Охин Хөхцэцэгтэйгээ хоёулаа

- Юу хийж байв?

- Нэгдлийн манаач, мужаан

- Зан төлөв нь?

- Номхон даруухан, маш ухаантай

- Хэн ажилд авав?

- Сум нэгдлийн дарга Хангал

- Удам угсаа гарал үүсэл нь?

- Элэнц өвөг дээдэс нь манай нутгийнх

- Хэн хэн гэдэг хүн байв?

Үүнийг мэдэх хүн нэг ч алга байлаа Тэд нэг мөр шийдэлд хүрч чадаагүй ч Сагад хэмээх нөхөр урд хөршийн тагнуул туршуул байж болзошгүй гэсэн магадлалд хүрэв. Ингэж маргалдаж мэтгэлцсэний эцэст сум нэгдлийн хамаг хөрөнгө болох албан байр, хөрөнгийн агуулах хашаа хороог хамгаалахаар хөдлөв. Тэнд буун дуу гарсан учир бүгд л дотроо муу муухай болгоныг бодож айж эмээнэ. Сумын дарга Хангал малын эмч Өлзий хоёр түрүүлэн сумын төвөөс олдсон ганц гар чийдэнг бариад бусад нь хойноос нь дагалдав. Сумын албан байрны өмнөх газарт нэг чимээ гарав. Тэд буу саадгаа бэлдэн тэр зүг рүү чиглүүлэв. Гэтэл нэгэн хүн газарт хэвтэн эвхрээд хоёр тийшээгээ бөмбөрөн хөдөлж байв. Тэд анхааралтайгаар ойртоно. Тэр хэвтэх хүн аяарханаар ёолох нь бүдэг бадаг сонсогдов. Гар чийдэнгийнх зай муу болоод гэрэл бүдэг улаан болж тод биш гэрэлтүүлнэ. Нөгөө хүний бүр дэргэд нь шахам ирээд сайн ажиглавал нэгдлийн манаач Магван байлаа. Малын эмч Өлзий яаран

- Хүүе ээ. Магван гуай та зүгээр үү? гэж асуухад тэр хэвлийгээ тэврэн ёолж

- Миний хууч өвчин хөдлөөд үхэхийн даваан дээр байна гээд дахин ёолов. Магваны гэдэс түгжирсэн учир маш яаралтай тусламж үзүүлэх учиртайг эмч хэлэв. Магван арай ядан

- Би амь алдах аюулд тулгараад ирэхээр нь манааныхаа бууны ганц сумаар буудаж дохио өгсөн хэрэг шүү. Дарга минь намайг өршөөгөөрэй гэхэд Хангал дарга их эмчид хандан

- Магван гуайг аваад Төгрөг сумын эмнэлэгт яаралтай хүргэ. Сагад мужааныг өглөө ирж манаанд гар гэж хэл. Өнөө шөнөдөө би эндээ үлдье Бусад нь амарцгаа гэлээ. Энэ хүний гаргасан шийдвэрийг өөрчлөх арга байхгүйг бүгд мэдэх учир гэр гэрийн зүг рүү одоходоо баяртай байлаа.

Сагад мужааныг тагнуул туршуул болгон Хангал даргыгаа хамсаатан хэмээн зэмлэх шахам байсан зарим нэг хүмүүс дотроо гэмшинэ. Түрүүлж дуугарсан хөхөөний хошуу хөлдөнө гэдэг үнэн бололтой. Энэ нэгэн явдлыг эргэн дурссан сумын удирдлагууд дор бүрдээ ийн бодоцгооно. Нэг нь

- Бид нутгийн ах дүүс хүмүүс бие биенээ олиггүй юманд сэрдэж сэжиглэх нь тийм ч сайхан зүйл биш ээ. Нэгнийхээ сэтгэлд хар хор суулгахаас цааш хэтрэхгүй тангараг дамцаг алдахын нэмэр гэж бодож байхад Ширмэн

- Тэр бунхан булш ямар хүнийх болоод хэн ирж сэргээгээд байна? Үнэнийг хэлэхэд нам төрийн бодлого, үзэл сурталд тохирохгүй шүү дээ. Үүнээс болоод бүх булш бунхан, хиргисүүрийг тахиад сэргээгээд эхэлвэл яах вэ? Энэ шашин шүтлэгийг чинь Маркс “ Хар тамхи” гээд тодорхойлчихсон шүү дээ. Бид нам төрийнхөө бодлогыг барьж түүний заасан

замаар л явах ёстой гэж нэг мөр шийдвэрт хүрч байхад өөр нэг нь

- Тэр нэг эрт дээр үеийн булш ч юм уу? биш ч юм уу? хэдэн чулуу тавьсан овгор шороог л засаж янзлаа биз. Тэр нь хүмүүсийн сэтгэл санаанд нөлөөлөөд үзэл суртлын дайн зарлаад байх нь юу л бол доо. Бид заримдаа дэмий юманд сүржигнээд байх юм гэж бодож байхад ондоо нэг нь

- Шал дэмий юмаар цагаа барж байх юм даа. Цаана нь ажил овоорчихоод байхад Тэр бунхан шарил бидэнд ямар хамаа байна. Ухвал хэдэн өгөр яс л гарна биз. Өөр юу л байв гэж. Ингэж суухын оронд ажлаа л бодъё доо хэмээн бодож суухад Намхай дарга хоолойгоо засаад танхимд байгаа гишүүдийнхээ анхаарлыг өөр дээрээ татаад

- Нөхөд өө. Цаг үеийн тулгамдаад байгаа ажлуудаа хариуцсан хүмүүс нь цаг нар алдалгүй хариуцлагатай хийцгээе. Харин энэ асуудлыг манай орлогч бид хоёр судлаж учрыг олъё. Олны дунд нэгэнтээ шуугиан дэгдээгээд байгаа асуудлыг зүгээр орхиж болохгүй байх. Бид чинь ард олныхоо итгэл найдварыг биелүүлэх гэж нам засгаас томилогдон алба хашиж байгаа гэдгээ сайн санах хэрэгтэй гэснээр хурал өндөрлөв. Тэд өнөөдрийн хөндсөн Бунхан салааны амны булшнаас болоод өнгөрч баларсан нэгэн инээдэмтэй ч эмгэнэлтэй үйл явдлыг нэхэн дурссан нь санаа сэтгэлээс нь сайн гарч өгөхгүй болохоор бодол бодлоо тээгээд ажил үйлээ хөөцгөөв.

Арван зургаа

Сумын төвийн намын үүрийн товчоо Бунханы салааны бунхан шарилыг хэн сэргээсэн тухай хэлэлцэж байх тэр мөчтэй давхцан Их салааны аманд байх дөрвөн ханатай багахан гэрт сохор өвгөн Балбар Авирмэд гавжийн тухай домог түүхийг үргэлжлүүлэн нэхэн дурсаж суулаа.

... Авирмэд гавж гурван манжийн хамт Тэнгэр уулнаас буцаж буугаад хөөрхий манжийн түшмэлийн хойт, урдахыг бүрэн хийж биеийг нь наранд ээвэр энгэр газар хөдөөлүүлэв. Түшмэлийн унаж явсан морь хуй салхинд мод гуядаж уруу газар луу хийсэхдээ зүүн хаагаа хуу татан нилээд их бэртэл авсан болохоор тэд хүнсэнд хэрэглэв. Энд үлдсэн гурван манж Авирмэд гавжийг шүтэн биширч

-Хай манай түшмэл танай хэлсэн үгийг авсан бол юундаа амиа алдах билээ. Бас тэгээд унаж явсан морь нь хүртэл ийм хүнд бэртэл авдаг нь юу билээ. Одоо бид энэ Тэнгэр уулаар яаж давна. Дахиад аюул болвол яана аа гэж яриа болоход түшмэлийн туслах гэх манж залуу

- Би монгол хэлээр муухан ярина. Харин сайн ойлгоно. Манай түшмэл

- Чи монгол хэл мэдэхгүй юм уу? гэхэд би

- Би мэдэхгүй бас сурах дургүй гэхэд тэрээр намайг дооглонгуй хараад

- Чи жинхэнэ манж хүн мөн байна. Надтай хамт явж намайг байнга хамгаалж бай гэж тушаасан билээ. Би тэгээд л дандаа хамт явж биеийг нь хамгаалж байлаа гээд чимээгүй болоход нөгөө монгол хэл мэддэг зарц манж нь

- Цааш нь ярь, ярь. Чи юу ч битгий нуув аа. Гавжид бид гурав шударгуу хандах нь зөв болвоо гэхэд туслах

- Хай .Хүрээ хийдэд байхад нэг орой донир Готов манай түшмэлийг их зоогонд урив. Түшмэл намайг дагуулж очсон юм. Гэтэл Донир

- Наад хүн чинь хэрэггүй. Та бид хоёрыг их Гэсгүй хүлээж байгаа гэхэд манай түшмэл муу санаалав бололтой

- Зүгээр ээ. Энэ хог монгол хэл мэдэх ч үгүй бас ойлгодоггүй юм гэснээ заль гарган хэрвээ дагуулахгүй бол намайг ганцаараа явсан гэдгийг ноёнд ховлож орхино шүү дээ гэхэд донир Готов

- Танай манж хятадууд ч бие биенээ тагнаж туршсан тун ч золигийн хүмүүс шүү. За яахав. яваг, яваг. Үүдэн дээр харуулд зогсоочихье гэв. Тэд их ч сүр бадруулсан зоог барьсангүй. Харин нэгэн чухал зүйлийн тухай хэлэлцэв. Тэр гурав хөшигний цаана суугаад намайг үүдэнд хүн харж бай. Хэрвээ ирвэл дохио өгөөрэй гэв. Тэдний яриа надад тодхон сонсогдож байлаа. Донир ямар нэгэн юмыг манай түшмэлд өгөөд

- Энэ болно биз дээ гэхэд манай түшмэл чимээгүй байснаа зургаан алтан ембүү арван

лангаар юм уу? гэж хоолой нь ээрэгнэн дуугарахад Их гэсгүй

-Тийм ээ. Түшмэл ээ. хангалттай биз дээ. Бид танд итгэж болох уу? гэж асуув. Манай түшмэл инээд алдаад

- Битгий санаагаа зовоо. Энэ юухан байх билээ. Хэзээ ч болох юм биздээ гэж асуув. Донир Готов

- Тэнгэр уул давуулаад л тэнд нь бөх нойрсуулчих. Тэнгэр уулнаас наана бол сүнс нь ирж нэхэл дагал болоод гай татна гэлээ. Манай түшмэл

- Тэр Авирмэд гэгч чинь гавж хүн гэл үү? гэж лавлавал Их гэсгүй

- Эрдэм номоор мархуухандаа. Манай Хамба ламын ивээлд багтаад бидний бөгсийг малтаад байгаа хэрэг. Зүгээр байсан бол юундаа ийм нүгэлд унах билээ. Бид ч бас хүн болохоор хожмоо бодож замын гай барцадыг арилгах нь зөв биз дээ гэхэд Донир

- Эрдэм гээд гавих юм байхгүй. Зүгээр л дүүгүүрийн чулуу шиг дүнгэнэж байдаг хоосон толгой доо. Дүүгүүрийн чулуу заримдаа зүггүйтэн ирээд толгой хагалчихаж мэдэх юм гэсэн ухаантай юм гээд инээхэд манай түшмэл

- Танай хүн тун ч мэргэн үг хэллээ гээд инээдэм болголоо. Их гэсгүй

- Эрхэм түшмэл ээ? Би таныг гаргаж өгч чадахгүй болохоор та өршөөгөөрэй. Бүгдийг манай Донир гүйцэлдүүлэх болно гэхэд манай түшмэл

- Аливаа нэг юм сэжиг бага байх тусмаа хийхэд хялбар байдаг юм. Би танай хоёрын итгэлийг алдахгүй гэж итгэлтэй нь аргагүй хэлэхэд Их гэсгүй

- Аян замдаа сайн яваарай. Манай Донир үдэж мордуулахдаа танай алтан шар замыг бас алтан шар өнгөөр мялааж ерөөл талбих бизээ гэсээр гарч одов. Донир, манай түшмэл хоёр хэсэг хугацаанд сархад зооглон элдвийг хүүрнэлдээд өндөрлөсөн гэж ярив. Авирмэд санаанд багтамгүй үг өгүүлбэр үйл мөрийг сонсоод дотроо

- Ээ бурхан минь. Бурханы шашны хуваргууд тэр мөртлөө зэрэг дэв тушаалтай хүмүүс ийм аймшигтай зүйлийг санаж сэдээд харийн хар санаатнуудтай хамжин гэм хоргүй нэгнийгээ хөнөөх гэж байдаг байх нь ээ. Бид чинь бурханы ариун сургаалыг сонсож дээдийн номын авшиг хүртсэн сахил санваартай шавь нар нь шүү дээ. Энэ хорвоогийн чинь юу нь үнэн юм бэ? хэмээн бодоод Хутагтын дөрвөн үнэнийг дурдахад хүрэв. Үүнд:

Зовлон үнэн

Зовлонгийн шалтгаан үнэн

Зовлонгоос гэтлэх нь үнэн

Зовлонгоос хагацах нь үнэн хэмээсэн байдаг.

Үйлийн үрийн шалтгаан бол хүний бүх насны дагуул, дахин төрөл олж зовлон эдлэхийн сурвалж болдог. Энэ их зовлонгоос хагацахыг хүсвэл гагцхүү сэтгэлээ ариусгах, үнэнийг гэгээрэхүйн мөрөөр олж чадна. Бурхан багш ариун үнэний сургаалиа тавих үед дээд тэнгэрийн эсрүн хурмаст алтан хүрдээ барин бөхийж доод газрын бодь гөрөөс урд хөлөө бохирон номын дуу сонссон юм гэнэ лээ гэж бодов. Тэр Их гэсгүй, Донир хоёрт огтхон ч гомдсонгүй. Харин тэдний мунхарсан сэтгэлд харамсаж байлаа. Тэр дахиад л Манлайгаа бодов. Манлай

-Сонин юм даа. Хамба ламтан чамайг ганцааранг нь дөрвөн манжтай төлөөнийхөө хүнээр явуулмааргүй л юм. Намайг зулын тос, цагаан идээ хүргэж очиход Хамба

- Манлай. Би танай Авирмэд гавжийг өмнийн Дашлхүмбэ хийдэд суулган ном эрдэм болоод бас бус зүйлд сургаж дадлага туршлага суулгаад дөрвөн жил болоод ирэхээр нь би чөлөөндөө сууж танайхны хавиар цэнгэг ус цэвэр агаарт гарч бие нь жаахан амраая гэж бодож байна гэхэд Манлай

- Багш аа. Та өөрөө хэлдэг биз дээ. Бурханыг өнө удаан олон жилээр шүтэж ивээлд нь багтаж номынх нь ариун сургаалийг сонсож явья гэж бодож байгаа бол эрүүл саруул байж урт наслахыг эрхэм болго гэж бидэнд захидаг шүү дээ. Багшаа таны санаа зөв байна. Манай Авирмэд таны итгэлийг алдахгүй гэдэгт би л хувьдаа итгэлтэй байна гэхэд Хамба

- Би ч чамтай адилхан бодолтой байгаа. Танай том хүү Агваанням хэр зэрэг сурч байна даа гэж асуухад Манлай инээмсэглээд

- Магтаад ч байх юм алга. Авирмэдийн дэргэд хоёр жил байлгаж ном эрдэмд сургасан нь тун ч сайн юм болсон шүү. Багш аа би нэг их голохгүй л байгаа гэв. Хамба

- Овоо доо хүү минь. Олноос олон шавь байлаа ч онцолж авах нь тун цөөн юм даа. Үхэн үхэтлээ энэ хүрээ хийдийнхээ төлөө зүтгэж амьдрал, амь насаа зориулна даа гээд урт гэгчээр санаа алдаж билээ гэж хэлээд Манлай урт соруултай гаансандаа тамхиа нэрж татах зууртаа

- Тийм юм ярьж байсан хүн чинь ингээд хөхөө өвөл эхэлж байх үеэр харийн манж хятадуудтай явуулна гэдэг нэг л санаанд багтахгүй байна. Цаана нь ямар нэгэн учир шалтгаан байх шиг санагдаад байна гэхэд нь Авирмэд Манлайгаа тайвшруулж

- Би хөө өөрөө л хүссэн хэрэг. Тэр хол байх Тэнгэр уулыг үзэх завшаанаа алдах вий гэсэндээ өөрөө зөвшөөрсөн юм шүү дээ гэж хэлээд түүний сэтгэлийг амрааснаа тодорхой санав.

Бурханы олон шавь нар дотор бусармаг явдалтай хүмүүс байгаа нь санаанд ер багтахгүй байлаа. Бурхан шүтээн орших номын цагаан буян дэлгэрсэн сүсэгтэн олны сайхан сэтгэл хурсан сүм хийдийн ариун өргөөнд сэтгэлдээ гурван хорыг боловсруулж арван хар нүглийг үйлдэж суугаа хуварга хүн байна гэж бодохоор Авирмэд их харамсаж байлаа. Би гавж хэмээх эрхэм алдар цолыг хүртэж гэгээрсэн гэх мөртлөө Бурханы сургаалийг уландаа гишгэж ухаандаа таван нисваанисыг хураасан, гаднаа хэргэм зэргийн хувцсаар гоёсон хорт могой мэт хүйтэн сэтгэлтэй хүмүүсийн өмнө тэргүүнээ бөхийлгөн тэдэнд хүндэтгэл үзүүлж үгийг нь үг дуугүй дагаж хүссэнийг нь хүлээн авч байснаа санах тусмаа дотроо халаглана.

Дахиад тэр хүрээ хийдэд ном хурж сууна гэхээс сэтгэл нь эмзэглэж дургүй нь хүрч байв. Талийгаач манж түшмэлийн туслах ачаа барааг нь цэгцэлж байх даа Их гэсгүй, донир хоёроос авсан зургаан алтан ембүүг гаргаж ирээд

- Гавж аа. Энэ зургаан алтан ембүү таны амь настай тэнцэж байсан нь үнэн билээ. Миний санахад та одоо хоёр амьтай боллоо. Тиймээс та энэ зургаан алтан ембүүг авах эрхтэй. Бид гуравт огт хэрэггүй. Дахиад ч гай зовлон ирэхийг үгүйсгэхгүй. Бид ч айж эмээж байна гээд хоёр гардан Авирмэдэд барихад тэр огт эргэлзэхгүйгээр тосон авч нөгөө гурван манжийг ээлжлэн харснаа

- Таны хэлдэг үнэн. Нэг амийг нь олон түмний тус буянд зориулъя. Нөгөө нэг амиа өөртөө урт наслахад хямгадъя гэхэд манжууд дороо бөхөлзөн та мэргэн хэмээн зулгуйдах аядана.

Энэ гурван манж талийгаач түшмэлдээ дургүй байсан бол энэ аялалын хорь гауй хоногт түшмэл нь Авирмэдийг дэндүү гоочлон илүүд үзэж үхэх хүнд үг хэрэггүй гэх зэргээр доромжлон дорд үзэж байсан. Тэнгэр уулан дээр түүнийг дагуулж гарсан хоёр хоногийн өмнө Авирмэдийн хэлсэн үгийг нохой хуцсаны дайтай бодолгүй үл ойшоон хорвоогоос явахад хоёр хоногийн наана цаана ямар ялгаа байна гэж өөрийнхөө санааг илт тод илэрхийлсэн.

Гэтэл тийм бардам байсан түшмэл өөрийнхөө амь насыг алдаад зогсохгүй унаж явсан морь нь хүртэл эндэж осолдсоныг гавжийн номын хүч гэж ойлгоод түүнд ийнхүү тал засаж зулгуйдах дүр эсгээд байгаа нь энэ билээ. Түүгээр ч барахгүй энэ гавж үргэлж сур бүслээд явсан нь модны хуурай мөчрийн унгинд тэр суран бүсээрээ өлгөгдөн амьд үлдсэн нь энэ хүний эрдэм номын хүч чадал их, болох үйл мөрийг эртнээс мэдэж байсан учир тэр сурыг бүсэлсэн гэх зэргээр шүтэн биширч өөрсдийгөө ч бас даалгаж амь насаа хамгаалуулахыг хүсэж байлаа.

Ядахдаа Тэнгэр уулыг аюул осолгүй давуулж өгөхийг гуйхаар зэхэж байв. Авирмэдийн бэртэл гэмтэл амархан илаарших аргагүй учир тэд зөвлөлдөөд нутгийн нэгэн айлтай танилцан Авирмэд тэр айлд өвөлжин биеэ бүрэн тэнхрүүлээд урин дулаан цагтай золгож байж нутаг буцахаар болж гурван манж хоёр тэмээн хөсөгтэйгөө аяныхаа зам мөрөө үргэлжлүүлэхээр шийдсэн билээ. Манж түшмэлийн туслах Авирмэдэд хандан

- Бид адилхан хүмүүс бас ном буяны садан билээ. Бид гурвыг эрдэм номынхоо их хүчинд багтааж аян замын минь саад бэрхшээлээс гэтэлгэж бүрэн бүтэн очиход минь туслана уу? гэж хүсэж байна гээд гарын бэлэг болгон бага сага юм барихад Авирмэд гавж инээмсэглээд

- Та гуравынхаа сэтгэлийг ойлгож хүсэж байгааг чинь хүлээж авлаа. Харин наад барьж буй юмаа та гурав өөрсдөдөө үлдээ. Та гуравт маань хол зам туулах учир хэрэг болно. Би энэ сайхан хүмүүсийн гэрт биеэ тэнхрүүлээд суурин байхын учир надад хэрэг болохгүй. Би өдөр бүхэн та гурвыгаа бурханд даатгаж саадгүй сайн явахын ерөөл тавих болно. Тэнгэр уулаар сайхан морилж давах болно.

Тэнгэр хангай биднийгээ ивээл элгэндээ багтаасан байгаа гэснээр гурван манжаа үдэж Авирмэд нэгэн уйгар айлд үлдэв. Энэ айл ам бүл дөрвүүлээ. Гэрийн эзэн Далай эхнэр Намуу, охин Үзмээ гурав мал маллаж амьдарна. Хүү Начин нь айл гэр болоод Өрөмчийн хошуунд

амьдардаг. Далай Авирмэдийн гуйлтыг сонсоод тийм ч таатай хүлээж авсангүй. Гэхдээ монгол ах дүү нар байна. Ийм хүнд гэмтэл бэртэлтэй хүнийг өвлийн хүйтэнд хөөгөөд явуулалтай нь биш. Биеэ тэнхрүүлээд эрүүл саруул болоод урь унахаар явна биз хэмээн дурамжхан дуугарсан билээ.

Энэ айл их эмх цэгцтэй цэвэрхэн ажээ. Далай мал ахуй гаднах ажлаа ягшгал хийнэ. Охин Үзмээ нь арван есөн настай гэр орон гал тогооны ажлыг тун ч эвлэгхэн амжуулна. Эхнэр Намуу нь олиг өвчтэй учир тэр болгон хөдлөөд байхгүй зөвхөн ам ангайж хошуу нэмэхээс цаашгүй. Авирмэд гэмтэл бэртлээс гадна битүү хүйтэн жин цохисноос уушиганд нэвтэрч салхи залгингуут хөхүүлэн ханиалгаж түгжирнэ. Гэрт байнга дулаан суугаад байвал арай гайгүй болно. Заримдаа нойрон дундаа ч хөхүүлж ханиалгана. Далай нэг өдөр хоймороо байх модон ширээг уудлан илгэн ууттай зүйл гарган

- Үзмээ миний охин шанага хэрийн ус буцалгаад орхиоч. Аавдаа цаад уур нүдүүрээ аваад өг гэлээ. Үзмээ ч усаа буцалгаж, Далай ч нэгэн ургамал нүдэж нунтаглав. Далай буцалсан усан дээрээ нөгөө нунтаг ургамлаа хийгээд таглаад орхив. Дөнгөж бүлээн болох төдийд дунд модон аягаар нэгийг Авирмэдэд уулгав. Маргааш нь өглөө, орой хоёр нэг нэг аягыг уух юм шүү гэж зааварлав. Тэгээд тамхиа татан сууснаа

- Манай Тэнгэр ууланд ургадаг Вансэмбэрүү цэцэг байгаа юм гэхэд Авирмэд бараг л дуу алдах шахав. Өөрийн эрхгүй Алаг хайрхан хар ангилагийн асга хаданд хосоор ижилсэх Вансэмбэрүү цэцэг үзэгдэх шиг боллоо. Тэр чимээгүйхэн дотогшоогоо бодлоо шингээн уяраад амандаа аяархнаар

- Вансэмбэрүү гэж шивнэхэд Далай сонссон бололтой

-Юу гэнэ ээ. Вансэмбэрүү гэв үү? гэхэд Авирмэд

- Тийм ээ. Би энэ цэцгэнд мөргөж шивнэсэн юм аа гэхэд Далай

- Та энэ цэцэгийг мэдэх үү? гэж асуув. Авирмэд их л тайвнаар

- Мэднэ ээ. Манай Алаг хайрхан ууланд ургадаг юм гэлээ. Далай бодолхийлээд

- Алагхайрхан гэнэ ээ. Нэг л сонссон уулын нэр байх чинь. Вансэмбэрүү чинь цөөхөн уул хайрханд ургадаг гэсэн гэж бодлоо бэлчээн байснаа

- Аан одоо саналаа. Маарамба ахаас сонсож байсан юм байна. Энэ Алаг хайрхан уулын нэрийг гэж баярлангуй хэлэхэд нь Авирмэд өлгөөд

- Тэр уул миний төрсөн нутаг юм шүү дээ гэв. Энэ уул нурууд чинь бүгд л ахан дүүс, бие биеэ харж нарийн учир жанцангаар холбогдсон байдаг юм гэнэ лээ. Манай Тэнгэр уулыг цэцэгсийн орон их Бодьсатва оршиж байдаг. Гэтэл энэ Мичингийн нурууг үзэм жимсний орон мичний хаан оршдог гэдэг. Танай тийшээ бас нэг тэнгэр гэсэн уул бий. Юу билээ дээ гээд бодолхийлэхэд нь Авирмэд

- Отгонтэнгэр хайрхан уу? гэж асуухад Далай урд өмнө дуу цөөнтэй байдаг хүн чинь энэ удаа баярлан

- Тийм, тийм Отгонтэнгэр хайрхан. Тэр хайрханд рашаан усны эх булгийн Очирваань бурхан оршдог юм гэнэ лээ гээд дахиад бодол болов. Далай алив нэгийг санах гэж байгаа бололтой чимээгүй болов. Авирмэд дотроо

- Энэ Далай гуай чинь их юм мэддэг хүн байна шүү. Вансэмбэрүү уушигны өвчинд сайн гэдгийг мэдэж байна. Эхнэр нь олон жил олиг өвчинд ороогдон өвдөж байгаа болохоор юм юм л эрж хайж элдвийг сонсож яваа биз дээ гэж бодож суув.

Вансэмбэрүү цэцгийн хандыг гуравхан удаа уугаад уушиг нь цэвэршиж гучаад хоноод Авирмэдийн бие бүрэн илааршив. Харин эхнэр Намуугийн бие улам л муудаад байлаа. Далай аргаа бараад Бархөл рүү явж эм тан залж ирэхээр болов. Тэр малын арьс шир, ангийн үс бага зэрэг мах авч явах гэхээр тэмээ ачаатай явахаар ирж очихдоо наад зах нь зургаа долоо хононо. Эднийг авч явахгүй гэхээр эм тан авах боломжгүй болоод байв. Үүнийг мэдсэн Авирмэд

- Далай гуай та санаагаа битгий зовоо. Энэ хоёр алтан ембүүг аваад яв. Эм тан, хүнс тариа тамхиа базааж аваад ир. Би сайн санааны үүднээс өгч байгаа юм. Би мал ахуй гадна ажлыг тань сайн хийх болохоор ажлаа бүтээгээд ирээрэй гэв. Далай амьдралдаа арван лангийн алтан ембүү барьж үзээгүй мөртлөө хоёрыг барьж байгаа даа бага зэрэг балмагдаж орхив. Далай Авирмэдэд

- Дүү минь их баярлалаа. Би ухасхийгээд ажил хэргээ бүтээгээд ирье. Дан тэмээтэй юухан байх вэ? гэсээр хөдлөв. Үзмээ ээжийгээ асарч гэр доторхи ажлаа амжуулна. Авирмэд мал ахуй, хот бууц, түлээ түлш, мөс цас гээд л гаднах хамаг ажлыг гэрийн хүн шиг сэтгэлээрээ хийж байхад Үзмээ бүсгүй түүний өөриймсөг хандаж байгаад баярлаж байв.

Хүний амьдралын ээдрээтэй олон зам мөрийг зурж бичихэд нэн бэрхтэй билээ. Түүнийг тааж тааварлах урьдчилан мэдэх арга байхгүй. Болж бүтэх юм хэмээсэн нь бүтэлгүйтэж хүсэж хүлээгээгүй үйл мөр хүрэлцэн ирдэг хүсэл хяслаар дүүрэн зовлон жаргал ээлжлэн байдаг энэ хорвоог яалтай нь билээ.

Далай гуайн эхнэр Намуу цагаан сар өнгөрөнгүүт өөд болж энэ айлын хүмүүсийг уй гашуу нөмрөв. Далай дуугаа хурааж бодолд дарагдаад үе үе уртаар санаа алдах нь сэтгэл сэмлэнэ. Гэтэл сэтгэлийн хайлангаа гадагшаа барьж чадахгүй асгаруулах дотогшоогоо халаглан харамсан гашуудах Үзмээ охин үнэхээр зүрх шимшрүүлж өр өвтгөнө. Авирмэд гавж өөрийнхөө чадлаар ном буян үйлдэнэ. Бас сэтгэлийн зовлон нэмэгдэнэ. Гэмтэл бэртэлтэй шарх сорвитой байхдаа толгой хорогдож эрүүл саруул болчихоод ийм их зовлон уй гашууд дарагдсан энэ айлын хоёр хүнийг орхиод явчихна гэдэг мөс жудаггүй хэрэг болно. Тиймээс буяны хоногийг нь тараах хүртэл азнахаар шийдэв.

Хүү Начин нь ирж хэд хоноод ардаа ажил ихтэй гээд яаран буцав. Авирмэд энэ айлын зарц барлаг аятай борви бохирох завгүй гадна дотнох болоод мал ахуйн ажилд зүтгэнэ. Цаг хугацаа гэдэг алив нэгэн зовлон зүдгүүрийг элээж бардаг билээ. Гэтэл Далай сэтгэлээ улам ч алдаж бор дарсанд дурлаж түүгээр сэтгэлээ засаж байлаа. Охин Үзмээ аавынхаа эл байдалд сэтгэл

их зовион ичиж зовохгүйгээр Авирмэдэд

- Ах минь та. Аавыг минь уй гашуугаасаа салж эрүүл саруул болтол ханьтай байгаач. Таныг явбал манайх гэдэг айл ямархуу байдалтай болохыг та гадарлаж байгаа шүү дээ. Аав минь архинд донтоод цагаан солиотой болчих шиг боллоо гэж уйлан хайлан түүнд мөргөн гуйхад нь санаа ихэд зовсон Авирмэд түүнийг түшин босгоход Үзмээ бүсгүй түүний хүзүүгээр тэврэн авч

-Та эндээ үлдээч. Намайг битгий орхиоч гэж зүрх зүсэм гунигтай аялгуугаар аймшиггүйгээр шивнэн хэлэв. Тэр айхын бараа ажлын дэм болгох гэж түүнийг гуйсангүй. Аврал эрж арчаагаа алдаж буй хэрэг биш байлаа. Тэр зүрх сэтгэлдээ нандигнан хадгалж өрөөлөөс бус өөрөөсөө ичингүйрэн нууцлаж айх гайхах зэрэгцэн алдаа оноогоо дэнсэлсэн хэлж боломгүй хэцүү бэрх үйлийн үрээр өдөөгдсөн үнэн хайр сэтгэлээ өөрийн мэдэлгүйгээр бас аймшиггүйгээр ийнхүү зарлав.

Авирмэд ухаалаг хүн болохоор Үзмээ бүсгүйн зүрх сэтгэлээс уянгалах энэ эгшигэн үг түүний сэтгэлийнх нь хөг аялгуут хөвчийг нь доргиоход эрүүл чийрэг эмнэг хангал бие нь тэр чигээрээ чичирхийлэв. Хүмүүний амьдралыг алт мөнгө, эд таваар биш сэтгэл хэмээх нэгэн их хүчин хөтлөн явдаг нь энэ бөлгөө. Авирмэд гавжийг нутаг буцахгүй байгаад Далай баярлаж байв. Энэ залуу хүн чанартай сайхан сэтгэлтэй хүн билээ. Охин бид хоёрыг орхиод явчихаж чадахгүй байгааг бодоход түүний сайхан сэтгэл бүр ч танигдаж байна. Би гэдэг хүн энэ хар уснаас нэг салж хүний өөрийн хүмүүсийг нэг амраах юм сан. За маргааш л нэг сайн ууж аваад больё гэж өөртөө ерөөл бусдад ам андгай тавьсан ч амьдрал дээр биелэхгүй байлаа. Түүнд маргааш олон тул тэр амьдарсаар байв.

Энэ зуурт Авирмэд ч олныг бясалгаад амжсан билээ. Тэр хүрээ хийдэд бугшиж бузар болсон Их гэсгүй, Донир мэтийн хар нүгэлтнүүдийг бодохоос эргэж очиж сууна гэж бодохоос ой гутна. Тэдэнтэй зэрэгцэн сууж нэгэн тогооноос хоол идэж, нэгэн агаараар амьсгалж, нэгэн хүрээ өргөөнд хамтдаа байж чадахгүй гэдэгтээ улам итгэл үнэмшилтэй болов. Бурханы айлдвар, номын цагаан буяныг аль ч газар нутаг орон дэлхийд ямар ч хэлбэр маягаар хүргэж буян үйлдэж болохыг ухаарав. Ботгон нүдтэй үзмэн уруултай, тэргэл саран шиг дүгрэг царайтай, тэнгэр уул шигээ ухаалаг Үзмээ бүсгүйг өнчирч хоцорсонд нь өрөвдөж орхиод явж чадахгүй нь гэж санаж байсан нь бүр орвонгоороо бүтэн эргэчихэв.

Тэр эрдэм номтой, эр чадалтайдаа биш эр заяаны зөнгөөр энэ бүсгүйг сэтгэлдээ хайрлаж ертөнцийн жам ёсыг даган ерөөл талбиж амьдрал хүсэж өдөөгдөн байсан гал дээр Үзмээ тос нэмэх төдий болж хоёр залуугийн хайр дурлал түймэр мэт дэгдэв. Цаг хугацааны эрхэнд хүний амьдрал захирагдаж байдаг билээ. Тээр жил Тэнгэр уулын бэлд айлын хаяа бараадан байсан тэр цагаас хойш бүтэн гурван жил ард хоцорсон байв. Хүний нас хэмжээтэй болохын учир гурван жил гэдэг чамгүй урт хугацаа билээ. Авирмэд, Үзмээ хоёрын амссан зовлон багадаагүй ихэдсэн байж мэднэ.

Далай хөлчүү явж мориноос унаж чирэгдээд хамаг биеэ эвдэн хэмхэрч гурван сар хэвтэрт байгаад мөнх бусыг үзүүлэв. Өнгөрсөн өвлийн их зуднаар хэдэн малын нохойд зулгаалгах ихэнх нь нүд аньж, ногоо зулгаах нь цөөн тоотойхон үлдэв. Хоёр залуу нэг л хүсэл мөрөөдлөөр Авирмэдийн нутагт амьдрахаар сэтгэл нэгдэн зориглов. Тэд Тэнгэр ууландаа

сүсэглэн залбирал даатгал өргөөд байгаа юмаа гололгүй бас орхилгүй хөтөлгөө моринд ачиж өмбүү цөмбүүг нь унасан мориндоо ганзаглаад Бархөл орж нутгийн жинчидтэй ам хэлээ ололцож дөрөө нийлүүлэн хөдлөв.

Тураг туйлдахдаа уулаа барааддаг, хүмүүн ядрахдаа урагаа түшдэг гэдэг. Харин бүсгүй хүн цагаан зээр хоёр нутаггүй гэдгийг Хонь усны их говийн зэрэглээ өөртөө шингээн чимээгүй хатирна.

Арван долоо

Өвгөн Балбар Авирмэд гавжийн тухай домог түүхийг дурсан санаж гүйцээгээгүй байхад нөгөө гайтай бунхан шарил сэргээсэн буруу номтонг олж илрүүлэх, хэн болохыг магадлах, хөшөө чулууны бичээсийн утга агуулгыг тайлах гэх зэрэг маш нууц ажлыг гүйцэтгэхээр намын даалгавартай итгэмжлэгдсэн төлөөлөгч Ширмэн Балбарынд гэнэтхэн морилов. Балбар бодол бясалгал, түүх дурсамжаа гүйцээж амжаагүйдээ дурамжхан байсан ч сумын төлөөлөгчийг хүндэтгэв. Ширмэн төлөөлөгч

-Балбар гуай. Та гэртээ л суугаад байна уу? ойр зуур гарав уу? гэж асуухад Балбар сохор нүдээ нухлан

- Би ганцаараа хаа холдох билээ. Ач хүүгээ ирэхээр нь морин дээр сууж хөтлүүлээд Сангийн далайгаа нэг тойрлоо. Бунхан салааны амны бунхан шарилыг сэргээсэн гэхээр нь тэнд нэг очлоо. Нүдгүй сохор амьтан чинь юугаа ч харж үзэх билээ дээ гэхэд Ширмэн

- Та тэнд өдөржингөө суусан гээ биз дээ хэмээн байцаах аястай болохоор нь Балбар

-Тэгсээн. Тэгсэн. Дээр үед юм гэнэ лээ. Та ч бараг төрөөгүй байсан байх. Энэ анчин Чоймболын эцгийн нэг хөх сэрх нүд нь сохорчихоод ганцаараа яваад л байдаг байж. Гэтэл нэг өдөр нөгөө сэрх чинь энэ бунхан булш дээр ирчихээд хөх чулуунд нь толгойгоо үрээд шөргөөгөөд өнжсөн юм гэдэг. Гэтэл маргааш нь ижил сүрэгтэйгээ яваад өгч гэнэ. Эзэн нь гайхаад малгайгаа аваад урдаас нь шидсэн чинь толгойгоо долийлгоод үргэсэн гэдэг. Тэгээд л сохорсон ямаа нүд орсон болохоор юмыг яаж мэдэхэв. Энэ муу хоёр нүдний нэг нь ч гэсэн нээгдэх ч юм билүү гэж горьдоод хэсэг суусан минь үнэн л дээ. Сохор хүнийг чинь тоож сонин хачин зүйл ярьж хөөрөх хүн ч олдохгүй юм даа. Таныг тоогоод ороод ирсэнд баярлалаа. Та цай уугаач гэхэд Ширмэн

-Балбар гуай. Тэр булш дээр бас нэг хөшөө босгосон. Түүн дээр бичиг бичсэн байна. Тэр бичиг юу гэж байгааг мэдэх арга байна уу? гэхэд Балбар нүдээ нухлан дотроо

- Энэ хүүхдүүд хийх ажлаа л хиймээр юм даа. Ийм дэмий юм хөөцөлдөж юугаа хийнэ гэж бодоод

- Би гэдэг хүн чинь ангархай ГА, эцгийн ПА эхийн МА- гаас цааш хэтрээгүй хүн шүү дээ. Хурлын номыг овоо л цээжилсэн байсан. Нүд сохорсноос хойш гутарч гунихдаа хараал уншсаар байгаад нөгөө цээжилсэн номоо ч мартсан. Одоо ч хадан гэртээ бушуухан очихсон гэж л бодож сууна гэв. Төлөөлөгч Ширмэн юу ч олж мэдэж чадаагүйдээ урамгүй байсан ч Балбараас

- Энэ булш бунханы тухай өөр домог яриа байдаг юм уу? Та мэддэг бол ярьж өгөөч гэхэд Балбар

- Би бага байхдаа нэг үлгэр шиг юм сонсож л байсан. Одоо заримыг нь мартаж орхисон бололтой. За байз. Энэ бунхан дор булш биш нэгэн ид шидтэй Бумба байдаг гэсэн. Энэ Бумба

байгаа орон нутагт эрдэм номд төгс эрдэмтэн мэргэд олноороо төрөх, эд хөрөнгө эрдэнэс хуран цугларч таван хошуу мал өсөж үржин бум хүрч байх ерөөлтэй юм гэнэ лээ. Сохор хүн дүйвээнээр гэдэг шиг би бодож л суух юм. Та бүгдээс эхлээд эрдэм номтой сайхан сэтгэлтэй залуучууд манай суманд олон байна. Мал ахуй ч сайн өсөж сум орон хүмүүсийн амьдрал ч дэгжин дээшилж байна гэхэд Ширмэн дотроо

- Энд үнэхээр ид шидтэй Бумба байгаад бидэнд ач тусаа өгч байвал мөн сайхнаа. Манай суманд эрдэмтэн мэргэд олон байна. Бас мал ч сайн өсөж байгаа шүү дээ. Бид дэмий юмны хойноос хөөцөлдөөд яваа юм биш биз гэж бодсоноо бодлоосоо айж цочих шиг болоод

- Би чинь намын гишүүн хүн. Хариуцлагатай алба хашдаг. Намаасаа нууц даалгавар авч нам төрийн эсрэг буруу үзэлтэнг олж илрүүлэхээр яваа хүн. үлгэр домог сонсчихоод түүний нөлөөнд автагдан үзэл бодол, үйл хэргээсээ буцаж болохгүй. Үхэх дөхсөн сохор өвгөний үгэнд үнэмшиж болохгүй. Ач хүү гээд байгаа Галсангийн Амархүүтэй ч уулзъя. Тэр нөхөр чинь их сургуулийн оюутан. Бас шүлэг зохиол бичдэг гэсэн. Дараа нь дуугүй Хайнзантай ч уулзана. Тэр хүнээр энэ бичээсийг заавал уншуулна. Би чинь нам төрийн маш нууц үүрэг даалгавар гүйцэтгэж яваа намын гишүүн хүн шүү дээ гэж төөрөлдөх шахсан ухаан бодлоо цэгцлээд баруун гараараа зүрхэн тушаагаа хадгалж яваа намынхаа гал улаан батлахыг тэмтэрч үзээд омогшив. Ширмэн гурван хоног Амархүүгийн мөрийг мөшгин хөөсөөр Өлзийтийн дэвсэгт байх хуц ухна маллаж байгаа Сагадын очсоныг мэдээд нэгэн санаа төрөв.

- Энэ Сагад нөхөр ер нь учир битүүлэг нөхөр шүү. Би тэр жил сэжиглэн буйгаа хэлээд амаараа шороо үмхээд хоцорсон . Энэ хүнийг манай Хангал дарга, малын эмч Өлзий хоёр л өмөөрөөд магтаад байдаг хүмүүс. Амархүү ч яахав залуу хүн болохоороо Сагадын охин Хөхцэцэгийг л бараадаад байгаа байлгүй. Гэхдээ л алив нэгийг сонссон үзсэн байхыг үгүйсгэхгүй гэж бодсоор Өлзийтийн дэвсэгт ирэхэд Сагадын гэрийн бууринаас өөрийг олж харсангүй. Хярын цэнгэг агаар зөөлөн илбэнэ. Ойролцоо хулгар шар тарвага хошгирно. Дурандахад үс нь бараг гүйцсэн харагдана. Ёстой л боодог хийхэд болсон санагдаад нүдэнд нь тос урссан шаргал хуйхтай алаг мах үзэгдэхэд амаа тамшаалан уруулаа долоов. Тэрээр гэнэт бодлоосоо цочин

- Би чинь намын гишүүн хүн гэж сэтгэлээ чангалав. Сагад нөхөр ганц гэрээрээ байх болохоор боодог лав хийж байгаа гэсэн хардах сэтгэл төрөнгүүт түүнийг шантаажлах арга олов гэж баярлав. Сумын төлөөлөгч Ширмэн нар жаргах үеэр хярын орой дээр байх Сагадын гэрийн барааг харав. Дээлийн хормой сөхсөн сэржигнүүр салхи үлээнэ. Тэнгэрийн баруун хаяанд бараан үүл хуралдаж жаргаж байгаа нарны туяанд зах нь улайрна. Тэр бараан үүл унтаж байгаад сэрсэн арслан аятай дүрс үүсгэв. Удалгүй гал дүрэлзүүлэн мушгирах луу болон хувирав. Нар далд оронгуут олон хар чононууд давхилдан ирж байгаа мэт болоход түүний дотор арзасхийн айх шиг болов. Тэр амандаа

-Шал дэмий юм бодоод. Олон хар чоно болоод байхдаа ч яахав дээ. Муу ёр байгаа даа гэж шивнэсээр Сагадын гэрт дөхөж ирэхэд морь нь чихээ сортолзуулан үргэх аядав. Ширмэн өөрийн эрхгүй хамар амаа дарахад хүрэв. Хуц, ухнын заарийн үнэрт морь хүн хоёр ийнхүү эгдүүцэн эвгүйрхсэн нь энэ билээ. Ширмэн төлөөлөгч Сагадтай гавьтай юм ярьж амжаагүй байтал тэр яаран ямар нэг юманд явах янзтай болоход нь Ширмэн

- Энэ нөхөр надаас дөлөөд зайлсхийгээд байна. Ямар нэг учир байгаа бололтой гэж бодож суутал Сагад
- Төлөөлөгч өө та тавтай суугаад цай ууж хоол зоогло. Би амжиж нөмөр газрын асга хад бараадъя гэлээ. Ширмэн төлөөлөгч гайхасхийгээд
- Та хаашаа явах гээд яараад байна аа? Би тантай бага зэрэг яриатай юмсан. Нам төрийн чухал даалгавар гүйцэтгэж яваа гэдгээ нэмээд хэлчихье гэж ихэрхэв. Сагад бага сага хувцас хунараа янзлах зуураа
- Өнөө шөнө нилээд шаггүй хүйтэн шамарга ирж бог гэхгүй бод малыг ч остоож мэднэ. Би муу санаандаа нөмөр нөөлөг газар бараадах гээд байгаа юм. Мал шамарганд нэг л цохиулчихвал дараа нь нөмөр газар очсон ч бээрээ нь гардаггүй золиг. Тэгээд л яараад байгаа ухаантай юм гэж тайлбарлахад Ширмэн дотроо
- Тэнгэрийн хаяанд бөөгнөрсөн хар үүлсийг санаад
- Та яаж мэдэж байгаа юм бэ? гэж асуухад Сагад тайвнаар
- Сар мичидийн тохиолготой. Бас салхины үзүүрт хүйтэн амьсгал ирсэн. Бөөн хар үүл нь мушгрич зангираад догшин дүртэй байгаа юм гэлээ. Ширмэнгийн сэтгэлд
- Унтаж байгаад сэрсэн арслан, сүр үзүүлэх луу, олон чононуудын дүр хувирал нь буугаад ирэв. Энэ үнэн байж мэдэх юм гэж санав. Тэр яаруухан өврөөсөө цаас гаргаад нөгөө бунхан булшны шинэ хөшөө чулуун дээр байгаа бичээсийг дуурайлган бичсэн бичгээ Сагадад сарвайгаад
- Та үүнийг нэг үзээд орхиоч. Юу гэсэн бичээс байна гэв. Сагад түүнийг аваад харвал өөрийнх нь бичсэн Их аграмба А. Чоймжуур гэж төвдөөр бичсэнийг тун ч адилхан хуулж бичсэн байв. Тэр
- Энэ хүн чухал даалгавартай яваа гээд байсан нь энэ бичээсийг мөрдөөд яваа байх нь гэж бодоод
- Энэ чинь юу юм бэ? Хээ угалз шиг хаашаа янзын эд вэ? Над шиг хүний ухаан хүрэхгүй бололтой гээд гайхан дээш доош нь эргүүлэн харахад Ширмэн дотроо
- Энэ хүн ч аргагүй байх аа даа. Манаач, мужаан хийж,хуц ухна хариулахаас цааш хэтрээгүй бололтой гэж бодоод доогтой маягаар инээмсэглээд
- За Сагад минь. Наад угалзан хээгээ надад өгчих. Тэгээд та ажлаа бод гэлээ. Сагад гарахдаа охиндоо хандан
- Төлөөлөгчийг үстэй дээлээр хучаад дулаахан унтуулаарай. Аав нь гэр орноо сайхан бөхөлчихсөн болохоор айх юм байхгүй. Би хоёр морио аваад явна гэснээ Ширмэн рүү харангаа

- Таны морийг би аваад явъя. Өглөө эрт аваад ирье гэхэд Ширмэн ёжтойгоор

- Сагад аа. Би унаж яваа морио мэдье. Харин та хуц ухна даа л эзэн бол гэж хэлэв. Сагад

- За, за тэгвэл би явъя. Мэдээтэй л байгаарай гэсээр харанхуй нөмрөх үеэр хуц ухнаа туугаад хөдлөв. Тэнгэр шөнө дундаас эхлэн муухайрч нарийн ширхэгтэй бороо орж байснаа хүйтэрч нойтон цасаар шамаргалаж сүүлдээ хяр дээгүүр цасаар шуурав. Өглөө уулын толгойд нар тусах үеэр намдав.

Чоно борооноор гэдэг юутай үнэн үг вэ? Сумын төлөөлөгч Ширмэн үстэй дээлээр хучуулаад тун ч тухтай нойрсож зүүдээ манаж чадсан бол унаж явсан морийг нь хоёр боохой цадатлаа зооглож аваад явсан байлаа. Урд орой унтахын өмнө Хөхцэцэг

- Төлөөлөгч өө та морио аргамжихгүй юм уу? Хүйтэн шамарга болвол уруудаад явчих байх даа. Өнөө шөнө амаргүй л байх болов уу гэж аав хаширлаад малаа аваад явлаа шүү дээ гэхэд Ширмэн ер тоосон шинжгүйгээр

- Хэрвээ хүйтэн цасан шуурга болвол аргамжаатай морь осгодог юм шүү дээ. Харин чөдөртэй морь нөмөр газар бараадаад осолгүй хонодог юм гэхээс өөрийг хэлээгүй билээ. Тэр үед Ширмэнгийн толгойд өөр нэгэн бодол эргэлдэж байв. Тэрээр

- Эр хүнд нэг муу аз байнга дагаж явдаг юм гэсэн. Өндөр уулын хяр дээр хорь хүрсэн бүсгүйтэй хоёулхнаа хононо гэсэн чинь юу гэсэн үг вэ? Тэгээд бас тэнгэр бүрхэг тас харанхуй, усан бороог урдаа уйлуулсан цасан шарамга тавина гэж байдаг. Энэ бүгд нийлээд надад нэгийг хэлээд байгаа юм биш үү? Үүнийг чинь л аз гээд байгаа юм гэж бодож байлаа. Ширмэн дулаан орондоо ороод аргалын галын үнэр үнэртэн хэвтэж байтал гэрийн берзентэн бүрээсийг борооны дусал түргэн түргэн цохих чимээ нэгийг сануулаад байгаа мөртлөө цаанаа нэг л түгшүүртэй мэт сэтгэгдэл төрүүлнэ. Түүний сэтгэлд гэнэтхэн

- Би чинь намын гишүүн сумын хариуцлагатай албан хаагч хүн. Намынхаа даалгавраар маш чухал нууц алба гүйцэтгэж яваа хүн шүү дээ. Гэтэл айлын охид бүсгүйчүүдийг оролдох хормойн ажил сэдээд олхиогоо алдаж явж болох уу? Ээ бүү үзэгд. Яасан ч болохгүй. Бүтэл нь хазайсан энэ хар толгой чинь намын дүрмэнд харшлаад нэр хүндийг нь унагах нь байна шүү дээ гэж бодоод Хөхцэцэг бүсгүйгээс айж ичин хүзүүнээсээ дээш хүрэн улаан болоод хөнжилдөө шургаад нүдээ тас анисан билээ. Өглөө босоод мориндоо явсан Ширмэн төлөөлөгч сул чөдөр барьсаар ирээд эмээлээ үүрээд алхахыг завдахад санаа ихээр зовж байсан Хөхцэцэг

- Төлөөлөгч өө. Та юундаа ингэтлээ яараа вэ? Цай уу. Аав одоохон ирнэ. Морь унаад явна биз дээ гэхэд тэр юу ч хэлсэнгүй. Алаг хайрхан уулын ноён оргилын мөнх цас мөсөнд ойх нарны гэрлийг харж байлаа. Уулын орой хяраараа бага зэрэг цас унаж энгэр, бэл, хоолой нь хүнхийж ногоортоно. Шөнийн орсон бороо, цасан шамарганд сэргэсэн цэцэгсийн үнэр хярын зэрлэг салхийг сүрчиглэн анхилам үнэртэж амьсгалахад нэн таатай. Гэлээ ч түүний сэтгэл дотооддоо будантай бас шамаргатай байлаа. Тэр эмээлээ доош тавьсанаа гартаа барьж байсан чөдрөө нэг сайн харснаа уртаар санаа алдаад уйтгартайгаар эмээл дээрээ шидчихэв. Хөхцэцэг санаагаа зовоож аргаа барж дэмий л хулмагнан

- Та гэрт орж цай ууна уу? гэж ээрэгнэн хэлэх нь төлөөлөгчийн морийг чоно идсэнд өөрөө л буруутай мэт ийнхүү барьц алдана. Сагад ирээд хэдэн сайхан үг хэлж Ширмэнг тайвшруулаад өөрийнхөө унадаг хүрэн морийг эмээллэнгээ

- Төлөөлөгч өө та унаатай залгасан газраа л хүрэн морийг суллаад тавьчихаарай гээд хамар аманд нь ямар нэгэн юм үнэртүүлээд таны морь миний тавьсан хил хязгаараас гараад явчихсан байна. Манай ойр хавьд чоно ульж л байдаг юм. Гэхдээ манайтай хил хязгаараа зөрчөөд байдаггүй өлзийгөө өгсөн амьтад юм сан.

Чоно борооноор гэдэг үнэн үг бололтой. Сайн санаатай итгэсэн хүнийхээ л унаар морийг зооглодог юм гэсэн. Саар муу явдалтай хар хорон санаатай хүнээс сэжиглэдэг гэж ярьдаг. Чоно байгаа газрын мал эрүүл, хүн соргог ухаантай байдаг л гэдэг.

Миний хүрэн моринд ижил сүрэг гээд хэлээд байх юм байхгүй. Манай охины гал шаргаас өөр ижилгүй амьтан. Харин эзэн хүн рүүгээ бол хаанаас ч ирнэ шүү дээ. Тиймээс та санаа зоволтгүй суллаад тавьчихаарай гэж захив. Сагад мэргэний чөдрийн ганц морийг унасан сумын төлөөлөгч Ширмэн сэтгэлдээ түмэн бодол тээгээд буцав. Түүний хол ойрыг хольж хутгасан эмх цэгц муутайхан бодлууд нь нэг цэгт төвлөрч зөв шийдвэр гаргаж чадахгүй байлаа. Тэр дотроо

- Би л илүү зан гаргаж хүнийг хий дэмий юманд хардаж сэрдэн хэрэггүй шахам булшны бичиг уншуулах гэж явснаас л боллоо. Сагад хөөрхий миний өрөөсөн гутал бололтой. Тэр бичгийг угалзан хээ юм уу гээд эргүүлж тойруулаад байсан шүү. Гэтэл энэ бороо цасан шуургыг мэдээд бас чононд хил хязгаар тавьсан, миний хүрэн морь аль ч газраас эзэндээ гүйгээд ирнэ гээд байгааг бодоход зүгээр нэгэн ч биш ээ гэж бодоод Сагадын хүрэн морины толгой, хоёр чихийг ажигласнаа дөрөөнд өндийн баруун гараа өргөөд

- Чуу хэмээн хэлтэл хурдан морь эргэх адил ухасхийхэд Ширмэн золтой л сугараад хоцорчихолгүй амыг нь ангайтал татан байж тогтов. Ширмэн амандаа

- Энэ чинь нүдэнд үзэгдэх байдлаараа номхон ноолгор, хашин хойрог харагдаж байсан ч халдаад ирэхэд агсам айзам, аймаар морь байх нь гэж хэлээд цааш гэлдрүүлэн олхиогүй олон бодлоо цэгцлэхийг хичээв. Түүнд

- Би намын гишүүн хүн. Хариуцлагатай үүрэг даалгавар гүйцэтгэж яваа төлөөлөгч гэсэн бодол орж ирэнгүүт нөгөө бусад аар саархан элдвийн муусайн бодлууд арилж оюун ухаан нь цэгцрэн омогшил төрөв. Ширмэн төлөөлөгч шуудхан бригадын дарга Санжийнд морио юүлээд Сагадын хүрэн морийг суллан тавихад Санж

- Энэ морь юухан байхав. Одоохон Сагад дээр гүйгээд очно. Эр хүн эмээлт морь хоёр жинхэнэ нөхөрлөдөг юм гэсэн. Тэр л энэ хүрэн морь Сагад хоёр юм шүү гэхэд Ширмэн амандаа

- Тийм шүү гэж хэлэв. Санж цааш нь

- Энэ хүрэн мориор зогсохгүй тэр олон хуц ухнууд чинь маллахад мөн ч хэцүү мал шүү дээ.

Тэгэхэд тэд яг сургуулийн хүүхэд шиг Сагад мэргэний санаа зоргоор захирагдана. Урд жилүүдэд хуц ухныг чинь хоёр хүн уур уцаараа барж найман морины турууг мултлан байж л намартай нэг золгодог байсан даа. Тэгэхэд энэ хүрэн морийг өвөл зунгүй дөрвөн улиралд унана. Ачлагны хоёр тэмээ, саалийн гурван үнээ бүгд адилхан гэхэд Ширмэн төлөөлөгч толгойгоо өргөн

- Сагад нөхөр чинь чононд хил хязгаар тавьсан, бид бие биедээ найрсаг байж өлзийгөө өгсөн амьтан гээд тэр малын дайсанг өмөөрч хамгаалах маягийн үг хэлээд байсан шүү гэж хэлснээ дотроо

- Намайг бас дайруулж доромжилсон. Сайн санаатай хүний унаар морийг зооглодог. Муу санаатайгаас нь сэжиглэн сэрэмжлээд орхидог гэсэн нь муу санаатайг явгалдаг. Сайн санаатайг өршөөдөг гэсэн санааг тонгоргосон хэрэг мөн. За яахав тэгэж л байг гэж бодож байтал бригадын дарга Санж магтаал үгээ олж ядан байж

- Сагад ч энэ цаг агаарын байдлыг яг л алган дээрээ тавьсан юм шиг хэлнэ. Нар, сар, од, эрхэс энэ ус, ургамал, ан амьтны байдал шинжээр л хэлээд байгаа юм. Үнэндээ л мэргэн эрдэмтэй хүн дээ гэхэд Ширмэн дотроо

- Тэр ч ортой байх шүү. Хангал дарга Өлзий эмч хоёр байн байн Сагадынхаар очиж түүнийг илт өмөөрч хамгаалаад байдаг нь нэг л учиртай. Цаана нь ямар нэгэн нууц байж л таарна гэж бодов. Ширмэн намынхаа гал улаан батлахдаа итгэл үнэмшлээ өргөн намын гишүүнээрээ омогшин шулуухан явсаар дуугүй Хайнзангийн ирээд буув. Хүнд итгэл үнэмшил төрнө гэдэг хүч тэнхээ зориг зүрхийг өгдөг билээ. Ширмэн төлөөлөгч Хайнзантай шуудхан ярилцахаар шийдэв. Тэрээр

- Хайнзан гуай та энэ бичээсийг нэг уншаад өгөөч гээд нөгөө бичгээ өгөхөд Хайнзан авч нилээд харав. Тэр дотроо

- Ээ бурхан минь. Их аграмба А.Чоймжуур гэж байна шүү дээ. Авирмэд гавжийн ганц хүү Чоймжуур байх нь. Авирмэд гавжийн тухай ааваасаа л сонсож байсан даа. Харин Чоймжуур Лэнсрэй гавжийн тухай бол бага зэрэг мэднэ. Лэнсрэй гавж гэдэг чинь Төвдөд очиж их хайланд сууж ном хэлэлцэх эрх авсан гэвшид олгодог урамшууллын цол шүү дээ. Чоймжуур ч мөн ч их эрдэм номтой залуухан ч гэвш байсан даа. Агваанням хамбын бага дүү Дэжидням бүсгүйтэй холбогдоод сүм хийд хурал номоо орхисон доо. Хожимоо төвдийн Лхас хотод очиж Аграмба зэрэг цолтой болсон дээгүүр зиндаанд ордог гэж дуулснаас цаашгүй дээ гэж бодож суух зуур Ширмэн аргаа олж ядан байж

- Хайнзан гуай. Би нам төрийн өмнөөс чухал даалгавар гүйцэтгэж яваа хүн шүү. Та бичээсийг түргэн уншаад юун тухай өгүүлсэн болохыг хэлээд орхи гэж өндөр дуугаар ширүүнээр тулган хэлэхэд Хайнзан мөн л дуугүй толгойгоо хөдөлгөнгөө дотроо

- Үгүй ер өө. Үүгээр юугаа хийдэг байна. Одооны багачуул дэмий юм хөөцөлдөөд явах юм даа. Хийчихмээр ажил мөн ч их байна даа. Хөгшин намайг бас ийм юмтай орооцолдуулж гай татах нь. Хөөрхий дөө энэ хүний эрдэм ухаан одоо ч биднийгээ эвээж л байдаг байх даа гэж бодоод

- Төлөөлөгч өө гэж дуугарахад ихээр баярласан тэр Хайнзан гуай руу горьдсон итгэж найдсан харцаар харж
- За Хайнзан гуай гэж зөөлнөөр хэлэхэд Хайнзан нөгөө бичгийг түүн рүү өгөхдөө
- Нэг А үсэг л байх шиг байна. Бусдыг нь мэдэх юм алга. Би чинь гавьтай юм сураагүй золиг шүү дээ гээд таг чиг болчихов. Ширмэн яах ч учраа олохгүй түүнд гомдсондоо болоод тэр үү амандаа
- Энэ өвгөнөөс дахин нэг ч үг сонсохгүйгээ сайн мэдэх учир чимээгүйхэн гэрээс гарав. Одоо түүнд ганцхан горьдлого үлдсэн билээ. Тэр нь сохор Балбар өвгөний ач хүү Амархүү байв. Бага залуу хүн болохоороо өвгөн ааваасаа сонссон элдэв юмаа гэнэдээд хэлж болох юм гэсэн горьдлого л байлаа. Тэр мөн л намынхаа гал улаан батлахыг гараараа барьж нүдээрээ харж омогшоод
- Ардын намынхаа дайсантай амь биеэ хайрлахгүй тэмцэж үнэн мөнийг заавал олох болно. Үзэл суртлын дайн гэдэг бол буу зэвсэггүй, цус гаргахгүй мөртлөө хамгийн хэцүү дайн. Энэ дайнд ялалт байгуулахад ганц морь чононд өгөөд ч зогсохгүй аавын хүүгийн алтан амь ч эрсдэж болно гэж бодсон Ширмэн эрлээ мухарлаж Амархүүг амархан олоод авлаа. Тэр хоолойгоо шахан байж
- Хүү минь нам төрийн өмнөөс би хэдэн зүйлийг чамаас асууна. Үнэн зөв хариулах ёстой шүү гэж ихэрхээд Амархүүг ажиглав. Амархүү ч түүний хэлснийг зөвшөөрч толгойгоо дохиод
- Мэдлээ дарга аа. Би мэдэх юм болгоноо үнэн зөв хариулах болно гэв. Ширмэн хоолойгоо засаад
- Чи өвөөтэйгөө Бунханы амны булшин дээр очсон уу? гэхэд Амархүү
- Очсон гэв. Ширмэн
- Өвөө чинь тэнд юу хийж, юу ярьж өдөржингөө суув. Үнэнийг хэлээрэй гэлээ. Амархүү инээмсэглээд
- Өвөө надаас энд юу юу байна гэж асуусан. Би байгаа юмыг нэг бүрчлэн хэлсэн. Гэтэл өвөө гайхасхийгээд
- Ямар тэнэг амьтан нь үүнийг ингэж сэргээдэг байна аа гэснээ дотор муухайраад байна..Өвөө нь жаахан суугаад амарья гээд суугаад л байсан. Би морьдын дэргэд байж байгаад унтчихсан байна лээ. Тэгээд сэртэл орой болчихсон байлаа. Өвөө бид хоёр гэр лүүгээ явсан гэхэд Ширмэн амандаа
- Ямар тэнэг амьтан бэ? гэснээ инээгээд
- Маргааш нь чи Сагад мэргэний рүү тэр хярын орой өөд ямар хэрэг зоригоор явсан бэ? гэлээ. Амархүү инээмсэглээд толгойгоо илэнгээ

- Хөхцэцэгтэй уулзах гээд түгдэрэхэд Ширмэн дотроо

- Сагадынд хонохдоо эр хүний нэг муу аз гэж бодсоноо нэхэн санаад нүүр нь улайгаад Амархүүгээс санаа зовсондоо

- За, за тэр ч яахав. Тэр бунхан булшинд хөшөө нэмж тавьсан бас бичиг бичээсийг хэн хийснийг мэдэх үү? гэхэд Амархүү

- Мэдэхгүй гэж хэлэхэд Ширмэн

- Чи мэдэж байгаа юмаа нуугаад байгаа юм биш биз гэж сэжиглэнгүй асуухад Амархүү дотроо

- Би өвөөгийн сохор биш, бунхан булшийг сэргээгээд байгаа хүн хэн бэ гэдэг хоёр айхтар нууцыг мэдэж байгаа хүн шүү дээ. Үүнийг бүр дээд газраас тусгай хүмүүс явж эрж хайгаад байгааг бодоход нилээд сүрхий хэрэг бололтой. Гэхдээ би энэ хоёр нууцыг хадгалах болно гэж бодов. Ширмэн намынхаа даалгаврыг биелүүлж чадаагүйдээ ихэд гэмшин бас хариуцлагагүй нөхөр гэж өөрийгөө зэмлээд намынхаа батлахыг гараараа барилж үзээд уртаар санаа алдав.

Арван найм

Амархүү Ширмэн төлөөлөгчөөс салангуугаа Бунханы хөтлөөр давж Бургасан энгэрт ганц гэрээр байх Яхир Балдангийн руу мориныхоо жолоог залав. Амархүү Ширмэнгийн асуултанд хэн хэндээ хал балгүй хариулт өгсөндөө сэтгэл хангалуун байлаа. Тэр дотроо

-Ширмэн төлөөлөгч намайг Сагад гуайн Хөхцэцэгийн хойноос хөөцөлддөг гэж бодсон байх аа. Гэхдээ Хөхцэцэгийн нэрийг сонсоод түүний царай улайгаад түр зуур бодол болсноо

- За за энэ ч яахав хэмээн яриаг өөрчилсөн шүү дээ. Бас нэг нууц байгаа юм биш үү. Би ч яахав. Өвөөгийнхөө сохор биш гэдгийг, Сагад мэргэнийг бунхан шарилыг сэргээгээд байгааг мэднэ. Мөн сумын төлөөлөгч Ширмэн Бунхан шарил сэргээсэн хүнийг олох гээд нууцаар сэмээрхэн яваад Өвөөтэй, Сагад гуайтай, Хөвчийн нурууны Хайнзан өвгөнтэй уулзаад байцааж сураг ажиг тавиад хөшөө чулуун дээрхи бичээсийн учрыг тайлах гээд явааг бас л би мэднэ. Тэр хөшөө чулуун дээрхи бичээсийг Сагад гуай бичиж Өвөө аав, өвгөн Хайнзан бид гурав л мэдэж байгаа. Хэн хэн маань ч төлөөлөгч Ширмэнд ам алдаагүй. Энэ мөн л сүрхий нууцлаг юм болж байна шүү. Уг нь хэнд ч хэрэггүй шахам зүйл шүү дээ гэж бодож бясалгасаар Бунханы хөтлийн баруун энгэрийн том том хүрэн хөх хадаар хүрээлэгдсэн нар ээсэн хонхор газарт хүрээд ирэв. Морины аргамжийн хэрийн дугуй тойрог үүсгэн ургасан хар голтой шар цэцгийг хараад гайхан бишрэв. Түүнд Улсын их дэлгүүрийн хивсний тасаг ороод уран гоёор угалз хатган шаглаж урласан хивс харж байгаа мэт санагдсан ч огт өөр үнэр сүрчиглэсэн агаар залгилж байгаагаа мэдрээд амар жаргалангийн өргөөнд морилов уу? гэмээр сэтгэгдэл төрөв.

Энэ хар голтой нарны цацраг шиг олон шар дэлбээтэй цэцгийг Минжиннагво хэмээн нэрлэдэг. Энэ гайхамшигтай цэцэг тэр болгон орон газарт ургаад байдаггүй. Эмийн жорд ордог анагаах эрдэм чадал ихтэй ховорхон цэцэг билээ. Ялангуяа хоолойн өвчинд дангаар нь хэрэглэдэг. Хэд хэдэн эм тангийн жоронд ордог ид шидтэй цэцгийн нэгэн. Амархүү мориноосоо бууж цэцэгсийн үнэрт бялуурах мэт тааламжтайгаар суниагаад дээш харан хэвтээд өгөв. Тэр хязгааргүй алсрах номин өнгөтэй тэнгэрийг ажиглан байснаа аажимхан нүдээ анин зүүрмэглэв.

- Ягаан алчуур хүзүүндээ зангидсан нэгэн бүсгүй түүн рүү аажимхан алхална. Амархүүгийн сэтгэл нь гэгэлзээд зүрх нь түргэн түргэн цохилох нь тод сонсогдоно. Тэр баярлаж байгаа, айж байгаагийн алиныг ч мэдэхгүй байлаа. Энэ хэн бэ? гэж амандаа шивнэн өөрөөсөө асуухад хэн нэгэн хариу үл хэлнэ. Ирж яваа бүсгүйн ягаан алчуур л тодроод байхаас нүүр царай нь харагдаж өгөхгүй байлаа. Зүс царай нь харагддаггүй ямар гээчийн их хяслан бэ? гээд сайн ажиглавал толгой бие нь үзэгдэхгүй зөвхөн тод ягаан алчуур нүдэнд нь тулаад нүүрийг нь бүрхэхэд тэр

-Хүүеэ гэж чанга хэлээд зүүднээсээ сэрэв. Түүний нүдэнд нэгэн эмэгтэй дэргэд нь зогсож байгааг хараад алмайран айх гайхах зэрэгцэн тэрхэн зууртаа бага зэрэг цочоод авав. Минжин бүсгүй инээмсэглэсээр

- Амархүү ах аа. Та чинь морио алдан барин хөдөө хээр газар ингэтлээ бөх унтах чинь юу

- билээ. Морь чинь яваад өгөхөөр би бүр айлаа шүү гэхэд Амархүү нүдээ нухлангаа эвшээгээд
- Баярлалаа. Минжин. Би энэ сайхан цэцэгсийн үнэрт бялуураад халуунд нозоороод унтаж орхиж гээд зүүдээ ярих гэснээ болиод
 - Зүүдээ манадаг нь дээр байх гэж дотроо бодоод Минжин өөд хараад
 - Чи хонинд яваа юм уу? гэж асуухад Минжин гартаа барьсан ягаан алчуураар хар батганыг үргээх зуураа
 - Үгүй ээ. Би адуучин Лутаа гуайнд морь хүргэж өгөөд буцаж явна. Цулбуураа чирсэн эмээлтэй морь явж байхаар нь эхлээд их гайхав. Эргэн тойрныг ажиглан харвал эзэн нь гулдайгаад хэвтэж байхыг үзээд айдас төрөв гэж ярьж байхад Амархүү Минжингийн гарт байгаа ягаан алчуурыг харсаар байлаа. Тэр дотроо
 - Энэ ягаан алчуур миний зүүдэндээ үзсэн алчуур мөн байна. Ямар сонин юм бэ? Алчуур нь харагдаад тэр бүсгүйн царай зүс, бие нь огт үзэгдээгүй шүү дээ. Би тэр бүсгүй хэн болохыг мэдэхийг их хүссэн дээ. Тэр ягаан алчуураар биеэ нуугаад над руу дөхөж ирээд нүүр нүдийг алчуураараа бүтээгээд л би сэрсэн гэж бодоод түүнд
 - Минжин чи наад ягаан алчуураараа миний нүүр нүдийг бүтээсэн үү? гэж гайхан асуухад Минжин
 - Би таны дэргэд ирээд түр зогссон. Хамрын чинь нүх рүү нэг хар батгана орох гээд байхаар нь би энэ алчуураар үргээсэн гэв. Энэ хоёр залуус нэг нь асууж нөгөө нь хариулсан бол хоёулаа мөн л гайхан Минжин
 - Амархүү ах унтаагүй сэрүүн л байсан юм байна шүү дээ. Миний алчуурыг харсан юм бол гэж бодож байхад Амархүү
 - Би чинь зүүдэндээ ягаан өнгийг үзээд байсан мөртлөө бусад өнгө хүний биеийг яагаад үздэггүй билээ. Энэ ягаан өнгө надад ойртох тусмаа улам л тодроод байсан гэж бодоод нүдээ аниад эргэж хэвтэв. Түүний нүдэнд биш сэтгэлд нь ягаан өнгийн алчуур тод үзэгдэн намирч хөдлөж байлаа. Тэр нүдээ нээж өндийгөөд Минжинг гайхан харснаа
 - Ямар сонин юм бэ? гэж амандаа хэлээд Минжингээс
 - Наад алчуур чинь чинийх үү? гэж асуухад нь Минжин инээмсэглээд
 - Энэ алчуур минийх. Гэхдээ жинхэнэ эзэн нь өөр хүн бий гэлээ. Амархүү их л сонирхож байгаа бололтой
 - Хэн юм бэ хэлээч дээ гэж шавдуулахад Минжин тоглоод шоглоод ч байгаа юм шиг царай гарган
 - Энэ алчуур Нарангаравынх л даа. Миний төрсөн өдрөөр надад бэлэглэсэн юм гэлээ. Амархүү бүр гайхаж орхив. Тэр дотроо

- Ямар хачин юм бэ? Би Нарангаравтай уулзахаар яваа. Гэтэл энэ ягаан алчуур нь зүүдэнд үзэгдээд байгаа мөртлөө сэрүүн үедээ нүдээ аньсан ч бас л сэтгэлд харагдаад байдаг нь ямар учиртай юм бол доо. Ном зохиолд гардаг шиг хүнд ухаангүй дурлаж түүнд шунаж байгаа үедээ солиорч хий юм харах элдэв бусын үг өгүүлбэр хэлдэг гэсэн гэж бодохоос айх шиг болов. Би чинь ирэх жил их сургуулийн физикийн ангийг төгсөнө. Гэтэл сэтгэл хямралаасаа болоод арай чадахгүй юм биш байгаа даа. Үгүй байлгүй дээ хэмээн эргэцүүлэн байтал Минжин

- Та чинь юу болчихов оо. Балай хүн шиг юугаа бодоод байгаа юм бэ? гэхэд Амархүү

- Би зүгээрээ. Энэ хар голтой шар цэцгийн үнэрт бүүр мансуурч гүйцлээ. Ямар ч сайхан цэцэг юм. Би ийм сайхан нутагт төрснөөрөө бахархаж байна гэв. Минжин их л төлөв түвшинээр

- Энэ цэцгийн үнэр бол миний биений үнэр шүү дээ. Манай байрны гурав маань

- Минжээ чамаас нэг л ер бусын үнэр ханхлаад байна. Осолдохгүй л цэцгийн үнэр дээ. Ямар нэртэй үнэртэй ус хийгээд байгаа юм бэ гэж асуудаг юм гэхэд Амархүү

- Үгүй ер өө. Яахаараа чамаас энэ цэцгийн үнэр үргэлж ханхалж байдаг билээ. Энэ цэцгийн нэр Минжиннагво шүү дээ гээд Минжин өөд харснаа

- Чиний нэр бас Минжин шүү дээ гээд гайхсан хэвээрээ амаа ангайн байхад Минжин инээмсэглэн

- Юунд нь гайхаад байгаа юм бэ? Худлаа байх гэж эргэлзээд байгаа бол өвөл манай оюутны байраар нэг очоод үнэн худлыг нь нэг үзэхгүй юу гэлээ. Амархүү Минжинг дагаж инээгээд

- Итгэхгүй байгаа юм биш ээ. Маш сонин санагдаад тэр. Би чамд нэг нууц зүйлийг ярья. Би сая таг унтаад бас зүүдэлж байлаа. Миний зүүдэнд чиний ягаан алчуур маш тод харагдаад байсан. Харин хүнийх нь бие, царай зүс нь огтхон ч үзэгдсэнгүй. Тэр алчуур надад ойртсоор нүдэнд тулаад нүүрийг бүтээхэд л би сэрсэн. Сая эргэж хэвтээд нүдээ анихад сэтгэлд минь ягаан алчуур тодроод салхинд намиран хийсч байхыг би харав гэснээ эргэн тойрныг ажиглан харснаа

- Минжин хүнд битгий хэлээрэй. Маш нууц шүү. Би учрыг нь олох гээд физикийн томъёо бодоод сууж байна гэхэд Минжин мөн л эргэн тойрныг ажигласнаа дотроо

- Энэ хүн надад итгээд нууцаа ярьж байхад гэж бодоод

- Амархүү ах аа. Та хүнд битгий хэлээрэй. Би нууцалж явдаг нэг зүйлээ хэлье. Би чинь яг энэ дугуйрсан Минжиннагво цэцгийн гол дунд төрсөн юм гэнэ лээ. Тэгээд надад Минжин гэж нэр хайрлаж бас энэ цэцгийн үнэр биед минь шингэсэн бололтой. Үүнийг нэг ч хүн мэддэггүй юм. Би ч хэлдэггүй нууцалдаг. Ээж бид хоёр бас Цагаан ах л мэднэ гэхэд Амархүү их л бодлогоширонгуйгаар

- Аан их нарийн учиртай байх нь. Цагаан гуай чинь танай аав гээд цааш ярих гэтэл Минжингийн нөгөө уур дүрсхийж
- Та юугаа яриад буруу тийшээ хадуураад байгаа юм бэ? Цагаан ах чинь миний газар ээж намайг тосож авсан хүн байхгүй юу. Бас ээж бид хоёрын амийг аварсан ачтан шүү дээ. Жил бүр ээж бид хоёр Цагаан ахынд очиж золгоно. Манай ээж хааяа л
- Миний охин чинь цэцгэнээс төрсөн холын амар амгалангийн орны дагина байхгүй юу гэдэг юм. Би хорь хүртлээ аавын тухай бодож яваагүй. Сургуульд байхад зарим хүүхдүүд
- Аавгүй дээ. Авгайн охин доо гээд л шоглож байдаг. Би огтхон ч тоохгүй болохоор сүүлдээ намайг шоглохоо больчихсон юм даа гэхэд Амархүү түүнийг өрөвдөнгүй хараад
- Танай ээжийг чинь манай Хөшөөтийн голын хамгийн сайхан бүсгүй байсан гэж хүмүүс ярилцахыг сонсож байлаа. Одоо ч гэсэн ажил төрөл, ааш зангийг нь амтай болгон магтаж байна шүү дээ. Чи чинь манай сургуулийн физикийн ангийн онц сурлагатан гээ биз дээ. Гуравдугаар курсдээ Сүхбаатарын нэрэмжит цалин авна даа гэхэд Минжин ягаан алчуураараа нүүрээ сэвэх зуураа
- Тийм гэсэн. Миний тодорхойлолтыг дээш нь явууллаа гэж байсан. За тэр ч яахав гээд бодол болов.
- Ээжийн найз хоёр авгайн ярьсан үнэн болов уу? Ээж минь Хөнхийгийн аав Балсан гуайтай суух гэж байсан нь үнэн болов уу? Хөнхийгийн ээж Сүрэн эгч ээж хоёр ихэр юм шиг найз байсан гэсэн. Тэгвэл би найман сарын арван зургаанд төрсөн. Гэтэл Хөнхий аравдугаар сард төрсөн байдаг гэж бодож байснаа Амархүү рүү харан
- Би таньд нэгэн сонин юмыг ярих уу? Та сайн ажиглаад ирнэ биз. Энэ сиймгэр ягаан алчуур чинь хөхцэнхэр өнгөтэй юм. Надад ирээд л ягаан өнгөтэй болчихсон. Харин надаас холдоод явахаараа хуучин хөх цэнхэр өнгөтэй болчихдог юм гэлээ. Манай ээж
- Чиний наад нэг алчуур чинь солонгон өнгөтэй юм аа даа. Заримдаа ягаан заримдаа хөх цэнхэр болоод байх юм. Их л сонин эд байна шүү гэж байсан гэхэд Амархүү гайхаж
- Чи чинь ёстой химийн урвалд оруулж ярьж байх шив дээ гээд инээхэд Минжин инээд алдаад
- Уг нь физик шинж чанараар нь та л тайлбарлах ёстой доо. Тийм ч учраас би энэ алчуурыг таньд өгье. Та авч явж байгаад маргааш нөгөөдрөөс надад авчраад өгчихнө биз гээд ягаан алчуураа Амархүү рүү сарвайв.

Хар ялаанаас төвөгшөөсөн хоёр морь толгой хаялан хазаарын чимээ өгөн халуунд нозоорсон бололтой хааяа хааяа дуртай дургүй сүүлээ шарвах нь нэн залхуутай. Хоёр залуус мориндоо мордоод өөр өөрийн явах зүг рүүгээ одоцгоов. Амархүүгийн сэтгэл нэг л хөнгөн хөөрүү болчихсон мэт санагдана. Тэр Ганган хул гэдэг дууг исгэрэн унаж яваа хул мориныхоо хондлойд суран ташуурыг зөөлөн хүргэхэд хул морь алдаж онож байсан хөлийнхөө

гишгэдлийг олж жигдхэн сайварлаж байлаа. Гүрээн хоолойд ногоо жигдхэн өндөр ургасан учир хулгар шар тарвага үе үе харайх нь үл үзэгдэн зөвхөн өвсний толгой л хөдөлж мэдэгдэнэ. Тэр болгонд хул морь чихээ сортолзуулан нэг сайн тогтоогоод тарвага болохыг мэдээд тайвширна. Бургасан энгэрийн доод шонтгор толгойн шил дээр хонин сүрэг бэлчээрлэж байгааг харсан Амархүү мориныхоо амыг татан гэлдрүүлээд өврөөсөө дурангаа гарган дурандав. Түүний магнайд баярын совин татаж царай нь гэрэлтээд ирэв. Тэр амандаа

- Нарангарав мөн байна. Өнөөдөр хишиг ээлжтэй байх нь. Юун сайн хэрэг вэ. гэж шивнээд дурангаа яхир Балдангийн гэр лүү чиглүүлэв. Гэрийн үүд онгорхой. Согоо хээр морь нь эмээлтэй шон дээр уяатай харагдана. Гэрээс нэг хүн гарч ирсэн нь Балдан гуай мөн байлаа. Тэр мөн л хол ойрыг дурандав. Тэр Гүрээний хоолойд морьтой ганц хүн гэлдэрч явахыг үзээд дурангийн харааг тогтоов. Амархүү ч мөн л тогтоон харж байлаа. Балдан амандаа

- Энэ хүн чинь бас намайг дурандаад байна шүү. Хэн юм бол доо гээд танихыг мэрийнэ. Харин Амархүү Нарангаравынхаа аавгай дурангаар ширтэлцсэнээ ялагдав бололтой мориныхоо амыг эргүүлээд нүүр буруулж түүнд ар нуруугаа харуулав. Балдан амандаа

- Энэ хүний байж байгааг хараач ээ. Надад танигдах дургүй бололтой гэж шивнээд өөр бусад руу дурангаа эргүүлэв. Тэр Чандмана өвдөгт зусаж байгаа дүү Балсангийндаа очихоор яаравчлав. Амархүү ч Балданг явахыг хараад сэтгэл амарч охин Нарангаравтай нь тавтай уулзах болсондоо баярлан хээрийн задгай бэлчээрт хэнтэйгээ уулзахаар болзсон юм бол гэж исгэрүүлэн аялсаар хул мориндоо ташуур өгөв. Нарангарав Амархүүг хүрээд ирсэнд баярлаж байсан ч гаднаа үл тоомсорлосон дүр эсгэн

- Та чинь ямар гээчийн чухал ажлаар хаанаас хаана хүрэхээр яарч яваа хүн бэ? гэхэд Амархүү инээмсэглэн

- Сангийн далай нуураас сайхан бүсгүй Нарангаравыг зорьж гарлаа. Санасан хэрэг минь бүтэж санаа минь амарлаа гэхэд Нарангарав

- Санаа чинь амарч санасан хэрэг чинь бүтсэн бол одоо эргээд яв даа гэв. Энэ хоёр залуус хэн хэн нь баяртай байлаа. Нарангаравын наргианч шулуун шударга занг мэдэх учир Амархүү зорьсон хэргээ шуудхан хэлэхээр шийдээд

- Нарангарав аа. Чамайг би нэгэн аялалд урья. Наймдугаар сарын арван зургаанд Их, бага барзан хайрханы дунд арван хоёр цагт уулзъя гэж хэлэхэд Нарангарав инээдээ барьж ядан байж

- Ямар сүрхий болзоо вэ? Их сургуулийн том оюутан хөдөөний нэг малчин бүсгүйг Хайрхан уулын орой дээр уулзахаар болзоонд урьдагийн учир юу билээ гэхэд Амархүү түүнийг их л аргадаж царайчилсан аялгаар

- Нарангарав аа. Инээдэм биш. Хоёулаа Хар ангалагийн асга хаданд ургадаг Вансэмбэрүү цэцгийг хамтдаа үзье гэж л байгаа хэрэг гэхэд Нарангарав дотроо

- Ямар сайхан хэрэг вэ? Урилгыг баяртайгаар хүлээж авлаа гэж бодоод Амархүүг

цаашлуулахаар шийдээд

- Та чинь одоо болтол Вансэмбэрүү цэцгийг үзээгүй юм уу? Ямар сонин юм бэ? Манай нутагт ийм хүн бас байдаг аа хэмээн гайхав. Амархүү бага зэрэг хулчигнан
- Би үзээгүй юм аа. Гэхдээ Хөхцэцэгээр сайн яриулж аваад үзэхээр шийдсэн юм гэхэд Нарангарав
- Тэгвэл та Хөхцэцэгтэй хамт үзээч. Манай Хөхөө ч тэр цэцгийг чинь гарын арван хуруу шигээ л мэднэ шүү дээ гээд дотроо
- Энэ Амархүү бас Хөхцэцэгтэй уулзаад Вансэмбэрүү цэцгийн тухай яриулсан байх нь. Сумын наадмаар морины уралдаан, барианы газарт Хөхцэцэгийн ам руу нь орох шахам ангайгаад зогсож байсан гэж бодоод алс уулын орой харан гуниглав. Амархүү Нарангаравын үг ярианы өнгө нүдний харцыг ажиглаад сэтгэлдээ таагүй байгааг мэдрээд бага зэрэг сандрангуйгаар
- Би Сагад гуайд хэл хүргэх болоод л тэднийд очсон хэрэг. Өөр зорилго байгаагүй гэж хэлээд дэмий л дээлээ засах санаатай бүсээ тайлтал Минжингийн өгсөн нөгөө ягаан алчуур унав. Амархүү ч түүнийг ажигласангүй. Гэтэл Нарангарав дуу алдан
- Хүүе ээ. Энэ алчуур чинь миний Минжинд бэлэглэсэн алчуур байна шүү дээ гэхэд учрыг сайн ойлгоогүй Амархүү
- Юун алчуур вэ гээд тонгойвол Минжингийн ягаан алчуур хөхцэнхэр өнгөтэй болчихсон хэвтэж байлаа. Амархүү түүнийг хараад Нарангараваас эмээж байсан эмзэглэл нь арилад өнгө солигдсон алчууранд хамаг анхаарлаа хандууллаа. Тэр амандаа
- Ямар сонин юм бэ? Түүний хэлсэн үнэн байх нь. Ёстой нууц юм чинь энэ боллоо гэж шивнэхэд Нарангарав ууртай маягтай
- Та чинь юун нууц мууц гээд байгаа юм бэ? Минжинд хэрэггүй болчихсон бол эзэн нь энэ алчуураа эргүүлээд авчихъя гээд ухасхийн авав. Амархүү алчуурын өнгө солигдсоныг гайхаж бас Нарангаравын аяс муутай үгнээс айж яахаа мэдэхгүй алмайрахад хүрэв. Нарангарав ихэд эргэлзэн ийнхүү бодов.
- Амархүү чинь зуныхаа амралтаар морь унаад айлын бүсгүйчүүдтэй уулзаад заримаар нь Вансэмбэрүү цэцгийг яриулаад заримынх нь алчуурыг өвөртлөөд, заримд нь их бага Барзан хайрхан дээр уулзъя гэж болзоо тавиад л явдаг хүн юм биз дээ. Өөр хэн гэгчтэй хичнээн удаа уулзаж болзсон юм бол доо гэж бодоод зүрх сэтгэлээ чангалан байж тайвнаар
- Та ч сайхан хүн юм аа. Хэн дуртайтайгаа болзож, цэцэг яриулаад бас алчуур дурсгал болгон аваад л өдөр шөнө өглөө үдэшгүй давхиад сайхан л юм. Залуу насны омгоороо замбараагүй давхиж байгаад биегүй болчих вий дээ. Сэтгэлээ сул тавьж алдаж асгавал наад махан бие чинь үгүй болж мэднэ шүү гэв. Амархүүд яг л авгайдаа загнуулж зандруулж байгаа юм шиг санагдахад дотор нь уужраад сэтгэл нь тайвширав. Тэр дотроо

- Энэ маань намайг бусдаас харамлаж бас хайрлаж, сургамжилж байна гэж бодоод түүний барьж байгаа хөхцэнхэр алчуурыг заагаад

- Минжинтэй уулзаж түүний ярьсан алчуур ягаан өнгөтэй байсан, одоо хөх өнгөтэй болно гэдгийг үнэмшсэнийхээ дараа надад эргүүлж өгөөрэй гэснийг бүгдийг ярьж тайлбарлав. Нарангарав ч Минжингээ бас Хөхцэцэгээ сайн мэддэг дотнын найзууд болох учир сайтар ойлгоод тайвширлаа. Нарангарав ч Амархүүгийн урилгыг хүлээн авч найман сарын арван зургаанд хоёр Барзан хайрхануудын дунд өдөр дунд уулзахаар болзоцгоов. Амархүү Нарангараваас салаад ихэд баяртайгаар буцав. Тэр бодолдоо дарагдан дүнсийнэ. Хул морь үүрэглэх шахам гэлдэрнэ. Тэр дотроо

- Энэ Балдан гуай ганц охиноо сургуулиас гаргаад ингэж гадаа гандуулж хөдөө хөхрүүлчих гэж дээ гэж харамссанаа өөр нэгэн мөчийг бас дурсав. Намын дарга Балданд

- Та ганц охиноо сургууль соёлд явуулаач гэхэд яхир Балдан

- Би ганц охиноо гарын салаагаар асгарах ус шиг хол явуулчихаад юугаа бодож суух ч юм билээ. Тэгээд сургууль соёл, тэр диплом ромбоор чинь амьдардаггүй юм. Амьдрал мэдэж ажил хийж сурвал алсдаа л хэрэг болно. Хүнд чинь төрмөл ухаан гэж айхтар юм бий. Түүгээрээ өөрийнхөө амьдралыг жолооддог юм шүү дээ. Тэгээд ч энэ нэгдэл нийгмийн чинь малыг хэн маллах болж байна. Бид нар ч яахав. Мануухай шиг өнөөдөр шомбойж л байна. Маргааш нь байхгүй л болчихно шүү дээ. Дарга минь та нар ч гэсэн үр хүүхдүүдээ ажил амьдралд сургамаар байгаа юм даа. Ухаан муутай л бол мянган сургууль соёл төгсөөд ч хувь нэмрээр бага шүү дээ гэж зэмлэж шүүмжлэх маягаар хэлсэн гэдэг.

Яхир Балдангаас нутгийн хүн бүр л эмээнэ. Тэр шударга шулуун зантай хүн. Нарангарав ч эцгийн занг өвлөж авсан нэгэн гэж бодсоор яваад Бунханы хөтөл дээр гараад ирсэн байлаа. Нар баруун хойшоогоо ташиж уулын сүүдэр уртдан нам дор унасан ч жаргах болоогүй байлаа. Хөтлийн баруун энгэрт байх Минжиннагвын шар цэцэг ургасан нөгөө л дугуй хонхортоо ирж мориноосоо бугаад анхилам үнэртэй цэнгэг агаараар нь ам хамраараа залгилан уушгаа цэнгүүлэв. Амархүү Минжингийн хөхцэнхэр алчуурыг өврөөсөө гаргахад ягаан өнгөтэй болчихсон байлаа. Тэр эвэртэй туулай үзсэн аятай нүдээ бүлтийлгэн амандаа

- Ай хөө. Ямар хачин юм бэ? гэж дуу алдав. Үнэнийг хэлэхэд учрыг ухаж мэдэхэд тун ч түвэгтэй нэгэн зүйлтэй дахин учрав. Тэр эцэстээ өөрийгөө гайхахад хүрэв.

- Би яахаараа ийм нууц юм болгонтой учраад байдаг юм болж байна. Өвөөгийн сохор биш, Сагадын булш сэргээсэн, Гэтэл энэ алчуур хоёр өнгөнд ээлжилж солигдоод байдаг Минжингийн энэ цэцэгтэй хонхорт төрсөн гэх мэтийн олон нууц түүнд хадгалагдаж байгааг сайн санах. Тэр ухасхийн мордоод гэрийн зүг давхисаар гэртээ ороод нөгөө ягаан алчуураа гаргаад харвал хөхцэнхэр өнгөтэй болсон байв. Амархүү аяга цай уугаад үг ч дуугаралгүй гарч шуудхан явсаар Минжингийн очлоо. Минжин ч нохой хорив. Амархүү морио бөхлөх зуураа

- Сайн байна уу? Минжээн гэхэд Минжин инээмсэглээд

- Сайн, та сайн явж байна уу? Яасан их яаруу яваа юм бэ? Наад морь чинь бүр усан хулгана болтлоо хөлөрсөн байна шүү дээ гэхэд Амархүү

- Морь хөлрөх ч яахав. Айх гайхах зэрэгцээд учрыг нь олохгүй будилж явна гээд нөгөө хөхцэнхэр алчуурыг гаргаад

- Май энэ алчуураа ав. Чиний хэлдэг үнэн юм байна гээд өгөв. Минжин хөх алчуурыг нэг үзүүрээс нь барьж аваад Амархүүг ажиглана. Амархүү Минжингийн барьж байгаа алчуураас нүд салгахгүй ажиглаж байв. Гэтэл хөхцэнхэр алчуур Минжингийн барьж байгаа үзүүрээс эхлэн ягаарч эхлэв. Амархүү амаа ангайн нүдээ бүлтийлгэн гайхсан харцаар харж байлаа. Тэр нэг ч үг хэлж амжихгүй ээрэгнэн байх зуур нөгөө алчуур ягаан өнгөтэй болж орхилоо. Тэр амандаа

- Ёстой хачин юм даа. Үүнийг хүнд хэлвэл үнэмшихгүй байх. Харин хэлсэн хүн л өөрөө худалч болоод хоцорно гэж шивнэхэд Минжин

- Та чинь амандаа ганцаараа яриад наад нүд чинь бүлтийгээд амаа ангайгаад галзуу солиотой хүн шиг яагаад байгаа юм бэ? Гэрт ор цай уу. морь чинь жаахан ч болов амраг гэхэд Амархүү юу ч хэлэлгүй гэрт оров. Тэр цай уух зуураа нэгэн танил үнэрийг мэдэрч байлаа. Яг л Бунханы хөтлийн баруун энгэрт ургадаг хар голтой олон нарийн шар дэлбээтэй Минжиннагво цэцгийн гайхамшигтай үнэр мөн байлаа. Тэрбээрт өвгөн аавынх нь нэгэн яриа сэтгэлд нь орж ирэхэд

- Энэ Минжин чинь манай ертөнцийн хүн биш байх аа. Тэр холын Авид бурханы оронд хүн цэцэгнээс төрдөг юм гэсэн. Тэгэхээр Минжиннагво цэцэгнээс л төрсөн байж таарахна. Цэцэгний хар голд л хамаг учир байж болох юм. Нарны элч дулааныг маш сайн татаж шингээнэ. Цэцэгний үндсээр дамжин асар их эрчим хүч хуримтлагдаж хүчирхэг тамирын орон үүсэж тэр тамир нь хөхцэнхэр өнгийг ягаан өнгөнд хувиргадаг байж болно. Тэгвэл миний сэтгэл бас зүүд хөх цэнхэр өнгөтэй болох нь. Тэгээд л тэр ягаан алчуур зүүдэнд мөн сэрүүн байхад сэтгэлд үзэгдээд байгаа бололтой. Минжинд энэ цэцэгний хүчирхэг энерги биед нь шингэн хадгалагдаж байгаа хэрэг. Энэ сонирхолтой нууцлаг зүйлийг зөвхөн тааварлах төдий санааг л дэвшүүллээ. Улам гүнзгийрүүлж үзэх шаардлагатай юм гэж бодолдоо умбаж суухад Минжин Амархүүг ажигласаар байлаа.

Арван ес

Амархүү Минжингийн өнгө солигддог ягаан алчуурын нууцыг тайлах санаатай олон өнцгөөс нь магадлал дэвшүүлсэн ч олигтой нэгийг олж чадсангүй Эцэстээ өвөө аав мэдэж байж болох юм гэсэн нэгэн горьдлого төрөв. Гэхдээ өвөөгөөсөө энэ нууцын үнэнийг олж мэдэхэд тийм ч амархан биш байлаа. Өвгөн дургүй юмандаа ганц үг хэлдэггүй хэцүү хүн билээ. Амархүүг ирэхэд Балбар өвгөн аль эрт орондоо орсон байлаа. Амархүү өвөөгийнхөө эл байдлыг хараад маргааш гэдэг мэргэн үгээр санаагаа тайвшруулж чадав. Балбар өвгөн Авирмэд гавжийн тухай дурсамжаа үргэлжлүүлэн бясалгасаар байлаа.

- Авирмэд гавж Үзмээ бүсгүйгээ дагуулсаар нутагтаа ирж санаа нь амарсан ч орох орон оочих аяганаас эхлээд олон зүйл шаардагдаж байлаа. Түүнд түүний амь настай тэнцэж байсан зургаан алтан ембүүнээс хоёрыг нь Үзмээгийн ээжид эм тан авах зэрэг буян номын ажилд зориулсан бол одоо дөрөв нь байлаа. Уул нь олон түмний эрдэм номын буяны үйлст зориульга гэж шийдсэн билээ. Гэтэл аргагүйн эрхэнд орох орон, ахуй амьдралын зарим зүйлд зарцуулах болов.

Алаг хайрхан уулын оройн мөнх цасан мөсний хайлбар хэдэн түмэн сувдан дулаас бүтсэн Улиастайн голын цэнгэг усан хоёр салаалан уулын хавцал уруудан эгшиг дуу аялан урсана. Энэ их голын сав дахь үхэр хонин хаднууд өндрөөс буух усны ширүүн урсгалд долоолгосоор байгаад мөлийж бөөрөнхий хэлбэртэй болсон байлаа. Голын ус хүчтэй үерлэх үед бага чулуу гэхгүй том чулуу ч гэсэн байраа сэлгэн бөмбөрч үзэгдэх нь их дуу чимээ гарган аймшигтай санагдана. Улиастай хоёр голыг их гол, бага гол гэж нэрлэнэ. Бага голын ханан хадан нөмөр нөөлөгтэй зандан ширээ мэт тэгшхэн замилгаатай өлгийд багавтар эсгий гэр бөмбийж өглөөний цэнгэг агаар цэлмэг тэнгэрийг аргалын шингэн цэнхэр утаагаар гоёмсоглон сүлэв.

Энэ шинэ буйран дээр байгаа шинэ айлыг Авирмэд гавжийнх хэмээх ажээ. Энэ айл руу очих бүдэг жим улам тодорсоор сүсэгтэн олон олширсоор байлаа. Нэг өдөр тэднийд нэгэн хүндтэй зочин морилсон нь гавжийн зиндаа багын дотнын нөхөр Манлай байв. Хоёр найз тэврэлдэн золгож бие биеийнхээ далыг зөөлөн алгадаж бүлээн тамираа илгээцгээв. Манлай инээмсэглэнгээ

-Гавж минь ирэнгүүтээ хэл чимээ өгөхгүй яаж байгаа юм бэ? Чиний чинь амьд үхсэнийг мэдэхгүй сураг тасарчихаар эхэндээ гайхаж л байлаа. Сүүлдээ бусдын муу санаанд хорлогдсон байж мэдэх юм. Эхнээсээ л нэг биш муу совин татаад байсан юм гэж бодож байтал хөөрхий Авирмэд Тэнгэр уулын хавьд бурхан болсон гэнээ гэж дуулаад бодол минь батлагдсан болохоор хорин нэг хоног зул барьж ерөөл авлаа. Зүйлийн хүрээ хийдэд Их гэсгүй, Донир Готов хоёр тэргүүлээд их л буян ном үйлдэж хурал хайлан хийж байгаа сонсогдсон хэмээн ярихад Авирмэд инээмсэглээд

- Аргагүй дээ. Буян үйлдэх ёстой хүмүүс нь буян хийж байгаа бол боллоо. гээд болсон явдлаас заримыг нь түүнд дурсан ярихад Манлай хөмсгөө зангидан хөмхийгөө зуугаад гаансандаа тамхи нэрэх зуураа

- Тэгнэ ээ. Энэ муусайн хувалзнууд. Би бүр гайхаад байсан юм. Яахаараа энэ хүнийг

ганцааранг нь манжуудтай манж руу явуулдаг билээ гэж би бодоод чамд хэлж байсан даа гэснээ урт цагаан соруултай гаанснаасаа тамхиа шуналтай нь аргагүй сороод утааг амтархан уушиглаад аажимхан үлээж гаргаад

- Хүрээний чийгэнд ялзарч, хөрөнгөнд цадсан хогнуудыг би нэг болгоод өгнө өө гэхэд Авирмэд сандран

- Манлай та тэгэх хэрэггүй. Тэднийг бурхан сахиус мэдэж байгаа. Та орооцолдох нь тун ч тусгүй хэрэг болно. Манай Үзмээ хөл хүндтэй болохоор хэл ам хэрэггүй байх гэхэд Манлай аягатай хар архийг ганцхан амьсгаагаар хөнтрөөд ихэд ярвайснаа

- Энэ ч мөн ч догшин дархи шүү дээ гэж хэлэнгээ инээмсэглэн

- Манай галын хүн ч гэсэн хөл хүндтэй гэхэд Авирмэд бэлэгшээгээд

- Юун сайн юм бэ? Танайх чинь хэдэн хүүхэдтэй болоод байна гэхэд Манлай

- Таван хүүхэдтэй л болох бололтой юм аа. Чамайг явахад чинь манайх чинь гэж бодолхийлж байснаа

- За байз. Агваанням, Гунгааням, Батням, Отгонням гэж хэлснээ тэр өвөл Отгонням төрсөн юм байна. Отголно гэсэн чинь байдаггүй гээд инээв. Авирмэд Бархөлөөс Манлайдаа зориулж ганц шил хар архи, дээлийн торго, эхнэр Лхам хоёрт нь мөн л нэг нэг дээлийн өнгө, хүүхдүүдэд нь мөсөн чихэр, ётон, үзэм зэрэг чихэр жимс авсан билээ. Манлай халамцаад нуух хаах юмгүйгээр яриа дэлгэж байлаа. Тэр инээд алдаад

- Манай бүл дүү Лхам өөрийг чинь бурхан болсон гэж дуулаад ихэд харамсан гашуудсандаа. Ноднин Зүйлийн голын нэг панзчин залуутай нийлж өрх өсгөж сум сунгасан. Хөөрхий минь одоо бас л хөл хүндтэй юм билээ гэхэд Авирмэд Үзмээ рүү харснаа

- Овоо доо. Бид хоёрын бэлгийг хүргээд өгчихөөрэй. Ойрдоо тийшээ явж чадахгүй байх. Гэрийнхээ дээд талын тэгш тавиу газарт Арьяабалын бүтээлийн сүм барьж босгон олон түмэнд ном буян үйлдэж насны бүтээл бүтээх санаатай байна. Чадал минь хүрвэл Бижийн аманд Намсрай бурханы дугана, энэ урд Баянголын Ястын бууцанд Дара эхийн дацан босгочих санаа өвөрлөөд сууж байна. Нутгийн ахан дүүс олон түмэн ихэд дэмжиж туслах төлөвтэй байна гэхэд Манлай олбог дээрээ өндийгөөд өвдгөө алгадан

- Би бүгдэд нь хувь хандив өргөнө. Тэгээд бас та хоёртоо сүү тарагны бас унаарын хэдэн бод бог ойртуулж өгнө гэхэд Авирмэд бас л сандраад

- Манлай минь хэрэггүй. Олон түмний тус дэмжлэгээр бид болно гэв. Манлай ууртай нь аргагүй аягатай архиа уугаад

- Намайг ах дүү ойр дотнын хүн гэж бодохгүй байвал олон түмний нэг гээд бодчихоорой. Би хүнээр туулгаад явуулчихна. Авахгүй гэвэл Алаг хайрханы суга өөд хөөчихөөрэй гэж чангаар хэлэв. Авирмэд дэмий л юу гэхээ мэдэхгүй гайхаж байтал Үзмээ

- Манлай ах аа. Таны сэтгэлийн бэлгийг хүлээж авалгүй яахав. Таны ач буяныг байнга санаж явах болно гэлээ. Үүнийг сонссон Манлайн хөмсөгний зангилаа тавигдаж нүүр нь гэрэлтээд ирэв. Тэр

- Миний дүү ухаантай бүсгүй байна. Тэнгэр уулын хүн чинь ийм л сийрэг ухаантай байх учиртай даа. Энэ бид хоёр чинь цустай барилдаж төрөөгүй ч дээлэндээ багтаж өссөн ах дүүс байхгүй юу гэхэд Үзмээ

- Би мэднэ ээ. Авирмэд таныг байнга ярьдаг байсан гэхэд Манлай инээд алдаад

- Тэгэлгүй яахав. Би хэдэн сарын ах санаатай юм болохоор ах нь болдог. Энэ маань намайг ах гэж дууддаг гээд цагаан цайлган зангаараа омогшиж байлаа. Хүн гэдэг сэтгэлээрээ урамшиж, жигүүрлэж амьдардаг нь үнэн билээ. Авирмэд дотроо

- Үзмээ минь овоо доо. Манлайн уур омог, хар архины халуун хоёр нийлвэл гавихгүй ч гэсэн гашуун байж мэдэх юм. Хичнээн их мал сүрэгтэй, баян байлаа ч олон ам бүлд юу болохов. Тэнгэрийн таалал байгалийн аашинд багтаж байдаг хойно доо. Баян нэг зуднаар, баатар нэг сумаар гэж үг байдаг. Би гоё дээлтэй том малгайтай, шунал нь ихэдсэн буг чөтгөрүүдийн үүр уурхай болсон сүм хийдэд суухгүй гэж нэгэнтээ шийдсэн болохоор энэ намартаа багтаагаад Арьяаболын бүтээлийн сүмээ босгоно хэмээн бодож суулаа. Гэтэл Манлай сайхан зангаар

- Авирмэдээ чи хийдэд очиж суухгүй гэж бүр шийдсэн хэрэг үү? Чамайг амьд сэрүүн байгааг Их гэсгүй, Донир хоёр мэдвэл юу болдог бол. Лав л их айх байх даа. Хамба насан өтөл болсон. Дээр нь бие муутай байгаа болохоор бүх юм тэр хоёр хүний гарт байгаа гэхэд Авирмэд

- Манлай минь . Цаг цагаараа байдаггүй гэж нэг үг бий. Тэр хоёрт сайн санааны үг одоо хор мэт гашуун амтагдах учир гал дээр тос нэмэх адил уур хилэн дүрэлзэн шатаж бусад олонд гай болно. Харин чимээ багатай алсаас тандаж байх нь тэр түймрийн гал цурманд орж аажимдаа нурам болон өөрөө бөхөх юм гэхэд Манлай

- Чиний зөв бололтой. Би Агваанямаа чиний дэргэд хэсэг суулгавал ямар вэ? Одоохондоо Хамба дэргэдээ авсан болохоор тэд бүгдээрээ л ам сайтай байгаа юм гэхэд Авирмэд бодол болон байснаа

- Агваанямын санаа сэтгэлийг хоёрдуулж болохгүй. Нэг л юмандаа итгэлтэй зорилготой байх нь зөв байх. Над шиг итгэлгүй зарим нэг үзэл бодолтой нь эвлэрч чадахгүй болчихвол тусгүй байх. Тэгээд ч Хамба дэргэдээ байлгана гэдэг алс холын нэг бодол байгаа байх. Агваанням хүссэн үедээ над дээр ирж байг. Би мэддэг болгоноо харамгүй хэлж өгнө. Би өөрийн төрсөн үр шигээ л бодож явдаг юм шүү дээ гэхэд Манлай халамцуу ч гэсэн сэтгэл нь уярч нүдээ аргадан байгааг нь харсан Үзмээ ч мөн л чимээгүйхэн хайлж байв. Амьдрал гэдэг яг л жилийн дөрвөн улирал шиг ээлжлэн солигдож авир аашийг үзүүлмүй.

Улиастайн голынхоо урсгалын харгиа аялгуу чимээг сонсож хоносон Манлай өглөө эрт босоод цэнгэг хүйтэн усаар нь нүүр гараа угааж дотроо сэрүүцүүлэн залгилаад улиас модны бундан навчтай саглагар мөчрүүдийн зай завсраар хөх тэнгэрийг тольдоход нарны цацраг

навч үнсэж найр тавих нь өнгө нэмж үзэмжээр гайхуулна. Энэ байгаль дэлхий юутай гайхамшигтай вэ? гэж тэр өөрийн эрхгүй сэтгэлдээ биширнэм. Нэгэн дээлэндээ багтаж өссөн ахан дүүс ихэр хоёр найз салж ядан байж Авирмэд Манлайгаа үдэж мордуулав. Хоёр голын огторгоор гэлдэрсээр далд орох Манлайгаа харсаар зогсох Авирмэд

-Миний амийг аварсан ачтан ах минь шүү дээ. Мөс жудаг сайтай хүн болохоороо энэ тухай нэг ч удаа ам ангайсангүй. Би хоёр гурван ч удаа дурсаж амь аврагдсан үйл мөрөө ярихад тэр баярлаж бахархсангүй өөрийн тусыг өндрөөр огт үнэлсэнгүй. Харин

- Амьд мэнд л байгаа хойно болно. Монгол эр хүнд морь, сур хоёр хэзээ ч хэрэг болдог юм шүү дээ гэж сургамжилахаас цааш хэтрээгүй шүү дээ. Наанаа ам түргэнтэй ааш хурцтай ч алсын ухаан ихтэй сэтгэлийн тэнхээтэй эр дээ. Надаас өмнө шашин номын шавь нар дотор байгаа бусармаг бузар болгоныг олж хараад эгэл жирийн хар бор амьдралыг сонгосон хүн дээ. Тэгээд ч миний итгэл үнэмшлийг алдагдуулахгүй гэж санаад энэ тухай надад нэг ч удаа дурсаж байгаагүйг бодоход жинхэнэ хүн чанар мөн шүү.

Одоо заавал өмч тасалж өгнө гээд байгаа. Түүнийг нь хүлээж авна. Манай Үзмээ ч их баярласан. Аргагүй байх даа. Аав ээжээ алдаад алс холын хүний нутагт ирсэн бүсгүй хүн чинь ийм сайхан сэтгэлтэй хүний ач буянд баярладаг нь зөв өө. Энэ их ач буяныг хариулж яахан барах билээ. Харин хүү Агвааннямд нь оюун ухааны нууц эрдмээс заримыг нь зааж өгч тус болно. Надад үүнээс өөр хөрөнгө байхгүй шүү дээ гэж бодож зогстол Үзмээ

- Авирмэд ээ. Манайд хүмүүс ирлээ гэж хэлэхэд тэр бодлоосоо арай ядан саллаа. Манлай Их гол гатлаад Бугын хөтөл өгсөн даваад Эхийн бэлээр шогшино. Тэр Дэрсэн эхэнд очиж нэгэн хэрэг бүтээх учиртай билээ. Тэр дотроо

- Буянтай хүний буян их юм даа. Авирмэд гавжийнхаа буянаар Алаг хайрхан уулаа нар зөв тойрох юм байна. Энэ хайрханаа нэг тойрчихоор сэтгэл амраад бие хөнгөрөөд явчихдаг юм шүү. Манай Авирмэдийг эрдэм номд илүүрхэж сурсан нууцын эрдэм чадалтай л гэгцгээдэг юм билээ. Түүний бусдад хор хүргэхгүй өөртөө л зөв байх гэдэг нь үнэн бололтой. Тэр хүчтэй хуй салхинд алгадуулж ургаа модтой мөргөлдсөн гэхээр яаж ч амьтай үлдэх билээ. Тэр айхгар аюулаас амьд мэнд үлдэнэ гэхээр эрдэм номынх нь хүч сайн л байгаа хэрэг. Таны өгсөн сурыг бүсэлж явснаас амьд гарлаа гээд байгаа юм. Тэр бол тохиолдол нэг л ерөөл тавилан шүү дээ.

Агвааннямыгаа л гайгүй сайн эрдэм номтой хүч чадалтай болгочих юмсан. Хэдэн дүү нараа чирээд явчихвал санаа минь амрахсан. Хүүгийн сэтгэлийг хоёрдуулахгүй ариун байлга гэсэн Авирмэдийн санаа бол тун ч зөв бололтой. Элдэв юм сонсож мэдчихвэл над шиг хар болж эгэл жирийн амьдралаар амьдарна гээд зүтгэж мэдэх л хүн шүү. Зөрүүд зүтгүү хоёроороо намайг бүр өвччихсөн нөхөр шүү. Хоёр жил Авирмэдийн дэргэд суулгасан чинь өөр болсон шүү. Одоо багштай нь ойр ойрхон уулзуулж эрдэм номоос нь сайн суралцуулах юм шүү. Арьяабалын бүтээлийн сүм босгож насны бүтээл бүтээж олон түмэндээ буян үйлдэнэ гэж байдаг. Энэ мөн буян нь дэлгэрсэн сайхан үйл мөр болно доо. Ийм ид шид нь бүрдсэн эрдэм ухаан нь дүүрсэн, оюун бодол нь тэгширсэн хүнийг гол ус хошуу хотлоороо дэмжээд өгөхөөр санасан хэрэг болгон нь сэтгэлчлэн бүтнэ биз дээ гэж бодсоор яваад зорьсон газраа хүрээд ирлээ. Манлай хэрэг зоригоо бүтээгээд гэр лүү гээ яарч байлаа. Тэр гол өгсөөд Арцатын

бэлчирт айлд бууж цай уугаад цааш хөдлөв. Тэднийх Тамчийн бэлчирт байгаа болохоор гэртээ дөхсөн байв. Тэр мориныхоо толгой хоёр чихийг ширтэн явахдаа

- Манай Лхам Авирмэдэд сайн байсан шүү. Бурхан болсон гэж дуулаад мөн ч их харамсаж гашуудсан шүү. Хэрвээ хүнтэй суугаагүй бол Авирмэд эхнэр аваад ирдэг Лхамд бүр л давхар гуниг ирнэ биз дээ. Хүнтэй суусан нь болж дээ. Гэхдээ манай хүргэн болдог залуу жаахан өлөн нүдтэй урт хуруутай золиг шиг байгаа юм. Тэгээд бас хол биш ойроор эргэлдээд байдаг олхиогүй явдалтай болохоор нь нутгийнхан ам муутай байдаг нь аргагүй шүү дээ. Эвгүй бол манай хаяаг ч хадарч магадгүй бололтой дог. Хүүхэд шуухадтай болоод ирвэл муу муухай явдлаа татах байлгүй дээ гэж бодолдоо хөтлөгдсөөр яваад гэртээ хүрээд ирэв. Тэр Авирмэдтэйгээ золгосон тухай хүүрнээд бэлэг болгож өгсөн торго, дурдам, чихэр жимсийг нь өгч хүүхдүүдийнхээ ходоодыг баярлуулж эхнэрийнхээ нүдийг хужирлав. Манлай эхнэртээ

- Манай Авирмэд Тэнгэр уулын бэлээр нутагладаг Үзмээ гэдэг сайхан бүсгүйг эхнэрээ болгоод дагуулаад ирж. Өөрөөс нь нилээд олон дүү бололтой юм байна. Ёстой л гавжид тохирсон ухаалаг сайхан сэтгэлтэй бүсгүй юм. Одоо хөл хүндтэй юм билээ. Цаад айлд чинь сүү тарагны бас шөлний, унаарын ганц хоёр мал өгөхгүй бол болшгүй нь. Агваанням өнөө орой ирнэ гээ биз дээ. Тэгвэл маргааш хэдэн мал туулгаад хүргүүлэнгээ багштай нь золгуулъя гэхэд эхнэр нь

- Цаад хүү чинь тэр газар оронг мэдэх юм уу? гэхэд Манлай

- Мэдэлгүй яахав. Бид хоёр чинь хоёр ч удаа Улиастайн голоор гаталсан шүү дээ гэлээ. Маргааш өглөө нь эртлэн Агваанням дүү Батнямын хамтаар бод бог нийлсэн цөөн мал туугаад хөдлөв. Агваанням өврөөсөө хадаг гарган доор мэхийгээд

- Багш таны амар амгаланг айлтгая хэмээхэд Авирмэд

- Амар сайн байна уу? миний хүү гээд хоёр хацрыг нь үнсэж

- Үгүй мөн том болж ээ гэснээ Батнямыг мөн л үнсэж золгов. Сонин сайхнаас сайн сонсож авлаа. Агваанням

- Хамба багшийн бие муухан байгаа. Хурал номондоо сууж чадахгүй голдуу л гэртээ байдаг юм. Хамаг ажлыг Их гэсгүй Донир хоёр үүрэгдэж явуулж байгаа. Хамба багш таныг бурхан болсон гэж дуулаад ихэд цочирдон халаглан уй гашуу болсон. Их гэсгүй Донир хоёр таны хойт мөрд зориулж их буян ном хуруулж хүндэтгэл үзүүлсэн байх. Хамба багш нэг амандаа

- Энэ хоёр бүтэлгүй золигнуудын хийсэн ажил. Ичихгүй тэгээд буян үйлдээд яваад байгаа юм даа. Хайран ч сайхан залуу нас. Их эрдэмтэн гээд халаглаад байсан гэхэд Авирмэд

- Чи очоод Хамба багшид миний мэндийг тусгайлан хүргээд намайг Арьябалын бүтээлийн сүм бариад ном буян хурах гэж байгааг сонсгоорой. Боломж гармагц очиж золгоно гэж байгааг минь зөвхөн өөрт нь хэлээрэй. Хэрвээ сонирхож юм асуувал чи мэдэж буй юмаа үзсэн харснаа ярина биз дээ. Бас нэг маш нууц зүйл байна. Донирын бэлтгэсэн цай эм танг багшид битгий өгөөрэй. Ууж болохгүй гэж багшид нууцалж хэлээрэй. Чи багшийн дэргэдээс

холдож болохгүй шүү гэж анхааруулаад бодол болсноо

- Чи жүд үзээд ирэхээрээ над дээр ирж байгаарай. Багш нь мэдэх бүхнээ зааж сургах болно гэснээр энэ удаагийн яриа өндөрлөв. Агваанням Авирмэд гавж багшаа хүндэлж дээдэлж шүтэн биширч байлаа.

Хорь

Зүйлийн хүрээний Гааданравжайчойн-хорлин хийдийн сүм дугана, айл болгоноор нэгэн чөтгөр хэсэж яваа юм шиг яриа амнаас аманд дамжин шивэр авир яригдана. Хоёр жилийн өмнө хойтын мөрийг нь дааж сайн төрөлд хүргээд буян ном хураад Их гэсгүй Чойжин бууж, Донир их гал түлж балин залаад байсан бурхан болооч гавж Авирмэд хувилан босч ирээд өмнийн Алаг хайрхан уулын өвөр бэлд Улиастайн бага голд Арьяабалын бүтээлийн сүм босгож хамаг амьтны буяны санг арвитгаж насны бүтээл бүтээж байгаа тухай яриа билээ. Үүнийг сонссон Их гэсгүй ихээр гайхширан амандаа

-Худал байлгүй. Харин сүнс нь тэнэж явж болох юм даа гэж шивэгнэж бодол болж суутал донир Готов орж ирээд Их гэсгүйг нүдээ том болгон хараад үдээр шиг үрчгэр гараараа туранхай хөх нүүрээ илснээ

- Та нэгэн сонин явган яриаг сонсов уу? гэж асуухад Их гэсгүй

- Юун сонин яриа байдаг билээ гэж огт мэдээгүй дүр эсгэн асуухад Донир Гэсгүйгийн нүүр нүдийг нь тогтуун ажиглаад дотроо

- Та л сонсоогүй байх вий. Нүүрэн дээр нь айдас тодроод судрын бичээс шиг дурайж байхад бас надтай тоглоом хийх санаатай юу гэж бодоод инээмсэглэх аядаад

- За тэгвэл сонсоогүй бол яамай даа. Ер нь хэрэггүй юмыг сонсоогүй нь дээр байдаг юм гэв. Их гэсгүй Донирыг шинжингээ

- Энэ арьс нөмөрсөн араг яс ч амаргүй эр шүү дээ. Одоо яах тухайгаа аль эрт бодож боловсруулаад бэлдчихсэн байгаа даа. Тэр Манж түшмэлийг тун ч найдвартай гээд байсан биз дээ. Энэ золигын манж нар бид нараар бас их тоглоом тохуу хийх юм даа. Энэ бид хоёр ч аргаа барж арчаагаа алдсан ёозны хоёр нүх юм даа. Донир өглөө гайхам үнэр амттай цай авчирч өгөхдөө юу ч ярихгүй л байсан даа. Бие сулраад зүрх бэлбэгнээд нэг хачин байх юм даа. Юу болох нь энэ билээ. Готов золиг надад арай өөр цай өгчихөөгүй байгаа даа гэж дотроо бодоод Донирт

- Та надад сонсох дургүй байвал өөрийнхөөрөө бол доо. Нэг хэлвэл билэг, олон хэлвэл улиг болдог гэдэг биз дээ. Энэ цуу яриа чинь тэгээд үнэн болж байна уу? гэж сөргүүлэн асуухад Донир ёозгүйгээр хараад

- Үнэн худлыг мэдэх юм алга. Хэн гэгч нь уулзаж учраад ирсэн юм бүү мэд. Тэнгэр уулын үзэсгэлэн гүнжтэй ханилан суусан юм гэнэ. Арьяабалын бүтээлийн сүм бариулж босгоод насны бүтээл бүтээж байгаа гэнэ. Манай хүрээ хийдэд хурал номонд суухгүй юм байх гэхэд Гэсгүй зовиурлан уртаар амьсгаа аваад

- Тэгвэл айгаад гайхаад байх хэрэг юу байна. Арай худал цуу яриа юм биш биз гэхэд Донир

- Цуу яриа биш бололтой. өөр бас нэг яриа яваад байна. Авирмэд гавж хоёр амьтай юм гэнэ.

Нэг амиа өөртөө, эхнэр хүүхэддээ зориулах юм байх. Нөгөө амиа олон түмэн эрүүл саруул байж урт удаан наслахад зориулах гэнэ. Тэр амь нь арван лангийн зургаан алтан ембүү гэнэ Түүгээрээ л номын өргөө сүм дугана босгоод байгаа хүн юм байх гэхэд Их гэсгүй баруун гараараа зүрхээ дарж зүүн гараараа чихээ барьсан байв. Тэр амаа хагас ангайн жавдан суудлынхаа арын түшлэгийг налав. Тэр амандаа

- Ээ бурхан минь гэж шивнээд нүд нь алагтан хоолой нь сонин дуугараад бүх бие нь сулран унав. Сандлын түшлэгэнд хүзүүгээ нугалан зүүн жавьжаар нь хэл нь цухуйж хөдөлгөөнгүй болсон нүдээрээ донирыг ширтсээр байх нь түүнийг түргэн хүрээд ирээч. Хамтдаа явья гэх шиг санагдав. Донир Готов хүсэн хүлээсэн хүсэл нь ийнхүү бүтсэнд дотроо баярлан уруулаа муруйлган жавьжиндаа үрчлээ гарган мишээгээд бараг ганцаараа мэдэх Их гэсгүйн нууц хөшгийг сөхөн арын хаалгаар хий гүйдэл шиг хэнд ч үзэгдэж харагдалгүйгээр явж одов. Хөөрхий Их гэсгүй амьд сэрүүндээ

- Энэ тэмээний үдээр шиг туранхай хөх эр цагаа болохоор намайг ч дөнгөх аргаа олчихсон л байгаа гэж хаширлаж муу санаалж байсан нь ийнхүү биелэлээ олов. Их гэсгүй тэнгэрт хальсан тухай мэдээ эгшин зуурт түгэн тархав. Хүрээ хийдийн дээд хэргэм тушаалтай өндөр настай Их гэсгүйг буян номыг тэгшлэн хурж сайн төрөлд хүргэн бусад зан үйлийг ёсчлон хийж хөдөөлүүлэв. Хамба багшийн бие өдрөөс өдөрт сайжирсаар байлаа. Хамба Агвааннямд

- Хүү минь. Донирын надад бэлдэж өгдөг үнэрт цэцгийн цайг намайг уухгүй байгаа гэдгийг маш нууцлах хэрэгтэй юм шүү. Ялангуяа Авирмэд гавжийн зөвөлгөө гэдгийг хэн ч мэдэх ёсгүй. Чи ч гэсэн янз бүрээр сэжиг авхуулчихаж болохгүй шүү гэж захиад тэр бодлоо нэрж чимээгүй болов.

- Энэ Готов эрдэм номд маруухан болохоороо муу арга л сэддэг хүн юм. Авирмэдийг үхүүлж балин залж гүрэм хийгээд ч хүч нь мөхөсдлөө. Харин үнэрт цэцгийн цайгаа надад бага тунгаар өгч амьд үхсэний хооронд байлгаж миний нэр нөлөөг ашиглан хүссэн бүхнээ амжуулах санаа өвөрлөж байж. Гэтэл Авирмэд гавжийг амьд сэрүүн байгааг сонсонгуутаа нууц хуйвалдааны гол нэгэн хүн болох Их гэсгүйг үгүй болгож түүнд бүх хэргийг тохож өөрөө уснаас хуурай гарах аргыг бодож олсон байна. Мөн ч хүний санаанд багтмааргүй зүйлийг бодож олсон байгаа юм шүү.

Тэр Готов золиг угаасаа хүний нүдэнд өртмөөргүй амьтан шүү дээ. Өртсөн ч өрөвдмөөр нэгэн. Туранхай, үрчгэр, хар, номхон ноолгор. Худалч хүнд өнөө маргаашгүй өдрөө хүлээсэн нүд хальтирмаар царай зүстэй. Харин бичиг үсгэндээ бол хэнд ч гологдохооргүй сүрхий хүн л дээ. Би сайн санаж бусадтай адил яваасай гэж л дэргэдээ донироор авсан юм даа гэж бодож суув. Донир Готов дотроо нэгийг бодно.

- Хамба лам сүүлийн үед улам сайжраад бараг л хуучин хэвэндээ орж хурал номондоо хааяа сууж ажил хэргээ ч өөрөө хөтлөн явуулах болов. Уг нь үнэрт цэцгийн цайг өдөр болгон ууж байгаа мөртлөө ийнхүү сэргэсэнд ихэд гайхаж байв. Тун хэмжээг нь ихэсгэж өгвөл тун ч түргэн үйлчилдэг болохыг Их гэсгүй дээр мэдсэн билээ.

Манжийн түшмэл намайгаа бас молигдож орхисон юм биш биз гэх хар санаа төрөөд нохойн гөлгөнд өгөхөд хэдхэн хормын дараа нүд аньсныг санав. Энэ үнэрт цэцгийн цай их биш

багахан үлдсэн болохоор хэрэгцээтэй үедээ хэрэглэж байя гэж шийдээд Хамба багшдаа өгөхөө түр зогсоов. Их гэсгүйгийн буяны хоног дуусахад Хамба лам Дониртойгоо огтхон ч зөвлөлдсөнгүйгээр Шаравдорж гэвхийг Их гэсгүйгийн оронд томилов. Готов уул нь өөрийн талын хүнийг товлож байсан ч бодол нь талаар өнгөрөв. Хамба лам нэг өдөр донир Готовыг дуудаад ойр зуурын юм асууж байснаа

- Шаравдорж Их гэсгүйд сайн тусалж сургаж байгаарай. Донир минь надад өгдөг нөгөө үнэрт цэцгийнхээ цайг яагаад өгөхөө больчихов оо? Миний муу доройтоод сулраад байсан биеийг минь мөн ч өөд татсан шүү. Чиний тусыг мартахын аргагүй гэхэд нь сонсож суусан Готовын үрчгэр хар нүүр хүрээнтээд ирэхийг ч Хамба лам ажиглав. Донир ихээр хөлрөөгүй ч духаа алгаараа илээд

- Багш аа. Би таньд олж өгнө. Багахан хэмжээтэй л байсан юм гэлээ. Харин Донирын чихэнд сонсогдоогүй нүдэнд үзэгдээгүй нэгэн үйл мөр болоод өнгөрсөн билээ.

Авирмэд гавж орой бүрэнхийгээр ирээд Хамба ламтай золгож хүндэтгэл үзүүлээд шөнөжин ярьж, хуучилж аваад үүр тэмдэгрэх төдийд мордсоныг л огт мэдээгүй билээ. Хамба лам Авирмэдээс болоод өнгөрсөн, одоо болж байгаа бүгдийг сонсоод толгойгоо сэгсрэн байж

- Энэ хүмүүсийг бүгдийг нь таньж мэдэх үнэхээр бэрх юм. Миний л дэргэд байнга байдаг ойр дотнын хүмүүс ийм айхтар юм санаж сэднэ гэхээр өөр хэндээ итгэх болж байна. Энэ бүгд миний л мунхагийн гай. Би өтөлж өвгөрсөн бололтой. Энэ хэцүү албыг ганц хүнд өгье гэж төлөвлөж байтал ийм завсрын гай хөө орж ирээд баллачихлаа. Чамд би хүчээр тулгалтай нь биш дээ. Чиний дамжуулсан үгийг сонсоод эргэлзэж байсан ч зөв гэж хүлээж авсан. Энэ Агваанням хүүгийн хатуу хяналтанд орж байж л нэг аюулаас мултрав.

Их гэсгүйн суудалд Донир маань өөрийн хүнийг товлож байгааг би мэдсэн юм. Тэгээд л багш нь ах зах хэргэм зэргээ мэдэж хийх ёстой ажлаа хийж бай гэдгийг сануулъя гэж бодоод хэнд ч мэдүүлэлгүйгээр Их гэсгүйд Шаравдорж гэвхийг томилсон юм. Ер нь эрдэм номын чадал муутайхан дол цохисон нас ахисан хүмүүс чинь л сэнтий суудлаа алдахаасаа айж ямар ч аргаар хамаагүй хамгаалахыг хичээж юу ч хийхээсээ буцахааргүй болдог бололтой юм. Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр гэдэг. Их гэсгүйд маань тийм л юм болчихлоо. Одоо яая гэхэв. Гавж аа би тантай нэг санал солилцмоор болоод байна. Танай шавь, Манлайн ууган хүү Агваанням ер нь хэр зэрэг хүүхэд вэ? гэж асуув Авирмэд

- Багш аа. Над дээр хоёр жил болсон юм. Ном эрдэмдээ тун ч идэвх зүтгэлтэй хичээнгүй хүүхэд байгаа юм. Олон таван үггүй, зорьсондоо бол ухарч няцах юмгүй зүтгэнэ. Хүний үгийг сайн авна. Гэхдээ л ихэнхдээ өөрийнхөөрөө зүтгэнэ шүү дээ. Бага зэрэг зөрүүд гэх юм уу. Ер нь л манай Манлайтай төстэй зантай юм даа гэхэд Хамба лам бодолхийлж байснаа

- Би чамайг алдчихсан болохоор бие минь эрүүл саруул байвал хэдэн жилдээ энэ хүүг дэргэдээ байлгаж эрдэм номонд ч хийдийн бусад ажил төрөлд ч сургая гэж бодоод байгаа ухаантай юм шүү дээ гэхэд Авирмэд гавж хоолойгоо засаад

- Би таны саналтай яахан зөрөх билээ. Би ч гэсэн мэддэг сурсан жаахан юмаа зааж сургана. Сурсан мэдсэн эрдмээрээ хэний ч дор орохгүй байх аа. Бусад ажлын арга барилыг нь та сайн

заагаад өгөхөд л болно. Ер нь залуу хүнийг дээш нь дэвшүүлэн тавих нь зөв юм шүү гэж Хамба багшийнхаа санаа бодлыг нь дэмжсэнд тэрээр ихэд баярлан

- Таньд гялайлаа. Нэг дор биш ч гэсэн хоёулаа зөвлөлдөж байж болно биз дээ гэхэд Авирмэд толгой дохин зөвшөөрөв. Хамба лам их л чухалчилж байгаа бололтой анхаарлаа төвлөрүүлээд

- Энэ Донир Готовыг яавал зохилтой вэ? Би ч янз бүрийн ааш авир гаргаагүй. Харин ч магтах шахам байгаа. Хэрвээ эрт сэжиг өгвөл юу ч хийхээсээ айж ичихээ байчихсан яг л монголын улайрсан бух л гэсэн үг гэв. Авирмэд инээмсэглээд

- Уг нь хийсэн гэм нүглээ өөрөө ойлгож ухаарвал зүгээр юмсан. Тийм болохоор янз бүрээр оролдож тэнэг мунхагийг нь өдөөх хэрэггүй байх. Өөрийг нь өөрт нь даатгачих. Гагцхүү өөрийн биеэ таньж бусдыг энэрч сэтгэлээ ариусган гэгээрсний үрээр хорт муу сэтгэл, үйлдсэн гэм нүглээсээ ангижирч чадна гэлээ. Хамба багш Авирмэдийн мэргэн ухаанд биширнэ. Үүр тэмдэгэрч тэнгэрийн хаяанд сүүн гэгээ сүлсэн байхад Авирмэд багштайгаа салах ёс хийгээд мордов.

Хорин нэг

Улиастайн голын баруун уулын оройд нарны шаргал туяа туссан байлаа. Авирмэд гавж дээлийнхээ энгэрийг товчлох зуураа

-Намар орой болсон болохоор өглөөдөө сэрүүвтэр байна шүү гэж хэлэхэд хэн нэгэн

- Тийм ээ. Сэрүүхэн байна гэж шулганан хэлэхэд Авирмэд дотроо

- Миний хүү чинь хэдүйдээ босоод дэргэд минь ирчихэв ээ гэж бодоод

- Чоймжуур аа. Миний хүү жаахан унтахгүй яасан юм бэ? гэхэд хүү нь

- Аав аа. Та номонд мэргэн, нойронд сэргэг бай гэдэг биз дээ. Нойрыг чинь сэргэж бардаг гэсэн шүү гэхэд Авирмэд хүүгийнхээ толгойг илээд

- Зөв байна хүү минь. Нойр хүнд чухал хэрэгтэй боловч ихэдвэл сайнгүй, ухаан мунхардаг. Хоол мөн ихэдвэл гэдэс дотор эвгүйрхдэг юм гэвэл хүү Чоймжуур нь

- Тийм байх аа. Би эртэд тарваганы базмагнаас их идээд дотор муудсан шүү аав аа гэхэд Авирмэд

- Наад сургамжаа мартаж болохгүй. Чи чинь өнөөдөр ямар ном цээжлэх ёстой билээ гэж асуухад Чоймжуур цовоо цойлгоноор

- Доди галсан гэв. Авирмэд

- Юуны тухай ном билээ гэхэд хүү нь

- Доди галсан гэдэг / сайн хувьт/ гэсэн сайн цагийн мянган бурханы нэрийн магтаал юм шүү дээ гэхэд аав нь

-Номыг хоосон цээжлээд байж болохгүй. Эхнээс нь нэр, утга зориулгатай нь бүрэн ойлгож сэтгэлдээ бүтээх хэрэгтэй. За мянган бурханаас ямар ямар бурханы ерөөл магтаал байдаг билээ гэхэд Чоймжуур бодолхийлж байгаад

- За. Хорвоонжиг /Орчлон эвдэгч/ Сэртэв /Алтан чадагч/ Одсүрэн /Гэрэл сахигч/ Шагимуна / Санжаа/ дөрөв байгаад залрах бурхан Майдар /Асралт/ гэж хариулахад Авирмэд баярлан

- Сайн байна хүү минь. Эрдэм номонд хичээнгүйлэн суралцах нь хамгийн чухал юм шүү гэж аав хүү хоёрын хөөрөлдөхийг харж зогссон Үзмээ бүсгүй сайхан инээмсэглээд

- Та хоёр минь орж цайгаа уу даа гэхэд Чоймжуур ээжий өөдөө хараад

- Ээжий минь. Аав сая намайг бас л шалгалаа гэхэд Үзмээ инээмсэглэснээ

- Миний бор хүүг өдөр шөнөгүй, өглөө оройгүй шалгаад л байх юм уу? ямар хэцүү аав бэ? гэхэд Чоймжуур хүү сандарч

- Үгүй ээ, үгүй ээжээ. Миний аавтайгаа ярьсан болгон санаанд минь мартагдахааргүй тогтоогддог юм аа. Би орж цайгаа уучихаад хурлынхаа уншлаганд сууна аа гэсээр гэртээ гүйж оров. Хүүгээ харж зогссон Авирмэд Үзмээ хоёр бие биерүүгээ харан аз жаргалыг илгээцгээн сайхан инээмсэглэцгээв. Авирмэд хүүгийнхээ тухай бодож зогсохдоо үртэй хүн жаргалтай гэдэг үнэн юм даа. Манай Манлайн бага охин Дэжидням манай Чоймжуур хоёр нэг өдөр ганцхан цагийн зөрөөтэй мэндэлдэг нь сонин тохиолдол шүү. Манай Манлай ч цагаан цайлган сэтгэлтэй хүн болохоороо тоглоом тохуу болгон

- Энэ хоёр хүүхдийн заяа төөрөг тавилан нэг байж мэдэх юм шүү. Юмны ерөөл байвал өрх өсгөж сунгасан ч яадаг юм. Хоёр аав нь чацуу бас хоёр ээж нь найзууд. Тэгээд л худ ураг болчихвол мөн гоёо гэхэд Авирмэд инээгээд

- Хүүхдүүдийн хувь тавилан л мэдэх хэрэг гэхэд Үзмээ санаа зовсон байдлаар

- Энэ тоглоомоос чинь болоод хоёр хүүхдүүд минь ичиж айгаад бие биенээ үзэж чадахгүй болчихвий дээ гэв. Дэжиднямын ээж

- Харин тийм ээ. Манлай минь. Чи халамцуу үедээ элдвийг бурж илүү дутуу юм хэлдэг шүү. Бодолтой л байгаарай гэлээ. Манлай мөн л халамцуу байсан болохоор ууртай маягтайгаар

- За, за би наад үгийг чинь санаж явъя гэхэд Авирмэд толгойгоо дохин Манлайнхаа ухаантайг бахархаж бардамнаж сууснаа дурслаа. Энэ хоёр айл жилдээ л нэг удаа нэгнийдээ айлчин гийчин хийж ам бүлээрээ цугларан тоглож наадаж, ярьж хөөрч инээж баясдаг билээ. Харин Манлай, Авирмэд хоёр бол хүссэн үедээ л уулзаж дотносно. Сэтгэлдээ байгаа сайн муугаа хэн хэндээ нуухгүй ярилцаж бие биедээ урам хайрлаж сургаж зөвлөнө. Тус дэм болно. Ялангуяа Манлай байнга л нааш цааш явна. Дулаан улиралд бол ганц охиноо аваад л ирнэ. Дөрвөн банди гарсан хойно хүрээд ирсэн ганц охиндоо амиа тавина. Заримдаа арай дэндүү эрхлүүлнэ. Манлайд үг хэлэх зоригтой хүн байхгүй. Тэр ганцхан Авирмэдийн үгийг л авна. Үзмээд илүүтэй сайн учир түүнийг яг л төрсөн дүү шигээ санаж бас хэлэх үгийг нь хүлээнэ. Их согтуу үедээ

- Миний муу дүү чинь Тэнгэр уулын дагина юм шүү. Та бүхэн энэ хүнийг хүндэтгэж бай. Эс хүндэтгэвээс би ёстой үзүүлээд өгнө шүү хэмээн магтаж бас өмөөрч үг хэлнэ. Сүүлийн үед Манлай архи даахгүй болж амархан согтоно. Тэр үедээ үр хүүхдээрээ бахархан мал хөрөнгөөрөө баярхах нь улам илүүтэй болж байгаад ойр орчмынхон нь сэтгэл зовно. Ялангуяа Агваанням ууган хүүгээ магтана.

- Миний хүүгийн эрдэм номтой эн зэрэгцэх хүн Зүйлийн хүрээ битгий хэл хаана ч байхгүй. Би дөрвөн хүү, нэг сайхан охинтой хүн гэж омогшино. Эхнэр нь санаа зовоод

- Та битгий үр хүүхдээрээ баярхаад байгаач. Хүүхдүүдэд минь муу хэл ам болох вий дээ гэхэд Манлай

- Чи дуугүй бай. Хүн гэдэг чинь байгаа юмаараа баярхаж, байхгүй юмаараа дугааж явдаг юм. Манай Агвааныг байж байхад муу хэл ам ирнэ гэж юу байдаг юм. Ёстой хүссэнийх нь хүзүү хугарч, хэлснийх нь хэл нь татах байлгүй. Би хар манжуудаас аваагүй хажуу дэргэдийнхээ хаяаг хадарч хулгай хийж худал хэлээгүй. Буурлын буянаас үлдсэн мал сүрэг надад нүүрээ өгч өсөж үржээд өдий зэрэгтэй болсон нь үнэн. Надад

Өл дааж хурд сорих зургаан азарга адуу байна

Өөхөн бөмбий ууцан сүүлтэй зургаан зуун эм хонь байна

Заяа түшсэн товчийг бөхөлж тогоо барих хань минь байна

Завсар орохгүй таван сайхан алаг үр минь байхад

Манлай хүүг хэн сургаж юуг заах билээ

Манай банхар нохойг хэн хорьж дийлэх билээ гэж ханхалзана.

Тэр Цэмбэл баяны үлдээсэн мал хөрөнгийг эзэн хүн нь баярламаар өсгөн үржүүлж явааг нь нутгийн хэн боловч үгүйсгэхгүй байв. Цаг хугацаа хурднаа өнгөрч хүрээ хийдийн Хамба ламын нас ахиж залуу лам Агваанн्याмын эрдэм ном нь чамбайрч эр бие нь өсөж идэрхэн насандаа гэвш хэмээх зэрэг цолыг хүртэв. Хамба ламтан өөрийн бодлогодоо итгэлтэй байж бусад мэргэдтэйгээ зөвлөлдсөний эцэст залуу гэвш Агваанн्याмыг Гааданравжаачойнхорлин хийдийн хамба хэмээх өндөр хэргэм зэрэг албанд тохоон томилж залж суулгав. Залуухан хамбатай болсон хүрээнийхний зарим нь

-Энэ залуу ч гайгүй хамба болж мэднэ. Авирмэд гавжаар ном эрдмээ чамбайруулж авсан хүн. Эрдэм номоор бол хэнээс ч дутах юм байхгүй. Харин эцэг нь баян Манлай шүү дээ. Тэр хүн их ойртвол хийдийн жаахан жасыг өдөр шөнөгүй зөөгөөд дуусгаж мэдэх юм. Тийм болохоор тэр эцгийг нь холхон байлгавал зүгээр юм гэж байхад өөр нэг нь

- Энэ залуугаар хамба болгодог нь өвгөн хамбаас гадна Авирмэд гавж их нөлөөлсөн байх. Авирмэд гавжийг чинь манай нутгийнхан бүү хэл халх даяараа магтан шагшиж байна шүү дээ. Түүний хүү Чоймжуур гэж нэг аюултай эрдэм номтой жаалхүү гараад ирлээ. Одоо арван гурван настай гэхэд түүний эрдэм мэдлэг арай дэндсэн гэж хэлэхээр илүү юм билээ. Агваанням хамбын аав Манлай Авирмэд гавж хоёр чинь дээлтэй төрсөн ах дүүс дотнын найз нөхөд шүү дээ. Энэ бүхэнд ямар нэгэн нарийн нандин нууц хадгалагдаж байж мэдэх юм гэж хэлэлцэхэд бусад нь

- Энэ залуу энэ хийдийг авардаг бурхан нь юм уу, алдаж асгадаг чөтгөр нь юм уу бүү мэд дээ. Агваанн्याмын аав Манлай чинь сүм хийд хурал номоо орхиод баян Цэмбэлийн ганц охинтой сууж хөлжсөн хүн шүү дээ. Одоо архинд донтоод ааш авир нь эвдрээд яваа хүн дээ. Удам угсаа нь иймэрхүү байхад Хамбаар тавьчих юм.

Агваанн्याмын багш Авирмэд гавж бол өөр хүн. Эрдэм номтой, нэр төртэй халхад танигдсан гавж. Тэр хүний цаад санаа нь энэ сүм хийдэд буглаж бугшсан бузар болгоныг үлдэн хөөж

ариусгах зорилготой гэсэн. Түүнийгээ гүйцэлдүүлэхийн тулд шавь Агваанн्याмыгаа энэ суудалд хүргэсэн байх. Харин хүүгээ бол элдэв юмтай орооцолдуулахгүй дан ганц номын мөр хөөлгөнө гэж байгаа гэнэ лээ гэж байв. Манлай ч баярлаж Авирмэдийнд ирээд

- За хөө. Цаад залуу чинь Хамбын суудалд залрах нь заларч орхилоо. Цаашдаа яаж шүү явдаг юм бол доо. Эхэндээ болмоор санагдаад байсан. Олон дахин бодоод байхаар санаа минь зовох юм. Гавж минь байнга л зааж сургаж залж явахгүй бол болохгүй нь дээ гэхэд Авирмэд гавж инээмсэглээд

- Манлай минь юундаа санаагаа зовоогоод байгаа юм бэ? Аль юм болгон дээр өөр талаас нь хараад байвал мөн л муу муухай болгоноор төсөөлөх нь лавтай шүү дээ. Агваанням өвгөн хамбаас нилээд зүйлийг сурч мэдсэн. Тэгээд ч өөрийгөө аваад жолоодоод явах ухаан суусан, эрдэм номонд сайн боловсорсон болохоор зовоод байх юм байхгүй гэж итгэлтэй нь аргагүй хэлэхэд Манлай сэтгэл нь жаахан амраад инээмсэглэх аядаад

- Хэлэхэд амархан хийхэд хэцүү л дээ. Би л очиж орооцолдохоо больё. Хүмүүс юу ч хэлж мэднэ. Манлай хүүгийнхээ толгойг эргүүлээд хийдийн жасыг бага багаар нь зөөж байна гэж мэдэх л улс гэхэд Авирмэд толгойгоо дохин зөвшөөрөөд

- Манлай минь та охин Дэжиднямдаа л анхаарал тавих ёстой шүү. Нөгөө хааяа унадаг өвчин нь яаж байна гэхэд Манлай санаа алдаад

- Одоохондоо гайгүй л байна. Зундуй маарамбаас эм залаад хүртэж байгаа. Тэр эм танг байнга ууж бай гэсэн. Зүрхний төрмөл гажигтай гэнэ. Эмээ уугаад л байвал унаж тусах нь гайгүй болно. Харин төрж хөнгөрч болохгүй гэсэн. Хэрвээ төрөх үе гарвал маш аюултай амь насанд нь ч гай болж болно гэж ихэд анхааруулсан шүү. Би дөрвөн залууд ганц охин дүүгээ хайрлаж халамжилж байгаарай гэж захиад эл өвчний байдлыг ганцхан Агвааннямдаа л чухалчлан хэлсэн дээ. Бид чинь ямар мөнх биш болохоор өнхрөөд өгсөний дараа юу л болдог бол гэхээс цээжний махаа барах юм даа гэж зовлонгоо андаа нэг бүрчлэн ярьлаа.

Хамба гэдэг албан тушаал Агвааннямд ахдах шахам хүндхэн байсан ч тэр зориглон насны аагаар хийх болов. Эхлээд Донир Готовыг хурлын лам болгон өөрийн сайн танил ламаар Донирын албанд томилоход нөгөө нэг хүмүүс хоорондоо

- Тэр хэлээгүй юу? Донирыг солих нь зөв. Залуу хүн шиг зоригтой байна гэхэд өөр нэг нь

- Энэ халаа сэлгээ бол Авирмэд гавжийн заавар мөн. Готов бол Авирмэдийг сүм хийдээс хөндийрүүлэх бүх үйл мөрийг өмнөх Их гэсгүйтэй хамтарч хийсэн гэдэг. Гэхдээ донир Готовыг бүр хийдээс хөөж ч болох байсан. Гэтэл түүнийг хуралд үлдээлээ. Энэ ч бас зөв гэж үзэж байсан болохоор Агваанням хамбын ажлын эхлэлийг сайшаах нь түүнд урам өгч байлаа.

Үнэнийг хэлэхэд Агваанням хамбын ажил хэрэгт аав Манлай, номын багш Авирмэд хоёр хуруу дүрэх нь битгий хэл хушуу ч нэмэрлэхгүй байгаа билээ. Гэтэл хүн бүр л өөр өнцгөөс өөр бодол саналаар дүгнэж байлаа. Бурхад нь амар амгаланг бүтээж байдаг бол Догшид нь бусармаг муу болгоныг дарж өгдөг билээ. Нэгэн өдөр Агваанням хамбад донир байсан Готов

бараалхаж түүнтэй тусгайлан уулзав. Тэр хорчгор хөх нүүрээ туранхай чөргөр гараараа илэн байж

- Хамба аа. Танд их баярласан шүү. Хийдэд минь хурлын ламаар үлдээж өгсөнд би баярлаж буйгаа хэлэх гэж л ирсэн хэрэг. Би чинь ганц бие хүн шүү дээ. Ах дүү амраг садан гээд байх хүн байхгүй болохоор энэ сүм хийдээс л гарвал надад орох орон оочих аяга, бараадчих ах дүүгүй учир энд үлдээсэнд маш их баярласан шүү. Би буруу зөрүү юм хийж байсан ч Хамба багш, сүм хийдийнхээ төлөө чин үнэнээсээ зүтгэж байсан. Миний зарим шударга үйлдэлд дургүйцэх нэгэн байсныг хэлэхгүй байж болохгүй байх аа. Хамбыг хүнд өвчтэй байх үед нь би хамаг ажил төрлийг нь үнэн сэтгэлээсээ л хийж гүйцэтгэж байсан. Та ч гэсэн мэдэх байх гэхэд Агваанням дотроо

- Та Хамба багшид минь үнэрт цэцгийн цайг бага тунгаар өгч үхсэн амьдын хооронд байлгаж өөрийн санаа бодлыг гүйцэлдүүлж байсныг мэдэхгүй гэж санав уу? Миний багш Авирмэд гавжийн сэрэмжлүүлсний ачаар амьд мэнд авч хоцорсон шүү дээ. Та Их гэсгүйг хороож хамаг бузар булхайгаа түүн рүү чихэж өөрөө цэвэр үлдсэн гэж бодож байвал эндүүрэл болох байх даа. Хэрэгтэй үед амьд гэрч байгаа гэдгийг санаарай гэж бодоод төлөв байдлаар

- Би таныг сайн мэднэ. Бүр арван хуруу шигээ гэж хэлж болно. Та сэтгэлээ дотогшоогоо хурааж хурал номондоо хичээнгүйлэн суугаарай. Хэрэг болвол би таныг дуудна. Аар саар бодол хүнд тус болохоосоо илүү ус болох нь цөөнгүй байдаг гэдгийг санаж явахад илүүдэхгүй байх. Хулгана муурын сахлаар оролдсон үлгэрийг нэг саначихаарай гэхэд Готов дор мэхийн

- Хамбын сургамж сануулганд гялайлаа. Би байнга санаандаа байлгах болно гэж хэлээд дотроо

- Та бид хоёрын хэн нь хулгана болоод муурын сахлаар оролдоод байгаа юм бол доо. Яваандаа муурын ам руу хэн нь орохоо тэр цаг мөчид л мэдэх болох нь гэж бодсоор бөхийсөөр ухарсаар гарав.

Тэр туранхай үрчгэр гараа чанга атган базлахад арьс нь жийрэг болж хамгаалснаас арай л хоёр яс хоорондоо хавиралдаж муухай дуу чимээ гарсангүй. Харин шүдээ зууж хавирахад орсон буурын шүдний хялганасан муухай дуу гарч байлаа. Тэр амандаа

- Энэ Авирмэдийн туршуул, чацга нь арилаагүй гөлөг бас намайг сургаж дарамтлах юм гэнэ ээ. Гайгүй байлгүй. Хорвоо нэгээр дуусдаггүй, хойноос нар манддаггүй гэдэг биз дээ гэж шивнэв. Энэ хүний сэтгэлийн угт өс хонзон тайлагдахааргүй уягдаж буглаж бузардсан байв. Тэр харчгар туранхай арьс нөмөрсөн араг яс харагдавч хамгаас эрүүл биетэй, хүрэл зүрхтэй, хүйтэн цустай нэгэн байлаа.

Амьдрал үргэлжилсээр ардаа түүхээ бичиж үлдээсээр өтөл өвгөдөө үдсээр өсвөр багачууд нь өсөж бойжсоор нилээд хэдэн жил өнгөрөв. Тэр жилийн өвөл цасгүй, хар хүйтэн чангарч мал амьтдын махыг барав. Хүмүүсийн сэтгэлийг жиндээв. Хавар нь хавсарга олонтой харшаа ихтэй учир малыг жилбэгүйдүүлж төлийг тураалд оруулж газрын ам аажим нээгдэв. Зундаа хур бороо бага бууж шим мандал гавьтай дэлгэрсэнгүй. Гол усны сав газраар хэнзэлж ургасан бэлчээрийг даган айлууд хаяа хаяагаа дэрлэх шахам бууж хар зуднаас үлдсэн цөөн хэдэн

маландаа анхаарал тавина. Зуд зулагтай гэж амны билгээр хэлдэг. Нохойд зулгаалгах нь унаж ногоо зулгаах нь үлддэг гэдэг.

Гэтэл хар зуд хар мөртэй ажээ. Гол усаараа, айл сахалтаараа нутаг орон лус савдгаа аргадан уул овоогоо тахиж идээ будааныхаа дээжийг өргөж, бүсгүйчүүд нь өөдтэй өнгөтэйгөө өмсөж гоёод зүс зүсмийн өнгөтэй галбир хийц сайтай хүлэг морьдоо унаж лус савдгаа баясгаж байв. Сутай хайрханы өвөрт Усан зүйлийн голын эхний овоонд сүм хийдийн лам нар хурал хурж галын тахилга хийж галын ид шидээр Хайрхан уулаа, хатан булаг усаа, лус савдгаа ариутгах зан үйлийг хийж байв. Хурал ном ая дангаа барин намуухан дуугаар эгшиглэхэд Унзадын бүдүүн баргил хоолойгоор

Сод богдын цахисан

Сутай хатны үлдээсэн

Үүлэн нэвт униарт

Өтгөн илчит галаа

Тосон Танхил эх

Торгон зөөлөн нүүрт

Гал галын эзэндээ

Өөхөн тосыг өргөнөм гэж магтан дуулахад олон бүгдээрээ Хурай, хурай, хурай гэж хоолой нийлүүлэн түрлэг нэмж шуранхайлан байв.

Түлсэн их гал нь өөхөн тосны өглөгийг урт улаан хэлээрээ үмхэж авангуугаа улам хүч орж хөгжин дэлгэрч дүрс хөрөг үүсгэн ид шидийг үзүүлнэ. Лус савдаг, уул ус, хүн, мал амьтад бүгдээрээ л галын ид шидэнд ариусан сэтгэлийн цэнгэлийг эдлэв.

Яг энэ өдөр Манлай, Авирмэд гавж хоёр үүр шөнөөр мордож өглөөний нартай уралдан Бижийн аманд байх Баян Намсрай бурханы дуганд буув. Тэд Намсрай бурханаа тахиж дараа нь өндөр цагаан мөргөд байх Өвгөн овоог тахиад Авирмэд шавь нартаа захиа даалгавраа өгөөд Бижийн голоо өгсөн буцав. Тэр хоёр энэ голыг арван дөрвөн удаа гатлав. Хур бороо элбэгтэй ус ихтэй жил бол морьтой хүн ч энэ голыг өгсөж чаддаггүй хөдөө замаар тойрч явдаг билээ. Гэтэл энэ жил осолдохгүй л амь тасрахгүй уулын булгийн усаар тэжээгдэн байж жирэлзэн урсах нь өрөвдөлтэй санагдана. Голын хажуугийн энгэр газарт харгана, тэсэг, таана дөнгөж ургаж ядаж байхад голын хөвөөгөөр ширэг, дэрс, цахилдаг байнгын чийгтэй болохоор арай гайгүй ургасан байв.

Тэд Арцатын бэлчирт бууж олны мэндийг мэдэж орон нутгийн тухай ярилцаад цай уугаад цааш хөдлөв. Зун хэдийгээр зулаг муутай ган гачигтай байсан ч малын буян их болохоор айл бүр л айргаа бүлж, тогоогоо нэг хоёр нэрж жаахан нэрмэлийн охь хурааснаа харамлахгүй тэр хоёрт өгнө. Тамчийн бэлчирт ирэхэд байдал бага зэрэг өөрчлөгдөж айл бүр Алаг хайрханы

өвөр Улиастайн голын Арьяабалын бүтээлийн сүмийн эзэн Авирмэд гавжийг гэртээ оруулж сан тавиулж, хонх дамрын дуу сонсохыг хүсэх учир айл болгонд орох болов.

Авирмэд гавж айлын хүмүүсийн жилийг асууж, засал заллагыг нь хийж сүлд хийморийг нь тэгшитгэж байлаа. Харин Манлай өргөн барьсан идээ будааных нь дээж охь шимийг нь хүртэж нилээдгүй халамцаж авир ааш нь хөдөлж зарим айлаас архи нэхэн өгөхгүй байхгүй гэвэл харамч долоч, ядуу зүдүүгээр нь дуудан агсамнаж эхлэв. Энэ болгоныг чимээгүй харж суусан Авирмэд арга нь барагдаад

-Хөөе. Манлай минь. Наад авир ааш чинь хэтэрлээ. Архи чинь дэндэж байгаа бололтой. Харанхуй ч болчихлоо гэхэд ухаангүй байгаа бололтой

- Надтай хэн яриад байна гэхэд нь Авирмэд түүнийг ажиглангаа

- Би Авирмэд байна аа. Хоёулаа явья гэхэд Манлай нүдээ сөлийлгөн байж

- Чи энэ муусайн гуйлгачингуудтай нийлж намайг бас дээрэлхэх санаатай юу? Чи ер нь юутай байсан юм бэ? Алд дэлэм сургүй, атга хүрэх будаагүй, алгын чинээ хөдөсгүй, ам даавуугүй амьтан байсан биз дээ. Ганц мод гал болохгүй, ганц хүн айл болохгүй гэдгийг мэдэх үү? Чи чинь ганцхан л хүүтэй шүү дээ. Тэгэхэд би дөрвийн дөрвөн сайхан хүүтэй, нэг үзэсгэлэн гоо гүнжтэй шүү. Гарын таван хуруу шиг таван хүүхэдтэй, тал дүүргэх таван хошуу малтай амандаа тос, өөх, өрөм хүлхдэг, алд биендээ торго дурдам өмсдөг, унасан унаа морьд нь усан тэлмэн жороо байхад уулзаж учирсан хүн болгон надад бөхийдөг юм гэлээ. Авирмэд бүр ч тайван болоод айлын хүмүүст

- Энэ маань жаахан байж байгаад сэргэчихнэ. Тэгээд би аваад явна. Одоо архи зохихоо больж байгаа юм билээ гэж тайвшралыг өгнө. Үнэндээ Манлай суугаагаараа хэдэн хором унтаад сэрэхдээ оюун ухаан нь бүрэн сэргэсэн байлаа. Тэр их л санаа зовсон байдлаар

- Би гэдэг хүн ч энэ ундааг харахаараа угжны хурга шиг залгилсаар байгаад ухаан алддаг болчихлоо. Элдвийн есөн шидийн юм донгосоогүй байгаа даа гэж өршөөл эрэн зөөлөн асуухад Авирмэд гавж

- Тийм юм огт болоогүй ээ. Хэсэг ганцаараа ярьж байгаад л дугжраад өгнө билээ гэхэд Манлай Авирмэд рүүгээ гэмшингүй харав. Айлын хүмүүс ч энэ хоёрын андын нөхөрлөлийг гайхаж байв. Гавжийн амгалан тайван байдал ч үлгэр дуурайлал болов. Манлай аягаа барин айлын авгайгаас

- Ганц удаа хийчих. Одоо мордъё гэхэд бүсгүй Авирмэд гавж өөд яах вэ? гэсэн харцаар харахад Авирмэд толгойгоо дохин

- Хийгээд өг гэж хариу үйлдэв. Манлай нэг амьсгаагаар залгилаад

- Ээ дээ энэ идээ ч мөн ч сайхан шүү. Бурхан, буянтай хүн хоёр хүртэж байх ёстой юм гэнэ лээ шүү гээд уруул амаа долоох нь их л тааламжтай амтархан байгаа бололтойг харсан хүн бүр л дотроо

- Энэ хүн архинд их дуртай болж дээ. Ядахдаа зөв шингээчихвэл зүгээр юм даа. Их л баярхаж бардамнах болж дээ. Уг хүн нь сайн хүн шүү. Архи золиг ч сайн бүхнийг баллаж хаяна. Савнаасаа бусдыг дийлнэ гэдэг үнэн үг шүү гэж бодож байв. Манлайнх Алаг хайрханы ар Цахирын аманд зусаж байгаа. Харин Авирмэдийнх Цалуугийн хонхор ширгэнд байгаа. Тэднийг мордоход тэнгэрт одод жагссан байлаа. Манлай

- Авирмэд ээ. Танайхаар дайрч аяга архи уугаад би гэртээ хүрнэ гээд мориндоо ташуур өгөн ухасхийв. Хэсэг явсаны дараа Манлай амандаа хараал урсган

- Би хөөргөө айлд орхичихсон байна гээд өвөр түрүүгээ тэмтэрч үзээд

- Ээ золиг гэж. Авирмэдээ чи гэртээ очоод аяга тагш юм бэлдээд байж бай. Би ухасхийгээд хөөргөө аваад ирье гээд мориныхоо амыг эргүүлэн хондлойд нь ташуураа буулган

- Хүүе гэж үг солихын завдалгүй явж одов. Авирмэд гавж гайхасхийж байснаа аяархан гэлдрүүлж бодолдоо дарагдав.

- Хүүг минь Агваанням дэргэдээ авна гэсээр байгаад л аваад явсан. Тэр хоёр ах дүү шиг хүмүүс болохоор хамтдаа байдаг нь зөв байх. Чоймжуур бид хоёрын дэргэд байгаад байвал амьдрал ч мэдэхгүй залхуу нэгэн болж мэднэ. Харин олны дунд явах нь бага ч гэсэн ухаан суух биз. Ном эрдмийн тухайд л би анхаарвал болох нь тэр. Миний хүүгийн толгой ч хоосонгүй шүү. Чоймжуур нэг өдөр аавдаа хандаж

- Аав аа. Би явсаар байгаад хаана хүрэх юм бэ? гэж асуухад нь Авирмэд

- Миний хүү эрдмийн оройд нэг үгээр оюун ухааны оргилд хүрэх юм шүү. Чи чадна аа. Миний хүү хичээгээрэй гэхэд Чоймжуур аав руугаа хараад

- Би чадна. Аав аа. Харин Дэжиднямыг яах вэ? гэхэд Авирмэд дотроо

- Энэ хүүхдийг яана аа. Нялх юм байж бас бүсгүй хүүхдийг бодож явдаг байх нь. Хүний санаа гэж мөн аугаа юм шүү. Эр хүний дотор эмээл хазаартай морь багтана гэдэг л үнэн юм даа гэж бодоод

- Миний хүү чи өөрөө л мэдэх хэрэг шүү дээ. Аав нь яаж мэдэж чадах билээ гэхэд Чоймжуур инээд алдаад

- Тийм үү. Би таныг мэдэх байх гэж бодож байсан юм. Тэгвэл би өөрөө мэдэх юм бол амархан байна гэхэд нь Авирмэд инээмсэглээд

- Миний хүү юу нь амархан байна гэж? Чи одоохондоо ийм юм бодох болоогүй шүү гэхэд Чоймжуур

- Ээж намайг миний хүү нэг бодол санаа, зорилготой бай. Олон юм бодоод байвал оюун ухаан чинь цэгцэрч төвлөрч чаддаггүй юм. Хоёр туулай хөөсөн хүн хоосон хоцорно гэдгийг сайн санаж яв гэж сургасан билээ гэхэд Авирмэд

- Наад сургаал үг чинь үнэн. Аав нь чамд ганцхан зүйлийг л захиад байгаа шүү дээ. Эрдэм номын оргилд гарчих. Дараа нь бусад бодож байгаа юмаа амжуул гээд байна шүү дээ гэхэд Чоймжуур их хэрсүү байдлаар

- Аав аа. Би ойлголоо. Аав, ээж хоёрынхоо хэлсэн сургасан болгоныг санаж явна гээд холыг харж байв. Авирмэд гавж уртаар амьсгал аваад хүүгээ харж дотогшоогоо ийнхүү бясалгав.

- Хүмүүний амьдралыг урд өмнөөс төлөвлөх арга байхгүй. Бодит юм болгон хором бүрт хувирч өөрчлөгдөж байдаг болохоор тэр. Харин сэтгэл нь баригддаггүй, захирагддаггүй биеийг бардаг төгс хоосон чанар юм даа. Ихийг мөрөөднө гэдэг нь сэтгэлийн тэмүүлэл биеийг барахын нэг зовлон мөн. Энэ нь шунаж тачаангуйн эрхээр ханахгүйн зовлонд ямагт баригддаг гэдэг бол уур хилэнгийн эрхээр нүгэлт үйлийн мөр улам улам зузаарч сэтгэхүйн зовлон гүнзгийрдэг. Харин мунхагийн эрхээр зовлонгийн шалтгааныг ухаж үл чадан улмаар зовлонгоо бататгаж хадгалж байдаг. Энэ болгоноос ангижирч ариусах ганц арга бол гэгээрэлд хүрэх юм даа гэж бодов. Авирмэд энэ бүгдийг дурсан бодож явсаар гэрийнхээ гадаа хүрээд ирэв. Авирмэдийн ирэх чимээнээр боссон Үзмээ дэнгээ өргөөд

- Манлай ах ирээгүй юм уу? гэж асуухад Авирмэд тайвнаар

- Удахгүй ирнэ ээ. Цаад цагаан лонхонд чинь юм байгаа юу? Байхгүй бол жаахан юм хийгээд бэлдчихээрэй. Гэртээ харих юм яриад байна билээ. Манайд унтаад өглөө эрт явбал дээр биз дээ гэхэд Үзмээ дотроо

- Манлай ах бас л нөгөө нанчидаа хүртсэн байх нь. Хүний үгэнд ч ордоггүй хэцүү хүн дээ. Харин согтуу ч эрүүл ч миний үгнээс ер хазайдаггүй юм шүү гэж бодов.

Тэр хоёр ойр зуурын юм ярьж Манлай ахыгаа хүлээсээр байтал үүр цайж сүүн шаргал туяагаараа орчлон хорвоог гийгүүлэв. Хол ойрд нохой хуцаж үхэр тугал ганц нэгээр мөөрч өглөөний анир үргээнэ. Алсад адуу үүрсэх нь бүдэгхэн сонсогдоно. Авирмэд дотроо

- Манлай ах эргэж очоод нэмж архи уугаад тэндээ унтав уу? эсвэл гэр өөдөө шууд явчихав уу? гэж бодлоо салаална. Гэхдээ сэтгэлд нэгэн түгшүүр хургана. Авирмэд Үзмээг харан

- Би гол уруудаад Тамчийн бэлчир ороод ирье. Юухан байхав. Чи цайгаа хийгээд жаахан мах чаначих. Манлай махнаас өөр юм идэх биш дээ гээд гарч мориндоо мордоод цогиулав. Гэтэл өмнөөс нь бүгээн морьтой хүн яаруухан явсаар Авирмэдтэй золгов. Тэр хүний царай барайж нүдэнд нь айдас дүүрсэн байв. Тэр сандран

- Авирмэд гуай. Би таныг зорьж явна. Боомын доод хошууны хавьд Манлай гуай бурхан болчихсон байна гэхэд Авирмэд тэнгэрт нэргүүлэх мэт мориноосоо буух ч гэждээ бараг л унаад хэсэг манарснаа өндийгөөд

- Үнэн гэж үү? гээд сул дорой дуугаар лавлахад нөгөө хүн гайхашрангуйгаар

- Үнэн гэлээ. Гавж мориндоо мордонгуут ухаан жолоогүй давхив Тэднийг ирэхэд Манлайн цогцосны дэргэд энэ муу чимээг сонссон хэдэн хүн ирчихсэн байлаа. Манлай хоёр өвдгөөрөө

сөхөрч суугаад бага зэрэг тонгойсон хэвээрээ нас барсан байлаа. Морь нь чөдөртэй хантайргатай дэргэд нь байлаа. Мөрийг шинжвэл өөр хоёр ч морины мөр үлдсэн байлаа. Өөр ямар нэгэн шинж тэмдэг алга байв. Мөн л нэгэн морьтонг Цахир ам өөд илгээж эхнэр хүүхдэд нь хэл хүргэж аваад ирэхээр болов. Нэг морьтон Бүс хайрханы Суга булагт байгаа Зундуй маарамбыг залахаар мордов. Тэд зөвлөлдсөний эцэст хоёр хүн Усан зүйлийн хүрээний Хамба Агвааннямд хэл хүргэх үүрэг аваад мордов. Амьдралд ийм болзошгүй аюул байнга дагаж байдгийг сайн мэдэх Авирмэд дотроо халагласаар байлаа.

- Би хамт буцах минь яав аа гэж халаглан өөрийгөө буруутгаж байв. Зундуй маарамба маш сайн нягталж үзэв. Тэр олонд хандан

- Та бүхэн талийгаачийн байр байдал, ул мөрийг сайн тогтоож аваарай. Талийгаач маань уушигны архаг багтраа өвчтэй байсан. Надаас эм залж байнга хэрэглэдэг байв. Гэр бүлийнхэн нь сайн мэднэ. Тэр багтраа өвчин нь сэдэрч амьсгал түгжрэх шалтгаанаас болж насан өөд болжээ гэв. Их уйлаан хайлаан болж байсан ч хүн бүр л талийгаачийг сайн төрөлд очих болтугай гэж сэтгэлдээ залбирч байлаа.

Хорин хоёр

Балбар өвгөн уртаар санаа алдаад амандаа

-Энэ хорвоогийн амьдрал ч тааж мэдэхийн аргагүй малын муу сархинаг шиг олон нугачаа хуниастай болохоор учир нь олдохгүй нууцлаг ертөнц юм даа. Хөөрхий муу Манлай харамсалтайгаар өөд болж дээ. Бас тэгээд хээр гадаа газар шүү. Ядахдаа гэр орондоо бол яахав гэхсэн гэж үглээд Авирмэд гавжийн үлгэр домог шиг түүхийн утсыг хөвж байснаа Манлайг насан өөд болоход ихэд хямарч энэ удаа ийнхүү түр завсарлахад хүрсэн нь энэ билээ.

Хөлтэй нүдтэй залуу болгон нь хадланд явсан болохоор өвгөн Балбар мэтийн хөлгүй, нүдгүй, нялх хүүхэдтэй голдуу мал ахуйгаа харж хандах хариулах зэрэг бас бус ажлыг амжуулахаар цөөн хэдэн хүн үлдсэн байв.

Сум хадлангаа Гаханч, Нохончийн гол, Алаг нуур, Уртын гол, Бижийн гол, Тамга гашууны ус зэрэг газруудад гар хадуур шимээсгээр хадаж бэлтгэнэ. Хадланд явах нь намрын нэгэн баяр цэнгэл болно. Баг багаараа цугларч ажил хөдөлмөрт шамдахаас гадна бие сэтгэлээрээ нэгдэн нутаг орон болоод өвөг дээдэс, түүх дурсгал, үлгэр домог сонсож ихийг мэднэ. Мөн наадаж наргин насны гайхамшигтай дурсамжийг үлдээнэ. Нэг газар нь эмэгтэйчүүдээ барилдуулж үзүүр түрүүг нь хонины өвчүү толгойгоор шагнаж байхад нөгөө голд нь хөл муутай хоёр нөхрөө уралдуулан уран жороог нь түрүүлүүлж урамшуулан хөгжилдөж байгаа бол өөр нэг газарт нь уран цэцэн үгээр уралдан

Хэлэлцвэл ч хэлэлцье, хэлэх үгээ бодоорой,

Дайралцвал ч дайралцъя даалин хөөргөө тавиарай гээд л цээжнийхээ хэрээр, оюуныхаа билгээр цэцлэн бусдыгаа хөгжөөнө. Хүмүүсээ хоёр хуваагаад нэг нэг цэцлэх хүнээ гарган бусад нь хөгжөөн дэмжигч болон хөгжилдөнө. Гэтэл ямаачин Цагаан нэг багаас гарч иртэл нөгөө багийнхан бүр сандарч байснаа сумын төвийн суурин ганзага Суманхүүг

-Одоо та л гарахгүй бол манай баг балрах нь байна гэхэд Суманхүү инээмсэглээд

- Цаад Цагаан золигт чинь би тавиад туучихна. Би чадахгүй гэж цааргалахад багийнхан түүнийг хүчээр тал талаас нь өргөөд гаргав. Цагаан Суманхүү хоёр дотноор бие биеээ харан инээмсэглэнэ. Багууд нэг нь Суман Суман гэж орилолдоход нөгөө нь Цагаан, Цагаан гэж уухайлна. Цагаан бэлэн цэцэн хүн болохоороо эхлээд

Өст хүнтэй

Өлийн хөтөл дээр гэдэг дээ

Өргүүлж мөргүүлээд

Өнгөтэй байх шив дээ

Сумын төвийн

Суурин ганзага

Суудлын ноён

Суманхүү чинь гэж цэцлэхэд

Суманхүү одоо дүүрсэн хэрэг гэж бодсон бололтой хоолойгоо засаж инээд алдаад

Яхир цагаан ямаанаас

Ямар ишиг төрөв цэхэр л биз

Ямаачин Цагааны амнаас

Ямар юм гарав шүлс л биз

Хэдэн хар ямаа нь

Хэрэн гүйгээд одлоо

Хялман цагаан залуу

Халтирч унаад хоцров оо гээд дууны үгийг гуйвуулан байж цэцлээд байдгаараа инээхэд багйинхан нь алга нижигнүүлэн байв. Ямаачин Цагаан ч инээд алдахад үүдэн хоёр том шүд гарч нүд нь зураас болчихсон байв. Тэр

Ямааны сүү шимтэй шүү

Ядаргаа сульдаанд сайн шүү

Хөшсөн биед чинь хэрэгтэй шүү

Хөөрүүлж уугаарай Суман минь гэхэд

Суманхүү алгаа ташиж баярлаад

Баярлалаа, баярлалаа

Бас дахин авчраарай

Владимар Ильич Ленин

Бас Суманхүү гэж хошигнон дуулахад

Цагаан шууд залган

Ууж идэхдээ

Уургын морь шиг

Унтаж хэвтэхдээ

Усны үхэр шиг

Ийм хүнийг багшаа болгочихвол

Эх орон минь яана аа гэж цэцлэхэд олон нийтээрээ хөгжилдөн хөөрөлдөж байлаа. Суманхүү мөчөөгөө өгөх шинжгүй алга ташингаа

Бүгээн цагаан нэртэй

Борлог цоохор морьтой

Сүжийн ямаачин чинь

Сүртэй байх нь юу вэ?

Нүдийг нь харвал

Гахай шиг байв

Шүдийг нь үзвэл

Тарвага шиг байв

Гандуу бор дээлтэй юм

Гүү унаж гангарсан юм

Янгиа эмээл тохчихоод

Ямбатан дээдэс шиг байх нь юу вэ? гэж бага зэрэг дайруулан довтлон цэцлэхэд Цагаан огт тоосон шинжгүй инээмсэглээд Суманхүү рүү хоёр гараа дэлгээд

Баруун чих нь

Боовон юм байна

Бодвол хөлдөөсөн биз

Баруун хацар нь

Батгатай юм байна

Баахан их тамхилаа биз

Баруун хөл нь

Майга юм байна

Багадаа цадаагүйнх биз

Бакал гутал нь

Задархай юм байна

Бадарчилж явсных биз

Зээ хө зүүн талыг мялаая гэхэд багууд чив чимээгүй болж зөвхөн батгана нисэх чимээ дүнгэнэж байлаа, Цагаан цааш нь

Зүүн чих нь

Хулгар юм байна

Хуудуу буруугийн санамж биз

Зүүн хацар нь

Сорвитой юм байна

Зүггүйтэж яваад маажуулаа биз

Зүүн ташаа нь

Өндөр юм байна

Жороо сайврын шинж биз гэхэд сонссон бүхэн Суманхүүг шинжин

Цагааны хэлсэн бүхэн тохирч байгаад гайхаж байв. Гэтэл Суманхүү дотроо

-Энэ Цагаан цааш нь юу ч гэж дайрч дарамталж, цэцэлж мэднэ гэж санаад хоёр гараа дээш өргөн амаа ангайн хэлээ гаргаад

-Цагаан аа далан таваар бууж өглөө. Одоо цааш нь цэцлэх хэрэггүй гээд инээд алдан алгаа ташив. Тоглоом нь тоглоом, наргиа нь наргиа л болохоор хүний үерхэл нөхөрлөл хүн чанарын дуурайлал мөн байлаа. Сонссон бүхэн баясаж бас цэцэлсэн үгийг нь батлах гэж Цагаан, Суманхүү хоёрыг далдуур ажиглан байв.

Цагаан борлог гүү унаж ирсэн нь үнэн бол инээхээрээ үүдэн хоёр шүд нь тарваганых шиг болоод нүд нь онийгоод зураас болох нь яг л гахайны нүд мөн байлаа.

Харин Суманхүүгийн бүх юм нь тохирч байснаас гадна өмссөн бакал гутал нь ар түрийгээрээ оёдол нь задарсан, зүүн хөлөө чангалахад баруун хөл нь суунги доголлон болохоор бага зэрэг өргөгдөн өлмийгөөрөө дөмнөн зогсох нь зүүн ташааг нь өндөр юм шиг харагдуулж байв. Энэ голын хадланчидын наргиа цэнгэл үүгээр өндөрлөсөнгүй найраг шүлгийн ая эгшиглэнгээр үргэлжлэв. Хөөрч баяссан олон түмэн найраг шүлгийн аялгууг шимтэн сонсоно. Амархүү соёлтой нь аргагүй толгойгоо бөхийлгөн олныг хүндэтгээд

Хөшөөтийн гол

Хөшөөтийн голын минь

Хөх усны эгшилэн

Миний зүрх рүү урсана

Би намуухан дуулна

Хүлэг морьдын чимээтэй

Шүлгэн салхины шивнээ

Миний сэтгэл рүү лимбэднэ

Би яруухан уянгална

Хөөмий аялгуунд бичээстэй

Хөшөө чулууны домог

Миний бие рүү шингэнэ

Би хөглөгдөн шуранхайлна гэж аялгуулан уншихад бүгдээрээ нэгийг бодолхийлж бас баярлан байлаа. Дараа нь Минжин бүсгүйг урьж залав. Бумаагийн Минжин охиныг бүгд сайн танина. Арван жил дараалан онц сурсан нэгэн. Түүний толгой эрдэм номын их сан л гэсэн үг. Минжин бага зэрэг ичингүйрч байгаад

Бүсгүй заяа

Үүлэн хээтэй номин чимэгтэй

Үндэс сүлжээтэй цэцгэн гоёлтой

Үүдтэй орчлонгийн багахан чөлөөнөө

Үртэй хүн бүтэн жаргадаг

Үүрэн өлгийтэй өндгөн дээр

Элээний сүүдэр битгий тусаасай

Үрээ гэсэн эхийн сэтгэл

Өнө мөнхөд ариун байгаасай

Эцгийн зөөлөн харцанд ухаажиж

Эхийн дулаан хайранд бүлээцэж

Бүүвэйн эгшиг аялгуунд уужирдаг

Бүсгүй заяа бүтэн төрдөг гэж шүлгээ дуудаад мэхийн ёсолсонд бүгдээрээ баяр хүргэж алгаа
нижигнүүлэн ташиж байхад Хөнхий ганцаараа

-Хүүе, хүүе гэж орилж байгаа нь бусдаас сонин содон бас хачин гажигтай харагдаж байв.
Зарим нэг нь

- Энэ Минжин Бумаагаас төрсөн нь үнэн. Харин эцэг нь хэн юм болоо. Бумаа бол царай зүс,
ааль аашаараа онцгой төрсөн бүсгүй. Нэг л муу явдлаас болоод ганцаараа хорвоог туулахаар
шийдсэн юм гэнэ лээ. Тэр муухай золиг л энэ Минжингийн эцэг болж таарах гээд байгаа юм
гэж бодож сууна. Дараагийн шүлгээ дуудах хүнээр нөгөө хашгирч орилоод хачин сонин юм
үзүүлээд байсан Хөнхий тодров. Тэр

Аав ээж хоёр минь

Хат ханасан ухаандаа амьдралыг бясалгасан

Хатуу зөөлөн хоёрыг сэтгэлдээ тэгшилсэн

Алдаа оноогоо эвхэж нуруундаа үүрсэн

Аав таныхаа аугаа их ухааныг дээдэлье

Бүлээн шунхаа бүтэн биедээ буцалгасан

Бүгээн сүүгээ энгэр мөөмөндөө хурайлсан

Бүүвэйн дууг долоон эгшигэнд аялгуулсан

Ээжий таныхаа энэрэхүйн их сэтгэлийг дээдэлье

Аав минь. Та хүүгээ нэг болгоо

Амин аргамжийг тань бөхөлж л явна би

Ээж минь. Та хүүгээ нэг сонсоо

Эгшигэн бүүвэйг тань аялж л явна би хэмээн уянгалуулахад хүмүүс түүнийг

-Ухаантай хүү хэмээн магтан хэлэцэж байлаа. Балсангийн том хүү бас хоосонгүй бололтой гэгцгээгээд дараа дараагийн шүлэг найргийг чих тавин чимээ аниргүй ихэд анхааран шимтэн сонсоно. Нэгийн даваанд есөн хүн шүлгээ дуудсан бол хоёрын даваанд дөрвөн хүн шөвгөрч үлдсэнээс Амархүү манлайлав. Тэр энэ даваанд Алаг хайрхан шлүгээрээ манлайлсан юм.

Алаг хайрхан

Алаг хайрхан уулын минь

Атираат бэлийн зөөлөн хөрсөнд

Аавын хүү ээжийн охин

Аяа уйлж дуулж мэндлэхэд

Асар дээд оргилд нь

Цас мөсөн хайлж уярдаг юм

Асга хадан сүмд нь

Вансэмбэрүү баясаж инээмсэглэдэг юм

Найраг шүлгэн чимээтэй салхи нь

Нар зөв эргэж бүжиглэдэг юм

Хөх сувдан чимэгтэй ус нь

Хөг эгшгээр бүүвэй аялгуулдаг юм

Өндөр хайрхан уул нурууд нь

Өмөлзөж ирээд мөрийг минь түшдэг юм

Үндэс шивээлсэн говь талууд нь

Өндийж босоод өлмийг минь тулдаг юм гэж нутгийнхаа шүтээн уулыг магтан дуулсан нь хүн бүрийн сэтгэлийг ихэд хөдөлгөв. Зарим нэг нь дотроо

-Бид чинь энэ хайрхан уулаа тойроод л торгон бэлд нь төрсөн юм байна шүү дээ. Бугат суманд төрсөн хэн боловч энэ хайрханыхаа бэлд төрж уул нуруудаа түшиж говь талуудаа тулж цэвэр агаараар нь амьсгалж, цэнгэг усыг нь залгилж өссөн шүү дээ гэж бодож байхад зарим нь

- Манай нутгаас эрдэмтэн мэргэд, их зохиолч, алдартан гавьяатнууд төрөн гарч мал сүрэг нь

өсөн үржиж байх юм гэнэ лээ гэж судар бичигт байдаг гэсэн. Нууц нь чухам хаанаа байна. Уул ус ургамал цэцгэндээ байна уу? аль эсвэл ямар нэгэн ид шидэнд байна уу? гэж сэтгэлдээ эрж хайж сууна. Харин хадлангийн явц байр байдлыг шалган дүгнэж яваа сумын төлөөлөгч Ширмэн өөрийг бодож суув. Тэр

- Хадлан ч яахав. Ингээд найр наадам шиг наадаж баясаж байгаад олны хүч оломгүй далай гэдэг шиг болж бүтдэг ажил. Нөгөө Бунханы салааны аманд байх Бунхан шарилыг сэргээгээд байгаа хүнийг мэдэж байгаа нэгэн эдэн дотор байж л таарна. Энэ Амархүү нөхөр ам алдчих вий дээ гэж бодоод олон бужигнан анхаарал нь сарнисан байхыг ашиглаад Амархүүд

- Хүү минь чи чимээгүй байдаг юм шүү. Улс төрийн нууцыг алдвал хатуу шийтгэл хүлээдэг гэдгийг мартав аа гэж анхааруулаад тэрээр чанга дуугаар

- Хадланчид аа. Та бүхэн чимээгээ аядаад миний үгийг сонс гэж хэлээд хоолойгоо засаж бага зэргээр шахасхийгээд

-Та бүхний баяр цэнгэлийн чинь дундуур би товчхон мэдээлэл хийх гэсэн юмаа. Би бүх хадлан хийж байгаа газруудаар яваад ирлээ. Хадлангийн явц сайн байна. Бараг далан хувийг нь хадаж амжсан байна. Та нар ч гэсэн сайн ажиллажээ. Та бүхнийг нам захиргааны өмнөөс сайшааж байна. Багийн дарга Санж сайн зохион байгуулжээ. Та бүхэн ажлынхаа чөлөөт цагаар тэмцээн наадам хийж байгаа чинь их таалагдлаа. Билэг цэцэн хүмүүс байхад шүлэг найраг бичдэг олон залуус байгаа нь бахархмаар. Би та бүхэнд нэг үлгэр ярья гэхэд түүний энэ үгийг сонссон зарим нь

- Энэ хүн чинь өнөөдөр юу болчихоо вэ? Их л намч зарчимч хүн юмсан. Юун тухай үлгэр болохыг нь сонсьё гэж бодож байв. Сумын төлөөлөгч Ширмэн

- Манай нутагт эрдэмтэн мэргэд олон төрж мал сүрэг өсөөд байгаагийн нууц нь Бунхан салааны аманд байх Бунхан шарилтай холбоотой байж мэдэх юм. Тэр дор хүний шарил биш оюун ухаан, эрдэм номын асар их эрчим хүч хуран цугларсан нэгэн ид шидтэй алтан бумба байгаа гэнэ. Түүнийг ойрын жилүүдэд сэргээгээд засаж янзлаад байгаа. Тэр буянтай хүнийг та нар мэдэж байвал нэрийг нь хэлж магтаж сайшаавал сайн юмсан гэлээ. Хүмүүсийн нэг нь ч дуугарсангүй ус балгасан аятай дүмбийнэ. Түрүүний ямар үлгэр юм бол доо гэж бодож байсан хүн хоёр янзаар ойлгов.

-Биднийг хууран мэхэлж байгаад үг алдуулахыг хичээж байгааг бодоход муу санаа нь бүр л муухай болж байгаа юм байна. Нөгөөтэйгүүр үгнээс үг олох гэсэн матаас нь бүр магтаал болчихлоо. Харин ч өөрөө матуулахаар намынхаа эсрэг хуучинсаг үзэл суртлыг магтчихлаа шүү дээ гэж бодов. Төлөөлөгч Ширмэн хүн бүр дээр харцаа тогтоож горьдлого найдвар тавьж байлаа. Гэтэл яхир Балдан тамхиа татах зуураа

- Төлөөлөгч өө. Танд их баярлалаа. Урд өмнө огт сонсож байгаагүй үлгэр сонслоо. Бид чинь тэр Бунхан шарилаас чинь айж эмээгээд холуур тойрч явдаг юм шүү дээ. Тэгвэл тэр чинь ид шидтэй бидэндээ ач буянаа хайрлаж байдаг алтан бумба байдаг байх нь. ёстой хэрэгтэй юмаа олж сонслоо гэв. Ширмэн төлөөлөгч гайхширан эргэн тойрноо ажиглаж байснаа дотроо

- Би сая юу ярьчихав аа. Намын гишүүн хүн байж элдвийн харш зүйлийг магтан яриад буруудлаа шүү дээ. Би намынхаа өмнө алдаа гаргалаа. Үнэн шударгаар буруугаа хүлээнэ ээ гэж бодож суув. Багийн дарга Санж

- За өөр яриа хөөрөө байхгүй бол бидэнд сайхан мэдээлэл өгсөн төлөөлөгчдөө баяр хүргэе гэхэд Ширмэн дотроо

- Юуны чинь баяр хүргэх. Нам төрийнхөө өмнө алдаа гаргачихаад байхад. Энэ Санж нөхөр намайг яаж тохуурхаж байгаа нь энэ вэ. Сагадын талын хүн байж мэдэх юм. Би нам төрийн эсэргүү нартай тэмцэх л болно гэж омогшоод

- Та бүхэн тэмцээн уралдаанаа үргэжлүүл гэлээ. Одоо дайралцаа хийж цэцлэх тэмцээнд ялсан ямаачин Цагаан, шүлэг найргийн тэмцээнд шөвгөрсөн Амархүү нарыг хуйхалж шарсан өвчүү, хонины сүүлний үзүүр, толгой тэргүүтнээр шагнаж урамшуулах ёстой байв. Хадланчид Амархүүг дахиад нэг шүлэг дуудаж өгөхийг хүсэв. Амархүү

Омогшил

Би

Засагт хааны хөх харчуулын нэгэн үр сад билээ

Замилгаат Алтайн өндөр уулсын нэгэн цохио билээ

Ариун хурын асгарах сувдны нэгэн дусал билээ

Аглаг говийн алтан элсний нэгэн ширхэг билээ

Би

Хөшөөтийн голын хөрсөнд саамшсан

Хөхүүл усыг хөхөж залгилсан

Хөшөө чулууг түшиж өндийсөн

Хөх толбоны үргэлжлэл билээ

Би

Хөл нэгтэй гурван уулын

Хөг лимбэн салхинд хатаагдсан

Хүн чулууны энгэрт зурагдсан

Хөх чонын удам билээ гэж омогшин дуулахад сонсож суусан бүхэн оюун билгийн хүч

тамирыг авч сэтгэлдээ омогшиж байв. Гэтэл ямаачин Цагаан босоод

Уншсан бүх найрагчдын маань

Ухаан билэг нь хурц байх болтугай

Сонссон бид бүхний маань

Сонор мялаагдаж сэтгэл ариусах болтугай. Хурай, хурай гэж хурайлж байхад хоёр хүн томилогдон шагналын өвчүү, толгой сүүлний можгорыг гучин зургаан тэнцүү хэсэгт хувааж бүх хүндээ хүргэхээр зэхсэн байлаа. Энэ эв нэгдлийн баяр байлаа.

Хорин гурав

Амархүү хадлангаас ирээд л Нарангаравтай тавьсан болзоондоо бэлдэв. Тэр өвөөгийндөө очоод хадланд явсан тухайгаа ярьж өгөхөд Балбар ихэд баярлан

-Миний муу ач хүү л надад нутаг нугын сонин хачин дуулгах юм даа хэмээн баярлахад Амархүү

-Өвөө таньд бүр сонин юм дуулгах гээд байна шүү дээ. Нөгөө Бунхан салааны Бунхан шарил дээр таны надад ярьсан үлгэрийг сумын төлөөлөгч бидэнд ярьсан гэхэд Балбар өвгөн гайхсан царай гаргаад

-Тэр хүн чинь яаж байгаа нь тэр вэ? Сэргээж зассан хүнийг нь олохоосоо өмнө өөрөө төмөр хаалганы цаана суух нь дээ. Уг нь их л хашир хүн дээ. Та нарыг гэнэдүүлэх гэж байгаад өөрөө гэнэ алдсан байна. Мэхт мэхэндээ унана гэдэг л болж дээ. Гэхдээ чоно үүрэндээ өлзийтэй гэдэг юм. Гайгүй байх аа гэснээ

- Амархүү минь. өвөөгийнхөө ховлогоны чулууг аваад аль. Би нэг таслаад орхиё. Нутгийн хүүхэд элдэв юманд орооцолдчихвол ямар сайн байхав гээд ховлогоныхоо чулууг түвэггүй тасласнаа Амархүүг тогтоож сайн хараагүй байтал ганцхан хумьж алгандаа бөөгнүүлээд

-Гайгүй л юм байна гэв. Амархүү дотроо

- Өвөө сохор биш нүдтэй болох нь үнэн юм байна гэж бодоод

-Өвөө би нөгөөдөр нэг юманд явна. Та үзээд чулуугаа таслаад өгөөч гэхэд Балбар өвгөн чулуугаа хоёр гарын алганд хурааж зайлаад амандаа ямар нэгэн юм шившиж шивнээд нэг үлээгээд таслав. Тэр эхний гурван хэсгээс эхлэн гурав тасалж мөн есөн хэсэгт байршуулаад мөн л дор нь хурааж хумиад авчихав. Амархүү мөн л гайхан ямар түргэн хураадаг юм гэж бодоод

-Өвөө минь. Ажил хэрэг бүтэх нь үү? гэж асуухад тэр огтхон ч жишимгүй

- Бүтнээ, бүтнэ. Чи тэр цэцгэнд гар хүрч болохгүй шүү. Хэрвээ гар хүрч таслах юм бол баяр баясгалан чинь үгүй болох юм байна. Мэдээтэй л байгаарай гэв. Амархүү дотроо

-Өвөө миний Вансэмбэрүү цэцэг үзэх гэж байгааг яаж мэдэв ээ? Нарангарав бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй шүү дээ. Ямар хачин юм бэ? гэж бодонгоо нэгэн хайрмал гамбир дээр өрөм тавиад өвөөдөө хандан

-Өвөө май. Өрөмтэй гамбир ид гээд өгөхөд тэр тосож авав. Сайн хартал өрмөн дээр нь нэгэн хялгас сүүдийж харагдав. Амархүү сандран

- Өвөө гэх зуурт нөгөө хялгасыг хуруугаараа чимхэж аваад хаяж орхив. Амархүү

-Өвөө та тэр хялгасыг үзсэн юм уу? гэхэд Балбар

- Юугаа үздэг юм бэ? сохор хүний чинь нүд хуруундаа шилжээд орчихдог юм шүү дээ. Чи чинь өвөөгөө нүдээрээ хардаг юм байна гэж бодоод байгаа юм биш биз дээ гээд ёжтойхон инээмсэглэв. Амархүү ч өвөөгөө дагаад ёжтойгоор инээгээд

- Яалаа гэж дээ өвөө минь. Нүдтэй бол сайхан л байна. Ядахдаа ач хүүгээ хараад зүгээр байхгүй юу. Харахгүй болохоор тиймхэн л юм даа гэхэд Балбар өвгөн чимээгүй дүнсийгээд

- Энэ хүүхэд намайг нүдтэй сохор биш гэж ажиглаад байгаа байх нь. Нэг бол миний цоо эрүүл нүдтэйг мэдчихээд сая тэр өрмөн дээр зориуд хялгас гозойлгоод надад өгсөн байж магадгүй юм гэж санаад аягатай цайгаа авах гэж гараа явуулан зориуд татаад асгаж орхив. Гэтэл Амархүү

- Өвөө та чинь яагаад байгаа юм бэ? цайгаа татаж асгаад байхдаа яадаг юм бэ? Нөгөө нүд минь гар хуруундаа орчихсон гэсэн чинь яалаа гэхэд Балбар өвөө

- Миний энэ муу золигийн нүд шилжээд байдаг болчихлоо. Үхэх дөхөж байгаа юм байлгүй дээ. Амархүү миний хүү сонс. Өвөөгөө хүмүүсийн доог тохуу болгох гээгүй юм бол ам хэлээ хямгадаж яваарай. Нэг нэр, нэг хочтойгоор нүд анимаар байна. Чи чинь их сургууль дүүргэх гэж байгаа нас биед хүрсэн эрдэм номтой том эр хүн шүү дээ гээд гэрийнхээ тооно өөд өлийн харав. Амархүү ч өвөөгийнхөө саяын хэлсэн болгоныг ухааж ойлгоод

-Өвөө би таныг сайн ойлгож мэдэж байгаа. Та надад итгээрэй. Таны олон жилийн итгэл үнэмшил болсон тэсвэр хатуужил, их ухааныг чинь хэзээ ч хөндөхгүй билээ. Би чинь таны ач хүү чинь шүү дээ гэхэд Балбар дотроо

- Үгүй ээ. Энэ хүүхдийн хэлж байгааг нь. Овоо доо ухаан сууж юмны учрыг ухааж ойлгож, ялгаж салгаж сурч л байгаа юм байна. Би хүүдээ итгэлгүй яахав гэж бодоод нүдээ аргадав.

Энэ сохор өвгөн төмөр биетэй, чулуун зүрхтэй хүн шиг ямар ч үед сохор нүднээсээ дусал нулимс гаргаж үзээгүй хатуухан зоригтой хүн билээ. Харин өнөөдөр л дөчин дөрвөн жилийн тэсвэр тэвчээр, зориг зүрх мөхөсдөж хадгалж явсан зовлон жаргал нь сад тавьж хайлан урсаж ганцхан ач хүүгээрээ өрөвдүүлж суугаа буурал өвгөн өндөр настан билээ.

Амархүү ч өвөөгийнхөө өмнө сөхөрч суугаад өмнө нь өвөөдөө зориулж бичиж байсан нэгэн шүлэгнийхээ хоёр мөрийг чангаар уншиж гурвантаа мөргөв. Тэрвээр

Түүх шастир бичээстэй

Түмэн хуйлаастай ном дор мөргөмүү хэмээхэд Балбар өвгөн тэргүүнээ дээш өргөн ач хүүгийнхээ утга гүн гүнзгий мөртлөө ихэд хүндэтгэн дээдэлж оюун ухааны дээд билэг чанарт адислаж өөрөө бүхнийг мэдэхийг хүсэж мөрөөдөж буйгаа бүрэн илэрхийлж чадсанд нь омогшин зовлон жаргалаа хумхиж хураагаад зүрх зоригоо чангалан байж

-Миний хүү өвөөдөө ир гэж уриад духан дээр нь үнсэж үнэрлэнгээ хүү минь эрдэм номондоо хичээнгүйлэн суралцаарай. Бас өвөөгөө уншаарай гэж хэлэв. Амархүү ч толгой дохин өвөөгийнхөө хэлсэн үгийг баяртайгаар хүлээн авлаа.

Балбар өвгөн ач хүүтэйгээ бие сэтгэлээрээ нэгдэж бие биенээ сайн ойлгож авч чадсандаа баярлаж байв. Өтөл насанд өөрийг нь ойлгож түшиж тулах сайн нөхөртэй болсондоо тэр билээ. Балбар өвгөн байн байн Амархүүгийн хэлсэн үгийг бодно. Тэр намайг түүх шастир бичээстэй түмэн хуйлаастай ном гэсэн шүү. Цаад санаа нь надаас л их юм олж сонсож мэдэх гээд байгаа хүн шүү дээ. Бас тэгээд хөөрхөн магтаад авч байгаа юм шүү. Харин манай энэ хүү ам бөхтэй юм шиг байгаа юм. Одоо ч том болж дээ гэж бодож суухад Амархүү дотроо

- Миний өвөө чинь аугаа хүн байхгүй юу. Их юм мэднэ. Тэр ховлогоор бол яг л хэлнэ шүү дээ. Цэцгийг битгий тасал гэж хэлэв үү? Хорин нэгэн чулууг мөн ч сайн уншиж байгаа хэрэг шүү. Тэгээд ч дөч гаруй жил сохор хүн болж жүжиглэнэ гэдэг амаргүй ажил шүү. Хүү нь хүртэл мэдэхгүй байгааг бодоход мөн л их тэсвэр тэвчээр ухаан зараа байх даа. Өвөө өмнө нь надад үүнийгээ мэдэгдэж хэлэх гээд зугуухан намайг гайхшируулаад байсан байх даа. Хөөрхий минь хэлж байгаа нь ч мөн л айхтар битүү утгаар шүү.

- Өвөөгөө хүмүүсийн доог тохуу болгох гээгүй бол ам хэлээ хямгадаж яваарай гэсэн шүү. Миний өвөө үнэхээр ухаантай хүн. Өвөөгөөсөө би олон арван нууцыг мэдэх болно гэж бодов. Амархүү хоног тоолон хүлээж байсан нэг зүйл бол Вансэмбэрүү цэцгийн болзоо билээ. Тэр Нарангаравтайгаа уулзах болзоогоо ийнхүү нэрлэсэн юм.

Их бага Барзан хайрханы дунд биед ирэхэд бага үд болж байлаа. Тэр эргэн тойрноо сонирхон ажиглаж байв. Алаг хайрхан уулын зоо нуруун дээр шахам хад чулууг хэргээр овоолсон мэт их, бага хоёр хайрхан тогтсон нь сонин санагдана. Гэтэл энэ зоо нуруу дээр ямар ч чулуугүй, тэгш цайдамд цэцэг ногоо алаглана. Хэн нэгэн энэ зоо нурууны хад чулууг цэвэрлэн хоёр хэсэг болгон овоолсон юм уу даа гэх сэтгэгдэл төрнө. Асга хадан дундаас хулгар шар тарвага өөрөө үзэгдэхгүй ч гэсэн чанга дуугаар хошгирно. Дуу нь чангарсныг бодоход үс нь гүйцсэн бололтой. Тэд бие биеийнхээ дуу чимээг аваад эргэн тойронд хошгирах нь элэглэж байгаа мэт инээдэмтэй санагдана. Буу шийдэмгүй явааг нь басаж байгаа аятай том хадан дээр балбагнан гарч ирээд сонирхон байж эргэн тойрноо харснаа Амархүүг үзэнгүүтээ хойд хөл дээрээ босоод хошгирч гайхуулан тас хар болсон сүүлээ годогнуулах нь

Өөхөн тарга авсан даа

Үс арьс гүйцсэн дээ

Нарангараваа хүлээгээд уйдав уу даа

Надтай наадаж тоглоо ч дээ гэх шиг эгдүү хүргэмээр элдэвлэн энд тэнд хошгирно. Сэржмядаг /Алтанцэцэг/ цэцэг том тод шар дэлбээгээ дэлгэн өндөр туяхан ишэн дээрээ хярын сэржигнүүр салхитай наадан бүжиглэх мэт найган ганхана. Харин хэсэг бүлгээрээ ургасан Жамъянмядаг /Зөөлөн эгшигт/ цэцэг улбар өнгөтэй олон давхар дэлбээгээрээ гайхуулан наранд эрхлэх мэт намуун тогтуунаар налайна. Бидний магтаж гайхуулаад байдаг сарнай цэцэг саруулхан өрөө тасалгааны цонхон дээр ургадаг бол Жамъянмядаг цэцэг Алаг хайрхан уулын аглаг өндөр зоо нуруун дээр ургадаг зэрлэг сарнай цэцэг мөн байв.

Тасалгааны сарнай нь зөвхөн сэтгэлийн цэнгэлийг өгдөг бол хээрийн зэрлэг сарнай нь /Жамъянмядаг/ хүний бие, хэл, сэтгэл гурвыг тэгшлэх бас анагаах эрдэм чадалтай байлаа. Тэр

дээшээгээ хөх тэнгэр лүү харахад маш өндөрт ганц бараан шувуу жигүүрээ дэлгэн аажимхан аялана. Цаана нь хязгааргүй алсран харагдах гүн хөх өнгийг харсаар байтал нүх мэт санагдлаа.

Гэтэл морь толгойгоо хаялж хазаарын чимээ өгөөд хангинатал үүрсэв. Амархүү Нарангаравынхаа барааг олж хараад ихэд баясав. Яагаад гэвэл Вансэмбэрүү цэцгийн болзоо түүний амьдралыг шийдэх юм шиг санагдаж байсан учир тэрээр ийнхүү чухалчилсан ажээ. Хоёр залуу зэрэгцэн уулын хяр өөд аажимхан явна. Хааяа хааяа өвдөг шүргэлцэж дөрөө хавирахад нэгэн өөриймсөг хөг аялгуу эгшиглэнэ. Төмөр дөрөөний хавиралдах чимээ энгийн үед хатуу төмрийн дуу л сонсогддог. Харин хайр дурлалдаа шатаж яваа хосуудад бол зөөлөн эгшиглэн мэт зөв аялгуу болж сонсогддог бололтой.

Хайрханы орой өөд ойртох тусмаа мөнх цас мөсөн ойртож агаар сэрүүсч хүйтэн мэдрэгдэнэ. Бидний сайн мэдэх тагтаа шувуунаас арай багавтар маш хурдан нисдэг боровтор хөх өнгөтэй шувуу мөнх цасыг мөргөөд л үзэгдэхээ болино. Гэтэл гэнэт цаснаас гараад шалмагхан нисэж одно. Энэ шувууг Ахуун гэж нэрлэдэг. Зөвхөн Алаг хайрхан уулын оройн мөнх цасанд амьдардаг ургамлын үндсээр хооллодог ялангуяа бамбайн үндсийг ихээр зооглодог ямбатай шувуу юм. Түүний мах, зүрхийг зүрхний өвчинд хэрэглэхэд эдгээх эрдмээр илүүтэй сайн гэж эмийн сударт дурьдсан нь бий. Хоёр залуус өгссөөр явтал тэжээвэр тахианаас арай том бор шувуу явгалан гүйнэ. Үүнийг харсан Нарангарав

-Амархүү. Энэ шувуудыг хараач. Ямар шувуу вэ? гэхэд Амархүү сонсож байснаа түргэн зуур бясалгаад

- Энэ шувуу чинь нөгөө алдартай Хойлог шувуу чинь байхгүй юу. Хойлог шувуу чинь хоёр ходоодтой гэж байгаа. Нэг ходоодонд нь идсэн уусан юм нь байхад нөгөө ходоодонд нь дүүрэн чулуу байдаг юм. Мах нь бол хүний биеийн тамирыг тэтгэж мах цусыг асар түргэн төлжүүлдэг бол ходоод нь ходоодны өвчинд үнэнхүү сайн юм гэсэн шүү. Би өвөөгөөсөө л сонсож байсан юм даа гэлээ Гэтэл Хойлог шувууд ямар нэг юмнаас үргэн газрын уруу явгалан гүйсээр дэрхийн нисэж одов. Юунаас үргэдэг билээ гэж санаад ажиглавал хярын орой барьсан хянга хадан дээр тэнгэр сэжилсэн сэлмэн эврүүд үзэгдэв. Амархүү дуугаа намсган бөхийгөөд

- Нарангарав аа. Тэр янгир ямааны эврийг үзэв үү? Сэрийгээд ямар сүртэй бас үзэсгэлэнтэй юм бэ? гэхэд

-Тийм ээ. Би огтхон ч үзэж хараагүй юмаа үзэж байна гэж Нарангарав дуу алдав. Байгалийн гоо үзэсгэлэн, ан амьтдын сор, жигүүртний дээд бүгд л энэ хайрхан ууланд нутагшин байгаа нь бахархмаар санагдаж байв. Амархүү Нарангарав хоёр явсаар хяр дээр гарч морьдоо бөхлөөд цааш Хар ангилагийн эх рүү хад асга дамжин явлаа.

Алс хол руу хараа билчээхэд гурван их говь цэлийгээд холын тэртээд Тахийн шар нуруу цагаан цэнхэр униар дунд сүүмэлзэн бүдэгхэн харагдана. Наашлаад хөвчийн нуруу үргэлжлэн сунана. Цагаан гол, Бижийн гол бусад уул толгод булаг шанд зураг аятай өнгө зохицон үзэмж төгс сэтгэлд бууна.

Хар ангилагийн энэ асга хад зүгээр эмх цэгц муутай энд тэндээс өнхөрч ирээд тогтсон биш байлаа. Харин зориуд урлан бүтээсэн мэт байгаа нь байгаль ээжийн өөрийнх нь бүтээл гэлтэй. Гэтэл Амархүү эхний Вансэмбэрүүг үзээд чимээгүй гайхаширахдаа дотроо

- Эхлээд Нарангараваараа үзүүлж түүнийгээ баярлуулбал зүгээр юм. Сайхан сэтгэлтэй тэр ихээхэн урамшиж баясах болов уу гэж бодсондоо ийнхүү чимээгүй болов. Амархүүг бодлоосоо салж амжаагүй байтал Нарангарав баярлан дуу алдаад

- Хүүе ээ. Тэр, тэр хараач Вансэмбэрүү цэцэг гэж баясан өгүүлэхэд Амархүү өөрөө үзээгүй дүр эсгэн түүндээ урам өгч

- Алив! хаана Вансэмбэрүү цэцэг байна гэж хэлэхэд Нарангарав бүр ч баясан

- Яагаав тэр байна шүү дээ гэж гараараа заан өөрийнхөө хурц нүдтэйдээ бахархаж бардамнах сэтгэл төрж байв. Амархүү мөн л уулга алдан

- Өө би үзлээ. Тэр байна гэхэд Нарангарав инээмсэглэн

- Аль нь эр, аль нь эм нь юм бэ? гэж асуухад Амархүү инээгээд

- Чиний үзсэн эр нь, миний үзсэн эм нь бололтой гэхэд Нарангарав түүний заасан цэцэг рүү харангаа

- Тийм байх аа. Эм нь болохоор арай л гэгээтэй өнгөлөг харагдаж байна шүү гээд Амархүүг харахад Амархүү ч түүн рүү харж байлаа. Хоёр залуу хэлж бичихийн аргагүй хайрын харцыг бие биедээ илгээн сэтгэл зүрхээрээ тэврэлдсэн байлаа. Вансэмбэрүү цэцэг ч баяр хүргэх мэт бүдүүвтэр иш нь нэгэн аялгуу өгөн бөхийх шиг санагдав. Хар ангилагийн хад асга, Алаг хайрхан уулын сүм мэт сүрлэг сайхан байхад Вансэмбэрүү цэцэг энэхүү уулын сүмийн хойморт залрах яв/эр/, юм /эм/ арга билгийн бурхан шүтээн шиг эрхэмсэг заларна. Хоёр залуус хоорондоо сэтгэлээрээ уягдсан бол хос Вансэмбэрүү цэцгэнд хүрч холбогдоод дүрс талстын үндэс болох гурвалжин үүсгэв. Энэ билэг ерөөлийн гурвалжин нь хүмүүний үргэлжлэл арга билгийн хууль жам ёсыг илэрхийлж байв. Гэнэт хүн ханиалгах чимээнээр оюун билгийн тамир эвхэгдэн байр байрандаа оршив. Амархүү дотроо

- Энд бас хүн явж байгаа байх нь. Хэн байдаг юм бол доо гэж эргэн тойрноо ажиглавал хэнийг ч олж харсангүй. Гэтэл дахиад л ханиалгах чимээ гарч том хадны цаанаас нэгэн хүн гараад ирэв. Сайн ажвал хуц ухна малладаг Хөхцэцэгийн аав Сагад гуай байлаа. Сагадыг таньсан Нарангарав санаа нь их зовж байв. Амархүүтэй уулын оройд хад асган дунд хамт байгаадаа тэр билээ. Харин Амархүү Сагадыг үзээд бүр баярлаж

- Энэ хүнтэй ингэж нэг уулздаг байж гэж бодоод инээмсэглэсээр угтаж очоод

- Сайн байна уу? Сагад гуай. Та сайн явж байна уу? гэхэд Сагад

- Сайн. Сайн байцгаана уу? та бүхэн сайн л явцгааж байна уу? гээд тэр хоёрыг биш Вансэмбэрүү цэцгийг харж бас харц гүйлгэн алив нэгийг ажиглах мэт болов. Тэр Нарангарав

руу харангаа

- За манай охины найз сайн явж байна уу? Аав ээжийн чинь биесүүд сайн биз дээ? гэхэд Нарангарав бага зэрэг ичингүйрэн байж

- Сайн, сайн. Хөхцэцэг гэртээ л байгаа юу гэхэд Сагад

- Байгаа, байгаа. Манайх гэдэг айл чинь дандаа л амьтан хүнээс дайжиж явах юм байна шүү дээ. Манайх энэ уулын баруун талын Хөх асганы бэлд байна гэснээ тэр хоёрыг ажигласнаа залгуулаад

- Би хуц ухна маллахын зэрэгцээ энэ хэдэн Вансэмбэрүүг малладаг юм. Вансэмбэрүүгээр ирэх жилийн хаврын эхэн сарын өнгийг шинждэг юм л даа. Өнөөдөр тэр өдөр нь юм. Би сая гэрээсээ гараад уул өөд мацуулсаар байж гарч ирээд хоёр эмээлтэй морь байхаар бүр гайхаж бас надтай адилхан ус ургамал, цэцэг ногоо ажиглаж байдаг хүн байгаа юм болов уу гэж бодлоо гэсээр инээв. Хоёр залуу ч Сагадтай Вансэмбэрүү цэцгийн дэргэд учирдаг нь бас ерөөлтэй билээ гэж бодоод Амархүү явдал мөрийнхөө учрыг тайлбарлах маягаар

- Сагад гуай бид хоёр анх удаа л Вансэмбэрүү цэцэгийг үзэж байна. Бид хоёр энэ цэцгийг үзэж нүдээ баясуулж сэтгэлээ цэнгүүлье гэж энэ өдрийг сонгосон маань сайн боллоо. Би эртэд танайд ирээд Хөхцэцэгээс Вансэмбэрүү цэцгийн тухай яриулж байхдаа тантай уулзаж яриулахсан гэж дотроо бодож байлаа. Тэгээд л Нарангаравыг гуйж хамт үзье гэсэн хэрэг л дээ. Энэ ч бас үзээгүй юм билээ. Харин тантай энд уулздаг нь ямар их аз завшаан бэ? гэв. Нарангарав

- Би ч гэсэн Хөхцэцэгээс сонсож байсан. Нэг үзнэ дээ гэж бодохоос биш үзэж чадаагүй юм. Энэ ямар гоё гайхалтай цэцэг вэ? гэхэд Сагад

- Тийм шүү. Үнэнхүү сайхан цэцэг. Би үүрээр ирж харна. Өдөржингөө харж орой нь унтуулж аваад л явна шүү дээ. Бидэн шиг л хоорондоо ярьж бас жаргал зовлонгоо хуваалцана гэхэд Нарангарав бүр гайхаад

- Тийм үү? Ямар сонин юм бэ? хэмээн их сонирхож байгаагаа нүдээрээ илэрхийлэн байгааг ажигласан Сагад

- Өглөө үүр цайгаад гарын алганы хээ үзэгдэх үеэр иш нь нэг сонин аялгуу гарган орой нь бөхийсөн бол тэр үед өндийнө. Их аажимхан. Сайн ажиглахгүй бол бараг мэдэгдэхгүй шахам. Тэгээд нар сайн мандаад ирэх үед бүгдээрээ нар луу харна. Мөн л намуухнаар хүүхэд инээх мэт дэлбээгээ дэлгэнэ. Яг тэр үед дэргэд нь байвал гайхамшигтай сайхан үнэрээр агаарыг сүрчиглэнэ. Тэр үнэрт агаараар амьсгалахад үнэнхүү таатай. Ер нь уушгийг бол бүрэн ариусгана. Хамрын бага зэрэг шуухинаатай бол тэр өдөртөө л нам дарагдана. Энэ мэт үнэрээ нар дагаж байх үедээ байнга ялгаруулна.

Вансэмбэрүү цэцэг яг боловсорч байх үеэр нь ан амьтад хүртэл энэ хад асганд чинь ирээд зогсчихно. Зарим нь бүр унтаад өгнө шүү дээ. Тарвага туулайнаас авхуулаад аргаль угалз, янгир ямаа тэр битгий хэл чоно хүртэл ирнэ шүү дээ. Энэ үнэрт агаараар амьсгалж уушигаа

ариусгасан амьтад чинь уул хадандаа явахдаа ер амьсгаадах багтрах гэж юм байхгүй зүгээр л дүүлээд байх нь тэр шүү дээ гэхэд амаа ангайн Сагад гуайн ам руу орох шахан суугаа Амархүүг харсан Нарангарав дотроо

- Манай Амархүү хүнээс юм сонсох мөн дуртай хүн шүү. Зуны наадмаар морь барианы газар Хөхцэцэгийн ам руу яг л энэ шиг орох нь холгүй байсан даа гэж бодлоо. Амархүү тэр л янзаараа

- Мөн ч гайхалтай сонин юм даа. Тэр үнэрт нь нэг ид шид байна даа гэхэд Сагад мэргэн

- Тийм ээ. Тэр үнэрээр зогсохгүй энэ цэцэг байгаа биеэрээ анагаах эрдэм чадалтай ховорхон хүн заяатай цэцэг шүү дээ. Би ч гэсэн тэр үеэр хоёр морио хэдэн хуц ухнаа, үхэр тугалаа авчирч Вансэмбэрүүгийн үнэрт агаарт байлгаж уушиг биеийг нь ариусгаж авна шүү дээ. Одоо манайх байгаа асганы бэлээс энэ өндөр хайрханы орой өөд мацаад гарчих морь суманд бол байхгүй. Тэгэхэд миний хүрэн морь бол яах ч үгүй мацаад бараг амьсгаадахгүй гараад л ирж байгаа юм шүү дээ гэхэд Нарангарав өөрийг сонсохыг хүсэж байгаа бололтой инээмсэглээд

- Тэр үнэр нь хэдийд боловсордог юм бэ? гэж асуув. Сагад

-Жил бүр өөр өөр хугацаанд боловсорно. Нөгөө л байгалийнхаа аяыг дагаж байгаа нь тэр. Түүнийг ажигласаар байгаад мэднэ. Нэгд цэцэгээ ажиглана. Хоёрт ан амьтдын байр байдлыг тандана. Энэ амьтад чинь тэр боловсрох үеийг нь андахгүй мэднэ шүү дээ. Би ч голдуу энэ уулын хэдэн чононы байр байдлыг ажигладаг юм. Эд нар чинь бүр биеэ бэлдээд янз бүрийн юм болно шүү дээ. Вансэмбэрүүгийн боловсрох үйл мөр нь ердөө л тавхан хоног үргэлжилдэг юм. Их богинохон хугацаатай байгаа биз гэхэд Амархүү

- Тийм юм байна. Энэ цэцэг орой унтахдаа ямархуу байдаг вэ? гэж асуухад Сагад инээмсэглэнгээ

- Өглөөнөөс аваад нар шингэх хүртэл нар луу харж нар дагаж мишээж байгаад нарыг үдэж өгөөд эр эм хосоороо бие бие рүүгээ харна.Тэгээд л аажимхан дэлбээгээ хумина. Эхлээд эм Вансэмбэрүү бүрэн хумьсаны дараа эр нь дэлбээгээ хумиад л амарна даа гэхэд Нарангарав

- Ёстой ухаантай цэцэг байна даа гэхэд Сагад гуай

- Би нэг удаа нар жаргаад хос цэцгүүд бие бие рүүгээ харсан байхад нь эм Вансэмбэрүүгийн дэлбээгээ хумихад нь гэм хоргүйгээр хориг тавилаа. Орой бүрий ч боллоо. Бусад Вансэмбэрүү бүгд л дэлбээгээ хумьж бөхийгөөд унтаад өгөв. Би нөгөө эм Вансэмбэрүүг дэлбээгээ хумьж бие биедээ хүндэтгэл үзүүлэхийг нь хорьсон болохоор түүний дэлбээ дэлгэрсэн хэвээрээ л байв. Гэтэл эр вансэмбэрүү цэцэг мөн л адилхан дэлбээгээ хумьдаггүй дэлгэрсэн хэвээрээ эм цэцэг рүүгээ бага зэрэг бөхийн харах мэт байсаар л байлаа. Би эм цэцгийн хоригийг авахад тэр түргэнээр дэлбээгээ хумив. Эр цэцэг нь аажимхан дэлбээгээ хумьсаар ихэд тонгойн бөхийсөн байв. Би очоод үзвэл уурласан юм уу эсвэл уйлсан юм уу дор байх чулуун дээр усархаг зүйл дуссан байлаа.

Би тэгээд л энэ цэцэг бидэн шиг бие биенээ хайрлаж түшиж хослон амьдардаг хүн цэцэг юм даа гэж бодсон шүү. Маш ухаантай эрдэм чадалтай бурханы цэцэг юм билээ. Унтахынхаа өмнө яг л хаан хатан хоёр шиг бие биедээ хүндэтгэл үзүүлнэ шүү дээ. Бөхийгөөд ёсолж байгаа нь ихэс дээдэс шиг санагддаг юм гэлээ.

Хоёр залуу хоёулаа Сагад мэргэний ам руу орох шахам ойртсон байлаа. Амархүүгээ хүний ам руу орох нь гэж шүүмжлээд байдаг Нарангарав ёстой л өөрөө Сагадын ам руу бараг л орчихсон байв. Энэ гурван хүн нэг хэсэгтээ гүн бодолд орж өөр өөрийнхөө зүрхний цохилохыг бүдэгхэн мэдэрч байв.

Вансэмбэрүү цэцгэнд илбэдүүлсэн мэт Алаг хайрхан уулын асга хадан сүмд нь морилж арга билгийн хос шүтээн болсон Вансэмбэрүү цэцгийг оюун ухаандаа хадгалж сэтгэлийнхээ хойморт залж буй нь энэ билээ. Хүний сэтгэл хүсэж мөрөөдсөн юмандаа ханаж цадна гэж байх биш дээ. Амархүү Нарангарав хоёр суусаар л байлаа. Дахиад ихийг мэдэхийг хүсэж байгаа нь царайд нь илэрч байв. Сагадыг босоход тэр хоёр

- Яаж байгаа юм бол доо гэсэн янзтай харж байлаа. Сагад мэргэн өврөөсөө дурангаа гарган хол ойрыг дурандав. Тэснэ тэснэ гэхэд яаж тэсэх вэ гэдэг шиг Амархүү суусан хэвээрээ

- Сагад ах аа. Вансэмбэрүү цэцгэний эр эмийг нь яаж таньж мэдэх вэ? гэв. Сагад дурангаа нүднээсээ салгаад доош суунгаа

- Сайн ажиглавал амархан. Хүмүүс голдуу орой амрахынхаа өмнө бие бие рүүгээ харахыг нь ажаад эр эмийг нь мэднэ гээд гараараа нэг цэцгийг заагаад энэ цэцэг эр цэцэг байна. Иш нь бүдүүвтэр дэлбээний өнгө нь үл мэдэг бараан байгаа. Энэ цэцгийн нөгөө хос болох эм нь энэ байна гээд бас нэгийг заагаад

- Дэлбээ цомирлог нь арай гэгээтэй өнгөлөг байгаа биз. Иш нь ч арай л нарийн гоолиг байгаа гэлээ. Хоёр залуу хичнээн сайн ажиглан харавч ялгаатай хэсгийг нь олж мэдэж чадсангүй.

- Энэ цэцгийг чинь авч өвчинд уудаг гээ биз дээ гэж Амархүүг хэлэхэд Нарангарав сая л ухаан оров уу гэлтэй

- Манай ээж нэг удаа буцалгаж ууж байсан нь санагдаж байна гэж хэлээд алив нэгийг санах гэж байгаа бололтой хуруугаа имэрч суулаа. Сагад

- Энэ цэцгийг авдаг гурванхан өдөр байдаг юм. Дуртай өдрөө ирээд зулгаагаад авч болохгүй. Хэрвээ тэгвэл хүний амь тасалж байгаатай ялгаагүй их нүгэл болно гэхэд Нарангарав амаа даран

- Пөөх ямар аймаар юм бэ? гэж дуу алдахад Амархүү

- Авдаг гурван өдөр нь ямар өдрүүд вэ? Хэдэн сарын хэдэнд авдаг юм бол гэж асуухад Сагад инээмсэглээд

- Авдаг өдөр нь бас л тодорхой тогтсон өдөр биш. Байгалийн билэг чанар ямар байснаас

болно. Нэг үгээр тэр жилийн хур бороо, нарны илч, салхины хүч, газрын ам нээгдэх гээд олон зүйлээс хамааралтай байдаг юм. Авах хүн бол долоо хоног цаашилбал арван хоног ажиглана. Цэцгийн үйл мөр нь гүйцэх үеийг л мэдэхийг хэлж байгаа хэрэг шүү дээ гэхэд Амархүү бүр гайхан учрыг огт ойлгохгүй

- Цэцгийн үйлийн мөр гэж юу байдаг юм бэ? Би бүр ойлгохгүй байна гэхэд Сагад бүр нарийсган

- Үйлийн мөр гүйцэх гэдэг нь байгаль дэлхийгээс, нар сар од эрхэсээс авах эрчим хүч, шимт тамирыг бүрэн авч ханаж дүүрсэнийг хэлж байгаа хэрэг. Яг энэ үедээ арга билэг салж тусгаарлахыг Вансэмбэрүү цэцгийн хагацал буюу бэлбэсрэх хэмээн үйл нь гуравхан хоног үргэлжилдэг. Энэ үедээ хүн хоолондоо цадсаны дараа хэхэрдэг шиг яг л хүн хэхэрч байгаа чимээ гардаг юм. Тэр үед нь авахад аюул багатай байдаг. Хар ухаанаар бол Вансэмбэрүү цэцгийн дэлбээ нь үндэс ёзоороосоо бүрэн тусгаарлагдан ямар ч холбоогүй болсон байна. Энэ үедээ дээд бурхан тэнгэртээ ид шидийн эрдэм чадлынхаа гайхамшигт дээжийг өргөн барьж байгаа нь тэр гэхэд Нарангарав гарын алгаа хавсран

- Ямар сонин юм бэ? дуртай үедээ авч болохгүй юм байна гэв. Амархүү Вансэмбэрүү цэцгийг ширтэн чимээгүй бодол болон сууна. Сагад цааш нь

- Тэр арга билэг тусгаарлагдсан гурав хоног өнгөрмөгц арга билэг дахин нэгдэж цэцгэнд хурсан ид шидийн эрдэм чадлын хүч тамираа үндэс ёзоорын уг руугаа татаж хурааж авдаг юм гэхэд Амархүү

- Тэр гурав хоногт нь хүнээс өөр амьтан цэцгийг тасалж авах уу? гэв. Сага инээмсэглээд

-Авна аа. Ялангуяа янгир ямаа тэр үеийг нь хүлээгээд энэ хад асганд бөөгнөрнө шүү дээ. Тэр гурван хоног эхлэмэгц л цэцгийг хүртэнэ шүү дээ. Энэ цэцэг идсэн янгир дараа нь их зовно гэхэд Амархүү

- Юундаа зовох билээ. Зохихгүй байгаа хэрэг үү? гэхэд Сагад

- Үгүй ээ. Цэцгийн янгирыг чинь чоно бүр андахгүй шүү дээ. Хөөрхий минь өөрөө ногоо иддэггүй болохоороо цэцэг идсэн янгирын махыг зооглох гэж л тэр байхгүй юу.

Энэ ертөнц гэдэг чинь нэхэл дагал ихтэйг нь бодохоор ухаантай юм шиг. Нүгэл буян хоёроо ялгахгүйг нь санахаар мунхаг юм шиг. Зовлонгоо жаргал гэж эндүүрэхийг нь харахаар гэнэн тэнэг юм шиг. Өөрийгөө мөнх хэмээн сэтгэх нь бүр толгойгүй юм шиг санагддаг шүү гээд хоёр залууг ажиглан байв. Амархүү бүрэн гүйцэд мэдэхийг хүсэж байгаа бололтой

- Сагад гуай тэр гурав хоногт нь хүмүүс цэцгийг зүгээр л таслаад авчихдаг юм уу? гэж асуухад нь Сагад дотроо

- Энэ хүүхэд чинь Вансэмбэрүүг л авах сонирхолтой болох нь дээ. Эсвэл учрыг нь бүрэн мэдэхийг хүсээд байгаа юм болов уу? гэж бодоод

- Хүн чинь ухаантай болохоороо юу гэж өөрөө шууд таслаад авч болохгүй шүү дээ. Тэр арга билэг саланги байх гурван хоногт чинь үндэс нь газар дэлхий лусын хааны мэдэлд байдаг бол цэцэг нь тэнгэр хурмастын хааны мэдэлд очсон байдаг юм. Энэ гурван хоногоос бусад үед бол тэнгэр, газар хоёулангийнх нь мэдэл бүрэн захирагдаж байдаг. Тиймээс тэнгэр хурмастын хаанаас нууж авах ёстой болно доо. Нэг бол майхан үгүй бол гурван саваа модыг үзүүрээр нь холбон гурвалжин үүсгээд дээлээ нөмөргөн тэнгэрээс нууж далдална. Цулбуурынхаа сурыг авч нэг үзүүрийг нь Вансэмбэрүү цэцэгний иш шилбэнд уяд нөгөө үзүүрийг нь нохойн хүзүүвчинд уяна. Хэрвээ нохой байхгүй бол эмээлийн хойт ганзаганд бөхлөөд орхино.

Үүр шөнийн хагацах үе бүрийгээр морь юмуу нохойгоо хөдөлгөн цэцгийг тасалж авдаг юм. Вансэмбэрүү цэцгийг авахын өмнө тэнгэр бурхандаа, газар дэлхийдээ, уул усандаа, Вансэмбэрүү цэцгэндээ айлтгал хийж ач буяныг нь магтан дуулна. Тэгэж байж л дараа нь ёс жамаа гүйцэлдүүлнэ шүү дээ гэв. Амархүү их л шүлэнгэтэн

- Өмнө нь ямархуу айлтгал хийдэг бол. Та хэлж өгөөч гэж гуйх шахам хэлэхэд Сагад бүр чангаар инээгээд

- Авах гэж байгаа хүн л өөрийн сэтгэлийн айлтгалыг л хийнэ шүү дээ. Түүнээс биш ингэ тэг гэсэн хатуу ёс байхгүй. Жишээлбэл: цэцгийн дор хормойгоо дэвсэж хоёр өвдгөөрөө сөхөрч суугаад гарынхаа алгыг дээш нь дэлгэрүүлж байгаад

Эцэг тэнгэр та дээрээс ивээж байлаа ч

Эгэлгүй хол учраас би золгож үл чадмуу

Эх газар дэлхий дороос тулж байлаа ч

Энгэр биеийг тань би эсгэж үл зүрхэлмүү гээд мөргөнө

Цааш нь

Алаг хайрхан уул таныгаа дээдэлмүү

Асга хадан сүмд тань морилмуу

Арга билгийн Вансэмбэрүү цэцгэнд мөргөмүү

Авралын дээд анагаах эрдмийг тань хүсмүү гээд бас дахин мөргөнө. Цааш үргэлжлүүлээд

Үйлийн үр минь буруу байвал

Хаан цэцгийн гэсгээлд сөгдмүү

Үнэн сэтгэл минь зөв байвал

Хатан цэцгийн хишигт багтмуу гээд дахиад гурав мөргөнө шүү дээ гэв. Амархүү бодлоо нэрэх

мэт болоод

-Ямар сайхан тансаг юм бэ? Эхлээд тэнгэр газартаа хандаад мөргөнө. Дараа нь уул ус нутагтаа сүүлд нь Вансэмбэрүү цэцгэндээ айлтгалаа хийгээд гурван удаа мөргөж сүсэглээд эцэст нь гурвантаа мөргөн их ёсолгоо хүндэтгэл үзүүлдэг юм байх нь. Мөн ч сайхан зан үйлтэй юм аа гэхэд Нарангарав бодолхийлээд дотроо

- Энэ сайхан цэцгийн тухай аав ээж хоёр минь сайн мэддэг болов уу? Хэрвээ мэддэггүй бол би л сайн ярьж ойлгуулъя. Хөхцэцэгийн аав Сагад гуайг мэргэн гээд байдаг. Миний бодоход мэргэн биш маш их эрдэмтэй хүн байна шүү дээ. Тэгээд яагаад охинтойгоо хоёулхнаа хуц ухна маллаад айл амьтнаас зайдуу ганц гэрээрээ яваад байдаг юм бол.

Манай Хөхцэцэг мөн ч сайн толгойтой шүү дээ. Аав нь байнга зааж сургаж байдаг биз. Миний найз энэ жил Улсын их сургуулийн түүх газар зүйн ангид эчнээгээр суралцах томилолт авсан. Алтанцэцэг бид хоёр л үлдэж байх шив дээ. Манай Хөнхий, Сэмбэрүү, Минжин, Содхүү, Хөхцэцэг гээд л бүгдээрээ сургууль соёлд явцгааж эрдэмтэн мэргэд болох нь гэж бодсон тэрээр Вансэмбэрүү цэцгийн тухай сэдвийг өөрчлөн

- Хөхцэцэг сургуульдаа хэзээ явах юм бэ? Бид хоёр наадмаас хойш уулзсангүй гэхэд Сагад инээмсэглээд

- Энэ есөн сард яваад нэг сар болоод ирэх юм гэсэн. Тэгээд хавар явах юм гэнэ лээ гэхэд Амархүү

-Сагад гуай энэ жил Вансэмбэрүү цэцгийн нөгөө бэлбэсрэх гурав хоног нь хэзээ бол гэхэд Сагад дахиад л Амархүүг ажигласнаа

- Одоо ер нь дөхөж байгаа шүү. Та хоёр тэр янгир ямаадыг хараач гэхэд түүний заасан зүг рүү харахад янгир сүрэглэсэн байв. Амархүү

- Нээрээ тийм байна шүү. Бид хоёр ч бас үзсэн л дээ. Энэ намар ямар болох янзтай байна гэж шалгааж асуув. Сагад ер түвэгшээсэн шинжгүй

- Та хоёр сайн хараарай. Вансэмсэрүү цэцгийн ишний доод хэсэгт газарт хүрсэн далбан ногоон навчийг харав уу? За тэгээд дээш нь явуулаад бай.Цэцгийн цомирлогийн дэлбээ ягаавгар байгаа биз. Түүний яг дор богинохон ногоон навч бий . Энэ ягаан дэлбээ маш зөөлөн уян налархай шинжтэй. Голын дохиурын булбарай бондгор хэсэг байгаа биз. Энэ гурваар шинждэг юм даа гэхэд Амархүү инээгээд

-Сагад гуай үүнийг судлаж суралцаж болох уу? гэж асуухад Сагад

- Бололгүй яхав. Наад зах нь арван жил хэрэгтэй дээ. Гүнзгийрүүлье гэвэл хугацаа нь сунаад л байна даа. Намар ямар болохыг шинжихийн тулд нар, сарыг ажиглахаас гадна Ангараг, Буд, Бархасбадь, Сугар, Санчир гарагуудын хөдөлгөөн байршлыг хөөн бодоод үзүүлэх элдэв нөлөөллийг тогтооно. Бас нэмээд долоон бүгээн, Мичид марал, Бат од, Гар од зэргийн нөлөөлөл хамаарлыг ч анхаарна. Намрынхаа гурван сарыг зургаан хэсэгт хуваана

Нэгд. Намрын эх хатгах

Хоёрт . Сэрүүнийг дуудах

Гуравт. Цагаан шүүдэр

Дөрөвт. Тэнцэл

Тавд. Хүйтэн шүүдэр

Зургаад. Хяруу унах гэж хуваана. Тэгээд л зурхайн тооны нууц түлхүүрээр утганд нэвтэрч тайлж тайлбарлана. Жишээлбэл:

Намрын тэргүүн сард

Хүйтэн салхи хүрч ирмүй.

Цагаан шүүдэр унамуй.

Чалчаа хорхой чалчмуй гэж байхад

Дунд сард

Хараацай одмуй

Олон жигүүртэн өндгөө хураамуй

Ичих хорхой үүрээ бэхэлмүй гээд

Адаг сард

Бялзуухай их усанд орж хясаа болмуй

Өвс мод шарлаж навчис унамуй гэх мэтээр зурхайн толинд заана. Бас амьдрал ахуйн байдлаар шинжих нь бий. Голио их шуугивал сайхан намар болно. Есөн сард тэнгэр дуугарвал дулаахан намар болно. Хөхөө эрт донгодвол намар нь урт болно гэх мэтийн маш олон шинжүүд байдаг хэмээхэд Амархүү өмнө бодож байсан бололтой шуудхан

-Цагаан шүүдэр гэж юу хэлээд байна гэж лавлахад Сагад мэргэн

- Газрын гадаргууд усны уур дэгдэж чадалгүй царцахыг цагаан шүүдэр гэдэг юм гэлээ. Энэ гурван хүн араа шүдэнд ууссан тос хөвсөн айраг шиг амттай ярианаасаа салж ядан байсан ч цаг хугацаа тэднийг захирч өөр өөрийнх нь үйлийн үрийг хөөлгөв. Сагад хоёр залууг үдэж мордуулаад өөрөө морио хөтөлсөөр хярын ирмэг даган алхах нь энэ хайрхан уулын эзэн савдаг нь мэт эгэлгүй сайхан санагдаж байв.

Хорин дөрөв

Вансэмбэрүү цэцгийн болзоондоо баярлаж баясаж ихийг үзэж сонссон Нарангарав нар шингэх үед гэртээ ирэв. Эх нь охиноо далдуур шинжиж ажиглана. Царай нь гэрэлтэж нүдэнд нь баяр дүүрэн байгааг олж харав. Тэр дотроо

-Манай охины сэтгэл нь баяр баясгалангаар дүүрэн байгаа бололтой. Энэ хүүхэд хэнтэйгээ уулзаж юугаа ярилцсан болоод ингэтлээ баярладаг билээ гэж эх хүний хайр халамжийн нэг болох төрх байдлаар шинжиж мэдэхийг хүсэж байхад эцэг Балдан ер тоосон шинжгүй цайгаа оочилно. Энэ ч гэсэн эцэг хүний дотор ухаандаа хайрлах хайрын нэг илрэл байлаа. Тэр дотроо

- Овоо доо. Охин минь нар шингэхээс өмнө амжаад ирлээ. Санаа амарлаа гэж бодож тайван цайгаа ууж суугаа Балдангийн сэтгэлийг эх охин хоёр яахан мэдэх билээ.

Нарангарав угийн цагаан цайлган, ам түргэнтэй хүүхэд болохоор удаан хадгалж чадсангүй унтахын өмнөхөн аав, ээж хоёртоо Вансэмбэрүү цэцэг үзсэн бас Сагадтай уулзаж яриулсанаа тоочиж орхив. Балдан

- Юун сайн юм бэ? Би нэг зав гарвал чамайг дагуулж Вансэмбэрүү цэцэг үзүүлье гэж бодож байсан юм. Гэтэл чи өөрөө үзэж хараад ирсэн нь сайн болжээ. Тэр Сагад энэ цэцгийн тухай мөн сайн мэдэж байна шүү. Би л ийм сайн мэдэхгүй юм байна гэхэд эхнэр нь хошуу нэмэрлэж

- Тэр Вансэмбэрүү цэцэг чинь ёстой л эмийн дээд нь юм билээ. Би хэсэг уугаад л миний уушиг бүрэн эдгэсэн шүү. Би ургаатай байгааг нь үзээгүй л дээ. Сэтгэлдээ л залбирч баярлаж явдаг юм. Ямартаа л өглөө бүр цайныхаа дээжийг Баян алтай, Алаг хайрхан уул, Вансэмбэрүү цэцэг минь гэж өргөж байхав. Үүнээс илүүг хийж чадахгүй тогооны хүн чинь яалтай ч билээ гэж үг хаях маягтай хэлэхэд Балдан таг дуугүй байснаа

- Болж байна. Үүнээс илүү юу хийх билээ дээ. Зөв сэтгэл байхад л бүгд болж байдаг юм гэнэ лээ. Би ч гэсэн дэргэд нь шахам байж л байна. Тэгээд санахаас өөрөөр хэтэрч чадаагүй л байна. Тэр Сагад зүгээр хүн биш ээ. Түүний эрдэм мэдлэгтэй ярих юм байхгүй. Одоо ажиглаад байхад манай сумын хэдэн дарга нар бүгд л Сагадын руу цуваад байгаа гэж хэлцэх юм байна шүү. Хамгийн том дарга нь Сагад л болж таарах гээд байна гэхэд эхнэр нь

- Иш хөөрхий дөө эхнэр байхгүй ганц охинтойгоо тэр муухай олон хуц ухныг яаж шүү нэг малладаг юм бол доо. Хуц ухна маллах амаргүй гэсэн. Жил болгон хүчээр шахам хоёр айл томилоод маллуулдаг хойтон жил нь үгээ хэлээд л зугатдаг байсан биз дээ. Тэр дарга нар байнга цуваад байгаа чинь сайндаа биш муугийн ёроор хуц ухнатай нь хатаах гэж байхгүй юу гэхэд Балдан эхнэр лүүгээ аяс муутайхан хараад хурал дээр босож үг хэлэх гэж байгаа юм шиг ярвайгаад

- Тийм биш ээ. Тэр дарга нар чинь ажлаа ярьж зөвлөлдөж яваа нь тэр. Энэ өвөл ямар болох вэ? Цас хаана хаана их унах вэ? Ямааг аль нутагт, хонийг аль нутагт өвөлжүүлэх, хуц ухныг

хэдийд нийлүүлэх, хавар нь хаана төллүүлэх гээд олон зүйл дээр зөвлөлдөж байдаг гэнэ лээ. Би ажиглаад л байдаг юм. Энэ Сагадыг хуц ухна малласнаас хойш манай сумын мал байнга өсөж байгаа. Тэр хуц ухна тарга хүчтэй бол ярих юм байхгүй сайн шүү дээ. Энэ хүнд нэг нууц эрдэм бий дээ гэхэд Нарангарав аав ээж хоёрынхоо ярианд оролцож

- Манай ангийн Хөхцэцэг манай аавд хурганы арьсны хэрийн маш нарийн илгэн дээр олон нар, сар оддын зураг зураад хооронд нь шугамаар холбоод тоонууд бичсэн томъёо юм уу гэмээр тэмдэглээнүүдтэй нэг юм байдаг. Бас аавынх нь аав түүний ааваас дамжиж ирсэн жижгэвтэр ногоон өнгөтэй бор цахир язмагтай шүрэн толгойтой Чүнчигноров хөөрөг бий . Энэ хоёрыгоо л миний хамаг хөрөнгө энэ дээ гэж ярьдаг юм гэж надад ярьсан гэхэд Балдангийн эхнэр

- Ээ чааваас даа. Тэр хоёрыгоо л хөрөнгө гэж боддог байх нь. Энэ суманд анх ирэхдээ гурван настай охиноо тэврээд өмссөн хувцаснаасаа өөр юу ч үгүй байсан юм гэнэ лээ. Тэгээд нэгдлийн манаач хийгээд л орох орон оочих аягатай болсон байх. Аав, ээж, өвгүүд нь манай нутгийн хүмүүс байсан юм гэсэн гэхэд Балдан Сагадыг өмөөрөнгүй аятай

- Чи юу ч мэдэхгүй байж хүмүүст ийм хэрэггүй юм ярив аа. Энэ хүн чинь хэлэлцэж барахын аргагүй эрдэмтэй хүн юм гэнэ лээ. Тэгээд л хууль цагдаагийн хяналтанд байдаг гэсэн. Илүү үг хүзүү орооно гэж үг бий . ам хамраа жаахан хямгадаж байвал зүгээр байх шүү гэхэд эхнэр нь

- Би та хоёрт л хэллээ. Өөр хэндээ ч хэлэх билээ дээ. Тэр Сагадынтай чинь манайх ч ялгаа алга. Айл амьтантай ойртож айлсаж буухгүй, дандаа л ганц гэрээрээ байгаагаа юу гэж боддог юм. Ийм яхир ярдаг хүнтэй чинь чөтгөр ч ойртож ханилахгүй шүү дээ гээд нөхрийнхөө “Яхир” хочийг нь дурдаад сайн гэгчээр хэлээд тавьчихлаа. Балдан дуугүй л

- Энэ маань дуугарахаараа бас чанга байна шүү. Надад их сануулга өглөө шүү гэж бодож суухад Нарангарав ээжийнхээ хэлсэн үгийг дотроо бодоод

- Манайх чинь зожиг айлд ордог гэсэн. Хүмүүс огт тоодоггүй . Яхир Балдантай маргалдаж байснаас тарваганы нүх рүү хашгирвал хамаагүй дээр гэж хэлэлцдэг юм гэнэ лээ гэдгийг Балсан авгынхаа хүү Хөнхийгөөс сонссоноо нэхэн санах. Балдан ч эхнэр охин хоёрынхоо бодлыг сайн гадарлаж байгаа болохоор сэтгэлийг нь засах аятайхан үг хэлэх юмсан гээд олж ядан байснаа

- Манайх чинь нэг настай мал малладаг болохоор бэлчээр муутай олон малтай айлтай ойролцоо буугаад байж болохгүй байна шүү дээ. Энэ эхийнхээ сүүнээс дөнгөж салсан амьтдыг чинь ургамлын шимтэй сэргэг соргог бэлчээрт тун ч тогтоож урт хугацаагаар идээшлүүлж байж л жаахан тарга хүч авхуулахгүй бол хүйтэн өвлийг давж чадахгүй бүгд л нүд анх болно шүү дээ. Энэ мал чинь илгээлтийн эзэн Нарангаравын нэр дээр байгаа. Миний охин хоёр жил дараалаад сумын аварга болчихлоо. Хойтон бол аймгийн аварга болно шүү гэх зэргээр тайван ярихад эх охин хоёр ихэд ойлгов бололтой сэтгэлийн нь гомдол тайлагдав. Балдан гадаалж тэнгэрийн байдал сар мичидийг харж зогсонгоо амандаа аяархан

- Тэр Сагад тийм ч амархан хүн биш ээ. Тун их эрдэмтэй хүн дээ гэж шивнэв.

Нарангарав бүсгүй гэртээ ирээд аав ээжтэйгээ Вансэмбэрүү цэцэг бас Сагадын тухай ийнхүү хөөрөлдөн байхад Амархүү өвөөгийндөө их л чухал яриа өрнүүлж суув. Балбар өвгөн ач хүүгийнхээ Вансэмбэрүү цэцэг түүний өнгө зүс, ид шид, эрдэм чадлыг нь магтан ярихыг сонсоод дотроо

- Миний ач хүүгийн ухаан одоо л задарч байгаа бололтой. Юм юмыг сонирхоод бас уг үндэсийг нь мэдэхийг хичээдэг болсон нь сайн хэрэг. Уг нь өвөөгөө дуурайвал хоосонгүй л байх ёстой гэж өөрийгөө ч магтаад авав. Тэр энэ бодолдоо өөрийгөө шоолон дотогшоогоо инээгээд

- Өвгөн настай хүнийг чинь хэн л магтав гэж . Өөрөө өөрийгөө магтахаас биш бусад нь өтөл, сохор, дүлий гэхээс цааш хэтрэхгүй гээд бас өөрийгөө өмөөрөөд авав. Балбар сохор аятай гараараа тэмтрэн байхад нь Амархүү инээд алдаад

- Өвөө та миний дэргэд зүгээр л байгаач гэхэд Балбар өвгөн муухан инээгээд

- Сурсан юмыг сураар боож болдоггүй гэж үг бий. Өвөө чинь дөчин дөрвөн жил сохор явсан болохоор сохроороо л байхаас болшгүй нь ээ. Ганцхан чиний дэргэд нүдтэй болоод бусад үед сохор байгаад байж чадашгүй нь. Миний хүү л өвөөгөө нүдтэй гэдгийг мэдэж байгаагаас цааш өөр элдвийн юм огт хэрэггүй. Нүд анитлаа л сохроороо байя.

Би гэдэг хүн чинь сохортоо итгэсээр байгаад бүр сохорчихож. Сохор биш гэдгийг хорвоо дээр нэг ч гэсэн хүн мэдээсэй гэж хүсэж байсан. Одоо ач хүү минь мэдсэн болохоор болох нь тэр гэв. Амархүү өвөөгөөсөө асуух уу? Байх уу гэж эргэлзэж байснаа асуухаар шийдэв. Тэр өвөөдөө ойртож гарыг нь бариад

- Өвөө би танаас нэг юм асуух уу? гэхэд Балбар өвөө нь

- Миний хүү асуугаач. Өвөө нь мэдэх юм байвал хэлж өгье гэлээ. Амархүү баярлан түүний гарыг чанга атган

- Өвөө та яагаад сохор болсон түүхээ ярьж өгөөч гэхэд Балбар Амархүүг ажиглан ширтэж байхад нь ач хүүд нь үнэн сохор хүн шиг санагдав. Балбар өвгөн дотроо

- Би зөв таасан бололтой. Энэ хүүхэд юмны ул үндсийг мэдэхийг хүсэж байгаа нь сайн хэрэг. Надаас үүнийг асуух гээд байгааг царайных нь өнгө нүднийх нь харцнаас уншсан юм аа гэж бодоод сохрох болсон гашуун бөгөөд нууц түүхээ дахин нэг санагалзахад хүрэв.

- Арван зургадугаар жарны таван шар мэнгэтэй хар Бичин жил байлаа. Хаврын дунд харагчин туулай сард манайхан гурван гэрээрээ Босгын хөтлийн улаан хаданд хаваржиж байв. Тэр жилийн хавар хавсарга ихтэй төл маланд тааруухан байхаас гадна хүний өвчин элбэгтэй ялангуяа нүд барьсан томуу дэлгэрч хөгшин хөвөөгүй өртөж байлаа. Энэ гайхал өвчин ч манай гурван гэрийнхнийг тойрсонгүй дайраад авлаа. Бусад нь гайгүй би гэдэг хүн, манай нагацын нэг охин бид хоёрын нүд эдгэрэх нь бүү хэл ногоон идээ бээр цуваад уг руугаа хатгаж өвдөөд тэсэж суухын аргагүй боллоо.

Гэтэл Онын шовгорын их өтөгт Аажаа гэж авгайлдаг Авар гэдэг айлын охин Алаг төрөөд сар гаруй л болж байсан юм. Бусад нүд нь өвдсөн хүмүүс тэднийд очоод Алаг бүсгүйн хөхний сүүг нүдэндээ дусаалгаад зүгээр болсон гэж сонсоод аав маань нагацын охин бид хоёрыг дагуулаад Аажаа Аварынд очиж Алаг бүсгүйн хөхний сүүг нүдэнд дусаалгав. Тэр шөнөө хатгаж өвдөх нь гайгүй болов. Маргааш нөгөөдөр нь гээд гурван өдөр дараалан дусаалгаад нүдээ боогоод хэдэн өдөр гэртээ байлаа. Гэтэл нэг өдөр манай нагац манайд орж ирээд аавд

-Одоо яадаг билээ. Манай охины нүд юу ч харахгүй байна шүү дээ. Ядахдаа ганц нүд нь бол яахав дээ. Гайтай хөөтэй чамаас л боллоо. Чи л элдэв юм сонсож ирээд охиныг минь дагуулж аваачаад сохлоод хаячихлаа гээд л омогдож гарав. Аав ээж хоёр минь нагац ахын өмнө айж чичирч байв. Миний сэтгэл ихээр түгшиж байлаа.

- Миний нүд яасан бол гэж ихэд айж боодлыг нь авмааргүй санагдсан юм. Би гэрээсээ гарах гээд босож харайнгуут хаалганыхаа тотгыг мөргөж унаад тэр үедээ ухаан алдсан байв. Нэг мэдсэн толгой дээр хүйтэн жин тавиад л ээж маань уйлаад аав ээжийг аргадан

- Битгий усан нүдлээд муу ёрлоод байгаач. Эхнэр хүүхдүүдэд нь битгий хэлээрэй. Түр азнаж бай. Би тэднээс нь тусгаарлаж гурав хоног гэртээ байлгаж гам хийсэн ухаантай юм шүү дээ. Гурван хүүхэд нь ноололдоод нүд ам нь өвдчихвөл яалтай билээ. Дээр нь чи уйлж унжаад байвал бүр хэцүүднэ шүү дээ гэхийг нь сонсоод би хэсэг хэвтэж байгаад нүдээ бага зэрэг нээвэл бүдэгхэн гэгээ үзэгдэж байв. Би дахиад л нүдээ аньж орхив. Аав тэр оройгоо яваад оточ маарамба залж ирлээ. Эхлээд нагацынд бууж охиныг нь үзээд дараа нь аав гэртээ авчраад намайг үзүүлэв. Маарамба

- Энэ чинь манай дуганч банди шив дээ гэхэд аав миний өмнөөс

- Тийм ээ гэв. Маарамба хэсэг юм бодож байснаа

- Та нар хүн амьтнаас асууж байж хөхний сүүгээ дусаалгахгүй дээ. Дураараа загнаад ийм юм болж байгаа юм. Буруу өдөр буруу хөхний сүү дусааснаас болж хямралдсан байна шүү дээ. Тэгээд хоёр гурван удаа дусаадаг нь ч юу билээ. Ядахдаа нэг удаа бол гайгүй байхгүй юу. Одоо дотроосоо эм уугаад л ажиглаад бай. Өөр элдвийн юм дусаах хэрэггүй гэв. Балдангийн эцэг

- Бусад хүмүүсийн нүд нь зүгээр болчихсон болохоор дагуулж аваачаад дусаалгачихсан юм л даа. Манай хадам ах ч миний толгойг авах нь холгүй чойжин буугаад бэрх байна. Аргагүй биз дээ. Ганц охин нь хорвоог харах нүдгүй таг сохор болчихоор уурлах нь зөв л дөө. Би гэдэг хүн л хамаг гай зовлон тарьж орхилоо гэж уйлах шахам өөрийгөө хараан зүхэж байв. Маарамба

- Тэр удаан өвдсөн нүдэнд хөхний сүү дусаахаар ээдэж исэлддэг юм. Тэр исэлдсэн шингэн нь нүдний угийн үрэвссэн судас судлыг гэмтээнэ. Нарийн хялгасан судсыг бүр тасална шүү. Тэгээд хонь өдөр шүү гэв. Балдангийн аав

- Түүнийг чинь яаж мэдэх билээ дээ гэхэд маараба инээгээд

- Энэ дуганч уул нь дуулсан л баймаар юм даа. Хулгана өдөр мэргэ төлөг буулгадаггүй худал

хэлнэ, хонь өдөр эм тан барьдаггүй хор болно гэж бий дээ. За энэ ч яахав. Хэдхэн хоногийн өмнө Усан зүйлийн хүрээний өвгөн Хамба зуун арван нэгэн насыг зооглож байхад нь ногоон малгайтай гурван хүн ирээд нам төрийн эсэргүү том толгойлогч гэж нэрлээд бариад явсан чинь баруун жалганд нь аваачиж хороочихоод л яваад өгсөн гэнэ. Тэр гурван ногоон малгайтнуудад олон хүмүүсийн нэрс байгаа юм байх. Зуун арван нэгэн настай өвгөнийг хороож байхыг бодоход тэд нартай уулзвал амьд гарна гэж бодсоны ч хэрэггүй бололтой. Би ч гэсэн маргаашаас эхлээд элдэв юманд явахаа болиод зүгээр энгийн хар амьдралаар амьдардаг нь аминд өлзийтэй байх гэж ярихыг сонсож суусан Балбар олон зүйлийг бодож байлаа.

Нагацын охин бүл дүү маань сохорчихлоо. Нагац ах аавд хамаг гэм бурууг чихэж байдаг. Миний нүд зүгээр байвал аавыг санаатайгаар охиныхоо нүдийг сохоллоо гэх нь мэдээж. Намайг сохорчихвол сэтгэл нь жаахан аядаж аавыг буруутган үзэн ядахаа больж мэдэх юм. Бас хийдэд шавилж суугаад зэрэг хэргэм зүүж алба хашиж байсан хүмүүсийн нэрс байгаа бол минийх ч байх ёстой. Дуганч гэхийг хаях ёсгүй. Тэр чинь сүм хийдийн хамаг ном судрыг мэдэж хуралд оруулж буцааж янзалж байдаг номын санч хүн шүү дээ. Миний нүд сохорчихвол ногоон малгайтнууд сохор намайг яах бол. Уг нь амьд мэнд байж гурван хүүхдийнхээ гарыг нь ганзганд хөлийг нь дөрөөнд хүргэчих юмсан гэх зэргээр олныг эргэцүүлэн бясалгаад маргааш өглөө нь босоод нүдээ нээхэд бүдэг гэрэл биш бүр тод харж байлаа. Тэр огтхон ч баярласангүй. Харин сэтгэлд нь айдас хургаж уйтгар гуниг бүрхээд нүд нь бүрэлзэв. Тэр нүдээ дахиад чанга гэгч нь анив. Балбар дотроо

- Би сохрох ёстой. Яагаад гэвэл аавынхаа гэм буруугүйг баталж бүл дүү бид хоёрыг өвчнөөс нь салгах гэж сайхан сэтгэлээр бас мөс жудгаар авч явсан болохыг нагац болоод бусад хүмүүст мэдүүлэх ёстой. Нөгөө давхар санаа минь ногоон малгайтнуудаас амьд үлдэхийн тулд сохрох ёстой гэж бодоод сэтгэлдээ уярч хайлахад түүний нүднээс тасралтгүй хар нулимс урсаж байлаа. Үүнийг харсан эхнэр хүүхдүүд нь уйлалдан аав ээжээ дуудав. Балбарын аав сандарч орж ирээд

- Яасан бэ? хүүхдүүд минь гэхэд Балбар чимээгүйхэн уйлсаар байв. Аав нь Балбарыг тогтоож харахад хоёр нүднээс нь хар усан нулимс тасралтгүй гоожиж нүдний дотор гадна буланд нь ногоон нуух хурсан байлаа. Тэр

- Балбар аа. Миний хүү яав аа гэхэд Балбар аяархнаар

- Аав аа миний нүд юу ч харахгүй таг сохорчээ гэж хэлээд хоёр нүдээ гарынхаа алгаар дараад удаан гэгчээр нухлав. Балбарын аав их дуугаар

- Ээ халаг минь. Ийм сайхан хүүхдүүдийнхээ нүдийг нь би сохолчихлоо. Над шиг амьсгаа нүд анивал таарна гээд орь дуу тавин орилж гашуудан уйлав. Энэ дуунаар нагац, бэргэн хоёр нь орж ирээд учрыг мэдээд өсөрхөж хорсож байсан сэтгэл нь зөөлөрч Балбарын аавыг ихэд өрөвдөж өөрсдөө даган уйлж

- Одоо яая гэхэв. Орилж чарлаад нүд орчих юм биш. Бидний л үйлийн үр, лай ланчиг юм байлгүй дээ. Ядахдаа нэг нүд нь сохорсон бол яая гэхэв. Тэгтэл заавал хоёулангийнх нь хоёр нүд хоёулаа сохордог нь юу ч билээ дээ. Одоо яах ч арга байхгүй. Амь нас алд бие нь бүрэн бүтэн байгаа болохоор бас ч учиртай. Амьд хүн аргатай гэдэг. Арга нь олдох бий. Аль сохор

хүнийг хэлж барахав гэж сэтгэлээ засаж зүрх зориггоо чангалсан билээ. Балбарыг уртаар амьсгал авахад нагац ах нь

- Миний хүү одоо тайвшир. Гурван хүүхэд чинь, хань чинь, ах дүү нар чинь байхад орчлон хорвоод нүдгүйдэхгүй шүү гэж сайхан үг хэлээд Балбарын баруун хацрыг үнсэхэд шорвог амтыг мэдрээд их харамсаж байгаа бололтой санаа алдаад түүний зүүн далан дээр баруун гарынхаа алгаар аяархан хоёр удаа алгадав. Балбар дотроо

Аав ээж, ах дүүс, ураг төрлийхнөө хууран мэхлэж байгаадаа ихэд гэмшиж байсан ч тоонот гэрт багтаж тогоотой хоолондоо амтархаж дутуу дулимагаа биеэрээ нөхөж дундуур сохроо сэтгэлээрээ дүүргэдэг, мах ясаараа барьцалдсан, улаан цагаанаараа сүлэлдсэн ахан дүүсийн эв түнжин эвдэрч, тангараг дамцаг тасран, хүний орчлонд байхгүй бузар булай, муу муухай өс хонзон зангилагдаж байсныг тайлж бие биеэ түшин сэтгэл зүрхээрээ нэгдэн эвийн мод мэт эвлэж чадсанд нь баярлаж байлаа. Тэр өдрөөс эхлэн Балбар сохорч долоо хоноод сохор Балбар хэмээх цол нэрийг олон түмэн хайрласан билээ. Балбар эхний нэг сардаа сохор хүн болох гэж ихээхэн зовлон эдэлсэн. Урд нь чулуу байхад тээглэж унах ёстой байтал дээгүүр нь алхах юм уу эсвэл морь малын өнгө зүсийг, энд тэнд байгааг нь хэлэх шахаад хэлээ хазна. Нэг удаа Балбар хүү Галсангийнхаа идэж байсан хөгшин боовных нь хамт уртаас урт хялгас ам руу нь ороход

- Хүүе ээ. Миний хүү хүлээж байгаарай гээд хялгасыг авч өгөхөд Галсан ихэд гайхан

- Аав аа та намайг харж байгаа юм уу? гэхэд ихэд сандран

- Үгүй ээ. чамайг яаж харах билээ. Аавын чинь нүд одоо л гартаа орж байх шиг байна гэхэд Галсан

- Өө тийм үү гэж хэлээд гэрээс гарангуутаа өвөө аавдаа

- Өвөө та сонсооч. Манай аавын нүд гартаа орж байгаа юм уу? гэхэд нь өвөө нь

- Хүмүүс тэгж ярьдаг юм билээ. Аавын чинь нүд гартаа орвол сайнсан. Ядахдаа ойр зуурын юмаа гараараа бариад өөрөө оролдоод сурчихвал ашгай юу гэхэд Галсангийн санаанд байсан аавын сохор нүдний эргэлзээ нэг мөр алга болж

- Аавын нүд гартаа ороосой гэж сэтгэлдээ залбирсан удаатай билээ. Балбар сэтгэлдээ

- Би сохор хүн шүү гэж итгэл үнэмшлийг бий болгож чадсан учир удалгүй сохор хүний дүрд сайн тоглож хэн ч харсан сохор хүн байна гэж үнэмшихээр боллоо. Гэтэл хойтон жил нь ногоон малгайтай дотоод яамны хоёр хүн

- Балбарынх хаана байна гэж нутгийн хүнээс сураглахад тэр

- Аан. Сохор Балбарынх уу? Их салааны аманд байгаа гэхэд яамны хүмүүс

- Тэр нөхөр гэртээ байгаа болов уу? гэж асуухад нь

- Тэр сохор амьтан чинь хаашаагаа явах билээ дээ. Бие засахаас хэтрэхгүй хөөрхийлөлтэй хүн бий гээд сохор болсон түүхээс нь товчхон ярьж өгөв. Нутгийн хүн Балбарыг барихаар явааг мэдэх учир ийнхүү өрөвдөлтэй амьтан байдаг гэдгийг сайн ойлгуулаад авсан нь энэ. Тэр

- Та бүхэн албаны хүмүүс бололтой. Би зам зааж өгье дөө. Манайх энэ булгийн эхний хоёр гэр. Очиж цай ууж хоол идээд яваач гэж урив. Албаны хоёр хүн ч дуртай нь аргагүй зөвшөөрөв. Хоёр зочноо их хүндэтгэн дайлж цайлж байх зууртаа гэрээсээ орж гаран аргал түлш оруулах үедээ хүүхдээ мордуулж Балбарт хэл чимээ хүргүүлэв.

- Манайд хоёр ногоон малгайтай хүн ирлээ. Чамайг зорьж иржээ. Бодолтой байгаарай гэжээ. Балбар ч хэл авангуутаа Бурхан тахил, ном судраа хурааж нохойны хэвтрийн ойролцоо байх хөмөрсөн хөөтэй тогоон доогуур хийж өтгөн шингэний муу данх саваа тавьж үстэй дээл нөмрөөд нүдээ нухлаж улаан болгоод нүүр амаа халтартуулан царай зүс муутай ядруу дорой амьтан болоод хэвтэж байв. Нутгийн нөхөр хоёр төлөөлөгчийг дагуулсаар Балбарынд ирж буув. Тэр гуравыг гэрт ороход Балбар хэвтсэн хэвээрээ

- Хүүхдүүд минь цаад мал ахуйгаа харж эргүүлж тойроорой. Намайг эргүүлдээд юу хийнэ. Би саяхан данхандаа морь харчихсан гэв. Хоёр төлөөлөгчийн ахалж яваа залуухан эр ам хамраа даран байхад дагаж яваа ахимаг насны хүн

- Бид нар таныг зорьж ирлээ. Та дуганч Балбар гэдэг хүн мөн үү? гэв. Балбар

- Тийм ээ.би мөн байна. Хүүхдүүдийг дуудаж хоол цай барихсан гэхэд нутгийн хүн ярианд оролцож

- Балбар аа сайн байна уу? Танайхан хаачаав гэхэд Балбар дуугаар нь танив бололтой

- Өө чи хүрээд ирсэн юм уу? Манайхан мал ахуйдаа явсан юм болов уу даа гэхэд залуу төлөөлөгч тэдний үгийг тасалж

- Та бидэнтэй ярина шүү. Хоол цай хэрэггүй. Та л хэрэгтэй байна. Дуганч гэдэг чинь юу хийдэг хүн бэ? гэж асуухад Балбар чихээ тавин анхааралтай сонсоод

- Өө би хэлээд өгье. Дуганч чинь дуганын гадна, доторхийг цэвэрлэнэ. Өглөө хурал эхлэхийн өмнө, өдөр хурал гадаалсны дараа цэвэрлэнэ. Их гэсгүй шалгаад муу байвал бэрээгээр нь жанчуулаад дахиад цэвэрлэдэг байлаа гэхэд ахимаг настай нь

- Та юу сурсан бэ? гэлээ. Балбар

- Сураад гийгүүлсэн юм бараг байхгүй дээ. Ямар сайндаа л дуганын цэвэрлэгээнд тохоогдох билээ дээ гэхэд ахлагч нь

- Тэгээд таныг чинь яагаад хувьсгалын эсэргүү том толгой лам нартай хамт нэрийг чинь заагаад байдаг билээ гэв. Балбар нүдээ нухлангаа

- Тэр ч бас аргагүй байх аа. Их гэсгүйд захирагдаж дуган цэвэрлэдэг болохоор Дуганч гээд бичихээр миний нэр орсон юм болов уу? гэхэд ахлагч нөгөө төлөөлөгчдөө хандан

- Та энд бурхан тахил, ном судар байна уу үгүй юу гэдгийг нэг сайн үзээдэхээч гэлээ. Гэрт байгаа авдар сав, гадаа хураалттай бараа, тэр битгий хэл овоолсон аргалыг нь хүртэл самарч үзээд ахлагчдаа
- Юу ч юм алга. Наад нөхөр чинь хог шороо цэвэрлэхээс илүү гараагүй бололтой гэхэд ахлагч нь
- За тийм байдаг байж. Та бидэнтэй явна даа. Түргэл гэлээ. Нутгийн хүн бараг л уулга алдах шахав. Тэр дотроо
- Би Балбарт гай тарьчихлаа. Одоо яадаг билээ. Намайг л зааж өгөөд хоёр хүн дагуулаад ирсэн гэнэ. Тус болох гэсэн биш ус болчихлоо гэж бодож байхад Балбар огт тоосон шинжгүйгээр
- За байз. Хүүхдүүд байдаггүй. Миний муу хашин хүрэн гадаа байна уу? гэж асуухад нутгийн нөхөр нь
- Хүрэн морь гадаа байна билээ гэж буруу хэрэг хийсэн аятай гэмшингүй хэлэхэд Балбар
- Би ч морин дээр гараад нэг суучихвал яваад л байна. Манайхныг ирэхээр учрыг сайн ойлгуулаад хэлчихээрэй гээд үстэй дээлээ өмсөв. Ахимаг настай нь
- Энэ хүн ч та бид хоёрт айхын бараа идэхийн нэмэр л нөхөр байна даа гэхэд залуу дарга
- Тэгвэл энд нь гүйцэтгэж орхих уу? хэмээн сүр үзүүлж гар буугаа гэрнээс нь гаргахад ахимаг эр нь
- Ардын гэрт буу дуугаргаж яаж болох билээ. Бид чинь ардын засгийн төлөөлөгч нар шүү дээ. Ахлагч аа. Та саяхан зовлон зүдгүүр үзсэн болохоор огт болохгүй. Ийм юм бүр харахын ч хэрэггүй. Энэ ажлыг надад даалгачих гэлээ. Ахлагч хэсэг бодлогоширч байснаа толгойгоо дохин зөвшөөрөв. Ахимаг эр
- Ахлагч та энэ нөхрийнд очоод байж бай. Би Балбарыг аваад ажил үүргээ гүйцэтгэе гээд дөрвөн морьтон гэрийн гаднаас хөдөлж хоёр нь баруун урагшаа айл руу явахад Балбарыг хөтөлсөн ахимаг эр хойт хамраар давж одов. Балбар дотроо
- Эхнэр хүүхдүүд байхгүй байсан нь онолоо. Шороонд булагдана уу, шоронд хатна уу? Аль нь ч байсан хамаа алга. Уг нь гайгүй болов уу гэтэл ингээд балраад баривчлагдаад явдаг байж гэж бодож явлаа. Өндөр хамрын арын том том хадан дунд аваачаад Балбарт
- Мориноосоо буу гэж тушаав. Тэр цааш нь
- Битгий тэнэг юм хийгээрэй. Шөнө болохоор гэртээ харина биз гэв. Балбар тэр эрийг бариад авбал элбэг дороо хийгээд цааш нь яах вэ гэж бодож явсан чинь энэ үгийг сонсоод бүр гайхаж орхив. Гэтэл тэр төлөөлөгч хүрэн морины цулбуурыг чиргүүлээд
- Чуу гэж чанга хэлээд цавь өөд нь ташуураар хатгаад үргээв. Гэнэт буун дуу тас хийгээд ойролцоох тарваганы тошны шороо манасхийгээд явчихав. Энэ чимээгээр нөгөө хоёр морьтон

эргэж харвал Балбарын унаж явсан хүрэн морь цулбуураа чирэн гөлмөө дэрвүүлэн гэрийнхээ гадаа очиж яваа харагдав. Ахимаг төлөөлөгч

- Амаа бөхлөж, амиа хичээж яваарай. Миний хэлснийг мартав аа гээд мордов.

Балбар муу сохор нүдээрээ амь аварсан ачтанаа мартахын аргагүй сайн гэгчээр харж царай зүсийг нь тогтоож авав. Хоёр төлөөлөгч зорьсон хэргээ бүтээсэн болохоор тэр даруйдаа ирсэн замаараа буцав.

Харин Балбар буудуулаад үхсэн аятай хоёр том хадны дунд дээш харан хэвтээд сохор нүдээ мартан тэнгэрийг ханатлаа ширтээд ааг ихтэй ургамлыг зулгааж авчраад амандаа хийн зажилж байлаа. Амьд байх гэдэг юутай үнэ цэнэтэй болохыг зүрх сэтгэлээрээ мэдэрч бүлээн шунх нь бүтэн биед нь буцалж байв.

Гэтэл хонь хурга, адуу малдаа яваад ирсэн хүмүүс Балбарыг байхгүйд гайхаж байтал нутгийн хүн ирж болсон явдлыг хэлээд бөөн үймээн уйлаан майлаан тарьж орхив. Тэрвээр

- Би л буруутай. Ингэнэ гэж огтхон ч санасангүй. Би байгаа юмаараа дайлж цайлж бас Балбарыг ардын хувьсгалын эсэргүү биш гэж их л тайлбарласан юмсан. Тэгээд хүүхдээрээ хэл хүргүүлж өөрөө биеэрээ дагуулж ирсэнээ ч бүгдийг тайлагнан гашуудан үглэв. Ойр дотнын хүмүүс цугларч Балбарын аав

- Хэрэг ийм болчихсон учир яалтай билээ. Миний муу сохор хүү яасан ч хүнд заяатай байсан юм бэ дээ. Хөөрхий дөө. Энэ гурван хүүхдийн заяа түшсэнгүй дээ гэж халаглаад

- Нар жаргаж харанхуй болох нь. Бушуухан эрж хайж цогцосыг нь олъё гээд хэдэн эрчүүд дагуулан мордон давхилаа. Тэд биржрүү их хадан дунд эрсээр байгаад шөнөтэй золгож тал сарны бүдэг гэрэлд эрлээ үргэлжлүүлсээр байлаа. Гэтэл морьтой хүүхэд ирж тэдэнд

- Аав гэртээ хүрээд ирсэн гэж цовоо цойлгон чанга дуугаар тодоос тод хэлэв. Уй гашууд автагдан уйлж унжиж байсан бол уулзаж учраад амьд байгаад нь баярлаж бас л сэтгэлээ хайлуулан уярч зүрх сэтгэлдээ гэрэл гэгээ цацрааж нүүр нүдэнд нь баяр баясгалангийн солонго татна. Балбар

- Намайг бурхан аварсан гэхээс өөрийг хэлсэнгүй. Харин бурхан тахил, ном судраа хөмөрсөн тогоон дороос авчруулав. Нутгийнхаа анд нөхрийг дуудуулан түүнд

- Баярлалаа гэж хэлээд тэвэрч авахад хоёр сохор нүднээс нь тунгалаг хөх нулимс урсаж байв. Би буруутан гэж халаглан өөрийгөө зэмлэж байсан нөхөр нь одоо Балбарт бурхан болон хүндлэгдэж байгаа нь их ухаарал эрхэм ёс жудаг билээ. Балбар сэтгэл зүрхээрээ сохор болсон нь ах дүүс, ураг төрлийн эв эеийн их тангарагийг аварсан бол алтан амь алд биеийг нь аварч үлдээв. Хүний оюун ухаан холыг харж чадвал хожмын үйл хэрэг ийнхүү өөрөө бүтдэг ажээ.

Хорин тав

Амархүү өвөө ааваасаа сохор болох болсон тухай аймшигтай бас гайхамшигтай түүхийг сонсоод бахархаж суулаа. Энэ хүнийг харахад сохор мэт боловч бүхнийг тольдож сэтгэлдээ бясалгахаас гадна номонд шимтэн оюуныхаа мэлмийг гийгүүлж бясалган амьдралыг арван зүгээс нь шинжиж дүгнэж суухын тулд ганцаараа аж төрдгийн учир энэ байлаа. Өтөл настай мөртлөө гэртээ ганцаараа байхад нь хүүхдүүд нь санаа зовон хэн нэгнийг хань болгон хамт байлгах гэхэд ихэд дургүйцэн

-Надад хэн ч хэрэггүй. Би ганцаараа байна. Хүүхдүүд нойр хүргэдэггүй шуугилдаад түвэгтэй байдаг юм гэж уцаарлахад нь

-Аргагүй байх даа. Нас ахисан сохор хүн чинь уур уцаар ихтэй зожиг зөрүүд болчихдог гэсэн үнэн юм байна. Өөрийнхөө зөнгөөр байх нь өөрт нь амар байдаг байх гээд ганцааранг нь байлгана. Өвгөн ч ингэж байхдаа их дуртай.

Балбар өвгөн байгаа биеэрээ түмэн хуйлаастай ном мөн байлаа. Түүнийг ач хүү Амархүү нь ингэж нэрлэсэн нь өгүүлшгүй үнэн билээ. Нар холдож саран ойртох намар цаг болоод Амархүү Нийслэл рүү сургуульдаа явж Балбар өвгөн Авирмэд гавжийн тухай хараахан гүйцээж амжаагүй дурсамжаа сэргээж түүхийн хуудсыг дахин сөхөж дэлгэв.

- Талийгаач Манлайн буяны үйл мөр нь болоод өнгөрсөн ч үлдсэн хүмүүстээ хүндхэн тусав. Таван хүүхэд нь таван өөр гуниг гутрал тээж байлаа. Аргагүй эцгийн оюун билэгт зангилагдаж байсан уяа тайлагдангуут өөр өөрийн заяа төөрөг хүсэл мөрөөдлөө дагахын тулд бодол бясалгал нь ийнхүү салан одох нь зөв бололтой.

Агваанням хамба аавынхаа үхэлд эргэлзэж ац бодолд зовж шаналж байлаа. Уушигны архаг үрэвсэл, багтраа өвчинтэй байсныг нь гэрийнхэн нь бүгд мэднэ. Заримдаа ханиалгаад таг чимээгүй болоод нүүр ам нь хөхрөн нус нулимс нь гоожоод тонгойгоод хэсэг болсноо нэг юм амьсгаа авдаг, эсвэл дал нуруу руу нь хүчтэй цохидог байсныг сайн санаж байлаа.

Гэтэл хамт явсан Авирмэд гавжид агсам тавьж үгээр дайрч доромжилсон бас үр хүүхдээрээ баярхаж сагсуурсан. Шөнө хамт явж байгаад айлд хөөргөө мартсан байна гээд ганцаараа буцсан. Тэгээд айлд очоогүй хээр нүд аньсан байдаг. Гэтэл хөөрөг нь өвөрт нь байсан гээд юм юмыг бодоод байхад аавынх нь үхэлтэй гавж багш нь холбоотой мэт санагдана.

Дүү Гунгааням нь эхнэр авч хадмынхаа хаяа бараадна, мал хөрөнгөө тасалж авна гэж сүржигнэнэ. Түүний дүү Батням нь бор дарсанд дурлан айл хэсэх нь ихдэж ажил хийх нь багадаад байлаа. Батнямын дүү Отгонням л мал ахуйгаа хариулж хамгаалж хамаг ажлыг амжуулна. Ганц охин дүү Дэжиднямын нөгөө унаж тусдаг өвчин нь үе үе хөдөлж ээжийгээ сандаргана. Удвал энэ бүхэнд байнга санаа зовж байсан ч үглэж уйлахаас цааш үл хэтэрнэ. Хааяа Авирмэд гавжийнд очиж зовлон жаргалаа хуваалцана. Удвал Үзмээд ярихдаа

-Бидний амьдралын утга учир үйлийн үрийн зангилаа манай талийгаач байсан бололтой. Энэ хэдэн хүүхэд миний санаанд хүрэхгүй бололтой. Аргагүй юм байлгүй дээ. Би биеийг нь

төрүүлж гэдсийг нь өлсгөөгүйгээс өөр өөдтэй юм хийсэн ч биш дээ. Бага хоёр нь надад хань бараа болж байх юм. Зундуй маарамба надад

-Дэжиднямын эм танг нь байнга уулгаж бай. Тэгвэл гайгүй. Уухгүй бол унаад л байна шүү дээ гэсэн гээд уг нь унахгүй бол сайн юмсан гэж бодол болон байснаа

-Удвал аа. Дэжидням өсөж том болж байна. Одоо арван долоотой билүү? Чамд анхааруулж хэлэхгүй бол болохгүй чухал зүйл байна. Би олон удаа бодоод чамд хэлэхээр шийдлээ. Энэ охин том болоод төрж хөнгөрч чадахгүй бололтой. Үүнийг сайн анхаардаг юм шүү гэсэн гээд л уйлав.

Удвалын уйлхайг дагаад Үзмээ ч мөн уйлав. Авирмэд санаа нь зовохдоо түргэхэн гэрээс гарна. Сүүлдээ хоёр эхнэрийн яриаг сонсохоосоо халширч гадуур байх ажлаа амжуулна. Удвал Авирмэдэд хандан

- Та л хэдэн хүүхдийг минь харж хандан зааж сургаж эцгийнх нь оронд эцэг болж яваач. Талийгаач маань хэний ч үгэнд ордоггүй ганцхан таны л үгэнд орж таныг түшиж үргэлж ярьж дурсдаг байсан хүн шүү дээ. Хүүхдүүд маань ч таныг их хүндэтгэж аавын дүү гавж ах гэж байнга л ярьцгаадаг. Би яахав. Баян Цэмбэлийн ганц охин гэж тосонд бялуурч, торгонд хөрвөөж өссөн тэнэг мунхаг амьтан шүү дээ.

Хүний ам харсаар байгаад хөшөө чулуунаас ялгарах юм надад алга. Ийм заяа муутай амьтнаас чинь үр хүүхдүүд нь үргэж хөндийрөх нь аргагүй шүү дээ. Манай өвгөн чинь том бага хоёртоо гар хүрэхгүй, дунд гуравт бол үе үе таван салаа боовны амтыг сайн мэдрүүлдэг байсан. Одоо тэр нь дутагдаад байх шиг байна. Манай Агваанням дүү нартаа ч юм хэлэхгүй дүлий дүмбэ оргисон бодолдоо дарагдаж хөмсгөө овоолсон нэг хүн л байх юм. Юугаа бодож бясалгаад байдаг юм бүү мэд гээд л аргадаж гуйсан өнгө аялгаар хүүрнэхэд Авирмэд

- Та санаагаа бүү зовоо доо. Таньд л болж бүтэхгүй санагдаад байгаа байх. Одоо хүүхдүүд өсөж том болцгоолоо. Алив юмс чинь мөнх бус болохоор байнга хувирч өөрчлөгдөж байдаг нь энэ хорвоогийн жам шүү дээ. Өндөг хүртэл хагараад дэгдээхэй болж өд сөд нь ургаж гүйцээд нисэн оддог нь үнэн бол шувууд жигүүртэй учир тэнгэрт өндрөөс өндөрт нисэж чаддаг ч эргээд зайлшгүй газартаа л буудаг юм. Тийм болохоор ээждээ эргэж ирдэггүй үр хүүхэд байдаггүй гэдэг үнэн шүү дээ. Хүүхдүүд нас бага цус шингэн ухаажиж гүйцээгүй болоод гэнэн тэнэг байгаа хэрэг гэхэд Удвал санаа алдаад

- Тийм байх аа даа. Манай хүн мөн ч нөмөр нөөлөгтэй түшиг тулгууртай байсан юм даа. Байгаа үед нь ганц ч урмын үг хэлж чадаагүйдээ харамсах юм. Өнгөрсөн хойно нь сангалзахаас хэтрэхгүй юм даа гэв. Үзмээ эрхээ эргүүлэх зуураа

- Ээ бурхан минь. Үхэл хагацал шиг хэцүү юм байдаггүй дээ. Би ч эхлээд ээжийгээ дараа нь эцгийгээ алдахад мөн ч хэцүү байсан. Энэ хүний сайхан сэтгэл, тус дэм байгаагүй бол би яах байснаа төсөөлж чаддаггүй юм. Би олон шөнө нойргүй хонож олон ч дахин бодоод

- Энэ хүнээс л салж болохгүй. Заяаны хань ч болно уу, зарц барлаг нь ч болно уу хамаагүй дэргэд нь байж бие сэтгэлээ зориулж энэ насыг барья гэж шийдсэн дээ гэж Авирмэдийг

хараад сайхан инээмсэглэв. Үзмээгийн энэ ярианд уярсан Удвал бас л нүдээ аргадаж суугаа нь дэндүү өрөвдөлтэй харагдаж байв.

Уйтгар гуниг хүний зүрх сэтгэлийг ийнхүү эзлэх нь эр хүний сүлд хийморийг дарж доройтуулдаг бол бүсгүй хүний заяаг хэлтийлгэдэг бөгөөд зовлонгийн нэг үндэс болдог билээ. Энэ үндсийг тасалж хаяхын тулд өнгөрсөн зовлон зүдгүүрийг мартаж зүрх сэтгэлээ ариусган шинэ бүхнийг эрэлхийлж өөдрөгөөр сэтгэж аливаад ухаалгаар хандах ухаан хэрэг болно. Энэ ухаанд хатуужил, тэвчээр, хайр халамж, хатан зориг бүгд л багтаж байдаг.

Энэ бүхэн Удвалд дутагдаад байгааг Авирмэд мэдэж байлаа. Эл ярианаас хойш хоёр жил аль хэдийнээ өнгөрч одон өмнөх үйл мөр мартагдаж байхад Агваанням хамбын эргэлзээ улам лавшран аавынхаа найз өөрийнхөө багш Авирмэд гавжтай өс зангидах хүртлээ өсөж өндийсөн байв. Энэ хэрээс хэтэрсэн бодол санаандаа Агваанням хамба итгэл үнэмшилтэйгээр хөтлөгдсөн байлаа. Хамба аавынхаа үхлийн талаар ац бодолд эргэлзэж байгаад нэгэн өвгөн ламаас

-Манайд маш сайн мэргэн хүн байна уу? Надад хэрэг болоод байна гэхэд өвгөн

- Есөн зоосондоо донир байсан Готовыг сайн гэдэг юм даа. Готов ч харахад харчгар ч гэсэн шидтэй золиг байгаа юм шүү гэж магтаад авсан билээ. Агваанням хамба Готовыг дуудаж авчраад

- Та надад зоосоо гүйлгэж нэг тус болооч гэхэд үрчгэр гараараа шанаагаа маажиж байснаа

-Юу юм бэ дээ. Хамба минь. Миний зоосыг бараг худал хэлдэггүй л гэдэг юм. Таньд бол дуртайяа туслана шүү. Та надад юун тухайгаа сайн тайлбарлаад өг. Би учрыг есөн зоосондоо шивнэж шившлэг хийх хэрэгтэй болно гэв. Агваанням аавынхаа үхлийн шалтгааныг нэг бүрчлэн яриад өөрийнхөө багш Авирмэдтэй холбож үзэж байгаагаа ч бас л тайлбарлав. Готов

- Аав чинь хөөргөө айлд мартаагүй байсан гэв үү? гэхэд Агваанням

-Тийм ээ. Өвөрт нь байж байсан гэнэ. Бас дэргэд нь хоёр ч морины мөр байсан. Багш болохоор

- Аав чинь хөөргөө аваад ирье гээд буцсан. Би дагаж яваагүйгээс л ийм юм болчихлоо гэдэг. Зундуй маарамба болохоор

- Уушигны архаг үрэвсэл, багтраа өвчтэй байсан. Энэ өвчин сэдэрснээс амьсгал түгжирч насан өөд болсон байна гэж үзсэн. Тэр ч үнэний талтай л юм билээ. Чухамдаа юунаас болов гэдгийг л мэдэх санаатай юм л даа гэхэд Готов

- За мэдлээ. Хамба аа. Би зоосондоо шившлэг хийе гээд зоосоо амандаа ойртуулаад нүдээ анив. Тэр дотроо

- Энэ хорвоогийн юм бүхэн ээлж дугараатай байдаг даа. Уулзахгүй гэсэн ч хувь тавилан Авирмэд бид хоёрыг дахиад уулзууллаа. Бурханы таалал юм байлгүй дээ. Би ёсчлон дагах

болно гэж бодоод зоосоо гүйлгээд л шууд хураачихав. Агваанням дотроо

- Яасан ч хурдан гүйлгэж хураадаг юм гэж бодож суутал Готов

- Хамба аа. Таны эргэлзээ бүрэн тайлагдлаа. Эргэлзэх юмгүй хоёулаа үнэн байна. Үхэлд хүргэсэн өвчин нь үнэн байхад өвчний ад донг хурцалж өгсөн амьсгалыг нь боосон Авирмэд бас үнэн байна гэлээ. Агваанням Готов өөд мэлрэн ширтэнэ.

- Энэ зоос үнэхээр сонин юм айлдлаа. Эргэлзээ байхгүй хоёулаа үнэн гэдэг чинь л үнэн болж байна. Миний санаанд яагаад ингэж буусангүй вэ? Зөвхөн аль нэг нь үнэн байх ёстой гэж бодоод байсан нь миний гэнэн тэнэгийн гай бололтой. Би ч болоогүй л байна даа. Багш надад

- Чи сурах ёстой юмаа арай л дутуу орхичихлоо доо. Одоо яая гэхэв гэж хэлж байсан нь санаанд нь бас орж ирэв. Би өвгөн Хамба багшийнхаа захиасыг биелүүлэх гэж их яарснаас бас энэ суудалд суух гэж хэт дурласнаас болж гавж багшийн үгийг огт хэрэгсээгүй өнгөрч билээ гэж бодов. Готов өөрийг нь ширтэж байгаа хамба Агвааннямын харцнаас есөн зоосны хэлэнд тун ч сайн итгэж байгааг нь олж хараад дотроо

- Готов хүү ч тийм ч амархан хоол биш шүү. Зоос бол голдоо нүхтэй хоёр талдаа бичигтэй зэс бас гуулин төмөр шүү дээ. Харин Готов бол холын бодолтой, ойрын мөлжүүртэй хохимой толгойтой сэтгэлдээ сэлмээ ирлэж дургүй хүргэсэн заримынх нь духанд нь тэмдэг тавьж явдаг их эр ээ гэж өөрийгөө өргөмжилөн бодлоо. Тэр

- Хамба аа. Та юугаа бясалгаад таг чиг болчихов оо гэхэд Агваанням

- Готов гуай таны зоосны мэргэн хэлэнд би итгэж байна. Та энэ мэргийг маш сайн эзэмшсэн байна шүү. Таньд баярлалаа гэхэд нь Готов инээмсэглээд

- Манай Авирмэдийг өөртөө л зөв хүн гэж манайхан хэлдэг юм билээ. Гэхдээ өөртөө зөв байхаас гадна өрөөлд их халгаатай болсон юм шиг санагддаг юм. Тэнгэр ууланд болсон аюулаас чинь нэг манж нь энд ирээд Улиастайн амбан руу явсан шүү дээ. Тэр ярихдаа

- Хай манай муу түшмэлийн нуруу нь хугараад гавал нь задраад тархи нь модны хожуул дээр ялцайгаад хэвтэж байсан шүү. Ээ бүү үзэгд. Хэлэхийн арга байхгүй шүү. Танай төлөөний хүн нөгөө гавжийг оролдоод янз бүр болсоор байгаад өөрийгөө дуусгасандаа хөөрхий. Танай тэр Авирмэд ч их эрдэмтэй айхтар хүн дээ. Одоо хүртэл нутагтаа ирээгүй юм уу? гэж асуухад нь

- Ирээгүй шүү дээ гэхэд

- Ямар сонин юм бэ? гурван хавирга нь хугарч, хэвлий нь ярагдан шархадсан бас их муухай ханиалгаж байсан даа. Тэр хүн тэгвэл бас л нүд аньсан болж таарах нь дээ гэсэн шүү дээ. Тэгээд л хойтон жил нь эхнэр аваад ирж гэнэ. Хүрээ хийдэд суухгүй юм гэнэ гэж дууддаж байтал жинхэнэ хэргийн эзэн хэнгэрэгийн дохиур болсон Их гэсгүйг хялбархан аваад залсан шүү. Тэгээд л би өөртөө зөв байсан ч өрөөлд халгаатай болж дээ гэж бодсон шүү хэмээн ярив. Тэр

- Өөрийнхөө буруугүй гэдгийг залуу Хамбад хүргэн үнэмшүүлэх, нөгөөтэйгүүр Хамбыг багштай нь эв эвдрэлцүүлж хонь чоно болгон хоёр биеэ үзэн ядаж өс зангидуулахыг хүсэж байлаа. Агваанням дотроо

- Би ер нь яавал зохилтой вэ? Багш шавийн барилдлага гэдэг тийм ч хялбархан салгачихдаг юм биш. Бас аавын минь багынх нь ганц найз нөхөр нь. Хүү нь миний шавь. Тэгсэн мөртлөө бараг надад багшилна. Ээж дүү нар минь Авирмэд багшид итгэж шүтдэг хүмүүс.

Гэтэл гэм зэмгүй цагаан цайлган сэтгэлтэй архи ууж олон үг хэлэхээс өөр буруу зөрүү үйл мөргүй аавын минь амь насанд хүрчих гэж дээ. Ямар хэцүү юм бэ? Үүнийг мэдсэнээсээ мэдээгүй нь дээр байж дээ. Одоо би яах вэ? гэж өөрөөсөө асуув. Тэр өөрөө хариулаагүй байтал Готов ийнхүү хариулав.

- Хамба та залуу хүн. Багштайгаа тэрсэлдээд та л хохирох болов уу. Гэхдээ судар номонд аавын амийг хөнөөсөн хүнийг хэзээ ч өршөөж болохгүй. Тийм заналт дайснаа өөрөөс нь эхлээд үр удмыг нь үгүй болговол зохилтой гэж бичээд доогуур нь улаанаар зурж тодотгон тэмдэглэсэн байдаг юм гэхэд Агваанням

- Заавал улаан өнгөөр зурдаг нь ямар учиртай юм бол гэж асуухад Готов

- Нэгд. Мартаж болохгүй гэдгийг сануулдаг. Хоёрт цусыг цусаар хариул. Гуравт. Амины төлөөсөнд амь хэрэгтэй гэдгийг бүү март гэсэн зарлиг юм гэнэ лээ гэж хэлээд гэм зэмгүй царай гарган алсуурхан Хамбын бодлыг уншихыг хичээнэ. Хамбын гүрээний судас бүдүүрч шанааны булчин нь гүрэлзэн нүдэнд нь улаан туяа сууж өс зангидаж байгаа нь илэрхий байлаа. Готов дотроо

- Би одоо арга замыг нь заагаад өгчихвөл залуу хамба гэнэн тэнэгийн харгайгаар насны залуу цусны шингэнээр зоригтойхон юм хийнэ биз дээ.

Авирмэд гавж аа. Давахгүй гэсэн даваагаар гурав давдаг юм гэсэн. Би хоёр дахиа давах гээд үзье дээ гэж бодож суулаа.

Агвааннямын нүдний харц хурцлагдан сэтгэлд нь өс хонзонгийн түймэр дэгдэв. Тэр түймрийн галанд түлэгдэж байгаа бололтой духанд нь хөлс бурзайж хөмсөг нь хоёр талаасаа нийлж овоороод гараа зангидаж шүдээ зууж хавирахад ёолж байгаа мэт хяхатнах чимээ гарч байв. Өс хонзон ингэж хүчтэй зангидахыг харж суусан Готов ч өөрөө айх шиг болов. Чөтгөр Готов чөргөр гараараа хорчгор нүүрээ арчаад уртаар санаа алдав. Түүний нүдэнд Их гэсгүй харагдаад

- Готов оо чи наад олиггүй хорон санаагаа татмаар юм даа. Би тамд очсон ч чамайг хүлээгээд байгаа шүү. Чи ч ирэх замаа засаад хугацаагаа богиносгоод байгаа юм аа даа гэхэд тэр ийнхүү сандарч санаа алдсан хэрэг. Хамба Готовын санаа алдахыг ажигласан болохоор түүнд

- Готов гуай та юунд санаа алдан дагжин чичрэхэд хүрэв гэж асуухад Готов их л зэвүүцсэн дүр эсгээд

- Намайг яагаад санаа алдав гэж үү? Хар багынхаа найз нөхөр, шавийнхаа аавын амь насыг нь яаж бүрэлгэж зүрхлэв. Мөн л их зориг шүү. Ядахдаа бага зэрэг зовоогоод л орхиж болоогүй юм байх даа. Энэ хүний толгой ч ёстой олгой болж дээ гэж бодож сууна.

Зарим сударт уулыг нураах гэвэл оройгоос нь оролдвол өөрөө л зовно. Харин бэлээс нь мөлжвөл уул өөрөө нурдаг гэж байдаг. Аль ч юмыг ихээс нь эхэлдэггүй багаас нь эхэлж бардаг л гэдэг. Хортой цэцэгний үр үндсийг таслахгүй бол хор хадгалагдсаар л байдаг юм. Хамба та холыг биш ойрыг бодвол таньд өлзийтэй байхаа даа гэж мэргэн үг айлдав. Готов дахиад л Агвааннэмыг ажиглаж байлаа.

Авирмэдийг унагаая гэвэл хүү Чоймжуураар оролд гэсэн санаа зөвөлгөө л өгсөн хэрэг л дээ. Хамбын сэтгэлд дэгдсэн өс хонзонгийн түймрийн гал омог нь дарагдаж бага зэрэг тайвширсан болохоор Готовын хэлсэн үгийг сайн тунгааж байлаа. Эрдэмтэн мэргэд л ийм үг хэлэх байх гэж бодсон Агвааннэмын Готов өөд хараад түүний эрдэмд биширч байлаа. Тэр дотроо

- Өвгөн хамба нүдэнд өртөхөөргүй энэ чөтгөр шиг эрийг олон жил дэргэдээ донироор байлгасны нууц тайлагдах шиг болов. Өвгөн хамбад үнэрт цэцгийн цай өгөөд байсныг нь хамба өөрөө мэдсэн хэрнээ дэргэдээ байлгаад л байсан шүү дээ. Нэг л далдын нууц байна даа гэж бодоод байсан нь энэ хүний толгойг ашигладаг байсан юм байна гэж бодоод

- Готов гуай таны хэлсэн үгийг ухаж ойлголоо. Таньд их баярлалаа гэж сэтгэлийнхээ гүнээс хэлэхэд Готов толгой бөхийлгөх зууртаа

- Залуу хамба миний өвөр лүү өөрөө ороод ирлээ. Миний хальс шиг хөхний хар сүүг хөхнө дөө гэж бодож суухад Агвааннэмын хамба өөртөө

- Би ер нь их тэнэг хүн байна шүү. Өстөн дайсныхаа үр хүүхэдтэй нь нэг гэрт суугаад нэг тогооноос хоол идээд, бас багш шавь болцгоогоод сууж байх даа яадаг билээ. Чоймжуурыг гэрээсээ хөөж тусад нь гаргаад дүү Дэжиднямыгаа дэргэдээ авч биеийг нь эмчлүүлж хоол цайгаа хийлгэе хэмээн бодоод тэр суудлаасаа босож Готовыг хүндэтгэн үдэж өгөөд гэр лүүгээ хурдан хурдан алхав. Өнөөдөр түүнийг толгой нь биш хөл нь захирч байв.

Хорин зургаа

Балбар өвгөн бодол бясалгалдаа гүнзгий орж Авирмэд гавжийн түүхийг хөөж байгаад Донир байсан Готовын шордож хатгасан шорвог үг, өс хонзон зангидсан муухай санаа, үр хүүхдээс нь эхлэн оролд гэсэн хар хорон арганд автагдсан Агваанн्याмын тэнэг мунхаг сэтгэлд өс авахын их түймэр тавиад өөрөө түүндээ шатаж үхэх нь холгүй алхаж байгааг нь бодохоос айдас төрж аргагүйн эрхэнд бодол бясалгалаа түр завсарлахад хүрэв. Тэр амандаа

-Нэг нь нөгөөгөөсөө асууж нөгөө нь худал хуурмагаар өөрийнхөө хүсэл зорилгыг биелүүлэх гэсэн атгаг муу санаагаар хэлсэн үгэнд нь үнэмшээд тэнэг муйхар юм хийхээр зорьж явааг нь санахаас ихэд харамсаж халаглаж байлаа. Хүний амь гэдэг усны хөөс мэт хялбархан эвдэрдэг ч ус уух хувь түшвэл тийм ч амархан тасардаг хямдхан зүйл биш гэдгийг Балбар дотроо бодоод Авирмэдийн амьдралын түүхийг үргэлжлүүлэн бясалгав.

- Агваанням хамба бодол саналаа санааныхаа зоргоор хийж эхэлсэнгүй. Хэсэг хугацаа өнгөрсний дараа Чоймжуурт аргадангүй байдлаар

-Чи одоо бие дааж амьдрах хэрэгтэй. Гэр орноо бэлдэнэ биз дээ. Би дүү Дэжиднямаа дэргэдээ байлгах хэрэгтэй боллоо гэснээс өөрийг айлдсангүй. Авирмэд гавж эл санааг сонсоод

- Зөв байна. Одооноос бие дааж амьдрал үзэх хэрэгтэй . Би ч хүүхэддээ гэр орон төхөөрч өгөх цаг нь болсон гэж бодоод хүүдээ гэр орон төхөөрөх ажилд шуурхайлав. Авирмэдийг нутгийнхан нь хоёр янзаар цоллож дуудна. Ихэнх нь Гавж гэж эрдмийнх нь цол зэргээр цоллож байхад нэг хэсэг нь үхэрчин Авирмэд гэж нэрлэж дуудах нь бас бий.

Авирмэдийнх гэдэг айл Улиастайн бага голд өрх өсгөж сум сунгаж өргөө гэрээ барьж байсан үеэс энэ айлын түүх эхэлдэг. Энэ цагт л өөрсдөө худалдан авсан нэг, Манлайн өмчилж өгсөн хоёр нийлээд гурван үнээтэй, цайны сүү амны тарагтай байсан бол өнөөдөр өсөж үржээд олон болж нутгийн ах дүүсийн дунд Үхэрчин хэмээн нэрлүүлсэн нь малын буян нүүрээ өгсний илрэл билээ. Авирмэд ч хүүдээ гэр оронг нь бэлдээд төвхнүүлээд өгөв. Тэр Агваанням хамбатай уулзаад буцъя гэж санаад очиход Донир нь гарч ирээд

- Өршөөгөөрэй. Гавж багш аа. Хамбатан чухал ажил хэлэлцэж байгаа учир зав муу, хүлээж авах боломжгүй байна гэж хэлүүлэв гэхэд Авирмэд дотроо

- Аргагүй байх даа. Хамбын ажил тийм ч амархан байхгүй. Хийе гэсэн хүнд бол барагдашгүй их ажилтай. Ийм залуудаа хамба болж байсан хүн бараг байхгүй шүү. Ажил хийвэл төгс сайн хийх хэрэгтэй. Нэг хүн ирлээ гэхээр л босч харайгаад байж болохгүй гэж бодсоор буцав. Энэ байдлыг ажиглаж байсан Чоймжуур дотроо

- Хамба багшийн зан авир эрс өөрчлөгдөж сүүлийн үед Чоймжууртай юм ярилцахаа больсон. Түүнд дургүй байгаа нь олон зүйл дээр илэрч байгаа бол өнөөдөр аавтай нь уулзалгүй буцааж байгаа нь нэг сонин бас сэжигтэй санагдаж байлаа. Эртэд шөнө дунд орж ирээд их л ууртайгаар

- Хөөе Чоймжуур чи босоод гал түлээтэх. Чи бид хоёрын багш шавийн барилдлага энэ цагаас тайлагдаж хоёр тийшээ болж байх шиг байна гэж үл ойлгогдох юм амандаа үглээд гараа зангидаж хөмхийгөө зууж байсан нь санаанд илхэн байлаа. Чоймжуур аавдаа энэ бүхнийг хэлэх гэсэн боловч ааваасаа эмээгээд хэлж чадаагүй билээ. Өмнө өөрийгөө өмөөрүүлэх гэж хов үг зөөсөн нь буруудаж аман дээрээ алгадуулсан удаатай билээ. Тэрээр

Өргөс хэдийгээр хатгасан ч сорви нь эдгэрдэг юм.

Үг хэдийгээр хоосон ч уг шарх нь хэзээ ч аньдаггүй юм шүү дээ.

Үг хөөсөн хүний үйлс бүтдэггүй.

Үхэр унасан хүнд нохой өшөөтэй гэдэг үнэн байдаг.

Илүү харсан хүний сэтгэл ер ханахаа больдог.

Билүү долоосон хүний хэл хорсохоос биш ер хурцлагддаггүй юм даа. Дотроо долоо дахин бодож байгаад нэг л үг хэлж бай гэж сургасныг нь бодоод тэр билээ. Агваанням хамба удсан ч үгүй ээжийгээ эргэнгээ охин дүү Дэжиднямаа авчрахаар явлаа. Агваанням

-Дүү охиноо дэргэдээ байлгаж биеийг нь эмчлүүлж бас тогоогоо бариульа гэхэд Удвал их л уриалгахнаар

- Тэгээ, тэг хүү минь. Одоохондоо ээж нь хоол цайгаа хийтэйгээ л байна. Нөгөө Чоймжуур хүү байгаа биз дээ гэж асуухад Агваанням хайхрамжгүйгээр

- Тэр тусдаа айл болоод надаас холдсон гэхэд Удвал хүү рүүгээ том хараад

- Хэдүйдээ тийм юм болчихдог байна гэхэд Агваанням муухан инээгээд

- Ээж минь хүний нохой идэхээр өөрийн нохой ид гэдэг биз дээ. Хар элгийн хүнийг хичнээн жил тэжээдэг юм гэв. Удвал уулга алдаад

- Чи дуугүй байгаач. Юуны чинь хар элгийн хүн гэж. Аавтай чинь ах дүү болсон, чиний багшийн чинь хүүхэд шүү дээ гэхэд Агваанням аймаар ярвайгаад

- Ханилж явж байгаад нэгийгээ эзгүй хээр газар үхүүлдэг тийм ах дүү байдаг юм уу? Ээжээ та бодоод үзээч. Хөөргөө мартсан гэхэд нь яагаад ганцааранг нь буцаав. Тэр үед байгаагүй хөөрөг яагаад өнгөрсөн хойно нь өвөрт нь байдаг билээ. Айлд мартаагүй хөөргийг хэн авчраад өвөрт нь хийчихэв. Энэ бол тодорхой шүү дээ. Би Гавжтай ямар ч барилдлага холбоогүй болсон. Манай хүрээнийхэн гавжийг өрөөл бусдадаа халгаатай гээд бүгд л зайгаа барьдаг. Ямар сайндаа л манжаар хороолгох арга мэх сэдэж байхав даа гэлээ. Удвал

- Ээ бурхан минь. Миний хүү чи тун ч төөрч будилж яваа юм аа даа гээд муужран унав. Дэжидням ууган ахдаа уурлаж үг хэлэх гэснээ хэлээ хазаад чимээгүй боллоо. Тэр дотроо

- Тийм байх ёсгүй. Гавж хэзээ ч муу муухай зүйл санахгүй. Энэ ахын толгой бүр эргэж

гүйцэж. Бидний аавыг орлох ах маань ийм юм бодож явахдаа яана. Хэдэн жил болоод төрлөө олчихсон хүний ясыг өндөлзүүлээд юу хийнэ. Би ахын руу явна. Очиж байгаад түүний бодлыг өөрчилнө. Бас Чоймжуурынхаа тогоог барина. Энэ хорвоо дээр бүхнийг орлож чадах ганц хүн бол Чоймжуур минь шүү дээ гэж бодсоноо ээж ах хоёрыгоо харснаа нүүр нүд нь манараад халуу дүүгээд явчихав. Тэр амаа ангайн урт урт амьсгал авахыг ажигласан эх нь

- Миний охин яав. Нөгөө зүрх ам чинь болохоо байв уу? гэж асуухад Дэжидням

- Үгүй ээж ээ. Ууган ахын ярьсаныг бодоод бүр уур минь хүрчихлээ гэхэд Агваанням хамба охин дүү рүүгээ хараад

- Дүү минь. Амьдрал гэдэг чинь бидний сайн сайхан санаж байгаа шиг биш. Харин ч санаанд ормооргүй муу муухайгаар дүүрэн байдаг юм даа гэхэд Дэжидням их л хэгжүүнээр

- Харин тийм бололтой. Эрдэм номтой, их мэдэлтэй ийм том хүний санаанд тийм муу муухай зүйл хадгалагдаж яваад би харамсаж байна хэмээхэд Удвал аман дээрээ

- Ахынхаа өмнөөс үг хэлээд яаж байгаа чинь тэр вэ? гэж хэлснээ дотроо охин үрээ өрөвдөж байлаа. Авирмэд гавж Чоймжуур хоёрыг сэтгэлдээ өмөөрч ахдаа гоморхож байгааг нь мэдэх учир

- Хөөрхий дөө миний охин Чоймжуурт тийм л сайн юм байх даа. Энэ аашилж аяглаж байгааг нь харахад муугүй бололтой. Өөрийнхөө биений байдлыг сайн мэдэхгүй болохоороо амьдралыг хүсэж мөрөөдөж байгаа байх даа. Эмэгтэй хүн чинь төрж хөнгөрч болохгүй гэхээр ямар олигтой байх вэ? Нэг ч гэсэн үр хүүхэд гаргахгүй бол яаж бүрэн бүтэн жаргалтай амьдарч чадах билээ дээ. Ах нь мэдэж байгаа болохоор энэ хоёр хүүхдүүд ч хоорондоо их л маргалдах байх даа. Ганц охиноо эрхлүүлсээр байгаад дэндүү дур зоргоороо аашилдаг болгосондоо гэмших юм даа гэж бодоод санаа алдахад Агваанням ээжийгээ харан

- Ээж минь та биеэ бодоорой. Элдвийг бодож хямраад байвал бие чинь улам муудаад л байна. Би дүүгээ сайн харж хандана. Та битгий санаа зовоорой. Үнэн юмыг үнэнээр нь байлгахыг би хүсэж байгаа. Өөр юм юу ч байхгүй гэхэд Удвал уйтгар гунигтай нүдээр ууган хүү, отгон охин хоёроо ээлжлэн хараад

-Та нар минь л бие биеэ хайрлаж хүндэлж явбал болох нь тэр. Өнгөрч одоод удаж байгаа хүний ясыг өндөлзүүлэх ч хэрэггүй. Амьд мэнд байгаадаа урмын үг хэлж сэтгэлийг нь бүлээцүүлж яв. Эндүү ташаа бодолтой хүн буруу өрөөлтэй морь шиг зовж явдаг юм гэнэ лээ. Хүмүүсийн эв түнжинг эвдрэлцүүлж өөрийн хүсэл зоригоо хангадаг муу сэтгэлтэй, хар дотортой хүмүүс хааяа нэг байдаг. Тэднийг харахад хайлсан тос шиг мэлмэрээд дор бөхийн долигноод инээж ханиаж их тусч мэргэн хүний дүр эсгээд байлаа ч дотроо хорт могойн шүд шиг хорон муу санаагаар хүний тархи толгойг байнга л хордуулж байдаг юм гэсэн гэж хэлэхэд Агвааннямд донир байсан Готовын дүр төрх хэл яриа бодол санааг нь яг харсан юм шиг хэлэв. Тэр дотроо

- Готов гуай тийм байж болно. Гэхдээ намайг тэгж хордуулж чадахгүй. Би тэр хүний хөлийн хуруу гутал дотроо хаашаагаа хөдлөв гэдгийг мэднэ гэж бодоод

- Ээжээ таны хэлсэн ярьсаныг сайн ойлголоо. Чоймжуур ч эрдэм номондоо шаггүй сайн болоод байгаа шүү. Хүрээ хийддээ бол дээд зиндаанд багтана шүү гэхэд Дэжиднямын царай гэрэлтээд нүд нь сэргээд ирэхийг Удвал сайн ажиглав. Тэрээр Агвааннямд хандан

- Цаад Авирмэд гавж багшийн чинь бие нь тийм ч сайн биш байгаа. Нөгөө Тэнгэр ууланд авсан шарх нь задраад уушигных нь өвчин сэдрээд байгаа юм гэнэ лээ. Миний хүү нэг очиж уулзмаар юм даа гэхэд хүү нь бага зэрэг инээмсэглээд

- Надад тэгж явах зав зай алга байна гэж эрс татгалзав. Үүнийг сонссон Дэжиднямын нүд гялалзаад

- Ээж би явж гавж багштай уулзаад ирэх үү? гээд үгээ дуусгаагүй байхад Агваанням таслаад

- Тэгэж явах зав зай алга гээд байгааг чи ойлгохгүй байгаа юм уу? Ер нь ч тэднийхээр орж гарахаа болимоор юм гэж омогдонгуй аятай хэлэхэд Дэжидням дүрсхийн уурлаад

- Тэгвэл та л орохгүй байна биз дээ. Бид нар ордгоороо орж ах дүүс амраг садан хэвээрээ байна гэж ширэв татав. Ах дүү хоёрын энэ зөрчил тэмцлийг нүдээрээр харж чихээрээ сонсож суугаа эхийн сэтгэл яахин амар байх билээ.

Түүний сэтгэл далай тэнгисийн ус атриатан долгилох шиг давалгаатан зовж байлаа. Амьд сэрүүндээ ийм муухай тангарагийн гэм эвдрэхийг үзэх тийм ч сайн хэрэг бус муугийн ёр гэлтэй. Эрдэм номын цагаан буянаар уягдсан багш шавийн барилдлага алдуурч нэгэн эхийн хэвлээс цуварч төрсөн ахан дүүсийн амин холбоос тасрах шахам болж үгэн жад мэс барьж бие биеийнхээ сэтгэл зүрх рүү чичлэж хатгаж байгааг харах гэдэг амьд хүний адгийн зовлон мөнөөс мөн байв. Удвал зүрхээ баруун гарынхаа алгаар аргадан байж амандаа

- Ийм юм үзэн дүлий дүмбэ, нүдэн балай амьд явахаар түргэхэн нүд аниж талийгаачийнхаа дэргэд очиж амар жимэр байх юм сан гэж шивнэж байв. Ус эх адаг хоёртоо булингартаад ирэхээрээ дундаа урсгал нь үгүй болж нялцгай замаг бий болоод өмхийрдөг жамтай билээ. Удвалд энэ ус лугаа бодогдоход түүний гол өөд юм өгсөөд нүд нь харанхуйлав. Ээжийнхээ царай төрхийг харж байсан ах дүү хоёр хоёулаа ухасхийж

- Ээж ээ гэж дуу алдав. Энэ дуу түүнд хойноос нь дуудах мэт бүдэг бөглүү холоос хашгирч байгаа мэт сонсогдов. Тэр хүүхдүүдээ эргэж харах гэсэн боловч эргэж хөдөлж огтхон ч болохгүй байлаа. Дотроо

- Миний хүүхдүүд надад юу хэлэх гэсэн юм бол доо. Уг нь хол явж байгаа хүний хойноос дууддаггүй бас дагаж явдаггүй л гэдэг дээ гэж санаж байтал өмнөөс нь их цагаан гэрэл цацраад хэн нэгэн ирж байгаа юм шиг санагдав. Сайн ажиглавал Манлай нь байв. Манлай

- Удвал аа. Хөгшин минь. Юугаа хийгээд наашаагаа хүрээд ирэв ээ. Чи ирж болохгүй ээ. Одоохон буц. Чамайг ер нь хэн дуудсан юм бэ? Хойноос чинь хүүхдүүд чинь дуудаад дагаад байна шүү дээ. Энд чамайг багтаах зай завсарч алга байна гэхэд нь гомдож цөхөрсөн байдлаар Удвал

- Би тэгээд хаашаагаа явах болж байна. Энд ирэхээр та хөөж тууж буц гэж зандрах юм. Буцаад очихоор хүүхдүүд хоорондоо үгээр дайтаад үйлийг минь үзэх юм гэж хэлэхэд Манлай

- Цаана чинь Авирмэд гавж байгаа шүү дээ. Түүн дээр оч. Тэр хүн бүгдийг зохицуулаад өгнө. Одоохон тэр хүнд очиж учраа хэл гэв. Удвал гунигтайгаар

- Манлай минь. Би хэдийгээр мэрийж зүтгэсэн ч огт болохгүй байна шүү дээ гэхэд Манлай

- Болно, болно. Чи хэдий чинээ зүтгэнэ. Төдий чинээ хүчээ барж улам л доройтох болно. Өөрийг битгий эрж хай. Тэр Авирмэд гавж дээр л оч. Би энэ нөхрийнхөө буян эрдэм номын хүчээр ийм гэрэл цацарсан гэгээн ордонд ирчихээд амар жимэр байна шүү дээ гэхэд Удвал уйлагнан

- Та ч яахав. Өөрийгөө бодоод байх юм. Намайг яагаад бодож болдоггүй юм бэ? Наана чинь байгаа бурханаасаа гуйж байгаад намайг дэргэдээ аваач. Та чинь яагаад ийм ачлалгүй амьтан болчихов оо. Таны хэдэн хүүхдүүд чинь тань шиг бас ачлалгүй мэт санагдаад байна хэмээн хайлан дуулав. Манлай аргаа барсан янзаар

- Удвал минь чи яасан их мунхраа вэ? Чиний хэлээд байгаа тэр бурхан чинь Авирмэд шүү дээ. Цаг нь болохоор би чамайгаа дэргэдээ авна шүү дээ. Юундаа илүү ихийг хүсээд байдаг юм бэ. Дэргэдээ байгаа бурханыг үзэхгүй тэртээ хол байгаа чөтгөрийг үздэг чинь юу билээ. Цаад хүүхдүүдээ ухаартал нь дэргэд нь бай.

Чамаас ганц юм гуйя. Ганц охиныг минь Чоймжуурт даатгаарай. Би охин та хоёрыгоо их хүсэж байна гээд гэрэл бүдгэрсээр Манлай үзэгдэхгүй болов. Харин уйлж унжих нусаа татах чимээ сонсогдож байв. Арц хүж үнэртээд галын илч мэдрэгдэн ахуй амьдралдаа эргээд ирсэн байлаа. Удвал амандаа

- Энэ хорвоо чинь яагаад хязгаар төгсгөлгүй үргэлжилсэн урт удаан зовлонг надад өгнө вэ гэж шивнэхэд нь Дэжидням

- Ээж ээ. Та нүдээ нээгээч. Охиноо хар л даа. Амандаа юугаа хэлээд байгаа юм бэ? Гурван ах мал ахуйгаасаа хүрээд ирсэн. Бид тавуулаа таны дэргэд байна шүү дээ гэв. Тэр нүдээ алгуурхан нээхэд хэдэн хүүхдүүд нь сэтгэлдээ айдас хурааж нүдэндээ нулимсаа мэлтэгнүүлэн сууцгааж байв. Удвал болоод өнгөрснийг заримыг нь санаж заримыг нь санахгүй байлаа. Тэр хүүхдүүдээ эргүүлж тойруулан хараад

- Ээж нь хэдэн хүүхдүүдээ бүр айлгачихав уу? Энэ муу зовлого заримдаа ингээд байгаа юм аа. Одоо гайгүй байх аа гэв. Дөрвөн дүү нь ууган ах Агвааньямынхаа санаа бодлыг сонсохыг хүсэж түүн рүү харж байлаа. Агвааньям дөрвөн дүүдээ юу хэлж сургаал хайрлахаа мэдэхгүй толгой нь манарч алмайрна.

Түүнд ганцхан зүйл бодогдоно. Тэр нь донир Готов билээ. Энэ хүн дэргэд минь байсан бол ийм үед алив нэг сургаал эрдмээ хайрлаж арга зам зааж өгөх байсан даа гэж бодож суутал Готов өөрөө Агвааньямын дэргэд сууж байв. Тэр чөргөр гараараа хорчгор нүүрээ илээд инээмсэглэх нь яг л хохимой толгойтой чөтгөр шиг харагдахад нь Агвааньям дороо займчин

хоолойгоо засав. Готов

- Хамба аа. Би таньд хэрэг болов уу? гэхэд Агваанням айснаасаа болж худал инээгээд

- Тийм ээ. Та хэрэг болоод байна. Би яах учраа олохгүй дүү нарынхаа харцанд ээрэгдээд торонд орсон шувуу мэт хөдөлж чадахгүй сууна гэхэд Готов

- Хамба минь ээ. Та тав чинь нэгэн гарын зангидсан нударганы таван хуруу юм байна шүү дээ. Энэ их хүчийг ашиглавал мөн ч ихийг хийж чадна даа. Ихэнхдээ ухаан хэрэг болдог ч хааяа хүч хэрэг болдгийг санаач: Чөтгөрийн бага нь адтай гэдэг биз дээ. Таны отгон охин дүү чинь адтай золиг байна шүү. Эр хүний хугарч нугардаггүй хатан зоригийг бас тасардаггүй улаан гол амь насыг нь хугалж тасалж чаддаг ганцхан зэвсэг байдаг. Тэр ч гэсэн таньд байна шүү гэв. Агваанням бодлого болж хэсэг азнаад

- Готов гуай. Тэр чинь ямар зэвсэг вэ? Би санахгүй байна гэхэд Готов

- Хичнээн их хүчтэй юунд ч дийлдэшгүй арга эр бие байлаа ч эм билгийн заль мэхнээс зайлж зугатаж үзээгүй гэдэг юм даа. Ялангуяа тэднээр үр үндсийг бүрмөсөн тасалж цэвэрлүүлэхэд тун ч уран гэж хэлэлцдэг юм гэлээ. Агваанням арай ядан ойлгоод дотроо

- Чоймжуурыг Дэжиднямаар үгүй болгуулж үндсийг нь таслуулж ав. Тиймээс охин дүүгээ Чоймжуурт ойртуулж дотносуул гэж байгаа бололтой гэж бодоод Готов руу харахад Готов

- Та дахиад л арга зам хайгаад байгаа юм аа даа: Хоёр л зам байгаа Хоёуланг нь зэрэг хэрэглэж болно. Мөн тус тусаар нь явж болно. Чоймжуурт эхлээд хэцүү сахил хүртээ. Дараа нь жимсээ ойртуулж хүртээлгэ. Тэгээд л хэцүү сахилын хатуу тангарагийг алдаж байж болшгүй гэм нүглийг үйлдлээ гээд л үгүй болго. Та жимсээ эргүүлээд дэргэдээ авчих. Дэргэд нь жимс ойртсон л байхад хүртээлгэх ч алба байхгүй нүхэнд өөрөө унана.

Нөгөө нь гэвэл жимс дэргэд нь байсаар байна. Гэтэл тэр өөрөө бөх гэгчээр нойрсож сайхан зүүдэндээ ханахыг л хэлж байгаа хэрэг гэв. Агвааннямд энэ хоёр арга хоёулаа боломжтой санагдаж байв. Тэр энэ бүгдийг нэг мөр үгүй хийж үр үндсээр нь тасалж байж бид нар амар тайван амьдарцгаана гэж бодож байлаа. Агваанням Готовг хандан

- Нөгөө гол хүнээ яах билээ гэж асуухад Готов инээмсэглэв. Дахиад хохимой толгойтой чөтгөр харагдав. Агваанням дотроо

- Та битгий инээгээд байгаач гэж бодтол Готов төв байдлаар

- За, за би инээхээ больё. Та харин инээдтэй юм битгий асуугаад байгаач. Үндэсгүй мод ургамал ургаж цэцэглэдэг юм уу? гэж асуухад нь Агваанням

- Үгүй гэж хариулахад Готов

- Үр үндсийг нь тасалчихаар гол иш нь өөрөө л унаад өгнө шүү дээ. Түүнийг унагахад ямар ч чирэгдэл зардал гарахгүй. Алив нэгэн төвөг учрахгүйгээр унаад өгдөг юм шүү дээ гэв. Агваанням Готовын их ухаанд мөргөж уран чадварт биширч байлаа. Тэр нүдээ нээгээд

харахад Готов аль хэдийнээ явж одсон байлаа. Агваанням амандаа

- Баярлалаа. гэж шивнэхэд Дэжидням

- Ууган ах аа. Та чинь бас юу болоод царай зүс чинь хэд хувираад амандаа баярлалаа ч гэх шиг хэнтэйгээ юугаа яриад байгаа юм бэ? гэхэд Агваанням инээмсэглээд гурван дүүдээ

- Ээжийгээ сайн асар. Мал ахуйгаа анхаараарай гэж захиад Дэжиднямд хандан

- Хоёулаа маргааш эртхэн хөдөлнө гэв.

Энэ яриа хөөрөө болсон цагаас хойш багагүй хугацаа өнгөрсөн байлаа. Агваанням хамба ч Готовын зөвлөснөөр нэг дэх арга замыг дагаж охин дүүгээ Чоймжуурт ойртуулж дотносуулж байгаа гэж бодно.

Гэтэл хоёр залуу хорвоод мэндлэхдээ л нэг л өдөр нэг цагийн зөрөөтэй төрсөн бол хар багаасаа тоглож наадаж өсөн бие биенээ сайн танихаар барахгүй дэндүү дотносож ижил дасал болцгоосон болохоор тэр хоёрт сайхан байлаа.

Тэд ч Агваанням ахдаа баярлаж байв. Хамба энэ залуусын энэ байдлыг хараад одоо ганцхан Чоймжуурт хэцүү сахил өгөх л үлдээд байв. Ийн байтал Авирмэд гавжийн бие муудаж Чоймжуур аавыгаа асрахаар яваад бүтэн гурван сар болов. Энэ бүгдийг Агваанням ажиглаж ямар үйл мөрөөр төгсөхийг нь хүлээж түүнд

- Гол иш нь уначихвал үр үндсийг нь таслах бүр ч амархан санагдаж байв. Хааяа хүний хүссэн хүсэл хар зөнгөөрөө биелэх нь байдаг. Авирмэд гавж тэнгэрт хальж нутаг нугын ах дүүс, ойр дотныхоо хүмүүсийг цочроосон бол зарим нэгний магнай тэнийж атгаг муу санаа нь биелэв. Чоймжуур аавыгаа асарч байх хугацаандаа ааваасаа ихийг сурч мэдэж авав. Авирмэд ч хүүдээ хэлж ярих, захиж үлдээх гэсэн бүхнийгээ гүйцэлдүүлж чадсан билээ. Авирмэд гавж хүүдээ

- Хүү минь хүний амьдралыг нэг хоёр талаас нь хараад таньж мэдэж дүгнэж болохгүй. Ядахдаа арван талаас нь харах хэрэгтэй. Бүр гүнзгийрүүлье гэвэл амьдралыг өндөг хэмээн үзээд харагдах хэсгээр нэг хавтгайд жишиж аваад тэгш хэмд арван хоёр цэг тавьж шулуун шугамаар холбоход нэг зуун дөчин дөрвөн гурвалжин дөрвөн зуун гучин хоёр өнцөг үүснэ. Энэ бүхнээр нарийвчилж үзвэл нэг тоон түлхүүрээр оньс мултарч амьдралыг бүрэн мэдэх боломжтой юм.

Харин хүмүүс амьдралыг олон өнгөтэй гэж эндүүрээд өөрийнхөө сэтгэлийн ивээл өнгийг эрж хайж төөрч будилдаг. Гэтэл амьдрал ердөө хоёрхон өнгөтэй байдаг. Тэр нь хар цагаан хоёр өнгө шүү дээ. Бусад үлэмж гоё өнгөнүүд нь үзэгдэх төдий солонго мэт хоосон байдаг юм.

Бас сайн сайхан амтуудыг мэдэрдэг. Тэр сайхан амтны ард ямар амт байгааг олж мэдэрч чаддаггүй. Тэгээд л жаргаж байна даа гэж баярладаг мөртлөө хойно нь ямар гэгчийн их зовлон дагаж гэтэж буйг ч хардаггүй нь маш аюултай. Тиймээс ч амьдрал ганцхан амттай.

Тэр нь гашуун амт байх жишээтэй юм.

Аавын нэр сүр эрдэм номоор дулдуйдаж битгий амьдар. Тэр бол аргаа ядсан хүний өөрийгөө унагах мэх мөн. Үүнийг байнга санаж яваарай.

Хүний сэтгэл гэдэг эмнэг догшин хангалаас ч аюултай билээ. Нэг л жолоо цулбуураа алдаж тавьж туувал хорьж тогтоох арга тун бага. Тэр амь насыг төгсгөөд, биеийг унагаж гээгээд явж оддог. Харин тийм эмнэг хангал сэтгэлийг зөв жолоодож тогтоон барьж эзэмдэх ганц арга бол ухаан, эрдэм номд хичээнгүйлэн гэгээрэлд хүрэх явдал юм.

Хэрвээ бэрх хэцүү үе тохиолдвол ухааны бяр тэнхээгээр зөв замыг сонгож нэгэн үзүүрт сэтгэлээр хандаж чадвал хаана ч хүрч ямар ч үйл хэргийг бүтээж чадна.

Аав нь чамд өөрийгөө л зөв авч явах багахан ухааныг өвлүүлж үлдээлээ. Энэ жижигхэн Чүнчигноров хөөргийг хадгалж яваарай. Надад өөр хөрөнгө алга. Ээжийгээ сайн халамжилж хайрлаж асарч байдаг юм шүү. Би бусдыг өмнө хэлсэн болохоор байнга санаж бай гээд л бурханы оронд одсон билээ.

Авирмэд гавжийн тэнгэрт хальсан тухай мэдээ хүрээ хийдэд ирж олон шавь нар нь хурал хурж буян үйлдэж байв. Дэжидням бүсгүй их л сандрангуйгаар Агвааннямд

- Ууган ах аа хоёулаа гавж ахын руу явъя. Үзмээ эгчид үзэгдэж Чоймжуурт хань бараа больё гэхэд Агваанням уруулаа шүлэмдэн муруйж инээмсэглээд

- Эсгий хийх газар нохой хэрэггүй гэдэг. Тэнд чи бид хоёрын хэрэг байхгүй. Ээжид ч дуулгах хэрэггүй гэв. Дэжидням ахдаа ихэд уурлан дотроо халаглан байж

- Та чинь юу болчихоо вэ? Даанч яав даа. Ах минь гэж мэгшин уйлаад дээл хувцсаа солиод ойр зуурын юмаа бааданд боогоод нөхөртөө уурласан эхнэр аятай

- Та энэ хог новш нь хөглөрсөн, золбин ноход нь хөлхөлдсөн газраа ганцаараа амьдраарай гэж хэлээд гарч одов. Агваанням охин дүүдээ юу ч хэлсэнгүй дотроо

- Энэ унах унаагүй хөл явган амьтан хаачив л гэж. Одоо гол мод иш нь уналаа. Удахгүй үр үндэс нь таслагдахаар миний муу дүү хэсэг уйтгарлаж байгаад сэтгэл санаа нь тайвширна биз гэж бодож суув.

Дэжидням ууган ах шигээ тэнэг мунхаг нэгэн биш билээ. Тэр аль хэдийнээ морины нуруунд дөрөөнд өндийж намрын хонгор салхинд гээг үсээ хийсгэн талийгаач аавынхаа анд нөхөр, биширч шүтдэг багш, хайрлаж явдаг хүнийхээ аавынх нь хойтын буянд сүүн цацалтай сэтгэлээ өргөхөөр хурдалж яваа нь энэ билээ. Балбар өвгөн амандаа

- Ээ хайран хүн гэж шивнээд бодол бясалгалаасаа түр салж урт гэгчээр санаа алдав.

Хорин долоо

Арван зургадугаар жарны төмөр хонь жилийн намрын адаг нохой сарын улаан тэргэл сартай өдөр Ангараг гараг байлаа. Анчин хэмээн алдаршсан Чоймболынх Могойн хоолойн Дусаалын бууцанд өвөлжихөөр буусан байв. Өглөө эрт боссон Чоймбол тэнгэрийн байдлыг ажиглан зогсохдоо

-Өнөөдөр чинь улаан мягмар гараг нохой өдөр байсан. Ганц янгир унагачихвал ч ангийн үүд нээгдэнэ дээ. Их сайхан өдөр болох нь. Өчигдөр ч сайхан л байсан. Гэхдээ шинийн арван таван тахиа өдөр шүү дээ.

Онгоцны амны их өтөгт яхир Балдан ахынх байгаа. Балдан ах мэдчихвэл намайг ч зүгээр өнгөрөөхгүй л байх. Би ч гэсэн хүний итгэл алдаж болохгүй. Гэхдээ цэвэрхээн хийх хэрэгтэй гэж бодоод Улаан хайрхандаа сүсэглэн залбирав. Тэр чөдрийнхөө ганц алаг морийг эмээллээд хоёр зуугийн тусгалтай цагаан калибр буугаа үүрээд эртлэн мордов. Энэ үед Онгоцны амны их өтөгт суугаа яхир Балдан охин Нарангаравтаа

- Миний охин хонио доод тал руу бэлчээгээрэй. Их сайхан өдөр болох нь. Аав нь Улаан хайрхан өөд явж нүдээ баясаж сэтгэлээ сэргээгээд ирье. Энэ хайрхан ч мөн ч үзэсгэлэн төгс сайхан нутаг юм шүү дээ гэхэд Нарангарав

- За ааваа. Тал руу идэш сайхан байгаа юм. Манай нутгийн уул нурууд хар, хөх бараан өнгөтэй байхад энэ Улаан хайрхан ганцаараа ийм сүрлэг гоёмсог улаан ягаан өнгөтэй байгаа нь их сонин шүү гэхэд Балдан

- Харин тийм ээ. Энэ хайрханы чинь тухай үлгэр домог их бий л дээ. Би нэгийг нь сонсож байсан юм. Энэ хайрханыг чинь Цагаан дарь эхийн хувилгаан Цогт охин тэнгэр Лхам бурхан Жанчир Мулингийн далайн чанадаас авчирсан юм гэнэ лээ. Тэгээд энэ хайрханыг догшин улаан сахиусын орон гэж дээр үеэсээ ихэд хүндэлж ирсэн юм. Тиймээс мод ургамал, ан амьтдыг нь огтхон ч хөнддөггүй юм шүү дээ. Дээр үед Жамган гэж нэг зөрүүд золигийн залуу байсан гэдэг. Тэр нэг өдөр ирж дунд тагт хүрээд өндрөөс өндөр томоос том ургасан сонгиныг хараад сэтгэл нь ихэд шунаж

Авч болдоггүй сонгиныг чинь

Амалж байгаад авья би

Сайн эцгийг хүсвэл аавыг минь ав

Сайхан эхийг хүсвэл ээжийг минь ав

Эр зоригийг хүсвэл намайг ав

Эмээлийн сайныг хүсвэл миний муу янгиаг аваарай гэж хэлээд өвөр хормой хоёроороо сонгино дүүргэж аваад ирж дээ. Аав нь ихэд уурлаж

-Тэнэг мангар солиг. Наад зулгаасан сонгиноо байсан газар нь аваачиж тавь гэхэд Жамган хөхрөөд

- Амладагаа амлаад авчихсан юм аа. Би хүний нэг ч юм амлаагүй. Дандаа өөрийнхөө юмыг л амласан гэж хэлээд өөрийнхөө муу янгиа эмээлийг гэртээ оруулаад ирэхэд аав нь

- Наад янгиагаа яах гэж гэрт оруулав. Бөгс багтахгүй ядаж байхад гэж уурлахад Жамган

- Энэ мууг минь гадаа байхаар аваад явчихаж мэднэ. Хэзээ ч юм морьтой болбол надад хэрэг болно гэжээ. Гэтэл тэр энэ айл шөнөдөө шатаад амласан гурван хүн, янгиа эмээлтэйгээ үнс нурам болчихсон байжээ. Мөн ч догшин хайрхан шүү.

Энэ хайрхан бас их учиртай. Манай анчин Чоймболоос юугаа ч харамлахгүй. Бас тэгээд гай зовлонгоос хамгаалдаг гэж ярьдаг юм байна лээ. Цаанаа нарийн учир жанцантай л байх. Охин минь дотроо бодож яваарай. Хүнд хэлэх юм биш шүү. Хэл ам болохын нэмэр гэв. Нарангарав ч хонио бэлчээж Балдан мордоод Улаан хайрхан өөд зорив. Мөн л энэ үеэр Улаан хайрханы Ламын аманд байх Сагад

- Өнөөдөр чинь улаан тэргэл сартай өдөр шүү дээ. Өвөг эцэг Чоймжуурын даяан бясалгал хийж байсан агуйд очиж мөргөө. Өчигдөр шинийн арван таванд Их тагийн агуйд очсон. Өнөөдөр Үнхэлцэгийн агуйд очно. Өвөг Их тагийн агуйд хэсэг амьдарч байсан бол Үнхэлцэгийн агуйд дияаны бясалгалаа гүйцээсэн юм гэнэ лээ.

Энэ хайрханы биед маш олон агуй бий. Заримд нь ан амьтад үр төлөө гарган амьдардаг байхад хойшоогоо харсан нэгэн жижиг амтай дотроо уужим агуйд шилийн сайн эрийн ам тангарагийг сахиулах ёсоор цогцосыг нь нууж тавьсан шарил ч байдаг.

Энэ хайрхан уулын ам салаа болгоноос цэнгэг ус урсаж түүнийг хөвөөлөөд бургас голдуу модлог ургамал ургана. Их бага тагийн аманд битүү бургасан ой бий. Мөн ховор ургамлын сор, ан амьтдын хүчихэг омог, жигүүртнүүд чуулах нь үнэнхүү сүрдэм сүрлэг билээ.

Олон он цагаар хадан хавцал руу урсаж буух ус нь хадыг элээж тогоо үүсгэн хальсан ус нь дараагийн тогоог үүсгэсээр хамгийн олон нь хорин нэгэн тогоо үүсгэсэн нь шатлуулж өрсөн усан тахил мэт үзэсгэлэнтэй ажээ.

Сагад мэргэн хүрэн морин дээрээ суугаад Улаан хайрхан уулынхаа олон гайхамшигт үзэсгэлэнгээр нь бахархан бодлоо бэлчээн сэтгэлдээ зурж явахад яхир Балдан Их тагийн нарийн зөрөг замаар аажимхан өгсөж явлаа. Харин анчин Чоймбол Сайн цагийн онь дээр гарч ирээд газар нутгаа сайн мэдэх учир хамгийн нууц зөрөг замыг сонгон сонороо өндөрсгөж хараагаа хурцлан ан амьтанд чимээ өгөхгүйн тулд зөөлөн урагшилж байв.

Алаг морь, анчин Чоймбол хоёрын амьдралын хамгийн жаргалтай цаг мөч энэ билээ. Чоймболын санаа бодол огтхон ч төөрсөнгүй. Яг л хүсэж байсан хүрэн халтар тэх нар эгээд амгалан хэвтэж байлаа. Чоймбол алаг мориныхоо магнайг нэг илээд орхиход тэр яг хүн шиг таг чимээгүй болоод чихээ ч хөдөлгөлгүй зогсов. Тэр хадны чөлөөний элсэрхэг ховил даган аажимхан мөлхөв. Буудах газраа товлон шагайх тэр агшинд нүднийх нь баруун буланд нэг юм

хөдлөх шиг болохоор нь түр азнан харвал хэсэг хадны цаана бас нэг ховил даган дунд зэргийн насны ирвэс гэтэн мярааж байв. Чоймбол дотроо

- Энэ ирвэс хүрэн халтар тэх рүү мярааж байна. Би хүлээх нь зөв бололтой. Ирвэс янгирын тэхийг барина. Би ирвэсийг буудна. Өглөө нэг л совин татаад байсан юм. Ингэх л гэж тэгээд байж гэж бодоод буугаа бэлдэн хүлээж байв. Гэтэл ирвэс биеэ хураан хамаг булчин шөрмөсөө чангалан нуруугаа нумруулж байгаад үсэрч дүүлэн нисэх мэт болоод хүрэн халтар тэхийн нурууг шүргэж алдаад цаана нь буучихав. Хүрэн халтар тэх ч тэр дороо босоод хад асга дамжин дүүлэв. Үүнээс үргэсэн сүрэг янгир ямаа хадан цохионы дороос хуйлран давхив. Чоймбол ч энэ бүгдийг хараад түр зууртаа алмайрч орхив.

Гэтэл дахиад л нүдний буланд юм сүүтэгнэх шиг болохоор нь харвал нөгөө залуу ирвэс нөгөө ховилдоо ирчихсэн дахин гэтэж мярааж байлаа. Чоймбол ч бүр гайхаж орхилоо. Тэр дотроо

- Энэ золиг чинь одоо юу руугаа ингэж мяраадаг байна. Бас янгир байгаа юм болов уу? гэж бодоод ажиглаж байлаа. Ирвэс ч биеэ хурааж нуруугаа нумруулаад үсэрч агаарт дүүлэв. Тэр нөгөө янгирын тэх хэвтэж байсан халуун ором дээр буув. Үүнийг харж байгаа Чоймбол нүдээ бүлтийлгэн гайхав. Тэр толгой сэгсрээд амандаа

- Мөн ч ухаантай амьтан юм даа. Алдсан алдаагаа газар дээр нь засаж байна шүү. Гэтэл би нэг сумаар хоёр ан унагачих юм бодоод хожоо хийж суусаар хоосон хоцорлоо доо хэмээн шивнэж байхад нөгөө ирвэс хоёр алхаснаа эргэж мөрөө нэг харчихаад толгойгоо занхагнуулан сүүлээ буулган үзүүрийг нь дээш гогцооруулан хад даван далд орлоо. Чоймбол түүний хойноос харж байснаа

- Ийм ухаантай амьтныг яаж буудаж болох вэ? гэж өөртөө хэлээд инээмсэглэв.

Чоймбол буун дуу гаргаж ангийн үүд нээж чадаагүй ч эр хүний уужуу ухаан ёс жудагаар хандан шунал уналдаа автагдалгүй хоёрын хоёр амь биеийг суллан явуулсанд нь улаан ягаан хадан байц, шовх оргилууд асга хадан цохио, Улаан уул баярлан талархаж байлаа.

Анчин Чоймболд нэг хоёроор тогтохгүй хэд хэдэн удаа буу дуугаргах боломж байсан билээ. Тэр ингэхийг огт хүсээгүй нь ухааны тэнхээ, бяд байв. Байгаль хүн хоёр ийнхүү бие биедээ дотносож хайрлан хүндэлж, бас хишиг буянаа харамгүй өгдөг нарийн нандин уялдаа холбоотой ажээ. Чоймбол алаг морин дээрээ ирээд эмээлийн бүүргэнд өлгөөтэй суран бугуйлаа хараад нэгэн удаагийн ан хийснээ дурсан санах.

Тэр хэсэг янгирын дороос өгсөж явгал янгир чимээ аваад дээшээ өгсөхөд нь нэгийг нь буудав. Тэх цаашаагаа нэг гишгээд эргэж унав. Тэх налуу улаан элгэн хад руу гулжигнан бөмбөрнө. Тосож авах арга бага байлаа. Янгирыг доошоогоо унавал авах боломжгүй байв. Чоймбол түргэхэн зуурт бугуйлаа бэлдэн бөмбөрч байгаа тэхийн толгой эвэр нь өндийгөөд ирэх үед бугуйлаа шидэж хоёр эвэрт нь оруулж татаж авч байснаа санах. Түүнээс хойш хааяа анд явахдаа суран бугуйлаа байнга л авч явна. Нутгийнхан түүнийг

-Буу буудахтайгаа адилхан бугуйландаа мэргэнийг нь гайхан магтан шагширдаг билээ. Чоймбол

- Хангай дэлхий, хайрхан уул хишиг буянаа хайрлах дургүй байвал буцъя даа гэж бодоод алаг морио хөтлөн хэсэг алхаснаа Их тагийн нарийн зөрөг дээр ирээд мордож ирмэг өөд нь аажуухан өгсөв. Гэтэл морь тургих чимээ гарахад нь гайхан харвал яхир Балдангийн хээр морь чөдөртэй зогсож байв. Чоймбол Балдангийн морийг таниад дотроо

- Юмны хувь ерөөл гэж мөн ч сонин юм даа. Өглөө гэрээсээ мордохын өмнөхөн Балдан ахыг дурсаж билээ. Тэгээд энэ хайрхан ууланд учирдаг тавилантай байжээ. Элдэв муу юм хийгээгүй яваа болохоор айх ч юм алга гэж бодсоноо айхгүй ч гэсэн аягүй гэгчээр буугаа бушуухан мөрнөөсөө мултлаад хад түшүүлэн нуусхийгээд тавив. Харин бугуйлаа мөрөндөө өлгөөд нэг өндөр цохио хадны ирмэг дээр ирээд дурангаар Балданг эрэв.

Тэр хайрханы орой ирмэгийг дагуулан дурандаж байтал гэнэт хүн орилох чимээ ойрхон гарав. Дахиад хүн орилох тод сонсогдов. Чоймбол ухасхийн хадан дээр гараад хартал Их тагийн агуйны доод цавчим налуу руу Балдан хөл алдан гэдрэгээ харж унаад бараг хэвтээгээр шахам хоёр хөлөө алцайн хоёр гараа дэлгэн бөгсөөрөө гулсаж байв. Удахгүй эгц босоо хадан ангалаг руу нисэхээр байлаа.

Чоймболд үг ч дуугарах зав болсонгүй хад дамжин гүйх зуураа бугуйлаа мөрнөөсөө мулталж эвхээд боломжтой зайнд хүрэв. Балдангийн зүүн хөл нь нэгэн хадны ирмэгт тулангуут түр зогсох мэт болоход Балдан цээжээ өргөн өндийхөд бие нь баруун тийшээгээ дийлдэн ханан хадны ирмэг рүү чиглэх тэр агшинд Чоймбол бугуйлаа шидэж орхив. Бугуйлын сур исгэрэн ирж Балдангийн дээшээ өргөсөн зүүн гарыг нь хүзүү толгойтой нь холбон оров. Тэр үед Балдан юуны ч учрыг олж чадалгүй ухаан балартан муужирсан байв. Чоймбол ч түргэнээр бугуйлынхаа сурыг нуруугаараа ороож хоёр хөлөөрөө хад өшиглөсөн байлаа. Тэрбээр

- Балдан ах аа. Баруун гараараа бугуйлын сурнаас бариарай гэж хашгирч байв. Балдан алив нэгийг төсөөлөх дайтай болтол ямар нэг юманд баглуулан дүүжигнэж байна даа гэж бодтол хэн нэгэн

- Балдан ах аа. Баруун гараараа бугуйлын сурнаас бариарай гэж хэлэхийг бүдэг бадаг сонсоод баруун гараараа сурыг атгаж аваад л

- Би үхлээс аврагдсан юм байна гэдгээ сайтар мэдэв. Тэр сурнаас барьсаар өндийгөөд хөл дээрээ босоод ирэв. Тэр

- Амь аварсан ачтан минь хэн бэ? гээд сайн харвал Чоймболын инээмсэглэсэн царайг хараад дотор нь эвгүй болж хоёр нүдийг нь усан нулимс бүрхээд аньсагаа хальж хацар даган аманд шорвог гашуун амтагдан байв. Балдан Чоймболыг тэвэрч аваад цээж нь оволзон дотогшоогоо эхэр татан, гадагшаагаа хайлж байваа. Энэ нутгийнхан баяр жаргал, зовлон зүдгүүрийн аль нэг эгзэгтэй агшинд Балданг дусал нулимс унагаж байгааг нь үзээгүй болохоор түүнийг яхир Балдан хэмээсэн тал ч бий. Чоймбол бүр санаа нь зовоод

- Балдан ах аа. Одоо тайвшир гэж дал мөрийг нь зөөлөн алгадаж байв. Эрчүүдийн мөс жудаг, заяа заваг нь бие биеэ түшиж зовж жаргаж амьдардаг жам ёс энэ билээ. Нутгийн хоёр эр хэсэг хуучилж яриа хөөрөө болоод морьдоо хөтлөн алхана. Балдан дахиад л

- Би Чоймболынхоо тусыг мартахгүй ээ. Хариулж чадахгүй ч байнга санаж явах болно гэхэд Чоймбол санаа нь зовсон бололтой

- Та энүүхэнд баярлаад байх юу байна. Энэ муу бугуйлтайгаа явсны хэрэг л гарлаа. Би ч хөдөлж байгаа юмны толгойг ч харин алддаггүй юм шүү гэхэд Балдан инээмсэглээд

- Сурсан юм гэдэг сайхан даа. Хэзээ ч хүнд хэрэг болно шүү. Надад бол юу ч байхгүй. Ганцхан нэг муу яхир зан л бий. Тэр надад тус болох нь битгий хэл ус болно. Ямар сайндаа манай хүн уурлахаараа

- Манайхаар ямар хүн амьтан орж гарах биш. Хуц ухна хариулдаг Сагадынхаас дор. Харин тэднийд чинь сумын дарга цэргээсээ эхлээд бүх хүн л очиж байдаг гэсэн шүү гэж байхав гэхэд Чоймбол

- Сагадынх энэ дор Ламын аманд байгаа. Тэр хүнтэй аль нэгийг зүйрлэх арга байхгүй. Тэр унадаг хүрэн морь нь адгуус биш ээ. Хүн л гэсэн үг. Хуц ухна чинь маллахад хэцүү мал шүү дээ. Хүний уур уцаарыг ч нэг барна даа. Тэгэхэд хуц ухна нь цэрэг, Сагад дарга нь гэхэд Балдан дотроо Чоймболоо ихэд тоож

- Энэ Чоймбол ч өөрөө бас л нэг Сагад. Бугуйлыг тэгэж мэргэн шидэж сураагүй бол би өдийд ингээд явж байхгүй шүү дээ гэж бодохоос Чоймболд мөргөмөөр санагдаж байв. Гэтэл тэр хоёрын өмнүүр хэсэг янгир харайгаад өнгөрснөө нэг нь эргэж харан зогсоод тэр хоёрыг ажиглах мэт болов. Чоймбол дотроо

- Энэ янгир чинь хайрханы хишиг юм уу даа гэж бодож зогстол Балдан

- Чоймбол оо. Энэ хайрхан чамд л хишиг буянаа хайрлахаас надад бол харамлана шүү дээ гэв. Энэ нь чи өөрөө мэд дээ гэсэн үг байлаа. Гэтэл тэр янгир аажимхан алхсаар далд орчихов. Балдан аяархнаар

- Яасан бэ? Чоймбол оо гэж асуухад Чоймбол Балдан руу харснаа

- Та эндээ хүлээж бай. Саяны ямаа хээл авах зусаг байна. Би энэ хадаар нэг өнгийгөөд авсан өгсөн хоёртоо хал балгүй ганц юм байна уу, үгүй гэдгийг мэдээдэхье гээд хөнгөхөн алхаж одлоо. Тэр хадаар өнгийгөөд удсан ч үгүй буу дуугараад явчихлаа. Үнхэлцэгийн агуйд байсан Сагадад буун дуу бүдэгхэн сонсогдов. Тэр

- Энэ юун буун дуу гардаг билээ. Энэ догшин хайрханд буу тавих хүн байхгүй дээ. Анчин Чоймбол яваа байх нь гэж бодсоор морио хөтлөн зайвар замаар уруудав. Өндөр ургасан өвс ногоо шарлаж гандаад сэржигнэх төдий салхинд найгана. Үе үе бөөн бөөнөөрөө сонгино ургаж цоор нь гүйцэд гандаагүй халгартан байх нь модлог ургамал мэт харагдана. Ийм сайхан хайрханд байгаа амьтад ч тарга сайн аваа байлгүй гэж бодож явтал эмээлтэй алаг, хээр хоёр морь харагдав. Сагад алаг морийг хараад Чоймбол яваа байх нь. Нөгөөх нь хэн юм бол доо гэж тааж яван байв. Тэр морио орхиод хадан дэлээр өнгийтөл хоёр хүн нэг янгир төхөөрөөд махыг нь мөчилж байхад нь явж очив. Тэр хоёр яриандаа болоод Сагадыг ер анзаарсангүй. Сагад хоолойгоо засаад

- Сайн байцгаана уу? гэхэд хоёул бондгосхийн цочоод авав. Балдан их л эмээсэн харцаар харж байхад Чоймбол инээд алдаад

- Сайн. Сайн явж байна уу? Гуянд дуртай юу? Гучин хувьд дуртай юу? өөрөө мэд гэхэд Сагад мөн инээгээд

Гучин хувиа өөрсдөдөө үлдээ

Гуя хүзүү хоёроо надад өгдөө гээд суухад Балдан санаа нь амарсан

боллолтой өврөөсөө хөөргөө гаргаж

-За сайхан намаржиж байна уу? гэхэд Сагад жижигхэн ногоон Чүнчигноров хөөргөөрөө зөрүүлж

- Сайхаан. Та сайхан намаржиж байна уу? гэж мэнд усаа мэдэлцээд нутаг усныхаа сайхан байгааг хэсэг ярилцацгаав. Балдан инээмсэглээд

- Сагад аа чи заавал хүзүү гуя хоёрыг авдаг нь юу билээ? Өөр бусдыг яагаад нэрлэсэнгүй вэ? гэж асуухад Сагад

- Би чинь та хоёр дээр ирсэн гурав дахь хүн шүү дээ. Голж шилэх юм байхгүй. Эх адаг хоёроос нь хүртэх ёстой гэдэг юм. Хүзүү дээд арга мах, зургаан үетэй амтлаг эр мах байдаг. Гуя бол адаг билэг мах гурван үетэй зөөлөн эм мах юм л даа гэхэд Балдан ихэд гайхаж толгой сэгсрээд

- Юм гэдэг мөн нарийн юм даа гэв. Сагад инээмсэглээд

- Хүзүү нугалж байвал уран болдог, махыг нь зоогловол ухаантай болдог гэж нэг ёргио үг байдаг. Дээр үед нэг баян хүн байж л дээ. Мал гаргаад зарц барлагтаа хүзүү, муу сархинаг хоёрыг нь өгнө. Өөр юу ч өгдөггүй байж. Тэр баян дотроо

- Энэ хоёр чиний хоолоо гэж тавлаж инээдэг байв. Гэтэл нөгөө зарц нь ухаантай бас эрүүл байж их урт насалжээ. Гэтэл хүмүүс

- Та яаж ийм урт насалж эрүүл саруул байж чадав аа? Хамгийн хүнд хүчир болгоныг л хийж байсан даа гэхэд зарц инээгээд

- Манай талийгаач эзний л буян шүү дээ. Нууцыг нь тэр хүн л мэдэх ёстой доо гээд нууцаа хэлээгүй өнгөрсөн юм гэнэ лээ гэв. Балдан гайхширан дотроо

- Энэ хүмүүсийн ярьдаг үнэн бололтой. Сагадаас их юм сурч мэддэг байх нь. Манай охин Вансэмбэрүү цэцгийн тухай яриулж ирээд хөгшин бид хоёрт гурван ч удаа ярьж өгсөн дөө. Энэ хүнийг их юм мэддэг болохоор нь сумын дарга цэрэггүй цувж байдаг нь зөв юм байна гэж бодоод

- Тэр Үнхэлцэгийн агуй дотор юу юу байх юм бэ? Би ч орж үзсэн биш дээ. Зарим хүмүүс

эртний хүмүүсийн бурхан тахил байдаг юм гэж ярьж байхыг л сонссон гэхэд Сагад

- Тэр агуйд юм юм бий шүү. Хэсэг суугаад авахад оюун ухаан сэргээд сайхан болчихдог. Эртний дияан бясалгалын агуй юм гэнэ лээ. Тэгээд л оюун ухааныг тэтгэдэг хүчтэй тамир, эрчим хүч байдаг бололтой юм билээ гээд өвөг Чоймжуур аграмбын дияаны бясалгалаа дүүргэсэн тухай дурсалгүй өнгөрөв. Чоймбол ярианд оролцон

- Сагад мэргэн минь. Өнөөдөр улаан мягмар гараг. Нохой өдөр болохоор нь буун дуу гаргаж ангийн буян хишгийн амыг нээдэг юм уу гэж наашаагаа ирсэн юм гэхэд Сагад инээмсэглээд

- Та ч аргагүй л анчин хүн юм аа. Би улаан тэргэл өдөр болохоор нь Үнхэлцэгийн агуйд ирж хоёр гурван цаг суудаг юм гэлээ. Балдан дотроо

- Энэ хоёр чинь хоёулаа зорилго бодолтой Улаан хайрханаа зорьж иржээ. Би гэдэг хүн чинь ямар ч зорилго чиглэлгүй зүгээр л нүдээ баясгаж сэтгэлээ сэргээе гэснээс өөр бодолгүй тэнэж ирээд бараг амь насаа алдах шахлаа шүү дээ гэж бодож суув. Анчин Чоймбол өнөөдөр өөрийнхөө хөглөснийг яриад инээхэд Сагад хайрханы орой өөд хараад

- Таныг энэ хайрханы савдаг ихэд таалж энэ хишгийг хүртээсэн бололтой. Та олон амьтны амийг хөнөөлгүй, сувдаг шунахай сэтгэл гаргалгүй, өгөөмөр сайхнаар хандаж чадсан сэтгэлийг чинь ихэд сайшаасан гэсэн үг л дээ гэхэд Чоймбол ханцуйдаа залбиран

- Энэ хайрхан ч надад хишгээ хайрладаг юм аа. Та сая улаан тэргэл өдөр гэж юу ярив аа? Би бодоод сайн ойлгохгүй л байна гэхэд Сагад инээмсэглээд

- Сарыг хэлж байгаа хэрэг. Сарыг зуун ная гаруй нэр томъёогоор нэрлэж билэг чанарыг нь тайлбарладаг юм. Сарыг шинжих судар бичгийн гол шүнд бага, их, улаан тэргэл гэж бичсэн байдаг юм. Шинийн арван дөрвөн бага тэргэл, арван таван их тэргэл, арван зургааны сарыг л улаан тэргэл хэмээн нэрлэдэг. Сар, шинийн нэгнээс арван таван хүрэл цагаан гэрлээр гийгүүлдэг бол арван зургаанаас эхлэн улаан туяа суудаг юм л даа. Тэгээд л улаан тэргэл сар гэж нэрлэдэг юм. Энэ өдөр билгийн хүч дээшлэх учир Үнхэлцэгийн агуйд дотоод эрчим хүч тамир цугларч аливааг бясалган суухад таатай нөхцөл бүрдэнэ гэсэн үг л дээ гэв. Балдан

- Бүх агуйд тэгэж цугларах уу? гэхэд Сагад

- Үгүй л дээ. Их тагийн агуй гэхэд бидний орон гэртэй адилхан нөхцөлтэй байхад Үнхэлцэгийн агуй бол эхийн ураг дулаан сав оронтой адил юм гэж ойлговол болно гэв. Балдан

- Үгүй ээ мөн хачин юм аа. Нэг хайрханы хоёр агуй л гэхэд өөр өөр шинж чанартай байх нь дээ гэж гайхан шогширч амандаа шивнэж байв. Тэр Чоймболд бугуйлдуулж байж амь аврагдсанаа Сагадад ярихад Чоймбол

- Нэг их сүртэй юм биш ээ. Гулсаад явж байгааг нь нягталбал зогсох янзгүй болоод эгц ханан хавцал руу унамаар аюул ойртоод ирэхээр нь бугуйлдаад тогтоосон юм гээд шөвгөр үзүүртэй богиновгор хутгыг Балданд өгөхөд тэр хутгаа авахдаа

- Тийм биш ээ. Чоймбол оо чамд бага юм шиг санагдаад байж болно. Надад бол амь настай минь дүйх аймшигтай аюул болох учир мартагын аргагүй агшин шүү гэв. Сагад
- Тэгэлгүй яахав. Амь нас гэдэг чинь юутай ч зүйрлэх аргагүй үнэт зүйл шүү . Амь эвдрэх гэдэг алга эргүүлэх шиг амархан бол амьд явна гэдэг алганы хонхор хазахтай адил хэцүү гэдэг шүү дээ. Балдан гуай та наад хутгаа үзүүлээч гэхэд Балдан
- Май гээд өгөх зуураа их л бахархалтайгаар
- Манай нутгийн алдартай дархан Монхооногийн хийсэн хутга юм гэнэ лээ. Манай аав ойр зуурын хутга шөвөг хийх дайны төмөр нүдэх дуртай хүн байсан юм. Тэр том дарханаас эрдэм ном сурах санаатай хоёр гурван жил дагасан юм гэнэ лээ. Аавын хийсэн юмыг ихэд голон
- Чамд төмөр нүдэх донгоос өөр юм алга уу? Гайгүй цэвэрхэн хийцтэй юм хийнэ. Харахад гоёмсог халдаад үзэхээр шал түүхий шүү гээд хутгыг нь авч өөрийнхөө хутгаар мод зорох мэт зороод
- Хараач хөө. Чи чинь төмрийг мод болгоод байна шүү дээ. Ухаан чинь гүйцэж бяр тэнхээ ороогүй байна. Тэгэхээр хат суугаагүй гэсэн үг гэж хэлээд нэгэн модон хайрцаг уудалж энэ жижигхэн хутгыг гаргаж ирээд
- Май. Энэ хутгаар тарвага сайхан өвчдөгийг сурчихаад хүрээд ирээрэй гэсэн гэдэг. Аав минь дархан багшийнхаа үгэнд орж тарвагыг морь эмээллэх хооронд өвчиж төхөөрдөг болсон юм гэдэг. Тэгээд дархан багш дээрээ очоод
- Би таны хэлснээр тарвага өвчиж сурсан гэхэд Дархан инээмсэглээд
- Би сонссон. Хүмүүс чамайг гайхан магтаж байна лээ. Нэг л юмыг төгс сайн сурна гэдэг гайхамшигийг бүтээж чаддаг юм шүү дээ хүү минь. Чи наад хутгаа ав. Би төмрийг нь хэрэглэе гэж бодож байсан юм. Одоо санаагаа өөрчлөөд чамд үлдээе гэхэд аав маань
- Дархан багш аа. Би энэ хутгыг нэг ч удаа ирлэсэнгүй. Билүүнд ирлэх гэтэл билүү нь өөрөө элэгдчих юм. Өөрөө хар аяндаа хурцлагдаад байх юм гэхэд Монхооног дархан хүг хүг хөхрөөд
- Аргагүй ээ. Би наад хутгыг чинь хатааж ир суулгахдаа арьс маханд хурцлагдан ирлэгдэж, хатуу эдэд хайрга болж байхаар хийсэн ухаантай юм. Мах арьсанд хурцлагдахаас гадна өөрөө өнгө орж байгаа биз? гэж асуухад аав
- Тийм ээ. Бүр гялалзаад өнгөлөг болдог юм гэхэд дархан инээмсэглээд
- Тэгвэл овоо доо. Одоо хүү минь буц даа гэсэн гэдэг. Аав минь бурхан болохынхоо өмнө энэ түүхийг надад ярьж өгөөд хадгалж хэрэглэж яв гэсэн дээ гэхэд Сагад хутгыг эргүүлж тойруулж үзээд
- Тийм байх аа. Нэг л их өнгөлөг харагдаад байхаар нь би гадаадын л юм байх гэж бодож суулаа. Энэ хутганд хүний оюун ухааны их хүч тамир тэнхээ бүрэн шингэсэн бололтой гээд Балданд эргүүлэн өгөв.

Нутаг нугын гурван эр Улаан хайрхан уулынхаа энгэр биеийн дунд тагт тулгын гурван чулуу шиг гурвалжин үүсгэн хөөрөг зөрүүлж оюун ухаанаа зангидан охион суугааг нь хайрханы догшин сахиус савдаг ихэд таалан байв. Догшин сахиус савдаг ч хүний оюун ухаанд итгэж бас биширч мөргөдөг бөлгөө.

Хорин найм

Арван зургадугаар жарны шороон хонин жилийн өвлийн эхэн хөхөгчин гахай сарын шинийн арван гурваны билэгт сайн өдөр байлаа. Өндөр уулаараа бага зэрэг цас унаж хөдөө цайдамдаа бараан байгаа нь өнөтэй өвөл болох шинжтэй байв. Балбар өвгөнд хол ойрын чимээ өгдөг нэг транзистор хүлээн авагч байв. Балбар энэ өглөө сурсан зангаараа зургаан цагт төрийн сүлд дуулал эгшиглэхтэй хамт л хүлээн авагчаа асаасан билээ. Тэр тун ч анхааралтай сонсож байв. Гэтэл Монгол улсад нэгдэлжих хөдөлгөөн ялсаны хорин жилийн ойг тохиолдуулан Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн мянга есөн зуун далан есөн оны арван хоёрдугаар сарын нэгний өдрийн гурван зуун дал дугаар зарлигаар Говь- Алтай аймгийн Бугат сумын “ Социализмын зам “ нэгдлийг “ Алтан гадас” одонгоор шагнажээ гэсэн мэдээг сонсоод эхэндээ баярлаж байсан ч чихэндээ итгэж ядан

-Би гэдэг хүн чинь үнэн зөв сонссон л байгаа даа гэж эргэлзэнгүй байснаа амандаа

- Үнээн, үнэн байлгүй яахав. Би худлаа сонсох учир байхгүй гэж магнайгаа дэлгэрүүлэн сэтгэлдээ төрийнхөө сүлдэнд залбирч суув. Тэр дотроо

- Нэг мянга есөн зуун тавин таван онд Улсын сайн малчны дөрөвдүгээр зөвөлгөөнд манай зургадугаар багийн дарга Авирмэдийн Дамдин ажил үйлсээрээ шалгарч яваад ирэхдээ энгэртээ “Алтан гадас” одон гялалзуулаад зүүчихсэн ирж билээ. Би дэргэд нь суучихаад энэ муу сохор нүдээрээ сайн харж байхад манай хүү Галсан

- Аав аа. Та гараараа бариад үзээч. Ямар гоё юм бэ гэж байсныг тодхон саналаа. Балбар өвгөн анх удаа “Алтан гадас” одонг сайн харж сэтгэлдээ тогтоож авснаа ийнхүү нэхэн дурсав.Тэрбээр

- Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонг сумаараа зүүнэ гэдэг мөн ч ховорхон тохиодол шүү. Манай нутгаас эрдэмтэн мэргэд, төрийн түшээ, алдартан гавьяатнууд олноороо төрөх түүхтэй юм гэнэ лээ. Энэ нутаг усанд л нэг нууц байгаа даа. Тэр бунхан салааны бунхан сэргэсэнд их учир бий шүү. Тэнд булсан бумбыг чинь би нүдээрээ үзэж гараараа барьж байгаад нүхийг нь ухааж баруун энгэрээс чулуу авчирч тавьсан хүн шүү дээ. Хайдавжамц маань надад хэлэхдээ

- Аавын минь чандар гээд ойлгочихож болно. Гэхдээ энэ бумбанд хүний оюун ухааны маш хүчирхэг тамир байгаа юм. Энэ хүчирхэг тамир цугларсан нутагт сайн сайхан бүхэн хурах ёстой юм. Ургамал цэцэгс нь ид шидтэй шимтэй байхад ус булаг нь рашааны охь болоод ан амьтан, мал сүрэг өсөж үржин хүн ард нь оюунлаг эрдэм номтой ажил төрөл сайтай амьдрал нь тэгш буян заяатай байх нигууртай юм шүү дээ гээд тэгш цагаан шүдээ яралзуулан инээмсэглэж байсан нь тодхон санагдав. Балбар энэхүү бодлоосоо уламжлан өмнө Авирмэд гавжийг насан өөд болоход нь

- Хайран хүн гэж уулга алдаад түр орхисон бодол бясалгалаа дахин үргэлжлүүлэв.

- Бурхан болооч гавжийн буяны мөр сайхан болоод өнгөрөв. Үзмээ Дэжиднямд хандан

-Охин минь их баярлалаа. Одоо ээждээ очихоос болохгүй байх. Танайх ганц гэрээрээ олон малтай болохоор зав зай муутайхан байгаа байлгүй. Манай Чоймжуур аавынхаа буяны хоногийг нь дүүргээд явах юм гэсэн гэхэд Дэжидням Үзмээд их л өөриймсгөөр

- Та биеэ бодож байгаарай. Нэг бол манайтай айл буучихвал зүгээр юм даа гэхэд Үзмээ инээмсэглээд

- Манай Чоймжуур л мэдэх байх даа. Энэ хэдэн үхэр байж байвал хэрэгтэй юм. Муу өвгөн минь энэ хэдэн үхрээ

- Надад нүүрээ өгсөн буянтай мал байгаа юм. Хүү бид гуравт энэ хэд байхад л болно. Илүү юм хэрэггүй гэдэг байсан даа гээд уртаар санаа алдахад Чоймжуур эхийнхээ сэтгэлийн шаналал гунигийг нь мартуулах санаатай Дэжиднямд

- Эгч ээ та өнөөдөр явах юм уу? гэж асуухад Үзмээ нүдээ том болгоод

- Энэ хүүхэд чинь юу гэнэв дээ гэхэд Дэжидням инээд алдаад хайрлаж хүндэлсэн харцаар Чоймжуурыг харж

- Намайг нэг хоногийн өмнө төрсөн болохоор эгч гэж хүндэлж байгаа юм гэхэд Үзмээ ч инээгээд

- Үгүй ер өө. Юун ч сүрхий юм билээ дээ. Өөрөө чамаас бага дүү хүн болох нь дээ гэхэд Дэжидням

- Тийм ээ. Одоо эгчийнхээ үгнээс гарахгүй юм байгаа биз гэж хэлээд инээснээ

- Миний дүү эгчийнхээ морийг эмээллэчих гэв. Чоймжуур ухасхийн босоод

- За эгч ээ гэсээр гарав. Энэ гурван хүн бие биендээ ийм элгэмсүү байгаа нь бурхан тэнгэрт таалагдаж байв. Үзмээ Дэжидням руу тогтуун хараад

- Охин минь цаад Чоймжууртаа түшиг тулгуур болж яваарай. Хоёр ааваа бодсон ч, хар багаасаа ижил дасал болсон нас чацуугаа бодсон тэр гэж захиж байв. Удвал бид хоёр яахав. Та хоёрыг л сайн сайхан явбал сэтгэл амар байх болно шүү дээ гэхэд Дэжидням дотроо

- Би Чоймжууртаа сайн хань болж чадна. Чоймжуур ч надад итгэдэг. Бид хоёр сайхан амьдарч хоёр ээжийгээ жаргаана гэж бодож байхад Үзмээ Удвалын ярьсан нэг яриаг санаж байлаа

- Ганц охин минь зүрхний өвчтэй юм байх аа. Хааяа унаж тусаад байдаг нь түүнтэй л холбоотой юм гэнэ. Төрөлхийн гажиг өвчин болохоороо бүрэн эдгэрдэггүй байнга л эм ууж байх ёстой юм гэсэн. Харин нэг хэцүү юм нь гэвэл төрж хөнгөрч болохгүй юм гэнэ шүү дээ. Ийм ч гайтай хөөтэй юм байх гэж дээ гэж халаглаж байсныг бодов. Тэгээд амандаа

- Бурханы зарлигтай хувь заяаг бид яалтай билээ гэж шивнэхэд Дэжидням сайн сонсоогүй учир

- Та надад юм хэлэв үү? гэж асуухад Үзмээ

- Үгүй ээ. Би л өөртэйгөө ярьж байлаа гээд инээмсэглэн муухай бодлоосоо салж чадлаа.

Удвал Авирмэд гавжийг бурханы оронд заларсныг охин Дэжиднямаасаа дуулаад ихэд цочирдон уулга алдаад

-Та минь намайг өвгөн дээр минь хүргэж өгнө гэж амлачихаад яагаад түрүүлээд явчихдаг юм бэ? Одоо би гэдэг хүн хаашаагаа харж үхнэ ээ гэж үглэн уйлж байв. Тэр бага зэрэг тайвшраад

- Цаад ууган ах чинь багшийнхаа буяны ажил явдалд очоо биз дээ гэхэд Дэжидням олон юм бодсон ч үгүй шулуухан

- Очоогүй ээ. Намайг явуулахгүй гэж хорьсон. Бас таньд битгий дуулгаарай гээд инээмсэглээд байсан шүү гэж гэв. Үүнийг сонссон Удвал гараа дээш нь өргөөд

- Ээ бурхан минь. Би чинь хүн л төрүүлсэн баймаар юм даа гээд өргөсөн гар нь доошоо сулран унаснаа хадуурын ирэнд өртсөн өвс аятай бүх биеэрээ ханаран унав. Энэ айлд эрлэгийн элч гэнэтхэн морилон ирээд таван сайхан хүүхдийнх нь зүрхийг нь зүсээд, элгийг нь эмтлээд сэтгэлийг нь сэмлээд эхийг нь аваад явлаа.

Агваанням хамбын сэтгэлд нь шатаж байсан өс хонзонгийн түймэр арай багадаж байтал манан будан уулыг дардаг шиг уй гашуу түүний сэтгэл зүрхийг нөмрөв. Тэр айж сандран аргаа барж мухардахдаа хань болгож хажуудаа байлгадаг Готовыгоо дагуулсаар ирлээ. Бас буян номыг нь гэрт нь хурахаар арван лам дагалдан ирсэн байв. Нэгэн бодлын үнэтэй хүндтэй юм шиг мөртлөө дэндүү сүржин сайрхуу мэт санагдаж байлаа. Энэ айлын гутгаар хүү Батням ууган ах Агвааннямтайгаа зөрөлдөн байж Чоймжуур ламыг авчирна гээд мордов. Агваанням хичнээн хорьсон ч дийлсэнгүй. Агваанням дүүдээ

- Энэ олон лам, бас Готов ах байхад Чоймжуураар юугаа хийх гээд байгаа юм бэ? Саяхан эцэг нь өөд болсон байхад яагаад ч ирэхгүй амны гарз болно. Ирсэн ч гай татаж мэднэ гэхэд Дэжиднямын нүд босож хараа нь хурцлагдаад ууган ах өөдөө харснаа

- Ээжийгийн минь хамгийн сүүлчийн захиасыг биелүүлэх ёстой. Тэр аавын байгаа газар очих юм гэнэ лээ. Үүнийг ганцхан Чоймжуурийг хийнэ гэсэн юм гэж ахыгаа мохоох санаатай бага зэрэг худлаа хэлэхэд нь Агваанням

- Чи хошуугаа хумхиад хол бай. Би өнөөдөртөө та бүгдийг мэднэ гэж зандрахад Дэжидням ууган ахынхаа чихэнд ойртоод

- Донир Готовтойгоо долоон уулын цаагуур далд ор гэж хэлэв. Агвааннямд хэлэх ч үг олдсонгүй. Лам нар буяны ном хурж байтал үүд сэвхийн онгойгоод Батням, Чоймжуур хоёр ороод ирэв. Агваанням хүн юм болохоор багшийнхаа хойтын буянд очоогүй учир бага зэрэг сэтгэл зовсхийж байв. Харин донир байсан Готов Чоймжуур ламыг далдхануур ажиглаж байв. Хурлын лам нар ч түүнээс сүрдэсхийж байлаа. Гэтэл энэ гэрийн хамгийг мэдэх болсон Батням хадаг гарган дэлгээд Чоймжуурын өмнө сөхөрч суугаад

- Ээжийн минь амьсгал хураахын өмнөх хүслийг нь дүүргэж их мөрийг дааж бурхан болсон эцгийн минь дэргэд хүргэж өгнө үү. Таньд салхинаас өөрийг нуруундаа хүргээгүй сартай хүрэн зүстэй хангал үрээгээ өмч болгон өргөө гэв. Чоймжуур бага хүн учир бага зэрэг тээнэгэлзэн багш Агваанням хамба өөд харав. Хамба ч юу гэхээ мэдэхгүй балмагдав. Гэтэл Готов

- Ав, ав. Чоймжуур лам аа гэж хэлэв. Энд болж байгаа бүхий л үйл мөр ерөнхийдөө Готовын санаагаар хийгдэж байлаа. Тэр дотроо

- Чоймжуур ламыг шахаанд оруулах сайхан боломж олдлоо. Хамбын эхийн их мөрийг яаж даахыг нь харья. Нэг бол дааж чадахгүй элэг доог болно биз гэж бодож сууснаа

- Чоймжуур ламд тусгайлан олбог тавьж суудал зас гэж дүрэмдэж байв. Чоймжуурын ирснээс хойш Дэжиднямын уйтгар гуниг багасч нүд нь сэргэсэн байв. Үүнийг ажиж суусан Агваанням дотроо

-Охин дүүгээ Чоймжуурт ойртуулж жимс болгоод байсан мэх маань бүр өөрөөр эргээд ураг төрлийн холбоотой болж байвал яана аа гэсэн бодол төрөхөд айх шиг болж бие нь татавсхийв. Тэр амандаа

- Арай ч үгүй байлгүй. Хэрвээ тийм бол яаравчлах болно шүү гэж бодож суув.

Чоймжуур шуудхан уншлагандаа орж Дэмцогядамын хувилгаанд хувилж жаран дөрвөн Ядамыг нь урин залаад өөрийн биеийг хүчит Чойжин болгож хувирав. Хурлын лам нар харж эс чадан нүдээ анин залбирч мөргөж байлаа. Агваанням Готов хоёр айх нь багадаж ичих нь ихдэж нуруу руу нь хүйт оргиж байсан ч бишрэн шүтэж бас гайхаж байлаа. Тэд дор бүрдээ

-Ийм айхтар эрдэм номын хүч чадалтай болчих гэж. Залуугаараа шүү. Аав нь багаас нь тун сайн сургаж дээ. Чоймжуур ламыг жил, мэнгэ, махбодь гурваараа зангилагдсан гансаг ихтэй оюун билгийн оройн дээд болох хүн юм. Ийм хүн өөрийнхөө дураар загнах гээд байдаг юм гэж толгой зурхайчийг айлдахад шавь нь

- Тийм юм билээ багш аа. Луу жил, усан махбодь, гурван хөх мэргийг хэлэв үү гэхэд толгой зурхайч

- Чи чинь овоо шүү. Энэ гурван зангилааны оньсыг тайлж байгаа чинь сайн хэрэг гэж магтаж байсныг бас л санав. Агваанням бодлоо улам гүнзгийрүүлэн

- Энэ Чоймжуураар оролдох ер зөв болов уу? Эл байдлыг ажиглахад дийлдмээргүй янзтай. Готов гуай л үндсийг нь тасал гээд байгаа юм. Надад бол өгөө аваа тэнцсэн гэж бодогдоод байдаг гэж бодож суухад Готов

- Болоогүй. Эрдэм номын чадал ихтэй ч хүн л болсон хойно алдах нь бий. Зүүний үзүүр багтах зай л байхад надад хангалттай. Барс ирвэс хичнээн хүчтэй ч улаан сугандаа амь нь оршдог гэдэг. Баатар нэг суманд, баян хүн нэг шуурганд балардаг даа гэж бардам бодож суув.

Зулын бүдэг гэрэлд Готов хааяа нэг инээх ярвайх хоёрын аль нэгийг хийхэд хохимой толгойтой чөтгөр шиг харагдана. Хурлын лам нар Готовын төрх дүрээс айж Чоймжуур ламын ид шидийн хүч, эрдэм номын чадалд нь шүтэн залбиран мөргөж байв. Буян номын ажил ч болдгоороо болоод өнгөрөв. Буян үйлдсэн хүмүүс ч ирсэн замаараа буцав. Агваанням долоо хонохоор үлдэж Готов буцах болов. Агваанням өөрийнхөө санаа бодлыг Готовт хэлэхэд Готов

- Үр үндсийг нь үлдээе гэж бодож байвал та нарт л гай болно доо. Тэгээд ч гавж мөрөөрөө явсангүй эхийг чинь аваад заларчихлаа шүү дээ. Энэ нэг юм хэлээд байгааг та ойлгохгүй байна уу? гэв. Агваанням сайн тунгааж үзвэл Готовын хэлдэг үнэн байлаа. Өөрөө л өвдөж хавдаад өмөн үү өвчнөөр мөрөөрөө явахгүй муу ээжийг минь чирдэг нь юу билээ гэж бодов.

Бүдгэрч бүүдийгээд унтрах шахан цурманд байсан өс хонзонгийн гал дахин дэгдэж түймэр болж дүрэлзэв. Яг үнэнийг хэлэхэд эхийгээ бурхан болоход морийг нь эмээллэж өгсөн хүн бол Агваанням өөрөө билээ. Нөгөө хэрээ хэрээнийхээ харыг гайхав гэгчээр өөрийнхөө хийсэн гэм нүглийг өөр хүнээс эрж хайна гэдэг мөн их тэнэг мунхаг хэрэг шүү.

Готов зөвхөн өөрийнхөө хорон санаа хүсэл бодлоо гүйцээхийг зорьж өөрийг нь ирт мэс болгочихоод урдаа бариад гэм нүгэл бүгдийг үйлдүүлж байгааг Агваанням яахан мэдэх билээ. Түүнд ямар ч зорилго чиглэл байхгүй ээрүүлийн гол шиг эргэлдэж эргүү тэнэгийн туйл болсон байв.

Тэр Чоймжуур ламыг ирмэгц хэцүү сахил хүртээхээр зэхэж байгаа билээ. Цаг хугацаа зогсох биш дээ. Хүлээсэн хүн ирж Агваанням Готов хоёрын хүсэл биелэх цаг нэгэнт тулаад ирэв. Баярласан хэрээ бархирав гэгчээр Чоймжуурыг гэртээ ирээд аяганы амсар зуугаагүй байхад нь Хамбын дэмч ирж түүнийг түргэхэн ирэхийг мэдэгдэв. Чоймжуур тэр мөчид нь явж очив. Хамба ч түүний аяыг олох санаатай аядуухнаар

- Одоо чиний эрдэм ном тэгширч хүч чадал чинь чамбайрсан байна. Бид чамайг сахил хүртэх цаг нь болжээ гэж үзэв. Дариухан хүртэх болохоор бэлтгэлээ базааж бай гэв. Чоймжуур мөргөөд

-Багш аа. Ямар сахил билээ гэхэд Агваанням хайнгадуухан

- Ямар сахил байхав дээ. Хэцүү сахил байхгүй юу гэлээ. Чоймжуур аавынхаа нэгэн яриаг дурсахад хүрэв.

- Авирмэд гавж Чоймжуурын толгойг нь лж удаан гэгчээр үнэрлээд

-Аав нь гэлэн сахил хүртсэн бол өдийд чи бид хоёр ингээд сууж байхгүй л байсан даа гэхэд Чоймжуур

- Тэр гэлэн сахил чинь тийм хатуу сахил уу аав аа гэж асуухад Авирмэд

- Тийм ээ. Гэлэн сахил авах зан үйл чинь их нарийн тогтоосон ёсоор хэрэгжинэ. Эхлээд багшийн асуусан бүгдэд хариулт өгнө. Үүнд харшлах шалтгаан үгүй бол гэлэн болох эрх нээгдэнэ. Тэдгээрийн дараа дөрвөн орон болох номыг шалгуулна. Мөн унал болох дөрвийг

тэвчих аргыг үзүүлнэ. Энэ ёсыг гүйцэтгэсний дараа бүтээх, бишрэх, дагах, гүйцэтгэх ариун явдалт аяга тахимлаг болж дом хийгээд сахилаа хүртдэг юм. Нэг үгээр Бурханы шашинд хоёр зуун тавин гурван үйлээс цээр хийх болдог юм даа гээд хүүгийнхээ толгойг илснээ цааш нь

- Бас надад хэцүү сахил хүртээх гэж хэсэг нөхөд дайрсан даа гээд санаа алдахад нь

- Ааваа. Тэр чинь ямар сахил вэ гэхэд Авирмэд инээд алдаад

- Тэр үү. Тийм ч сайхан эд биш ээ. Манай шашин номын сахил биш. Хүрээ хийдүүдийн дотооддоо мөрддөг сахилгын сахил юм шүү дээ. Нэг үгээр бурханы шашинд илтээр заналхийлсэн, буруу үзэлтэн, нууцыг задруулсан гэмт этгээдэд хүртээдэг сахилгын сахил юм л даа. Хэрвээ сахилаа нэг удаа зөрчвөл эрлэг ирэх биш өөрөө өөрийгөө эрлэг рүү хүргэж өгдөг хатуу мөрддөг хууль ёстой сүм хийдийн дэглэсэн сахилгын цээрийн сахил юм гэхэд Чоймжуур аавдаа

- Тэр чинь хатуу сахил биш харгис муухай сахил байна шүү дээ гэлээ. Авирмэд

- Бурханы шашинд чинь бузар хэрэг хийсэн нүгэлтэнг дээд хэмжээгээр цээрлүүдэг ёс байхгүй. Яагаад гэвэл нүглийг цээрлэж амьтны амь насыг аврах тангарагтай тийм ч зорилготой болохоор тэр дээд хэмжээгээр цээрлүүлэх эрхийг зөвхөн өөрт нь өгч байгаа хэрэг. Юм гэдэг их нарийн утга учиртай юм шүү дээ гэж ярьсныг сайн сана. Чоймжуур маш түргэн бодож боловсруулж зөв шийдвэр гаргадаг билээ. Тэр дор бөхийн мөргөөд

- Багш аа. Би юуны учир хэцүү сахил хүртэх ёстой болов. Та надад ах минь, багш минь болдог хүн. Надад ийм учраас энэ сахилыг хүртэх ёстой гэдгийг минь сайн тайлбарлаад өгөөч. Үнэн байвал нэн дариухан хүртэе гэлээ. Агваанням хэсэг чимээгүй сууснаа

- Чи энэ сахилыг мэдэх юм уу? гэж сөргөж асуухад нь Чойжуур

- Тийм ээ багш аа. Би мэдэх учир магадтай үндэс утгыг нь тайлбарлуулахыг танаас хүсэж байгаа хэрэг гэлээ. Агвааннямд ийнхүү айж тэвдэх, агдаж бачуурах үед л Готов санаанд нь орж ихэд үгүйлэгддэг билээ. Энэ удаа Готов гуай дэргэд минь байсан бол гэж бодогдож байв. Тэр хоолойгоо засаад

- Чи илүү юманд дурлаж юм болгоныг хэтэрхий мэдэмхийрч бусдыг үл тоох, дээдэст ихэрхэх, доордыг доромжлох басамжлах хандлага чинь манай шашины ёсонд ноцтой харшлаад байна. Энэ бүгдийг чи өөрөө мэдэж байгаа шүү дээ. Тиймээс сахил хүртээх нь зөв гэж шийд гарсан. Ловонгуудын зөвлөл дээр би ганцаараа татгалзсан ч жин дарж чадсангүй гэв. Чоймжуур бөхийгөөд

-Багш аа таньд баярлалаа. Би ловонгуудын зөвлөлийн хурлын шийдвэрийг үзнэ. Бас бүх ловонгуудтай уулзаж хүн бүрээс нь тодруулга авна. Гарцаагүй үнэн байвал хэцүү сахилыг авахад бэлэн байна гэв. Агваанням хамба өөрөөсөө зайлуулж бусдад санаагаа тохох гэсэн хуурмаг санаа бодол нь өөрийнх нь хүзүүг ороогоод ирэхээр хэрэг бишдэх нь гэдгийг гадарласан тэрээр

- Хөөе Чоймжуур аа. Чи жаахан азнаж бай. Хэрвээ чи тэд нартай уулзвал тэд нар чамд дургүйцэх болно. Ловонгуудын дотоод хэрэг рүү орлоо гэж үзнэ. Багш нь маргааш тэдэнтэй уулзаад учирлаад үзье гэж хэлэхэд Чоймжуур мөн л бөхийгөөд

Овоо босгоогүй бол шаазгай юунд суух вэ?

Үндэс нь байхгүй бол цэцэг жимс юунд ургахав

Үг алдвал барьж болдоггүй

Үйл өнгөрвөл эргүүлж болдоггүй гэдэг.

Би багшийнхаа үгийг сонсож дагах мулгуу ухаантай нэгэн билээ. Би таныг хүлээе гэсээр гарч явлаа. Сандарч мэгдсэн Агваанням хамба

-Энэ залуу үнэхээр эрдэм номд сайн боловсорчээ. Гурван сар аавыгаа асарч байна гээд байсан. Тэгэхдээ л эрдмийн их ухааныхаа түлхүүрийг хүүдээ өгсөн бололтой. Уг нь надад өгөх тухай ярьж байсан юм шүү. Би ер нь юу л болоод явна даа, Готов гуайн үг үнэн гэж дагаад байхаар ойр дотнын хүмүүс ах дүүстэйгээ зөрчилдөөд нэг болохгүй болоод байдаг. Одоо явал зохилтой вэ? гэж бодохоор нөгөө Готов л санаанд нь орж түүнтэй л зөвлөлдмөөр болно. Тэр ямар ч аргагүй болж харанхуй болмогц Готовын руу өөрөө явлаа. Готов хамбаас ч илүү баян чинээлэг тохь тухтай амьдарч байв. Тэр Агвааннямаас болсон явдлыг бүгдийг сонсоод харчгар нүүрээ татвалзуулан муруйлгаад араг савар шиг туранхай чөргөр гараараа манжийн бэлэглэсэн хар архины бөглөөг мултлах зуураа

- За тийм байдаг байж .Могой тасарвал гүрвэлийн чинээ гэдэг байх аа. Готов өтлөвч гоохгор бандитайгаа байлгүй дээ. Хамба минь битгий санаа зов. Та жаахан л хүлээж бай. Надад одоо арван гурван настай охин хүүхдийн зүүн сүүжний яс л олдчихвол бүх юм миний санаснаар болно. Тэр үед би таны саад тотгор болгоныг чинь түвэггүй зайлуулж өгнө гээд муухай дуугаар инээхэд Агвааннямд хүний дуу биш юм шиг эвгүй сонсогдов. Харах царай зүс, дуугарах дуу нь хүртэл нэг л ёозгүй санагдаж сэжиг төрж байв. Готов бага гарын мөнгөн аяганд хар архи дүүргээд хамбад барихдаа

- Монголынхоо ёс заншлыг л бодлоо. Та болгоочих гэхэд нь Агваанням

- Готов гуай миний ёстой сураагүй юмны нэг гэхэд

- Хамба аа. Цай уухад юуг нь сурдаг юм бэ? Илүү хэрэг байхгүй. Үүнийг чинь сэтгэл санааг сэргээдэг, дотор биеийг цэвэршүүлдэг гэж бичсэн байдаг юм. Эмэнд ч орно. Нүдээ аниад найман гэгээнийг бясалгаад би хараагүй, мэдэхгүй гээд хүртэж орхи гэж зааж өгөв. Өөөрийнхөө үнэнч туслагчийн үгнээс гажилтай нь биш дээ. Агваанням нүдээ аньж байгаад л хүртэж орхив. Муу хүний нөлөө ийнхүү сайн болгоныг харлуулж унал руу түлхэж байдаг. Готовыг хараал жатга муу үйл хийдэг гэж ярьдаг. Бас түүнээс хүн бүхэн л зай барьж холуур тойрдог билээ. Агваанням Готовт хандан

- Та одоо хэцүү сахил хүртээж болохгүй болохоор өөрийнхөө чаддаг хэцүү аргыг хэрэглэхээр

шийдээд байна уу? гэхэд Готов инээмсэглээд

- Одоо хэрэглэхээс өөр арга алга. Бас хугацаа хэрэг болох нь. Би нөгөө эрж хайж байгаа юмаа олоход амархан биш байна. Тийм болохоор бас нэг арга хэрэглээд үзье гээд муухай ярвайгаад инээв. Тэрвээр хамба руу ёжтойхон харснаа

- Эвийг нь олоод Улиастай манж амбанд хүргүүлээд Манжийн эсрэг бодлоготой гэдгээр барьж хорионд оруулж байгаад учрыг нь олуулъя гэхэд Агваанням дагаж инээд алдаад

- Наад арга чинь зөв бололтой. Та бид хоёрын гар цусдахгүй өөр хүний гараар могой бариулна гэдэг болох юм биш үү гэхэд Готов

- Хамба та тун ч онож хэллээ. Мэргэн ухаан болгон үг хэлээр илэрч байдаг гэдэг дээ гээд Агвааннямын хамрын хоёр нүх өөд унгас сайн чихээд тавьчихав.

Үүр дөнгөж гэгээрч байх үеэр нэгэн морьтон их яаруу бололтой Сутай хайрханы урд сугаар ороож Зүйлийн хүрээний зүг хурдална. Тэр хүн шулуухан явсаар хүрээ хийдийн их хамба Агвааннямын өргөө гэрт морилов. Дөнгөж нүдний аньсгаа салгаж байсан хамба томоор эвшээгээд их л дурамжхан маягтай элчийг хүлээн авлаа. Элч

-Билэгт лам таньд үүнийг хүргүүллээ. Маш яаралтай гэсэн учир таны амгаланг алдагдууллаа. Өршөөгөөрэй гээд маш нууц гэсэн бичвэртэй бичгийг гардуулав. Хамба Агваанням дотроо

- Эд нөхөд чинь Улиастайд хүрээгүй мөртлөө яахаараа ийм бичиг илгээдэг билээ. Ямар нэгэн учир ургалаа даа гэж бодоод бичгийг задалвал

- Их хамбын амар амгаланг айлтгая. Бидний зам зуурт санамсаргүй гай зовлон тохиолдлоо. Цагаан олмын гармаар үертэй байсан ч үүрэг даалгаврынхаа давчуу хугацааг санаад голыг гаталж байтал лам Чоймжуур морьтойгоо хөл алдаад үерт урсаад сураггүй боллоо. Шөнө дунд байсан болохоор өглөө эртлэн эрж хайсан боловч эс олов. Одоо цаашид хэрхэх тухайгаа таны айлдварыг хүлээхээр шийдээд аян замаа түр саатаав гэсэн байв. Хамба ч тэр дариудаа Готовыг дуудаж зөвлөлдөв. Готов толгой сэгсрэн

- Тийм бүтэлгүй юм байх гэж. Энэ билэгт лам Шарав та хоёр чинь нэг зиндаа дотнын хүн гээд байсан биз дээ гэхэд хамба

- Тийм ээ. Дотнын итгэлтэй хүн минь мөн. Тэгээд ч нөгөө хүн маань өөрөө мөрөөрөө яваад өгсөн байхад та юунд уцаарлав гэв. Готов чөргөр гараараа туранхай хорчгор нүүрээ арчингаа

- Надад нэг л сэжигтэй санагдаад байна. Хамба та Билэгт ламд учрыг ер хэлээгүй биз дээ гэхэд хамба

- Хэлээгүй. Хурал номын зорилгоор яваагаа л мэднэ. Өөр бусдыг зүүдэндээ ч санахгүй байх гэхэд Готов бодлого болж байснаа

- Шарав чинь Авирмэд гавжийн гарын шавь нь мөн биз дээ гэлээ. Түүний энэ их сэжиг Агвааннямд таалагдахгүй байв. Алив нэгэнд ердөө ч итгэдэггүй дандаа хардаж сэрдэж буй нь

санаанд нийцдэггүй билээ. Ямар сайндаа ойр дотнын нөхөдгүй, олон түмэн сэжиглэн чөтгөр Готов гэж нэрлэж байхав гэж бодсон Агваанням нухацтайгаар

- Та юу гэх гээд байна? Манай Шаравт итгэхгүй байгаа хэрэг үү? гэхэд Готов арай зөөлрөөд

- Хэргийн учир итгэхгүйдээ биш Чоймжуур лам Завхан голын цагаан олмын гарамд усанд унаад үхчих хүн биш ээ. Тэр чинь Алаг хайрхан уулын өврийн үхэр хонин чулуун дунд тэвэг өшиглөж тоглодог, догшин урсгалт Улиастайн голд шумбаж өссөн хүн шүү дээ. Авирмэд гавж хүүгээ Арьяабало бурханд амь насыг нь даатгаад, ухаанд нь Жамъян бурханыг залж, биед нь Сандаг бурханы хүчийг шингээсэн бололтой юм. Миний зоос худал хэлэхгүй. Чоймжуурыг чинь Эрэгсүм Гомбо бурханы хувилгаан юм гээд байна. Язгуурын гурван бурханы билэг чанар тодорсон болохоор тийм ч амархан биш бололтой. Тэгээд дээр нь гурван үндэс зангилагдсан гансагтайг нь яана. Та бид хоёр энэ хүний махан биеийг нь үгүй хийхээс биш оюун билэг хүсэл зоригийг нь мохоож чадахгүй юм байна. Одоо би зоосонд дахиад нэг үзээд орхие гээд зоосоо зайлж нүүрнийх нь үрчгэр арьс татвагнан хохимой толгойгоо хөдөлгөн есөн зоосоо гүйлгэв. Тэр хоромхон зуурт тогтоон уншсанаа

- Тэгнэ ээ тэр. Баярын совин гэрэлтээд магнай дэлгэрч оюун ухааны цоморлиг нээгдсэн байна. Үлэмж төгс умай цэцгийн баланд бялуурч амьд хүмүүний бие сэтгэлийн жаргал эдэлмүү хэмээжээ гээд зоосоо хурааж бодол болов. Агваанням дотроо

- Үлэмж төгс умай цэцгийн баланд бялуурна. Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж бодож суутал Готов үүний хариу болгох мэт

- Та бид хоёр танай охин дүүгээр чинь өөш тавьж хортой жимс болгосон маань эндүүрэл болжээ. Тэр бүсгүй түүний төлөө амь биеэ зориулахаар нэг мөр шийдсэн бололтой гэв. Агваанням энэ болгоныг сонсоод ихэд хямарч сэтгэл нь тавгүйдэв. Тэрээр

- Миний дүү Дэжидням минь. Чи чинь юугаа бодож санаж яваа хүн бэ? Эцгийг чинь хорлосон муу санаатай өстөнийхөө хүүтэй хувь заяагаа холбоно гэдэг чинь юу гэсэн үг вэ? Ийм тэнэг мунхаг юм хийж яаж болно. Одоохон сэтгэлээ татаж ав. Чамайг үүнийг хийж чадахгүй гэвэл би эцсийн аргаа хэрэглэхээс аргагүйд хүрнэ гэж бодоод нүд нь хурцлагдав. Тэр Готовт бараг мөргөх шахам болоод

- Ах минь. Та л тус болооч. Нөгөө хэцүү аргаа хийж өгөөч. Та миний дүүг түүнээс салгаад надад үлдээгээд өгөөч гэж царай алдан өвдөг сөхрөн байгааг нь харсан Готовын дургүй нь хүрэв. Тэр дотроо

- Ийм арчаагүй байж яаж хамба хийнэ дээ. Энэ байтугайгаа ч золиослох зүрх зоригтой байх хэрэгтэй шүү дээ. Одоо миний өвөр лүү өөрөө ороод ирлээ. Хамбын эцгийн энэ цагаан хаш хөөрөг ч мөн сайхан нүнжигтэй эд шүү дээ гэж бодоод

- Хамба минь жатга хөөлгөх чинь амархан юм биш. Бас айхтар сонголт хийх хэрэг гардаг юм билээ. Таньд маш хүндхэн юм тохионо. Юу вэ гэвэл та хайртай хоёр юмныхаа нэгийг нь өөртөө авч үлдээд нэгийг нь төлөөсөнд тавих болно гэв. Агваанням айсан нүдээр Готовыг харж юуны тухай яриад байгааг нь үл ойлгон

- Готов ах аа. Та юуны тухай яриад байна? Би сайн ухаж мэдэхгүй будлиад байна гэхэд Готов инээмсэглэж хамбыг тайвшруулахыг хичээсэн хэдий ч хамбад мөн л хохимой толгой харагдсан учир бүр ч айж бэмбэгнэж байв. Готов дотроо бах тав нь ханаж

- Энэ хүнийг ээ. Бүр сүнс нь зайлаад өтгөн шингэнээ алдахад хүрчихлээ шүү дээ. гэж бодоод

- Тэр амархан даа. Хамба минь та охин дүү, цагаан хөөрөг хоёрынхоо аль нэгийг өөртөө авч үлдэхийг л сонгох хэрэгтэй болоод байна даа гэхэд Агваанням амаа ангайгаад үг хэлж чадахгүй алмайрав. Муу санаа эзнээ отно гэдэг мэргэн үгийг тэр яахан ухаарч санаж чадах билээ. Амь нь гарч байгаа амьтан аятай хорон санаандаа боймлуулан хомхой сэтгэлтний идэш болох нь энэ байлаа. Энэ том суудалтай, их мэдэмхийрч хоосонг самардсан тэнэг эр төрүүлсэн эхийнхээ морийг эмээллэж эрлэгт илгээсэн бол төрсөн дүүгээ хөөрөгтэйгөө дүйцүүлчихээд хөглөж суугааг эцэг эхийнх нь сүнс харж байгаа бол их л харамсан халаглаж байгаа даа.

Агваанням үг хэлж чадахгүй хэсэг болоод амнаас нь ганц ч үг гарсангүй эцгээсээ өвлөж авсан алтан нуухтай залуу шүрэн толгойтой их гарын цагаан хаш хөөргийг үг дуугүй Готовт сарвайхад тэр хөөргийг хурга шүүрэх бүргэдийн савар шиг муухай чөргөр гараараа шүүрч авав. Тэрбээр

- Өнөө шөнө би онгон догшин сахиусанд хувилж охин дүүгээс чинь Чоймжуурыг салгаж аваад биеийг нь галд шатаан үнс болгоод сүнсийг нь тамын орны хүйтэн тамд хүргэнэ гээд хөнгөхнөөр босоод гарч явав. Агваанням хамба маань уншиж бурхандаа мөргөсөөр хоцров. Маргааш өглөө нь нарны шаргал туяа Сутай хайрханы мөнх цас мөсөн оргилтой залгах үеэр Зүйлийн хүрээний баруун зүүн жигүүрт цагаан лавайн дунгийн дуу ээлжлэн тасралтгүй эгшиглэж амар амгаланг оршоов. Тэнгэрт бүртийх ч үүлгүй тунгалаг хөх өнгөөр дуниартана. Өглөө бүр шинэ шинэ сайн сайхантай золгодог бол өнөөдрийн тухайд бүх юм шинэ болсон мэт өнгөлөг харагдаж байв. Агваанням хамба энэ болгоныг ажиглан сэтгэлээ сэргээж байв. Гэтэл Донир нь яаран ирээд мэнд ус мэдээд түүнд

- Урд шөнө гүн харанхуй үеэр болов уу даа донир байсан Готов гуай гэртэйгээ шатаад зөвхөн үнс л үлдсэн байна гэв. Агваанням хамба

- Ээ бурхан минь. Юу гээч болоод байна? гэж амандаа үглээд дотроо

- Би өнөө шөнө догшин сахиусанд хувилна. Чоймжуурыг үнс болгоно. Сүнсийг нь хүйтэн тамд хүргэнэ гэсэн хүн чинь яагаад өөрөө үнс болчихдог билээ гэж бодож байтал Цорж, Ширээт лам, Их гэсгүй гурав орж ирэв. Тэд болсон явдлын тухай ярьж буяны хурал ном хурахаар тогтов. Гэтэл шижээч гурван лам ирж газар дээр нь бүгдийг шинжиж үзсэнээ товч яриад

- Энэ хөөрөг гээд хамбын хаш хөөргийг гаргаад

- Бага зэрэг шар туяа цохисноос өөр юмгүй гээд ширээн дээр тавихад Цорж лам

- Энэ чинь Хамба таны хөөрөг байх шив дээ гэхэд Агваанням толгой нь хүзүүтэйгээ

хүрэнгээд гар нь бага зэрэг салгалан

- Тийм байна. Мөн байна гэхээс өөрийг хэлж чадахгүй ээрэгнэн байв. Шинжээчид

- Талийгаачийн далны ясны толгой, л шатаж гүйцээгүй үлдсэн байна билээ гэв. Ширээт лам

- Энэ ер нь юу болоод байна вэ гэж лавлахад шинжээч нар

- Энэ хүн муу хатуу хар үйл хийсэн бололтой. Шатсан буйрнаас нь зайдуухан хүний сүүжний яс хэвтэж байна лээ. Бодвол тэр хатуу үйлийн хэрэглэгдэхүүнд орсон байх гэхэд Ширээт лам толгой сэгсрээд

- Хараал жатга хийсэн л болж байна даа. Талийгаач амнаасаа илүү гарах эрдэмгүй хүн л дээ. Муу санаа нь ингээд өөрийг нь аваад явчихлаа даа. Тэр сүүжний яс, далны толгой хоёрыг үнс болгоод гэрийнх нь буйрыг аргадаж лус савдагт түй өргөх хэрэгтэй гэхэд Цорж

- Энэ хүн чинь жатга хөөлгөөд өөр дээрээ буулгачихсан болох нь дээ гэхэд Ширээт лам

- Үгүй юм шиг байна. Цаад хүн нь их эрдэм чадалтай бололтой. Шууд л хариулсан учир ингэж юу ч үгүй болдог гэдэг. Гаднын хүний юмыг бүрэн бүтэн үлдээнэ гэж бодохоор үнэнхүү эрдэм номын ид шид ихтэй гэж үзэхээс өөр арга алга гэв. Цорж

- Хамба минь. Та хөөргөө сайн ариусгаж аваарай гэсээр гарч явав. Агваанням ганцаараа үлдээд бодолдоо дарагдан

- Энэ Чоймжуур ямар гээчийн номын ид шидийг эзэмшээд авчихав аа? Аавын минь хөөргийг үлдээдэгийн учир юу билээ. Готовынх биш болохоор үлдээв үү? Миний ч гэсэн бие сэтгэл нэг хүлээснээс мултарч чөлөөтэй болсон мэт санагдаад байна. Амар тайвныг мэдэрч байгаа нь юу билээ? Готов гуай миний оюун ухаан бие сэтгэлийг минь эзэмдэн баглаж атгаж байсан юм болов уу? Эсвэл би тийм сул дорой арчаагүй амьтан байв уу? Дөрвөн аюулын нэг нь доройтох нь хотол биеийг дарна гэж байдаг. Тэр л надад байх шиг.

Манайхан чинь хэн нэгнийг бурхан болоход тэр аяараа хөдөлж зовлонгоо хуваалцан буян үйлддэг билээ. Гэтэл өнөөдөр чинь юу ч болоогүй юм шиг амгалан байх чинь ямар хачин юм бэ? гэр шатаж байхыг нь нэг ч хүн үзээгүй хараагүй байдаг гэж бодож суув. Тэр өдөржин л бодолдоо дарагдаж өнжив.

Орой нар жаргахын үед дүү Батням нь ууган ахынхаа хоол хошийг нь дөхүүлээд ирэв. Тэдний эх бурхан болсноос хойш гурван ч жил өнгөрсөн байлаа. Тэр хоёр цаг агаар, нутаг усны талаар хэсэг ярилцаад Батням буцна гэхэд Агваанням дүүгээрээ хань татаж байгаагаа өөрөө ч мэдэхгүй

-Миний дүү унтаад яваач гэж гуйх шахам хэлэхэд Батням түгдэрсхийгээд

- Отгонням ганцаараа байгаа болохоор явахгүй бол болохгүй гэв. Агваанням дүү өөдөө хараад

- Цаад Дэжидням чинь байгаа биз дээ гэхэд Батням ууган ахдаа хэлж зүрхлэхгүй байсан зүйлээ хэлэхээр шийдэв. Тэр

- Ах аа. Дэжидням гэрээсээ яваад өгсөн. Бид нар сайн ярилцсан. Дүү маань Чоймжуурыг дагаад тэдний рүү явсан гэлээ. Энэ удаа Агваанням бага зэрэг балмагдсан ч талийгаач Готов санаанд нь орж ирсэнгүйд тэр гайхаж байв. Тэр хүн ёстой л үр үндсээрээ таслагдан хол явж одсон бололтой. Батнямаас Дэжиднямыг таван сартай хөл хүндтэйг дуулаад арай л орилсонгүй

- Одоо яана аа гэж гаслав. Батням

- Та тайван бай. Ямар нэгэн арга чарга байх л байлгүй гэхэд Агваанням дүүдээ хандан

- Та нар мэдэж байгаа юм уу? гэхэд Батням толгой дохиод

- Мэдэлгүй яахав. Чоймжууртай ч сайн ярилцсан. Тэр дэргэдээ байлгаж Үзмээ эгч асарч тойлох юм гэнэ лээ. Тэр нь ч зөв байх. Манай охин дүү чинь дураараа ч хүн юм. Тэр хэлэхдээ.

- Би Чоймжууртаа амь нас бие сэтгэлээ нэгэнтээ зориулсан болохоор ямар ч хувь тавилан байна би түүнийг хүлээж авна. Би хэн нэгний хар буруу сэтгэлийн золиос болохгүй. Үндэс мөчиргүй өгөр мод шиг ганцаараа урт богино насалмааргүй байна. Би хорвоод бүсгүй хүн болж төрсөн учир үрийн зулай үнэрлэж эхийн элбэрэл хайрыг дэлгэрүүлэн үртэй хүн шиг бүтэн жаргамаар байна. Миний үхэх агшин үр минь төрөх үе нь юм бол үрийн минь заяа, ханийн минь тэнгэр түшиж тулах байлгүй. Хувь заяаны минь хүрд хаашаа эргэнэ. Би түүнийг дагах болно. Би хорвоод хэнд ч гомдоллохгүй. Өөрийнхөөрөө амьдраад бүтэн ирсэн шигээ бүтэн буцмаар байна. Би ах нартаа итгэдэг шигээ өөртөө итгэлтэй байна. Намайг ойр байвал царайг минь харж сэтгэлээ дэлгэрүүлж байгаарай. Харин хол явчихвал үрийг минь хайрлаж сэтгэлээ чангалаарай. Холын одонд цацлаа өргөөрэй гэж хэлсэн шүү дээ гэхэд Агваанням дотроо

- Хэн нэгний хар буруу сэтгэлийн золиос болохгүй гэж надад хандсан үг байна шүү. Чоймжуур аавын хөөргийг надад эргүүлэн үлдээсэн нь охин дүүг чинь би аваад явлаа гэсэн сануулга байх нь. Аугаа их ухаантай айхтар золиг юм гээч. Бие муутайг нь мэдсээр байж санаатай юм шиг бие давхар болгодог нь яаж байгаа хэрэг вэ? Зөвхөн өөрийнхөө үр үндсийг үлдээж авах гэсэн атгаг санаа биш гэж үү? гэж бодоод амандаа

- Одоо би яах вэ гэж аяархан шивнэхэд нь Батням ахынхаа аливаад шийдвэр гаргаж чадахгүй бусдын ам харж байдгийг нь мэдэх болохоор

- Одоо яахав гээд байх юм байхгүй. Бидний хувь заяа иймээс хойш дагахаас өөр зам мөр байхгүй. Сөрнө гэвэл өөрсдөө л хохироод үлдэнэ шүү дээ гэлээ. Агваанням аавынхаа хөөргийг гартаа эргүүлэн байснаа дотроо

- Аавын их заяа гомдсон байх даа. Хөөргийг нь хар муу санаатай хүний гарт атгуулж хараалын голомтны үнсэнд үлдээсэн болохоор гомдож л таарна. Энэ эд надад хүндээд байна.

Дүүдээ өгье гэж гэнэт шийдээд

- Батням аа миний дүү аавын хөөргийг чи барих хэрэгтэй юм байна. Надад юу ч битгий хэл. Чи гэр орон голомтыг нь сахиж яваа болохоор гээд өгөв. Батням юу ч хэлэлгүй авч үнэрлээд

- Ах аа. Би энэ намар орон гэрээ тусгаарлана. Манай Отгонням ч бас бэр буулгах байх. Та намайг авсан гэж бодоод өөртөө үлдээ дээ гээд эргүүлээд барихад нь эргэлзсэн ч үгүй шууд авав. Дүү нарынх нь амьдралаа авч яваа ухаан, хэлж ярьж байгаа үгний мэргэнд баярлаж сэтгэлд нь гэгээ татаад явчихлаа.

Чоймжуурынх Сүжийн усанд намаржиж байлаа. Дэжидням ойр ойрхон дуншин Зундуй маарамба үе үе судсыг нь барина. Үзмээ их л айж балмагдан сэтгэл нь өвдөнө. Дэжиднямыг ёолж зовиурлах болгонд тэр гараа атгалан духанд нь хөлс бурзайна. Харин Чоймжуур нүдээ анин чимээгүй үхэх төрөхийн эгзэгтэй агшинг огтхон ч тоосон шинжгүй дүмбийн алив нэгийг бясалган сууна. Энэ болгоныг сэргээн дурссан Балбар өвгөн бодлоосоо айх шиг болоод арай ядан салав.

Хорин ес

Балбар аяга цай ууж амсхийгээд ойр зуурт сэтгэлээ саатуулах гэсэн боловч бодол нь амьдралын эгзэгтэй агшинг нэхэж эргүүлэн гүн бясалгалд суулгав.

Байгаль дэлхий алив нэгэн аюул болохын өмнө амсхийх мэт болоод чимээгүй дүнсийдэг билээ. Энэ нэгэн өргөө гэрт ойр ойрхон дуншин өвдөж байсан Дэжидням орь дуу тавихаа больж түр амсхийв. Зундуй маарамба яаран гарын бугуйг атгаж судлыг тэмтэрнэ. Үзмээ юу хийхээ мэдэхгүй үүдний хавиар эргэлдэж амандаа алив нэгийг шивнэж байв. Харин Чоймжуур баруун талдаа юу хийж байгааг нь тааж мэдэх нь битгий хэл амьд үхсэний алийг нь хэлэхэд бэрхтэй хэцүү байлаа. Зундуй маарамба

-Эх хүүхэд хоёрыг аврахсан гэж бодож байсан ч Дэжиднямыг аврах арга алга байлаа. Одоо ганцхан горьдлого үр хүүхдийг нь аврах хэрэгтэй гэж өөртөө хэлнэ. Олон удаа ойлгуулж хэлсэн ч зүтгэсээр байгаад өөрөө төрнө гэсэн хүнийг яалтай нь билээ. Чоймжуур ламд бас хэлсэн ч тэр Дэжиднямынхаа үгнээс зөрж эс чадна. Үзмээ айж сандрахаас өөр ид шид байхгүй амьтан амандаа юм хэлээд уншаад байгаа юм уу гэмээр уруул нь хөдлөөд байхаас биш чухам юу хэлээд байгаа нь эс дуулдана. Үхлийн ирмэгт байгаа хүний дэргэд байх эмч оточ хүн л яг өөрөө үхэх гэж байгаа мэт зовж шаналдаг билээ. Зундуй маарамба Дэжиднямын царайг байнга ширтэж ажиглана. Гэтэл түүний хацарт улаан туяа суугаад нүдний зовхины татвагнах зогсож судасны цохилт жигд хэвийн болоод ирэв. Маарамба дотроо баярлаж байсан ч яагаад ингэдэг билээ гэж гайхаж байлаа.

Гэнэт ухаан орсон аятай Чоймжуур хонх дамар дүнгэнүүлэн ойр орчмыг бүхэлд нь цочоож орхив. Тэр их дуун дундуур нялх хүүхдийн цовоо цойлгон дуу агаар цалгиан цангинаад Сүжийн уулсыг өндөлзүүлж булаг усыг оргилуулав. Дэжидням ч төрж хөнгөрөн бие нь тэнхэрч энэ айлд шинэ хүн морилон ирж шинэ амьдрал эхлэв.

Хорвоо сайн сайхан болгонд ханаж цадахгүй баярлаж байхад ганцхан Зундуй маарамба л олныг эргэцүүлж тархиа гашилгаж суув. Дэжиднямын төрөхийн өмнө зүрхний гажиг засарч эрүүл саруул хүн шиг хөнгөрсөн бол гурав хоногийн дараа нөгөө гажиг согог дахин илэрсэн билээ. Яг төрөх үеийн хүчтэй булчингийн агшилт зарим эрхтэнд үйлчлэх учир түүний зүрх даахгүй байсан билээ. Гэтэл тэр үед бүх гажиг засарч хонх дамар хүчтэй дуугарах мөчид хүүхэд төрсөн шүү гэж бодож байсан Зундуй маарамба Чоймжуур ламтай дотночилон ярилцахад Чоймжуур

- Маарамба ах аа. Би яг тэр агшинд оюун ухаанаа нэг цэгт төвлөрүүлж чадаад илбийн ухааныг эзэмдсэн төдий хэрэг. Тэр ухаан дээд тал нь гурав хоногоос хэтэрч чадалгүй дахин задардаг юм гэхэд Зундуй маарамба толгой сэгсрэн

- Мөн ч гайхалтай юм аа. Тэгвэл танайд нэг биш хоёр хүн шинээр мэндэлсэн юм байна шүү дээ. Гэхдээ л Дэжиднямын өвчин улам хүндрэх байх. Эм тан уугаад ч хүчрэгдэхгүй болж мэдэх юм шүү. Ёстой азтай хүүхэд юм даа гээд яриагаа өндөрлөсөн билээ.

Үзмээ шиг баяртай жаргалтай хүн алга байлаа. Ач хүүгээ үзэх гэдэг хичнээн сайхан болохыг

Үзмээ хэлж чадахгүй уулзсан болгонтойгоо толгойгоо дохин хоёр нүдээ аргадна. Тэр Авирмэд гэдэг хүний үр удам тасралгүй үргэлжилсэнд баярлахаас гадна ганц хүүгийнхээ хань Дэжиднямыг эрүүл саруул төрөөд эсэн мэнд байгаад нь бурхан болсон аав, ээж хоёрынх нь ариун сүнснийх нь өмнө нүүр бардам байгаадаа баярлаж байлаа.

Зундуй маарамба хэдийгээр ам бөхтэй ч оюун ухааны ийм хосгүй гайхамшигийг магтан шагшихгүй байж чадсангүй. Эл яриа ч дүүгүүрийн чулуу шиг чимээ гарган Усан зүйлийн хүрээгээр нэг тархав. Агваанням охин дүүгээ амьд мэнд хоёр яс салсанд баярлаж байсан ч дотроо Чоймжуурт дургүй хэвээрээ байлаа. Түүнийг миний охин дүүгийн нөхөр шүү гэж тэр хэзээ ч өрөвдөж өршөөж үзэхгүй байв. Тэрээр

-Аав ээж хоёрыг минь эрлэгт хүргэсэн хүн бол Авирмэд гэж бүр итгэсэн байлаа. Одоо хүү нь ганц охин дүүг минь яах л гэж байгаа бол. Тэр цагт л чамтай үзнэ дээ гэж бодож байв. Цаг хугацаа өнгөрсөөр Чоймжуурын хүү Хайдавжамц хоёр ойтой боллоо.

Чоймжуур догшин улаан сахиусны орон Улаан хайрханы Үнхэлцэгийн агуйд намар хаврын зургаан сарын улаан тэргэлээс эхлэн битүүнийг дуустал дараа сарын шинийн нэгнийг хүртэл дияан бясалгалд сууна. Бусад үед нь голдуу Улиастайн бага голын Арьяаболын бүтээлийн сүмд сууж ном бясалгана. Мөн бусад дуган хурлын газраар явж ном айлдана.

Хүү Хайдавжамц нь өсөж торниж байлаа ч эх Дэжиднямын бие өдрөөс өдөрт муудсаар байлаа. Дэжидням хэний ч сэтгэл санааг зовоохгүй гэж хүчээр шахам инээж хөхөрч байлаа. Тэр хүүгээ харан баярлаж

- Аав шигээ эрдэм номтой хүн болоорой. Ээж нь холоо яваад түргэхэн буцаад ирнэ. Эмээ ээжийнхээ үгэнд сайн ороорой. Аавыгаа бясалгалд явсан хойгуур битгий л дэггүйтээд мод унаад мал үргээгээд сүү татаж асгаад байгаарай гэж хэлээд муухан инээмсэглээд Үзмээд хандаж

- Ээж ээ. Манай Хайдавжамц аав шигээ эрдэмтэй хүн болох болов уу? Та юу гэж бодож байна? гэхэд Үзмээ дотогшоогоо уйлан байж гаднаа сэтгэлээ барьж

- Энэ золиг аав ээж хоёрыгоо хоёуланг нь өвчөөд төрчихсөн юм. Миний ач хүү чинь их эрдэм номтой хүн болно. Сүжийн усан дээр төрсөн сүрхий хүү шүү гэж өхөөрдөнө. Дэжидням хүүгийнхээ толгойг удаан гэгчээр үнэрлээд Чоймжуур өөд тогтуун зөөлөн боловч гунигтайгаар хараад

- Хүү та хоёр минь л сайн явбал би хаана ч байсан жаргалтай байна. Ууган ах минь тэгэж байгаад ухаарах байгаа даа. Наад гурван ах ч яахав. Өөрсдийгөө аваад олны дунд явна. Та ууган ахад минь номын цагаан буянаар туслаж ухаан бодлыг нь ариусгаж өгөөрэй гэж хэлээд бурханы орондоо морилов. Түүний амгалан царай хөх тэнгэр шигээ цэлмэг унтаж байгаа юм шиг тайван байлаа.

Чоймжуур ээж хүү хоёр дээрээ хааяа ирнэ. Ихэнхдээ Улаан хайрханы Их тагын агуйд дияан бясалгалаа хийж байв. Тэр ингэж амьдарч байхдаа олныг эргэцүүлнэ. Тэр аавынхаа захиасыг эн тэргүүнд бодно.

- Миний хүү амьдралд юу эс тохиолдохыг хэлж барах билээ. Зорилго чиглэлээсээ хэзээ ч ухарч няцаж болохгүй. Заавал эрдэм номын оргилд гардаг юм шүү. Аавынхаа хүрч чадаагүй тэр оргилд хүрвэл миний сэтгэл дүүрэх болно. Сэтгэл дүүрнэ гэдэг нь би нутаг усандаа эргэж төрнө гэсэн үг юм шүү гэснийг санаж сэрнэ. Нөгөө нэг зүйл гэвэл Дэжидням бурханы оронд морилохынхоо өмнө их хүсэж гуйсан аялгаар

- Ууган ахад минь номын цагаан буянаар ариусган ухааруулж тус болоорой гэсэн билээ. Гэтэл тэр өөрийгөө шүүнэ.

- Хурал номоо орхиж оргож боссон. Багшаасаа урваж барилдлагаа тасалсан. Донир асан Готовын муу сэтгэлийг хариулж амь насыг нь үгүй болгосон. Адаг сүүлд нь авааль гэргийгээ алдаж ганц хүүгээ өнчрүүлсэн гээд бодохоор бага хугацаа жижигхэн орон зайд тэвэрт багтахгүй тэнгэрт тулам их нүгэл үйлдсэн юм шиг санагдаж байв. Тэр даяаны бясалгалаа дүүргээд хүүгээ аваад бурханы оронд очиж мөргөл буян хийж хийсэн нүглээ наманчилж бага ч болов нимгэлье гэж шийдэв.

Энэ шөнө Агваанням хамбын нойр хулжив. Тэр Готовын үгэнд ороогүйдээ харамсаж байв. Үндсийг нь таслаагүй үлдээснээс хор нь боловсорч ганц охин дүүг минь аваад явлаа. Дараа нь бид дөрвийн хэн нэгний нь ээлж хүлээж байгаа. Тийм болохоор би гурван дүүгээ хамгаалах ёстой. Ном эрдмийн чадлаар дийлэхгүй нь мэдээж. Тэгвэл аав ээжээс заяасан яс махныхаа бяр тэнхээгээр эр хүний ёсоор үзэх цаг нэгэнтээ болсон гэж бодоод хар дээл өмсөн хэт хутга зүүгээд омголон хонгор мориндоо зүтгэлэн байж мордоод амандаа

-Би гэдэг хүн чинь бөгсөн биеэ ч даахгүй болох нь шив дээ. Энэ их чийгэнд суусаар байгаад дороосоо ялзарч байгаа бололтой шүү. Өнөөдөр л энэ хэргийг нэг мөр болгоё. Ингэж амьдаараа тамын тогооны ирмэг дээр тарчилж зогсохоо больё гэж шивнээд хонгор морины хондлойд тэнзэн ташуурын хүчийг үзүүлэв. Тэр Баян голын эхэнд зусаж байгаа айлуудад бууж цай уугаад Улаан хайрхан хүрэх замыг сайтар заалгаад цааш хөдлөв.

Урд өмнө энэ Улаан хайрхан уулыг сонсож л байснаас огт үзээгүй болохоор ойртоод ирэх тусам ихэмсэг догшин дүр төрхөөс нь сүрдэж байв. Яагаад ч байгаа юм бүү мэд нэг л зүрх халираад байх шиг санагдана. Тэр Шар чулууны хөлөөр гараад ар хормой өөд нь өгсөж явтал хонгор морь ямар нэг юмнаас бусгаж огло харайхад Агваанням хазайсан талруугаа толгойгоо даахгүй унаад өгөв. Тэр цулбуураа тавиагүй учир морь нь биеэ чангалан зогсоод хааных нь хөх мах чичирч байв. Сайн харвал хамрынх нь угалз томрон нүдэнд нь айдас хургасан байлаа.

Ойр хавьд нүдэнд үзэгдэх юм алга байлаа. Саяхан гарсан бололтой жижигхэн дэвхрэг ганц нэгээрээ үсрэх нь үзэгдэнэ. Морио хөтлөөд явах гэтэл лаг шаварт зоогдсон аятай огт хөдөлсөнгүй. Энэ чинь юу билээ гэж бодоод өөрийгөө чагнавал хоёр өвдөг нь чичирч зүрх нь хүчтэй дэлдэн сэтгэлд нь айдас хүйдэс хурган ар нуруу руу хүйт оргин даарах мэт жихүүдэс хүрч байв.

Хамба хамаг мэддэг ном тарниа дүнгэнэтэл уншсаар суув. Хичнээн хугацаа өнгөрснийг ч мэдсэнгүй нар жаргах дөхсөн бололтой. Улаан хайрханы оройд жаргах нарны сүүлчийн туяа тусаж сэрвэн хадан хяр өндөр шовх байц оргилууд нь Шамбалын орны орд харш сүм дуганы

орой мэт гайхамшигтай гоёмсогоор харагдаж байлаа. Агваанням ихэд сүсэглэн мөргөөд хонгор мориндоо ирсэн замаараа сурсан тарниа бясалгаад буцав. Тэр хүрээ хийд өргөө гэртээ ирээд дониртоо

- Миний бие барагтайхан байна. Хоёр,гурав хоног гэртээ хэвтье. Онц чухал хэрэг гарахгүй бол над руу ирэх хэрэггүй. Харин миний дэргэд байнга байх нэг шавь банди олоод явуулчихаарай гэж хэлэв. Донир ч хамбын хүссэнийг ёсоор болгож дуугүй томоотой нэгэн шавийг

- Лам та хамба багшийн дэргэд хоёр гурав хоног байж тус дэм болж асарч тойгло гэж үүрэгдээд явуулав. Хамбын өргөөнд ирсэн залуу лам ямар нэгэн айлтгалгүйгээр шууд л мөргөв. Хамба Агваанням түүнийг харж байснаа

- Нэр хэн билээ гэхэд

- Намайг Хайнзан гэдэг гэхэд Хамба

- Аль нутгийн хүн билээ гэв. Хайнзан дор мөргөөд

- Би Хөвчийн нурууны харъяат билээ гэв. Хамбын нүд сэргээд явчихлаа. Тэр

- Өө чи чинь манай аавын нутгийн хүн байна шүү дээ. Миний аав чинь яг Хөвчийн нурууны унаган хүн байхгүй юу. Чи сонсож дуулж байсан байж магадгүй. Манлай гэдэг хүн байсан юм. Аав нь Алтан гэж хүн байсан гэдэг. Би огт үзээгүй л дээ гэхэд Хайнзан дуугүй л бодлогоширно. Орой болж хоол цайгаа зооглосны дараа Хамба

- За Хайнзан минь. Надад сонин хачин юм яриарай. Үлгэр ч байсан болно шүү гэлээ. Хайнзан албан хүчээр маягтай амаа ангайлгаад хэсэг болсноо

- Хамба багш аа. Би танай аавтай нэг удаа уулзаж байсан юм байна. Танай аав том цагаан хаш хөөрөгтэй байсан биз дээ гэж асуухад Агваанням ихэд баярлаж байгаа бололтой инээмсэглээд

- Ямар сонин учрал вэ? Хаана уулзсан байх билээ гэж асуухад Хайнзан

- Арваад жилийн өмнө юм байна. Манайх Сангийн далайн Хөх энгэрт зусаж байлаа. Тэр жил ган гачиг ихтэй айл амьтан голдуу л гол усаа бараадан зусаж байсан юм даг. Намайг Бижийн аманд айлд морь хүргэж өгөөд ир гэж аавыг хэлэхэд би нөгөө морийг нь барих гэж хөөцөлдсөөр байгаад оройтож орхисон юмдаг. Манай ээж надад

- Одоо орой болчихлоо. Өглөө эрт явбал зүгээргүй юу гэхэд аав маань уурлаад

- Өнөөдөр хүргэх ёстой юм. Одоо яв гэлээ. Гэтэл ээж маань намайг явуулахгүй гээд

- Та чинь яаж байгаа юм бэ? Ийм нялх амьтныг харанхуй шөнөөр тэр хол газар луу явуулж юугаа хийнэ. Өглөө үүрээр мордоно биз гэж татгалзахад аав

- Юуны чинь нялх хүүхэд. Арван нас хүрчихээд аав ээждээ эрхэлж байгаа хэн байна. Миний хүү чинь эр хүн болчихсон шүү дээ. Өнөө жил гол ус үерлэнэ гэх биш. Голоо дагаад яваарай. Дандаа айлууд байгаа. Нохойноос л болгоомжлоорой. Өөр айгаад байх юм байхгүй. Одоохон морд. Хөнгөхөн шиг хагируулаад яваарай гээд л намайг мордуулав. Би Суга булгаар даваад Боом руу уруудаж явгал нэгэн морьтой хүн мориноосоо буугаад хөхүүлж ханиалгаад таг тонгойгоод суучихсан байхтай тааралдав. Би ч мориноосоо буугаад дэргэд нь очоод

- Ах аа. Та яав аа гэхэд тэрээр арай чамай амьсгал аваад

- Ахынхаа хоёр далны дунд хүчтэйхэн цохиотох гэлээ. Би байдаг тэнхээгээрээ цохиход тэр хүн амьсгал аваад

- Би гуйж чи цохиж байдаг . Мөн ч таарсан хоёр амьтан юм даа. Хэдэн настай юм бэ дээ гэхэд нь би

- Арван настай гэхэд

- Ээ хөөрхий дөө. Энэ шөнөөр хаа хүрэх гэж яваа амьтан бэ? гээд надтай хөөргөөрөө тамхилав. Би хөөргийг нь алдах шахахад тэр хүн инээгээд

- Наад хөөрөг чинь их гарын цагаан хаш шүү. Наад хөөргийг чинь айлд мартсан байна гээд манарч явгал баруун суга руугаа хийчихээд будилж явсан байна. Энэ муу согтуу толгой бүр солиорч гүйцжээ. Ах нь ийм бөглөрдөг өвчинтэй юм л даа. Хээр гадаа үхэж л амьтан ах дүүд балаг тарьж гай хөө болчих вий гэж айх юм.

Намайг Манлай гэдэг. Манайх Алагийн арын Цахир аманд зусаж байгаа. Түүгээр явбал орж гарч байгаарай. Хүүгийн минь хүрэх газар бас болоогүй байна. Одоо яв даа. Би хэсэг сууж байгаад Цалуугийн хонхорт байгаа Авирмэд гавжийнд очиж хононо. Тэр минь намайг хүлээж байгаа. За хүү минь сайн яваарай гээд хоцорсон юм гэж яриагаа өндөрлөхөд Агваанням хамба их л анхааралтай сонсоод ихийг бодож байгаа бололтой гуниглан байснаа урт амьсгал аваад нүдээ анихад гэмшил харуусал тээсэн гашуун хар нулимс аажимхан бөмбөрч байв.

Хүн хэдийгээр тэнэг мунхаг үйлд хөтлөгдөн алдаж онож явсан ч хожмоо ухаарч гэрэл гэгээтэй зөв замыг сонгож байгаа нь дэндүү сайхан. Хамба гурван өдөр шөнө хоол нойрондоо муухан байж үргэлж бодлоо бясалгаж суув. Нойр муутай байснаас түүний нүд улайж доод зовхинд цэлхгэр хаван суусан харагдана. Хайнзан дотроо ихэд гэмшин

- Хамбын аавтай нь уулзаж байснаа санамсаргүй ярьж өгсөндөө өөрийгөө буруутган сэтгэл нь зовно. Агваанням хамба Хайнзанд

- Хайнзан минь их баярлалаа. Би танаас аавынхаа тухай маш чухал зүйл сонслоо. Та миний сохорсон ухаанд минь гэрэл гэгээ оруулж өглөө. Би таны тусыг мартахгүй байнга санаж явах болно гэхэд Хайнзан дор мөргөж бөхийгөөд

- Хамба багш аа та юу ярина вэ? Миний болгоомжгүйгээс болоод та бүр хэцүү байдалд орчихлоо. Намайг өршөөгөөрэй гээд дахин мөргөхөд Хамба сантран

- Хайнзан минь. Одоо болно. Та надаас өршөөл эрэх хэрэггүй. Би харин олон хүнээс өршөөл гуйх ёстойгоо ухаарч ойлгож байна. Би өөрт чинь тайлбарлахад дэндүү урт нуруу түүх болохоор өнөөдөртөө больё. Надад хийх ажил их байна. Та хурал номондоо шамдаж буян их үйлдээрэй гээд үдэж өгөв.

Агваанням өөрөөсөө ичмээр их нүгэл хийж явснаа бодохоос зүрх нь шимширч ёлно. Сэтгэл нь хургаж нуугдана. Тэр амьдралын өмнө инээх эрхээ хасуулж уйлах нь багадаж байв. Тэр өөрийнхөө хамгаас илүү дээдлэн явах ёстой багшийгаа, төрсөн эхийгээ, цорын ганц охин дүүгээ, гайхамшигтай эрдэм чадалтай оюуны оргилд хүрэх шавь хүргэнээ, багшийнхаа гэргий Үзмээ эгчийгээ, бас гурван сайхан дүүгээ гомдоож явсан гээд бодохоор хийсэн нүглийнхээ дороос босож чадахгүйгээ мэдэртнэ. Тэр босохын тулд юу хийх ёстойгоо бодлоо. Газар унасан хүн газраа түшиж тулж босдог юм гэнэ лээ. Хол явсанд нь би сэтгэлээ өргөж буян үйлдье. Ойр байгаад нь очиж мөргөн өөрийн биеэр өршөөл гуйя. Тэдэнд итгэл зүтгэлээ өгье гэж шийдэв. Агваанням юуны өмнө гурван дүүгээ урин залав. Тэд гурвуулаа айл гэр болоод үр хүүхэдтэй өнөр өтгөн амьдарч байгаа билээ. Гунгааням нь аавтайгаа адилхан сайн морь унаж сайхан хөөрөг гаанс хэрэглэх дуртай байхад Батням бор дарсанд дурлах нь илүүтэй бол Отгонням нь хүнд тусархуу өглөгч сайхан сэтгэлийг нь хуулсан байлаа. Гэтэл Агвааннямд аль ч чанар нь алга байв. Ах дүү дөрөв цайлах зуурт Отгонням нүдээ нухлан байж

- Миний муу охин дүү байсан бол тавуулаа хичнээн сайхан байх байсан бол гэхэд бүгд дотроо харамсан элгээ эмтлэн байлаа. Агваанням гурван дүүдээ хандан

- Миний дүү нар тэнэг мунхаг ахыгаа өршөөгөөрэй. Би л тэнэг зан гаргаагүй бол дүү минь энд байж л байхгүй юу. Нүгэлт би дүүгээ өөрөөсөө түлхээд зогсохгүй төрүүлсэн ээжийгээ хүртэл гомдоож эрлэгт түлхсэн хүн шүү дээ гээд ихэр татан уйлахад гурван дүү нь дагалдан хайлав. Ахан дүүсийн амин холбоо улам батжин сэтгэл зүрхээрээ бөх гэгчээр гагнагдан оюун билгээрээ хэлхэгдэн уягдав. Ах дүү дөрвөн морьтон Хамба ламын хашаанаас хөдлөн Алаг хайрханы өвөр Улиастайн бага голыг чиглэв. Ойрд ингэж хамт яваагүй болохоор бүгд л баяртай байв. Энэ дөрвөн хархүү Үзмээ эгчтэйгээ золгож зээ хүү Хайдавжамц, хүргэн Чоймжуур нартайгаа уулзан буруу зөрүү бодлоо цайруулж ураг төрлийнхөө холбоог улам сэргээж авахаар яваа нь энэ билээ. Тэд газрын цагаанаар Нарийны гол уруудан Баян голын эхээр гаран гол даган явсаар Бураат булгийн рашаанаас хүртээд цаашлан Улиастайн бага голын урд цагаан огторго дээр гарч ирэв. Улиастайн зүүн баруун булаг бүгд л айлтай байлаа. Тэднийг голд дөхөж ирэхэд Арьяаболын бүтээлийн сүмд маанийн бүтээл бүтээж маанийн үрэл шаагин айраг исэх мэт дуугаран үржиж дээшээ оргилон шүхэрлэн бууж байв. Үүнийг ажигласан Агваанням хамба дотроо

- Чоймжуур ламтан байгаа л юм байна .Юун сайн хэрэг вэ. Миний хутга мэс бэлдэн уур омгондоо шатан Улаан хайрханы догшин савдагт алгадуулаад буцсаныг минь мэдсэн болов уу? Би л сайн мэдэхгүй болохоос Чоймжуур ламтан өөрөө мэдээд намайг буцаасан ч байж мэднэ. Хэн мэдэх билээ. Үүнийг хэн ч мэдэхгүй. Ганцхан би л мэднэ гэж бодож байлаа. Гэнэт ах дүү дөрвөн ханхар хархүү гэрт ороод ирсэнд Үзмээ уулга алдан

- Ээ бурхан минь. Одоо би яана аа гэж сандран босоход нь Агваанням

- Үзмээ эгч ээ. Та тайван сууж бай. Бид тантай золгоод үнсүүлээд авья гэхэд Үзмээ үг дуугүй суугаад хоёр сайхан алаг нүднээс нь баярын цэнхэр дусал хэлхэгдэн цуварч байв. Энэ хүн сэтгэлдээ хураасан зовлон жаргал, нүгэл буян, ганцаардлын айдас, эндүүрэл, итгэл үнэмшлээ нэг мөр алдаж асгаж байгаа нь энэ билээ. Энэ бүсгүйн элэг нь дэвтэж сэтгэл нь цайрч, сүү шиг дэвэрч, бүгээн улаан хоёр тамир сүлэлдэн бүүвэйн дуу эгшиглэж хоёр мөөм нь ирвэгнэн чинэрэв. Эх хүний хайр энэрэл ийнхүү ивлэж уйлж дуулан ирдэг ажээ. Ах дүү дөрвөн идэрхэн залуус эхээ санан бэтгэрсэн сэтгэл, элдэвт хорлогдон төөрч будилсан буруу зөрүү бодол, гуниг гутрал, зовлон жаргалаа нэг мөр мартан ээжтэйгээ уулзсан нялх хүүхэд шиг баярлан баясаж бас гомдоллон тунисан доголон нулимстай нүдээрээ итгэл дүүрэн харж аз жаргалтайгаар инээмсэглэх нь яг л вансэмбэрүү цэцэг наранд эрхэлж байгаа мэт нэгэн хөрөг дүрийг зурна. Сэтгэл гэдэг юутай ч зүйрлэмгүй аугаа их нандин гайхамшигтай нууцын нэг билээ. Ах дүү дөрөв сэтгэлдээ амар амгаланг бүтээж чадсан ч зээ хүү Хайдавжамц, хүргэн Чоймжуур хоёртойгоо уулзаж учирч чадаагүйдээ бага зэрэг сэтгэл гэгэлзэн байлаа. Үзмээ ах дүү дөрөвт ярихдаа

- Миний охин бие нь муу байхдаа Чоймжуурт

- Ууган ахад минь номын цагаан буянг хүртээж өгөөрэй. Тэр ухаантай хүн болохоор ойлгоно гээд л хоёр ч удаа хэлээд авсан гэхэд Агваанням ихэд гэмшин дор бөхийн мөргөөд амандаа алив нэгийг шивнэн зузаан цээж бачимхан хоёр мөр нь овгосхийн харамсан хайлж байв. Тэр дөрвүүлээ Үзмээгээс үг сонсохыг хүсэж горьдож горилсон харцаар харна. Үзмээ санаа алдаад

- Манай гурван ах гурвуулаа амьдралаа аваад явчихна гэж итгэлтэй байсан гэхэд Отгонням шүүрс алдаад

- Миний дүү ч их ухаантай хүн байсан даа. Хөл хүндтэй болсныхоо дараа хачин ихээр баярлаж намайг барьж авч үнсээд л сүйд боллоо. Би дотроо

- Яасан тэнэг хүүхэд вэ? Маш аюултай амь насанд халтай гээд байхад ингэж баярлаж байх хэрэг юу байна гэж бодоод

- Миний дүү чи юундаа баярлаж баясаад байгаа юм бэ? Биенийхээ байдлыг мэдэж байгаа биз дээ гэхэд тэр

- Ах минь би бүсгүй заяанд төрчихөөд эх хүн болж чадахгүй л юм бол амьд яваад яахав. Үр хүүхэдгүй өгөр мод шиг амьд явснаас үрээ тээж төрүүлээд явах ёсоороо явбал сэтгэл минь амарна. Энэ хүүхэд бол хол байгаа хоёр сайхан аав ээж гурваас минь надад явуулсан үнэт эрдэнэ. Чоймжуур бол бурхан тэнгэрээс заяасан миний ганц хань нөхөр хайр минь билээ. Би одоо жаргалтай байна гэхэд нь би

- Чи тэгвэл Чоймжуураа үлдээхдээ сэтгэл чинь шаналахгүй байна уу? гэхэд тэр

- Үгүй ээ. Тэр хоёулаа байгаа болохоор ажрахгүй. Энэ хорвоо дээр намайг ойлгодог хүн бол Чоймжуур. Тэр миний энэ насны минь ганц хүсэл мөрөөдлийг сайн ойлгож хүлээж авсан юм. Тэр минь миний нүд рүү харж байгаад

- Дэжидням аа. Би нэгхэн агшинд ганцхан удаа чамд тус болж чадна. Өөр илүүг хийж чадахгүйдээ сэтгэл минь их өвдөж байна гэсэн юм. Чоймжуур бол биднээс өөр хүн. Тэр оюун ухааны оргилд гарна. Бурхан ухаантай бусдаас онцгой бурхан хүн дээ гэж билээ гэхэд бүгд л чимээгүй сонсож байлаа. Агваанням дотроо Зундуй гавжаас сонссоноо санав. Зундуй

- Дэжидням яг төрөх үедээ зүрхний гажиг өвчингүй болж цоо эрүүл зүрхтэй болоод хонх дамар дуугарангуут л төрчихсөн дөө. Гурав хоногийн дараа л зүрхнийх нь гажиг дахин илрээд илт мэдэгдээд эхэлсэн шүү. Танай хүргэн Чоймжуур лам ч хосгүй эрдэмтэй ховорхон хүн юм билээ гэж байсныг нь санан

- Мөн ч айхгар байна шүү. Нэгхэн агшинд ганцхан удаа тус болохоос өөр илүүг хийж чадашгүй нь гэж байсан нь тэр төрөх үед нь тусаа хүргэсэн байх нь. Миний дүү сайн хүнтэй учирч эрүүл саруул төрж үр хүүхдээ хоёр ойтой болтол нь өсгөж өндийлгөөд л явж дээ. Санааг нь зовоож байсан ганц гай нь би л болж таарах нь. Би ухаарч хамаг гэм нүглээ нимгэлж буян үйлдэн хүн шиг амьдрах болно гэж өөртөө ам андгай тавив. Агваанням буруу бодол тээж будилж явснаа бүгдийг нь нуулгүй ярихад Үзмээ

- Манай өвгөний бие бүр муудаад ирэхэд Чоймжуур

- Багшид хэл хүргүүлэх үү? гэхэд тэр

- Хамба гэдэг чинь амар алба биш ээ. Хэн хүний дуудсанаар дураараа яваад байвал ажил нь цалгардаж гүйцнэ биз дээ. Уг нь Самдангийн сүүлийн нэг шат дахиад давхар шат хоёрыг л дугуу орхичихсон юм даа. Түүнийг л дүүргэсэн бол эрдэм ухаан нь бүрэн ханах байсан юм. Одоо яая гэхэв. Өөрөө хичээгээд зүтгэвэл миний хүүгээс ч суралцаад дүүргээд авч болох л юм гэж байсан гэхэд их л баярлаж байсан ч амандаа

- Би ч заяа муутай амьтан даа гэж үглэв. Отгонням хамгийн дуу шуутай нь билээ. Тэр бодож байгаагаа ийнхүү хэлэв.

- Үзмээ эгч ээ. Энэ цаг мөчөөс эхлэн би таныг ээжээ гэж дуудаж байвал болох уу? гэхэд Үзмээ дуу алдаад

- Ээ бурхан минь. Би ээж чинь болж чаддаг болов уу? гээд бурхандаа залбирахад Агваанням

- Бид дөрвүүлээ ээжээ гэж байя. Отгон дүүгийн минь ээж бас бидний ээжийн дотнын хүн юм чинь гэхэд Үзмээ бурхандаа залбирсаар байв. Тэр амандаа

- Би ч олон хүүхэдтэй больё гэж их л боддог байлаа. Хүсэл минь одоо л биелж байх шиг байна гэж шивнэж байлаа.

Чоймжуур лам нэг сарын өмнө гурван настай хүү Хайдавжамцаа аваад бурханы орон дэлхий болсон тэр газар луу мөргөл хийхээр явсан билээ. Чоймжуур нэг талаар урд хийсэн нүглээ наманчилж сэтгэл санаагаа ариусгая. Нөгөө талаар аавынхаа захиасыг биелүүлье . Эрдэм номын оргилд хүрэх гэж зүтгээд үзье. Хүүгээ дээд тэнгэрт даатгаж номын цагаан мөрт оруулъя. Би ганц хүүгээ хүн шиг хүн болгож өсгөвөл Дэжидням минь баярлах ёстой. Аав ээж

хоёрын минь буян заяагаар юм биз дээ.

Би нэг зуун ерэн хоёр жилд ганцхан удаа тохиодог хүний оюун ухааны дээд барилдлага болох “ГАНСАГ”- тай жил мэндэлсэн нь надад тус болно. Аав минь эрдэм номтой их хүн байсан болохоор миний оюуны гансагийг нээж олон гайхамшигийн оньс түлхүүрийг надад атгуулж өгсөн нь үнэн билээ. Хэрвээ миний гансаг нээгдээгүй бол би бусдын адил амьдарсаар энэ биеийг барах байсан байх. Миний төрсөн минь үнэн бол төгсөх минь мөн л үнэн билээ. Тиймийн учир би оюуны энэ гансагийн билэг билгүүнийг улам дэлгэрүүлж эцэст нь төрсөн орон дэлхий нутаг усандаа залах ёстой.

Энэ гансаг нь хүний оюун ухааны охилж хураасан нөөцөлсөн хүчирхэг эрчим хүч /энерги/ их тамир болон орон нутагтаа орших ёстой. Оюун ухааны их тамир гансаг оршиж байгаа нутгийн зон олон ард түмэн, мал сүрэг, ан амьтад, уул нуруу, ургамал цэцэгс, булаг ус нь төгс дээд гансагийн охь шимийг хүртэж байх заяатай юм. Тиймийн учир би нутагтаа заавал эргэж ирэх ёстой. Энд миний ээжий намайг хүлээж суугаа болохоор би эргэж ирэх ёстой гэж сэтгэл зүрхэндээ ам өгөөд ээждээ хандан

-Ээж минь. Намайгаа өршөөгөөрэй. Таныгаа ганцааранг чинь үлдээгээд хол явж байгаадаа хүү бид хоёр их гэмшиж байна. Юуны өмнө би эцгийнхээ захисныг биелүүлж түүний сэтгэлийг дүүргэж хүсэл зоригийг нь хангах ёстой. Хүүгийн нүд ухаан хоёрыг нь нээж номын цагаан мөрт багтай оруулчихвал би талийгаач ээжийнх нь өмнө нүүр бардам байх болно гэхэд Үзмээ дотроо

- Би нутгаасаа гарахдаа энэ үйл мөрийг өөрөө сонгоод өөрөө шийдсэн. Урд өнгөрч одсон, өнөөдөр болж байгаа, хожим болох үйл мөрүүд мөн л миний сонгосон сонголтын минь үйл мөн билээ. Энэ болгоноос би ухрах бас татгалзах эрх байхгүй. Харин хүлцэнгүй дагах ёстой. Ингэх нь миний үүрэг хариуцлага болно гэж бодоод

- Миний хүү зөв шийдсэн байна. Шийдвэртээ бүү эргэлз. Хөдөлсөн л бол хүрэх газартаа хүртэл зогсож болохгүй гэхэд Чоймжуур

- Ээжээ таньдаа гялайлаа. Ганцхан та минь л зөвшөөрч байгаа бол хүү бид хоёрт эргэж буцах бодол байхгүй. Та л биеэ бодож эрүүл саруул сууж байвал бид хоёр хэргээ бүтээгээд ирнэ шүү дээ гэхэд Үзмээ инээмсэглээд

- Надад санаа зовоод яах юм бэ? Ээж нь хоёр хүүгээ хүлээгээд өөрийгөө анхаараад байж чадна. Хүү минь наад Хайдавжамцыгаа сайн анхаарч байдаг юм шүү гэхэд Хайдавжамц

- Би зүгээрээ. Аавтайгаа хамт байхад юундаа айх билээ дээ гэж том хүн шиг ярихад нь Үзмээ өхөөрдөн

- Энэ хүүхдийг ээ. Мөн ч том санаатай хүн шүү. Эцгийгээ дагаад хамт яваа болохоор юундаа санаа зовох билээ дээ гээд санаа алдахыг нь ажигласан Чоймжуур дотроо

- Муу ээж минь гаднаа их тайван байгаа дүр эсгэж байгаа ч дотроо сэтгэл нь зовоод л байгаа боллолтой. Хайдавжамцыг л хэсэг санах биз дээ. Хар багаас нь хамт байсан болохоор аргагүй

дээ гэж бодоод

- Ээжээ Хайдавжамцын маань нагац ах нар ирнэ. Хүү бид хоёрын явдал суудлыг сайн тайлбарлаад ойлгуулаад өгчихөөрэй. Би ч хүүдээ сайн ярьж өгнө гэхэд Хайдавжамц

- Би мэднэ. Ууган ах, их ах, дунд ах, бага ах дөрвийг л хэлээд байгаа юм уу? гэхэд Үзмээ

- Ээж нь ярьсаар байгаад миний хүү чинь нагац нараа бүгдийг нь сайн мэднэ гээд түүний толгойг удаан гэгч үнэрлэж хоёр булцгар булбарай гарыг нь зөөлөн барилж билээ. Чоймжуур хүүгээ тусгайлан бэлдсэн мөрөвчин үүргэнд хийж үүрээд хөтөлгөө мориндоо ойр зуур хувцас хунар, идэх уух хүнсээ ачаад хөдөлсөн дөө гэж Үзмээгийн ярихыг сонсож суусан дөрвөн ах дүү дор бүрдээ нэг нэгийг бодож суув. Агваанням дотроо

- Багш минь надад их л олон юм ярьж байснаас зарим нь санаанд минь алга байна. Би ер нь их мунширсан юм аа даа. Миний энэ мунхагийг талийгаач Готов гуай тун ч сайн ашиглаж байсан бололтой. Тэр хүн өөрийнхөө атгаг санааг тэнэг надаар үйлдүүлэх гэж байсныг бодохоос аймаар шүү. Би ч өөрийгөө өмөөрч хүнийг муулах нэр нүүр надад байхгүй. Багш надад

- Алив үгийг хэлэхдээ, үйлийг хийхдээ долоон удаа бодож нэг удаа хэлж, хийж байх хэрэгтэй. Төмөр хутганы хат дэндэхээрээ хугарч бутрах нь амархан байдаг. Хүн алив нэгэнд туйлшрах нь дэндүү тэнэг юм шиг харагддаг. Цэцэн хүний ухаан үүрийн гэгээтэй хамт нээгдэж байхад мунхаг хүнийх үдээс хойш бүх үйл болоод өнгөрсөн хойно нээгддэг. Суусан цэцнээс явсан тэнэг дээр гэх мэтийн олон арван алт мэт сургаал үг бий дээ.

Хүн өөртөө эзэн байх гэдэг чинь сэтгэлээ захирч сурахыг л хэлж байгаа хэрэг шүү дээ. Сэтгэлийг захирдаг арга хэрэгсэл нь ухаан юм. Түүнээс биш хөрөнгө мөнгө, эрх мэдэл биш ээ. Ертөнцийн юмс үзэгдлийн жам ёс сургаалыг маш сайн судлах хэрэгтэй. Үг өгүүлбэр чинь өнгө хэлбэр нэрийтгэлдээ биш утга дотоод чанартаа хүч чадал нууц ид шид нь оршиж байдаг юм шүү. Бид гадаад хэлбэр үйл мөрийг нь дагаж дуурайгаад давтаад байгаа нь тийм сайн хэрэг биш. Энд авч гээхийн ухаан л дугаад байгаа юм гэх мэтээр олон зүйлийг айлдаж байсны заримыг дурдахад ийм л байна гэж бодсон тэр Үзмээд хандан

- Ээж ээ. Та өвөл болохоор хэдэн мал ахуйгаа гурван дүүд өгчихөөд миний дэргэд дулаахан өвөлжиж бай. Бид дөрөв таныгаа хүндэлж асрах цаг нь болсон. Хоёулаа зунд нь энд ирж зусаад би багшийнхаа бүтээлийн сүмд нь сууж буян үйлдэж байя гэлээ. Үүнийг сонссон Үзмээ болоод гурван дүү нь талархан хүлээж аваад Агвааннямын их ухаарлаар бахархаж байв.

Гуч

Хаврын адаг сар дуусах дөхсөн энэ өдрүүдэд хөвчийн нуруунд хөх униар татаад гол ус булаг шандтай газартаа ногоо жигдхэн ургаж мал сайн цадаж хөл нь удааширч бие нь нозоорон хивж хэвтэх олонтоо болжээ.

Говь нам дор газраа халуун тунарч зэргэлээ бүжиглэнэ. Алаг хайрхан уул алсын бараа харуулдан бодлогоширно. Тэнгэр гүн хөх ногоон өнгөөр сүлэлдэж, нар ойртож улбар шар туяатай болсон нь бүгчим халууныг илтгэнэ. Ангир шувууд аялгуулан гол усанд ирсэн нь зун цаг ойртсоныг илэрхийлнэ.

Хөвчийн нурууны баруун хойт атираат уулсын дундуур “Цагаан гол” хэмээх үзэсгэлэн төгс булаг ус, баян бүрд ихтэй ай сав газар оршино. Энэ голын сав газрын шимт ургамалтай тавиу бэлчээртэй орлого цайдам бүрт мал сүрэг багширч айлууд саахлан буусан нь амьдрал үргэлжлэн дэгжин дэлгэрч хөгжин цэцэглэж буйг илтгэнэ.

Цагаан гол хужир мараа, борзон ихтэй, ургамал нь амтлаг чанартай, гол ус шавар нь эмийн шимтэй анагаах чадалтай болохоор ан амьтан, мал сүрэг, хүн зон ийнхүү хаврын улиралд хуран чуулдаг билээ. Цагаан голын тухай олны ам дамжсан домог яриа ч их байдаг.

Дунд биед нь Агуйт хэмээх асар том агуй бий . Дээр үед хүмүүс орогнон амьдарч номын бясалгал хийж байсан ул мөр одоо ч бий. Хавартаа хүчтэй цасан шуурга тавих, байгалийн аюултай үзэгдэл болсон үед энд таван зуу орчим мал, өөр бусад амьтад хүмүүс ч хоргодон амь аврагдан эсэн мэнд үлдэж байсан олон тохиолдлыг тоочиж барахын аргагүй.

Түүнээс доошлоод “Хар боом” гэж энэ цагаан голын сав хөндийн хамгийн нарийн хадан хавцал бүхий бачуу хэсэг байх. Энд ханан хад хоёр талаас сүртэйгээр шахаж хавчих мэт болоод цаашаагаа өргөн ширэг, тэгш талбай үргэлжилсэн үзэсгэлэнтэй сайхан газар. Энэ өдөр энэ сумын хүн малын тал хувь нь Цагаан голын Хар боомд цугларсан байлаа. Улсын бэлтгэлд мал авах төв энд байрлах учир тэр билээ. Мал хаших чулуун хороо, мал бэлтгэлийн хүмүүсийн байрлах гурав дөрвөн гэр, хоолны газар худалдаа зэрэг байхаас гадна малчид малаа өгөхөөр ирээд гэр майхан зэрэг орон байраа баг бригад, гол ус айл саахалтаараа барьсан нь эгээ л нэг суурин газар гэлтэй.

Өглөө цагаан гэгээ орохоос эхлээд оройн бүрий харанхуй болтол хүн малын хөл татрахгүй, дуу шуугиан тасрах гэж ер үгүй билээ. Үнэнийг өгүүлэхэд малын хөлөөр боссон шороо тоос, хаврын бүгчим халуунд халууцсан хүмүүсийн хөлөрсөн нүүрэн дээр буугаад зууралдан халтар хултар болгон хэн болох нь бараг танигдахгүй шахам болгоно. Багт наадам болж байна уу? гэж эндүүрмээр санагдана.

Тэд бие биенээ харан бөөн инээдэм болж тоглоом шоглоом хийн нэр хоч өгнө. Тэдний зүс нь халтар, хамар нь цагаан, тарлан цоохор, ташуу судалтай янз бүр болсон байхад нүд нь гурвалжин, зуйван, навчин, бундан, зурвасан хэлбэртэй, өнгө нь хар, ногоон, бор, цэхэр, хөх, цэнхэр байх. Гэтэл шүд нь арсгар, дорсгор, доёгор, эмсгий, онгорхой, тэгш цагаан байхад шар, бор хар өнгөөр яралзана. Ярилцах хэлэлцэх дуу нь нарийн, бүдүүн, зөөлөн, хатуу,

хахирган, нялуун ая авиа гаргах нь найрал хөгжим аятай хөг аялгуу нийлэн эгшиглэнэ. Тэдний инээж баясах нь арслан архирч, адуу янцгааж, үхэр мөөрч, ямаа майлж, тарвага хошгорч байгаа юм шиг янз бүрээр авиа чимээ гарган хөхөрнө.

Уулзаж учирч баярлах нэгэн байхад уурлаж уцаарлан омогдох, уйтгарлаж гуниглаж санаа алдах, уйлж унжин сэтгэлээ онгойлгох, нүд ирмэн болзоонд урих, нууцаар уулзан энгэрээ задгайлах нь байгаа бол хардаж сэрдэн хар дэвтэрт бичих муу санаатан ч мөн л байлаа. Ийм олон ааш авир алаг эрээн сэтгэлүүд ийш тийш сүлэлдэж, тэр гэх тэмдэггүй тэмтэрч баригдах биегүй дэл сул үймэлдэх нь дэндүү инээдэмтэй. Олон цугларсан газарт оноож хэлж барамгүй үйл мөрүүдийн алийг нь онцолж авах билээ дээ.

Гэтэл нэгэн хүрэн гунан үхрийг хоёр нөхөр булаацалдаж минийх, чинийх хэмээн мэтгэлцэн сүүлдээ нохой гахайдаа хүрч сүрхий маргалдав. Завтай болгон нь маргалдаж байгаа хоёр нөхөр дээр ирж тойрог үүсгэн жүжиг ший үзэж байгаа мэт хүрээлэв. Тэд аагаа багтааж ядсандаа хүний муу муухайд дурлаж ирээгүй билээ.

Нүүдэлчин монголчуудын соёл иргэншилд тогтсон нэгэн эрхэм ёс төрийн зан заншлын дагуу өөрсдийн мөс жудагтаа хөтлөгдөн хуран цугларсан нь энэ билээ. Иймэрхүү маргаан цөөвтөр гарах болгонд газар дээр нь маргалдсан хоёр эзэн, маргаан өдөөсөн зүйлийн хамт олон түмний нүдэн дээр шүүн хэлэлцээд таслан шийдвэрлэдэг сайхан ёс заншилтай. Үүнийгээ “Нутгийн шүүх” “Хамтын шүүх” гэж хоёр янзаар нэрийддэг юм. Энэ удаа ч энэ хоёр шүүх ажиллахад бэлэн болсон байв. Хүрээлэн байгаа бүх хүмүүс шүүгч бас гэрч болдгоороо эцсийн шийдвэр нь үнэн шударга байдаг.

Тэд хүрэн гунын зүс, им тамга, шүд насыг бүрэн тогтоогоод маргалдах хоёр этгээдээр удам угсаа, гарал үүслийг нь тус тус хэлүүлээд дараа нь үүнийг батлахаар гэрчүүдийн мэдүүлэг үргэлжлэв. Ийнхүү шүүн хэлэлцээд адуучин Чоймболын үхэр болохыг батлан тогтоов.

Энэ хүрэн гунан үхэр болбол тээр жил Чоймбол янгир агнасан хэргээр ялд унаж байхад нь багийн хурал дээр яхир Балдан түүнд тусалж маяг тугалтай хүрэн үнээ зүсэлж өгч байсан тэр маяг тугалаас төрсөн хүрэн гунан үхэр нь хүрэн үнээний угсаа гарвал үүсэлтэй болохыг нь хуруу дараалан тоолж тогтоосон билээ.

Ялсан нэг нь үнэнд мөргөн баярлаж байхад ялагдсан нөгөө нь шүд зуун өс зангидаж хар хорыг буцалгадаг билээ. Өндөр Тавхай гэдэг өл халзан толгойтой энэ эрээс нутгийнхан холуур дөлж явдаг нь түүний хар хэл ам муу үйлээс эмээхийн учир энэ билээ. Өнөөдөр ч өндөр Тавхай хагартлаа уурлаж муу заль башир арга нь биелээгүйд өшиж хорсон Чоймболд

Ан амьтны хулгайч

Адгийн муухай Чоймбол чи

Олны санааг үймүүлж байгаад

Үхрийг минь булаав уу чи

Халуун зуухандаа шарагдаад

Халаглаж байхыг чинь харна аа би

Хөөтэй тогоогоо тэврээд

Хөглөж явахыг чинь үзнэ ээ би гэж хэлээд нулимж орхиод ичсэн хүн яана гэдэг билээ дээ. Тэр мориндоо мордон нуруугаа харуулан явж одов. Өндөр Тавхайгийн энэ үгийг сонссон зарим нь

-Өндөр Тавхай ч нэг үхэртэй болох шахаад алдсандаа уурлаж үгээ олж хэлж чадахгүй үхэр шиг мөөрлөө дөө гэж байхад өөр нэг нь

- Өндөр Тавхай тийм амар хүн биш ээ. Муу арганд сайн л гэдэг юм. Ийм хүний хэлсэн үг, хийсэн үйл нь бүтэхийг хэн эс мэдэх билээ дээ гэж бодоод

- Муу үг холуур явах болтугай гэж шивнэж байв. Бусад олон нь

- Өндөр Тавхай өмдөндөө дусаахаас наахнуур уурлаж өл халзан толгойгоо ухаантай гэж бодсон юм байх даа. Ийм арга замаар ядарсан нэгнийгээ айлгаж сүрдүүлж явдаг арчаагүй золиг байгаа юм. Манай анчин Чоймбол тийм адгийн юм хийх хүн биш ээ. Гадар царай нь ядруу харагддаг болохоос дотор ухаан ихтэй хүн шүү дээ гэж магтаж байв. Харин ганц нэг нь

- Энэ өндөр Тавхай чинь хатуу муу үйлэндээ сүрхий золиг байгаа юм. Уурандаа юу ч хийж мэднэ дээ. Болгоомжтой байхад илүүдэхгүй л байх. Чоймбол хашир хүн өөрөө мэдэж байгаа биз ээ гэж бодно. Харин Чоймбол олны дунд явж байснаа гэнэт үзэгдэхээ больж хаашаага юм алга болсон байв.

Тэр Цагаан голын хойт Хүрэн толгойд хаваржиж байгаа дуугүй Хайнзангийн ирэв. Хайнзан Чоймболын эцэг хоёр их дотнын найзууд бас хамаатан садан ч болно. Чоймбол болсон явдлыг дуугүй Хайнзанд нэг бүрчлэн ярьж өгөхөд Хайнзан юу ч дуугарсангүй хөөрөгнийхөө даалинг ухаж байснаа гурван шоо гаргаж ирээд таван нүхэнд нь шивнэж шившээд зүүн гарынхаа алган дээр орхив. Тэр гурван удаа орхиод чимээгүй болсноо

- Хоёулаа бага сага арга чарга хийхгүй бол болохгүй бололтой. Тавхай чинь хэцүү хүн байна шүү гэхээс өөрийг хэлсэнгүй. Тэр бага гэр банагтаа ороод замбайн гурилаар хэлбэр дүрс бүхий балин бариад хар улаанаар будаж маяг оруулаад оройн бүрийгээр хүмүүсийн явдал суудлаас сэрэмжлэн байж их гал түлүүлээд нөгөө балингуудаа шатаалгаж үнс болгоод нөгөө л гурван шоогоо орхисноо урт гэгчээр амьсгаа аваад

- За хөө. Би ч хариулж чадахгүй ч хальтруулж чадсан эсэхийг мэдэх юм алга. Чи яахав хоноод өглөө эрт гэрлүүгээ явна биз дээ. Танай ширмэн тогоо хагарсан байвал битгий харамсаж халаглаарай. Хагархай тогоогоо гэрийнхээ зүүн хойт зүгт долоон алхамаас хол тавиарай. Оройн бүрийгээр мөн л зүүн хойт зүг рүү зуун найман алхмаас цааш гарган хонхор газарт тавиад чулуугаар цохиж бүр жижиглээд шороогоор булаад хаячихаарай. Тэгээд зүгээр ээ. Тэр өндөр Тавхай хэцүү хүн байна шүү гэхээс өөрийг огтхон ч хэлэлгүй дуугүй дүмбийн суув.

Чоймбол өглөө эрт босоод гэрлүүгээ явж байхдаа Хайнзан гуайн хэлснийг нэг бүрчлэн нягталж бодно. Тэр

- Би ч хариулж чадах юм биш. Харин хальтруулж чадав уу, үгүй юу бүү мэд. Тогоо хагарна. Тогоог жижиглээд сайн булчих гэсэн шүү дээ. Гэтэл Тавхай гуай намайг хөөтэй тогоог чинь тэврүүлнэ гэл үү гэж ухаж бодсоны эцэст

- Тавхай манай тогооны хүнээр оролдсон бололтой. Түүнийг минь эрлэгт илгээгээд би тогоогоо барьж галдаа шарагдах нь байна шүү дээ. Ямар муухай хүн бэ? Гэтэл Хайнзан гуай түүний хийсэн хараалыг хариулахгүй зүгээр л хальтруулаад ширмэн тогоонд буулгана гэсэн үг байна. Ямар аймаар юм бэ? Энэ хоёр хүн чинь хоёулаа эрдэм номын чадал ихтэй хүмүүс юм. Тавхай нь буруугаар хэрэглэж бусдад хор хүргэж байхад Хайнзан гуай Тавхай бид хоёрын хэн хэнд маань тус хүргэж байдаг.

Энэ хорвоо чинь хар цагаан хоёр өнгө сүлэлдэж гэрэл сүүдэр хоёр бие биеэ харж чадахгүй нуруугаараа нийлж хоёр тийшээ харж байдаг жам ёстой болохоор яах ч арга алга гэж бодсоор гэртээ очтол бүх үйл мөр Хайнзан гуайн хэлснээр болсон байв. Чоймбол түүний хэлж ярьсныг ягштал нь биелүүлээд эхнэр лүүгээ зөөлнөөр харахад өмнөөс нь сайхан инээмсэглэх нь өглөөний нар мандахтай адилхан гэрэл гэгээ цацарч шинэ амьдрал эхэлж байгаа мэт сэтгэгдэл төрж байв.

Цагаан голын Хар боомоос хөдөлсөн жижиг тэрэг Агуйтыг өгсөв. Сум нэгдлийн дарга Хангал улсын мал бэлтгэлийн ажилд биечлэн оролцож жигдрүүлээд Бижийн аман дахь тариа ногооны ажилд яаран яваа нь энэ билээ. Хөнгөн тэрэг жирийсээр домогт Хасагийн хар үзүүрээр ороов. Хасагийн хар үзүүр гэж нэрлэх болсон энэ газрыг Цагаан голын хойт хар толгой гэдэг байжээ. Дээр үед хасагийн дээрэмчид нутаг усаар хөлхөлдөн хүн ардыг хүчихийлэн доромжилж цусан улаан мөр үлдээн мал хөрөнгийг нь дээрэмдэн тонож гэр оронг нь түймэрдэн шатааж олон түмнийг хоморголон түйвээж байсан гэдэг. Тэр үед энэ хар үзүүр дээр хасаг монголын хоёр тал хүчтэй тулалдаж байхад

-Хасаг монгол ялгараад гэх дуунаар ялгарч хасагийн дээрэмчдийг дарсан түүхтэй билээ. Тэр цагаас хойш “Хасагийн хар үзүүр” гэж нэрлэх болжээ. Хангал дарга Дардантын хоолойн дэрсэн эх хавийн нутгийн ургамлын гарц байр байдлыг ажиглан явсаар Улаан булгийн хөтлөөр давж Дуут хайрханы бэлээр давхисаар Бижийн аманд ирэв. Тэрбээр тариаланчидтай уулзаж талбай нэг бүрээр оров. Бор түлхүү, Сэвэрийн тохой, Хөх хошуу, Цагаан чулуут, Арал гээд Бижийн голын сав дагуух булан тохой болгоныг ашиглан ийнхүү нэр ус өгөн тариалангийн талбай болгожээ. Энэ гол нийтдээ хорин хоёр талбайд усаа өгнө. Энд ургаж боловсорсон үр будааны шимийг сум орон нутгаар зогсохгүй хол ойрын хүмүүс хүртэнэ. Бижийн амны хөх тариа гэж нэгэн овгийн үр будааг ч энд тарьдаг болжээ. Энэ хөх тариаг хамгийн өсгөвөртэй олон болж үрждэг гэж олон зүйлд бэлэгшээн хэрэглэнэ. Ганцхан ширхэг үрнээс арван зургаан иш түрүү салбарлан гарч түрүү болгоноос арван наймаас хорин зургаан ширхэг үр багцлан ургана. Ийм үржиж арвижиж олон болох билгийг нь билэгшээн шашны болон уламжлалт зан үйлдээ өргөн хэрэглэнэ.

Мандал өргөх, хишиг даллага авах, шинэ гэр барих, хурим найр зэрэгт ихэвчлэх хэрэглэх бөгөөд зөвхөн Бижийн голын хөх тариа / арвай/ -г сонгож авдаг. Хөх тариаг боловсруулж

чулуун тээрмээр таган гурил болгоно. Энэ нь хүнсний дээд зэргийн бүтээгдэхүүнд орно. Түүний үнэр амт, шим тэжээлэгтэй дүйцэх юм ховорхон. Тариаланчдын ажил сайн байгаад сэтгэл ханасан Хангал дарга дараагийнхаа ажилд яаран давхив. Түүнд үзэж харах нутаг ус арвин, уулзаж учрах хүмүүс олон, нутаг уужим, явах газар хол, цаг хугацаа бачим байгаа болохоор ийнхүү яаран довтолгоно. Тэр говийн зарим ус, горхи булаг, баян бүрдүүдийн байр байдлыг эргэхээр Тамга гашууны усыг чиглэн хурдална. Говьд зэрэглээ тунарч үнэн худлыг мэдэхгүй дүрс хэлбэр үүсгэн ухаан бодлыг төөрөлдүүлнэ. Үе үе хулан давхих нь үзэсгэлэнтэй ч зэрэглээ түүнийг даажигнан анааш мэт урт хүзүүтэй болгосноо арслангийн цээж шиг үс ихтэй зантгар толгойтой болгох нь инээдэмтэй. Бас хар сүүлт зээр сүрэг сүргээрээ үзэгдэх нь олонтой. Хангал дарга машины явдалд бүүвэйлэгдэн явахдаа Сагадын нэг яриаг дурсан санах.

- Сагад инээмсэглээд

-Бидний уг гарвал үүсэл овог удам маань язгуурын монгол өвгөн овог удам болох Урианхан овог юм билээ гэхэд Хангал

- Бид чинь халх овгийн л гэж явдаг шүү дээ гэхэд Сагад

- Тэгэлгүй яахав. Бид чинь халх урианхан. Харин миний ярьж байгаа угсаа овог чинь Алунгоогийн өмнө үе буюу Добу мэргэний үеэс ч өмнө байсан өвгөн овог шүү дээ. Урианханчуудын уугуул нутаг нь Бурхан халдун уул, Онон мөрний цутгал, Балжийн гол, Түнхэлэг горхины орчмын нутаг юм гэвэл Хангал

- Өнөөгийн Хэнтий аймгийн нутаг болж байна аа даа гэхэд Сагад

- Тийм ээ. Хэнтийн Дадал сумын нутаг тэр чигээрээ юм билээ. Манай монголын язгуурын үндсэн бүлэг аймаг болох Нирун, Дарлиган урианхан хоёр чинь гол цөм нь байжээ гэхэд Хангал

- Нирун гэхээр их эртнээс уламжлагдсан болж таарах нь гээд бодол болоход Сагад

- Манай монгол чинь Хүннү Сүннүгээс л эхлэнэ гэж үздэг шүү дээ. Энэ бүхэн “Монголын нууц товчоо”-нд тодорхой бичигдсэн байдаг юм гэвэл Хангал инээмсэглээд

- Бидний өвөг дээдэс хэдүйд юуны учир энэ нутагт ирж сууршсан байх билээ гэж асуухад Сагад

- Нэг мянга таван зуун далаад оны үед Батмөнх даян хаан Мандухай цэцэн хатан хоёр Монголын нэгдлийг сэргээх гэсэн бодлого оролдлогыг нь Хусай тавнан, Исмэн, Бэгэрсэн тэргүүтэй том толгой язгууртнууд эсэргүүцэн босож бусад түмэдийг гартаа оруулахад ганцхан Урианхан түмэн тэдний дарангуйллыг хүлээн зөвшөөрөөгүй юм билээ гэв. Хангал

- Урианхан түмэн яахаараа ганцаараа тэмцдэг билээ. Тийм хүчирхэг байсан хэрэг үү? гэхэд Сагад

- Энд бас нарийн учир бий. Батмөнх даян хааны эцэг чинь Баянмөнх жонон шүү дээ гэвэл Хангал дарга

- Тийм ээ. Жонон чинь их наслаагүй байх аа гэв. Сагад цааш нь

- Тийм ээ. Муу хүмүүсийн үгний хоронд өртөж Мандуул хаантай зөрчилдсөнөөс болсон. Харин Батмөнх даян хааны эх нь Урианханы Шихэр хатан юм л даа. Даян хаан чинь эцгийн талаар алтан ургынх, эхийн хувьд Урианхан овгийн цусан төрлийн хаан юм. Тэр Исмэн, Тавнан нарын толгой бүлгүүд цэргийн хүчээр Урианхан түмний бослогыг дарж аваад энэ түмэнг нэг хоёр хошуугаар нь бусад түмдэд тараан өгч захируулсан юм билээ гэхэд Хангал

- Манай аймгийн түүхэнд бол Засагт хан аймаг байгуулагдахад хоёр урианхан хошуу байсан. Нэг нь Дайчин бэйс

/ван/ Жалчингомбодорж, Дархан ван Доржжанцангарамжав нарын хошууд байгаад одоогийн зургаан сумыг бичсэн байдаг юм. Манай Бугат, Тонхил, Төгрөг, Цээл гээд л байгаа. Би өмнөх түүхийг нь гүнзгийрүүлж үзээгүй юм гэлээ. Энэ хоёр эрхэм хүмүүс нэг нь дарга, нөгөө нь хуц ухна хариулдаг малчин байсан ч оюун билгээрээ нөхөрлөсөн эрдмийн хүмүүс байв. Машин хичнээн хурдалсан ч газар арвин болохоор туулах зам хол билээ.

Хангал дарга Сагадтай нэг удаа маргалдсанаа саналаа. Тэр Сагадыг мужаан байхад нь гэрийн авсаархан бургасан мод хийлгэж байлаа. Отор нүүдэл хийхэд тохиромжтой хөнгөхөн бүрээстэй байхаар бодоод энэ гэрт таарсан жижигхэн зуух, тогоо шанага ч бэлдүүлэв. Гэрийн бургасан мод хийхэд цаг хугацаа их шаардагдана. Бас ажиллагаа ихтэй билээ. Хангал дарга Сагад дээр очоод

-Сагад аа. Ажлынхаа цагийг уртасгаад түргэхэн хиймээр байна. Гараас чинь их л удаан гарч байна шүү гэхэд Сагад инээмсэглээд

- Дарга аа. Би хоёр нарны хооронд л хөдөлж байна. Төмөр биетэй байсан бол аль эрт салж унаад эргэж засагдахааргүй болсон байх. Харин махан биетэй тулдаа л амь мэнд салгалж байна шүү гэлээ. Зарим хүмүүс уурлахаараа

- Би ямар төмрөөр хийсэн биетэй биш дээ гэж омогддог. Гэтэл энэ Сагад юу юу гэнэ вээ? Төмөр байсан бол аль эрт салж унасан. Харин махан биетэйдээ л амьд мэнд байна гэнэ үү? гэж бодоод

- Чи төмөр машин байсан бол аль хэдийнээ хийгээд дуусчихгүй юу гэвэл Сагад мөн л инээмсэглээд

- Та ч төмөр, хүн хоёрыг салгаж ойлгодоггүй юм шив дээ гээд ажлаа хийхэд нь дарга

- Энэ нөхрөөр хуц ухна хариулгаж уур уцаарыг нь багасгавал таарах юм даа гэхэд Сагад өлгөж аваад

- Дарга аа. Би хуц ухна хариулъя. Нэр төр ч үгүй юм юмны нөхөөс болж явахаар нэртэй

төртэй эцэг мал маллавал сайхан шүү дээ гэхэд дарга

- Амьгүй хэдэн модыг янзалж чадахгүй хүн чинь айхтар догшин малыг маллаж яаж чадах билээ. Алдаж асгаад балрах биз. Дуугүй л наад гэрийнхээ модыг хийгээд гүйцээгээд өг гэхэд Сагад дотроо

- Өлзий эмчтэй уулзаж учир явдлаа хэлье гэж бодов. Тэр Өлзий эмчтэй яриад дарга дээрээ дахин ороход дарга бүхнийг сонсоод

- Сагад минь. Тэр чинь тийм амархан ажил биш. Охин чинь сургуульд явна. Тэгээд ганцаараа айл амьтнаас зайдуу бөглүү нутагт нутаглана. Хуц ухнанд санаа зовно. Дээр нь нэмээд чамд санаа зовж байхаар Сагад аа нэгдлийнхээ хашааг сахиад нэхийгээ давслаад модоо мэрээд санаа амар байж бай гэв. Сагад гомдонгуйгаар

- Та хүч чадалд итгэхээс биш хүний оюун ухаанд итгэдэггүй хүн байна гээд өөр юу ч хэлэлгүй гараад явчихлаа. Өлзий эмч Хангал дарга хоёр удаан ярилцсаны эцэст хуц ухна маллуулахаар шийдвэрлэсэн билээ. Тэр хоёр Сагадын байнга л ярьдаг оюун ухаанд нь итгэсэн хэрэг. Сагадад хуц ухныг нь тоолж өгчихөөд

- Сагад минь. Нутаг усаа сайн сонго. Болж бүтэхгүй юм байвал санаа зовох юмгүй эртхэн хэлж байгаарай. Хашир малчдаас үгийг нь сайн сонсож бай. Битгий хэл ам таталж хэрэг түвэг босгоод байгаарай гэж дарга, эмч хоёулаа хичээнгүйлэн гуйхад нь Сагад инээгээд

- Надад битгий санаагаа зовоо. Бүгдийг нь би өөрөө мэдье. Би энэ нутаг ус, зон олон, нэгдэл нийгэмдээ тусыг бүтээе гэж бодоод байдаг юм. Одоо л надад боломж олдлоо. Дарга, малын эмч хоёртоо баярлалаа гэхэд тэд инээлдээд

- Хуц ухна маллачихаад ямар сайн тусыг бүтээх юм бол доо гэж тоглоом хийхэд Сагад дээшээ тэнгэр өөд хараад

- Би тэнгэрийн одноос олон сүрэг налайн бэлчээрлэсэн баян тансаг сум нэгдэл, ард түмэн болгоно гэж хэлэхэд дарга эмч хоёр зэрэг шахам

- Ерөөлөөр болог. Сагад минь хичээгээрэй гээд явуулсан билээ. Тэр цагаас хойш Сагадын малч ухаан эрдэм мэдлэгийг сумын их бага хүн бүр мэдэж түүнийг хүндэлдэг болсон билээ. Хөнгөн тэрэг давхисаар Хангал дарга Сагадтай зөвлөлдсөний дагуу нутгаа ажиглан шинжсээр Тамга, Гашуун, Шанзав, Цагаан морьт, Төхөмийн хоолой, Уртын гол, Алаг нуур, Гаханч нохончийн голоор орж Баянголын аманд тарьсан төмс хүнсний ногоогоо үзээд Сагадын тухай бодлоо хөвсөөр сумын төвд ирэв.

Гучин нэг

Сумын төв дээр дарга цэрэггүй хөдөлгөөнд орсон байв. Ямар нэгэн хэл мэдээ ирээгүй тайван налгар байтал гэнэт аймгийн Цагдаагийн газрын дарга утсаар

- Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайд Шагж танай суманд очих учир хүлээж аваарай гэсэн билээ. Төрийн сайд ямар хэрэг зоригоор явааг хэн ч мэдэхгүй байв. Ийм тодорхой мэдээлэлгүйгээр ирж байхыг бодоход маш нууц ажил байж таарна. Ямар нэгэн ноцтой хэргийн учир Сайд өөрөө ирж байж мэдэх юм гэж янз бүрийн таамаглал дэвшүүлж байлаа. Бидний сайн танил сумын хариуцлагатан Ширмэн арай өөрөөр бодож байлаа. Тэр

- Арай Бунханы хөтлийн амны бунхан шарилыг дахин сэргээсэн тухай дээшээгээ мэдээлэгдээд Сайдын хэмжээнд хүрчихсэн юм биш биз. Аймгийн Цагдаагийн газрын дарга зөвхөн Сайдыг хүлээж авна уу? гэхээс өөрийг хэлээгүй гэсэн. Юу л болоод байна даа. Би гэдэг хүн өнгөрөгч намрын хадлангийнханд сохор Балбарын ярьж өгсөн үлгэр домог шиг юмыг ярьсан. Хожим нь Намхай дарга надад аминчлан

- Та хашир хүн байж олон түмэнд бунхан шарилын тухай юундаа тэгэж магтаж дэвэргэн ярьдаг юм бэ? Тэр тухай чинь надад нууцын мэдээгээр ирээд байна гэхэд нь би айсандаа болоод мөргөх шахан

- Дарга аа. Намайгаа өршөөгөөрэй. Би намынхаа өмнө буруутай хэмээхэд дарга инээмсэглээд

- Энд ирээд тогтсон бол ч яахав. Дээшээгээ явчихвал хэцүүднэ дээ. Хийж хэлж байгаа юмандаа жаахан бодолтой болгоомжтой байх хэрэгтэй шүү. Улс төрийн сонор сэрэмжийг ямагт санаж явах нь өлзийтэй байх гэж сануулсныг бодохоос дотор нь эвгүйрхэж толгой нь эргээд явчихав. Үнэг архины сургийг сонсоод согтдог гэдэг шиг нийгмийн хамгаалах яамны сайд ирэх нь гэсэн бүдэг бадаг чимээ дуулаад л айж эмээж алмайрч унаж байдаг нь ч юу билээ дээ. Тэр хэсэг хугацаанд тайвшраад сумынхаа хэсгийн төлөөлөгч дээр очоод тандвал

- Манай дарга Сайдыг очно гэж над руу ярьсан юм аа. Би дээд дарга нарт энэ мэдээг хүргэснээс илүүг сайн мэдэхгүй байна гэв. Тэр сайн лавлаж мэдэхийг хүсэж байгаа болохоор хэсгийн төлөөлөгчөөс

- Сайдыг ямар хүмүүс дагалдаж яваа бол гэхэд хэсгийн төлөөлөгч

- Миний бодоход Аймгийн нийгмийн аюулаас хамгаалах хэлтсийн дарга, цагдаагийн дарга гээд бас бусад хүмүүс яваа байх. Та юундаа ингэж сонирхоод байгаа юм бэ гээд сэжиглэнгүй маягтай харахад

- Би сонирхсон юм алга аа. Хоол унд, орон байрных нь хүрэлцээ л юу болдог бол гэж бодсон юм. Арай хүн амьтан баривчлах гэж байгаа юм биз гэж айсан маягтай асуухад нь хэсгийн төлөөлөгч инээгээд

- Сайд юу боллоо гэж хүн баривчлаад явж байх вэ дээ гэхэд Ширмэн муухан инээгээд

- Тийм байлгүй дээ. Сайд хүн чинь юу боллоо гэж хүн баривчлаад явж байх билээ гэж амандаа давтан хэлснээ урт гэгчээр санаа алдаад дотроо

- Би намын гишүүн хүн гэж сэтгэлээ чангалав. Намын үүрийн дарга, хэсгийн төлөөлөгч нар Сайдыг Сүжийн хөх хошуун дээр тосов. Шар хадны уужим хоолой руу дөрвөн жижиг тэрэг тоосоо хуйлруулан цуварсаар гарч ирэхэд зуны бүгчим халуунд боссон тоос манан будан мэт суунаглана. Дарга нар Сайдад сум орныхоо ажлыг танилцуулахад Сайд сайшаан толгой дохихоос хэтэрсэнгүй. Бас элдвийн юм асууж шалгаасан ч үгүй. Шуудхан

- Танай суманд Сагад гэж хүн байна уу? гэж асуув. Сумын дарга нар бие биен рүүгээ харснаа зэрэг шахам

- Сагад гэдэг хүн бий гэлээ. Сайд

- Тэр хүнтэй уулзахад боломжтой биз дээ. Хэр хол байна гэж асуухад бас л бие биен рүүгээ харснаа

- Гайгүй ээ. Харин ганц гэрээрээ л байгаа даа.

- Чухам яг хаана байгаа бол гэхэд нэг нь

- Сагад гуайг ч олоход хэцүү дээ. Ядахдаа мөр үлдээдэггүй юм. Гэрийн буурин дээр нь очиход айл байж байгаад нүүгээд явж гэж хэлэхийн аргагүй шүү. Яг л эрүүл газар шиг цэвэрлэж засаад явна шүү дээ гэхэд Сайд инээмсэглээд

- Сагад гуай чинь ямар мал малладаг хүн юм бэ? гэж асуухад малын эмч Өлзий

- Хуц ухна малладаг юм даа. Жинхэнэ эрдэмтэн малчин даа гэхэд Сайд инээмсэглээд

- Тийм үү? Тэгвэл тэдний рүү хөдөлцгөөе гэлээ. Сайд ирээд Сагадыг сураглаад тэдний рүү явлаа гэдэг яриа сумын төвийн айлууд, хүн нэг бүрт сонин содон чимээ болж сонсогдов. Бидний мэдэх Ширмэн маань

- Лав л намайг сонирхоогүй Сагадыг сураглаад явлаа. Миний таамаглаж байсан үнэн байж мэдэх нь. Нэг л сэжигтэй санагдаад байдаг юм аа. Ийм их эрдэм номтой хүн хуц ухна хариулаад айл амьтнаас дайжаад ганцаараа тэнээд байна гэдэг нэг л биш дээ. Ээ дээ гадаадын туршуул л мөн байх аа даа. Эрдэмтэйгийн хувьд ч их эрдэмтэй хүн шүү. Үүнийг үгүйсгэж болохгүй гэж өөрөө хүлээн зөвшөөрч байв. Дөрвөн хөнгөн тэрэг сумын төвөөс хөдөлж Улаан булагийн хөлөөр гарч Хөх даваагаар давав. Энэ алдартай даваагаар давж үзээгүй хүмүүс сэтгэлдээ айдас хурааж биеэ чангалан машинаас үсрэн буухад бэлэн байлаа. Сайд толгой сэгсрэн

- Мөн ч цавчим өндөр бас сайхан даваа байна шүү гэж өгөөмөр өлзийтэйд нь баярлан магтаж байлаа. Тэд Улиастайн бага голд тулаад ирэхэд урд өдөр нь Алаг хайрханы орой хяраар цагаан мөндөр цохиж өдөржин орсон борооны усанд үерлэж бор хоормог татан угалзан хээ үүсгэн нүсэр том уулын үйлдвэрт орсон мэт их чимээ гарган том бага чулуунууд харшилдан

хавирч том чулуу нь дороо займчин суудлаа засах шиг болоход жижиг чулуу нь хүчтэй боргионд цохигдон ойж бууж бөмбөрнө. Энэ сүрт үерийг харсан хэн болгоны сэтгэлд айдас дүүрч зүрх алдан зориг халирна.

Алтайн сүрлэг уулс, өндөр даваа гүвээ, түргэн урсгалтай агсам үертэй гол мөрнүүд, энэ голын улиасан ой шугуй, цэцэгсийн үнэртэй хөх салхийг нь амталж ханахгүй, дуулж дуусахгүй үзэсгэлэн, давтагдашгүй хөрөг зураг мөн байлаа. Улиастай их бага хоёр голоор трактороор хөтлүүлж гараад Бугын хөтөл өгссөөр Алаг хайрхан, Буга хайрхан хоёрыг холбох асар том чулуун овоотой сүүн цагаан хөтлөөр давж эхийн бэлээр хурдалсаар Дэрсэн эх, Цалуу, Бижийн голоор гаталж Могойн харын бэлд ирэв. Сагадын гэрийн буйрны бүдэг оромд мөргөөд зам мухардав. Нутгийнхан зөвлөлдөв. Малын эмч Өлзий

- Сагад уржнан энд ирж хэсэг болоод Хөв Жингэнээд бас хэд хоносон юм. Сагад ярихдаа

- Энэ Хөв Жингэнээд газрын мана ургадаг юм байна. Мана Энэтхэг Балбад усанд ургадаг. Тэндээс авчирч эм танд оруулдаг юм шүү дээ. Мана идсэн малын арга билгийн тамир тэгширч их эрүүлжин тарга тэвээрэг сайн авдаг юм. Мал иш навчийг нь идээд, би амь үндсийг нь үлдээгээд биеийн хэсгийг нь авдаг юм. Эндээс бас гандигар түүнэ. Алаг нуураас лидэр өвс авчихна. Гажаа нь ер олдохгүй дээ. Бас л гаднаас зөөвөрлөж авдаг ургамал. Хот руу захиад цагаан гаагаар гажаагаа орлуулаад Манашитан хийнэ.

Манашитан гэж манайхаар Мана дөрөв гэсэн үг л дээ. Үүнийгээ хийж аваад охин бид хоёр чинь бүтэн хоёр жил хэрэглэх эм тантай болно шүү дээ. Би ер нь эм тариа огт хэрэглэдэггүй. Бэлдсэн жаахан тан, түүсэн багахан цэцэг навч ургамал өвсөө ууж идээд болчихно. Дээр нь энэ цэвэр агаар цэнгэг ус, тараг сүү байхад өвчин тусах гэж байхгүй шүү гэж ярьж байсан.

Одоо Хөв Жингэнээд нутаглаж байгаа байх. Нар жаргахаас өмнө очъё гээд Могойн харын хөндий өгсөн явсаар Сүрлэг шовх улаан ягаан уулын бэлд ирэхэд том том улаан хад давхарлан өрсөн мэт цохионы дор нэгэн цагаан гэр бөмбийж харагдав. Энэ айл Сагад мэргэнийх мөн байлаа. Хөвийн усны зүүн биений цагаан өлгий налуу налгар энгэрт Сагад малтайгаа явж харагдав. Сайд гэрт нь буулгүй суудалдаа өндийгөөд Сагадыг гараараа зааж

- Шуудхан тэр өөд очъё гэж сэтгэл нь хөдөлж яарч байгаагаа нууж чадахгүй догдолж хөөрсөн аялгаар хэлэв. Сайд машинаасаа бугаад дагалдаж яваа хүмүүстээ

- Та бүхэн эндээ хүлээж бай. Би өөрөө очъё гэлээ. Сайдын энэ үйлдлийг хүн бүхэн гайхаж байлаа. Сайд өөрөө Хэнтий нутгийн хүн. Энэ суманд анх удаа ирж байгаа. Ямар нэгэн холбоо байх учиргүй дээ гэж бодож байхад зарим нь

- Энэ Сагад нэг бол Дотоод яамны чекист хүн байж мэдэх юм. Хүн хүнээс өөр нөхөр шүү. Өөрөөс нь зүс буруу нэг охинтой. Өөр ах дүү байхгүй. Аль ч ажлыг үнэн сэтгэлээсээ хийнэ. Хангал дарга Өлзий эмч хоёрын сэтгэлд нийцдэг хүн дээ гэж элдвийг бясалган Сагад хэмээх оньсого шиг хүнийг тааварлах гэж олон янзаар бодоцгооно. Сайдыг өгссөөр очиход Сагад ч тосож аваад бие биеэ харж түр зуур болсноо Сайд

- Сайн байна уу? Бавуу ах аа гэхэд Сагад гайхан дотроо

- Миний жинхэнэ нэрээр дууддаг хэн байх билээ гэж сайтар ажигласнаа

- Үгүй ээ энэ чинь манай Шагж уу даа? гэж хэлээд урдаас нь алхав. Сайд ч мөн л алхаад бие биеэ хүндэтгэн тэврэлдэж золгов. Сагад

- Сайн. Сайн байна уу? Та намайг мартаагүйд их баярлалаа гэхэд Шагж сайд

- Ах минь тийм хүн чанаргүй юм гэж юу байх билээ. Харин та намайг удаж байж нэг юм ирсэнд өршөөгөөрэй гэлээ. Тэр хоёр бие биендээ хүндэтгэл үзүүлж байгаа байдлыг харж зогссон дагалдах хүмүүс Сайд нь Сагадыг илүүтэйгээр хүндэтгээд толгойгоо бөхийлгөн хоёр гараа дэлгээд байгааг бодоход насаар дүү юм уу, эсвэл цол, зэрэг дэвээр доогуур мэт санагдана. Хоёр эрхэм аажимхан алхан наашилна. Шагж сайд дотроо

- Миний ах амьсгал хураахынхаа өмнөхөн надад

- Энэ Бавуу тун ч ховорхон хүн шүү. Түүний эрдэм номын хүч чадалтай эн тэнцэх юм ховорхон. Бас хүн чанар сайтай хүний төлөө л төрсөн хүн шүү. Бодь сэтгэлтэн гэж Бавууг л хэлэх байх. Тэр хүнд тус хүргэхээр өөрийгөө зориулж төгс болгохын тулд өөрөө эрдэм номонд шамдаж гэгээрэлд хүрсэн хүн дээ. Ах нь хорвоогийн жам ёсоор хол явах нь мэдээж. Хүн урагтаа ойртож нойрсдог. Тураг уулаа бараадаж түшдэг гэдэг. Дүүтэйгээ амьд сэрүүн уулзаж нутаг нугадаа ясаа тавих гэдэг амьд хүн бүрийн сүүлчийнх нь хүсэл зорилго байдаг. Тэр хүслийг минь надад биелүүлж өгсөн хүн бол энэ Бавуу юм.

Одоо надад чамаас гуйж хүсэх ганц юм бий. Дүү минь чи энэ Бавууг яг л намайг гэж санаж түүнийг хүндэтгэж түүнд тус болж явбал би энэ хүний тусыг санах төдий хэрэг болно. Энэ хүн миний амийг хоёр удаа аварсан. Түүнтэй тэнцэх юм энэ хорвоод байхгүй. Харин ачийг нь мартаггүй байнга санаж чадах л чухал. Тиймийн учир ахынхаа өмнөөс миний дүү л хийх болж байна гээд тэнгэрт хальсан билээ.

Тэр ийнхүү бодоод Хөв Жингэнээн уулсыг харна. Дээгүүр нь бөөн цагаан үүлс тогтсон байлаа. Нар хүмүүсийн сайхан сэтгэл, байгалийн төгс үзэсгэлэнд хоргодох мэт уулын цаагуур аажимхан далд ороход улаан шаргалтуяа нь зэсэн өнгөөр тэнгэрийн хаяаг чимэж байлаа. Сайд, Сагад хоёр хүмүүс дээр ирж мэнд усаа мэдэлцэв. Сагад дунд зэргийн нуруутай ухаалаг бор нүдтэй сайхан төрхтэй хүн байлаа. Сайд тэдэнд хандан

- Та бүхэн минь ажлаа бодохоос намайг хараад энд байгаад юу хийх билээ. Би энд хонож өнжих болно гэлээ. Хэлтсийн дарга

- Бид таныг ийм бөглүү газарт яаж орхиж болох билээ гэхэд Сайд

- Би ойрын хоёр жилдээ нэг ч өдөр амарч чадаагүй явсан юм. Өнөөдөр л энэ үзэсгэлэнт байгаль, ус ургамал, уулс, үүлстэй цэвэр агаарт бие амрааж энэ эрхэм хүнээс эрдэм номынх нь аугаа их ухааных нь шимээс хүртэж байж оюун санаагаа ч баясуулж цэнгүүлье гэж бодсон хэрэг л дээ гэлээ. Цагдаагийн дарга инээд алдаад

- Сайд аа. Та биднийг энд үлдэхийг зөвшөөрөөч. Бид ч гэсэн ийм сайхан нутагт ганц хоног

боловч саатмаар байна шүү дээ гэхэд Сайд Сагад өөд харахад тэр сайхан инээмсэглээд

- Өдөр шөнөгүй төрийнхөө албанд зүтгэдэг хүмүүс энэ нэгэн агшинг алдмааргүй байгаа нь зөв байх аа даа. Тэр засагт маань эрүүл саруул эрдэм мэдлэгтэй ухаалаг ард түмэн, албадынхаа хүчинд сүр хүчтэй хүчирхэг төр болж өнө удаан оршин тогтноно гэдэг биз дээ гэлээ. Энэ үгийг сонссон бүх хүмүүс Сагадын ухаантай эрдэм номтой хүн болохыг сая л мэдэж түүнийг хүндэтгэн байхад сумын дарга нар Сагад мэргэнээрээ бахархаж байв. Малын эмч Өлзий

- Манай сумын хуц ухна малладаг малчин л ийм эрдэмтэй байхад энэ нутгийн зон олон ард түмнийг асуух хэрэг юу байна гэхэд тэд бүгдээрээ

- Үнэн шүү хэмээцгээгээд бахархан баярлаж бие биеэ хүндэтгэж байв. Сагад тэр дор нь хоол гаргаж зоог шүүс бэлдэн зочидоо дайлав. Тэнгэрийн баруун хаяанд сэмжин үүл үзэгдэх төдий зуны дунд сарын арван нэгний сар сүүн туяа гэрлээр хорвоо дэлхийг гийгүүлнэ. Шөнө дөлөөр Сагад мэргэн сайд Шагжийг дагуулан цохио хадны зөрөг замаар өгсөнө. Тэд явсаар том хавтгай хадны дэргэд очив. Тэр хадыг том гэхээс өөрөөр зүйрлэх аргагүй байв. Дээр нь гэрийн буйран чинээ хонхорт борооны ус тогтон мэлтэгнэнэ. Усны мандалд арван нэгний сар хөвнө. Сар чимээ аниргүй Сайд, Сагад хоёрыг ширтэнэ. Тэр хоёрын зураг төдий дүрс ч мөн л усны мандалд тусаж шингэж чадалгүй өөрсдийнхөө үнэн төрхийг гайхах мэт болоод сартай ханьсан үлгэр домог түүх хуучилна. Сайд Шагж

- Ах аа. Та чинь бас охинтой байсан юм уу? гэж асуухад Сагад усны толио мандалд хөвөх өөрийнхөө дүрс рүү харангаа

- За тийм л юм гэх үү дээ. Миний охин бид хоёрын учирсан ерөөл тавиланг яривал барагдахгүй дээ. Би гэдэг хүн охиноосоо болоод хань ижилтэй ч болсонгүй. Охиноо хүний гар харуулаад яах ч юм билээ гэж бодлоо. Нөгөө эсэргүүний үлдэгдэл гэж оргож босож явахдаа нэрээ солиулсан болохоор тэр үед дотносож ойртсон бүсгүйдээ ч учрыг тайлбарлаж амжилгүй өглөө эрт шууданд суусан даа гээд чимээгүй болов.

Сагадад энэ болгоныг ярина гэдэг хэцүү байгаа бололтой. Сайд Шагж Хадан нуурын мандалд хөвөх сарыг хэсэг ажиглаж байснаа дээшээгээ харж тэнгэрийн уудамд олон оддын дунд амгаланаар орших сарыг ажиглан байв. Тэр бага насандаа хүнд хэцүү амьдралыг туулж өнгөрүүлснээ дурсан санахад хүрэв.

- Тэр жилийн аймшигт зудтай өвөл манай нутагт маш их цас унаж их ч хүйтэн болж билээ. Аав ээж хоёр маань хэдэн малаа аваад цас багатай малын ам хуурах өндөр өвстэй нутаг руу явж ах бид хоёр гэртээ үлдэв. Манайх ээжийн ах бидний нагац Манжаагийнтай айл байсан болохоор тэднийхэнд биднийг даатгасан хэрэг. Гэтэл хориод хоногийн дараа өндөр уулын цас нурж их гай гамшиг авчрав. Тэр цасны нуралтаас үүссэн цагаан уруйд аав ээж хоёр минь өртөж амь насаа алдаж ах бид хоёр өнчин хоцров. Бидний нагац ах нэр хүндтэй лам хүн байгаад хар болсон хүн л дээ. Манжаа ахын дүү, ээжийн дээд талын ах Мандах гэж Дотоод яаманд төлөөлөгч хийдэг ах ирж аав ээж хоёрын минь буяны ажлыг дуусгаад ах бид хоёрыг нэг нэгээр нь авч өсгөх болов. Манжаа лам ах маань

-Ийм гай зовлон ирэх гэж. Нутгийн лус савдаг л догширлоо. Одоо яах ч арга байхгүй гэхэд Мандах ах

- Ах аа. Та битгий илүү дутуу юм яриад байгаач. Наад хар толгойгоо боддог байгаа даа. Нам засгаас дахиад л шүүрдэлт хийж томоохон баривчилгаа явагдах гэж байна. Та аятайхан байж байгаад үлдэхээ бод. Энэ удаагийн ажиллагаа өргөн хүрээтэй болж магадгүй гэхэд Манжаа нагац их л уурлаж байгаа бололтой

- Надад хийсэн хэрэг байхгүй. Маанийн зургаан үсэг уншихаас илүү юм ч байхгүй амьтнаар яах гээд байгаа юм бол гэхэд Мандах ах

- Тэр зургаан үсгээр та олон хүнийг хуурч мэхлэн буруу үзэл суртал руу хөтөлсөн гээд байгаа хэрэг шүү дээ. Хэлгүй дүлий мэт чимээгүй байх хэрэгтэй. Надад найдах хэрэггүй. Та л буруутан эсэргүү болвол дүүг нь мөн л буруутан болгоно. Та бид дөрвүүлээ байсан бол одоо нэг охин дүүг маань гай гамшиг аваад явчихлаа. Нэг охин дүү минь л үлдлээ. Одоо хоёулаа амьд байх ёстой биз дээ. Хоёр өнчин зээгээ хүн болгохын тулд амьдрах ёстой шүү дээ гэв. Манжаа нагац их л юм бодож сууснаа

- Дүүгийн хэлдэг үнэн байна. Хэн хэндээ гай болохгүй байх нь зөв юм. Би ах нь болохоор хоёр зээгийнхээ ах Дондовыг авч өсгөө. Мандах минь чи энэ Шагжийг дэргэдээ ав гэснээр ах бид хоёр хоёр нагацындаа нэг нэгээрээ очив. Нам төрийн эсэргүү ардын дайсанг үндсээр нь таслах орон байр сүм хийдүүдийг нь нураан галдан шатааж ном судар бичгийг нь үнс болгон салхинд хийсгэх их ажил өрнөж олны сэтгэлийг сэртхийлгэв. Гэтэл нутгаас нэгэн хүн ирж Манжаа лам өргөмөл хүү Дондовыгоо дагуулан сураггүй алга болсон. Тэр ойрын хүндээ

- Би өнчин зээгээ номын цагаан буян түшүүлж олон түмэнд буян үйлдүүлье. Эцэг эх хоёрынх нь сүнс баярлах байх. Бас ганц дүүдээ гай болохгүй байя. Дүү нар минь өөрийнхөө үйл мөрөөр амгалан амьдраг. Би яахав. Нэгэнтээ л эрх барьж маань тоолж сурсан хүн түүнийгээ орхиж чадашгүй нь. Энэ зам мөрөө үргэлжлүүлье гэж хэлээд өмнө зүг рүү явсан гэнэ гэдгийг сонсов. Мандах их уйтгарлан удаан бодол болж сууж байснаа амандаа

- Ахын минь зөв. Бид хоёр аль аль нь амьд байж амьдрах ёстой гэж шивнэв. Түүнээс хойш олон жил өнгөрлөө. Би Мандах ахынхаа буянаар сургуулиар явж Дотоодыг хамгаалахын бэлтгэл хүчний дунд сургуулийг дүүргээд Орос улсад дөрвөн жил суралцаад ирэв. Тухайн үедээ би Дотоод яамандаа өндөр боловсролтой мэргэшсэн боловсон хүчин байв. Надад ахлах дэслэгч цол олгоод Монгол, Хятадын харилцааг хариуцсан төлөөлөгчөөр томилов. Монгол Хятадын хил нээлттэй хоёр улсын иргэд чөлөөтэй зорчдог байсан юм. Гэтэл яамнаас надад маш нууц даалгавар өгч сарын хугацаатай гүйцэтгэх томилолт өгөв. Би энэ хугацаанд даалгавраа биелүүлэхийн зэрэгцээ нагац Манжаа, ах Дондов хоёрыгоо битүүхэн сураглаж эрж хайж байв. Гэтэл Манжаа нагацыг маань таних хүн гараад ирэв.Тэр хүн

- Манжаа гүртэн ч мөн ч чадалтай хүн байсан даа. Манай энэ нутгийнханд их ч тус болсон гэлээ. Би гайхасхийгээд

- Тэр хүн чинь одоо байхгүй юм уу? гэхэд нөгөө хүн над руу том хараад

- Байхгүй ээ. Бурхан болоод дөрөв таван жил болж байгаа шүү. Та чинь хаанахын хүн бэ? гэж сэжиглэнгүй асуухад нь би шуудхан
- Би зээ хүү нь байна. Дондов ах хаана байна гэж асуухад тэр хүн инээмсэглээд
- Аргагүй л зээ хүү нь мөн бололтой. Дондов Цахар хошууны Гүнчингийн охин Ургамалтай ханилаад охин хүү хоёртой сайхан амьдарч байгаа. Манжаа гүртэн хүүгийн дээ байж сайхан асруулж байгаад өөд болсон доо. Ёстой буянтай хүн гэв. Би Дондов ахындаа яваад очлоо. Гэрт оронгуутаа л ах дүү хоёр тэврэлдэж аваад золгох юм гэж бодож байтал тэгсэнгүй.
- Сайн байцгаана уу? гэхэд ах минь
- Сайн. Сайн байна уу? гэж дурамжхан маягтай хариулаад цээжин дээрээ гараа тавиад муухай ханиалган ярвайв. Ахын минь багын төрх зүс тэр хүнд байхгүй болохоор би эргэлзэнгүйгээр
- Та Дондов гуай мөн үү? гэхэд тэр над руу харсан ч үгүй тонгойсон хэвээр
- Мөн гэлээ. Би багтай болгохын тулд
- Манжаа нагацын Дондов ах та мөн үү? гэж их санаж хүссэн аялгаар асуухад ах минь толгойгоо өндийлгөн нүдээ том болгон хэдэн хором ажигласнаа
- Чи чинь Шагж уу? миний дүү гэж бүдэгхэн хэлээд өндийснөө хажуу тийшээгээ намсхийгээд унаж орхив. Тэгэхэд л ахын минь бие олиг өвчтэй муухан байсан юм. Би ахындаа хоёр хонож бид хоёр сэтгэлээ онгойтол хөөрөлдөж авсан даа. Ах минь надад хэлэхдээ
- Ах нь заавал нутагтаа очиж ясаа тавина. Надад өөр хүсэх юм алга. Мандах нагацтайгаа золгоно. Хэрлэн мөрнийхөө уснаас хүртэнэ. Миний дүү овоо доо. Ах нь очоод чамайг олоход ч амархан болж. Бас айх аюул ч холдсон бололтой. Дуудуулах алдар нэртэй суух суудалтай байх хэрэгтэй гэж Манжаа нагац надад сургадаг байлаа. Бас
- Би чиний утааг үзэж босгоор чинь алхаж бурханд чинь мөргөөд ханийн чинь гараас цай авч зооглоод сууж байхыг л хүсэж байна гэв. Би нагацынхаа хүслийг биелүүлж чадсан байх гэж боддог гэснээ их бардам сэтгэл хангалуунаар
- Жимс ээ миний охин дүүгээ дагуулаад хүрээд ир гэж дуудсанаа
- Би нагац ааваасаа зөрөөд охиндоо нэр өгчихсөн юм. Ээж нь Ургамал юм чинь охин үр нь Жимс л байж таарна гэхэд Нагац инээд алдаад
- Ерөөлөөр болог. Аавынх нь хайрласан нэр бүрэн бүтэн яваг гэж билгийн үг хэлээд харин дүүд нь би нэр өгнө шүү гэж билээ. Миний хүүг гарахад нагац хэлэхийн аргагүй ихээр баярлаж
- Яг л ном ёсоороо боллоо гээд амандаа тарни айлдаад судар номоо сөхөн их ёс төр болоод

- Жигмэд гэдэг нэр хайрласан даа гэж дурсаж билээ. Ах минь их л зовиуртайгаар амьсгалж уртаар санаа алдаад

- Авга ахтайгаа золгосон болохоор миний хоёр хүүхэд сайн сайхан амьдрах болно гэж баярлан бардам хэлсэн дээ гээд Шагж сайдыг чимээгүй болоход мичид марал баруун хойшоогоо гудайж гүн шөнө болсныг илтгэнэ. Харин шинэдийн саран хадан нуурын мандлаас аль хэдий нь нисэн одсон байв. Мөдхөн үүр тэмдэгрэх болно. Сагад дотроо

- Сайдыг сайхан амраасан ч юм байхгүй хээр гадаа нойргүй сэтгэл санааг нь үймүүлээд зогсож байх ч гэж дээ. Ядахдаа гэр орондоо тавтай тухтай суулгасан бол яахав гэхсэн гэж бодож байхад Шагж дотроо

- Миний муу ах бурхан болохынхоо өмнөхөн над руу ядруу боловч итгэж найдсан харцаар хараад

- Дүү минь. Ертөнцөд сайн сайхан юм олон бий. Үүнийг хэн боловч хүлээн зөвшөөрнө. Гэхдээ бүгдийг мэдэхгүй өнгөрөх нь ч бий. Бүүр онцгой сайныг нь мэдэхгүй өнгөрдөг болохоор би харамсдаг юм. Сэтгэл дундуур явсан хүн сайн төрөлд төрдөггүй юм гэнэ лээ. Ах нь сэтгэлээ хангах гэж л дүүдээ хандаж байна. Намайг хүргэж ирдэг Бавууг насан туршдаа намайг гэж бодож яваарай. Яг л миний төрсөн ах гэж санаж чадвал ах нь баярлах болно. Миний сэтгэл ханах нь тэр. Энэ ертөнц дээр олон сайн юм байлаа ч бид хоёрт онцгой сайн нь Бавуу юм шүү. Хүний мөс чанараараа эрдэм чадлаараа хүн хүнээс илүү хүн шүү. Эднийхэн дөрвөн үеэрээ эрдмийн цол хэргэмтэй эрдэм номоороо дээд оройд нь явсан болохоор Бавуудаа бас санаа зовох юм гэж захиж би ахдаа

- Таны сэтгэлийг би хангана гэж ам андгай өгсөн билээ.

Би нэг удаа нууцын зэрэглэлд нэвгэрч байхдаа Бавуу ахын тухай үзвэл элэнц эцэг нь гавж Авирмэд, өвөг эцэг нь Их Аграмба Чоймжуур, өөрийн эцэг нь Хайдавжамц Лэнсрэй гавж, хүү Бавуу нь эх орноосоо оргон зайлсан онц ноцтой гэмт хэрэгтэн, эрэн сурвалжилна гэсэн байв. Надад ахын минь захиас өөрийн ам андгайгаас гадна миний хүн чанар намайг хөтөлсөн билээ. Эрдэм ном сурч эх орон ард түмэндээ оюуны ид шид эрдэм чадлыг үзүүлж ихийг бүтээхээр ирсэн иргэн бүрээ барьж аваад хороогоод байх гэдэг үнэндээ сэтгэлд багтамгүй.

Буруутанг нь яллатугай

Буруугүйг нь өршөөтүгэй гэсэн эзэн богдын мэргэн үг ч санаанд тодорсон. Би учир шалтгааныг ухаж ойлгосон болохоор гэм зэмгүй нэгэн иргэн хүнд тус хүргэх нь зөв гэж итгэл үнэмшил, хүн чанартаа хөтлөгдөн Бавуу ахтай маш богино хугацаанд зөвлөлдөөд өөрийнх нь хүссэнээр Жамцын Сагад нэртэй болгоод нэгхэн хоногийн дотор нутаг руу нь явуулсан билээ. Сагадыг явсаны маргааш Бавуугийн хэргийг сөхөж эрэн сурвалжилж Модны артелын мужаан Бавуу, усны гудамжинд байсан оромж, хотоос гарсан хүмүүсийн бүртгэлд Бавуугийн нэр байхгүй байлаа. Түүнийг эрж байхад хоёр хятад иргэн гэртэйгээ шатаж нас барсан мэдээ иртэл хоёр биш гурван хүн байсан нь тогтоогдож түүнийг тодруулбал монгол гутлын оймсны дутуу шатсан түрий олдсон байна. Тэгээд эрэн сурвалжилж байгаа бидний багийнхан Бавуугийнх мөн байж мэднэ гэж үзээд модны артелын Бавуугийн сайн танил гурван хүнд

үзүүлэхэд тэд бүгд

-Бавуугийн гутлын түрий мөн гэж батлаад Хайдавжамцын Бавуу гэдэг хүн Монгол улсын иргэний бүртгэлээс хасагдаж эрэн сурвалжлах ажиллагааг зогсоож хавтаст хэргийг нь архивт шилжүүлсэн билээ гэж бодоод Сайдг санаа алдахад Сагад хоолойгоо засаад

- Та ахынхаа хоёр хүүхэдтэй тэр цагаас хойш уулзаж чадаагүй юу? гэж асуухад Сайд

- Би сая хэрэггүй юм бодож байгаад өмнө ярьж байснаа ч бүр мартаж орхиж гэж инээмсэглээд

- Уулзаж амжаагүй. Хөрш оронтой харилцаа ч муудчихлаа. Хилийн асуудал хатуу чанга болчихлоо гэхэд Сагад

- Сайн цаг ирнэ. Итгэж найдах гэдэг бүтэхийн учралын үндэс билээ гэж бичсэн байдаг. Манайханд ч санаж явбал бүтнэ гэж айхтар үг бий шүү дээ гэхэд Сайд баярлан

- Тэр үнэн шүү. Ах аа. Би ч мөн ч болхи хойрго хүн шүү дээ. Хориод жилийн дараа л тантайгаа ирж золгож байдаг. Ахын маань сэтгэл уурлаж байгаа байх даа гэхэд Сагад

- Харин баярлаж байгаа. Надад ярихдаа

- Миний дүү надаас хэдэн хувь илүү хүн шүү. Аль ч талаараа надаас тохой илүү байх аа. Бавуу минь. Чи танилцаад ирэхээрээ мэднэ гэж бахархаж байсан шүү гэхэд Сайд

- Миний ах сайхан сэтгэлтэй хүн байсан. Надад хир халдаах дургүй. Магтах болохоороо нилээд хэтрүүлнэ шүү дээ. Арай л хоёр толгойтой арван нүдтэй гэхгүй бол яамай шүү. Таныг л их ярина. Манай Бавуу тэнгэрийг уншдаг юм. Аав нь Хайдавжамц гэж нэг сайхан Гэвш байсан. Тэр хүн зурхайн ухаанд тун ч сайн мэргэшсэн дээ. Манай нагацтай их дотно. Дандаа л тоглоом наргиа хийнэ. Хайдавжамц гуай нагацыг

- Маань их тоолж байна уу гэхэл нагац инээд алдаад

- Мааниа ч тоолж л байна. Махаа ч тоолж л байна гэхэд тэрээр

- Аль алийг нь тоолох нь аминд өлзийтэй шүү. Манай багш үлгэр чинь худал юм шиг мөртлөө үнэнээс үүссэн байдаг. Үнэн юм чинь явсаар худал болдог юм. Энэ чинь л хоосон чанар байхгүй юу гэдэг байсан гэхэд нагац

-Магадтай, магадтай гээд инээд алдана гэж нэг удаа дурсаж байсан шүү гэхэд Сагад өлгөж аваад

- Би бага сага мэднэ. Манжаа гүртэн гэж сайн Чойжин байсан даа. Ямандагийн арван зургаан Ядамыг авна. Бууж байх нь бүр сүрдмээр шүү. Цахарын хүрээнийхэн гүртэнг шүтэн биширнэ. Ихэд хүндэтгэнэ. Манайд хааяа ирэхээрээ

- Өндөр алтайн цагаан оргил амгалан айлдаж байна уу? гэсээр мэнд мэдээд мөргөнө. Аав

инээгээд

- Бурхан халдуны буяны Чойжин буурал гүртэн сайн морилж ирэв үү? гээд л уулздаг байсан. Тэр хоёр өдөржин шөнөжин ярина. Чухам юу ярьдаг байсныг сайн мэддэггүй юм. Зарим нэгийг санахад нар, сар, оддын тухай ярьж байх шиг бас олон бурхад тэдний харилцааны талаар ч ярина. Заримдаа нутаг орноо, ард олноо, ахан дүүсээ яриад уйлж хайлна. Би санаа зовоод гараад явна гэж хэлээд Сагадыг чимээгүй болон шүлсээ дотогшоо залгихад энэ хоёр эрхэм хүмүүс хоёулаа зүрх сэтгэлдээ хайлан уярч байв.

Хорвоогийн хайр энэрэл ихэвчлэн далд оршиж байдаг ажээ. Алаг хайрхан уулын оройгоор үүрийн гэгээ цухуйх төдий бүдэг үзэгдээд удалгүй улбар шар туяа дагуулсаар оддоо бэлчээв. Тэнгэрт үүрийн цолмон тодоор гялалзана. Энд тэнд бүдэг бадаг одод анивалзана. Сагад их л олзуурхан байж

- Сайд аа. Та чанх баруун тийш сайн хар. Улаан шаргал өнгөтэй одыг харав уу? гэхэд Сайд хуруугаараа заагаад

- Аан. Харлаа. Тэр улаан шаргал бүдгэвтэр од уу? гэхэд Сагад

- Мөн, мөн. Энэ Санчир гараг шүү дээ. Энэ улаан шаргал гараг маш алгуур явдалтай. Чанх баруунаа шингэдэг. Төрсөн гэр нь Мол одны тэг мөч аргын хоногийн хот мандал нь арван мянга долоон зуун жаран зургаан хоногттой тэнцдэг юм гэхэд Сайд ихэд гайхан шүтэн биширсэн харцаар ширтэж байв. Сагад гарынхаа алгыг дэлгэрүүлэн харснаа

- Яг энэ мөчид өдөр эхэлдэг юм гэлээ. Сайд Сагад руу харангаа

- Аль мөчөөс гэж асуухад Сагад

- Төрөлхтний гарын алганы зураг үзэгдэх мөчөөс өдөр эхэлдэг гэж үздэг юм гэхэд Шагж сайд хэсэгхэн болоод

- Аан одоо ойлголоо. Алганы хээ зураасыг хэлж байгаа хэрэг байх нь гэхэд Сагад

- Тийм ээ. Энэ тэнгэрийг уншдаг хүмүүс чинь малчид юм шүү дээ. Тэнгэрийн бичээснээс гадуур ямар нэгэн үйл мөр үзэгдэл явагдахгүй. Манай эзэн богд уншихаар тогтохгүй ярьдаг байсан гээд боддоо гэж их л бахархан ярьж байв. Сайд толгойгоо дохин зөвшөөрч

- Нүүдэлчний соёл иргэншлийн аугаа их ухаан давтагдашгүй ололт ялалт юм даа гэж бодож байв. Жингэнээн өндөр шовх хүрэн улаан оргилыг нарны шаргал туяа тэвэрч авав. Тэр хоёр ч нүдээ баясган сэтгэлээ цэнгүүлэн харж байлаа. Эрхэм хоёр бие биеийг хүндэтгэн инээмсэглээд Сагад

- Таныг ганц удаа зүтгээд ирэхэд нь бараг л гэртээ оруулахгүй шахам аяганы амсар халыг зуулгаад хадан хавцалд авчраад нойргүй хонуулчих гэж гээд гэмшин өчихөд нь Сайд инээд алдахад Жингэнээн уулс түрэн шуранхайлж цуурайтахад чанга инээсэндээ санаа нь зовсон Шагж

- Уучлаарай. Би дэмий л чанга дуугарчих шиг боллоо гэхэд Сагад

- Зүгээр ээ. Манай нутгийн уул ус таньд баярлаж байгаа бололтой. Харин таныг явсны дараа л намайг зэмлэх байх даа. Төрийн сайдыг хээр хонууллаа гэх болов уу гэж алиалахад Сайд

- Ах аа. Та бид хоёрын энэ яриаг эндээс өөр хаана ярих билээ. Тийм боломж одоохондоо алга л байна. Та бид хоёрын хувийн нууц маш нууц хэвээрээ л байх болно гэв. Сагад толгой дохин

- Би сайн ойлгож байна. Амьдрал нууцаа хадгалах тусмаа улам л утга төгөлдөр амттай болох юм даа. Нутгийнхаа нүд болсон Хөв Жингэнээн уулсын тунгалаг булаг ус, зандан ширээ шиг тавиу хаданд тогтсон хурын усан нуурын мандалд тэнгэрийн сарыг ододтой нь хөвүүлэн өөрсдийнхөө дүрстэй наадуулан цэнгүүлсэн зуны нэгэн шөнө та бид хоёр сэтгэлээ дэлгэж биенээ сайн ойлголоо гэхэд Шагж сайд

- Хэлээд яахав ах минь. Би хэдийгээр төрийн сайдын алба хашиж байгаа нь үнэн бас хүн хэмээх нэгэн бодьгал мөн болохоор хүсэл мөрөөдөл, мөс жудаг, хайр энэрэл, харамсал гуниг, хадгалах ариун нууц бүгд л байдаг юм. Шавар бурханыг хичнээн будаж шунхадсан ч шавар хэвээрээ л байдаг гэдэг шиг сайд байсан ч би Шагж хэвээрээ л байх болно гээд инээхэд Сагад мөн л инээгээд

- Тэгвэл би өнөөдөр Сагад байсан ч мөн бие нь Бавуу шүү гээд Шагж руу харахад Шагж

- Тийм шүү. Ах аа би нэг юм асуух гээд байснаа бүр мартаж орхиж. Та энэ хуц ухнаас өөр мал маллаж болохгүй байгаа юм уу? гэхэд Сагад инээгээд

- Хуц ухныг нэг л муу мал шиг үзээд бас муу хүн малладаг юм шиг санах нь ч бий л дээ. Би арай өөр бодолтой энэ малыг сонгож маллая гэж бодсон юм. Би ирээд нэгдлийн мужаан, манаач, түүхий эдийн нярав, галч зэрэг бага тушаалын бүх ажлыг нь арав гаран жил хийлээ.

Нэр нөлөө ч гэж байхгүй, хүн хүч дутагдсан газар болгонд нөхөөс болж явлаа. Тэгэж байж охиноо сургууль соёлоор явуулж арав дугаар ангийг нь төгсгөөд цааш нь явуулах гэтэл Хөхцэцэг маань намайг ганцааранг нь орхихгүй гээд ангийнхаа дөрвөн охинтой тавуулаа мал аж ахуй дээр ажиллана гээд илгээлт аваад ирлээ. Охиноо ирэхээс өмнө би хуц ухна маллахаар болоод хүлээгээд авчихсан байсан юм. Гэтэл илгээлтийн эзэд нэг настай мал маллана гэсэн шийдвэр гарав. Би охиндоо

- Аав нь өвөг дээдэс аав ээжийнхээ нутаг, ахан дүүс, олон түмэн, нэгдэл нийгэмдээ ямар нэгэн тус хийх ёстой. Уг нь энэ нутагт буман сүрэг бэлчээрлэж түмэн унага зэллэх учиртай, хүн ард нь оюун ухаан эрдэм номоор тэгш явах заяатай юм гэнэ лээ. Мал сүрэг өсөж арвижихад олон хүчин зүйл нөлөөлөх нь мэдээж. Гэхдээ голлох хүчин зүйл нь юу вэ? гээд үзээд үндсийг нь хөөвөл эцэг мал байлаа. Эцэг мал хэдий эрүүл чийрэг, тарга хүчтэй, байгалийнхаа эрс тэс нөхцөл байдалд шалгарсан бие бялдартай, удам угсаа нь онгон догшин сүрлэг байна түүний үр төл мөн л тийм байх нь гарцаагүй. Мал төлөөрөө өсөн үрждэг.

Нөгөө нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн үе шатны нарийн ажиллагааг тэнгэрийн бичээстэй зохируулан явуулъя. Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зусландаа бод, бог мал аль нутагт ямар

өвс ургамал усанд байлгах, ган гачиг зуд турхан, зун зуншлага ямар байх гээд л бүгдийг нүүдэлчидийн соёл иргэншил, монголын уламжлалт ёс өвөг дээдсийнхээ хөх ухаанд өвлөгдсөн тэнгэрийн бичээсийг ашиглах санаатай байгаагаа хэлбэл охин минь зөвшөөрч тэгээд л хуц ухна малладаг Сагад нэртэй болсон доо. Охин маань Улсын их сургуулийн түүх газар зүйн ангид эчнээгээр суралцаж байгаа гэхэд Шагж

- Таны зөв байна. Та ч айхтар гүн гүнзгий сэтгэсэн бололтой. Танай сум нэгдэл чинь төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнагдсан. Бас Улсын хошой аварга малчин Бумаа, Залуу аварга Нарангарав гээд олон аварга сайчуудтай юм билээ гэхэд Сагад бахархалтайгаар инээмсэглээд

- Тийм ээ. Тэр Залуу аварга Нарангарав чинь миний охины найз, илгээлтийн эзэн, нэг настай мал малладаг юм. За Бумаа бүсгүй бол аваргаар тогтохгүй баатар болох хүн. За тэгээд олон сайн малчид бий дээ гэж сэтгэл хөдлөн магтах үгээ олж ядан байх нь хүний төлөө л төрсөн хүн гэлтэй. Өөрийгөө бол хийх ёстой юмаа л хийж яваа гэж үзэж байгаа нь мөс жудагтайн шинж байв. Шагж дотроо

- Ахын тэнгэрийн бичээсийг унших эрдэм ухааныг монгол түмэн өвлөж авах ёстой. Монголын ард түмний оюуны өмч дахин давтагдашгүй уламжлал, ёс заншил мөн билээ. Би үүнийг анхааралдаа авъя. Энэ хүний оюун ухааны хүч тамир, ид шид, эрдэм чадал нутаг орон ард түмэндээ тун ч сайн шингэж хүрч байгаад нь ихэд баярлаж бас бахархаж байв.

Эрхэм хоёр хүний энэ уулзалт хүний амьдралд байдаг нууцын нууцыг нээхээс гадна зарим нууц нь хэвээрээ үлдэв. Шагж сайд Сагадын охин Хөхцэцэгийн тухай лавлаж асууж зүрхэлсэнгүй. Сагад ч нууцыг дэлгэхдээ дурамжхан байгааг мэдсэн билээ. Арга байхгүй бас л нэг адал явдал тайлж тайлбарлахад хэцүү уяа зангилаа байгаа нь мэдээж хэрэг. Энэ хүний тухай миний ахын хэлж байсан нь үнэн бололтой.

Бавуу тэнгэрийг уншдаг хүн. Ховорхон оюун ухаан шүү гэсэн билээ. Ийм аугаа их ид шид мэт эрдэм номтой эгэл нэгэн хүн холын хол сум нэгдлийн хуц ухна хариулаад оюун ухааныхаа эрдэм чадлыг хөдөлмөр бүтээл болгоод сэтгэл хангалуун алхаж яваа нь үнэхээр сайхан санагдаж байв.

Эрхэм хоёр хүн Хөв жингэнээн сүрлэг урлан уулнаас аажимхан бууж ирж явааг харсан хүмүүс төрийн сайд эгэл малчин хоёроороо бахархаж байв. Тэдний нүднээ илт харагдах байдал нь бахархам сайхан байсан ч дотоод сэтгэлдээ өөр өөрийг бясалгаж байлаа.

Хуц ухна малладаг жирийн нэг муу малчин төрийн сайдтай зэрэгцэн хээв нэг алхаж зарим үед сайд түүний тохойг түшихэд тэр инээмсэглэн байх нь дэндүү эрээ цээргүй, ичгүүргүй төрийг дорд үзсэн мэт санагдаж байхад заримд нь энэ хоёр эрхэм ажил алба нь өөр өөр боловч эцсийн бүлэгтээ хүмүүн гэдгээр сэтгэж хүн чанарыг дээдэлж байв.

Төрийн сайд дагаж гарчихаад уулын мухарт хэн нэгэнтэй шөнө дундуур уулсын орой өөд явуулчихаад санаа амран бөх гэгчээр унтаж амарсандаа санаа зовж байсан ч сайдынхаа дүр төрхийг хараад баярлана. Аргагүй шүү дээ. Төрийн төлөө зүтгэдэг хүмүүс байгалийн үлэмж сайхан цэвэр цэнгэг агаар, уулын хөх салхинд бялуурч нам цохиулсан нь үнэн билээ. Шагж

сайд олон юм ярьсангүй. Хөхцэцэгт хандан

-Охин минь. Сургуульдаа очихдоо манайд заавал зочлоорой гэж уриад холынхоо аялал төрийнхөө албанд мордов.

Гучин хоёр

Холоос ирсэн Шагж сайд нэгийг мэдэж хожмыг ухаараад буцсан бол хуц ухна малладаг Сагад нэгийг тайлж өгөөд хоёрыг хадгалаад үлдэв. Тэр охин Хөхцэцэгийнхээ тухай бодохдоо өөрөөсөө айдаг билээ. Гэхдээ өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй болохоор санаа нь амардаг. Гэтэл аав ээж нь гэнэт гараад ирвэл яана аа гэж эмзэглэдэг. Хүний хувь заяа тавилан ерөөл гэдэгт итгэдэг болохоор охиноо өөрт нь даатгадаг билээ.

Нөгөө нэг хадгалдаг юм нь юу вэ гэвэл энэ хорвоод хүн болж мэндэлсэн цагаас хойш тэр нэгл бүсгүйд сэтгэлээ нээж хүн гэдэг бодгалын зовлон жаргалыг бие сэтгэлээрээ эдэлж бүлээн шунхаа буцалган бүтэн биеэ шатааж богино заяагаа мартсан удаатай. Агшин болгон үнэ цэнэтэй ч энэхүү үхэлтэй тэнцэх үйл нь түүний амьдралын мартахын аргагүй үнэтэй агшин байсан юм.

Тэр сэтгэлээ нээж биеийг элээсэн бүсгүйтэйгээ зөрөг замаар салж одсонгүй зөрүү тавилангаар зөрж өнгөрсөн. Гэлээ ч энэ бүсгүй түүний зүрх сэтгэлд эдгэхээргүй үлдсэн гүн шарх, арилахааргүй хадгалагдсан дүр төрх билээ. Сагадын нууц барагдахааргүй их мэт боловч өөрөө уншиж дуусахааргүй шастир түүхийн боть ном юм.

Сум буйдхан, хүн ам цөөн болохоор Сайд ирээд явж гэнэ, Сагадынд очоод хонож гэнэ гэх мэтийн яриа айлаас айлд, амнаас аманд дамжин тархав. Энэ яриа зүгээр ч нэг тархахгүй хачир нэмэр аван амт шимт орон ярьсан сонссон аль алиных нь сэтгэлийг хангана.

-Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайд өөрийн биеэр гэрт нь очиж баривчлаад шөнө дөлөөр гэрээс нь авч гараад Жингэнээ уулын энгэрт аваачаад ганцаараа байцаасан гэнэ. Ам очиг нь яв цав таарвал тэр дор нь дээд хэмжээ өгөх байсан гэнэ шүү. Дагаж явсан хүмүүс, манай дарга нар буун дуу гарвал яана гэж чих тавьж нойргүй хоносон юм байх. Гэтэл аз тохиож буун дуу гараагүй юм байх аа. Өглөө нь нөгөө Сайд нь Сагадыг түшчихсэн бүр ах дүү аятай инээмсэглээд ирсэн юм байх гэж байхад өөр нэг нь

- Тэр сайд хүүгээ л Сагадын хүргэн болгох санаатай ирж Хөхцэцэгийг нь гуйх гээд олноос санаа зовоод Сагадыг ганцааранг нь дагуулаад шөнө дөлөөр ууланд гарсан юм байх. Тэгээд тохиролцсон бололтой их л баяртайгаар хөтлөлцөөд уулнаас бууж ирээд Сайд явахдаа Хөхцэцэгт

- Охин минь сургуульд очихдоо манайхаар заавал зочлоорой гэж урьж залаад явсан гэнэ гэж байхад нөгөө нь

- Манай Сагад чинь Дотоод яамны нууц төлөөлөгч том цолтой хүн юм биш үү? Хүмүүсийн дэргэд ярьж болохгүй учир хоёулхнаа шөнө дөлөөр ууланд гарсан юм байх. Маш нууц ажиллагаа явуулж байгаа бололтой юм. Бараг Сагад ч Сайдаасаа илүү цол хэргэмтэй юм биш үү? Сайд нь Сагадын өмнө бөхөлзөөд тохойг нь түшээд сүйд майд болох юм гэнэ. Нууц даалгавар нь сайн биелсэн бололтой Сайд нь их л баяртай буцсан юм байх гэсэн гурвалжин дөрвөлжин бөөрөнхий яриа хүмүүсийн сонирхлыг татаж байлаа.

Адуучин Лутаа энэ яриаг сонсоод нэг их тоосонгүй хоёр ч унага чононд алдсан болохоор нойр нь хүрэхгүй их зовж байлаа. Тэр бодсоор байгаад Сагад мэргэнээс асуухаар шийдээд тэдний рүү мордов. Сагад Лутаагаас бүгдийг сонсоод

- За Лутаа минь дэмий цагаа үрэх гэж. Наашаа явахаар цаашаагаа явж анчин Чоймболд хэлэхгүй дээ. Нөгөө чамд хэлэхээр хаданд хашгирсан нь дээр гэдэг биз дээ гэхэд Лутаа инээмсэглээд

- За итгээд ирж байхад битгий золигтоод байгаач. Ямар алт мөнгө гуйж яваа биш, арга ухаан айлдаач гэж л аргаа ядаж явна гэж үг хаях янзтай болов. Сагад

- Тэгээд ямар өнгөтэй чоно байх юм гэхэд Лутаа

- Өнгө зүсийг нь харсангүй ээ. Харин мөр нь бол сайр жалганы элсэн дээр тод гарсан байна лээ гэв. Сагад бодлого болж байснаа

- Танай адуунд өөр зүсмийн адуу байгаа юу? гэхэд Лутаа бодож байгаад

- Бий. Нэг байдсан гүү бий шүү. Уг нь манай азарга нэг ч удаа унага алдаж үзээгүй юм л даа. Саяхандаа хоёр ч унага өгчих юм гэв. Сагад шуурхайлав бололтой

- За хоёулаа түргэхэн яваад мөрийг нь нэг үзээд орхиё. Чоно ухаантай бол хүн бүр ч ухаантай шүү гэж хэлээд мориндоо мордов. Сагад чонын мөрийг ажиглаж удаан бодол болоод дахиад өөр жалганд үлдсэн мөрөн дээр очиж үзээд

- Энэ чинь манай эндэхийн чоно биш байна. Говийн чоно байна. Адуугаа энд авчраад орхичих. Энэ чоно заавал эргэж ирнэ. Хоёулаа сайн ажиглая. Танай адуунд зүс буруу адуу орсон түүнээс л болж байгаа байх. Түүнээс азарганд шалтах юм алга бололтой гэлээ.

Сагад, Лутаа хоёр адуу байгаа газрын эсрэг энгэрт дурангаа карбин буутай бариад суув. Гэтэл адууны дороос жалга дагаад нэгэн чоно өгсөн яваа нь дурангийн хараанд өртөв. Чоно ч адууны дэргэд очиход хээр азарга ч хангадан адуугаа хураан атгасан шагай шиг болгоод чонын өмнөөс дэл сүүлээ сагсалзуулан чихээ босгон хараагаа хурцлан хүзүүгээ сунган доош тавиад хүчирхэг хурц шүдээ гарган очиход чоно өөрийн эрхгүй ухарч хоёр талаар нь бултагнан элдэв маяг үзүүлж байв. Гэтэл хураагдсан адуун дундаас нэгэн адуу дээш огин хоёр удаа цоройгоод л ижлээсээ цойлон оройлон гарахад хээр азарга ч түүнийг эргүүлж хураахаар давхихад хураасан адуу ч бутарч тал тал тийшээгээ сарнин хөдлөхөд чоно ч самбаачилж эхлэв. Сагад Лутаад хандан хуруугаараа заагаад

- Тэр хөх хад руу бууд гэлээ. Энэ нь байлдааны үеийн даргын тушаал шиг л Лутаад сонсогдов. Лутаа ч тушаалыг ёсчлон гүйцэтгэв. Буун дуу уул ус, ан амьтдыг үргээн цуурайтахад үймсэн адуун дунд явж байсан чоно аль хэдийнээ жалга уруудан хурдалж байв. Сагад толгойгоо илэнгээ

- Лутаа та харав уу? тэр өөр зүсмийн адуунд гэм нь байж. Тэр байдас цойлоод гарна. Азарга түүний хойноос давхина. Адуу бутарна. Чоно сиймхийгээр нь унага даага шоглоно. Та тэр

адууг гаргахгүй бол бүх унагаа түүлгэнэ гэсэн үг дээ гэхэд Лутаа толгойгоо сэгсрэн

- Мөн ч санаанд орохгүй золиг байна шүү. Сагад аа. Говийн чоно болохыг яаж мэдэв гэж асуухад Сагад

- Та тэр мөрийг ажиглаа биз дээ. Хөлийн таваг нь арай том, хумс нь богиновтор байдаг юм. Манай уулын чоно бол тэгэж элс зөөлөн газар дагахгүй шүү дээ. Хад чулуу асга дамжин биеэ нууж явна. Тийм учир таваг нь бага, хумс нь уртавтар, хад чулуунд явахад хальтрахгүй түвэг багатай байх жишээтэй. Уулын чоно өндөр сортой, хөх саарал өнгөтэй байхад говийн чоно голдуу шаргал саарал өнгөтэй байдаг. Танай хээр азарганаас бол уулын чоно айж сүрдэнэ. Гэтэл говийн чоно орсон буурнаас л айхаас бус азарганаас айхаа мэддэггүй юм. Тэр адуу цойлоогүй бол танай азарганд цавчуулж амиа алдаж мэдэх л юм гэлээ. Азаргыг нь магтсан болохоор дотроо баярласан Лутаа Сагадад

- Та яагаад саяын чоныг буудуулсангүй вэ? гэж дурамжхан асуухад Сагад

- Нутаг руугаа явж байгаа амьтныг замд нь хөнөөгөөд яахнав. Аллаа гээд ямар хоёр унагаа олоод авах биш. Харин түүний оронд амь өршөөх гэдэг чинь арав дахин их буян үйлдэж байна гэсэн үг шүү дээ. Ойр зуурыг харах тусмаа нүдэнд тодордогч санаа сохордог юм гэж үг байдаг гээд инээхэд Лутаа

- Тэр байдас зүс буруу байх нь дээ гэхэд Сагад

- Тэгэлгүй яахав. Бидэнд чинь ганзага нийлэхгүй гээд л нэг яриа байдаг биз дээ. Түүнтэй адилхан адуунд зүс нийлэхгүй гэж бий. Тэр адуугаа эзэнд нь өг гэхэд Лутаа Сагадад баярласнаа илэрхийлээд адуугаа туугаад гэрийн зүг одов.

Сагад Хөшөөтийн гол руу явж байхдаа Галсан гуайн хүсэлтийг хүлээж авснаа дотроо бодож байлаа. Галсан Сагадад хандан

- Сагад минь би нэг л чухал хэргээр өөрийн тань зорьж ирлээ. Манай хүү Амархүү Балдангийн охинтой айл гэр болох юм гэнэ. Тэгээд гэр орныг нь бариад хоёр талаасаа нийлээд сууна биз гэхэд зөрөөд болдоггүй. Заавал монголынхоо ёс заншлыг дагах юм гэнэ. Тэгээд тэр ёс заншлыг чинь хэн хийх юм гэхээр

Та яваад Сагад гуайд учир явдлаа яриад тэр хүнийг гуй гэлээ гэж хэлэхэд нь Сагад дотроо

- Тэр Амархүү бол тун ч чамбай залуу даа. Манай охины найз Нарангаравтай Вансэмбэрүү цэцэг сонирхож явсан. Жил бүр надтай уулзана. Вансэмбэрүү цэцгээр эрдмийн цол зэрэг хамгаалсан хүн. Их ч мэдлэгтэй эрдэмтэй хүн байна лээ. Манай Нарангарав чинь улсын аварга. Энэ жил бараг хошой аварга болчихвий. Энэ хоёр хүүхдийн сайн сайхан амьдралын сайн үйлст нь би татгалзаад байх ч юу байх билээ дээ гэж бодоод зөвшөөрсөн учир ийнхүү яваа нь энэ билээ.

- Нохой хорио гэх чимээнээр гэрээс Балдангийн эхнэр гарч ирээд

- Болгоо. Сайн морилцгоож явна уу? хэмээгээд урин залав. Сагадыг хоёр хүн дагаад орж ирэхэд Балдан дотроо

- Манай охины хэлдэг үнэн боллоо. Сагад мэргэн ирэх юм гэсэн нь гэж бодоод

- Та бүхэн дээшээгээ морилцгоо гээд хөөргөө өврөөсөө гаргав. Сагад жижгэвтэр Чүнчигноров хөөргөөрөө мэнд усаа мэдэж ойр зуур нутаг орныхоо тухай хөөрөлдөв. Сагад, Балдан эхнэртэйгээ хоёулхнаа байгаад нь дотроо гайхаад Балдан руу харахад Балдан мөн л Сагад руу

- Яах ёстой вэ гэж асуусан харц илгээв. Сагад ойлгосон болохоор

- Балсан ахынх зусландаа суугаа биз дээ гэхэд Балдан инээмсэглээд

- Тэднийх зусландаа суугаа гэснээ эхнэр лүүгээ хараад

- Хөгшин чи нэг гараад ирээч гэв. Тэгээд

- Та бүхэн идээ цай зооглож суугаач гэж хэлээд инээд алдаж өөртөө цай аягалж авав. Тэднийг ийн байх зуурт Балсан, эхнэр Сүрэн, хүү Хөнхийтэйгээ гурвуулаа хүрээд ирэв. Сагад гайхасхийн Балдан руу харахад Балдан инээгээд

- Сагад минь. Миний нэг муу заль л байхгүй юу. Дүү нараа ир гэж дуудахаараа гэрийнхээ бүслүүрт нэг улаан туг намируулчихдаг юм. Эд маань байнга манай руу дурандаж байдаг юм. Уг нь шөнө л хатгадаг юм л даа. Чоно чинь улаан өнгөнөөс их дайжна шүү дээ. Сүүлдээ л бидний холбоо болчихоод байгаа юм. Тэгээд ч хүрээд ир гэж хэлэх гээд морь биеийг зовоохоор энэ бас тустай юм гэж учирлав. Сагад инээгээд

- Таны ухааныг хэн гүйцэх билээ дээ. Бид ч ажилдаа орёе доо гэхэд Балдан тун ч нухацтайгаар хоолойгоо засаад

- Сагад минь. Муу нуухаар сайн илчил гэдэг биз дээ. Бид ч ёс төрд тун ч маруухан улс шүү. Боломжтой бол зааж зураад өгөөрэй. Нэг нутгийн ах дүү нар байна даа юугаа ч нуух билээ дээ гэв. Сагад

- Тэгэлгүй яахав. Ил цагаан байх гэдэг итгэлцлийн баталгаа гэдэг биз дээ гэж хэлээд хөөргөө гарган малгайгаа тэгшилж ёс гүйцэтгээд

Алаг хорвоогийн жам ёсоор

Арга билгийн үйлийн үрээр

Авралт бурханд тань мөргөө

Алтан босгонд тань бараалхая

Аав ээж ах дүү та бүхнийхээ

Амар амгаланг айлтгаж байна

Эртний ерөөлт үнэн учралаар

Эрдэнийн элбэрэлт дагина

Энэ цагаан өргөөнд байгаад бэлэгшээж

Төрийн ёсоор үрийн хишиг хүртээхээр ирлээ

Буга намнадаг хүү манайд байхад

Булга зүйдэг охин танайд байна

Буяны ерөөл нь бид бүхэнд байхад

Бүл ургын билэг нь та бүхэнд байна

Үрийн хишиг бүтээх

Үйл хэргийг зөвшөөрнө үү гээд хөөргөө барихад яхир Балдан хэнэггүй царай гарган хөөргөө даалингаас нь удаан гаргах зуураа

Үрийн хишиг бүтээх гэдгийг

Үнэндээ сайн ойлгохгүй байна

Уран цэцэн үгээр биш

Үнэн мөрийн утгыг хүснэ

Буу үүрдэг хэн гэгч нь

Булга зүйдэг хэнийг хүсэв

Зүс нэрийг нь мэдэхгүй тамхийг

Зүгээр авах нь хаашаа юм бэ дээ гэлээ.

Сагад дотроо

-Бид ёс төрд маруухан зааж зураад өгөөрэй гээд байсан нь худлаа болж таарлаа. Аргагүй л яхир Балдан гэдэг ч мөн дөө гэж бодоод

- Урлаж цэцэлж гайхуулсангүй. Утга төгөлдөр үгээр өрж тайлбарлав. Тэр Галсангийн хүү Амархүү Балдангийн охин Нарангарав бүсгүйтэй сэтгэл нийлж энэ насны амьдралаа холбож зовлон жаргалаа хамтдаа хуваалцан амьдрахаар шийдсэнийг нь тодорхойлсон юм. Балдан хэцүү хүн болохоороо дотроо

- Одоо боллоо. Анхных нь хөөргийг за гээд ухасхийгээд аваагүйгээс цааш боллоо. Ямар Сагадын цаана гарч чадах биш гэж бодоод хөөргөө ёсчлон зөрүүлж хүндэтгэлийг нь хүлээж авахаа илэрхийлэв. Сагад дараагийн хүндлэлийг Балсанд үзүүлэхэд тэр

Сайн үйлс бүтээхээр

Саадгүй морилж ирэв үү?

Хэрэг зоригийг чинь сонслоо

Ямар орон дэлхийгээр явж

Юу юу үзэж харав даа гэж асуухад нь Сагад хөөргийг үнэрлэх зуураа

Буман сүрэг налайсан

Бугат нутгаар явлаа

Түмэн сүрэг налайсан

Төрсөн нутгаараа явлаа

Есөн эрдэнээр бүтсэн

Орон дэлхий юм байна

Есөн хүсэл тэгширсэн

Олон түмэнтэй учирлаа

гээд хөөргийг ёсорхоогоор эргүүлэн барив. Энд бие биенээ давах гэсэн атаа жөтөө тэмцэл байсангүй. Харин монголын төр ёсны хүндлэл хүний мөс жудагийн илэрхийлэл тэгширч байлаа. Өрх өсгөж сум сунгаж айл, орон гэр болох нь улс орондоо бүл нэмж төрдөө хүч тамир өгч байгаа хамгийн эрхэм нандин зан үйлийн нэг билээ. Балдан дотроо

-Ийм сайхан төр ёс, зан заншил байдаг аа. Би ганц охинтой хүн. Хэн нэгэнтэй хэл амгүй нийлчихвэл би яаж ч чадахгүй. Энэ Хөшөөтийн Балбарынхан ухаантай хүмүүс ээ. Эхнэр бид хоёрт энэнээс илүү ямар хүндлэл байх билээ. Үртэй хүн жаргадаг гэдэг үнэн бололтой. Муу охины минь буян заяа шүү дээ гэж бодохоос хамар самсаа шахираад ирэхэд бушуухан хөөргөө үнэрлэн сайхан найтаагаад аньсага норгосон дусал сувдаа нууж чадав.

Энэ бүгдийг харж сонсож суугаа Хөнхий өөрийг төсөөлнө. Хөнхий өнгөрөгч жил сургуулиа төгсөөд сумынхаа дунд сургуульд багшаар томилогдон ирээд ажиллаж байгаа билээ. Тэр сэтгэлдээ тээж явдаг Минжингээ л бодов. Би сүй бэлэг тавих болвол хэнийг гуйж явуулах вэ? Сагад гуай лавгай явахгүй байх. Цагаан ахыг гуйвал яах бол. Үгүй ээ болохгүй юм байна. Минжингийн хүй барьсан эжий нь гэсэн шүү дээ. Тэгэхээр Цагаан ах тэдний талд сууна. Суманхүү ахыг явуулах гэвэл тэр явж өгөхгүй байх аа даа. Цагаан ахаас айгаад хөдлөхгүй

байх. Тэгээд ч хөл нь доглон болохоор цаад тал маань сайнаар бодохгүй байх. Ерөөсөө авга ах Балданг явуулбал зүгээр юм байна гэж бодсоноо дотогшоо инээгээд

- Би мөн сэрүүн зүүдлэв ээ. Сэтгэлийг нь битгий хэл гарыгнь олигтойхон барьж уран зөөлөн биеийг нь тэвэрч үзээгүй байж сүй бэлэг тавих юм бодоод сууж байх ч гэж дээ. Минжээ маань одоо Москвад сансарын физик судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийж байгаа. Манай ангиас анхны эрдэмтэн болох байх. Намайг яагаад үзэж чаддаггүй юм бол. Чоно үзсэн аятай л нүд нь гурвалжин болоод оч үсэргээд эхэлнэ. Гэхдээ надад тийм ч муу биш л дээ. Ээж нь бол мөн ч сайхан хүн шүү. Хүн бүр л Бумаа эгч шиг бол мөн сонин болно доо. Гэтэл манай аав ээж хоёр Бумаа эгчийн тухай ярихад их дургүй. Эдний хооронд ямар нэг зөрчил байна уу? гэж бодоход байх үндэс байхгүй дээ. Харин нэг удаа Минжээ уурандаа

- Танай аав ээж хоёрыг таних ч үгүй мэдэх ч үгүй гээд их л хорсолтойгоор чанга хэлснийг санаж байлаа. Ямар учиртайг нь огтхон ч мэдээгүй билээ. Бумаа эгч хошой аварга болсон. Удахгүй баатар болох байх гээд хүмүүс яриад байх юм гэж бодож суутал Балдан хоолойгоо засаад

- Бид чинь нэг нарийн учрыг яриагүй байгаа юм байна шүү. Нарангаравыгаа энэ малнаас хөндийрүүлэхгүй санаатай байгаа. Хот хүрээ рүү явуулна гэж байхгүй. Хүргэн маань хотынхоо ажлыг орхиод наашаа ирэхгүй бол их л ярвигтай юм болно доо гэхэд Сагад

- Балдан ах аа. Тэр талаар санаа зоволтгүй. Амархүү маань “Алаг хайрхан уулын Вансэмбэрүү цэцгийн анагаах увидас” сэдвээр эрдмийн зэргээ хамгаалсан. Одоо “Бунханы хөтлийн Минжиннагво цэцгийн ягаан өнгө гаргахын учир шалтгаан” сэдвээр докторын зэрэг хамгаалах ажлаар таван жилийн томилолттой энд ирж сууршина гэхэд Балсан

- Бурхан минь малчин эрдэмтэн хоёрын нутаг таардаг л байгаа даа гэхэд Балдангийн эхнэр үг хавчуулж

- Сэтгэлтэй л бол нутаг таарахгүй гэж юу байх билээ гэж үнэн үг хэлэв. Тэднийг ийн хөөрөлдөж байтал адуу хангинатал янцгааж уяатай морьд хариу үүрсэв. Хөнхий дуран бариад гэрээс гарав. Морь дахин тодоор янцгаахад Балдан аягатай цайгаа барьсан хэвээрээ өндийгөөд хүмүүсийг тойруулан харснаа

- Энэ чинь миний лазан хээрийн дуу мөн байна гэж хэлээд босоод ирэв. Эхнэр нь

- Та аягатай цайгаа өгөөч гэж хэлээд авахад Балдангийн царай шаргалтан нүд нь боссон хэвээр үүд рүүгээ хоёр алхаад л цохондоо цохиулсан ямаа шиг муухай дуугараад унав. Сагад Балдангийн дээд уруулын хамрын дунд угалзтай уулзах уулзварт эрхий хуруугаараа хоёронтоо хүчтэй дарахад Балдан нүдээ нээгээд өндийв. Тэднийг гэрээс гарахад лазан хээр морь туранхай зарим газраа шар үсээ гээж амжаагүй амьтан морь болгон дээр очин золгож мэндэлж байгаа мэт хамар амаараа хачин дуугаран толгойгоо хаялан зогсож байв. Лазан хээр морины түүх гэвэл

- Өнгөрөгч жилийн хавар Балдан хөхөө Намжил хоёр улсын бэлтгэлийн мал тууж хот оруулж тушаасан юм. Балдан явахынхаа өмнө хоёр өдөр бодлого болон байснаа лазан хээр морио

сонгож авч явсан. Тэр лазан хээр хонь туухад тохиромжтой хөгшин учир хотод худалдахад болно гэсэн тооцоотойгоор авч яваад нэгэн морин тэрэгчинд зараад ирсэн билээ.

Гэтэл лазан хээр Балданг чиглэн ирээд толгой хаялан унгалдаж эрхлэх мэт аяглахад Балдан сөхөрч суугаад

-Лазан хээр минь. Тэнэг мунхаг намайг өршөө. Сэтгэлдээ голж ижил сүргээс нь шоовдорлон нүд үзүүрлэж холын хол хүний нутагт таван сохор зоосноос өгчихөөд сэтгэл амраад ирсэн. Нүцгэн нүүртэй нүгэлдээ тэнэгтсэн намайг өршөө хэмээн уйлан хайлан үглэв.

Лазан хээр Балданд бүр ойртож ирээд хамраа дуугарган хошуугаараа мөрийг нь шөргөөв. Энэ молор эрдэнэ болсон ухаантай адгуус мунхаг эзнээ өршөөж чадаж байгаа нь хорвоогийн түмэн гайхамшигийн нэгэн мөн байв.

Эр хүн морин эрдэнэ хоёр ийм л учир шалтгаанаар уягдсан нандин холбоотой ажгуу.

Лазан хээр морь Балдангийн унаган адуу билээ. Багаас нь сургаж номхон ноолгор болохоор нь Нарангарав л өдөр шөнөгүй унаж сүүлдээ чөдөрлөхөө ч больсон юм. Өглөө Нарангаравыг хараад л өөрөө хүрээд ирдэг байв. Орой хонь хураахад нэг жигүүрийг нь Нарангарав хумьж байхад нөгөө жигүүрийг нь лазан хээр хумиад толгойгоо хаялан хазаарын чимээ аялгуулан аажимхан алхалж байдаг. Нарангаравын гараас боорцог, ааруул, чихэр юу л өгнө идэж орхино. Өөр бусдын гарнаас юу ч эс иднэ. Нас гуч хүрсэн болохоор нүднээс далд юу ч болсон хамаагүй гэж бодсон Балданд буруу өгөх арга байхгүй. Тэр лазан хээрийгээ сэтгэлдээ хайрлаж муулагдахыг нь нүдээрээ харахгүй гэсэндээ л нүднээс далд орхисон хэрэг. Лазан хээр Балдангийн өмнө хэдэн хором болоод толгойгоо өргөн хөл дээрээ дүүхэлзэн дороо эргэх нь лазан, хөгшин гэж хэлэхийн аргагүй хийморьлог харагдана.

Гүрээний хоолойд Нарангарав хоньтойгоо явна. Лазан хээр тэр зүг рүү харан үүрсэн янцгааснаа чиглэн давхив. Түүний төмөр тахтай дөрвөн туурайд газрын зөөлөн хөрс тамгалагдан шүүслэг ногоо хэрчигдэн гэнэтийн дайрлаганд өртөнө.

Нарангарав ч лазан хээрийг таниад өөдөөс нь гүйнэ. Хүн морь хоёрын учран золгох агшинг харж зогссон хүмүүсийн зүрх сэтгэл ямар байсныг төсөөлөн хэлэхэд тун ч бэрхтэй. Үзээгүй би хүртэл үзэг цаас хоёрыг нийлүүлэн үг өгүүлбэр бичиж чадахгүй нь мэдээж билээ.

Энэхүү сүй билгийн ерөөлтэй өдөр унаган морь нь тэртээ холоос сар өдрийг товлосон юм шиг гүйгээд ирсэнд хүмүүс ихэд бэлэгшээж байв. Балдан их сургууль дүүргэсэн мэт их ухааныг олж авав. Сагад лазан хээр морины толгой, хондлойг нь айргаар мялаагаад аманд нь сүү амсуулж дэл шанхыг нь сайхан засав.

Амьдрал баян бас тансаг амттай сайхан үнэртэй ажээ. Орой наран жаргав уу үгүй юу лазан хээр морь уяан дээр ирж зогсоод унтаж орхив. Бүр сүүлдээ хавтгайгаараа хэвтсэн байхыг нь хараад бүгд л сандралдан очиж харвал сэрэх шинжгүй нам нойрсож байв. Морь гэдэг молор эрдэнэ нутаг орноо, ижил олон сүргээ, эзэн хүнээ ингэж ихээр санан нойр хоолоо умартан аюулт араатан, атгаг муу сэтгэлтнээс холуур шөнө дөлөөр голдуу явж бартаа саадтай бэрх хэцүү замыг сонгон холын хол газрын гүнээс гүйж ирчихээд сэтгэл нь амарсан бололтой

ийнхүү бөх гэгчээр унтаж байгаа нь амар амгалан оршиж байгаа мэт. Балдан лазан хээр морио эргээд тэнгэрийн одыг ажиглан зогссоноо

-Энэ тоолж барамгүй оддын алиныг нь оногоож аваад бороо шороо орж босохыг мэдээд байна .Мичид маралаас бусдыг нь мэдэх юм алга даа. Сагадын хэмжээнд хүрэхгүй ч гэсэн Сагадад шавь орж ойр зуурын өөртөө тохирсон эрдэм мэдлэгтэй больё гэж эрсхэн шийдээд итгэл үнэмшлээ сэтгэлдээ босгоод гэрлүүгээ зоримогхон алхав.

Гучин гурав

Амархүүгийн сүй бэлгийг хүргээд үрийн хишиг бүтээгээд ирсэн Сагад нарын гурван хүнийг Галсан их л хүндэтгэн угтав. Галсан хөөрөглөхдөө

Сайн явцгаав уу?

Санасан хэрэг

Сайхан бүтэв үү? хэмээхэд Сагад

Үрийн хишиг төрийн ёсоор сайхан бүтлээ

Үндэстэй бүхэн цэцэглэж байхын ерөөлтэй ирлээ гэхэд Галсан тэргүүтнүүд

Ерөөл баг оршиг гэж билгийн үгээр түрэв. Галсан дунд хүүдээ хандан

-Миний хүү өвөө аавыгаа аваад ир. Хэвтэж байсан одоо босоо биз гэлээ. Сагад Балбар өвгөний тухай ааваасаа сонсож байснаа санав.

- Хайдавжамц хүүгээ ажиглаж байгаад

-Нутагтаа очоод өвөө аавынхаа бунхныг олж чадахгүй бол Хөшөөтийн голын Сүжийн энгэрт нутагладаг Балбар гэдэг хүнийг сураглаж олж уулзаарай. Тэр хүнд хэрэг зоригоо хэлэхэд чамд тусална. Аавын бумбыг залахад надад тусалж надтай хамт байсан хүн. Би тэр айлд өвөлжөөд хавар нь наашаагаа буцсан юм. Том хүүгийнх нь нэрийг Галсан гэдэг. Одоо хэдэн хүүхэдтэй болсныг мэдэхгүй. Балбар Усан зүйлийн хүрээнд дуганч байсан хүн. Бичиг номондоо сүрхий гүнзгийрсэн хүн дээ гэж ярьж байсныг эргэн дурсав. Сагад нутагтаа ирээд Балбар гэдэг хүнийг сураглахад

- Аан. Хөшөөтийн голын сохор Балбар уу? Нүд нь сохорсноос хойш хүнтэй ч юм ярьдаггүй ганцаараа гэртээ хэвтээд байдаг болсон хүн дээ гэсэн билээ. Сагад өөрөө нэр усаа солиод ирсэн учир хүнтэй уулзаж нууцаа дэлгээд байхыг хүссэнгүй. Битүүхэн эрэл хайгуул хийсээр байгаад өвөөгийнхөө Бурханыг олоод авсан болохоор Балбартай уулзах шаардлага гараагүй билээ. Балбар өвгөн ачдаа хөтлүүлсээр орж ирээд хоймор залрав. Тэр хүн бүртэй тамхилж хөөрөг зөрүүлээд

- Хэн билээ гэж нэрийг нь асууж байлаа. Сагадыг нэрээ хэлэхэд тэр хэсэг бодолхийлээд

- Аан. Манай Амархүүгийн яриад байдаг мэргэн Сагад байх нь ээ гээд цайгаа уух зуураа Сагадыг ажиглан харж байв. Сагадтай хоёр ч удаа харц мөргөлдөөд авав. Сагад дотроо

- Энэ Балбар гуайн нүд сохор нүд биш байна. Ийм нүд яахаараа сохор байх билээ. Мөн сонин юм аа гэж бодож суув. Балбар дотроо

- Энэ хүү чинь эцэгтэйгээ мөн ч адилхан хүн байна шүү. Хайдавжамц ч сайхан төрхтэй их

ухаантай хүн байсан даа. Өвөг эцгийнхээ бунханыг сэргээгээд яваа хүн чинь энэ мэргэн Сагад байх нь. Сайн байна. Манай Амархүү мэдээд байгаа мөртлөө нэг ч удаа ам ангайгаагүй шүү. Тун ч ам бөхтэй золиг юм. Энэ Сагад сайн л нууцалж чадсан байна даа. Уг нэр нь Бавуу л баймаар юм. Бунханыг сэргээсэн байна гэж над мэтийнх нь баярлаад, нам төрийнхөн нь эрэл хайгуулд хатаад эзнийг нь барьж аваад төмөр торны цаана суулгана гээд нууцаар тагнаж туршаад л байсан. Гэтэл эзэн нь хамар дор нь ойрхон хажуу дэргэд нь байж байдаг.

Энэ орчлонгийн түм буман нууцын ороолдоо ончроог тайлах тийм ч амархан бус аа. Яг л зүүд мэт бүгд хоосон шүү дээ гэж бодож сууна. Тэд цаг агаар зун зуншлагын талаар ярьцгаалаа. Балбар сохор хүний төрхөө тун ч чадварлаг гаргана. Хэн ч харсан үнэмшилтэй байв. Сагад түүний нүдийг л бодоод байв. Балбар Сагадтай хоёр удаа харц мөргөлдөхдөө нэгэнд нь харцаа буруулсан нь сохор бишийг гэрчилнэ. Сохор хүн хүн рүү барагтай эгцэлж хардаггүй. Харсан ч нөгөө хүнийхээ харцнаас дальдардаггүй билээ. Сохор хүн ихэвчлэн ярьж байгаа хүн рүүгээ чихээ тавьдаг, бас гараараа барьж тэмтэрч үзэх нь илүүтэй байдаг. Мөн гар, хөл, толгойны хөдөлгөөний эвсэл алдагддаг. Гэтэл Балбарт ийм нарийн мэдрэмжийн төлөв шинж хэвээрээ байгаа нь сохор биш гэдгийг дахин баталж байв. Балбар өвгөн хүмүүсийн ярианд оролцож

- Манай нутагт чинь эрдэмтэй хүмүүс олон байлаа. Аграмба Чоймжуур гэдэг хүний хүү Хайдавжамц гэж ном эрдэмтэй хүн байв. Би тэр хүнийг сайн танина. Түүнд нарийн илгэн дээр зурж тэмдэглэсэн тэнгэрийн бичээс байдаг байсан. Хайдавжамц надад

- Үүнийг л толгойдоо хийж чадвал дээшээгээ хараад л тэнгэрийн бичээсийг уншина. Тэнгэрийн бичээс чинь мөнхөд байнга байдаггүй мөч хором бүрт бичигдэн өөрчлөгдөж байдаг юм. Хоног өдрийн бичээсийг одод жагсах үед уншдаг юм гэж ярьж байсан гээд хааяа хааяа муу нүдээрээ Сагадыг ажиглаад байв. Сагад түүнийг нь мэдэж байв ч мэдээгүй дүр эсгэн жишим ч үгүй царай гаргана. Балбар дотроо

- Сэтгэлээ тун ч сайн захирч байхыг бодоход чамгүй боловсорсон бололтой. Энэ хүүтэй чинь дотно танилцана. Ийм ухаантай хүнд итгэж болно. Эд нар хорвоог гадарладаг болохоороо хэзээ ч дэл сул үг амнаасаа унагадаггүй юм. Харин хоосон толгойтой хүний амнаас мөнхөд сул хий гарч байдаг. Тэр нарийн илгэн дээр зурсан тэнгэрийн бичээс энэ хүнд байж л байгаа даа. Яагаад нэрээ сольж Сагад гэсэн нэртэй болсон юм бол доо. Цаанаа нэг л учир жанцантай байж таарна. Энэ залуутай бүхнийг ярилцаж сэтгэлээ онгойлгомоор санагдах учир ийнхүү бодоод

- Сагад аа. Сохор байх гэдэг чинь амьд байгаагаасаа илүү хэцүү юм. Хүн ч тоож элдвийг ярих юм алга. Чихний үзүүрт

- Сохор Балбартай юугаа ярьж цагаа барж насаа ахиулж явах билээ дээ гэх нь дам сонсогдох юм. Зарим нэг залхуу хойрог замбараагүй нэгнийг сонсоод

- Ээ чааваас. Нүдтэй ч болоосой гэж бодож суухаас хэтрэхгүй юм. Манай ач хүү Амархүү өөрийг тань байнга л ярьж байдаг. Тэр Вансэмбэрүү цэцгээр эрдмийн зэрэг хамгаалахад их тус болсон. Би Сагад гуайн эрдэм мэдлэгийг цаасан дээр буулгаад Сагад гуайд өгөх эрдмийн цолыг нь авчихсан юм. Уг нь хамтарсан бүтээлээр оруулсан боловч удирдагч маань

зөвшөөрөөгүй юм. Харин Сагад гуайг зөвлөхөөр оруулах нь зөв гэж үзсэн юм гээд л олон юм ярина шүү дээ. Бас л нэг ерөөл тавилан байдаг бололтой гээд түр азнаснаа хоолойгоо засаад

- Одоо ч орой болчихлоо. Сагад аа. Манай муу бор гэр бид хоёрыг голохгүй бол манайд хонож надтай элдвийн юм хөөрөлдвөл зүгээр байна гэж гуйж хүссэн аялгаар хэлэхэд Сагад дотроо

- Аавыг минь сайн мэдэх сохор нүдтэй мөртлөө сохор биш, үнэн үгтэй их эрдэмтэй энэ өвгөнтэй сайхан ярилцах юмсан гэж бодож байсан бодлыг ийнхүү хөндсөнд баярласан Сагад уриалгахнаар

- Танд түвэг болохгүй бол танайд хоноод явахад сайхан л байна гэв. Балбар өвгөн ихэд баярлаж байгаа бололтой ач охиндоо хандан

- Өвөөгийн дөө ороод цай хоол бэлдээрэй гэж хүүхэд аятай хөөрцөглөн хэлээд хөнгөхнөөр босов. Балбар Сагадаас олон зүйл сонсохыг хүсэж байхад Сагад Балбараас мэдэхгүй байгаа түүхээ мэдэхийг хүсэж энэ өвгөний нууцын авдрыг нээж хамгийн нарийн амттай түүхийг сонирхож байв. Эрхэм хоёр хүн бие биеэ хүндэтгэн чухам юунаас эхлэх вэ? гэдгээ асуух мэт харц мөргөлдөв. Балбар өвгөн дотроо

- Энэ залуу миний нүд эрүүл болохыг аль эрт мэдсэн бололтой гэж бодоод би эхлэе гэж шийдэв.

- Тэр жилийн намар эрт цас унаж хүйтэрч эхлэв. Намрын адаг сарын шинийн арван таван гэхэд бүх айлууд өвөлжөөлсөн байлаа. Алаг хайрхан уулын оройгоос үүл будан салахаа байж өнжиж хоноод л бага багаар цас орж уулс нурууд тэр чигээрээ цасан бүрхүүлтэй болов. Хярд байсан сарлагийн бух бууж нам дор газар бараадсан байх нь хэцүүхэн өвөл болохыг илтгэнэ. Балбарынх Сүжийн усны бор үзүүрийн хөх хоргол нь хөлд булхсан дулаахан өвөлжөөнд буугаад гурав хонож байв. Оройн нарны цагаан шаргал туяа Улаан хайрханы оройгоос салж ядан байх мөчид нэгэн хүн

- Нохой хорио гэхэд Балбар гэрээс гарвал гуч эргэм насны зүс үзээгүй нэгэн эр

- Та сайн байна уу? гэсээр мориноосоо буулаа. Гэрт орж хөөрөг зөрүүлэх зууртаа Балбар

- Нутаг нуга хаана байна даа? Хэрэг зориг хэнд вэ? гэж асуухад ирсэн хүн хариу хэлэхийн оронд

- Энэ Сүжийн ус гэдэг газар мөн үү? гэж асуув. Балбар сайхан төрхтэй зөөлөн бор нүдтэй хүнийг ажиглан харж байснаа

- Мөн, мөн. Сүжийн ус гэдэг газар. Та чинь холоос яваа юм аа даа гэхэд Хайдавжамц инээмсэглээд

- Тийм ээ. Өмнийн их говийн цаадах өндөр цаст уулын бэлээс явна. Зорьсон нутаг энэ Сүжийн ус гэдэг газар. Энэ нутаг миний төрсөн газар юм гэв. Балбарын нүд сэргээд явчихав. Тэр дотроо

- Энэ Сүжийн ус дээр төрсөн болохоор манай нутгийн хүн бололтой. Гэтэл Сүжийн ус гэдэг газар мөн үү? гэж асууж байдаг. Ямар учиртай юм бол гэж бодохоос чихрэнд дуртай шиг үг сонсмоор санагдаад
- Та чинь хэний хэн гэгч болж байна даа? гэж асуухад Хайдавжамц тайвнаар
- Намайг Хайдавжамц гэдэг. Манай аавыг Чоймжуур гэдэг хүн байсан юм гэв. Балбар амандаа
- Чоймжуур гэнэ ээ? гээд таг чиг болчихов. Тэр амаа ангайсан хэвээр Хайдавжамцыг харсаар байлаа. Хайдавжамц санаа нь зовсон бололтой
- Та яасан бэ? бие тань зүгээр үү? гэхэд Балбар сая л сэхээ оров бололтой
- Би зүгээр ээ. Харин та чинь төрсөн нутгаа сураглаад явахыг бодоход энэ нутагт төрснөөс цаашгүй юм аа даа? Аавыг тань бол бага сага мэдэх юм байна. Усан зүйлийн хүрээний ламтан Чоймжуур л болох гээд байна. Тэр их хүн залуудаа бага балчир хүүхэдтэйгээ бурханы орон Лхасд мөргөхөөр явсан гэсэн. Тэр хүүхэд л та болоод байх шиг байна. Ламтанг эрдмийн оройд гарч олон шавь нартай болсон тухай сураг сонссон гэхэд Хайдавжамц баярлан
- Тийм ээ. Би гурван настайдаа аавтайгаа явсан болохоор төрсөн нутгийнхаа нэрийг л мэдэхээс цааш юу ч мэдэхгүй л дээ. Аав маань нутаг усаа байнга л ярьж байдаг байсан учир нэр ус нь миний цээжинд байгаа гэхэд Балбар Чоймжуур гэсэн нэрийг сонсоод их хүндэтгэлтэйгээр хандаж байлаа. Тэрбээр нэг л зүйлийг асуух гээд асууж чадахгүй байгаа бололтой хулмалзаад байгааг гадарласан Хайдавжамц түүнийг өөрөө шууд хариулав.
- Аав маань өнгөрөгч хавар жанчаа тайлж насаа хураагаад бурханы оронд заларсан. Аав бид хоёр эргэж ирнэ гээд ээжийгээ, ахан дүүс та бүгдийгээ, нутаг усаа орхиод явсан ч эрдэм номын буяны үйл дэндүү арвин байсны учир ямар ч боломж гараагүй билээ. Эцэст нь надад захиасаа захиад л өнгөрсөндөө хөөрхий минь. Би захиасыг нь биелүүлэх гээд л нүдээ боолгосон аятай сураг ажиг тавьж яваа минь энэ шүү дээ гэв. Балбар нүдээ аньж залбираад
- Танай аав тань нутагтаа байхын л эрдэм номын оройд гарчихсан байсан. Аав нь Авирмэд гавж гэж аугаа эрдэмтэн хүн байлаа. Тэр хүн хүүдээ эрдэм номоо өвлүүлсэн байх. Бас аавыг тань төгс гансагтай хүн гэдэг байсан. Түүнийг оюун ухааны гурамсан барилдлагад төрсөн төрмөл бурхан гэж ярьж байхыг л би сонсож байсан даа. Тэр үед би бага ч байлаа. Их ламтанг холоос л харж байсан. Одоо бодоод байхад та чинь аавтайгаа их адилхан хүн байна шүү дээ гэхэд Хайдавжамц инээмсэглээд
- Зарим хүмүүс тэгж ярьдаг юм аа гээд чимээгүй болон бодлогоширов. Балбар дагаад чимээгүй болсон ч дотроо
- Чоймжуур ламтан хүүдээ ямар захиас захиад түүнийг нь биелүүлэхээр яваа юм бол доо. Энэ захиас маш нууц юм байж таараа. Тийм болохоор юу боллоо гэж ярих билээ дээ гэж бодсон ч сонсож мэдэхсэн гэсэн хүсэлдээ хөтлөгдөн

- Та нутагтаа хаана очих, хаагуур явах бодолтой байна даа гэж асуухад Хайдавжамц
- Юуны өмнө аавынхаа захиасыг биелүүлнэ. Дараа нь өвөг аавынхаа Аръяаболын бүтээлийн сүмээр орно. Ээж, эмэг ээж хоёрынхоо газар дээр очно гэлээ. Балбар дотроо залбираад
- Ээ бурхан минь. Эмэг эх Үзмээгээ бурхан болсныг хэзээ хаанаас олоод сонсчихдог байна. Тэр хол газар шүү. Хүмүүс очоод нутаг нугын тухай сонсгодог байх нь. Энэ хорвоо дээр нууц юм ч их, нууцгүй юм ч олон л байдаг бололтой. Эрдэм номтой их хүмүүстэй хүн болгон л золгож уулздаг биз дээ гэж бодоод Хайдавжамцад хандан
- Та хэзээ нутаг нугаараа явах бодолтой байна. Таныг дургүйлхэхгүй бол би зам зааж бараа больюу гэж л бодож сууна гэхэд Хайдавжамц ихэд баярлан
- Юун сайн хэрэг вэ? Тантай хамт явбал надад сайхан байна. Би гэдэг хүн чинь Хөшөөтийн голын гурван нуураар орж Адаг нуурт байгаа дацанг эргэнэ. Тэгээд Сангийн далай нуурын баруун хойт талд Дэлгэр салаа, Баруун салааны задгайрах цагаан өлгийд аавынхаа захиасыг биелүүлэх болно. Тэнд л бумбаа залах ёстой юм шүү дээ гэхэд Балбар амандаа
- Баруун салааны задгайрах цагаан өлгийд гэж аяархан хэлээд бодол болсноо
- Тэгээд хэзээ явах вэ? гэж асуув. Хайдавжамц
- Таныг зөвшөөрвөл танайд хоёр хоноод хөдөлье. Маргааш, нөгөөдөр, нөгөөдрийн маргаашаас тэнгэр зохирч намрын шар наран арван нэг хоног ээх болно. Дулаарч намуухан өдрүүд болно гэсэн үг л дээ гэхэд Балбар гайхасхийж
- Та үүнийг яаж мэдсэн байх билээ гэхэд Хайдавжамц инээмсэглэн
- Марсэр, Бат од хоёрын зөрөх хугацаа дөрвөн хоног үргэлжилдэг юм. Уржигдараас эхэлсэн нөгөөдөр дуусна. Энэ хоёр од улаан зүгийн замд зөрөхдөө заавал тэнгэрийг хямраадаг. Харин цагаан зүгийн замд зөрөхөд яадаг ч үгүй юм. Намрын адаг сарын шинийн хоёрны сар гэдэргээ унан хоёр үзүүрээ дээш харуулсан байхад нэг үзүүрт нь шувуухай од. Нөгөө үзүүрт нь чөдөр од тохиосон нь цас эрт орох хүйт эрт эхлэхийг мэдээлсэн. Энэ тохиолгын төгсгөл нь Марсэр, Бат од хоёрыг зөрөх хугацаагаар өндөрлөж байгаа хэрэг л дээ гэснээ Балбар луу харж
- Би таньд тайлбар толийг нь үзүүлье гээд өврөө уудлан нэгэн зүйлийг гарган ирж задалбал хурганы арьсны хэрийн маш сайн боловсруулсан нимгэн илгэн арьсан цаасан дээр арилдаггүй бэхээр бичсэн тэнгэрийн түмэн одод түүнийг өнгөөр ялган мянган шугамаар холбосон зураглал нууцын өндөр зэрэглэлтэй томъёогоор тэмдэглэсэн бичвэрийг үзүүлээд
- Одод тохиосон үед тэнгэрийн эрхэсийн бичээсийг уншаад энэ толь бичвэрээс тайлж тайлбарлаж уншдаг юм гээд оддын нэрийг хэлж бас Марсэр, Бат од хоёрын зөрөх хугацаа дөрвөн хоног байх нь. Улаан зүгийн замд шүү дээ гээд л тайлбарлан зааж байв. Балбар ч өөрийгөө их хүрээний дуганч байсны хувьд их биш ч бага сага юм гадарлана гэж боддог байсан бол энэ удаа нүд нь эрээлжилж толгой нь эргэхээс цааш хэтэрсэнгүй. Тэр дотроо

- Аргагүй л удам угсаагаараа эрдэм номтой эрхэм хүмүүс юм даа гэж бодов.

Хайдавжамц Балбарынд хоёр хонохдоо их зүйлийг мэдэж авлаа. Балбартай ойртон дотносож эр хүний жудгаар нөхөрлөж чадав. Балбар нэг л зүйлийг сонсохыг хүсэж байсан энэ хүсэл нь ч биелэв. Тэрвээр Хайдавжамцын эцэг Чоймжуур ламтны тухай л мэдэхийг хүссэн билээ. Хайдавжамц

-Аав бид хоёр нутгаасаа гараад гурван жил явж байж Түвдийн Лхасын бурханы оронд хүрсэндээ. Аав минь гурван настай хүүгийнхээ ая таваар явсан нь тэр. Нэг үгээр гурван өвөл нь суурин сууж гурван зун буюу дулаан үеэр явсан хэрэг л дээ. Бид хоёрыг Лхаст очиход Их хүрээний донир угтаж аваад бүх зүйлд туслалцаа үзүүлэв.

Аав ихэд гайхаж байв. Бид хоёр мөргөл үйлдэж аав минь нүглээ наминчлаад буцах ёстой байсан юм. Аав хүрээ хийдээ орхисон, эхнэр авч сахил санваараа зөрчсөн, бас эхнэр нь залуугаараа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн гээд дааж барахын аргагүй нүгэл үйлдсэн гэж үзэж байлаа. Гэтэл бид хоёрыг ийнхүү хүндэтгэлтэйгээр тосож амьдрал ахуйд тус дэм үзүүлж аавыг Чойрын хуралд суухыг урив. Аав энэ их хүндэтгэлийн учрыг олж мэдээд ихэд баярлав. Аав бид хоёрыг нутгаас гарснаас нэг сарын дараа манай нагац ах Их хүрээний Хамба Агваанням эмээ ээж дээр дүү нартайгаа ирж золгоод аав бид хоёрыг явсныг дуулаад

- Би хүргэн, зээ хоёроосоо өршөөл гуйх ёстой байсан юм. Одоо явчихсан бол яая гэхэв. Энэ хоёртоо бага ч болов тус болохыг хичээнэ ээ гэж хэлсэн юм гэнэ лээ. Тэгээд л Лхаст байгаа Чойрын хийдийн хамба ламд хүсэлтээ илэхрийлэн хүн явуулж аав бид хоёрыг очихоос бараг хоёр жилийн өмнө шийдвэрлэчихсэн байсан л даа. Аав ном эрдэмдээ хичээнгүйлж байж гурван жил болоод Гавжийн дамжаа дүүргээд, цааш нь суралцаад Аграмбын зэрэг цол авсан. Халхын Чоймжуур Аграмба гэж нэр цуу алдар нь түгсэн дээ. Нутаг руу явж эмэг ээжийг авчирна гэж байтал Агваанням нагацаас хэл ирж, манай оронд хувьсгал ялж, сүм хийдийг татан буулгаж, цол хэргэмтэй лам хуврагуудыг баривчлан яллаж байна. Хэл чимээ очтол тэндээ хүлээж бай гэсэн юм.

Аав бид хоёр Энэтхэг оронд зургаан жил сууж аав багшлан олон шавь нартай болов. Гэтэл дахиад Түвдэд уригдан сургалт боловсруулах хүрээлэнгийн тэргүүнээр ажилласан. Энэ л амьдралынхаа бүхий л хугацаанд тэнгэрийн бичээсийг тайлах тайлбар толийг бүтээсэн. Энэ толь бичгийг ашигладаг хоёрхон хүн Лхаст байгаа. Аав намайг зургаан настайгаас эхлэн шавилан суулгаад арван зургаан жил суралцуулаад хорин хоёр настай байхад Гэвшийн дамжаа бариулсан. Тэр цагаас эхлэн тэнгэрийн бичээсийг уншуулж тайлбар толь ашиглууж сургахад насан өөд болтлоо зүтгэсэн дээ. Аав бид хоёр шөнө од жагсангуут тэнгэрийн бичээсийг уншина. Дараа нь надаар тайлбар толиос тайлуулж тэмдэглэл хийлгэнэ. Дараагийн жилд мөн л нөгөө өдөртэйгөө таарч тохирсон нь юу байна, зөрж байгаа нь юу байна гээд л жишүүлэн дүгнэлт хийлгэнэ. Зөвхөн тэнгэрийн бичээсийг уншиж тайлахад л бүтэн найман жилийг зарцуулсан гээд л бодоод үзээрэй. Аав маань боллоо гэж хэлээгүй. Улам цааш нь баяжуулаад явах юм шүү гэсэн дээ гээд Хайдавжамцыг санаа алдахад Балбар

- Танай аавыг чинь Усан зүйлийн хүрээнд сууж байхын л гавжийн зэрэгтэй залуу гэж байсан л даа. Агваанням хамба буруу зөрүүгээр зарим зүйлийг ойлгосноор тангарагийн гэм үүсэж зөрчилдсөн гэдэг юм. Танай нагац Агваанням чинь аавын чинь аав Авирмэд гавжийн гарынх

нь шавь байхгүй юу. Хамба болсныхоо дараа танай аавыг дэргэдээ байлган багш шавийн барилдлагатай болсон хүмүүс. Готов донир гэж нэг хүн байлаа. Түүний хар хорон санаанд өртөөд буруу үйл мөр удаа дараа гараад аав тань сүм хийд хурлаа орхисон юм. Тэгээд ч хурал номоо бясалгалаар сольж энэ урд харагдах сүрлэг гоо үзэмж төгс Улаан хайрханы Их тагд байх Үнхэлцэгийн агуйд гурван жил сууж даяаны бясалгалаа дүүргэсэн гэж хүмүүс ярьдаг юм.

Тэгэхэд та ч гурван нас хүрсэн байх. Тэр хугацаанд их буянтай үйлдлүүдийг хийсэн. Хөшөөтийн голын гурван нуурын Адаг нуурт нэг дацан босгон лус, газрын эзэд, усны эздийг тахиж байв. Баянголын ястын бууцан дээр нэг дацан байгуулсан даа. Аавынхаа Арьяаболын сүмд байнга очиж хурал хурна. Бижийн амны өндөр мөргө дээр байсан Баян намсрайн дуганд ч мөргөдөг байсан гэж ярьцгаадаг юм. Танай талийгаач ээж Дэжидням их ухаалаг бас царайлаг хүн байсан юм гэнэ лээ. Тамч Цалуугийн голын гүнж хэмээдэг байсан гэсэн. Өвөг эцэг Авирмэд гавжийн чинь тухай үлгэр домог шиг юм зөндөө сонсож байсан даа гэхэд Хайдавжамц толгойгоо дохисноо

- Аав минь манай нагац Агвааннямд их баярладаг байсан даа. Ээжийг нь дэргэдээ аваад яг л өөрийнхөө эх шиг асарч тойлж байгаад мөнх бусыг үзүүлэхэд толгойг нь түшиж байгаад хойт мөрийг нь даасан гэдэг юм билээ. Аав надад нэг удаа л

- Миний хүү. Аавын чинь хадам ах бас багш, чиний нагац ах Агваанням их ухаантай хүн шүү. Чи бид хоёр байнга ачийг нь санаж хүндэтгэж явах ёстой юм шүү. Чи чинь дөрвөн том нагацтай хүн шүү дээ. Ээжийг чинь Ноён ээжийн дэрстэй хондон дээр хөдөөлүүлсэн. Гэтэл миний ээж чиний эмэг ээжийг мөн л тэр нутаг дээр хөдөөлүүлсэн гэж Агваанням ах захиандаа бичсэн байна. Үүнийг сонсоод аавын чинь сэтгэл амгалан болчихлоо. Тэртэй тэргүй энэ орчлонгийн жам ёс ийм болохоор бид чинь хаашаагаа зайлах билээ дээ. Тэр хоёр ээжийн ерөөл тавилан ийм л байсан бололтой.

Хоёр ээжийнхээ нутгийг сайн тогтоож аваарай. “Ноён ээж” гэдэг газар шүү. Хэзээ нэгэн цагт чи очиж л таарна. Миний энэ толгой дотор айхтар юм орсон бололтой ихээхэн өвдөх юм даа. Хэзээ юм бүү мэд. Нэг л цаг мөчид аваад залрах байх аа даа. Нөгөө Бумбаа залах газраа мартав аа. Сангийн далай нуурын баруун хойт бие баруун салааны амны тавиу цагаан өлгийд шүү дээ. Чиний төрсөн нутаг “Сүжийн ус” гэдэг газар. Наад бумбанд чинь аавын чинь бие, хэл, сэтгэл гурвуулаа шингэсэн юм шүү дээ. Бүх номын цогцос их тамир хурсан Сандуйн жүдийн бүтээл юм шүү дээ. Газрын хөрснөөс гурван тохой гүнд байрлуулаад дээр нь бунхан хийвэл зүгээр байх. Хүмүүс бунхан шарил гэж ойлговол алсдаа бат бөх өнө удаан байхад нь хэрэг болно. Энэ бумба оршиж байгаа газар нутагт ард түмэн нь оюун билэг төгөлдөр эрдэмтэй номтой, цэцэн мэргэн байж, мал амьтан нь өсөн үржиж, уул ус ургамал жимсээр тэгш байхын сайн заяа түшиж байх юм. Уг нь би өөрөө залья гэж бодож байсан ч явж чадах тэнхэлгүй болчихлоо. Одоо миний хүү л аваачиж залах болох нь дээ. Чамайг байгаа болохоор миний санаа амар байна гэж захисан юм даа гэв. Балбар Хайдавжамц хоёр бие биеийг харан сэтгэлийнхээ итгэлийг илэрхийлэн сайн тамирыг илгээнэ. Балбар бага зэрэг хулгасхийж байснаа

-Та нутагтаа үлдэхгүй буцаад явах хүн үү? гэхэд Хайдавжамц

- Тийм ээ. Би буцна. Цагийн байдал тийм ч тайван биш байна. Бас дээд цахар хошуунд эхнэр хүүхэд гэр орон минь байгаа. Миний хүүг Бавуу гэдэг. Гурван настай. Цаг сайхан болвол гурвуулаа ирэх санаатай байгаа. Хэрвээ ирвэл танай хаяаг л бараадна шүү дээ гэхэд Балбар баярлаж

- Тэгэлгүй яахав. Бид чинь нэг булгийн уснаас ундаалсан нутаг нугын хүүхдүүд шүү дээ. Цагийн ааш араншинг сайн ажиглах нь зөв байх аа. Хэн хүнгүй л дотроо айж суух юм байна шүү. Би ч хүрээ хийд дээр дуганч байсан хүн. Эв нь таарвал гайгүй л байх. Эгзэг нь таарчихвал яаж ч мэдэх л юм гээд уртаар санаа алдав. Балбар сэтгэлдээ хадгалж явдаг түгшүүрээ нууж чадсангүй.

Хайдавжамцын хэлснээр хоёр хоногийн дараа тэнгэр зохирч нар илчээ хайрлаж агаар бүлээрч дор газрын цас хайлав. Байгалийн энэхүү үзэгдэлд хүмүүс баярлаж байсан ч дотроо

-Хүйт эхлэхийн өмнө цас хайлах ч сайны дохио биш дээ. Мөсөн бүрхүүл тогтвол мал идэх юмгүй болж хэцүүднэ дээ гэж сэтгэл зовж байлаа. Балбар, Хайдавжамц хоёр гэрээсээ мордож Сүжийн хөтлөөр давж Улаан хадын амаар орж Хөшөөтийн гол уруудан явсаар Адаг нуурын дацанд ирэв. Энэ дацан аль хэдийнээ үүд хаалгаа барьж хээрийн салхи хөлхсөн аалз тороо татсан шавар оромж болсон байв. Хэсэг судар номын баринтаг задарч ус цасанд ороод атирч зарим хуудас нь салхинд хийсэж эзгүй хээрт хамхуултай ханьсана. Арга байхгүй л эздийг нь барьж хороосон болохоор орон байр нь эзгүйрч оюун билэг нь хөсөр хаягдах нь ухаант хүмүүсийн уйлах багадаж тэнэгүүдийн мунхрах нь түймэрийн гал шиг дүрэлзэж байв. Хайдавжамц дотроо

- Аавынхаа оюуны бүтээл болох хамаг номын цогцос их тамир хурсан бумбыг ийм догшин авир ааштай байнга заналхийсэн цаг дор энэ нутагт үлдээнэ гэхээс сэтгэлд нь нэг л багтаж өгөхгүй байлаа. Хамгийн гол нь хүн амьганд үзэгдэж харагдаж мэдэгдэж болохгүй. Үүнийг Балбар бид хоёроос өөр хэн нэгэн мэдэх ёсгүй. Тиймээс шөнө дөлөөр бүгдийг амжуулах болно. Хэдийгээр зуслангийн газар айл амьтангүй мэт боловч малч хүмүүс чинь хаана юу болов гэдгийг сонор соргоогоороо мэдэрч байдаг ухаантай хүмүүс шүү дээ гэж бодож явахад Балбар давхар давхар бодолд дарагдаж явлаа. Дааж ядаж байгаа мэт хоёр мөрөө цээжтэйгээ хөдөлгөн хөшсөн муу шар усаа тараахад мөрнийх нь үе хүт хүтхийн дуугарна. Тэр дотроо

- Дотоод яамны дамран малгайтнууд намайг муу дуганч гээд тоохгүй орхивол сайн л байна. Дуганч чинь хамаг ном судартай хутгалдан ихэс дээдэстэй ойрхон байдаг болохоор нэр ус минь нилээд дээгүүр бичигдээд хороогдох хүний тоонд орчихсон байхыг үгүйсгэх арга байхгүй. Хэрвээ гай зовлон холуур өнгөрсөн ч энэ айхтар бумбыг Хайдавжамцтай залсныг хэн нэгэн мэдвэл нөгөө гай зовлон чинь тойрох биш бүр дайраад толгойг минь залгиад өгвөл яана. Ямар ч хэцүү хорвоо вэ? Яасан ч барагддаггүй лай ланчиг вэ? Энэ бумбыг шөнө дөлөөр залаад булш бунхан болгосон нь зөв бололтой. Манай нутгийнхан ч тун ч ухаалаг сонор соргог хүмүүс шүү дээ. Аль нүхэнд хэдэн тарвага ичсэнийг андахгүй мэднэ. Амьтад малын мөрийг хараад нас шүдийг нь зүстэй нь хэлнэ. Энэ бумба залсан газарт миний мөр бүтэн үлдэх юм бол

- Өө энэ булш шарилыг чинь Балбар авчирч тавьсан байна. Ойрдоо муу юм дуулдаагүй дээ. Энэ Балбар чинь юугаа хийгээд яваа хүн бэ? гэж хардаж сэрдэх болно гэж бодоход нуруу руу

нь хүйтнээр жин тавьж давхар айдас нөмөрнө. Тэр хоёр ийнхүү бодол бодлоо хэлхсээр Шар хөтөл дээр гарч ирээд Сангийн далай нуураа харж сэтгэлээ баясгав. Энэ нуур захаасаа зайрмагтсан ч голдоо ус нь мэлтрэн харлаж торгон мандалд нь үл мэдэг долгио атирна. Хайдавжамц бодлогоширонгуй байдалтай нутаг нугыг тольдон байснаа

- Балбар аа. Хоёулаа Бумба залах газраа үзэж товлочихоод шөнө дөлөөр ирж залъя гэлээ. Энэ үг Балбарын загтнасан газар нь маажих шиг болж тэр дотроо

- Ухаантай хүмүүстэй ханилж явахад бодол санаа хүртэл ингэж нийлдэг юм даа гэж бодоод их л ураилгахнаар

- Таны хэлдэг түмэн зөв өө. Адаг нуурын дацан та бид хоёрт нэгийг хэлж хоёрыг санууллаа шүү дээ. Сэрэмжтэй л байхгүй бол та ч явсан юмгүй би ч суусан юмгүй болохыг хэлэхэд бэрхтэй мэдэхэд хэцүүхэн л байна шүү гэж хаширлаж байгаагаа битүүхэн илэрхийлэв.

Тэд ярилцсан ёсоороо шөнө дөлөөр ирж Бумбаа захисны дагуу залж баруун биений энгэрээс хавтгай хөх чулуу авчран бунхан булш хэлбэртэй болгоод мөрөө сайн далдлан ойр орчмыг нь сайн цэвэрлээд ул мөргүй болгоод үлдээв. Буцаж явах замдаа Хайдавжамц

-Балбараа та их хаширлаж байгаа тань сайн хэрэг. Та маш их буян үйлдлээ. Энэ бумбыг үргэлж сэтгэлдээ залж оюун ухаандаа бясалгаж явбал танд их тус болно. Муу гэм амь насны аюулаас гэтэлгэнэ. Манайхны нэг мэргэн үг байдаг даа. “Эзэн хичээвэл заяа түшнэ” гэдгийг сайн санаж яваарай. Сайн үйлс бүхэн мөнхрөх тавилантай. Харин муу тэнэг үйл тухайн үедээ хүчирхэг мэт боловч мөнх бусыг үзэх нь амархан байдаг. Энэ их ном судар, бичиг түүх шастир галд шатаагдан ус бороонд норж ялзарч зэрлэг салхинд хөөгдөн хамхуултай ханьсан хөсөр хэвгэх нь дэндүү хайран харамсмаар санагдаж байсан ч аргын хувьд дийлэнх байдаг учир хүмүүсийн оюун санаанд хадгалагдан үлддэг. Нэг үгээр арга эзэлсэн мөнхийн бүтээл юм шүү дээ. Ном өөрөө бодитой орших учир мөнх бусыг илэрхийлдэг. Харин номын дотоод билэг чанар хүний оюун билгийн хүрдэнд хадгалагддаг болохоороо мөнхөд оршиж байдаг юм гэлээ. Балбарын ухаанд урам нэмэгдэж биед нь хүч тамир орж байв.

Энэ хоёр хүн маргааш нь “Ноён ээж” хэмээх нар ээсэн үндэс сүлжсэн дугуйрсан тойрмын хөлд нь бууж мөргөл үйлдэн хүндэтгэл үзүүлээд ерөөл тавилаа. Хайдавжамц эмэг эх, ээж хоёрынхоо алтан шарилын өлмийд нь ёсорхон сэтгэлдээ хөрөг дүрийг нь бүтээж оюун ухаандаа ач буяныг нь санаж чадлаа. Тэд Алаг хайрхан уулын өвөр бэл Улиастайн бага голд байх Арьяаболын бүтээлийн сүмийг зорив. Хар боомоор уруудан Шар хадны хоолойг гаталж Баянголын эхний дэрс зэгсэн шугуйд орж шургав. Булгийн эхний тэгш хавтгайд бууж түр азнав. Энэ хонхор газрын баян бүрд үнэхээр байгаль урласан уран зураг мэт ажээ. Баруун хоймрыг эзлэн Алаг хайрхан, Буга хайрхан, Бүс хайрханууд ханхайж байхад зүүн өмнө нь үзэсгэлэн төгс Улаан хайрхан сүрлэг харагдана. Баруун биеэр Хөвчийн нуруу алсрахад зүүн биеэр Сүжийн уулс хүрээлнэ. Рашаан уснаас амсаж морь биеийг хэсэг амраасан хоёр баатар маань Баянголыг уруудан аян замын мөрөө хөөв. Ястын бууцан дээр байсан дацан мөн л адилхан хэлмэгдэн тэнэг мунхагийн хар сүүдэр дайрч өнгөрсөн байлаа. Энэ бүхнийг харах нүд хайрлах сэтгэл сэмэрч байв. Хайрлах сэтгэл дэндүү их байвч харамсан халаглах нь бүүр ч их байлаа. Баянголыг уруудах тусам хоёр талын цавчим өндөр хадан цохио үргэлжлэн хараа салгахгүй байгаа мэт дээрээс тонгойгоод

-Ямар хэрэг зоригоор хаана хүрэх гэж яваа хүмүүс вэ? Муу үйл хийвэл та нарыг өршөөхгүй. Харин сайн үйлд зорьж яваа бол саад бүхнийг чинь арилгая гэх шиг бодлогоширон дүнхийнэ. Тэд Бурааны булгийн рашаанд дөрөө мулталж ёсчлоод цааш хөдлөв. Балбар

- Та ч энэ хавийн нутгийг сайн мэдэхгүй байх гэхэд Хайдавжамц

- Би чинь Сүжийн усан дээр төрөөд энэ Улиастай бага голын Арьяаболын сүмд эмэг эхтэйгээ гурван нас хүрсэн хүн шүү дээ. Гэхдээ гурван настай байсан гэхээр юугаа мэдэх билээ дээ. Харин эмэг ээжийнхээ дүр төрхийг муухан санадаг юм. Ээжийнхийгээ бол огтхон ч мэдэхгүй шүү. Аав минь сайхан хүн байсан гэхээс өөрийг дурсаж ярьдаггүй байсан. Дэндүү их хайрлаж байсан болохоороо дурсаж ярихаасаа халгадаг байсан биз дээ. Ямар сайндаа л төрсөн эхийгээ орхиод гурван настай намайг аваад нүгэл хилэнцээ нимгэлнэ гээд холын нутгийг зорьж байх билээ. Би ч ааваасаа асууж байсангүй. Аав надад

- Миний хүү би чамайг хурал номоос хөндийрүүлж тэнгэрийн бичээсийг уншиж тайлж сурахад л хамаг анхаарлаа хандууллаа. Аавд нь чамд өвлүүлж үлдээх хөрөнгө байхгүй. Харин оюун ухааныхаа бүтээлийг л өвлүүлэхээр шийдлээ. Бас нэг юм бий. Аавын минь хөөрөг. Энэ Чүнчигноров хөөргийг алга хийж болохгүй. Энэ бидний үе удмыг дамжиж явах сахиус минь байгаа юм. Аав нь амных нь ирмэгийг жаахан хэлтэлчихсэн юм. Өөр янз бүрийн сэв байхгүй. Ээж чинь төрж хөнгөрч болохгүй гэдгийг өөрөө мэдсээр байгаад бас гуйж хүссээр байгаад чамайг төрүүлсэн юм. Тэр

- Би хүүхэд төрүүлж эх хүний жаргал зовлонг нэгхэн агшинд ч бол үзмээр байна. Нөгөөтэйгүүр танай үр удмыг чинь амин аргамжийг тань тасалчихгүй бөхөлж өгмөөр байна. Би бүсгүй хүн болж төрсөн болохоор бүтэн заяанд нь жаргамаар байна гэж өөрө зүтгэснийг нь бодоод байхад түүний минь зөв байсан юм билээ. Миний хүү ч гэсэн хүний ёсыг барьж хорвоогийн жамыг дагах хэрэгтэй. Энэ оюун билгийн эрдэм номын цагаан аргамжийг тасалж болохгүй үргэлжлүүлж байх ёстой гэдгийг мартаж болохгүй гэж сургаж билээ. Би аавын сургаалыг хүндэтгэж дээд цахар хошууны Бүүвэй гэдэг хүний бага охин Цээмаа бүсгүйтэй нийлээд гурван жилийн өмнө хүү маань төрсөн. Би танд ярьж байсан даа. Бавуу гэдэг нэртэй гэж. Цаг түвшин сайхан болвол бид гурав нутагтаа ирнэ дээ гэхэд Балбар

- Хүрээд ирээрэй. Нутгийн уул ус, ахан дүүс нар түшээд л авна гэхэд Хайдавжамц баярлан

- Балбар аа. Хэдэн малтай болчихоод аав ээжийнхээ нутгаар нутаглаж амьдрах юмсан. Аав минь нутгаа их санаж шөнө болгон шахам Сангийн далай, Хөшөөтийн гурван нуур, Алаг хайрхан, Улаан хайрхан бусад уул нуруудаа зүүдэллээ гэж яриад давсгүй бараан цай бэлтгүүлэн лусад сэржим өргөдөгсөн гэж ярьсаар яваад Улиастайн голын урд цагаан огтрогоор давж бага гол ороод ирлээ. Харин Абыяболын бүтээлийн сүм бусдыгаа бодвол бүрэн бүтэн ном судар нь өрөөстэйгөө байлаа. Гэхдээ л сүүлийн нэг жилдээ хурал хурсан шинж алга байв. Хайдавжамц дотроо

- Манай эмэг эх өнгөрөөд л эзгүйрч эхэлсэн бололтой юм. Нагац ах ч нас нь өндөр болсон бас айдас хүйдэстэй байгаа болохоор хөлөө хумхин гэртээ бүгээ биз гэж бодов. Тэр хоёр цаашаагаа хөвчийн нурууны Агуйтын эхэнд өвөлжиж байгаа нагац ах Агваанямтай золгохоор зам шулуудав. Агвааням хамба ганц биеэр насыг барж байгаа нэгэн. Тэр олон ач

нартай боловч ойртон дотносох нь ховор. Харин газар дээр ганцхан зээ хүүтэй. Түүнтэйгээ төрсөн цагаас нь ганц удаа боловч уулзаж учраагүй зөвхөн сэтгэлдээ тээж явдаг билээ. Гэтэл гэнэт гэрт нь морилоод ирэхэд нь үнэмшиж ядан

- Чи чинь тэгээд миний зээ Хайдавжамц болж байна уу? Ямар сайхан ханхар эр болсон юм бэ дээ. Яг л аав дүрээрээ байна даа. Нүд нь ээжтэйгээ төстэй юм даа гээд тогтуун харна. Агваанням ихэд баярлан өөрт байгаа амттай болгоноороо дайлж отгон дүү Дэжиднямынхаа тухай дахин дахин дурсан ярьж өөрийгөө мунхаг тэнэг амьтан гэж үзэн ядаж байлаа.

Би Зундуй маарамбаас бүгдийг сонссон. Миний дүү эрүүл саруул хөнгөрөөд гурван жил хүүгээ эрхлүүлж эр нөхрөө халамжлаад бурханы оронд явсан гэнэ лээ. Хүний орчлонгийн жаргал зовлонг гүйцээгээд амар амгаланг бүтээж чадсан гэсэн гэж ярив. Хайдавжамц Балбар хоёр өнжиж хоноод буцах болоход Агваанням

- Би гэдэг хүн өгөр модон мэт ганцаараа доёйгоод насыг барлаа. Хэдэн ач зээгээрээ л элгээ дэвтээж сэтгэлээ хуурах юм даа. Хүү минь цагийн аясыг сайн ажиж байж л наашаа зүглээрэй. Урь унаж дулаан болохоор нагац аав нь аавын чинь бунханд очиж мөргөж маань уншина. Цагийн байдлыг оногоож мэдэхэд тун ч бэрхтэй байна хэмээсээр тэднийг үдэж мордуулав.

Хайдавжамц Балбарынд өвөлжөөд хаврын тэргүүн сарын шинийн гурванд өмнө зүгийг чиглэн холын аяндаа мордов.

Балбар өвгөнөөс энэ бүгдийг сонсож мэдсэн Сагад толгойгоо илээд

-Аавын нагац Агваанням гуай хэдэн насыг зооглосон бэ?гэхэд Балбар өвгөн нүдээ нухлан бодолхийлж байснаа

- Хоёр жилийн дараа юм даг. Мянга есөн зуун гучин гурван онд баривчилж аваачаад цаазаар хороосон юм гэнэ лээ. Хоёр зун л танай өвөг аавын бунхан шарилд мөргөсөн дөө. Гучин хоёр онд миний нүд өвдөөд гээд сохор болсон тухайгаа яриад гучин гурван оны зун танай нагацыг хороосны дараахан намайг Их салааны хойт хамар давуулж биржрүүн хадан дунд аваачаад тэр буянтай бурхан хүн тарваганы дош руу буудаад намайг амьд үлдээсэн юм даа. Би нүд сохроогүй, хэлмэгдлээс амьд мэнд үлдсэнээ өвөг эцэг Чоймжуурын шидэт бумбыг танай аавтай хамт залж шүтэж биширч явсны ач л гэж санадаг юм. Надад энэ хоёр гайхамшигтай тохиолдлоос өөр ч олон зүйл дээр ач тус нь мэдрэгддэг юм гээд бахархан ярьсан Балбар өвгөн

- Гарч биеэ амраая гээд босоход Сагад ч мөн дагалдлаа. Эрхэм хоёрыг гадаалахад өмнө зүгээс үүр цайж сүүн өнгө цацан шаргал өнгө дагуулж уулын орой ирмэгээр зэсэн өнгөөр хөвөөлсөн байлаа. Шөнөжингөө хөөрөлдсөн хоёр гэртээ орж цай зооглох зуураа дахин хуучлав. Балбар өвгөн хөхөрсөөр

- Миний сохор биш гэдгийг манай ач хүү Амархүү л ганцаараа мэднэ. Одоо та мэддэг боллоо. Өөр хэн ч битгий мэдээсэй гэж бодох юм даа. Насан өндөр болсон над шиг хүн нэг хоч, нэг нэртэйгээ л дуусъя гэж бодогдох юм гэхэд Сагад толгойгоо дохин

- Тийм ээ. Тэр таны зөв гэхэд Балбар

- Ярьж байгаа дуу хоолой нь хэлж байгаа үг, төрх байдлаараа аавтайгаа яасан ч адилхан юм бэ дээ. Аав ээжийгээ дуурайхгүй хүүхэд гэж хаана ч байх юм билээ дээ гээд ямар нэгэн юм асуух гээд байгаа бололтой Сагад руу харахад Сагад дотроо

- Балбар гуай миний нэр, охин хоёрын тухай л ярих гээд байна даа гэж гадарласан тэрээр

- Балбар гуай манай аав Улаан хайрханы Үнхэлцэгийн агуйд очоогүй юм уу? гэж асуухад Балбар

- Үгүй ээ. Очоогүй явсан. Дараа ирэхээрээ очно гэж л ярьж байсан даа. Би ч тантай тамхилахдаа аавын чинь Чүнчигноров хөөргийг хараад л таньсан л даа. Олон хүмүүсийн дунд сохор мөртлөө

- Энэ танай аавын хөөрөг байна шүү дээ гээд нүдтэй хүн шиг юм яриад байлтай нь биш дээ. Чимээгүй л өнгөрсөн дөө. Харин нөгөө тэнгэрийн бичээсийн тайлбар толь бичиг нарийн нимгэн илгэн цаасан дээр арилдаггүй бэхээр бичсэн зүйл өөрт чинь байгаа биз дээ гэхэд Сагад инээмсэглээд

- Байлгүй яахав. Аав надад өөрөө бичиг үсэг заагаад дараа бүтэн арван хоёр жил тэнгэрийн нар сар оддыг уншуулж, тайлбар толь дээр ажиллуулж сургасан юм гээд өврөөсөө нөгөө нарийн нандин толь бичгийг гарган дэлгэв. Балбар өвгөн учиргүй мөргөн ёсорхов. Энэ толь бичгийн доод буланд нь “ Халхын Чоймжуур Аграмба” гэж нууцын шараар маш жижгээр татсан байлаа. Балбар дотроо

- Хүний оюун ухааны бүтээл үр хүүхэддээ өвлөгдөн үргэлжлээд явж байгаа нь юутай сайхан бэ? Тэгэхэд би дөрвөн хүүхэддээ ямар эрдэм номоо зааж сургах билээ дээ. Муу заль, сохор аз хоёроо л өвлүүлэхгүй бол өөр юу байх вэ гэж бодож суухад Сагад

- Энэ Балбар өвгөн байгаагаараа түүх шастир юм даа. Манай аавыг мөн ч сайн мэдэж байна шүү гэж бодоод түүн рүү ихэд хүндэтгэн биширсэн харцаар харахад Балбар өвгөн эцэг хүний энхрийлсэн зөөлөн харцаар хариу барив. Энэ хоёр эрхмийн харцнууд учран золгох нь итгэлцлийн галыг ноцоож байв.

Гучин дөрөв

Балбар өвгөн Сагадтай хуучилж нэг хоногийг өнгөрөөсөн нь түүнд чамлалттай санагдаж байв. Тэр Бунхан салааны бунхан шарилыг сэргээсэн нууц эзнийг олж мэдсэн ч Бавуу яагаад Сагад нэртэй болсон бас Хөхцэцэг охины тухай мэдэхийг хүсэж байсан ч мэдэж чадаагүйдээ тэр билээ. Балбар Сагадыг дагаад явахад ч бэлэн байсан ч яахан болох билээ. Ахан дүүсийн тангараг, амь насаа аврах заль мэх болгон харж байсан ч сохор хүн болж амьдралынхаа хамаг жаргалыг золиослон зовлонг бүтээсэн тэр сохор хэвээрээ үлдэхийг хүсэж байв. Зөвхөн ач хүү Амархүү мэргэн Сагад хоёрт л нууцаа задалж нүглээ наманчилж чадсандаа баяртай байлаа. Сагадын хувьд тэр сэтгэлээ эзэмдэж сурсан нэгэн болохоор дэлгэгдэх болоогүй нууц түүхийг дэлгэх хэрэггүй гэж үзэж байлаа.

Үйл хийвэл бүтгэл нь

Үр суулгавал соёолтол нь гэж үг байдгийг санах. Сагад охин Хөхцэцэгээ эчнээ сургуульд нь гурван сарын хугацаатай явуулна. Хөхцэцэг энэ жил дөрөвдүгээр курсыг дүүргэнэ. Ирэх жил сургуулиа төгсөх билээ.

Ганц охиноо хуц ухнын дэргэд байлгасаар насыг нь баралтай нь биш улс нийгэмдээ хөдөлмөрлөж амьдралаа бүтээж үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх нь хүний л жам ёс билээ. Сагад шатар нүүж ацан шалаанд ороход бэлэн болсон хүн аятай бодлоо нэрнэ. Охиноо сургуулиа төгсөхөөр нь хуц ухнаасаа салж төв бараадна гэхээр арай л болоогүй санагдана. Энэ нэгдэл нийгмийн мал сүрэг өсөж үржин тоо хэмжээндээ бүрэн хүрч тэгшрээгүй байхад хуц ухнаа зөнд нь орхиж чадахгүй байлаа.

Тэрвээр би их нэр хүндийг хүссэнгүй цалин пүнлүүгээ бага гэж голсонгүй зөвхөн өөрийн элэнц өвөг дээдэс эцгээсээ өвлөж авсан эрдэм мэдлэгийн их ухаанд суурилж бодож боловсруулсан үйл хэргээ гүйцэтгэхийг л хүсэж байв. Тэр арав гаруй жил хуц ухна маллахдаа бас зүгээр суусангүй нэгэн сүр утлага бүтээж чадсан билээ. Тэр өглөө орой хоёрт мал хотолсон үед салхи хаанаас байна тэр зүгт утлагаа аргалын цог дээр уугиулна. Үүнийг үнэрлэсэн мал ихэд тайвширна.

Ялангуяа эр амьтны бадарсан хүслийг нь номхотгон тааламжтай байдлыг бий болгон тогтвор оруулж оргилуун сэтгэлийг нь хангана. Тэд энэхүү содон соргог сүрчиг үнэрийг дахин мэдрэхийг өөрийн эрхгүй хүснэ. Хуц ухна тэр өдөр хуял тачаал омог нь номхорч тайвшраад хөлний хөдөлгөөн нь удааширна. Тогтуун тааваараа бэлчээрлэж маш сайн идээшилдэг. Үүний үрээр махан тарга чамбайрч маш зузаан өөхөөр бүрхэгдэнэ. Ийм тарга хүчтэй хуц ухна үргэлжид эрүүл байдаг. Бас хээлтүүлэх чадвар өндөртэй үр төл нь эрүүл чийрэг, өсгөлүүн, бойжилт нь түргэн, байгалийн эрс тэс уур амьсгал, хатуу ширүүн нөхцөлд ч дасан зохицож амьдрах чадвар өндөртэй байдаг. Нэг үгээр байгальтайгаа зохицон шалгарсан шилмэл омгийн сүрэг бий болгоно гэсэн зорилгыг өмнөө тавьсан хэрэг. Сагад энэ зорилгоо хэнд ч тайлбарлан таниулж магтаж омойтоогүй билээ. Ухаантай нэг нь уг үндэс сурвалжинд нь ороод сүүлийн жилүүдэд мал эрчимтэй өсөж байгааг Сагадтай холбож үзэх нь бий. Сагадын тэнгэрийн бичээсийг уншдагийг бараг сум орноороо мэддэг болжээ. Тэд ч амны билгээр түүнд “Мэргэн” гэсэн нэр цолыг хайрласан. Харин Сагадад хадгалагдаж байгаа мянга түмэн

нууцыг хэн ч мэдэхгүй билээ. Ямар сайндаа гадаадын тагнуул туршуул гэж хардаж сэрдэж байхав дээ. Сагадын сэтгэлийнх нь гүнд нэгэн түгшүүр хургасан байв. Тэр Балбар өвгөнөөс сонссон эмэг эх Дэжиднямын хүсэл үе үе сэтгэлд бууж үг хэл нь чихэнд сонсогдоно.

-Би танай дээд язгуурын удам угсааг таслалчгүй бөхөлж өгнө гэсэн нь ямар аугаа ухаан бэ? Өөрийнхөө амь насыг үл огоорон аугаа үйлсийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлээр зорих гэдгийг юутай ч зүйрлүүлэх аргагүй юм даа. Тэр хүний сэтгэлийн тэнхээ холыг тольдох оюун билэг надад яагаад заяагаагүй юм бол. Оюун ухааны охь манлай дээд язгуурын төрлийн удам угсааны амин аргамжийг би таслах гэж үү? гэж Сагад дахин дахин өөрөөсөө асуугаад

- Үгүй л баймаар юм даа гэж амандаа аяархан шивнэв. Түүний сэтгэлд эр хүний зөн совин хөвөрч алс холоос амар амгаланг ирэх мэт болоод заяа тэгширч тайвшралыг олно. Тэр өөрийн эрхгүй хорь гаруй жилийн тэртээ өнгөрөн улирч ард хоцорсон ч саяхан л болоод өнгөрсөн мэт гэрэл цацарч байгаа нь сэтгэлд мартагдахааргүй хоногшин үлдсэн нэгэн гэгээн дурсамжийг нэхэн санахад хүрэв.

.. Бавуу аав Хайдавжамцыг бие барсны дараах буяны хоногийг гүйцээгээд нутгийн зүг хөл тавьсан билээ. Бавуу аавыгаа нутагт нь хүргэнэ гэж амлаж хичнээн хичээсэн боловч өвчний ад хор дэндүү ааглан амь насыг нь авч хорвоогоос халин одов. Хорвоогийн жам ёсыг яалтай ч билээ дээ. Харин аавынхаа сэтгэлийг, ухаан бодлыг нь нутагт нь хүргэж тэнд амьдрахаар шийдсэн Бавуу ийнхүү зориглон хөдлөв.

Тэр Бурхан халдун уулын харъяат Дондов ламтантай ханьсав. Дондов бие муутай учир Бавуут бараадан түүнд итгэж найдан нутагтаа очихоор ханилсан нэгэн. Дондов эх орон, нутаг нуга, Бурхан халдун ууландаа очиж Хэрлэн голынхоо ус рашаанаас хүртээд газар дээр байгаа ганц дүүтэйгээ золгоод нутагтаа ясаа тавина гэж зүтгэж яваа хүн. Тэр эхнэр, хүү, охин гурваа нутагтаа энх тунх амьдар . Хэзээ нэгэн цагт дүү Шагж, энэ Бавуу хоёртой заавал уулзаарай гэж захиад эсгий гэр, эхнэр хүүхдүүдээ үлдээгээд явж байгаа билээ. Бавуу, Дондов хоёр жар гаруй хоног үхэл амьдралтай тэмцэн байгалийн эрс ширүүн авир ааш араншинтай тулгарч зовлон жаргалаа хуваалцан нутгийнхаа гүнд хөл тавьж Улаанбаатар хотод ирэв. Бавуу Дондовыгоо ганц дүүтэй нь амьд мэнд уулзуулсандаа баяртай байлаа. Бавуу ийнхүү ах дүү хоёрын золгохыг харж энэ агшин амьдралын ямар их үнэ цэнэтэй болохыг санаж байхад Дондов дүү Шагждаа хандан

-Энэ Бавуу хүний төлөө төрсөн амьд бурхан. Намайг аль эрт өмнийн говьд амь асгарах гурван ч тохиолдол тохиоход эхнийхэд нь л орхих ёстой байсан юм. Гэтэл өөрийнхөө амь насыг зөнд нь орхин аварч тэтгэв. Эцсийн нэг агшинд дөрвөн мөч минь үзүүрээсээ хөрч бадайран эзгүйрч амьсгал минь хураагдан зүрх минь зогсоход хүрэхэд халуун улаан цусаа ханаж амаар минь залгиулж бүлээн амьсгалаа илгээн бүтэн биеийнхээ тамираар тэтгэн байж дахин амилуулав. Би ийм амь насны өглөгийг үлгэр домог ном судраас олж уншаагүй бас сонсоогүй билээ. Харин өөрийнхөө биеэр мэдэрч хүртэж, харж сонсож амь насны дээд өглөгийг хүлээж авснаа л үнэнээр нь хэлж байна. Миний дүү энэ хүний ачийг байнга санаж яваарай. Бурхан мэт шүтэж хүндлэн дээдэл. Ах минь гэж надтай адилхан намайг амьд мэнд гэж санан түшиж өргөж өндийлгөж тус дэм болж явдаг юм шүү гэж захиж хэлээд мөнх бусыг үзүүлж бурханы оронд одов.

Шагж дотоод яаманд ахлах дэслэгч цолтой гуравдугаар тасагт мөрдөн байцаагч ажилтай байв. Тэр Бавуутай сайн ярилцсаны эцэст арван тав хоногийн мужааны дамжаанд суулгаж мужаан болгоод модны хоёрдугаар артельд мужаанаар оруулав. Ногоон нуурын хороололд нэгэн жижиг шавар тагзыг хөлслөн амьдарч эхлэв. Бавуу удсан ч үгүй ажилдаа дасаж төлөвлөгөө нормоо давуулан биелүүлдэг сайн мужааны тоонд багтав. Модны хоёрдугаар артелийн цаахна талд оёдлын артель байв. Энэ хоёр артелийн ажилчдын хоол ундыг бэлтгэн хангах үүрэгтэй ажилчдын тавдугаар гуанз гэсэн хаяг бүхий хоолны газар ажиллана. Бавуу хоёр жил болохдоо ажилчдын хоолны газрын буянаар оёдлын артелийн нэгэн бүсгүйтэй танилцан ихэд дотносож байв. Тэр бүсгүйн нэрийг Бадамханд гэдэг. Бавуу Бадамханд хоёр хааяа үзвэр үзнэ. Бавуу гэр орноосоо санаа зовоод Бадамхандыгаа нэг ч удаа гэртээ урьж залаагүй билээ. Харин Бадамхандын байнга ирж очин заримдаа хонож өнжинө. Тэр хоёр нутаг нуга, ах дүүсээ ярина. Бадамханд зөөлөн бор нүдтэй, дунд зэргийн нуруутай, урт үстэй, уран гартай бүсгүй байв. Тэрбээр

- Би чинь Засагт хан аймгийн Жалханз хутагын шавь одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сумын Ойгон нуурын харьяат шүү дээ. Тэнд миний аав, ээж, дөрвөн дүү минь байгаа. Би айлын том хүүхэд учраас аав ээждээ тус бол, ажил хий гэж нагац ах маань энд авчраад оёдолчны дамжаанд суралцуулж энэ артельд оруулж өгсөн юм гэхэд Бавуу

- Сайхан юм аа гэхээс өөрийг үл ярина. Тэр нутаг ус, ах дүүсийн тухай юугаа ярихаа мэдэхгүй болохоор ийнхүү дуугаа хураана. Бадамханд ч түүнийг шахаж шаардахгүй. Харин Бавуу аавынхаа Чүнчигноров хөөрөг, нарийн илгэн арьсан дээр арилдаггүй бэхээр зурж бичиж тэмдэглэсэн тэнгэрийн бичээсийн тайлбар толийг дэлгэн үзүүлж

- Энэ хоёр л миний хамаг хөрөнгө, амьдрал ахуй минь билээ. Би энэ хоёртойгоо байгаа цагтаа хамгийн их баян хүнд тооцогдох учиртай юм гэж ярина. Бадамханд тэр толь бичгийг хичнээн харсан ч учрыг нь олохгүй болохоороо

- Энэ чинь ямар хачин бичгээр бичсэн юм бэ? бичиг юм уу? зураг юм уу? гэж асуухад Бавуу инээгээд

- Бичиг, зураг, тоо аль аль нь бий. Би чамд сайн тайлбарлаж бас зааж өгнө. Бадмаа чи сайн сурах хэрэгтэй шүү. Үр хүүхэддээ ч бас зааж өгнө. Энэ хоёрыг ч хүүхэд минь өвлөж авах ёстой болно гэхэд Бадамханд ичингүйрэн тонгойход хоёр хацар нь улаа бутарч нүүр нь халуу дүүгэнэ. Тэр нууцхан харцаар Бавууг харснаа инээмсэглээд

- Яасан ч эрт ихийг бодох юм билээ. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий бэлдэнэ гэдэг л болж байх шив дээ гэхэд Бавуу их л зоримоогоор

- Хүсвэл төрнө, хүлээвэл ирнэ гэж үг байдаг даа гээд Бадамханд руу харахад хоёр залуугийн харц учран уягдаж хайрын зул бадамлав. Тэд бие биеэ хайрлахын эрхээр бүтэн биеэрээ огшин бүлээн шунхаа буцалган орчлон хорвоог огоорч мартан оньс мултарч үүд нээгдээд учир шалтгааны нарийн утганд нэвтэрч бие, хэл, сэтгэл гурваараа уусан шингэв. Энэ нь арга билгийн жам ёс амьдралын хүрдний эргүүлэг байлаа.

Бадамханд Бавуутай ойртож дотносохоор барахгүй амьдрах тухай бясалгана. Гэхдээ Бавуу

нутаг ус, ахан дүүсээ нэг ч удаа дурсаагүй, амьдардаг орон гэрээ ч үзүүлээгүй учир битүүлэг нууц хүн хэвээрээ байгаа билээ. Бадамханд хааяа бүсгүй хүний богино ухаанаар бодож

- Би энэ хүнд арай эрт итгэж энгэр биеэ задгайлж эр заяаг дэндүү ихээр хүсэмжилж хөнгөн хуудуу хандаад байгаа юм болов уу? Энэ хүн нэг хөөрөг учир нь үл мэдэгдэх нарийн илгэн дээр бичсэн зураг шиг юм үзүүлээд

- Надад үүнээс өөр хөрөнгө байхгүй. Энэ хоёртойгоо байхад би баян хүн хэмээсэн нь нэг л сонин санагдана. Түүний эрхэм хоёр юмных нь дэргэд Бадамханд эн зэрэгцэхээргүй жижигхэн мэт төсөөлөгдөх нь гомдмоор. Гэтэл Бавуугийн үг хэл үйл мөр бүхэн нь нягт нямбай, алдаа мадаггүй. Өөрт байгаа юм бүхнээ ариг гамтай цэвэрхэн хэрэглэнэ. Энэ болгон Бадамхандад таалагдана. Заримдаа

- Маргааш нөгөөдөр хоёр тэнгэр муухайрч цасан шуурга болно ч гэх юм уу, эсвэл ирэх долоо хоногоос дулаарч арав гаруй хоногтоо сайхан налайна гэнэ. Түүний хэлсэн бүхэн үнэн байж тэнгэрийн араншинтай яг таарна. Тэр үнэхээр их мэдлэгтэй биширч хүндэлмээр ухаантай хүн. Бас хүн ойлгохын аргагүй юм ярина.

- Манай монгол орон чинь хорин дөрвөн улиралтай юм шүү дээ. Бид хураагаад дөрөв болгочихоод байгаа юм. Уг нь үндсэн үйлдвэрлэл болох мал аж ахуй, газар тариалангийнхаа үйлдвэрлэлийг гурван хэмжээст тохируулан явуулбал илүү үр дүнд хүрч болох юм гэж ярихад нь Бадамханд

- Та хорин дөрвийг хураагаад дөрөв болгочихлоо гээд байх юм. Дөрвөн улирлаа л хэлж байгаа юм биз дээ гэхэд Бавуу

- Тийм ээ. хөврөх, өсөх, хураах, нуух дөрвийг л хэлж байна. Би чамд дэлгэрэнгүй тайлбарлаж өгье

- Нэг улирлыг зургаан улирал болгож байсан юм. За хоёулаа хураах улирлыг задлая гэхэд Бадамханд

- Хурааах чинь аль улирал билээ гэж асуухад Бавуу инээгээд

- Хураах гэдэг чинь намар шүү дээ. За

Нэгд: намрын эх хатгах

Хоёрт: сэрүүнийг дуудах

Гуравт: цагаан шүүдэр

Дөрөвт: намрын тэнцэл

Тавд : хүйтэн шүүдэр

Зургаад: хяруу унах гэж зургаан улирал болгон ажил амьдралдаа хэрэглэж байсан юм гэж

ярина. Энэ бүхэн Бадамхандын гайхширлыг төрүүлж шүтэн бишрэхэд хүргэдэг байв. Тиймийн учир Бавуугийн хэн болох, аль нутаг усных, ямар ах дүүс, аав ээжтэй, хаана амьдардаг, ямар өргөө гэрт суудаг болох нь чухал биш байв. Гагцхүү энэ хүн байгаа байдал төрхөөрөө хийж буй үйл мөрөөрөө, хэлж байгаа үг яриагаараа, мэдэж буй эрдэм ном, оюун ухаанаараа Бадамхандыг татаж итгэхгүй байхын аргагүй байдалд хүргэнэ. Бүсгүй хүний богино ухаан цагаан цайлган сэтгэлээр огтхон ч хандсангүй. Бадамханд бүсгүй сэнтийд тэгш замилсан, бүтэн заяа тэвэрч заларсан дотроо бодолтой, дороо суурьтай нэгэн билээ. Гэтэл гай газар дороос, гахай модон дотроос гэдэг шиг нэгэн өдөр Шагж ахлах дэслэгч Бавуугийн ажил дээр ирж уулзаад цагийн байдлыг ярьж өгөв.

-Ардын хувьсгалын эсэргүү нам төрийн дайсан хар, шар феодал толгой лам нарын үр үндсийг самнан шүүрдэж нэг мөр таслан шийдвэрлэхээр болж байна. Танай өвөг эцэг Аграмба Чоймжуур, Лэнсрэй гавж Хайдавжамц, хүү Бавуу нар эх орноосоо оргон зайлсан эсэргүү нар гэж тэмдэглэгдээд хүү Бавуу нь монголд эргэн ирсэн. Улаанбаатар хотд байгаа гэж тодорхой бичсэн байна. Энэ тухай та бид хоёроос өөр нэг ч хүн мэдэж болохгүй . Маш нууц байхгүй бол хэцүүднэ

-Юуны өмнө та нэрээ сольж Улаанбаатараас явах хэрэгтэй. Аль болох хол явбал сайн байна гэлээ. Бавуу хэсэг бодлогоширон байснаа

- Шагж аа. Цагийн байдал ийм дээрээ хүрсэн бол дүүгийн үгийг дагая. Намайг наашаага ирснийг яаж мэддэг байна гэж гайхан асуухад Шагж их л хянамгайлан

- Мэдэлгүй яахав. Таны байсан газар чинь манай хоёр гурван ч туршуул тагнуулч байгаа шүү дээ. Бас нууц мэдээлэгч нар ч байгаа. Та нэрээ яая гэж бодож байна гэхэд Бавуу инээмсэглэн

- Одоо сольё. Бавуу гэдгийн ёгт нэр нь гадас, царил юм. Гадас гэдэг нэртэй хүн байхгүй. Тийм нэр ч байхгүй. Таван үсгээ холиод Сагад нэр авбал ямар вэ? гэхэд Шагж дотроо

- Бавуу ах ч айхтар хүн юм аа. Нэрнийхээ утгыг заавал хадгалах гээд байна. Энэ хүнийг одоо л аварч үлдэхгүй бол аюултай. Аварч хамгаалж чадвал талийгаач ахын минь хүсэл зориг хангагдаж тэнгэрт байгаа сүнс нь баярлах байх даа. Сүүлчийнх нь итгэл найдвар, захиасыг нь биелүүлж чадвал надад ч сайхан л байна. Бавуу ах бол юуных нь эсэргүү, нам төрийн дайсан байх билээ дээ. Зүгээр л нэгэн эгэл ард шүү дээ. Сүүлчийн самналт, шүүрдэлт гээд байгаа нь манай яаманд ирээд жил ч болоогүй байгаа Оросын сургагч комисарын л бодлого байх. Одоо яах ч аргагүй болохоор нэрээ сольж оргон зайлахаас өөр арга алгадаа гэж бодоод

- За Сагад гэж болох юм. Овгийг тань бас солино шүү дээ. гэхэд Бавуу шуудхан

- Жамц гэвэл зүгээр болов уу гэв. Шагж

- За болж байна. Маргааш өглөө таван чиглэлд шуудан долоон цагт явна. Би таны зам явахыг бэлдэх ёстой. Хаана очих бодолтой байна гэхэд Сагад өмнө нь бодож байсан бололтой

- Говь – Алтай аймгийн Бугат суманд очно гэж ямар ч эргэлзэж тээнэгэлзсэн юмгүйгээр хэлэв. Шагж

- Ах аа. Та орой манай гэрт ирээрэй. Би таны бичиг баримтыг цэгцэлнэ. Та ойр зуур хэрэгтэй гэсэн юм аа л аваарай. Орон байр, ор дэр чинь тэр хэвээрээ үлдэнэ шүү. Таныг хотод л эрэн сурвалжлах болно. Ойр дотнын хэн нэгэнд сэжиг ажиг өгч болохгүй. Элсэнд гээсэн зүү шиг л сураггүй болох хэрэгтэй гэсээр явав. Энэ гэнэтийн байдал Бавууд хүнд хэцүүгээр туссан ч тэр бие сэтгэлээ захирч барьж сурсаны ачаар тайвширч эгэл жирийн байдалдаа орж чадав. Түүнд

- Би амь насаа алдаж болохгүй. Аавынхаа нутагт очиж өвөг эцгийн оюуны бүтээлтэй золгох ёстой. Нутаг ус, ах дүүс, олон түмэндээ тус болж буян үйлдэх ёстой. Би эх орноосоо урваагүй. Нам засаг ард түмэндээ дайсагнаагүй. Эгэл жирийн амьдралаар амьдарч яваа иргэн хүн. Миний өвөг дээдэс эцэг эхэд минь ийм муу үйл мөр хэзээ ч байгаагүй гэж бодохоос нам засагтаа гомдох шиг болно. Энэ төөрөгдөл манан будангаас ангижрах цаг ирэхэд өвөг дээдэс, эцгийгээ гэм зэмгүй эгэл нэгэн эрдэмтэн хүмүүс байсныг олон түмэнд хэлүүлж өөрийнхөө солигдсон овог нэрийг ч сэргээх болно гэж бодож байлаа.

Бавуу тэр өдөр нормын ажлаа хийж дуусгаад шуудхан Бадамханд дээр очив. Бадамханд инээмсэглэсээр

-Ажлын цаг арай л болоогүй байхад яаж яваа юм бэ? Зүгээр биз дээ гэж дотночилон асуухад Бавуу түүнийг дөлгөөн хараад

- Зүгээр ээ, зүгээр. Өнөөдрийнхөө нормын ажлыг хийсэн болохоор ахлагч явж болно гэсэн юм. Тэгээд л хүрээд ирлээ гэв. Бадамханд

- Тэгвэл намайг хүлээгээд байж бай даа. Би одоохон гэсээр явав. Бавуу дотроо

- Бадамханд маань намайг хэл чимээгүй алга болчихоор гайхах байх даа. Амьдрал минь аятайхан болмоор янзтай болж байтал ийм хар гай дайрах гэж. Бид хоёр ч заяаны хань мөн байх аа. Бадамханд маань юу гэлээ. Аа тийм.

- Та бид хоёр нэг л тавилантай нэг л заяатай хүмүүс байх. Надад тэгэж бодогдоод байдаг юм. Ээж минь таны тухай бүдэг бадаг үг надаас сонсчихоод

- Заяаны хань чинь сэтгэлд өөрөө ургаад, тодорч ирээд залардаг юм. Тэр дүр хөрөг хэзээ ч бүдгэрч арилдаггүй тэр хэвээрээ л байдаг. Мартая гэж бодсон ч мартагдах гэж ер үгүй шүү дээ. Бусад нь бол хаврын тэнгэр шиг ааш авир нь зурсхийгээд л өнгөрдөг. Эргэж санах гээд санаанд огт орохгүй шүү гээд л гараа савчин инээж билээ гэсэн шүү дээ.

Би өнөөдрийн тухайд Бадамханддаа учир явдлыг тайлбарлан хэлэх арга даан ч алга даа. Амьд мэнд явбал уулзах ерөөл байх биз. Намайг олдохгүй болохоор Бадамхандаас асууж байцааж мэдэх юм. Энэ маань мэддэгээ хэлэхэд л болно. Хэрвээ холбоо сүлбээтэй нэг гэрт байсан бол энэнд маань гай болох байлаа. Би эв эеийг нь олж байгаад Бадамхандыгаа олж авна гэж бодож суутгал Бадамханд ирээд

- Бавуу, Норжмаа гурвуулаа үзвэр үзье. Өчигдөр манайхан үзсэн байна гэхэд Бавуу Шагжийнд очихоо санаад

- Би амжихгүй бололтой. Та хоёр очоод үзчих. Ирээд надад ярьж өгөөрэй. Би айлд юм хийх захиалга авчихсан учир боломжгүй болчихлоо гэхэд Бадамханд инээгээд
- За Норжмаагийнхаа саналыг авъя. Тэр тантай юм үзэх их дуртай байдаг юм. Бавуу дэндүү ухаантай хүн шүү. Та хоёр ч ёстой заяаны ханиуд шүү. Ухаантай хархүү, уран бүсгүй хоёроос сайхан үр төрнө дөө гээд л бид хоёрыг явуулаад байсан гэснээ царайгаа төв болгоод
- Үгүй байзаарай. Би танд маш нууц бас баяртай мэдээ дуулгая гэж бодсон юм. Гэтэл та чинь завгүй юм шив дээ. Маргааш л дуулгахаас даа гэлээ. Бавуу дотроо
- Маш нууц тэгээд баяртай мэдээ гэхээр юу байх билээ. Аав ээж нь ирж байгаа юм болов уу? Тэгвэл ч сайхан л юм болох нь гэж бодсоноо
- Үгүй би чинь өглөө эрт явна шүү дээ. Маргааш өглөөнөөс эхлээд Сагад болно. Тэр баяртай мэдээг Сагад биш Бавуу сонсох ёстой. Одоо л сонсохгүй бол Бавуу хэзээ ч сонсож чадахгүй байж мэднэ гэж санаад тэр
- Бадамханд аа. Тэр баяртай мэдээгээ одоо л надад дуулгачихаач гэж гуйж хүсэхэд нь Бадамханд бодлогоширонгуйгаар
- Харин ээ. Тэгдэг ч юм билүү гэж эргэлзэн байтал Норжмаа орж ирээд яриаг тасалдуулж орхив. Нэг нь сонсохыг, нөгөө нь дуулгахыг хүсэж байсан ч хяслант хорвоогийн хатуу аашинд хэрчигдэн таслагдаж хэлж сонсох нь хэзээ болохыг тааж мэдэхийн аргагүй болж нууцлагдан үлдэв.

Хоёр залуус салж ядан бие бие рүүгээ татагдан байх нь сайны ерөөл мэт боловч цаана нь хүсэл хяслын хүлээсээр боймлож салж хагацахын муу ёр совин нуугдаж байгааг Бадамханд бүсгүй яахин мэдэх билээ дээ. Тэд өөр өөрийн зам мөрийг хөөн одов. Бавуу шуудхан явсаар Шагжийнд ирэв.

Шагж ганцаараа суудаг учир тэр хоёрт саад болох юм байхгүй байв. Шагж

- Ах аа. Таны биеийн байцаалт болох бичиг баримт энэ байна. Жамцын Сагад. Говь – Алтай аймгийн Бугат сумын харъяат гэсэн байгаа. Энэ таны зам явах. Би таныг бүртгүүлээд замын зардлыг тань өгчихсөн. Ах минь дүү нь аашаа барж арга ядсандаа л ийм юм хийхэд хүрлээ. Юуны учир вэ гэвэл энэ самналт шүүрдэлтэнд өртөж болохгүй. Амьд мэнд байгаа цагт алив нэг юмны учир олдоно. Би энэ муухай арга мэхээр л таныг аварч үлдэхийг хүссэн юм. Үүнээс илүүг хийж чадахгүй байгаадаа ичиж байна гэхэд Бавуу яаран
- Дүү минь. Чи юугаа ярина вэ? Чи л байхгүй бол би гэдэг хүн энэ самналтаас яаж мултарч чадах билээ. Бурханд очсон ахын чинь л буян заяа намайг түшлээ. Сайн хүний ивээлд багтах сайхан юм аа. Амьд мэнд байсан цагт арга нь олдоно. Дүүгийнхээ ач тусыг ах нь байнга санаж сэтгэлдээ залбирч явах болно гэхэд Шагж

- Ах минь. Таны байгаа газар нэр усыг би мэдэх болохоор тань руу эхэлж очно. Та намайг хүлээж байгаарай. Энэ самналт лавтай бүтэн жил үргэлжлэх байх. Үнэнийг хэлэхэд эгэл

жирийн нэг иргэн хүнээ худал хэрэгт гүтгэн унагаж амь насанд нь заналхийлэхийг би буруу гэж үзэж байгаа ч хүч чадал эрх мэдэл минь мөхөсдөж байна. Ямар сайндаа нэг ч гэсэн хүн аврахсан гэсэн дээ л нам засгаа хуурч залилан мэхлэхэд хүрэхэв дээ. Ийм хуурмаг хилс хэлмэгдүүлэлтэнд үнэн болгон ялагдана. Харин мэхийг нь дагуулж мэх хийсэн хүн л хожих байх гээд их л зовж байгаа бололтой уртаар санаа алдав.

Алдаа оноо, үнэн худлын дэнсэн дээр хэзээ нэгэн цагт гарах нь мэдээж билээ. Чухам хэзээ вэ гэдгийг хэлэхэд бэрхтэй. Тэр гол юмаа чухалчлах учир сэтгэлээ ихэд захирамжлан чангална. Гагцхүү Бадамхандын дүр хөрөг, баяртай мэдээ сонсох хүсэл хоёр л тод хэвээр үлдэв. Шөнө дөлөөр Шагжийнхаас гарсан Сагад олон бодол тээсээр удаан алхана. Тэр явдал дундаа тэнгэрийг ажиглана. Тал саран сүүн зам татуулна. Бат од Гар одыг сартай жишүүлэн шинжвэл ойрдоо хур бороогүй тогтуун байхыг илтгэнэ. Тэр амандаа

-За яамай даа. Хол замд явахад бороогүй байвал боллоо. Хүн амьтан танихгүй хүн чинь юугаа хэлж хуйхаа маажиж амьдарна даа. Амьд байгаа цагт амьдрах л болно доо гэж бодоод биеэ хөвчилж сэтгэлээ шулуутгав.

Тэр түргэн түргэн алхсаар хог үнсээр дүүрэх шахсан гүн жалганы эхээр тойрч явтал жалганд хоёр нохой хуцан байснаа харайгаад эргэж харан дахин хуцаад давхиж очин боргох маягтай ямар нэгэн юманд хандаж байгаа нь илэрхий байв. Сагад ажигласаар л байв. Гэтэл хүүхэд уйлах чимээ гарав. Тэр чихээ тавин сайтар чагнавал жалган дотор уйлж байв. Сагад айх шиг болоод том дуугаар

- Хүүеэ гэж ноходод чимээ өгөөд явж очив. Сарны бүдэг гэрэлд юм сайн харагдахгүй байлаа. Тэр бүр ойртоод харвал үс даахь нь сэгсийсэн, гурав дөрвөн насны гэмээр жижигхэн хүүхэд унтаж байгаад сая л сэрсэн бололтой нүдээ нухлан уйлагнаж байв. Сагад бушуухан өргөөд тэврэхэд тэр хүүхэд түүний хүзүүгээр тэврээд хацраа хацарт нь наагаад дахиад л унтаад өгөв. Сагад учраа олохгүй хэсэг зогсов.

Хорвоо түүнийг ямар нэгэн байдлаар сорьж шинжих мэт чимээгүй дүнсийнэ. Хувь заяа хаашаа хөтлөөд байгааг эс мэднэ. Тал саран ододтойгоо талархаж байгаа мэт анивалзан мишээнэ. Харин хоёр нохой нялх хүүхдийг аварч чадлаа гэсэн аятай хуцахаа болиод сүүлээ хөдөлгөн урт улаан хэлээ унжуулан амар тайвныг бүтээнэ. Амьдрал олон ааштай, гашуун амттай ажээ.

Ийм л нэгэн дурсамж Сагадын сэтгэлийн тойромд уяатай ботго шиг эргэлдэн бүүвэйн эгшгээр буйлсаар байдаг юм. Сагад дурсамж бодлоосоо салж чадсан ч Бадамхандынхаа маш нууц баяртай мэдээг хорь гаруй жил хүсэж хүлээж явсан бол өнөөдөр дэндүү ихээр хүсэж байв. Тэр энэ оргилсон хүсэл мөрөөдлөө барьж тогтоож чадамгүй болоход дэмий л мориндоо ташуур өгч дөрөөнд босож салхи татуулан давхив.

Хээрийн зэрлэг салхин дээлийн задгайлсан энгэрээр орж өвөр дүүргэн сэрүү татуулна. Энэ хорвоо дээр хяслын хүлээсийг тайлж тасчин хаядаг их хүчин байдаг гэдэгт Сагад итгэж яваа билээ. Би өвөг дээдсийнхээ амин аргамжийг таслах ёсгүй бөхөлж үргэлжлүүлэх ёстой хүн гэж амандаа шивнэв. Энэ дээд язгуурын удам угсааны эцсийн ганц судас нь би гэж үү? гэж өөрөөсөө асуухад хариуд нь яагаад Бадамханд бүсгүй түүний хэлсэн маш нууц баяртай мэдээг

сонсох хүсэл мөрөөдөл минь ийнхүү тод томруунаар дүрслэгдэн дурсамж түүх дахин сэргэх болов гэж бодогдоно. Сагад өөрөө өөрөөсөө асуусан асуултандаа бүрэн хариулт өгсөн мэт сэтгэлийг нь амар амгалан эзлэв.

Тэр Сангийн далай нуурын баруун хойт хөвөөгөөр явахдаа энэ нуурын торгон мандлыг ажиглан байв. Хөх ногоон өнгөөр намиатан алс хол руугаа харлан уулын дүрс, тэнгэрийн үүлсийг хөвүүлэн наадна. Ус хөдлөх төдийхөн зөөлөн салхинд торгоны хээ шиг долгио нуурын мандалд хөвөрнө. Үе үехэн дээлийн хормой сөхөж хүч тэнхээ орсон мэт ширүүсэн үлээхэд бодол бодлоо гүйцэх гэж нэхэл дагал болох мэт өвгөдийн магнайн үрчлээг зурж нуурын мандал атираатан ар араасаа нэхэн алсарч одно. Энэ хэдийгээр ус боловч ертөнцийн толь, амьдралын түүх шастир, учир утгыг шингээсэн ном байлаа.

Сагад явсаар Бунхан салааны амны бунханы хөлөөр гарахдаа бунхан талын хөлөө дөрөөнөөс мулталж тэр талын гарынхаа алгыг өөд нь харуулан дэлгэрүүлэн сэтгэлдээ маань уншаад өнгөрөв. Тэр бунханд мөргөж тойрч бууж мордож бусдын хараанд өртөхийг огт хүссэнгүй. Монгол ёсоороо морьтой өнгөрөхдөө үзүүлэх үйлдэх ёстой хүндэтгэлээ ийнхүү ёсчлоод өнгөрөв.

Амьдрал гэдэг яг л нуурын мандлын атираа шиг ар араасаа бие биенээ хөөх мэт цуварч урсана. Энэ атираа болгон гүйцэгдэхгүй, гүйцэхийг хүсэх мэт явсаар нэгэн цэг дээр ирээд төгсөж байлаа. Энэ мэт амьдрал үргэлжилсээр эцсийн цэгт төгсдөг гэдгийг сануулах нь эгээл номын бичээс мэт гүн утгыг илэрхийлнэ.

Сагад мэргэнд гэнэтийн болоод санаанд оромгүй нэгэн урилга заллага ирэв. Түүнийг намын дарга Намхай авчирч өгөөд

-За Сагад минь. Явах бэлтгэлээ хий дээ. Монгол улсын шинжлэх ухааны хүрээлэнгээс урьж зална гэдэг сайхан байна. Энэ чинь ховорхон тохиолдол шүү. Ямар нэгэн шалтаг байхгүй яваад ир гэхэд Сагад гайхширан

- Дарга аа. Би гэдэг хүн чинь малаа яах билээ. Ядахдаа охин эчнээ сургуульдаа явчихсан байдаг. Энэ хэдэн эврээ даахгүй шахам амьтад л хэцүүдэх нь байна гэхэд Намхай дарга инээд алдаад

- Сагад минь. Санаа зоволтгүй. Бид ярилцаж байгаад хоёр хүн томилчихсон байгаа. Бүр явчих гэж байгаа биш юундаа санаа зовно вэ? Нөгөөдөр ирж аваад аймаг явна. Таны онгоцны билет, хотод очоод байрлах буудал бүгд бэлэн байгаа. Сум орноо, хамт олноо сайн танилцуулаад ажлынхаа арга барилыг сайн ярь. Өөр юу байх билээ гэсээр давхин одов. Хурдан тэрэгний тоос зам даган манарч хоцров.

Гучин тав

Сагад хорь гаруй жилийн тэртээ амьдралын их сорилгонд орж Хайдавжамцын Бавуу хэмээх нэрээ ногоон нуурын шавар тагз, ор дэр аяга шанагатайгаа орхин Жамцын Сагад гэдэг нэртэй болоод морин тэрэгчинд алгадуулах шахам аашлуулж загнуулан байж хэний үр сад болохыг нь ч мэдэхгүй гурван настай балчир хүүхдийг орхихын аргагүй орчлонгийн хатуу ширүүн авирт захирагдан холын хол Алтай нутаг руугаа Газ -51 машины тэвшин дээр тэврэн суугаад хотоос явж байсан бол өнөөдөр тэнгэрийн мөнгөн хүлэг хөлөглөөд эргэн ирж нэр сүртэй нийслэлийн маань нэрээр нэрлэгдсэн Улаанбаатар зочид буудалд буугаад тухлан байгаа нь сайхан.

Сагад ирээд гурав хонож байлаа. Тэр үнэтэй цэнэтэй зочид буудалд дээд зэрэглэлийн хоол ундаа хэрэглэн нийслэлийнхээ хөгжил дэвшилтэй танилцан ихийг мэдэж нүдээ цэнгүүлж, сэтгэлээ баясгаж байв. Гэхдээ түүний санаа зовно. Намайг ингэж ихээр хүндлэхийн хэрэг юу билээ. Илүү зан гэж дотроо бодно. Тэр ирээд гурав хонож байгаа ч охинтойгоо бас Шагж сайдтай ч холбоо барьж уулзаж чадаагүй байгаа билээ. Юуны өмнө охин Хөхцэцэгтэйгээ уулзмаар санагдана. Гэтэл ганцаараа явж чадамгүй бололтой.

Улаанбаатар хотын энэ олон барилга байгууламж хаана юу нь байгааг олж мэдэхэд түвэгтэй болжээ. Тэр хөдөө хээр байгалийн үзэсгэлэнт нутагт дураараа явж сэтгэлийн амгаланг бүтээж чаддаг байсан бол энд хичнээн сайхан байлаа ч гурав хоноод л нутгаа санаж бушуухан буцах минь гэж бодогдоно. Өдөр болгон хамт байж бүхнийг танилцуулж байгаа ажилтанд бодол саналаа хэлэхэд тэрбээр их уриалгахан хүлээн авч хэсэг хугацааны дараа түүнд

-Сагад гуай. Шагж сайд гадаадад томилолттой яваа юм байна. Хөхцэцэг бүсгүйтэй орой зав гарахаар нь уулзахаар тохирлоо. Таныг ирсэн гэж дуулаад танай охин их гайхаж

- Манай аав хотод ирээд Улаанбаатар зочид буудалд гурав хонож байгаа гэв үү? Та хүн андуурсан байх. Тийм учир байхгүй. Тэгээд ч надтай уулзахгүй гурав хононо гэж хэзээ ч үгүй гээд инээгээд байна лээ. Би түүнд

- Танай аав тань Говь-Алтай аймгийн Бугат суманд мал малладаг Жамцын Сагад гуай мөн биз дээ? гэхэд тэр

- Мөн байлгүй яахав. Аав минь ирсэн гэхээр сонин санагдаад байна. Үнэмшихэд бэрхтэй юм. Хичээл дуусахаар уулзъя гэсэн. Та бид хоёр өнөөдрөөс эхлээд ажилдаа орно. Гэхдээ хүрээлэнгийн захирлын баталсан хөтөлбөрийг л дагах болно. Одоо хэвлэл мэдээллийн төлөөлөгчтэй уулзаж хэвлэлийн бага хуралд оролцоно гэлээ. Сагад зөвөлгөө авах санаатай

- Тэнд би юу ярих учиртай вэ? гэж лавлахад нөгөө ажилтан инээмсэглээд

- Та өөрийнхөө тухай товч дурьдана биз. Тэд чинь аяндаа таны хэл амыг сугалах шахам элдвийг асууна. Тэр болгонд та хариулаад байхад л болно гэлээ.

Хэвлэл мэдээллийн сэтгүүлч, сурвалжлагч нар Сагадын ярихыг ихэд анхааралтай сонсож

байлаа. Тэд зураг авч үг яриаг нь бичиж тэмдэглэнэ. Эхний хүн

-Та тэнгэрийн бичээс гэж ярилаа. Би урьд өмнө ийм нэр томъёо сонсож байсангүй. Та дэлгэрэнгүй тайлбарлаж болох уу? гэхэд Сагад

- Бололгүй яахав. Манай монгол түмэн чинь аль эрт дээр үеэсээ эхлэн нар, сар, одод, эрхэсийн хөдөлгөөн түүний байршил, харилцан шүтэлцээ, холбооноос хамааран манай дэлхийд хэрхэн ямар нөлөөтэй болохыг нь олон жилээр ажиглан мэдэж байсан аугаа их ухаан байсан. Энэ ухаанд суралцаж тэнгэрийг шинжихийг бичээс гэж байгаа юм гэхэд өөр нэг нь

- Та мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн явуулах үндсэн хөтөлбөр төлөвлөгөөгөө цаасан дээр үйлддэг биз дээ гэхэд Сагад

- Мал аж ахуйн үйлдвэрлэл чинь байшин доторхи машин тоног төхөөрөмжтэй үйлдвэрээс огт өөр нөхөн үйлдвэрлэл явуулдаг амьд үйлдвэр шүү дээ. Энэ үйлдвэрлэлийг хөтлөхөд тэнгэрийн бичээс л гол үүрэгтэй гэхэд бас нэг нь

- Таны ярианд өндөр хөгжсөн нарийн технолгитой том суурин үйлдвэрлэлийг үгүйсгэх хандлага цухалзаад байх юм. Яагаад тэр вэ? гэлээ. Сагад инээгээд

- Би үгүйсгэж байгаа юм биш ээ. Монгол хүний хөх ухаан нүүдэлчдийн соёл иргэншлийн гайхамшигийг л хэлээд байгаа хэрэг. Өөр бусдаар өөлөх хэрэггүй гэв. Нөгөө нэг нь

- Монголын хөх ухаан гэж хэлээд байгаа ухаанаа жаахан тодруулаач гэв. Сагад

- Монголчууд бид чинь тэнгэр газартайгаа нарийн шижмээр холбогдон хүч тамирыг нь ашиглан зураг бичээсийг нь уншин амьдрал ахуйдаа хэрэглэж чадаж байгаа ухааныг л “Монголын хөх ухаан” гээд байгаа юм. Хөх гэдэг нь тэнгэрийн өнгө билэгдлийн нэр юм гэж товчхон хэлэхэд өөр нэг нь

- Өнөөдөр шинжлэх ухаан өндөр хөгжөөд дээд тооны хүрдэнд тэнгэр газрыг судлан шинжилсээр байна. Та тэнгэрийн зураг бичээс гэж ярьж байна. Тоо үгүйгээр тооцоолох гэж байх уу? гэж асуухад Сагад

- Таны хэлдэг түмэн зөв. Тэнгэрийн бичээсийг уншсаны дараа хариу тайлбарыг нь тоогоор бодож гаргадаг юм. Одоо шинжлэх ухаанд чухам хэдэн оронтой тоо хэрглэдэгийг би мэдэхгүй. Харин тэнгэрийн бичээсийн хариуг гаргахад жаран дөрвөн оронтой тоогоор бодож гаргадаг гэхэд өөр нэг нь их л сонирхож байгаа бололтой

- Та хэдэн оронтой тоонд бодлого боддог вэ? гэж сөргөх маягтайгаар асуухад Сагад тайвнаар

- Би сэтгэшгүй тоон дотор бодлого боддог. Энэ нь жаран долоон оронтой тоо л доо гэв. Үүнийг сонссон зарим сэтгүүлч гайхаж байхад нөгөө нь

- Энэ нөхөр худлаа залчихлаа гэж бодно. Сэтгэшгүй тоог сонссон цөөн нь Сагадаар бахархаж байв. Сагад үргэлжлүүлэн

- Энэ бүхэн чинь л нүүдэлчдийн соёл иргэншлийн гайхамшиг дээд түвшин шүү дээ гэлээ. Өөр нэг нь босоод

- Танаас маш сонирхолтой юм сонсож байгаадаа баярлаж байна. Та ийм соёл иргэншил, хөх ухаан эгэл жирийн ард түмний амьдрал ахуйд тусгалаа олсон зарим жишээнээс яриач гэж хүсэхэд Сагад

- Би ганц хоёр жишээ хэлье. Бид чинь унаж яваа морио алдахгүйн тулд чөдөрлөдөгийг та бүхэн мэднэ. Чөдрийн урд хоёр хөлийг хаа гэж нэрлэдэг. Энэ хоёр хааны зөв тал буюу зүүн хаа гурван хуруу богинохон байдаг. Хэрвээ ижил тэнцүү байвал морь шулуухан явж холдоно. Зөв тал нь богинохон учир зөв тал руугаа даярч тойроод идээшлэх нь гэрээсээ холдохгүй гэсэн санаа юм л даа. Мөн үхэр тэрэгний дугуйг ойцон цойцон хийсэн байна гэж шүүмжилж ярих нь бий. Гэтэл маш сайн тооцоолсны дагуу тэгэж хийдэг. Ямар учир начиртай тооцоо вэ? гэвэл хөллөөд чирч яваа үхрээ ядраадаггүй, тэр цойцон дугуй хүчний хувиарлалтыг тэнцүүлж өгдөг. Өөр нэг сайн тал нь юу вэ гэвэл газрын уруу түрж хөөдөггүй юм. Хэрвээ өөгүй бөөрөнхий дугуй улам хүч аван бөмбөрдөг бол тэр цойцон дугуй тэгшивтэр тал дээрээ түрэх хөдөлгөөнийг саармагжуулж байдаг юм гэлээ. Сэтгүүлчид өөр хоорондоо ярилцаж байснаа нэг нь

- Та тэнгэрийн бичээсийг уншина гэсэн. Тэнд гарагуудын нэр бичигдсэн байх уу? гэж асуухад бусад нь нирхийтэл инээлдэв. Сагад

- Бичигдэлгүй яахав. Би заримаас нь сонирхуулья. Баасан гарагийг Сугар гэдэг боловч тэнд Зохист аялгуу гэж нэрийн зүйлд дурдана. Нууц нэр нь Цагаан Бямба гэхэд Санчир гэж тэмдэглээд Нарны хөвгүүн гэнэ. Нууц нэр нь Хөх дээлт. Пүрэв гараг Бархасбадь гээд Аялгуу гэж тэмдэглээд Мэргэн өгүүлэгч гэж нууцалдаг. Мягмар гарагийг Өлзийт хэмээгээд Улаан биет гэж нууцлах жишээтэй юм гэхэд өөр нэг нь

- Та Лхагва гарагийг орхичихлоо шүү дээ гэвэл Сагад

- Өө тийм үү. Лхагва гараг нь Буд шүү дээ. тэмдэглэхдээ Сарнаас төрсөн гээд Тодорхой төгөлдөр гэж нууцалдаг юм. Бас нэг нь

- Та тэнгэрт байгаа байдлаар нь нэг үгээр нүдэнд үзэгдэх хаана байхыг нь хэлж зааж өгч болох уу? гэхэд Сагад огт түвэгшээсэнгүй

- Бололгүй яахав. Та бүгдийн сайн мэдэх үдшийн бүрий хийгээд үүрийн гэгээнээр тодорч харагддаг одыг Зохист аялгуу хэмээдэг. Нэр нь Сугар гараг шүү дээ. Энэ одны төрсөн гэр нь Бурналасан. Одны тэг мөч болоод аргын хоногийн хот мандал нь хоёр зуун хорин дөрөв буюу арван долоо хоног байдаг гэхэд нэг нь

- Намайг Бямбаа гэдэг. Та бямба гарагийн тухай яривал сайн байна гэлээ. Сагад

- Энэ Санчир гараг нарны хөвгүүн тэнгэрийн чанх баруунаа байрладаг улаан шаргал өнгөтэй алгуур явдалтай од юм. Сайн тогтоон харахгүй бол үзэгдэхгүй байж мэдэхээр их бүдэг харагддаг юм. Аргын хоногийн хот мандал нь арван мянга долоон зуун жаран зургаан хоног

байдаг гэхэд зохион байгуулагч босоод

- Уучлаарай. Та бидэнд хоёр цагийн боломж байсан бол дөрвөн цаг болтлоо сунжирчихлаа. Одоо хурлаа өндөрлөө. Сагад манай хүрээлэн дээр сарын хугацаатай хичээл заах юм. Энэ хугацаанд та бүхэн сонирхсон зүйлээ асууж тодруулж авч болно шүү дээ. Та бүхэнд баярлалаа гэснээр өөр өөрийнхөө ажил мөрд одоцгоов.

Хөхцэцэг аавыгаа ирсэнд их баярлаж бас гайхаж байлаа. Хөхцэцэг инээгээд

-Аав аа. Та хэдэн малаа яасан бэ? Дэргэдээс нь салж чадахгүй байнга дагадаг хүн чинь яаж нэг юм салав гэхэд Сагад

- Дарга нар давхиж ирээд ийм том газрын урилга заллага авчихаад явахгүй бол болохгүй. Дээд газраас үүрэг даалгавар авсан. Малыг чинь хариулгахаар хоёр хүн томилсон. Нутаг орон сум нэгдэл, олон түмнийхээ нэр хүндийг бодож хичээж яваарай гэж захиад онгоцонд суулгачихав шүү гээд охиноо харснаа инээд алдаад

- Бид хоёр анхан хотоос баруун тийшээ нутаг руугаа зүглэхдээ мөн ч лут хүмүүс явж билээ. Одоо ч хоёрхон цаг нисээд буучих юм аа. Цаг мөн ч сайхан болж. Энэ Улаанбаатар хот ч их хөгжсөн байна шүү гээд сэтгэл догдлон ярихад Хөхцэцэг бодлогоширон суув. Тэр дотроо

- Нөгөө эмч Жаргал эгчийн тухай аавд хэлэх үү, яах вэ? хэмээн эргэлзэн байв. Аавынхаа хөөрч баярласан сайхан сэтгэлийг нь хямраагаад хаячих юм болов уу? гэж бодолхийлэн байснаа хэлэхээр шийдэв. Аваасаа алив нэгийг нуугаад байвал аав минь надад гомдох биз гэж бодов. Тэрвээр

- Аав аа. Одоогоос арваад хоногийн өмнө манай сургуулийн оюутнуудын сагсан бөмбөгийн тэмцээн боллоо. Гэтэл эвгүй хөдөлсөн юм байлгүй миний нуруунд юм орчихоод хөдөлж чадахгүй болчихлоо гэхэд Сагад

- Ээ золиг оо. Нуруу зоогоо авчихаж л дээ. Сайн гамтай байхгүй бол дахидаг золиг доо гэж уулга алдав. Хөхцэцэг инээгээд

- Манай ангийнхан намайг сургуулийн эмчид үзүүлэв. Эмч намайг үзлэгийн орон дээрээ доош харуулан хэвтүүлээд цамцыг минь сөхөж нурууг минь ил гаргаад харснаа

- Ээж ээ гэж чанга дуугаар уулга алдаад таг чимээгүй болчихлоо. Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр эмч миний нурууг илээд л нусаа татаад уйлаад байх шиг сонсогдов. Би хөдөлж чадахгүй учир чимээгүйхэн л хэвтэж байв. Эмч маань хэдэн хором болоод босож гар нүүрээ угаагаад нэгэн тарилга найруулж миний нурууны яг л өвдөж байгаа газарт тарив. Таван минут болоод нурууны өвчин ч намдаад гайгүй болов. Эмч намайг түшиж босгоод урдаа суулгаад

- Овог нэр чинь хэн бэ? гэж асуугаад бүртгэлийн дэвтэртээ бичиж байв.

- Сагадын Хөхцэцэг гэхэд эмч амандаа

- Ямар сонин нэртэй хүмүүс вэ? гээд л намайг ширтээд байлаа. Би санаа зовоод харцаа буруулахад эмч
- Санаа битгий зов. Миний нүд рүү хар гэлээ. Бид хоёр хэсэг ширтэлцлээ. Эмч маань амандаа
- Мөн сонин юм аа. Яг л мөн байна гэж шивнээд
- Хаана төрсөн бэ? гэхэд нь би
- Говь – Алтай аймгийн Бугат сумын төвд төрсөн гэхэд эмч
- Төрсөн он, сар өдрөө хэл дээ гэхэд би он сар өдрөө бичүүлэв. Эмч
- Эхийн чинь нэр гэж асуув. Би дуугарсангүй. Эмч дахиад л
- Эхийн нэр хэн бэ? гэв. Би бас л дуугарсангүй. Гэтэл эмч
- Зүгээр ээ. хариулахгүй байж болно. Аав тань юу хийдэг вэ? гэж асуухад нь би
- Нэгдлийн хуц,ухна малладаг малчин гэхэд эмч намайг дахин ажиглан хараад
- Өмнө нь зоо нуруугаар нь өвдөж байсан уу? гэхэд
- Үгүй гэв. Эмч сайхан инээмсэглээд
- Одоо боллоо. Гамтай байгаарай. Маргааш хичээлээ дуусахаар над дээр хүрээд ирээрэй гээд тавагтай чихэр барин
- Чихэр ид гэхэд нь би таваг дээрээс чихэр авахад гарыг минь бариад авлаа. Би гайхасхийн харвал тавагтай чихрээ тавиад миний хоёр алгыг харж бас эргүүлэн хараад над руу харж инээмсэглээд
- Маргааш хүрээд ир гэхээс өөрийг хэлсэнгүй. Би маргааш нь эмчийн өрөөнд ороход тэр намайг хүлээсэн шинжтэй сууж байв. Эмч
- Охин минь хүрээд ирэв үү? Нуруу зүгээр биз дээ? гэхэд би
- Таньд баярласан шүү. Одоо зүгээр ээ гэсэн. Эмч намайг дагуулаад гэртээ авчирч хоол цайгаар дайлав. Тэр надаас
- Хотод чамд таних айл бий юу? гэж асуухад би
- Аавын дүүгийнх байдаг. Ах маань сайд хийдэг юм. Би ангийнхантайгаа хичээл давгахад дөхөмтэй гээд байранд байдаг гэхэд эмч
- Танай ах юуны сайд юм бэ? гэж асуухад нь

- Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайд Шагж гэхэд эмч нүдээ томруулан намайг харснаа
- Шагж ахад ах байхгүй шүү дээ. Ганц ахтай байгаад аль эрт насан өөд болсон доо. Мөн сонин юм аа гэж гайхаж байснаа
- Шагж ахын ээж миний ээж хоёр чинь төрсөн эгч дүү хоёр байхгүй юу. Тэд чинь дөрвүүлээ байсан юм. Шагж ахын ээж аав хоёр бурхан болоод хоёр ах нь хоёр хүүг нь нэг нэгээр нь авч өсгөсөн юм гэлээ. Би бүр гайхаж орхив. Эмч босоод зургийн цомгоо авчраад надад дэлгэн үзүүлэв. Жаргал эмч нэгэн жижигхэн охины зураг гаргаж ирээд
- Энэ миний том охины зураг. Удсан болохоор их бүдгэрсэн байна. Гурван настайдаа алга болчихсон юм. Эрэл сурал болсоор байгаад нэгэн морин тэрэгчинтэй уулзаж бүдэг бадаг сураг гаргаад дахин сураггүй болсон. Одоо байгаа бол чамтай чацуу охин байх ёстой юм гээд уйлахад нь би санаа зовоод
- Өө тийм үү. Хөөрхөн охин байна гэлээ. Эмч нүдээ арчаад бага зэрэг тайвшраад Шагж ахын зургийг гаргаад ирлээ. Би ахыг таниад
- Энэ манай Шагж ах байна шүү дээ гэхэд эмч бас л гайхсан байдалтайгаар
- Танай аав чинь яг аль нутгийн хүн бэ? гэхэд би
- Манай аав Говь –Алтай аймгийн Бугатын хүн. Аавын аав Сүжийн ус гэдэг газар төрсөн. Түүний аав Улиастайн бага голд Арьяаболын сүмийн дэргэд төрсөн. Бүүр өвөг аав Цагаан бургасны голд төрсөн гэхээр дөрвөн аав дөрвүүлээ сумандаа төрсөн юм гэхэд эмч
- Тийм байна. Шагж ах хэзээ очиж аавтай чинь золгосон юм бэ? гэж асуув. Би
- Уржнан жил. Аав бид хоёрыг бүр газрын мухарт байхад дөрвөн хөнгөн тэрэг олон дарга нар дагачихсан ирсэн. Аав ах хоёр Жингэнээн ууланд гарч шөнөжингөө ярьж суугаад унтаагүй юм даг. Чухам юу ярьсныг би мэдэхгүй гэлээ. Жаргал эмч бодлогоширон
- Тийм үү. Манай ах ч хуулийн хүн болохоор барагтай бол дуугардаггүй хүн л дээ. Их сонин учралууд ургаад байх юм. Аавтай чинь нэг уулзах юмсан. Аав тань нутгаасаа ер явахгүй хүн үү? Энэ хаягаар захидал бичвэл хүрнэ биз дээ гэхэд би
- Хүрнэ ээ. хүрнэ. Манай сумд аав л ганцаараа ийм нэртэй юм гэсэн гээд Хөхцэцэг аав руугаа харахад Сагад хөмсгөө овоолоод алив нэгийг бясалган нам гүмхэн болчихсон байлаа. Хөхцэцэг дотроо
- Аав минь ямар юмаа бодоод суугаа юм бол доо. Жаргал эмч намайг үзээд миний нуруун дээрхи хөх цэцгэн мэнгийг хараад ээжээ гэж чанга дуугаар уулга алдсан, бас уйлсан. Олон зүйл лавлаж асуусан. Шагж ах Жаргал эмчийн бүл ах байхад аавын дүү гээд байгаа мөртлөө Жаргал эмч аав хоёр бие биенээ огт танихгүй байдаг нь мөн сонин юм аа гэж бодоод цагаа харж
- Аав аа гэхэд Сагад алгуурхан толгойгоо өргөөд

- Миний охин юу гэв гэж асуухад Хөхцэцэг

- Би одоо байр луугаа явлаа. Манай жижүүр цаг их барина. Цаг хоцорвол үүд түгжээтэй орох боломжгүй болчихдог юм гэхэд Сагадтай сайн танил болсон зохион байгуулагч залуу орж ирээд

- Сагад гуай. Таныг охинтойгоо хамт байхыг манай удирдлагууд зөвшөөрсөн. Манайх энэ өрөөг авсан болохоор сул орон дээр охин чинь орж болох юм байна. Энэ түр үнэмлэх гээд Хөхцэцэгт үнэмлэх өгөхөд түүн дээр

- Сагад овогтой Хөхцэцэг. 301 номерийн өрөө гэсэн байлаа. Хөхцэцэг аавынхаа хүзүүгээр тэвэрч аваад

- Аав аа. Их баярлалаа. Би маргааш ном дэвтэр хувцас хунараа аваад ирье гэхэд зохион байгуулагч

- Одоо надтай хамт яваад аваад ирж болно. Унаа бэлэн байгаа гэв. Бүх зүйл хэсэгхэн хугацаанд бүтэж Сагад Хөхцэцэг хоёр төвхнөөд авав. Аав охин хоёр нутагтаа бол Алаг хайрхан уулынхаа өндөр хяр Өлзийтийн дэвсэгт эсгий гэрээ эзлээд аргалын утаа үнэртэж эцэг малаа малладаг хүмүүс чинь өнөөдөр улсынхаа нийслэл Улаанбаатар хотынхоо төв дунд Улаанбаатар зочид буудлын өндөр зэрэглэлийн уужим тавиу тансаг өрөөнд тухалж байгаа нь зүүд үү гэмээр үнэмшихэд бэрхтэй санагдана. Сагад орондоо ороод унтах гэсэн боловч бодол хургаж нойр хулжив.

- Охины яриад байгаа тэр Жаргал гэдэг эмч охины минь ээж мөн байх нь. Ёстой л ерөөл тавилангаар уулзсан байж таарлаа. Хорвоогийн амьдрал гэдэг ийм л нарийн нандин үйл мөрөөр холбогдож байдаг юм даа. Гэтэл тэр эмч нь манай Шагжийн бүл дүү байдаг нь бүр сайн хэрэг. Сайд чинь миний охины нагац ах нь болох нь дээ. Юмны учир жанцан ч нарийн юм. Бид ч дэндүү цөөхөн юм. Нутаг орон ч дэндүү уужим юм. Уржнан Шагж надаас

- Та чинь охинтой байсан юм уу? гээд асуухад нь би тэр үедээ тайлбарлаж нэг ч үг дурсаагүй шүү дээ. Арай цаг нь болоогүй гэж бодож байсан юм. Эх охин хоёр бие биенээ олно гэдэг илүү их баяр баясгаланг авчирна. Эхийн шаналж зовсон сэтгэл ч амархан гийж мэдэх юм. Тэр тэрэгчин өвгөнтэй уулзсан нь сайн болж. Намайг охиныг худгийн дэргэд орхих гэснийг минь мэдсэн нь бүр сайн хэрэг. Ямарч хулгайн хэрэг биш гэдгийг мэдсэн байх. Энэ хэргийн уяа зангилаа тайлагдах дөхөж л байгаа юм байна гэж бодсоор үүрийн гэгээтэй золгов. Сагад босоод тайван амгалан нойрсож байгаа охиноо хараад

- Эвий дээ миний муу охины унтаж байгааг. Намайг бурханд яваад өгөхийн цагт гав ганцаараа үлдээд хэцүүднэ гэж үргэлж сэтгэл минь шаналж байсан юм. Одоо төрсөн ээж ах дүү нартайгаа уулзаад ганцаараа биш гэдгээ мэдэж олуулаа болчихвол аавын чинь сэтгэл зовлон шаналлаасаа салж амрах нь байна. Миний охин одоо жаргах болно оо гэж бодлоо.

Аав охин хоёр ажил төрөл, хичээл номондоо шамдан өглөө гараад л орой уулзана. Сагад Шинжлэх ухааны хүрээлэнд ирээд арваад хонолоо. Богд ууланд байрлах одон орон судлалын төвөөр орж эрдэмтэн мэргэдтэй нь ярилцаж санал бодлоо хуваалцав.

Тэнгэрийн бичээст дурьдагддаг од, эрхэс гарагийг нээн илрүүлж нар сарны байрлалаар уялдаа холбоог нь нарийвчлан тогтоож гаргасан нь бахархмаар санагдаж байв. Гагцхүү тайлах оньс түлхүүр нь бүрэн гүйцэт биш байлаа. Сагад өвөг эцэг Чоймжуурын оюуны бүтээл болох “Тэнгэрийн бичээсийг тайлах оньс ба тодорхой гэрэлт толь” хэмээх нарийн илгэн дээр арилдаггүй бэхээр бичиж зурж томъёосон мөнөөх нууц номыг дэлгэхэд хүрэв. Эрдэмтэн мэргэд ч энэ бяцхан ном хэмээсэн маш нууцлагдсан толийг үзээд үнэндээ учрыг нь үл мэдэх тул шинжлэх ухааны мэдээлэлтэй жишүүлэн харьцуулан үзэж тодорхой дүгнэлт гаргахаар шийдвэрлэв.

Тэд арав хоногийн турш тэнгэрийн бичээсийг тус тусдаа уншиж тайлбарлан тайлж бодит болж байгаа байгаль цаг уурын үзэгдлийг маш нарийн тэмдэглэн хооронд нь тулган дүгнэлт гаргаж байв. Арав хоногийн дараа нэгэн шийдвэрт хүрч чадав. Сагадад байгаа тэнгэрийн бичээсийн тайлбар тодорхой гэрэлт толийн үндсэн эхийг архивт оюуны маш үнэт бүтээлээр бүртгэн авч улсын өмч болгон хадгалахаар, хоёрхон хувь хуулбарлан нэгийг нь Сагад эзэмших нөгөөг нь Улсын музейн үнэт үзмэрт тавихаар болов.

Мөн тэнгэрийн бичээсийн тайлбар тодорхой гэрэлт толийг задлан дэлгэрүүлж ном болгон эрдэм шинжилгээний ажилд зориулан хэвлүүлж улс орон даяар мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд үндсэн хөтөлбөр болгон хэрэгжүүлж ашиглахаар тогтов. Сагад тайлбар толио таниулан ярьж эрдэмтэн сонсож тооцоолж үзэхэд гурван боть ном болохоор тооцоо гарлаа. Нэг боть нь таван зуугаас зургаан зуун хуудастай байхаар бодов. Энэ бол шинжлэх ухааны эрдмийн зэрэг авах дайны том бүтээл байна гэж үзэв. Энэ их бүтээлийн эзнийг Сагад гэж үзэх нь зөв гэхэд Сагад эрс татгалзан

-Наад оюуны бүтээл чинь миний өвөг эцэг Чоймжуурын олон жилийн хөдөлмөрийн үр шимээр бүтээгдсэн юм. Тэр жижигхэн илгэн номын доод буланд “Халхын Чоймжуур Аграмба” гэж бичсэн байгаа. Хүний бүтээлийг би өмчилж яахин болох вэ? Харин задалж дэлгэрүүлж ном болгоход миний охин Хөхцэцэг л надад тус болж чадна. Бусад хүмүүс бид хоёрын задалж бэлэн болгосон материалыг ном болгон хэвлэхэд тус дэмжлэг үзүүлэхэд болно гэлээ.

Сагадын тавьсан саналыг бүгд хүлээн авлаа. Сагадын охин Хөхцэцэг Монгол улсын их сургуулийг түүх газар зүйн мэргэжлээр төгсөж байгаа болохоор түүнийг шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний туслах ажилтнаар авч гурван жилийн хугацаатай Сагадтай хамтран Мөнх тэнгэрийн таалал оршвой. Түүний тодорхой гэрэлт толь болох “Чоймжуур” / номын хураангуй/ нэг, хоёр, гурав хэмээх гурван боть номыг үндсэн эхээс нь задлан дэлгэрүүлж хэвлэлд бэлтгэн өгөх үүрэг даалгавар авахаар боллоо. Сагад үүнийгээ эрдэмтдэд тайлбарлахдаа

- Би тэнгэрийн бичээсийн тайлбар толийг задалж дэлгэрүүлж бичихдээ тэнгэрийн зургаа уншаар, газрын хувиараа ашигласаар, малаа малласаар цэнгэг ус цэвэр агаарыг нь хүртсээр улам баяжуулан охинтойгоо зөвлөлдөн ойлгомжтой алдаа мадаггүй хийе гэж бодсон юм. Бодит байдалд тулгуурладаг нь шинжлэх ухааны зарчим мөн. Харин хүний оюун ухаан нь аливаа юмс үзэгдлийн дотоод билэг чанарыг нээхийг зорьдгоороо арай өөр юм. Энэ хоёрыг харьцуулан нэгэн бүтээлийн хоёр тал болгон цогцоор авч үзвэл гайхамшигийн дээд болно. Би хичээх болно. Нэгэн хүн

- Миний хавханд хоёр тарвага орчихсон гэж баярлан ярьснаа хоосон зогсож байв гэнэ.
- Таны хавханд орсон хоёр тарвага чинь хаана байна гэж асуухад баярлаж байсан хүн чинь ихэд уурлаж
- Юуны чинь хаана байна гэж. Нүхэндээ л байхгүй юу гэхэд нөгөө сонсож байсан хүн уурлан
- Чи худлаа ярилаа. Хүнийг ингэж хуурч яаж болно хэмээхэд манай эр
- Худлаа яриад байхдаа яадаг юм. Би бодож байгаа юмаа үнэнээр нь л ярилаа гэсэн юм гэнэ лээ гэж нэг яриа байдаг. Би нутагтаа очоод
- Охиноо Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний туслах ажилтнаар оруулаад, өвөг эцгийхээ нэрээр нэрлэсэн гурван боть ном гаргахаар боллоо гэвэл үнэмших хүн олдох болов уу? гэж хошигнон хэлэв. Түүний энэ хошигнолыг эрдэмтэд сонсоод
- Энэ Сагад гүйцэгдэхгүй ухаантай хүн юм. Эхлээд хий хоосон амлаж болохгүйг сануулаад дараа нь заавал бодит үнэн болж биелэх ёстойг хэллээ шүү дээ гэж байв.

Сагадын хотод байх ажил дуусан болохоор нутаг руугаа буцахаар яарна. Охин Хөхцэцэг нь сургуулиа дүүргээд албан ёсоор ажилдаа орж тушаалаа гаргуулаад гурван боть номын эх бэлтгэх үүрэг даалгавраа аван томилолтоо өвөртлөөд очихоор болж үлдэв. Сагад Говь – Алтай явах нисэх онгоцондоо орж суудалдаа тухлав. Энэ үед Шагж сайд олон улсын нислэгээр Буянт – Ухаагийн олон улсын нисэх буудалд газардан гэр лүүгээ явж байлаа. Сайд туслахаасаа

-Ойр зууртаа тайван байна уу? гэхэд туслах

- Тайван байсан сайд аа. Өчигдөр таны ах гэж нэг хүн таныг сураглаад явсан. Харахад хөдөөний хүн бололтой байсан даа. Нэр нь хэн билээ дээ. Нэг л сонин нэр байсан гээд бодолхийлэхэд нь Шагж

- Сагад гэж байна уу? гэхэд туслах

- Тийм ээ. Сагад гэж байсан гэхэд Шагж амандаа

- Ах хүрээд ирсэн байх нь. Намайг байхгүй байхад ирдэг нь юу ч билээ дээ. Өнөө орой л сургийг нь гаргая. Хөхцэцэг охинтой уулзахад л олоод авчихна шүү дээ гэж шивнэж явлаа. Сайд Хөхцэцэгийн байр, сургуулийнх нь хаягийг туслахдаа өгөөд

- Энэ охинтой уулзаад зав чөлөөтэй байвал манайд аваад ир. Завгүй байвал аав нь хаана байгааг сайн лавлаж мэдээд ир гэлээ. Хөхцэцэг аавыгаа онгоцонд суулгаж үдэж өгөөд сургууль дээрээ очоод байрандаа эргэж иртэл өөрийг нь сураглаад залуухан цагдаагийн дэслэгч зогсож байв. Дэслэгч ёслон мэндлээд

- Таныг завтай бол Шагж сайд гэртээ урьж байна гэхэд Хөхцэцэг амаа барин

- Ах, аав хоёр ингэж зөрөх гэж. Одоо яах билээ. Би ахынд очиж учрыг хэлье гэж шийдээд
- Би завтай байна гэснээр Шагж сайдынд ирэв. Сайд сайхан зантай угтаад
- Ах нь хол явж ирээд сая л гэрийнхээ барааг харж байна. За тэгээд аав тань хаана морилж байна гэж яаран асуухад Хөхцэцэг санаа зовсон байдалтайгаар
- Ах аа. Би сая аавыг Алтайн онгоцонд суулгачихаад ирлээ гэв. Шагж гайхан
- Юу гэнэ ээ. Хэзээ ирээд одоо буцаж байгаа юм бэ? Би чинь яваад хорин зургаа хоноод ирж байна гэхэд Хөхцэцэг
- Аав яг хорин хоёр хоноод явж байгаа юм гэлээ. Хөхцэцэг Жаргал эмчийн тухай асууя гэж бодсоноо болив. Тэр дотроо
- Жаргал эмчийн алдсан охинтой нь би их адилхан байсан байх аа. Гэхдээ л надад дотнын минь хүн шиг л санагдаад байгаа юм. Заримдаа өмнө нь уулзаж учирч байсан таньдаг хүн юм уу? гээд бодоод байхаар зүс нь ердөө санаанд орж ирэхгүй юм гэж бодож байлаа. Сагад онгоцны нүргэлэх дуунд нүдээ анин бодлоо бясалгана.
- Өвөг эцгийнхээ оюуны их бүтээлийг өөрийн сумаар зогсохгүй монгол орон даяар бүх суманд, малчны хот айл болгонд монгол хүн бүрт өглөг болгон хүртээхээр болсонд их баяртай байлаа. Халхын Чоймжуур аграмбын “Мөнх тэнгэрийн таалал оршвой” хэмээх тодорхой гэрэлт толийг монгол улс өмчөөр бүртгэн авч улсын архивт хадгалагдахаар болсон нь аавынхаа захиасыг биелүүлж өвөг эцгээ мөнхжүүлж чадлаа гэж бодно. Энэ атгахан номыг дэлгэрүүлэн гурван боть болгон хэвлүүлэх болсон нь элэнц эцэг гавж Авирмэд, өвөг эцэг Аграмба Чоймжуур, өөрийн эцэг Гэвш Хайдавжамц гуравтаа номон суврага босгож байгаадаа хүсэл сэтгэл нь хангагдан амар амгаланг оршоож байв. Тэр амандаа
- Амьд мэнд явсны ач тус буян нь ийм их бөлгөө гэж шивнэв. Шагж сайд охин Хөхцэцэг хоёрынхоо ач тусыг санав. Тэр улмаар Хөхцэцэгийн ээж Жаргал эмчийн тухай бодлоо.
- Эх хүний зөн совин гэдэг их боловч эх үрийн нарийн нандин холбоо сэрэл мэдрэмжийн танин мэдэхүйн ухаан билэг арай л илүүтэй билээ. Мэнгээр нь таньсан боловч түүнийгээ батлахын тулд нүдээр нь нэвгэрч сэтгэл зүрхнийх нь бичээсийг уншаад бас гарынх нь хээгээр шинжсэн байгаа юм даа. Бас болоогүй ээ. Багадаа авхуулсан зургийг нь үзүүлж сэрэл мэдрэмжийг нь сэргээхийг зорьсон нь тун ч айхтар хүн болохыг гэрчилнэ. Тэр Жаргал эмч охиноо мөн гэдгийг мэдсэн хэрнээ надтай уулзахаас наана ямар нэгэн байдлаар авир ааш гаргаж аяглаагүйг бодоход их ухаантай хүн дээ. Монголчуудын энэ хөх ухаан бядлаг тэнхээтэй юм шүү гэж бодож явлаа.

Гучин зургаа

Сагад мэргэн уригдаж залагдан Улаанбаатар яваад буцаж ирэхдээ олз омогтой ч сэтгэлдээ олон бодол тээсээр ирж сумынхаа удирдлагуудад хэрэг явдлаа товчхон танилцуулаад гэр орон мал руугаа явав. Удалгүй Хөхцэцэг бүсгүй сургуулиа амжилттай төгсөөд Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний туслах ажилтнаар орж анхныхаа албан томилолтоор гурван жилийн хугацаатай ажиллахаар авсан үүрэг даалгавраа мөн л нам захиргааны дарга нарт танилцуулаад гэрийн зүг хөдлөв. Сагад охиноо ирсэнд баярлан

-За одоо бид хоёр том ажилтай болсон доо. Хоёулаа нухаад л байна даа. Миний охин Шагж ахтайгаа уулзсан нь сайн болж. Харин Жаргал эмчтэй уулзаагүй юу? гэж асуув. Хөхцэцэг дотроо

-Аав яагаад Жаргал эмчийг асуух болов.Шагж ахын бүл дүү гэж сонсоод танилцахыг хүссэн байх гэж бодоод

- Үгүй аав аа. Жаргал эмч Орос улсад байгаа гэсэн. Нөхөр нь Элчин сайдын яаманд ажилладаг. Тэнд хоёр сар болох юм гэнэ лээ гэв. Сагад дотроо

- Энэ түвэгтэй юмны учир хэзээ нэг шувгардаг бол. Шагж сайдын тус дэмжлэг л их хэрэг болох нь дээ. Бид ч учраа олчихно. Охинд маань л хүндхэн тусаж мэдэх юм даа. Энд нэг аав байж байтал тэнд бас нэг аав, ээж хоёр гараад ирнэ. Тэд төрүүлээд гурван настай болтол нь өсгөсөн. Би өдий болтол нь бойжуулсан. Миний охин ч ухаалаг хүн дээ. Би л эртнээс чимээ өгч дасгаж байх нь зөв болно. Аав ээж нь, бид гуравын хувьд ч баяртай байна гэж бодож суутал Хөхцэцэг

- Аав аа. Та Шагж ахын бүл дүү Жаргал эмчийг яагаад таньдаггүй юм бэ? Эмч бас таныг танихгүй гэж байсан гэхэд Сагад энэ яриаг тун ч олзуурхан өлгөж аваад

- Тэр эмч чамаас ээжийнхээ нэрийг хэл гэсэн гэл үү? гэхэд Хөхцэцэг аав руугаа сүрхий хараад

- Тийм ээ тэгсэн. Хоёр удаа асуучихаад хэлэхгүй байж болно гэсэн. Нэг бол намайг ээжгүй гэж өрөвдсөн байж болно. Эсвэл ээжийг минь мэдэж байгаа болоод хэлэх хэрэггүй гэсэн байх гэхэд Сагад инээмсэглээд

- Мэдэж байгаа болоод л тэр биз гэж хайхрамжгүй маягтай хэлэхэд Хөхцэцэг бодлогошироод

- Тийм байж болно. Надад өмнө нь таньдаг байсан дотнын хүн минь юм шиг санагдаад байх юм. Би тэр үед үүнийг огт санасангүй дээ. Уг нь асуугаад авдаг байж. Ааваа та надад миний ээжийн тухай нэг ч удаа ярьж дурсаж байгаагүй шүү дээ гэхэд Сагад сайхан ааш гарган охиноо өхөөрдөөд

- Хичээл шалгалтандаа хүнээр хэлүүлэх юм уу, номноос хуулж бичээд онц авах тийм ч сайхан биш шүү дээ. Харин өөрийнхөө мэдэж байгаа юмаа бичээд эх орны гурав авах тэр онцоос

хамаагүй дээр юм биш үү. Чи юу гэж бодож байна гэхэд Хөхцэцэг аав руугаа том хараад

- Аав аа. Та надад миний ээжийг хэлж өгөхгүй гэсэн үг үү. Би өөрөө эрж хайж уулзах юм уу? Ямар сонин юм бэ? гэхэд Сагад

- Юу нь сонин гэж. Тэр Жаргал эмч л сайн мэдэж байж болох юм даа гэлээ. Хөхцэцэг гайхан нүдээ эргэлдүүлэн гэрийн тооно өөд харахад Сагад

- Охин минь гэрийн тоононы хүрээ дугуй байгаа биз дээ. Хүний амьдрал чинь тэр дугуй хүрээ шиг эргэлдэж байдаг юм шүү дээ. Чи дахин дахин бодож сайн бясалга. Хорвоо чинь хүний арвин их нууцыг хадгалж байдгаараа учир битүүлэг оньсого шиг санагддаг. Үүгээрээ маш хүчирхэг болдог. Бас хязгааргүй баян тансаг ид шидийг үзүүлдэг. Түүнийг нь бид хэрхэн ойлгож хүлээж авснаараа жаргал зовлонг амсдаг. Энэ бүхэн төгсгөлдөө ирэхэд эцэст нь юу ч байхгүй хов хоосон л байдаг. Энэ нь хорвоо ертөнц хүмүүний амьдрал мөнх бус гэдгийг илэрхийлдэг юм гэлээ.

Энэ жил энэ суманд буман ажил буцалж түмэн хэрэг бүтэж байлаа. Амархүү Нарангарав хоёрын хурим сайхан болж өнгөрөв. Хүн л болсон хойно алив нэгэн үйлийг болж өнгөрсний дараа нэг хэсэгтээ л аяга цай уух зууртаа амаа уралдуулан хөөрөлддөг нь гэм биш зан билээ.

-Нарангарав ч үнэхээр сайхан бүсгүй юм аа. Тэр тэнгэрийн өнгөтэй цэнхэр дээлэн дээр одон медалуудаа зүүчихээр улам л үзэмж төгс болчих юм. Балдан гуайг ганц охиноо сайхан өсгөж гэж байхад өөр нэг нь

- Яхир Балдан ч ганц охиноо гарт нь гав зүүх нь холгүй л хорьж цагдаад гэртээ байхад нь хаалганыхаа хоёр түгжээ нэг цоожоор, хасар банхар хоёр нохойгоороо, хонинд явахаар нь хоёр нүднийхээ үнэтэй дурангаар манасаар байгаад л сохор Балбарын ач хүү Амархүүд алдчих юм даа гэж гомдолтойхон хэлж байхад бас нэг нь

- Амархүү ч эрдэмтэй номтой сүрхий залуу шүү дээ. Нутгийн хоёр хүүхэд нийлээд сайхан амьдарч явбал сайхан шүү дээ. Балдан ах өдөр шөнөгүй манахын хүчинд л эрдэнэ мэт сайхан охиноо нутаг усандаа үлдээж чадлаа. Энэ гоо үзэсгэлэнг аваад явчих халхын харчууд хааяагүй л байна. Адилхан эрчүүд бид хэнээсээ юугаа харамлах билээ. Амжаад авсан хүний л зол заяа шүү дээ гэхэд бас нэг нь

- Илгээлтийн эзэд чинь бараг л сургууль соёлд яваад өгсөн. Ганцхан Нарангарав л нэг настай мал малласаар байгаад Улсын хошой аварга малчин болж Алтан гадас одон олон медалиар энгэрээ мялаасан даа. Одоо ч том алдар цолонд тулаад оччихсон шүү дээ. Харин Амархүү бол эрдэмтэн хүн. Алаг хайрхан уулын Вансэмбэрүү цэцгээр эрдмийн зэрэг хамгаалсан. Одоо докторын зэргийг Бунхан хөтлийн Минжиннагво цэцгээр хамгаалах гэж байдаг. Нутаг орныхоо нэр алдар, ургамал цэцгийг нь хүртэл дэлхийд таниулна гэдэг үгээр хэлэхийн аргагүй гавьяа шүү дээ гэцгээж байхад Хөнхий, Минжинд сэтгэлээ нээхээр бүр шийдээд байлаа.

Минжин бүсгүй Орос улсаас түр чөлөөгөөр ирсэн байлаа. Юуны учир ирснийг зарим нэг нь бага сага гадарлаж байлаа. Минжингийн ээж Бумаа аварга энэ өнгөрөгч хавар улсад урд өмнө

гарч байгаагүй төл хүлээн авч бойжуулсан улсын гурван удаагийн аварга билээ. Тэр зуун эхээс зуун тавин хоёр ишиг бойжуулсан нь түүхэнд байхгүй амжилт байв. Түүний тухай радиогоор ярьж, сонин хэвлэлийн эхний нүүрэнд зургийг нь тавьж алдар гавьяаг нь дуудаж баатар гэж цоллож байв.

Хүмүүсийн амнаас ам дамжин Хөдөлмөрийн баатар гэдэг хүндтэй цолыг Бумаа аварга л хүртэх ёстой гэсэн цуу үг, яриа хуурай өвсөнд тавьсан түймэр шиг түргэнээр түгэн тархаж байлаа. Аргагүй л олны амны билэг ортой байдаг бололтой. Удсан ч үгүй Бумаа аварга Улаанбаатарт очиж Монгол улсын хөдөлмөрийн баатар цол хүртэж алтан соёмбот медаль, Сүхбаатарын одонгоор энгэрээ мялааж аймаг сумынхаа нэрийг цуурайтуулав.

Бид Бумааг сайн мэднэ. Залуу зандан насандаа хүнийг хайрлаж, хайрандаа бялуурч яваад хар муу санаанд өртөж доромжлогдон гашуун зовлон амсаж амьдрах хүсэл мөрөөдлөө гэж аль болох түргэн амь биеэ алдаж асгахаар шийдэж байсан ч охин Минжингээ Бунханы хөтлийн Минжиннагвын хунхад төрүүлж түүний часхийсэн цовоо цойлгон дуунд цочин сэрж уран зөөлөн уруул, бүлээн дулаан амьсгалыг нь мэдэрч уураг сүүн мөөм нь ивлэж үр гэдэг сэрлээр эх хүн гэдэг мэдрэмж ирж үртэй хүн бүтэн жаргадаг юм гэсэн үгээр мунхарч гүйцсэн тэнэг бодлоо гэж ухаантай амьдрахын утга учрыг олж авч чадсан нэгэн билээ.

Хөдөлмөрийн баатараа аймаг, сумаараа, хотол олноороо баярласан сэтгэлүүдээ нийлүүлэн баглаа цэцэг болгон барьж угтацгаав. Баатарт хүргэсэн сайхан сэтгэлүүд дөрвөн хоног үргэлжлээд л борооны усны үер татардаг шиг аажимхан багасав. Бумаа баатар өглөө эрт босож хэдэн ямаа сааж сүүг нь саванд хийж амыг нь бөглөөд, хотын чихэр жимс нэг хадаг бэлдээд охин Минжингээ дагуулаад гэрээсээ хөдлөв.

Ээжийнхээ энэ үйл мөрийг Минжин ч сайн ойлгохгүй байлаа. Авсан ээж Цагаан ахынд очих юм боловуу гэтэл баруун хярыг чиглэв. Алаг хайрхан ууландаа л сүү, идээ будааныхаа дээжийг өргөж хадаг тавих юм байх гэтэл явсаар байгаад хуц ухна малладаг Сагад мэргэний гэр лүү хандав. Минжин ч Хөхцэцэгтэй уулзана гэхээс сэтгэл нь сэргээд явчихлаа. Гэсэн ч Минжингийн сэтгэлд нэгэн сонин бодол ургаад явчихлаа. Ээж энэ Сагад гуайтай ямар холбоотой юм бол оо. Тийм ч сайн танилууд биш дээ гэж бодно. Минжин сүүлийн үед аавыгаа мэдэхсэн. Ямар хүн байдаг бол. Алдаа оноотой байсан ч барааг нь харж явах юмсан гэсэн бодол үе үехэн орж ирдэг болсон билээ. Тэр бодол нь илүүтэй давамгайлав уу яав?

-Арай энэ Сагад мэргэн чинь миний ... гээд бодсоноо

- Арай ч үгүй байлгүй дээ. Намайг төрөөд гурван ойтой байхад л гурван ойтой Хөхцэцэгийгээ тэврээд хотоос ирсэн юм гэнэ лээ гэж ярьдаг шүү дээ гэж санаад өөрийгөө шоолж инээв. Охиноо харсан Бумаа

- Миний охин юунд инээв? Би чиний бодлыг мэдэж байна гэхэд Минжин мориныхоо амыг татаад

- Ээж ээ. Та үнэхээр мэдэж байвал хэлэл дээ гэхэд Бумаа

- Ийм нууц юмыг тэр болгон хэлээд байдаггүй юм шүү дээ. Эх хүн чинь үрийнхээ бодлыг

байнга л уншиж явдаг юм гэхэд Минжин гайхсан маягтай

- Миний ээж чинь агуу хүн юм чинь. Би таниараа бахархаж байна гэхэд Бумаа инээмсэглээд

- Үгүй. Ээж нь охиноороо бахархаж байна. Миний охин ээждээ амьдрал, аз жаргалыг бэлэглэсэн ачтан. Энэ Сагад мэргэн надад алдар хүндийг хүртээсэн ухаантан миний багш байгаа юм гэлээ. Минжин ээж рүүгээ том хараад

- Та чинь хэдүйдээ Сагад гуайтай багш шавь болчихдог байна аа гэхэд ээж нь

- Сагад гуайгаас нутаг ус, малынхаа үржил, удам угсаа, хээлтүүлэгч ухна сонгохдоо зүс, эвэр туурай, авир аашийг нь хүртэл шинжинэ шүү дээ. Мал маллагааны маш нарийн нууц эрдмийг зааж сургана. Та нар шиг танхимд суугаад бичиг ном дэлгээд байхгүй. Цай уух зуурт юм уу, хурал зөвөлгөөний завсарлага чөлөөгөөр аль болох цаг завьг ашиглаад асууж сураад авчихна шүү дээ. Охин минь бодоод үз дээ. Зуун ямааны тавин хоёр нь ихэрлэнэ гээд сана. Ер нь манай сумын мал яагаад түргэн эрчимтэй өсөж байна. Гурав дөрвөн жилийн өмнө сум нэгдлээрээ төрийн дээд шагнал “Алтан гадас” одон хүртсэн. Энэ бүхэнтэй ч Сагад гуайг холбож түүний малч ухаан уйгагүй хөдөлмөрийн үр шим гэж үзэхээс өөр арга алга байна. Сагад гуай чинь тэнгэрийн зургийг уншиж тайлдаг их эрдэмтэй хүн шүү дээ. Саяхан Шинжлэх ухааны хүрээлэнд уригдаад хичээл ном заагаад ирсэн. Манай суманд чинь ихэс дээдэс, эрдэмтэн мэргэд алдар цуутнууд олон байна. Ээж нь энэ нутаг усаараа, зон олноороо бахархаж баясаж байдаг юм гэлээ. Минжин

- Ээж ээ. Би таньд нэг нууц юм хэлье. Манай ангийн Хөнхий намайг зовоогоод байх юм. Би өөр бодолтой явдаг л даа гэхэд Бумаа хэсэг зуур бодол болж байснаа

- Миний охин чи өөр бодолтой байдаг чинь сайн хэрэг. Хөнхийд буруу өгөх хэрэггүй. Ээж нь нэг ухаан гаргая. Чи санаа зоволтгүй гэв. Сагадын тэр хоёрыг ирэхэд ашгүй Сагад Хөхцэцэг хоёулаа бичиг цаасанд хутгалдаад сууж байв. Бумаа баатар ч мэнд усаа мэдээд хадгаа дэлгэн хотын чихэр жимсээ гаргаж Сагадад барихад Сагад гайхсан янзтай хараад

- За баатар минь. Би баяр хүргэхээр очиж амжаагүй сууж байтал та өөрөө хүрээд ирдэг чинь юу болж байна гээд малгайгаа засаад тосож авав. Бумаа баатар инээмсэглээд савтай сүүгээ гаргаад

- Энэ манай ямааны сүү. Нөгөө хэдэн ухнаа мялаах санаатай авчирсан юм гэхэд Сагад

- Та төрсөн нутаг түмэн олныгоо төлөөлөөд төрийнхөө хишгийг хүртээд ирлээ. Буман сүргийн манлай болсон сүрэг сүргийн тэргүүн сүрлэг сайхан сүрэгт минь сүүн цацлаа өргөчих. Бүгд л баярлах байлгүй гэхэд Бумаа

- Таны хэлдэг зөв байна. Олон түмнээ төлөөлөөд өргөө гэхэд Сагад инээгээд

- Тэг дээ, тэг. Сайхан сэтгэлийн үзүүрт сүү гэдэг юм шүү дээ гээд сууж байв. Хөхцэцэг Минжин хоёр хэзээний нийлээд суучихсан хоол зоог бэлтгэж байлаа. Энэ дөрвөн хүн хоёр хоёроороо халуун дотно яриа үүсгэн хоёр залуу бүсгүй нь эрдэм шинжилгээний их бүтээлийн

тухай ярилцаж байхад аав ээжүүд нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг тэнгэрийн бичээстэй зохируулан хөтөлж явуулах амьдралын хөгжил дэвшлийн талаар хүүрнэж байв. Энэ нутаг усанд хайр хүндэтгэлийн хүч тамир дэлгэрэн оюун билгийн цагаан тамир хуран хүн бүрт өглөг болон хүрч байв. Бумаа баатар Минжин хоёр Сагадынд тухалж хүслээ хангаад арын ажилдаа яаран буцлаа. Тэр хоёрыг гэртээ ирээд удаагүй байтал хэн нэгэн

- Нохой хорио гэв. Минжин гэрээс гарснаа Хөнхийгийн аав ээж хоёр болохыг таниад гэртээ эргэж ороод ээждээ

- Одоо яана аа. Хөнхийгийн аав ээж хоёр байна шүү дээ. Ямар хэргээр манайд ирдэг билээ гэж сандран хэлэхэд Бумаа

- Өө тийм үү. Ээж нь тосъё гээд гарлаа. Бумаа, Балсан Сүрэн хоёрыг хараад дотроо

- Сайн хүн санаагаар гэдэг хүрээд ирсэн нь боллоо. Миний нэг явдал өөрөө бүтчихлээ гэж бодоод

- За сайн морилж ирцгээв үү? гэсээр угтан авч гэртээ залан морилуулав. Бумаа баатар дотныхоо хүмүүсийн адил идээ будаа, зоог барьж явсан, үзсэн дуулсан болгоноо ярив. Балсан дотроо

- Бумаа ч угаасаа бурхан заяатай бүсгүй дээ. Бид хоёр ч учрах ерөөл тавилангүй л байсан юм байлгүй дээ. Энэ маань ганц охиноо сайхан өсгөөд ганцаараа ч гэсэн мөн л гялалзаж байна даа. Манай Хөнхий ээждээ Минжингийн тухай ярьсан гэсэн. Бумаа ч ганц охиноо манай хүү рүү хандуулах ч үгүй байх даа гэж бодож суухад Сүрэн дотроо

- Бумаа бид хоёр холбоотой тугал шиг гэрээс гаравч оровч байнга л хамт байна. Нэг оронд өвөртөлж унтчихаад нэг аяганы хоёр талаас халбагадаж хоол идчихээд салдаггүй найзууд байсан даа. Манай Балсан ч Бумаагийн араас сөхөрч унатлаа явсан юм даг. Сүүлдээ ч бүр нийлж суухаар шийдчихээд байсан. Тэр жил Бумаагийн аав ээж хоёр хонь туугаад явчихсан ганцаараа ганц гэрээрээ Хужиртын усан дээр зусаж байлаа. Хотын нэг машин буруу замаар явж Хужиртын голын довон дунд шалбааг шаварт суугаад машинаа эвдээд өөрөө өвдөөд Бумаагийн найм хоноод аймаг явж сэлбэг авчраад машинаа засаж байна гэж арав гаруй хоноод явсан билээ. Энэ зуурт явган яриа, хов жив туулайн чинээ байснаа яван явсаар мангасан чинээ болж Балсанд хүрээд түүний зүрхийг огшоож сэтгэлд нь хар хорын манан татаж сэрэх ухаан харах нүдийг нь харанхуйлан хаав. Ийм хүн ямар л өөдтэй үйл мөр хийж үг яриа ярих билээ дээ. Тэр айхтар гээд байгаа хов жив нь ердөө л нэг шоглоомын үгс байв.

Хужиртын голын шаврыг яана аа

Хурдан тэрэгний эвдрэхийг яана аа

Хүргэн жолоочийн будлиуг яана аа

Хөөрхөн Бумаагийн аашийг яана аа

гэсэн цэцэлсэн тоглоомын үг нь явсаар ая орж дуу маягтай болоод сахилгагүй саваагүй зарим нь Балсанд дуулдахаар аялж дуулах бүрт Балсангийн уур омог шатсаар угаан мананд будилж мунхарсан нь тэр. Бумаад

-Энэ чинь юу болоод байгаа юм бэ? Би хүүхэд нохойн доог болж гүйцлээ. Чи үнэнээр нь хэл гэхэд Бумаа инээмсэглээд

- Чи чинь юугаа болчихоод омогдож хашгираад байгаа юм бэ? Тэнэг хүний үнэн өөртөө үнэн байдаг юм гэсэн. Чи өөрийнхөөрөө ойлго гэхчигээ. Балсан тэр чигээрээ гарч давхисаар Нарийний голын аманд зусаж байсан Сүрэн бүсгүй дээр ирж энэ тухай яриад

- Би Бумааг үнэнээ хэл гэж шахахад намайг тэнэг мангараар минь дуудан үнэн гэж ойлго гэлээ гэж жижигхэн хүүхэд аятай Сүрэнд хов зөөж өөртөө өмгөөллийг хүсэв. Сүрэн ч хэрэг болгон Бумаа дээрээ очиж хонож өнжихдөө энэ тухай ярилцахад Бумаа

- Тэр хүн л үнэн гэж бодож байгаа бол үнэн л байх. Худлаа гэж бодвол худлаа л байх. Нөгөө илжигний чихэнд ус ч хийсэн, алт ч хийсэн адилхан сэгсэрнэ гэдэг шиг тэр хүнд юу ч хэлээд нэмэр байхгүй. Өөрийнхөө бодож байгаагаараа л зүтгэнэ шүү дээ гэлээ. Сүрэн

- Наад үг чинь үнэн гэсэн үг үү? гэхэд Бумаа Сүрэнг өрөвдсөн нүдээр хараад дотроо

- Ээ чааваас. Сүрэн минь чи яачихсан хүн бэ? Ухаанд чинь ухна уначихаагүй байлтай юм даа. Энэ маань бас тэнэгэрчихэж гэж бодоод

- Өөрсдийнхөөрөө л ойлгоцгоо. Би чинь монгол хүн шүү дээ. Өвдөж зовсон хүн ирэхээр хөөж туугаад байж чадаагүй юм. Тийм мөс жудаггүй юм гэж юу байх билээ гээд чимээгүй болж дотроо

- Би биений хир ирэхгүй байгаагаа Сүрэнд хэлэх үү, яах вэ? гэж тээнэгэлзэн байснаа энэ удаадаа хэлэхгүйгээр шийдсэн билээ. Сүрэн ч дотроо

- Миний найз чинь хүн биш чөтгөр болчихсон юм байна. Бумаа минь тэр муухай жолоочоос бузартсан байх аа. Ийм хачин авир ааштай хүн ч биш дээ гэж бодсоор бушуухан буцав. Сүрэн Балсантай уулзаад буруу зөрүү үг хэлээгүй ердөө

- Манай Бумаа бузартсан байх аа. Чи хэсэгтээ очоод хэрэггүй биз гэснээс өөрийг огт хэлээгүй билээ. Гэтэл Балсан олон хоног ч гэх нь хаашаа юм долоо хоног л бодолд дарагдав.

- Бумаа намайг яаж зовоож цөхрөнгө минь барж байж нааштай үгээ хэллээ дээ. Одоо болж бүтэх нь гэж бодож байтал дахиад л зовоогоод хэл ам татлаад эхэллээ. Хөөрхөнөөрөө бүр гайхуулчих юм. Харсан хөгшин залуу эрчүүдийн нүдийг унагаад түүндээ бүр онгирч нэг муу тостой жолоочтой наалдаад байхдаа яадаг байна. Би ч дөрөөг нь даахгүй бололтой гэж бодоод хар мунхаг сэтгэлдээ хөтлөгдөн Бумаагаа орхин Сүрэн рүү явсан нэгэн. Сүрэн бүсгүй ч чи хүрээд ирэв үү гэж баярлан угтаагүй. Харин ч түүнийг зэмлэж

- Чи чинь юу билээ. Бумаа л байхгүй бол би амьд яваад яах юм гээд байсан хүн чинь одоо

Бумаа шиг муухай хүн байхгүй болчихоод найзаас нь амьдрал гуйгаад явж байдаг чинь юу билээ гэж тас шилбүүрдсэн билээ. Гэтэл намар болоход Бумаа хэвэл биеэрээ бүдүүрснээ хэнээс ч нуусангүй. Тэр Балсанг ирнэ гэж итгэж найдаж хүлээсээр байсан билээ. Хад хүртэл салхинд элэгдэн цаг хугацааны эрхээр нүхлэгдэн цоордог билээ. Түүн лүгээ Балсан ч тайвшраад ухаараад хүрээд ирнэ гэж л итгэж найдаж байсан хэрэг. Гэтэл мөн л явган наргиан жирийлгэсээр Балсан Сүрэн хоёрт сонсогдов.

Будлиу жолооч яваад талийв аа

Бумаа бүсгүй бүдүүрээд үлдэв ээ

Буцаж ирнэ гэж харуулдаад хүлээв ээ

Булингартай нүд нь чилээд хэцүүдлээ

гэж нөгөө л аялгуунд оруулан дуулцгаав. Энэ хов жив шиг хорон үг хос хоёрыг салгаж хол хоёрыг ойртуулав. Алаг хорвоогийн амьдралын эргүүлгэнд алдаа онооны зөрүүгээр эцэг үр хоёр төөрч будилсан түүх энэ бөлгөө.

Одоо Бумаа баатар л нууцын оньсыг мулталж үнэний хүрдийг эргүүлэх үлдээд байв. Бумааг сайхан инээмсэглэхэд Балсан, Сүрэн хоёр буруу хэрэг хийсэн хүүхэд аятай хулмагнан байх нь инээдэмтэй санагдаж байв. Бумаа

-Баяр хүргэж ирсэнд чинь их баярлалаа. Та хоёр чинь миний л багын найзууд шүү дээ. Бид гурвын дунд нуух юм байгаа ч бас нууж болохгүй юм ч байна. Хүүхдүүд ч том болцгоочихлоо. Танай Хөнхий чинь манай Минжингээс гурван сараар дүү юм шүү дээ. Залуу байхад аль будилахыг хэлж барахав. Энэ хоёр хүүхэд чинь нэг л үндэснээс ургасан цэцэгс юм шүү дээ. Би энэ байдлыг Балсанд хэлэх гэж байтал их омогтой байхаар нь дараа больё гэж бодсон. Сүрэнг ирэхэд миний аман дээр хоёр ч удаа гарч ирээд Балсандаа эхэлж хэлье гэж бодоод би шүлстэйгээ буцааж залгисан. Дараа нь надад хэлэх боломж олдоогүй юм. Тэр тоглоомын үг явсаар шоглоом болоод бидний хувь заяаг өөрчилсөн. Энэ нууцыг бид гурваас өөр хэн нэгэн мэдмээргүй нандин хэвээрээ үлдмээр байна. Миний охин намайг төрх дүрээрээ илүүтэй дуурайсан ч Хөнхий энэ хоёрт адил төстэй зүйл олон бий. Та хоёр минь зөвхөн Хөнхийд хэлээд нууцалж явахыг сайн ойлгуул. Одоохондоо Минжин мэдэх хэрэггүй гэхэд сонсож суусан Балсангийн хөлс шанаагаа даган урсаж хормой дээр нь унаж байлаа. Тэр хоёр бүсгүйн өмнө шахаанд орж ялд унасан хэрэгтэн шиг толгойгоо гудайлган чимээгүй сууна. Сүрэн ч сэхээ аваад

- Бумаа минь гэхэд Бумаа түүний үгийг таслаад

- Одоо бид болоод өнгөрсөн түмэн зовлонгоо, буруу зөвөө ярих биш бие биенээсээ дөлж бусгаж булгаж явахгүй нэг нэгэндээ тус болж орж гарч сайхан нөхөрлөж явъя. Хөнхий багш хүн болохоор үүнийг сайн ойлгох байх. Хэрвээ өөрөө зөвшөөрвөл Минжинтэйгээ хүж барьж эгч дүүс болог. Би Хөнхийдөө итгэж байгаа болохоор үүнийг бодсон хэрэг. Эгч дүү гэдгээ олонд илчлэх биш нууц хэвээр нь байлгаж чадвал энэ хоёр хүүхдийн эцгийн нэр бүрэн бүтэн үлдэх юм гэж л санасан хэрэг. Нэр хугарахаар яс хугар гэж үг байдаг шүү дээ гэснээ

- Та хоёр цай ууж юм ид. Би ухасхийгээд хэдэн ишгээ буцаагаад ирье гээд гарав. Тэр энэ хоёртоо зөвшилцөх боломж олгож байгаа нь энэ.

Амьдрал гэдэг олон түлхүүртэй оньс болгон нэгийгээ нууцалж байдаг гайхамшигтай ид шидийн нууцаар бүтээгдсэн илбийн цоожоор мануулсан өөгүй бөөрөнхий сав билээ.

Бумаагийн хүссэнээр Хөнхий Минжин нар хүж барилдлагатай дээлтэй төрсөн эгч дүүс болцгоолоо. Хөнхий учрыг маш сайн ойлгосон учир амраг сэтгэлийн хайраа ахан дүүсийн хайр болгон сольж энэ насаараа Минжингээ хайрлаж явах болсондоо баярлаж байв. Хайрлах нь хүндэтгэл итгэлцлийн хамгийн дээд ухагдахуун мөн. Харин дурлах нь хэсэг хугацааны шохоорхол хэтэрхий их шунахын нэг хэлбэр юм гэж Хөнхий багш тодорхойлж байв.

Минжингийн тухайд амьдрал алга урвуулах шиг өөрчлөгдөж дурлалдаа шатаж шаналж байсан Хөнхий албин чөтгөр аятай гэнэт дүү нь болохоор шийдээд хадаг сүү барин аав, ээжийгээ дагуулаад ирсэнд гайхаж байсан ч сэтгэлд нь дотно зөөлөн санагдсан учир баярлан угтав. Минжин бүсгүй сэтгэлдээ нэгэн оньсого мэт нууц зүйл байгааг мэдэрч байлаа. Хөнхийгийн аав ээж, өөрийнх нь ээж энэ гурван хүний дунд л энэ нууц хадгалагдаж байв. Амьдралын нууц болгон нууц байх үедээ л үнэ цэнэтэй нэр хүндтэй байдаг. Олонд дэлгэгдэж нээгдсэний дараа үнэ цэнээ алдаж тэр ч битгий хэл ор тас мартагддаг билээ.

Гучин долоо

Сагад малтайгаа бэлчээрт явж байлаа. Намрын нар хичнээн сайхан ээж байлаа ч илч нь төдийлөн ойр биш хол мэт мэдрэгдэнэ. Сайн ажигласан хүнд цайвар хүрээ холуур татсан байв. Тэнгэрийн өнгө тэр орчимд гүн хөх биш мөн л цайвар өнгөөр шингэрч алсарна. Ногоо өвс ургамлыг ярж харвал доорхи чулуу нь нарийн тоосонд их дарагдсан харагдана. Үхэр огтоно дуугаа хурааж тогтож ядан гүйлдэж хөөгөө хураана. Хулгана ноохойгоо далдалсан байв. Тарвага ичээгээ нар ээвэр энгэрт бэлдэнэ. Хярд тошсон сарлагийн бух нам дор газрыг сонгож эхэлнэ. Энэ бүгдийг ажиглаж яваа Сагад

-Энэ өвөл цас их унаж зарим нутагт зуд турхантай байж мэдэх нь дээ. Нутаг усаа сайн сонгож малдаа дээд зэргийн тарга хүч авахуулчихвал ч айх юу байх билээ. Энэ зун халгай багагүй дарж авсан нь сайн боллоо. Би ч эвэртэн дархтан хэдийгээ нөмөр нөөлөг сайтай наранд ээвэр өвсний хаялга ихтэй, модлог ургамал элбэгтэй өвөр бэл нь дулаан Улаан хайрханаа бараадуулвал дээр байх даа гэж бодно.

Хорвоог таньж мэдэх гэдэг тийм ч амархан биш билээ. Хоног өдрүүд хойно хойноосоо урсан өнгөрнө. Амьдралын үйл мөр адал явдлууд ард хоцорч түүх болон үлдэнэ. Цагаан өнгөн дээр хараар бичигдэн илээр оршихыг цадиг шастир гэж хүндэлнэ. Харин далд нууцлагдан булшлагдах заримыг нь хэн ч мэдэхгүй үлдэж хорвоо түүнийг хадгалж чадсанаараа улам хүчирхэгжиж ид шидээр гайхуулна. Хэн ч үл мэдэх нууц булшин дотроо амилж албин чөтгөр аятай гарч ирээд заримыг нь айлгаж ичээгээд заримд нь гайхамшигийг үзүүлнэ.

Амьдрал аугаа ухаантай асар уудам мөртлөө заримдаа дэндүү тэнэг өчүүхэн мэт төсөөлөгддөг. Энэ бүгдэд бодлоо бэлчээн сэтгэлээ чилээн малаа хариулж явгал Сагадын хүрэн морь чихээ сортолзуулан аль нэгэн анир авч толгойгоо өргөн алсын бараа харна. Хоёр морьтны барааг Сагад харав. Тэдний хоорондоо ярилцах дуу дүнгэнэн тод дуулдана. Энэ нь агаар сийрэг байгааг илтгэнэ. Хоёр морьтон ойртоод ирэв. Яхир Балдан, анчин Чоймбол хоёр байлаа. Бидний сайн танил Чоймбол юм юманд хоосонгүй гэдгийг бид мэднэ. Тэр тоглоом маш сайн даадаг өөрөө ч хатуу тоглодог нэгэн.

- Олон жилийн өмнө Сангийн далайн хөх энгэрт багийн хурал болж байлаа. Хүмүүс цугларсан хурал цуглааны үеэр сумын төвийн суурин ганзага Суманхүү ирж өр ширээ нэхэн авлага авцаагаа тооцон бас ч үгүй сүр үзүүлж сүржигнэнэ. Тэр аман дээрээ арай ч дээ гэмээр аашилж байсан ч ачир дээрээ ийнхүү хатуу тоглодог ардаа бол их зөөлөн хүн билээ. Өрийн дансанд байнга нэрээ бичүүлж бас олон удаа нэхүүлж явдал суудал тарьдаг хүн бол анчин Чоймбол. Түүний тоглоом дэндүү хатуу болохоор сайн мэдэх нэг нь хулгаж зай барина. Энэ удаа Суманхүү тоглож буй шоглож байгаа аль нь ч мэдэгдэхгүйгээр Чоймболд

За хөө. Тооцоогоо бодно доо

Зангууны өргөс шиг зовлон минь

Өрийн данснаас салдаггүй

Өгөр толгой Чоймбол минь

гэхэд Чоймбол инээмсэглээд

Өр ширэнд чинь

Өгөх юм даан ч алга

Өөрийгөө бодоод байвал

Өрөөсөн хөлийг минь ав л даа

Зангууны өргөс санаад байвал

Залуухан эхнэрийг минь тоол доо

Гайтай хөөтэй дансыг чинь

Галд өргөчихнө шүү гэхэд Суманхүү дотроо ихэд уурлан

-Миний муу хөлийг минь дайруулж надаас тав ах эхнэрээр минь даажигнахдаа яадаг байна аа. Тоглоом тоотой нь дээр гэдэг биз дээ гэж бодоод

Зангууны өргөсөө өөрөө түүгээрэй

Залуу эхнэрээ хотод зараарай

Энэ их өрийг чи яаж дарж чадах вэ

Эмээлтэй морийг чинь эхлээд авья гээд доголлонгоо нуусхийж зөөлөн алхсаар Чоймболын эмээлтэй моринд мордон Босгын хөтлийг чиглэн хэд шогшсоноо алхуулав. Суманхүү ганзага сампин зангидсан шовгор малгай өмссөн нь араас нь харахад ноён мэт төсөөлөгдөж байв. Гэтэл Чоймбол гэр дээр тавьсан бугаа аван

Суманхүүг би гүйцдэггүй юм аа гэхэд

Сум гүйцэх байлгүй дээ

гээд бугаа шагайв. Харж байгаа хүмүүс айн ширвээтэж зарим нь

-Тоглоом ихэдвэл шоглоом болно гэдэг үнэн шүү дээ. Энэ Чоймбол золигтой тогловол хэзээ ч ялна гэж байхгүй заавал ялагдаж төгсдөг жамтай гэж байхад өөр нэг нь

- Дааганаас унадаггүй даравгараас унадаг гэдэг дээ. Суманхүү үгээр дайрч өдчихөөд унаж яваа морийг нь булаагаад байхдаа яадаг байна. Чоймбол ч харснаа л нам буудаг мэргэн бууч даа. Энэ ер нь юу болж төгсдөг бол гэж айж байхад нөгөө нэг нь

- Суманхүү ганзага ч сумын төв рүү явмаар байна. Машинд хөл дайгаад ирсэн чинь явгараад

хоцорчихлоо гэж байсан. Тоглоом наргиа хийж байгаад Чоймбольгоо явгалаад морийг нь унаад явлаа даа. Чоймбол золиг сумтай буу галт зэвсэг барьж тоглодог нь юу ч билээ дээ гэж бодож байтал Чоймбол буугаа сумлаад зогсоогоороо зүүн гар дээрээ тавиад шагайnguут гохоо дарав. Буун дуу тасхийж ойр орчмыг цочоов. Харж байсан хүмүүс уулга алдан толгой нь эргэж нүд нь эрээлжлэв. Энэ орчимд нам гүм болов. Юу болоод байгааг хэн ч мэдэхгүй манарсан байлаа. Гагцхүү Чоймболын тас тас хөхрөх нь үлгэрт гардаг аймшигтай хар мангас хүний маханд цадчихаад хөхөрч байгаа мэт санагдан айдас төрүүлж байв. Тэрээр их дуугаар

Ноён үгүй болов оо

Нохой хуцахаа байв аа

Өрийн данс хураагдав

Өр шир дарагдав аа гээд мөн л чангаар хөхөрсөөр байв. Сэхээ орсон зарим нь айдас хургасан нүдээр дальдчин байж Суманхүүг харвал тэр мориноосоо буугаад газар сөхрөн суусан байв. Үүнийг харсан болгон дотроо наманчлан

-Ээ бурхан тэнгэр минь. Ийм ч юм болох гэж. Хайран хүн. Хөл муутай ч хөгшин эхнэртэй ч хорвоо даахгүй гэж байгаа биш хоёр гурав хоног ч бол амьд явж болно шүү дээ. Ангийн хулгайч Чоймбол чинь араатан авиртай адгийн хог юм даа гэж бодоцгоогоод нүдээ зориг муутайхан нээвэл инээдэм наадам болцгоож байв. Сайн ухаарч амжаагүй нэг нь

- Ямар муухай хүмүүс вэ? Нэгийгээ үгүй болгочихоод олон хэрээ шувуу шиг орилолдож гуагчаад байхдаа яадаг байна гэж бодоод сайтар ажиглавал Суманхүү буцаад ирчихсэн нэг гартаа малгайгаа нөгөө гартаа сампинг нь барьчихсан марсайтлаа инээгээд

Манай Чоймбол чинь

Ан хийхээ болиод

Малгайн сампин намнаж

Айлын оньс мулталдаг болжээ гэхэд бүгдээрээ нирхийтэл инээлдэх нь айж цочсон аймшигаа үлдэн хөөж амар амгаланг бүтээж чадав. Гэхдээ л Суманхүү наанаа инээж алиалж байгаа ч дотроо ихээр айж эмээсэн нь нүднийх нь харцанд нуугдаж нүүрэн дээр нь бичээстэй байв.

Түүний царай цайж шар үс нь өрвийж шанааны судас нь бүдүүрч муу хөлөө сойж зогссон ч дээлийн хормой нь үл ялиг чичирч байгаа нь айсныг гэрчилнэ. Үнэнийг хэлэхэд Чоймболын бууны сум Суманхүүгийн малгайн сампинг онож таслах үед Суманхүүд толгойн нь оройг зүсээд өнгөрөх шиг санагдаад түр зуур манаран ухаан санаа нь алдарсан билээ. Тэр сайндаа ч мориноосоо буугаагүй буух ч гэж дээ бараг уначихсан билээ. Газарт гараараа тулаад л сэхээ орж, сарнисан бодлоо төвлөрүүлэн цэгцлээд түр азнаад сайн ажиглавал малгайны нь сампин тас үсрээд уначихсан газар хэвтэж байгааг хараад дотроо

-Чоймбол золиг чинь малгайн сампинг буудсан байх нь ээ гэж бодоод малгайгаа авч

толгойгоо илж үзээд урт гэгчээр санаа алдаад сампинг үзвэл малгайд бөхлөгддөг хамгийн нарийн шилбээр нь тас буудсан байв. Тэр цагаас хойш Чоймболтой тоглоом хийдэг үеийн нөхөд бараг үгүй болсон гэдэг гэсэн нэг дурсамжийг санаад Сагад дотроо

- Энэ Чоймбол ер нь юм юмтай нөхөр шүү. Бугуйланд уран, буунд мэргэн, үгэнд цэцэн, нөхөрлөлд итгэлтэй хүн дээ гэж бодов. Балдан Чоймбол хоёр Сагадыг их л хүндэтгэн мэнд усаа мэдэлцээд Балдан

- Сагад багш минь. Энэ Чоймбол бас танд шавиар орж тэнгэрийн бичээсийг сурна гээд надтай хамт хүрээд ирлээ гэв. Сагад инээмсэглээд

- Сайн байна. Олон хүн сурах нь бидний амьдралд үр өгөөжөө илүүтэй өгнө шүү дээ. Одоо бас хүмүүс ирэх байх гэж хэлж дуусаагүй шахам төмөр дөрөөний харших чимээ сонсогдон хоёр морьтон гараад ирэв. Дуран барьж суусан Балдан

- За энэ чинь цэцэн билэгт Цагаан, суурин ноён Суманхүү хоёр шив дээ гэхэд Чоймбол

- Тийм үү: Энэ хоёр уул нь ам хуурай явдаггүй л юм даа. Яагаад ингэж амаа үдүүлсэн юм шиг чимээгүй явж чадаж байна гэж гайхав. Сагад би яаж дуугүй суугаад байх билээ гэсэн маягтай

- Тэгвэл их л сонин юм болоод байгаа байх нь ээ гэхэд Балдан

- Тэр ч тийм шүү гэсээр босов. Цагаан ч морио бөхлөчихөөд цээжээ хүгийлгэн хоёр мөрөө огшоогоод хөлөө алцагнуулан ирэхэд Балдан угтаж аваад хав барилцаад авав. Бие биенээ ээлжлэн өргөж нэг бүтэн эргүүлээд тавьснаа мөр мөрөн дээрээ гараа тавиад толгойгоо нийлүүлэн мөргөлдөж буй бух аятай их хүч гаргаж байгаа бололтой хөлөөрөө газар тулан түлхэлцээд авснаа больж дал мөрөөрөө тэврэлдэн мэндийн билэгтэй үг солилцоод

- Чи минь энэ жил царигтай байна. Хөл чанга. Ясны бял сайн байна. Онд мэнд орох нь ээ гэж Балданг хэлэхэд Цагаан инээмсэглээд

Гол нуруундаа бяргтай

Гудас ясандаа тамиртай

Гарын булчин зангираад

Хөлийн шөрмөс чангараад

Эр бие чинь хөвчрөөд

Энэ өвлийг ажрахгүй давах нь ээ гэв.

Балдан ерөөл оршиг гээд сууцгаав.

Үе тэнгийн үхэр жилтэй хоёр гэдэг шиг Балдан, Цагаан хоёр хааяа уулзахдаа ийнхүү нэг нэгнийхээ тэнхээ тамир, эрүүл мэнд, биений ерөнхий байдлыг сорьж шинжиж үздэг билээ.

Энэ нь нүүдэлчдийн соёл иргэншлийн нэгэн эрхэм ёс, хүн чанар, мөс жудаг, үерхэл нөхөрлөлийн нарийн нандин илэрхийлэл юм. Мэдэхгүй зарим нь тоглоом шоглоом хийгээд байгаа юм уу даа гэж эндүүрэх нь бий. Хөх ухаан мөнх тэнгэрээс юүлэгдэнэ. Суманхүү Чоймболтойгоо гар барьж мэндлээд

Энэ хайрхан уулын

Эзэн савдаг болсон та

Хулгар шарыг намнаа л байлгүй

Хуйхтай махаар нь дайлаач

гэхэд Чоймбол инээд алдаад

Сумын төвийн суурин ноён

Суманхүү таны хувь дутлаа

Хууль цаазны эрхэнд багтсан

Хулгар шарын аз гийлээ дээ гэхэд сонссон гурвуул зэрэг шахам

-Тэр үнэн. Хуулиар хамгаалуулчихаад гэрт орж ирэх нь холгүй байна шүү гээд инээлдэв. Тэд тэнгэрийн бичээсийг таньж мэдэх, уншиж сурах, тайлж хэрэглэх хичээлдээ орцгоов. Сагад

- Бид ерөнхийлөн мэдвэл зохих зүйлийнхээ талаар үзье. Их замбуутив гэж Сэрүүн уулнаас усан мандлын доод зах хүртэлх үйлийн оронг хэлдэг. Дорнын тив заримдаа саран, Өмнийн тив гурвалжин, Өрнийн тив дөрвөлжин, Умрын тив төгрөг болоод хий,гал, шороо, усны мөн чанарт шүтэн барилдаад нийт арван тив хэмээдэг гэхэд Суманхүү алиа хошин зангаараа биш хичээллэх дүрмийг баримтлан гараа өргөөд

- Багшаа. Төгрөг гээд байгааг юу гэж ойлгох вэ? гэхэд Цагаан чимээгүйхэн инээгээд

- Суман минь. Чиний худалдаа хийдэг өр ширэнд нэхдэг төгрөг биш ээ. Оддын гэрээр аялдаг тойрог замыг хэлж байгаа юм гэхэд бусад нь инээж хөгжихөд Сагад

- Төгрөг нь нэг үгээр дүгрэг, дугуй гэсэн утгыг агуулж байгаа юм. Манайхны дунд хүртэл байдаг. Төгрөг сартай манхан хээрийгээ гээд л дуулдаг шүү дээ. Одоо доод үндсэн дөрвөн хот мандлаа үзье. Шороо, ус, гал, хий гэсэн хот мандал бий хэмээгээд бидний сайн мэдэх нимгэн илгэн дээр арилдаггүй бэхээр бичиж, зурж тэмдэглэсэн нууц номон дээрээ зааж байв. Тэрээр

- Одоо бид цагийн хүрдийг маш сайн ойлгож авах хэрэгтэй. Гараг эрхэс тэргүүтний нэгэн бүтэн орчлыг хүрд гэдэг. Хүрдийг хоног, цаг, мөч, амьсгал, чинлүүр гэх зэргээр тооцдог. Сарны явдлын арван хоёр цаг нь нэг хоногтой тэнцэнэ. Нэг цаг хоёр арваны таван мөчтэй гэхээр нэг мөчид жаран чинлүүр багтана. Нэг чинлүүрт зургаан амьсгал багтах нь гэхэд

Суманхүү дахиад гараа өргөн

- Нэг амьсгал чинь одоогийн ямар хугацаатай тэнцэх болж байна гэж асуухад Балдан

- Тун ч зөв юм асуулаа гэж суув. Сагад түр бодолхийлснээ

- Нэг амьсгал нь дөрвөн секундтэй тэнцэх юм байна. Та бүхэн орой гэртээ очоод одод жагссаны дараа тэнгэрийг ажиглаад сар, мичид хоёрын байрлалаар уншиж ойлгосноо тэмдэглэн аваарай. Мөн сар, гар од хоёрын тохиолыг адилхан тайлж тайлбарласнаа бичээрэй гэхэд Чоймбол

- Зөвхөн өнөө орой л юм уу? гэж асуув. Сагад инээмсэглээд

- Орой болгон тэмдэглэнэ. Дараа надтай уулзахдаа авчирч үзүүлнэ. Нэг үгээр гурван зуун жаран таван хоногийн тэнгэрийн бичээсийг тэмдэглэж бас тайлбарласан байх юм. Би та бүгдийн мэдвэл зохих юмыг л заана. Энэ бяцхан номыг гээд нөгөө илгэн дээрхи нууц номоо заагаад

- Бүрэн утгаар нь бүгдийг зааж сургана гэвэл бүтэн арван зургаан жил хэрэгтэй болно гэвэл Балдан

- Базарваань. Нас хүрэхгүй юм байна гэв. Тэд газар, шороо, өвс ургамал, цэцэг навч хийгээд нарны болон тэнгэрийн өнгөний тухай хөөрөлдөөд өнөөдрийн уулзалт өндөрлөж дараагийн уулзах цаг хугацаа, газраа товлоод гэр гэр лүүгээ хөдөлцгөөв.

Удалгүй хөнгөн тэрэгний нүргэлэх дуу гарснаа чимээ алдраад нам гүм болчихов. Сагадын дэргэдээс мордсон дөрвөн морьтон ч эргээд ирж байгаа харагдав. Гэтэл малын эмч Өлзий намар цагийн хайлган үеийн малыг үргээхгүй гэсэн бололтой машинаа хол орхиод явганаар ирж яваа харагдав. Тэд мөдхөн Сагад дээр цугларцгаав. Малын эмч Өлзий нэгэн захидлыг Сагадад өгөнгөө

- Би хоёр хэргээр явна. Нэг нь таны гарт гэсэн энэ захидлыг хүргэж өгөхөөр нөгөө нь гэвэл энэ өвөл өвөлжөөлөх талаар та бүгдтэй санал солилцохоор ирлээ. Сая доктор Амархүүтэй уулзаад та бүгдийг энд байгааг дуулаад их яарлаа. Жаахан хоцорсон бол алдах байлаа шүү гэж инээгээд

- Энэ жилийн өвөл хир зэрэг байх бол гэхэд бүгд Сагад руу харав. Сагад

- Энэ өвөл цас их унана. Зарим нутагт зуд турхан ч болж мэднэ. Юуны өмнө нутгаа л сайн зөв сонгох хэрэгтэй. Нөгөө гол зүйл бол малыг дээд зэргээр тарга хүч авхуулах, хадлан тэжээлээ сайн базаачихвал айгаад байх ч юм байхгүй л дээ гэлээ. Өлзий нутгийнхаа газрын зургийг гаргах зуурт Сагад ирсэн захидлын хаягийг харснаа барилж үзээд задлахыг яарсангүй өвөртөө хийв. Өлзий эмч

- Нөгөөдөр бид өвөлжилтийнхөө төлөвлөгөөг хэлэлцэж батална. Намхай дарга Хангал дарга нар өөр нутгаар явж хүмүүстэй уулзан санал хүсэлтийг нь сонсож яваа. Би энэ хавиар өнөө

маргааш хоёр явна гэлээ. Дэлгэгдсэн зураг дээр хүн бүхэн л хараагаа тогтоон нүдээ чилээнэ. Хүн бүр л өөрсдийнхөө өвөлжөөний газар хуваарийг харна. Өлзий эмч харандаагаар заагаад

- За энэ Тахийн шар нуруу түүний бэл, Бор үзүүр, Ямаан ус, Борлог морьт, Дамбэл, Таван түнгэ, Алаг энгэр, Анал, Луусан гээд нэрлэж байхад Сагад

- Эмч ээ. Бид хавар төллөх малаа хаваржаатай нь давхар бодох хэрэгтэй шүү гэхэд Балдан

- Тийм шүү. Энэ юу гэнэ вэ? Аан Бор хавцал, Шагшиг, Эхэн сухай, Товх хүрэн, Мухар хад, Чанзав, Цагаан морьт, Сайнхүүгийн хар, Таван овоо гэж зааж уншаад

- Энэ чинь ямар сайхан зурагдсан зураг вэ? Бүх нутгаар яваад ирэх шиг санагдчихлаа гэхэд Сагад харандаагаар заримыг дугуйлаад Уушиг, Тоодогийг ус, Цэмцэг гэж амандаа хэлж өөр хэлбэрээр тэмдэглээд Алаг нуур, Гаханч, Нохонч, Өвөр хад гэж тодотгон зураад

- Энэ тэмдэглэсэн нутагт цас их унана. Энд эр сувай малыг, энд төллөх малыг, энэ хавиар нэг настай малыг, энэ хэсэгт ямааг, энд бод малыг өвөлжүүлвэл зүгээр байх гэж бодно гэхэд бусад нь нутаг ус өөрийн өвөлжөөний тухай санал бодлоо хэлэв. Өлзий эмч ихэд баярлан

- Та нөхөд үнэтэй санал онолоо өгч тус боллоо. Бас Сагадаас тэнгэрийн зургийг уншиж сурахыг зорьж байгаа чинь тун сайн хэрэг. Нам захиргаанаас дэмжиж тус болно гэхэд Балдан гараа өргөөд

- Эмч минь. Тэгэх хэрэггүй. Бид өөрсдийнхөө зөнгөөр бага сага юм мэдээд авья гэж л бодож байгаа юм гэхэд Сагад

- Манай нүүдэлчин монголчуудын шавь сургалтын нэг л хэлбэр юм. Эд нар маань сар оддын тухай мэдээд ирэхээрээ аяндаа л цаана нь ямар од байна. Их тэргэл, Улаан тэргэл, Цагаан зүг, Улаан зүг, Сарны аривал, хомсдол гээд л мэдэхийг улам их хүсч сэтгэл нь хорхойсон чихрэнд дуртай хүүхэд шиг л өөрсдөө дурлаад хүрээд ирнэ. Энэ оюун ухааны дээд өглөгийг хүн бүхэнд хүртээж чадвал сайхан амьдарч ажиллацгаах болно хэмээн сэтгэл хангалуун хэлэв.

Цагаан зүгээс сүүн гэгээ татаж нарны шаргал туяатай сүлэлдэн байв. Энэ суманд намрын шаргал наранд налайж хөлөө жийн амарч суугаа нэг ч хүн алга байлаа. Бижийн аманд тариан түрүү долгион хүчит комбайн нүргэлэн үтрэмд үр будаа цайрч цэвэршин тээрмийн эргүүлэгнээс арвайн гурил үйлдвэрлэгдэн савлагдана. Баян голын адагт төмс хүнсний ногоо боловсорч гүйцээд сортлогдон машинд ачигдана.

Арвин цагаан хөдөлмөр энд тэндгүй өрнөж бүтээгдэн, баялаг сайхан үр шим нь иссэн айраг шиг амтагдана. Эе эвийн хүчин их цагаан сэтгэлүүд элгэн тараг шиг бүрэлдэн бүлээн тамир дэлгэрнэ. Сагад олон нөхдөө үдэн мордуулаад тавгайхан сууж өвөрт байгаа захидлаа гарган задлав. Тэр энэ захидал ирнэ гэдгийг мэдэж бас хүлээж байсан болохоор тайван байлаа. Сагад захидлыг задалтал нэгэн фото зураг гараад ирэв. Үзвэл гурван настай охин хүүхдийн зураг байв. Сагад уулга алдан

-Ээ хөөрхий минь. Миний охины зураг байна шүү дээ. Аавтайгаа анх уулзахдаа ийм л

хөөрхөн амьтан байсан даа гэж амандаа шивнэн ширтэж байв. Тэр захидлыг дэлгэв.

- Сайн байна уу? Сагад гуай. Таны амар амгаланг эрье. Юуны өмнө бид өөрсдийгөө таньд танилцуулах нь зөв байх. Миний нэр Жаргал. Их сургуулийн эмнэлгийн албанд их эмч, нөхөр Гэлэг Оросд суугаа элчин сайдын яаманд цэргийн атгаше ажилтай, хүү Баатар Москвагийн их сургуульд оюутан. Бид гурвуулаа одоо Москвад амьдарч байна. Би жилийн хугацаатай томилолттой ирсэн. Энэ захидлыг би бичиж байгаа болохоор нууц нь зөвхөн та бид хоёрт хадгалагдана. Би таньд итгэж найдаж байгаа болохоор захидлаа нуршуудуу дэлгэрэнгүй бичиж бас нэгэн зураг явууллаа. Та намайг өршөөгөөрэй. Би эх хүн болохын учир бүтэн биеэсээ тасалж, бүлээн амьсгалаараа амилуулж, бүгээн сүүгээрээ амлуулж өсгөж бойжуулсан гурван настай охин үрээ сураггүй алдаад бүтэн хорин хэдэн жил амьдын хагацалд унаж бүтэшгүй эрэл хайгуулд бүдэрч бэдэрч яваа нэгэн зовлонтой эмэгтэй билээ. Би охиноо амьд мэнд яваа гэдэгт итгэдэг ч чухам хаана, ямар хүний үр сад болоод амьдарч явааг нь мэдээд царай зүсийг нь холоос ч болов харвал сэтгэл минь амарч зовлонгоос салах юм гэж санана. Би охиноо олчихоод зарга заалхай хийж өөртөө татаж авах гэж зүтгэхгүй. Тийм эрх эдлэх ёсгүй, нэр төр ч үгүй, ичих нүүр ч үгүй нэгэн гэж боддог юм. Яагаад гэвэл хүн хариуцлагаа ухамсарлах ёстой. Алдаагаа хэн нэгэн рүү чихэж түлхэх биш өөрөө үүрч хүлээх чадвартай байхыг үүрэг хариуцлага гэдэг болов уу. Иймээс би таньтай зөвлөлдөн нэгэн учир битүүлэг нууцын уяаг тайлахыг хүсэж надад сайхан сэтгэлээр туслана гэдэгт итгээд нэгэн түүхийг сонирхуулья.

- Одоогоос хорин хэдэн жилийн тэртээ зуны бүгчим халуун өдөр байв. Би хүү Баатарыгаа төрүүлэхээр эмнэлэгт хэвтэв. Гурван настай охин Хэрлэнцэцэгээ асруулахаар өөрийнхөө төрсөн дүү арван долоон настай Мөнхөөтэй хамт гэртээ үлдээв. Тэр үед манай нөхөр Москвад цэргийн сургуульд, би хотод анагаахын ухааны дээд сургуульд оюутан байсан юм. Би төрж хөнгөрөөд долоо хоноод эмнэлгээс хүүтэйгээ гараад ирэхэд охин Хэрлэнцэцэгийг минь сураггүй алдаад дөрөв хонож байлаа. Дүү маань охиныг минь олчихно гэж найдаад надад хэлэлгүй удсан байв. Би ч ухаан санаа минь орж гаран нялх биетэй уйлж унжин сандарч мэгдсэн амьтан хичнээн эрж хайсан ч олж чадсангүй. Цагдаагийн газар мэдэгдэв. Манай бүл ах Шагж гэдэг хүн дотоод яаманд тусгай төлөөлөгч байсан юм. Түүндээ ч хэлэв. Ах маань

-Эрт хэлэхгүй яав даа. Ямар ч байсан эрлийн хэсгийг өргөн хүрээтэй болгож бүх хороо хэсэгт эрэл хайгуул хийж байгаа гэв. Гэлээ ч сураг ажиг эс сонсов. Гэтэл нялх хүүхэддээ анхаарал муу тавьснаас болоод өвдөж эмнэлэгт хэвтэв. Тэр үед надад амьд явах хэрэг юу байна. Бушуухан нүд аньж орчлонг орхимоор санагдаж байсан ч улаан нялзрай хүүгийнхээ уйлах дууг сонсож урин дулаан амьсгалыг мэдрээд л тэр муу бодлоо гэж чадсан юм. Манай дүү Мөнхөө зуны халуунд охин минь унтаж байхад нь гэртээ орхиод худгаас ус авахаар очиход нь бага зэрэг дараалалтай байж таараад хүлээн зогсож байгаад усаа аваад ирэхэд нь охин минь нойрноосоо сэрээд гэрээсээ гараад төөрөөд явчихсан юм билээ. Гэтэл нэг өдөр дүү минь нэгэн морин тэрэгчин өвгөнийг дагуулсаар над дээр ирэв. Тэр өвгөн морин тэрэг хөтөлж ачаа бараа зөөдөг нэгэн байлаа. Өвгөн

- Одоогоос сар шахмын өмнө юмдаг. Жижигхэн охин тэвэрсэн нэг залууг би өглөөний таван цаг хагасын орчимд тээврийн товчоонд хүргэхээр болов. Бид нэг худгийн дэргэдүүр гарах үед

нөгөө залуу

- Ах аа түр зогсохгүй юу гэлээ. Би ч бас ус авах бодолтой байсан болохоор зогсож усаа авлаа. Тэр залуу гурав, дөрвөн настай болов уу гэмээр үс даахь нь сэгсийсэн охиндоо
- Миний охин энд байж байгаарай. Явж болохгүй шүү. Одоохон аав, ээж чинь, хүмүүс ирээд авна. Чи гэртээ очоод гоё чихэр иднэ гэж хэлээд ганц ёотон гарт нь бариулж орхичихоод ирэв. Миний уур хүрсэн гэж жигтэйхэн. Би дотроо
- Нялх үрээ хүрдэн дээр, айлын үүдэнд орхидог гэсэн. Энэ залуу чинь худаг дээр гоё үг хэлж ганц ёотонгоор хуураад орхидог нэгэн байх нь гэж бодоод
- Чи чинь яасан монголоо алдсан мал, хүн чанараа алдсан чөтгөр вэ? Нялх үрээ худаг дээр хаяад өөрөө хөдөө зугатах нь уу? гээд л хацар чихэн дундуур нь хүчтэйхэн алгадаж аваад
- Наад хог новшоо аваад буу. Чам шиг юманд би явж өгч чадахгүй гэж омогдов. Гэтэл нөгөө жаахан сэгсгэр үстэй охин
- Аав аа гэж уйлж ирээд хөлийг нь тэврээд авлаа шүү. Би дотроо
- Ээ чааваас даа. Энэ амьтныг ээ. Өөрөө хаягдах гэж байж бас аавыгаа өмөөрөөд ирж байгааг нь ээ гэж өрөвдөж би өөрөө ч ганц хоёр сохор зоос олохоо бодоод
- Наад охиноо аваад бушуухан суу гэж тушаагаад замдаа нэг ч үг дуугаралгүй явсаар тээврийн товчоон дээр очоод
- Чи наад хүүхэд орхиод үзээрэй гэж сүртэйхэн хэлэхэд тэр залуу их л итгэлтэй аялгаар
- Баярлалаа ах аа. Та надад найдаж болно гэж хэлээд том түрийвчнээсээ багсайсан мөнгө гаргаж ирээд мөнгөө төлсөн. Тэр залуу тийм ч муу хүн биш болох нь мэдрэгдсэн шүү гэж яриу. Би энэ өвгөний яриаг сонссоноос хойш зүрх сэтгэлээ чангалан
- Миний охин сайхан сэтгэлтэй хүний ивээл хайранд багтаж монгол сайхан эх орныхоо аль нэгэн нутагт амьд сэрүүн амьдарч яваа гэдэгт эргэлзэхгүй итгэх болсон. Би маш тайвнаар эрж хайсаар эдүгээ хүрсэн билээ. Надад охины минь гурван нас хүрээд авхуулсан гэрэл зураг, зоо нуруу зүүн хонгыг нь дамнасан цэцгэн хэлбэртэй хөх мэнгэ хоёр л сэтгэлд минь үлдсэн билээ. Би таньд захидал бичих болсон тухайгаа дурдъя. Над дээр ангийнхаа охидуудаар түшүүлсэн охин ирээд
- Нуруу зоондоо юм оруулчихлаа гэхэд нь би хэвтүүлээд нуруу зоог нь гаргатал цэцгэн хэлбэртэй хөх мэнгэ нүднээ тусав. Тэр үед би түр манараад нэг мэдсэн хөх цэцгэн мэнгийг нь илэн уйлж хайлж байлаа. Сэхээ оронгуутаа сэтгэлээ барин нус нулимсаа нуугаад эмчилгээгээ хийв. Дараа нь охиныг бүртгэлийн дэвтэрт бүртгэж авлаа. Мэдээж хэрэг аав нь өөр хүн байна гэж бодсон ч ээжийнх нь нэрийг хоёр удаа асуухад юу ч дуугарсангүй. Тэр ч битгий хэл ээж гэдгийг сайн ойлгохгүй байгаа юм шиг санагдсан шүү. Миний таамаглал улам л лавшраад байв. Гэртээ авчирлаа. Бүх зургаа үзүүлэв. Ганцхан миний бүл ах Шагжийг л

таньж байв. Тэр надад

- Шагж сайд манай аавын дүү гэхээс өөрийг хэлж чадахгүй байлаа. Би улам тодруулах санаатай алганы нь хээ, гарын хурууг нь хүртэл шинжиж үзээд миний охин Хэрлэнцэцэг мөн байх гэж итгэхэд хүрсэн. Би охиноо амьд мэнд байгааг нь мэдэж гэртээ авчирч гарыг нь барьж, хамтдаа цай ууж, дуу хоолойг нь сонссон. Аж төрж амьдардаг газар нутаг, аавынх нь хийдэг ажил, өөрийнх нь сурдаг сургууль, эзэмших мэргэжлийг нь мэдэж авсан болохоор боллоо гэж бодож байв. Би охиндоо

- Би чиний ээж чинь байна гэж хэлж зүрхэлсэнгүй. Бас тийм эрх, нэр төргүй гэж өөрийгөө үзсэн болохоор чимээгүй байхаар шийдсэн юм. Гэтэл сэтгэл минь надад огтхон ч захирагдсангүй. Заавал үнэнд хүрч уяаг бүрэн тайл. Утга учрыг нь нарийн мэд хэмээн тушаасны учир энэхүү захидлыг бичиж охиныхоо зургийг явуулж сайтар зөвлөлдөж авахаар шийдвэрлэсэн минь энэ билээ. Сагад гуай. Та намайг өршөөгөөрэй. Хэрвээ би эндүүрч будилж яваа бол надад охины минь зургийг энэ захидлын хамт буцаагаарай. Баяртай. Таныг гүнээ хүндэтгэсэн Жаргал гэсэн байлаа. Сагад захидлыг ийнхүү уншиж дуусгаад нямбайлан эвхэж өвөртлөөд охиныхоо гурван настай зургийг удаан харж суув. Тэр дотроо охинтойгоо анх уулзсанаа эргэн дурсав.

- Бавуу Шагжийнд очиж Хайдавжамцын Бавуу гэдэг нэрээ Жамцын Сагад гэдэг нэрээр сольж нэг үгээр нутаг заагдан маргааш өглөө нь эрт шууданд суух тушаал аваад толгойдоо олон бодол эргэлдүүлж тал сарны бүдэг гэрэлд өмнөх замаа муухан харж бүдчин явж байсныг бид сайн мэднэ. Тэр Бадамхандтайгаа уулзах хэрэгтэй гэж бодож явсан ч Шагжийн

-Ах минь. Энэ тухай хэн ч мэдэх ёсгүй шүү. Зөвхөн та бид хоёрын дунд байх нууц. Амьд яваа цагт бусад нь болно. Ийм аргаа барсан арга хэрэглэж байгаа намайг өршөөгөөрэй гэсэн сайхан сэтгэлийн үг л чихэнд сонсогдож, итгэл дүүрэн царай төрх нь нүдэнд үзэгдээд ирэх шиг болоход Сагад Бадамхандын руугаа тэмүүлж байсан сэтгэлээ хураагаад алхаж байсан замаа буруулж нэгэн хог үнсээр дүүрэх шахсан гүн жалганы эхээр тойрч явтал хоёр нохой гүйлдэн тоглож, хуцаж боргоод бас хүүхэд уйлах шиг болоод байгаад анхаарч харвал үс даахь нь сэгсийсэн бяцхан охин унтаж байгаад сэрсэн бололтой уйлж байв. Сагад тэр бяцхан хүүхдийг өргөж авахад охин хүзүүгээр нь тэврээд санаа нь амарсан бололтой дахин унтаж билээ. Сагад охиныг тэвэрч явсаар гэртээ авчраад нүүр гарыг нь угааж ойр зуурхнаар хооллож бараан цай залгилуулаад үс даахийг нь самнах гэтэл сам байсангүй. Сагад өөрөө халимаггүй болохоор сам хэрэглэдэггүй учир сам яаж байх билээ. Тэр охины үсийг гарынхаа үзүүрээр ороолдоог нь гаргах төдий самнаад түүнээс гэр орон, аав ээжийг нь хичнээн дахин асуусан ч охин юу ч дуугарсангүй.

- Мөнхөө ах аа гэж хоёр удаа дуудав. Сагад дотроо тэвдэж байлаа. Өглөө эрт явна гэж байдаг. Ойр хавьд айлд үлдээе гэхээр сайн мэдэх айл байхгүй. Бас үүр шөнөөр хэн л хаалгаа тайлж өгөх билээ. Олон дахин бодсоны эцэст өглөө эрт хүн амьтан их явдаг худаг дээр үлдээе гэж шийдсэн юм. Сагад хоёр цамц, өмд, ганц гутал хоёр жил ажиллахдаа хоолноосоо хэмнэсэн таван төгрөг дээр Шагжийн өгснийг нэмж түрийвчиндээ хийгээд охиноо тэврэн гэрээсээ гарлаа. Тэгээд л морин тэрэгчинтэй таарч худаг дээр очоод охиныг үлдээх гэсэн боловч тэрэгчин өвгөнд нэг сайн алгадуулж зэм хүртээд шуудангаас хоцрохгүйн тулд охиноо аваад явсан түүхтэй билээ.

Сагад охинтойгоо нутагтаа ирээд мужаан хийж байхдаа суурин ганзага Суманхүүг хот руу нэг явахад нь Бадамханддаа нэг захидал бичээд оёдлын артелиг сайн зааж өгөөд явуулав. Суманхүү эргэж ирээд нөгөө захидлыг буцааж өгөхдөө

- Сагад минь. Бадамхандыг олох нь байтугай тэр оёдлын артель чинь ор сураггүй алга болоод ормон дээр нь орон сууцны том барилга баригдаж байна. Манай дүү хотод удсан учир сайн мэдэх боловч Бадамхандыг олох арга байсангүй гэсэн билээ.

Сагад тэр цагаас хойш охиноо л сайн хүн болгохоор шийдэж хань ижилтэй болох тухай бодлоо бүрмөсөн мартсан. Сагад зөвхөн өвөг эцгийнхээ оюун ухааны их бүтээлийг олон түмэндээ хүргэж өглөг болгон хүртээхийг л гол зорилгоо болгосон юм. Гэтэл охин хүүхэд өсөж өндийн том болоод өөрөө нас ахиж өтлөөд ирэхийн цагт мөн л нэгийг бодож хоёрыг сэтгээд ирэхээр хорвоогийн жам ёсоор бурханы оронд залраад яваад өгөхөөр муу охин минь ганцаараа үлдээд өгнө гэсэн бодол ургаж сэтгэлийг нь зовоож эхэлсэн билээ.

Бүсгүй хүн эр хүний нөмөрт жаргадаг нь үнэн ч бас зовдог гэдгийг бодож байв. Тэнэг мунхаг нэгэнтэй учирвал түших тулах ах дүү, ойрын садан төрөлгүй амьтныг зовоож мэднэ гэж бодох тусам төрсөн эцэг, төрүүлсэн эх, зулай зулайгаа гишгэж төрсөн ахан дүүсийг нь олж уулзуулж ойртуулах нь зөв болохыг ойлгож мэдсэн дээ гэж бодоод Сагад охиныхоо зургийг өвөртөө хийгээд гэрийн зүг хандав. Сагад охиндоо

- Энэ өвөл яггүй болж мэднэ. Энэ хэдэн малдаа махан таргыг нь сайн чамбайруулж өөхөн таргыг нь жаахан зузааруулж авахгүй бол өвлийн өлчир жавар, гурван есийн хүйтнийг давж чадахгүй болж мэднэ. Аав нь өглөө эрт бэлчээж, орой аажим хотлуулж идэшний цагийг нь уртасган хужир борзон, ааг сайтай ургамалтай бэлчээрт хөлийг нь хорьж байнга дагахаас болохгүй нь бололтой. Миний охин номынхоо бичиг цаастайгаа шургуухан ноцолдоод байгээд өглөө бүр эрт малтайгаа явна.

Хөхцэцэг гэр орноо цэвэрлэж байтал авдар дээр аавынх нь илгэн номын дээр нэг фото зураг байж байв. Хөхцэцэг сайн ажиглавал өмнө үзэж байсан санагдав. Тэр зургийн ард “ Охин Хэрлэнцэцэг. Гурван нас хүрч байв” гэсэн байлаа. Түүний санааны үзүүрт

- Би энэ зургийг Жаргал эмчийнд үзсэн шүү дээ. Яагаад аавд байдаг билээ. Энэ зураг хоёр хувь болох гээд байна. Энэ Хэрлэнцэцэг гэдэг хэн байдаг билээ? Энэ зургийн ард ямар нэгэн нууц зүйл нуугдаж байгааг зөн совингоороо Хөхцэцэг мэдрээд байлаа.

Аав минь ээжийн тухай огт ярьдаггүй хүн. Гэтэл Жаргал эмчийн тухай надаас сонссоноосоо хойш “ Ээжийн чинь тухай энэ Жаргал эмч л сайн мэдэж байх ёстой болох нь” гээд сайхан зантай байсан. Аав Жаргал эмч хоёр бие биенээ танихгүй мөртлөө Шагж ах аавыг ах гэдэг. Жаргал эмч бүл дүү нь байдаг. Энэ учир зүггүй ороолдсон утасны учгийг тайлж утгыг нь олох цаг ирнэ байх. Жаргал эмчийг би урьд өмнө таньдаг дотнын хүн шиг минь санагддаг нь ямар учиртай юм бол доо гэж бодоод Хэрлэнцэцэг охины зургийг байснаар нь буцааж тавив.

Гучин найм

Орчлонгийн түм буман нугалаасанд хүний амьдралын үйл мөр өөр өөрийнхөө заяа төөргөөр үргэлжилж байлаа. Хөшөөтийн голын сохор Балбар өвгөний бие лагшин чилээрхэж үр хүүхэд ач зээ нараа сандаргав. Балбар ач хүү Амархүүтэйгээ аминчлан дотно яриа өрнүүлэв. Тэрвээр

- Миний хүү. Өвгөн аав нь чамайг нэг чухал юманд заръя. Бас л нууц гэмээр юм уу даа. Энэ нэг хадаг, дээлийн өнгө хоёрыг Хөвчийн нурууны дуугүй Хайнзанд хүргээд өгчих. Бид хоёр ч бие биенээ бараг танихгүй шахам хүмүүс. Өвөөгийнхөө нэр, цол, гуншинг сайн дурдаад бие нь ядраад байна гэж хэлээрэй. Өөр олон юм битгий хэл. Надад хэрэгтэй юмыг хийж чадах хүн энэ хүнээс өөр байхгүй юм шиг санагдана. Тэгээд миний хүү Сагад багш дээрээ очоод завтай бол нэг хүрээд ирээч гэж гуйж байна гээд дамжуулчихаарай гэв. Амархүү доктор ч өвгөн аавынхаа тушаалыг нэн даруй биелүүлж Хөвчийн нурууны Хайнзан гуайнд очиж Балбар өвгөний хэлсэн ёсоор үгийг нь дамжуулбал Хайнзан мөн л хайнгадуухан байдлаар

- Хөшөөтийн голын Балбар гэж сонсож байснаас зүсийг нь үзээгүй билээ. Энэ хол газар хүн зарж над руу явуулж юу хийнэ. Сохор хүн биш байна шүү дээ гэхээс өөр юу ч хэлсэнгүй. Хадаг дээлийн өнгийг ч авсангүй. Амархүү баруун орон дээр нь үлдээгээд гарав. Тэр хойноос ямар нэг юм хэлэх байх гэж бодож байсан ч Хайнзан үг хэлэх нь битгий хэл суудал дээрээсээ ч хөдөлсөнгүй. Энэ хүний муухай зан гаргасанд гомдсонгүй харин өвөг аавыг нь сохор биш гэж үнэнийг нь хэлсэнд гайхав. Амархүү өвөөгийнхөө даалгавраар Сагадынд ирэхэд Сагад байсангүй. Тэр Хөхцэцэгтэй хэдэн хором ярилцаад

- Танай ангийн Хөнхий захирал Сэмбэрүү эмч хоёр удахгүй хуримаа хийх гэж байгаа гэхэд Хөхцэцэг инээгээд

- Юун сайхан юм бэ? Анги дотроо тэр хоёр маань айл гэр боллоо доо. Манай ангийнхан ч тэр хурим дээр цугларах юм байна даа гээд аавынхаа яваа зүгийг зааж өгөв. Сагад мэргэн Амархүүгээс өвөө аавынх хүсэлтийг сонсоод

- Ах нь малаа хотлуулчихаад л давхиад очъё. Шөнөөр л хамаг ажлаа амжуулахгүй бол өдөр нь энэ хэдэн малаас салж болохгүй байна. Намайг очиход чи байвал сайн байна. Бид гуравт зөвлөлөдөх юм бас бий гэлээ. Амархүү баярлан

- Би таныг хүлээж байя гээд мордов. Тэр залуу хүний хийморь золбоогоор мориндоо мордоод л дөрөөнд босож тоос татуулан давхихад молор эрдэнийн дөрвөн туурайд дэлдэгдэх чимээ бөмбөрийн дуу шиг нижигнэж байлаа. Сагад энэ бүхнийг харж, сонсож зогсохдоо охиныхоо тухай л бясалгав. Хөхцэцэг ааваасаа

- Энэ жижигхэн охины зураг хаанаас гараад ирэв ээ? гэж асуухад Сагад дуугарсангүй. Хөхцэцэг

- Аав аа. Энэ зураг чинь Жаргал эмчийн охины зураг байна шүү дээ. Надад бас үзүүлж байсан. Тантай ямар холбоотой юм бэ? гэхэд Сагад инээмсэглэн

- Харин л дээ. Чи сайн ажиглаад байгаач. Хэнтэй төстэй байна гэхэд Хөхцэцэг хэсэг харж байснаа

-Ай мэдэхгүй. Дэндүү бүдэгхэн юм. Урд өмнө харсан болоод тэр үү таньдаг ч юм шиг санагдаад байх юм гэхэд Сагад

- Тэгвэл таньдаг л байх нь дээ гээд инээв. Хөхцэцэг бодол болж энэ учир битүүлэг нууцын эзэн нь өөрөө ч юм шиг санагдана. Тэр хэд хэдэн удаа энэ зураг чинь арай миний зураг мөн юм биш үү гэж бодож билээ. Гэхдээ ааваасаа асууж чадаагүй юм. Хөхцэцэг зориг зүрх гарган байж ааваасаа

- Ааваа энэ Хэрлэнцэцэг охин чинь би юм уу? хэн юм бэ? гээд сонирхсон аястай мөртлөө айсан нүдээр харж асуухад Сагад дотроо

- Миний охинд гэнэт ийм юмыг мэдэх гэдэг тийм ч амар байхгүй нь мэдээж. Тийм болохоор аажимхан мэдэж дассаар байгаад аав, ээж дүү нартайгаа уулзах нь амар байхгүй юу гэж бодоод

- Миний охин юундаа яараав. Аяндаа л учир нь олдож, уяа нь тайлагдана шүү дээ. Хүлээж л байхгүй юу гэж битүү бүрхэг юм хэлээд чимээгүй болов. Тэр цагаас хойш дахин энэ тухай асуугаагүй билээ. Хааяа бодол болон суугаа охиноо харахаараа Сагад дотроо

- Миний охин сайн бясалга. Аав нь охиноо сэтгэлдээ амар тайвныг бүтээж чадаж байгаа гэж итгэж байна гэж бодно.

Сагад хонио хотлуулж яаруухан хоол цайгаа зооглоод Балбар өвгөний рүү хөдлөв. Сар аажим гарах учир мандахыг нь хүлээсэнгүй. Сагад ямар ч харанхуй манан буданд төөрдөггүй бол хүрэн морь нь зам харгуйн бартаа өөнд явахдаа гарамгай билээ. Балбар өвгөн ач хүү Амархүүтэйгээ хоёулаа Сагадыг хүлээж байв. Балбар өвгөн

-Бие минь жаахан ядраад одоо гайгүй боллоо. Хадан гэр лүүгээ явах болоогүй бололтой. Надад бас хоёр гурван жил байна гээд инээхэд Сагад

- Та хоёртой нэгэн зүйлийг зөвлөлдөж ярилцмаар байна. Балбар гуайг сохор биш гэдгийг бид гурваас өөр хэн ч мэдэхгүй билээ. Одоо энэ олон түмэн, үр хүүхдүүд, ах дүү нар чинь мэдэх хэрэгтэй гэхэд Амархүү гайхан өвөө рүүгээ харахад Балбар

- Сагад минь. Тийм юм байхгүй ээ гээд их л дургүйцэж байгаа бололтой гараа савлав. Сагад

- Ах минь. Та энэ насаа заавал сохроор төгсгөх хэрэг юу билээ. Та ертөнцийг харж байгаа нь үнэн боловч таныг хардаг боллоо гэвэл хичнээн олон хүн баярлахыг та бодож үзсэн үү? Ядахдаа л үр хүүхдүүд, ач, зээ нарын чинь сэтгэл цэлмэнэ шүү дээ. Өвөө нь сохор гэж дуудуулж сонсож яваа хүүхдийн сэтгэл хичнээн их эмзэглэдэгийг та мэдэх үү? Сайн бод.

Өнөөдөр шинжлэх ухаан өндөр хөгжлөө. Амархүү доктор та өвөөгөө аваад хот яв. Балбар гуай хотыг үзээд улс орныхоо хөгжил дэвшлээр нүдээ цэнгүүлж сэтгэлдээ омогшоод аваг. Долоо

хоноод ирэхдээ нүдэндээ эмчилгээ хийлгээд хараа ороод ирлээ гэхэд л болно. Таны сохор байсан, хараа орж хардаг болсон нууцууд бас л бид гурвын дунд хадгалагдсаар байх болно шүү дээ. Таныг нүдэндээ эмчилгээ хийлгээд хардаг боллоо гэхэд бид сумаараа баярлах болно. Баярласан хүн бүрийн нас нэмэгдэж байдаг юм гэнэ лээ гэхийг Балбар, Амархүү хоёр анхааралтай сонсоод бодлогоширон байснаа Амархүү

- Өвөө энэ чинь ёстой сайхан санаа байна шүү гэхэд Балбар хашираас гашуун гарахгүй гэсэн байдалтай яаран дуугарсангүй хэсэг болоод

- Болж бүтвэл ч уул нь зүгээр л юм л даа. Би гэдэг хүн сохорчихлоо гэж бүхнийг хуурч мэхлээд дөч тавиад жил болчихлоо. Одоо үзэж хардаг болчихлоо гээд бас л олон түмнээ хуурч мэхлэх болох нь дээ гэхэд Сагад

- Таны эхний ухаан чинь амь нас, ахан дүүсийн тангараг дамцгийг аварч хоцорсон нь үнэн. Харин танд эргэж нүдтэй болох боломж олдоогүй. Та анх сохор биш гэдгээ Амархүүд мэдүүлчихээд хичнээн их баярлаж байлаа.

- Намайг сохор биш гэдгийг хорвоо дээр нэг ч гэсэн хүн мэдэж байгаа нь сайхан гэж баярласан. Дараа нь надад хэлээд

- За боллоо. Хоёр хүн мэдэж байгаад сэтгэл минь сайхан байна гэсэн. Тэгвэл одоо олноороо мэдвэл бүр ч сайхан шүү дээ. Та өнөөдөр эрх чөлөөгүй хүн бүхнээс нуугдаж бүгж амьдарч байна. Харахад наранд амьдарч байгаа юм шиг мөртлөө харанхуй нүхэн тамд байгаатай ялгаа алга. Үнэхээр сохор бол би элдвийг бодолгүй тайван байж чадна. Харж байгаа мөртлөө таг сохроос илүү айж шаналан, аргаа барж үйлээ үзэж амьдаараа зовж амьдрахаа боль. Би танд үүнээс илүүгээр тусалж чадахгүй. Харин нууцыг бол хадгалж чадна гэлээ. Тэд сайтар ярилцсаны эцэст Балбар өвгөний тэнхээ ядруу байгааг хүн бүр мэдэж байгаа энэ цаг үетэй давхцуулан ач хүү Амархүү нь хот авч яваад эмнэлэг сувилалд хэвтүүлэн биеийг нь тэнхрүүлээд улсынхаа нийслэлийг үзээд ирэхдээ Дорнын зүүний эмчилгээ, бариа заслаар эмчлүүлээд хараа ороод ирлээ гэж найруулахаар тохиролцоцгоогоод Сагад шөнө дөлөөр гэр лүүгээ буцав.

Балбар өвгөн тэнхээрхээд ач хүү Амархүү нь хот руу аваад явсан гэнэ гэсэн яриа дорхноо л хүн бүхэнд хүрэв.

-Ач ам барина гэдэг дээ. Настай өвгөн хүнийг ядруу байхад нь хол газар авч яваад замын ая даадаг л байгаа даа гэж зарим нь бодож байхад

- Амархүү ч том доктор хүн. Зүгээр хараад сууж чадаагүй байх. Одоо чинь анагаах ухаан өндөр хөгжчихсөн. Элэг зүрхийг хүртэл сольчихож байна. Юмыг яаж мэдэхэв. Балбар өвгөн нүд орчихоод ирэх ч юм билүү хэн мэдлээ гэж байхыг сонссон нэгэн

- Ашдын билгээс амны билэг гэж байдаг. Нүдтэй болчихоод тэвхэлзтэл алхаад ирээсэй. Балбар ч нүдтэй байсан бол сайхан барилдана. Морь сайн уяна. Бичиг үсгэндээ тун ч мундаг гэдэг юм билээ. Аль нэг дарга хийгээд явж байх л байсан хүн шүү дээ. Сохор хүний зовлон ч ямар барагдах биш дээ гэхэд бас нэг нь

- Сохор, дүлий бүгд л адилхан байх аа даа. Дээр үед нөгөө муу буурал өвгөнийх Төхөмийн хоолойд намаржиж амны усаа холоос зөөдөг байж гэнэ. Өвгөн чих нь хатуу дандаа л буруу зөрүү сонсож уурлаж уцаарлана. Гэтэл нэг өдөр гэрийнх нь гадаа ухна ямаа хөөж дуугарахад ӨВГӨН

- Ус өгөөч гэж буруу сонсчихоод уцаарлан

- Манайд ус байхгүй гэснээ амандаа

- Дандаа л ус гуйна шүү. Өөрсдөө яваад авахад яадаг юм гэж үглэж байсан юм гэнэ лээ гээд инээдэм болж байв. Удсан ч үгүй аяганы хариу өдөртөө агтны хариу жилдээ гэдэг шиг билгийн үгний хариу ерөөл юм байлгүй

- Балбар өвгөн хараа ороод ирж гэнэ гэсэн сүүн өргөлтэй сайхан үг Бугат сумын төвөөр цуурайтаж дөрвөн хайрхан, уул нурууд нь давтан түрж нутгийн түмэн олон баярлан угтав. Тэд улс орон, анагаах ухаан хөгжсөнийг ам булаалдан чихэнд чийр болтол магтацгааж байв. Балбар өвгөнд хүн бүр ирж баяр хүргэн дээд нэг нь хурдан морь бэлэглэж байхад дагалдаад ерөөлийн үг урсаж байв.

Судар бичигт нарыг ертөнцийн нүд гэдэг билээ. Тэгвэл хүний нүд бидэндээ нар нь бололтой. Хүн бүхэн

-Зуу насалж зургаадай таяг тулаарай гэж ерөөл өргөхөд Балбар өвгөн сэтгэлдээ хүч нэмж биеэ тэгшитгэн дотроо

- Бурхан минь би зуу наслах байх шүү гэж дотогшоогоо инээснээ бууны хүйтэн ам үмхэх шахаад хярсан туулай шиг хадан дунд хэвтэж байснаа санаад амьд явахын сайн ерөөл, утга учир, баяр жаргаланг ойлгон мэдэрч амьдралыг улам хайрлаж байв.

Балбар гэртээ ирж нэг хоноод л өглөө эрт босож морио авчирч эмээллээд бага сага чихэр жимс богцонд хийж ганзгалаад ганцаараа хөдлөв. Тэр өөрийнхөө дураар хэнийг ч гуйхгүй, хэнээс ч айхгүй, сэтгэлдээ амар амгаланг бүтээгээд бие хөнгөн шингэн явж байгаагаар сайн мэдэрч

-Сагадын хэлээд байсан эрх чөлөө гэдэг чинь энэ байх нь. Юунаас ч нүдээ нуухгүй явах гэдэг юутай сайхан юм бэ. Би сохор гэж байхдаа бүхнийг харж байсан ч ийм үзэсгэлэн гоо, өнгө төгөлдөр, эрх чөлөөг мэдэрч байсангүй. Би нүд биш сэтгэлээ сохолж явсан байх нь гэж бодсоор Бунханы хөтлийн аман дахь Бунхан шарил дээр ирэв. Тэр бууж мөргөж байхдаа хэнээс ч айхгүй, ичих зовох юмгүйгээр чанга дуугаар “Их Аграмба Авирмэдийн Чоймжуур” гэж уншаад гурван удаа мэгзэмийг дуудав. Тэр амандаа

- Энд хэн нэгний шарил биш А.Чоймжуур аграмбын оюун ухааны бүтээл эрдэм номын хүчит их цагаан тамир оршиж байгаа юм гэж сүсэглэн хэлэв. Тэр цааш бөг бөг шогшуулж байснаа шодон буурлынхаа амыг татан гүн сайвар алхаагаар намбалаг явж одов. Балбар шулуухан явсаар Сагадын гадаа очоод

- Нохой хорио гэхэд Сагад гарч ирээд Балбар өвгөнийг танингуутаа

- За ах минь сайн явж ирэв үү? гэсээр угтав. Энэ хоёр эрхэм хүмүүс ичиж айх юмгүйгээр ярилцаж цай хоол зооглов. Балбар Сагадын хийж буй номны тухай сонсоод ихэд баярлан

-Эцэг өвгөд эцгийнхээ нэр төрийг өргөж явааг нь зөв гэж бэлэгшээгээд

- Би чинь тэнэг мунхаг хүн байжээ. Амьд мэнд яваагаа л эрх чөлөө гэж бодож байв шүү. Гэтэл тэр эрх чөлөө чинь огт өөр олон юманд хамааралтай аугаа юм байж гэхэд Сагад инээгээд сайхан харж

- Та өөрийнхөө дураар дуртай юмаа хийж, хүссэн бүхнээ гүйцэлдүүлж байгаагаа сайн ойлгож дээ гэхэд Балбар

- Ойлголгүй яахав. Сохор хүн гэж юу ч хийлгүй олон жил болсон болохоор миний бие их гамтай байжээ. Санасныг бодоход цариг гайгүй байна шүү. Би чинь сумдаа ирэхдээ нэг нүдний шил зүүж ирэв ээ. Сагад минь. Хамар аман дээр дараад түвэгтэйг яана. Хүмүүс юун шил вэ гэж асуухаар нь

- Сохор нүдээ гэрэл гэгээнд, салхи шуурганд дастал зүүж бай гэсэн юм аа гээд байлаа. Өнөөдөр наашаа явахдаа гэртээ мартаад гараад ирж гэлээ. Сагад

- Одоо санаа зовох юу байхав. Ах минь өөрийнхөө дураар сайхан амьдрах хэрэгтэй. Та олон хүнийг баярлуулж хүслийг нь биелүүлж чадлаа гэхэд Балбар

- Сагад минь. Чиний л ач буянаар олонд хүндлүүлж эрх чөлөөтэй болж авлаа. Ах нь дүүгийнхээ тусыг хэзээ ч мартаггүй гээд гэр лүүгээ буцав.

Энэ үед Хөвчийн нурууны дуугүй Хайнзан өвгөн Балбарыг хараа ороод иржээ. Олон жил сохор байсан нүд хараа ордог л юм байна даа. Хүний хувь тавилан аз л байх даа гэж ярилцахыг сонсоод ганц ч үг хэлэлгүй дотроо

-Балбар өвгөн ч тун ч тэвчээртэй хүн юм даа. Энэ олон жил сохор хүн болж явах ч амаргүй байсан байх. Тэгээд сайн цаг дөхөөд ирэхээр хараа орчихлоо гэж байдаг. Мөн ч ухаантай суу заль ихтэй хүн байна шүү. Дуганч байсан болохоор баривчлагаанд өртвөл шууд л дээд хэмжээ авах байсан. Сохор болсон нь аминд өлзийтэй гэдгийг сайн л бодсон байна.

Би зүүдэндээ нэг урт сахалтай өвгөнийг үзээд сохор гэж өрөвдөж байтал над руу нүдээ ирмээд

- Танд итгэж найдаж байгаа шүү гэхэд нь би түүн рүү нүдээ ирмэхэд тэр инээд алдаад нөгөө нүдээ ирмээд

- Таны баруун нүдний дээд сормуус хорин найм юм байна. Яагаад нэг илүү байдаг билээ гэж надаас асуухад нь би юм хэлэх гэтэл

- Миний нүдний дээд сормуус шувуу болоод нисэв. Гэтэл тэр өвгөний хоёр нүдний дээд

сормуус бас л шувуу болоод нисэхэд тэрээр урт сахлаа шувтран

- Ямар гоё юм бэ? гурван шувуу гэж хэлээд инээгээд л байв. Би ч сэрэв. Тэр өвгөний сайхан инээд чихэнд сонсогдсоор л байв. Зүүдээ тайлж учрыг нь олъё гээд үзэхэд

- Хүнээс хэл сонсоно гэсэн байв. Гэтэл Балбарын ач хүү ирээд сохор Балбар гэж тодхон хэлэв. Би үүнийг сонсоод

- Ээ тийм байх нь. Зүүдний минь тайлал одоо л олдлоо гэж бодоод ач хүүд нь

- Сохор хүн биш гэж хэлэхэд тэр хүү чимээгүйхэн гараад явчихсан даа гэж бодож байв. Хайнзан цааш нь зүүдээ задалж

- Тэр өвгөний сахал нь их урт өвдгөө хүрч байсан. Энэ Балбар зуугаас дээш наслана шүү. Сахлыг насны билэгдэл гэж тайлбарт заадаг. Тэр гурван шувуу нисээд байгааг хоёр ч утганд тайлж болох юм. Балбар хоёр нүдтэй биш гурван ч нүдтэй байх нь. Гурав дахь нь оюун билэг нь болж байна. Тэр хоёр нүдээ ээлжлэн ирмэсэн. Би нэг нүдээ ирмээд гурав болж байгаа нь надаас насны гурван бурханы авшигийг хүртье гэж хүссэн байхад бас заслын гурван гүрэм номыг уншаарай гэж сануулж байгаа хэрэг. Хадаг дээлийн өнгө хоёрыг явуулсан нь нэгэн тэнгэр дор бурханы мэлмийд багтаж өлмийд мөргөж авралд нь даатгагдан маанийн зургаан үсгийг сэтгэлдээ залж амандаа хүлхдэг нь та бид хоёр л байна шүү. Хоёулаа бие биенээ болгоож хамтдаа явья гэсэн ерөөл байх нь. Энэ Балбар өвгөний ухааныг хэн ч гүйцэхгүй бололтой. Нүдтэй болоод ирдэг нь болж дээ.

Бид хоёрын уулзах болзоо ч ойртоод л байна даа гэж бодож байхад сумын захиргааны нэгэн албан өрөөнд хариуцлагатай албан хаагч намын гишүүн Ширмэн бүхий л хавтастай бичиг хэргээ дэлгэн цаасан далай дотор живэх шахам сэлж хааяа урт амьсгал аваад бодолд шумбана. Энэ бол бидний эртний танил Бунхан салааны амны бунхан шарилын хөшөө чулууны бичээсийг уншин утгыг тайлахаар зүтгэж байдаг намын гишүүн албан хаагч Ширмэн билээ. Тэр нөгөө бичгээ эрж хайж олохгүй цөхрөнгөө барж суугаа нь энэ. Балбар өвгөнийг хараатай болоод ирж гэнэ гэдгийг дуулснаас хойш нөгөө бичээсийг зурсан цаасаа эрж мунгинан байгаа энэ хүний зовлонг бусад нөхөд, дарга нар нь огт мэдэхгүй тоохгүй байгаад нь заримдаа гомдоно. Намынхаа батлахыг барилж үзээд омогшин гомдлоо гээнэ. Үеийн зарим нөхөд нь Ширмэнд

- Миний найз биеэ бодож байгаач. Ингэж зүтгэж явсаар байгаад нэг мэдэхэд л унаад өгнө шүү. Хэдэн хүүхэддээ хэдэн жил харагдахаа бодооч гэхэд тэр их л учирлан

- Ажил албаа хашвал хийсэн шиг хийх хэрэгтэй. Ажлаа л сайн хийж байвал амьдрал сайхан болно шүү дээ. Манайханд биеэ оторлох бусдын хөдөлмөрийг мөлжиж сорж амьдрах гэсэн бэртэгчин хүмүүс мэр сэр байгаад байна. Тэдэнтэй уйгагүй тэмцэж ухуулан сурталчилж байж зөв зам руу оруулна. Тэр битгий хэл гээд л дуу нь улам чангарч өндөрсөөд

- Нам төрийн эсрэг буруу бодол санаатай эсэргүү нарын үлдэгдэл шаар шавхруу ч чийгний улаан өт шиг матигнаж байхыг үгүйсгэх аргагүй гээд “ Чийгний өт” гэж нэрлэсэндээ өөрөө баясан эргэн тойрноо харснаа инээд алдаад

- Түүнийг бид нэгэн зорилготойгоор бяц гишгэвэл зохилтой гээд гараа өргөнө. Нөхөд нь түүнийгээ цаашлуулан

- Манай хүн ч жанжин Сүх шиг уран илтгэж урам хайрлаж байна шүү гэхэд тэр их л ухаалгаар

- Хүн нэг л зорилго чиглэлдээ үнэнч байх нь чухал. Урваж шарваад хоёр нүүр гаргаад байгаа хүнд би угаасаа дургүй. Иргэн хүн бол нам төрийн төлөө л үнэнчээр зүтгэх ёстой. Энэ бол миний үзэл баримтлал мөн. Би үүнээсээ хэзээ ч эргэж буцахгүй гэж омогшин хэлнэ.

Ширмэн ийм л шударга зантай нэгэн билээ. Энэ нь хүн бүрт л байх ёстой сайхан чанар бусдадаа үлгэр дуурайлал болох итгэл найдвар өгөх эрхэм ёс байв. Ажил хийж байгаа хүн алдаа дутагдал гаргах нь хааяа байдаг л асуудал. Энэ хүн ч ялгаагүй заримдаа дэндүү туйлширч хөнгөн гоомой хандах нь бий. Тэр гэнэт сэрсэн мэт босон харайгаад хоёр алгаа үрэн инээд алдаад

- Би өөрөө явж Балбар өвгөнийг дагуулаад тэр бунхан шарил дээр очоод хөшөө чулууны бичээсийг уншуулаад авъя. Хэн бичсэнийг нь бас мэдье гэж шийдсэн учир ийнхүү хөөрөн баярлахад хүрсэн байв. Тэр алив нэг ажлыг хийхээр шийдсэн бол нэг мөр зүтгэдэг хүн. Өмнө хэдэн жилийн тэртээ энэ бичээсийг цаасан дээр дуурайлган биччихээд Балбарынд очиж түүх сонсоод, Сагадынд хонож морио боохойд алдан явгарч Хөвчийн нурууны дуугүй Хайнзанд амаа таглуулаад Амархүүтэй уулзаж эрлээ мухарлаад эцэст нь намрын хадланчдаас ам алдуулах гэж байж бунхан шарилыг магтсан хэргээр намын даргаасаа сануулга авч байсан хүн.

Өнөөдөр хэнээс ч үүрэг даалгавар аваагүй мөртлөө өөрийнхөө дураар ийнхүү Балбарын луу мордов. Тэр Балбар өвгөнийг дагуулсаар Бунханы амны бунхан шарил дээр ирж буув. Балбар морио бөхлөөд бунханыг гурав тойроод өмнө нь ирж суугаад мөргөв. Ширмэн маань өөрийн мэдэлгүй нэг л мэдсэн Балбар өвгөнийг даган гурав тойроод зэрэгцэж суугаад мөргөж байлаа.

Гэтэл гэнэт сүр сархийн хөнгөн тэрэг ирээд тооромзлов. Ширмэн мөн л цочин айсан нүдээр харвал намын үүрийн дарга Намхай тэргэнээсээ буугаад ирж яваа харагдав. Түүний зүрх зогсчих шахав. Тэр айсандаа бүх бие нь чичирч байв. Босох гэсэн боловч чадсангүй хөл нь хөдөлсөнгүй. Сөхөрч суугаад залбирсан хэвээрээ л байлаа. Намхай дарга Балбар өвгөнтэй мэнд мэдэлцэн биеийн байдлыг нь асууж мэдээд

- Өвгөн минь сайн байна. Одоо нүд чинь зүв зүгээр биз гэхэд Балбар

- Зүгээр ээ. Хөөрхий минь нам засаг та бүгдийн минь ач буян гэв. Ширмэн даргаасаа санаа зовон их л хулчигнасан байдалтайгаар

- Дарга аа. Би Балбар гуайгаар энэ бичээсийг уншуулж утгыг нь олох санаатай л яваа юм гэхэд Намхай дарга инээгээд

- Учрыг нь олохоосоо өмнө сайн мөргөөд авдаг чинь сайн боллоо. Одоо тэгээд утга учрыг нь

асуугаач. Би ч бас сонсож мэдье гэв. Гэтэл байдал буруугаар эргэж Балбар өвгөн Ширмэнгээс

- Танай аавын нэр хэн билээ гэж асуув. Ширмэн гайхан Намхай дарга руу харав. Намхай
- Өвгөний асуултанд мэддэг бүхнээ хариулах болно шүү дээ гээд инээхэд түүний сэтгэл жаахан боловч тайвшраад
- Сүндэв гэж товчхон хариулахад Балбар
- Сүндэвийн аав, чиний өвөг эцэг хэн бэ? гэлээ. Энэ удаа Ширмэн эргэлзсэнгүй
- Гунгааням гэлээ. Балбар
- Гунгаанямын ахыг мэдэх үү? гэхэд тэр
- Муухан мэднэ. Нэрийг нь сонсож байсан. Агваанням гэхэд Балбар
- Аавынхаа отгон дүү нэг эмэгтэй байсны нэрийг мэдэх үү гэж асуухад Ширмэн Балбарыг гайхсан нүдээр хараад энэ нөхөр яах санаатай юм бэ? гэж дотроо бодоод
- Муухан мэднэ. Дэжидням гэсэн байх аа гэж мэдэн будилав. Балбар өвгөн төлөв байдлаар
- Энэ бичээсийн дор танай аавын аав чиний өвөг эцэг Гунгаанямын төрсөн дүү Дэжиднямын хань Их аграмба А. Чоймжуур гэдэг хүний оюуны бүтээл их цагаан тамирын бумба заларч байгаа юм. Агваанням хамба насан өөд болтлоо энэ бумбанд ирж мөргөдөг байсан даа гэхэд Намхай
- За Ширмэн минь. Чиний мөргөдөг зөв юм байна гэхэд Ширмэн
- Дарга аа намайг уучлаарай. Би сайн мэдэхгүй шүү дээ гэж ээрэгнэн хэлэхэд Намхай дарга
- Энэ том эрдэмтний чинь зохиосон тэнгэрийн бичээсийн тайлбар толь гурван ботийг манай Сагад охинтойгоо дэлгэрүүлэн хэвлэлд бэлтгэж байна шүү дээ гэснээ Балбарт хандан
- Балбар гуай. Манай Ширмэнгийн аав Сүндэвийн авга эгч Дэжиднямаас гарсан Ширмэнгийн бүл дүү болох хүүхдийг хэн гэдэг билээ гэхэд Балбар
- Дарга аа та Ширмэнгээс асуугаач гэв. Ширмэн дарга өөдөө харав. Намхай дарга
- Ширмэн минь чи тэр нэрийг сонсож байсан уу гэхэд Ширмэн ихэд сандран дотроо
- Одоо л болохоо байлаа. Төвд рүү явчихсан Хайдавжамц гэж хүн байх учиртай гэж аав ярьж байсан. Би ч одоо бүр оргодол эсэргүү нарын удам угсааны хүн болоод явчихлаа гэж бодоод
- Би сайн санахгүй байна гэж худал хэлэхэд Намхай дарга

- Худал хэлвэл хуультай шүү хөө гэхэд Ширмэн айж учраа олохгүй байтал Намхай дарга
- Хайдавжамц гэж тодхон хэлэхэд Ширмэн бондгосхийн цочоод
- Аа тийм. Хайдавжамц гэж сонсож байсан юм байна гэж бүдэгхэн хэлэхэд Намхай
- Хайдавжамцын хүүг мэдэхүү? гэж асуухад Ширмэн бүүрч ихээр сандарч
- Дарга аа намайг өршөөгөөрэй. Би ёстой мэдэхгүй хэмээн үнэнээ өчив. Намхай дарга ергөөтэй маягтай инээгээд
- Балбар гуай та Хайдавжамцын хүү хэн болохыг Ширмэнд хэлээд өгөөч гэхэд Балбар
- Хайдавжамцын ганц хүү чинь Сагад мэргэн юм шүү дээ гэхэд Ширмэн ухаан алдаж унах нь уу гэмээр сөхөрч суугаад
- Энэ чинь юу болоод байна даа дарга аа. Би ингээд балардаг байж гэхэд Намхай, Балбар хоёр инээд алдаад Намхай
- Ширмэн минь. Чи чинь юугаа яриад байна аа гэхэд Ширмэн амаа ангайж хэсэг болоод
- Сагад бид хоёр чинь бөөсөө хувааж идэх бүлэнцэрүүд байсан байна шүү дээ. Би түүний нүүрийг яаж харна аа. Байнга хардаж сэжиглэн тандаж явсан шүү дээ гэхэд Намхай дарга
- Чи зөв л хүнээ сэжиглэж байж. Одоо ажил их байна. Балбар гуайд морио орхиод эмээлээ аваад надтай хамт буц. Манай сум чинь нэг хөдөлмөрийн баатар, хоёр гавьяаттай болох нь гэхэд Балбар залбирч Ширмэн
- Дарга аа хэн хэн бэ гэж асуухад Намхай
- Манай Хангал дарга Монгол улсын хөдөлмөрийн баатар, Өлзий малын гавьяат эмч, Нарангарав гавьяат малчин болсон. За тэгээд төрийн одон медалиар олон хүмүүс шагнуулсан даа гэхэд Балбар
- Манай бэр Нарангаравуу? гэж чихэндээ итгээгүй бололтой лавлахад Намхай
- Тийм ээ. Танай ач Амархүүгийн эхнэр Нарангарав гэж чанга хэлэхэд Балбар өвгөн
- Ээ төрийн минь сүлд өршөө гээд бунханд дахиад л мөргөв. Хөнгөн тэрэгний тоос Босгын хөтлөөр дамнан цайрна. Хөтөлгөө морьтой Балбар өвгөн гэр өөдөө давхина. Зэгэлхэн өнгөтэй бүдэг тоос агаарт угалз зуран аажимхан арилж замхарна.

Гучин ес

Намын үүрийн дарга Намхайн унаж яваа хөнгөн тэрэг Нарийний голыг уруудав. Тэд дор бүрдээ бодлоо нэрнэ. Зөвхөн моторын дуу л дүнгэнэнэ. Гэтэл анир эвдэж Ширмэн

-Мөн сонин юм аа. Явсаар байгаад Сагад мэргэн бид хоёр ахан дүүс болчих юм гэж гайхан хэлэхэд Намхай дарга төв маягаар

- Чи юундаа гайхаад байгаа юм бэ? Ажил гайгүй болмогц Сагад мэргэнийд очиж наад нүгэлээ наманчилж мөргө. Тэр хөшөөн дээр бичээстэй А. Чоймжуур гэдэг хүн чинь Сагадын өвөг эцэг гэдгийг ойлгосон уу? гэхэд Ширмэн санаа алдаад

- Ойлгосон. Дарга та яагаад ийм сайн мэдэж байна аа гэхэд Намхай инээгээд

- Балбар өвгөн, Сагад мэргэн бид гурав бага сага хөөрөлдсөн юм. Ер нь энэ бунхан Бумба дээр нэгэн том цагаан суварга босгох бодолтой байгаа гэв. Ширмэн бүр ихээр гайхаад

- Дарга аа энэ чинь болох уу даа? Та сайн бодоорой гэж хаширлахад Намхай дарга

- Бололгүй яахав. Бид цаг үеэ мэдэрч үнэн мөнийг тогтоож зөв юм хийж байхад айх юу байх билээ гэв. Ширмэн Намхай даргынхаа үгэнд итгэж тайвшраад

- Дарга аа. Том цагаан суварга босгочихлоо гэхэд аравнайлж ёс үйлддэг, ном судрыг нь уншдаг хэн байдаг билээ гэж их л санаа зовсон аятай асуухад Намхай дарга инээгээд

- Ширмэн минь түүнд санаа зовох хэрэггүй. Хөшөөтийн голын Балбар, Хөвчийн нурууны дуугүй Хайнзан, хуц ухна малладаг мэргэн Сагад гурав л бүгдийг ёсчилон хийчихнэ шүү дээ гэхэд Ширмэн эргэлзсэн маягтай

- Тийм үү? гэж гайхан хэлэхэд Намхай мөн л инээгээд

- Чи чинь эргэлзээд байгаа юм уу? Ширмэн минь. Аливаа юмны ул үндэс, учир утгыг нь сайн ойлгож байгаач. Заримдаа дэндүү туйлшраад байх юм гэхэд Ширмэн уриалгахнаар хүлээн авч

- Мэдлээ дарга аа гэж тодхон хэлэхэд Намхай дарга

- Манай сумаас олон баатар, гавьяатнууд, төрийн шагналтан, эрдэмтэн мэргэд, их зохиолчид төрлөө. Сумаараа төрийн одон зүүлээ. Мал өсөж бум хол гараад явчихлаа. Газар нутаг маань өгөөжөө өгч байна. Өнгөрсөн өвөл ямар аймшигтай зуд турхан болов. Бид өнчин ишигний гарзгүй давж гарлаа. Энэ бүгдийг улс даяар гайхаж байна. Ширмэн минь. Энэ бүгдийг сайн тунгааж бодоод үзээрэй. Худалч хүнд бол Балбар өвгөн тэр бунханд мөргөсөөр байгаад хараа орчихлоо шүү дээ гэв. Ширмэн бодол болон чимээгүй болов. Тэд ч зорьсон газраа ирэв. Энэ бөмбөрцгийн өнцөг булан бүрт амьдрал үргэлжилж ажил хөдөлмөр өрнөсөөр байлаа.

Алс холын алтан Москвад суугаа Жаргал эмчид нэгэн захидал ирэв. Тэр задалж чадахгүй

гаднаас нь барилж үзэн шинжиж байв. Жаргал энэ захидлыг хүлээж хүсэж өдөр нь бодолдоо бясалгаж, шөнөд нь зүүдэндээ уншиж байсан учир ийнхүү догдлон байгаа нь энэ билээ. Тэр дотроо

-Охины минь зураг ирээгүй, бас миний бичсэн зузаан захидлыг эргүүлж явуулаагүй бололтой гэж бодоод бага зэрэг тайвширлаа. Жаргал захидлыг ихэд нямбайлан задалж дэлгэв.

- Сайн байна уу? Алс холын Алтайн нурууны Алаг хайрханыхаа бэлээс мэндчилж байна. Танаас охиныхоо гурван настай үеийнх нь зурагтай захидлыг тосож аваад их баярлалаа. Та дэлгэрэнгүй бичсэн учир бүгдийг ойлголоо гэж уншаад Жаргал охиноо тэврэх мэт захидлыг элгэндээ наагаад

-Ямар шулуун шударга, илэн далангүй сайхан сэтгэлтэй хүн бэ? гэж бодоод цааш уншив.

- Та охиноо холоос харах юм уу, сайн сайхан явааг нь мэдвэл боллоо гэжээ. Тийм биш ээ. Та бас эдлэх эрх, нэр төрийг дурдан өөрийгөө буруутгасан нь ёс зүйд огтхон ч нийцэхгүй билээ. Эх үр хоёрт ямар ч ёс төр, нэр нүүр гэж байдаггүй юм. Зөвхөн амин судлаар холбогдож алд биеэрээ барьцалдсан болохоор эх үр хоёрт ийм хиймэл ёс төр, хууль зүй үйлчилдэггүй юм аа. Тиймээс та эмзэглэж байгаа сэтгэлээ хурааж хэрэггүй бодол саналаа орхихыг хичээгээрэй гээд Жаргал түр азнаад

- Энэ юутай үнэн үг вэ? Би чинь эх хүн байж үр хүүхдийнхээ өмнө хайрлах эрхээ хасуулах нь юу билээ. Эх хүний чинь үрээ хайрлах сэтгэл нь үргэлжид ундарч байгаад үхсэн ч сүнс нь үргэлжлүүлэн хайрладаг бус уу. Энэ хүн надаас өөрөөр сэтгэж олон давхар санааг агуулж чадаж байна. Хөхцэцэг охин их ухаалаг байсан нь ийм учиртай байх нь гэж бодоод захидлын өгүүлбэрийг үргэлжлүүлэн хөөв.

- Би нэгэн цагийн эндүүрэл, төөрөгдлийн эргүүлгэнд орж амь биеэ алдах эгзэгтэй агшинд охинтойгоо учирсан юм. Би охиноо авч явахыг яахан хүсэх билээ. Өөрийнхөө амь насыг яая даа гэж яваа амьтан чинь. Охиноо ойролцоох худаг дээр үлдээхээр шийдсэн юм. Гэтэл нэг өвгөн намайг захиргаадаж охин минь намайг ааваа гэж дуудаж би ертөнцийн хэмжээст хуйлагдан хол газар авч одсон нь миний буруу, эх үрийг салгасан нүгэл байсан. Би охиноо хүний гар харуулахгүй гэж бүхнээс сэтгэлээ хурааж гагцхүү эрдэм номтой сайн хүн болгож өсгөө гэж хичээсэн. Гэсэн ч би охиныхоо төрсөн аав, ээж ах дүү нар нь гараад ирээсэй гэж байнга хүсэж хүлээж байв. Хэрвээ би орчлонгийн жам ёсоор мөнх бусыг үзүүлэхэд хүрвэл охин минь түших тулах юмгүй гав ганцаараа хоцорно гэж бодохоос би үхэж болохгүй гэж өөртөө байнга хэлдэг байлаа. Охин минь зөн совингоороо элгээрээ таныг “Миний ээж” гэж бүрэн ойлгосон. Ийм төгс ойлголттонд хүргэхийн тулд миний болхи ухаан нилээд урт хугацааг өнгөрөөчихлөө. Уучлаарай. Уулзаж байгаад ужиг түүхийг учирлаж ярья. Охин бид хоёр та бүгдийг хүлээж байна. Баяртай гээд захидал өндөрлөв. Жаргал захидлаа мөн л элгэндээ тэврээд амандаа

- Би маш түргэн охин дээрээ очих ёстой гэж шивнэхэд сайхан алаг нүднээс нь ариун хурын асгарах сувд мэт дусал ар араасаа чимээгүйхэн урсаж уураг сүүн хоёр мөөм нь үрээ хурайлж дуудах мэт мэдэгдэм хөдлөх шиг болж ирвэнэн ивлэв. Энэ бол аугаа хайр энэрэл, амьдралын гайхамшигт үнэ цэнэ билээ.

Амьдрал үргэлжилсээр алаг хорвоо эргэсээр байлаа. Эх үрийн ариун холбоо хөвчрөн бие бие рүүгээ татагдан байх энэ мөчид Улаанбаатар хотын нэг өндөр байшингийн таван давхарт нас намба тогтсон нэгэн эмэгтэй гартаа сонин бариад дахин дахин уншиж бодол дурсамжаа охилон санаашран сууна. Энэ эмэгтэйг Бадамханд гэдэг. Тэр сонинд бичигдсэн “Сагад мэргэн” гэсэн нийтлэл хөргийг уншиж сэтгэлээ чилээн суугаа нь энэ. Уг нийтлэлд Сагад мэргэн ямар ч ажлыг хийхдээ мэргэжлийн өндөр түвшинд, уран чадварлаг хийдэг бөгөөд мужааны ажилд бүрэн мэргэшсэн өндөр зэрэгтэй мастер юм гэдгийг уншаад Бадамханд дотроо

-Бавуу маань сайн мужаан байсан. Сүүлдээ айлуудад уригдан гэрт нь алив нэгийг хийдэг болсон доо гэж бодоод цааш уншив.

- Сагад мэргэнд нэгэн нарийн илгэн арьсан цаасан дээр арилдаггүй бэхээр зурж бичиж бүтээсэн тэнгэрийн бичээс гэж нэрлэдэг бяцхан ном, шүрэн толгойтой оюу дун эрдэнийн давхар нуухтай бор цэхэр язмагтай ногоон өнгөтэй бага гарын Чүнчигноров хөөрөг бий. Тэр энэ Чүнчигноров хөөргөө миний дөрвөн үеийг дамжин ирсэн сахиус минь байгаа юм гэж ярина. Би энэ хоёртойгоо байхад баян хүн гэж хэлэх дуртай гэдгийг дахин дахин уншиж Бадамханд нэгэн дурсамжаа нэхэхэд хүрэв.

- Бадамханд Бавуудаа дэндүү итгэж хайрлаж байсан болохоор түүнд нутаг ус, төрсөн бууц, аав ээж, ахан дүүс тэднийхээ авир ааш сайн мууг бүгдийг нь тоочин ярина. Өөрийгөө бол хоёр зуун жаран гурван яс үе мөчөө нэг бүрээр нь бодол саналаа мөрөөдлөө тэр чигээр нь уудлан дэлгэнэ. Харин Бавуу нутаг ус болоод аав ээж, ахан дүүсийнхээ бас өөрийнхөө тухай нэг ч үг өгүүлбэр хэлээгүй билээ. Бадамханд ч түүнээс шаардаж байсангүй. Бавуу нарийн илгэн арьс дээр арилдаггүй бэхээр бичсэн тэнгэрийн бичээс, Чүнчигноров хөөргөө үзүүлээд

-Би энэ хоёртойгоо байхдаа хамгийн баян хүн. Энэ бичээсийг би чамд зааж өгнө. Бас хүүхдүүддээ заана. Энэ сахиусан хөөргийг хүү минь залгамжилж авах болно гэхэд нь Бадамханд

- Юун ч эрт их юм мөрөөдөх нь вэ? гээд инээлдэж байснаа дурсаад авав. Тэр хүү Хантүшигээ бодоод

- Миний хүү ч аавыгаа арай л дэндүү дуурайж өвчөөд төрчихсөн шүү гэж давхар бодов. Тэр нийтлэлээ үргэлжлүүлэн уншив.

- Сагад мэргэн аминаасаа илүү амин эрдэнэ ганц охинтойгоо хоёулаа амьдарна. Охин Хөхцэцэг нь одоо Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан хийж байна. Сагад мэргэн охинтойгоо “Тэнгэрийн бичээсийн тайлбар толь” “Чоймжуур” хэмээх гурван боть номыг өргөн олон уншигчиддаа өргөн барихад бэлэн болоод байна гэснийг уншсан Бадамханд

- Хөөрхий дөө энэ хүн охинтойгоо хоёулхнаа амьдардаг гэжээ. Охиных нь ээж яасан юм бол доо. Бас л над шиг зовлон үзсэн хүн юм болов уу? гэж бодоод цааш нь уншив.

- Энэ сумын сайн үйл болгон, ололт амжилт бүхэн Сагадтай холбоотой гэдгийг бид бүхэн

мэднэ. Энэ хүнийг наян настай буурлаасаа эхлээд нялх балчир хүүхдүүд бүхэн хүндэлнэ. Сагад гуай байгаа биеэрээ бас эрдэм мэдлэг оюун ухаанаараа нүүдэлчдийн соёл иргэншлийн давтагдашгүй гайхамшигтай өв уламжлал, зан заншил, хөх ухааны сан хөмрөг, их цагаан тамир мөн билээ Таныг зуу насалж зургаадай таяг тулахыг ерөөе. Б.Хөнхий/ Сургуулийн захирал/ гэсэн байлаа. Бадамханд амандаа

- Үйл мөр, эрдэм мэдлэг, эдлэл нь мөн болоод байдаг. Гэтэл овог нэр нь өөр байх юм даа. Ямар ч байсан тэр нийтлэлийг бичсэн Хөнхий захиралтай холбоо барьж лавлах хэрэгтэй юм байна. Хүү Хантүшигтэйгээ зөвлөлдье гэж шивнэж байв. Бадамханд ард хоцорсон түүхийг эргэн дурсав.

- Тэр орой Бавуутайгаа уулзаад үзвэрт хамт явъя. Бас хөл хүндтэй болсноо хэлэх гэсэн бодолтой байсан ч Бавуу

-Би амжихгүй юм байна. Айлд захиалгаар юм хийх ёстой гэсэн болохоор Бадамхандын үзэх үзвэр, хэлэх гэсэн үг нь өөрт нь үлдэж эдүгээ болтол эзэндээ хүрээгүй байгаа билээ. Тэр цагаас хойш Бавуугийн зүс нь үзэгдээгүй дуу хоолой нь сонсогдоогүй юм. Гэтэл тэр явдлаас хоёр хоногийн дараа Бавуугийн ажлын газрын залуу ирээд Бадамхандаас Бавууг сураглахад нь Бадамханд

- Хоёр хоногийн өмнө айлд юм хийнэ гээд явснаас хойш надтай уулзаагүй гэхэд нөгөө залуу

- Бавуу ажилдаа ирэлгүй хоёр хонож байдаг. Түүнийг дотоод яамнаас хүн сураад байна. Их л ноцтой хэргээр мөрдөж байгаа бололтой юм гээд явлаа. Бадамханд ихэд айж цочирдов. Тэр дотроо

- Бавуу надад нутаг ус, аав ээжийнхээ тухай юу ч яриагүй, бас бүх юманд хянамгай нямбай ханддаг нь энэ мөрдлөг, гэнэт алга болсонтой нь холбоотой байж мэдэх юм гэж бодно. Гэтэл мөрдөн байцаагч Бадамхандыг дуудаад

- Та Бавуу гэдэг хүнийг таних уу? гэхэд Бадамханд

- Танина гэлээ. Мөрдөн байцаагч

- Энэ хүнтэй та ямар холбоотой вэ гэхэд нь

- Ямар ч холбоогүй. Хааяа хамт явж, үзвэр кино үздэг гэв. Мөрдөгч

- Та хоёрт гэр бүлийн холбоо байгаа юм биш үү гэж ширүүхэн дуугарахад Бадамханд

- Гэр бүлийн гэх нь битгий хэл гар гараасаа ч барилцаж үзээгүй гэхэд мөрдөгч инээгээд

- Энэ хувьсгалын эсэргүүний үлдэгдэлтэй ямар ч холбоогүй бол сайн хэрэг гэсээр явав. Дахиад хоёр хонож байтал нөгөө мөрдөгч дуудаад монгол гутлын оймсны хагас түлэгдсэн түрийний хэсгийг үзүүлээд

- Энэ Бавуугийнх мөн үү? Сайн ажигла. Үнэн зөв хариу өгнө шүү гэлээ. Бадамханд сайн

ажиглан харвал Бавуугийн гутлын оймсны түрийтэй адилхан мөртлөө арай биш байлаа. Тэр дотроо

- Яагаад үүнийг асуугаад байгаа юм бол доо. Биш гэвэл юу болох вэ гэж бодож байтал мөрдөн байцаагч

- Та мөн бишийг нь хэлж чадах нь уу? Мөн байвал бидний эрэл мухардана. Биш гэвэл эрэл үргэлжилнэ гэхэд Бадамханд дотроо

- Биш гэвэл эрлээ үргэлжлүүлнэ гэнэ үү? Тэр минь амьд мэнд байж мэдэх юм. Уг нь тийм ч амархан түлэгдээд үхчихмээргүй л юм даа гэж бодож суутал мөрдөгч

- Та асуултанд шуудхан хариулаарай. Мөн үү? Биш үү? гэж тулгахад Бадамханд

- Би яг хэлж чадахгүй юм байна. Бавуу ийм түрийтэй оймстой нь үнэн. Би олон харж байсан болохоор нүдэнд бугаад байна. Гэхдээ энэ түрий мөн бишийг сайн баталж чадахгүй байна гэлээ. Мөрдөгч

- Та таньж л байвал боллоо. Баярлалаа танд гэв. Бадамханд Бавуугийн тухай үнэндээ бага мэдэж байлаа. Тэр Бавууг шатаж үхсэн гэдэгт үнэндээ итгэхгүй байлаа. Харин амьд мэнд аль нэг газар яваа гэдэгт итгэлтэй байсан юм. Хэзээ нэгэн цагт хэл чимээ ирнэ. Зүс царай нь үзэгдэнэ гэж хүлээнэ. Цаг хугацаа өнгөрөх тутам түүний хэвэл бие бүдүүрнэ. Хүүгээ хөдлөх бүрт Бадамханд түүнтэй ярьж

- Миний хүү томоотой байгаарай. Аав нь удахгүй хүрээд ирнэ гэж ярьдаг байсан ч хүү төрөөд Хантүшиг нэр хайрлаад таван нас хүрч даахин сэвлэгийг нь үргээгээд найман нас хүрээд сургуульд оров. Бадамханд энэ хугацаанд зүгээр суусангүй. Ажлаа хийж хүүгээ өсгөхийн зэрэгцээ оройгоор арав төгсөв. Бадамхандад ээж, дүү нар нь ирж туслан өмөг түшиг болж байв. Тэр үйлдвэрийн тэргүүний оёдолчин болж залуучуудын эвлэлийн урилгаар Их сургуулийн үйлдвэрийн технологич инженерийн ангид суралцаж амжилттай дүүргэж одоо оёдолын үйлдвэртээ технологич инженерээр ажиллаж байгаа билээ.

Хүний л амьдрал болсон хойно түүний амьдралд бишгүйдээ л олон жаргал зовлон тохиолдож байв. Бадамхандын царай зүс гоё ганганд нь биш түүний сайхан сэтгэл, хүн чанарт нь олон хүн татагдана. Зарим нь амьдрах санал тавьж сэтгэлээ дэлгэсэн нь ч бий. Бүр нойтон хамуу шиг зууралдан хоёр гурван жил даган зовоосон нэгэн ч бий. Бадамханд хүү Хантүшигээ хараад хааяа Бавуудаа гомдоно.

Эцэггүй эхээрээ овоглуулан эцэг хүний хайраар дутаж яваа түүнийг өрөвдөнө. Бадамханд хүүгээ хайрлаж өрөвдөхийн эрхээр өөрийгөө, бие сэтгэлээ золиослон дутаад байгаа тэр хайрыг нь нөхөөд дүүргээд өгье гэж хичнээн мэрийсэн ч олон дахин хүчилсэн ч огт болохгүй юм гэдгийг ойлгосон билээ. Эцэг хүний хаан хайрыг орлож чадах тийм хайр хэнд ч байдаггүйг мэдэрсэн юм. Тийм хаан хайр зөвхөн эцэг хүнд л байдаг байна. Энэ бүгдийг бясалгаж чадсан Бадамханд сайн сайхан санал хүсэлт, амьдрал бэлэглэсэн аз жаргал бүгдээс татгалзан бие сэтгэлээ хурааж зөвхөн хүүгийнхээ төлөө амьдрахаар шийдэж бурханы оронд явглаа Бавуугаа хүлээнэ гэж итгэж чадсан нь энэ хорвоо дээр оршдог олон хайраас онцгой

үндэс бөхтэй тамир ихтэй үлэмж нандин хайр байв. Бадамханд хүүгийнхээ төлөө амьдарч чадсан сэтгэлийн тэнхээ, ухааны бяр тэгширсэн цагаан өргөлтэй сүүн далай бүтэн заяатай бүсгүй билээ. Бадамхандын ард хоцорсон түүх ийм бөлгөө. Энэ бүгдийг бясалгаж суусан Бадамханд сонинд байгаа Сагадын тухай нийтлэлийг дахиад л уншив.

- Түүний маллаж байгаа хуц, ухна өндөр уулын хад асганд сүрэглэн байх нь эрт дээр үед үлгэрт гардаг зэрлэг амьтдыг санагдуулам сүрлэг харагдана. Сүр хүчээрээ гайхуулсан том эвэр, урт сахал, их зогдроороо гангарсан сүргийн манлай энэ амьтад Сагадыг үзэхээрээ, түүний дууг сонсохоороо цэрэг аятай номхорч үг дуугүй захирагдана. Хотондоо нэг л жимээр ирээд бэлчихдээ мөн л тэр жимээрээ дуулгавартай нь аргагүй чөрхөлсөн тэмээд мэт цуварч одно. Энэ мөн л Сагад мэргэний хөх ухааны хүч тамир билээ гэж дундаас нь уншаад уртаар санаа алдаад амандаа

- Би чинь Сагад мэргэн гэдэг хүний тухай уншчихаад дандаа Бавуугаар сэтгээд Бавуугийн тухай бодоод байдаг нь ямар учиртай юм бол. Хэрвээ Сагад Бавуу мөн бол би яах ёстой билээ. Сагад Бавуу биш Сагад байвал яах ч үгүй орхино. Үгүй орхиж огт болохгүй. Тэр “Тэнгэрийн бичээс”, “Чүнчигноров” хөөрөг хоёрын үнэн мөнийг олох л болно. Бавуу мөн л бол би уучилна. Бас хэлж амжаагүй одоо болтол хадгалж явсан үгээ хэлж санаа минь амарна. Хүү минь дугааж явсан хаан хайраа нөхөж дүүрэн жаргалтай бүтэн сэтгэлтэй болох болно гэж ганцаараа ярив.

Хантүшиг одоо их сургуулийн барилгын зураг төслийн ангийг дүүргээд Улсын барилгын зураг төслийн институтэд ажиллаж байгаа билээ. Тэр том болох тусмаа эцэг Бавуутайгаа усны дусал мэт адилхан болж байгаа нь Бадамхандын сэтгэлийн нандин утсыг хөндөн гэгээн дурсамжийг нь сэргээгээд байж болох талтай. Гэтэл Бавуугийн бие, хэл, сэтгэл гурав Бадамхандын сэтгэл зүрхэнд шингэн огт арилахааргүйгээр бат бөх оршиж байгаа нь тэдний үнэнч хайр сэтгэлийн илэрхийлэл байв. Үнэн юм бүхэн үүрд байж чаддаг билээ. Нар мэт гэрэл гэгээгээ цацаж байдаг ийм ариухан нандин үнэнч хайр сэтгэлийг хэзээ нэгэн цагт сайн сайхан аз жаргал угтаж байдгийг хэн ч үгүйсгэхгүй биз ээ.

Хантүшиг ээжийнхээ зөвлөсний дагуу “Сагад мэргэн” хэмээх нийтлэл бичсэн Б. Хөнхийд товчхон захидал илгээв.

- Сайн байна уу? Хөнхий захирал аа. Таны бичсэн “Сагад мэргэн” хэмээх нийтлэлийг уншаад энэ эрхэм хүнтэй уулзахыг хүсэж байгаагаа танд хэлье гэж бодлоо. Багш та миний хүсэлтийг ойлгож надад зуучилж Сагад гуайтай уулзуулж өгөөч. Одоо юу хийвэл зохилтойг та надад зөвлөж зааж өгнө үү? Би таниас хариу хүлээж байя. Танд итгэж гүнээ хүндэтгэсэн Б. Хантүшиг гээд хаягаа бичсэн байлаа. Хантүшиг энэ захидлыг бичиж дуусаад ээжийнхээ тухай бодол бясалгалд оров.

-Ээж минь энэ Сагад мэргэний тухай нийтлэлийг дахин дахин уншаад гүн бодолд дарагдаад удаан суух нь юу юм бол доо гэж бодно. Тэр нэг удаа

- Ээж ээ та Сагад гуайг таньдаг юм уу? гэхэд Бадамханд инээмсэглээд Хантүшиг рүү зөөлөн харж өхөөрдөөд

- Үгүй ээ. Энэ Сагад гэдэг нэрийг анх удаа л сонсож байна. Харин тэр нимгэн илгэн дээр бичсэн “Тэнгэрийн бичээс” “Чүнчигноров” хөөрөг хоёрыг л таних юм шиг санагдаад байна. Хэрвээ энэ хоёр мөн байвал Сагад гэдэг хүн хэн болохыг нь мэдэж болох юм гэхэд Хантүшиг
- Та чинь яагаад л цагдаа шиг хүн мөрдөж мөшгөөд байгаа юм бэ? гэхэд Бадамханд
- Миний хүү хүлээгээд л сууж бай. Аливаа юманд учир шалтгаан, үр үндэс байж бий болдог шүү дээ. Түүнтэй адил энэ Сагадын тэр хөх ухааныг, өгөөмөр сэтгэлийг танимаар байна. Миний хүү энэ нийтлэлийг бичсэн захирал багш Хөнхийд захидал бичээд Сагад мэргэнтэй танилцахыг хүсэж байгаагаа мэдэгдээд тэр хүнийг тусалж өгнө үү гэж хүс. Хэрвээ тусална гэвэл миний хүү явж очоод уулзаад ирнэ биз гэхэд Хантүшиг гайхан
- Ээж ээ та өөрөө явахгүй юм уу? Би очоод тэр мэргэн хүнтэй чинь юугаа ярих юм болж байна хэмээн бага зэрэг цааргалахад Бадамханд хүү рүүгээ тогтуун хараад
- Өдий том болсон эр хүн чинь явалгүй яахав. Аль нэг юмны өмнө ээжийгээ түлхдэгээ одоо больмоор доо. Нөгөө кинон дээр гардаг шиг
- Энэ мэргэн яаж хүлээж авна. Түүнд нь тохируулж ярилцаж танилцаад ирнэ биз дээ. Ээж нь тэр хүнд үг хэлгүй үнэнийг үзүүлье гэж бодсон хэрэг гэж хэлээд бодлогоширов. Тэр дотроо
- Тэр Сагад Бавуу мөн бол энэ хоёр хүн улаан нүүрээрээ уулзаад учраа олвол зүгээр юм. Дунд нь хэн нэгэн хүний хэрэг байхгүй гэж бодож байхад Хантүшиг мөн л дотроо
- Ээж сая юу гэвээ. Үг хэлгүй үнэнийг үзүүлнэ гэж юугаа яриад байгаа юм бол. Энэ Сагад гэдэг хүнд нэгэн учир битүүлэг нууц хадгалагдаж байгаа юм байна гэдгийг ойлгож байлаа. Хантүшиг энэ бүхнийг эргүүлэн нэг дурсаад амандаа
- Одоо Хөнхий захирлаас захидал ирэхийг л хүлээж байя гэж шивнэв. Түүний сэтгэл ямар нэг юманд яараад догдлоод байгааг тэр сайн мэдэрч байв. Хүний амьдрал битүү утгаар сүлжигдэн уран нарийн үйлээр шаглагдан төгс төгөлдөр болон бүтээгддэг ажээ.
- Москвад суугаа Жаргал эмч хоол нойроо мартаж шахам алив нэгэнд яаран сэтгэлийнхээ хөдлөлийг барьж ядан амандаа
- Мөн байжээ миний охин. Би зөв таамаглаж байсан ч сэтгэлээ барих гэж хичнээн зовлоо доо. Одоо үнэнийг мэдчихээд яахан суугаад байж чадах билээ. Далавчтай бол нисээд явчихмаар байна. Дахиад алдчихвий гэж айж байна. Цаг мөч бүр удаан өнгөрч би хүлээхийн зовлонд бас дахин шаналмааргүй байна гэж үглээд нөхөр хүү хоёртоо учрыг тайлбарлан хэлэхэд Гэлэг баярлан
- Аа тийм үү? Юутай сайхан мэдээ вэ? Одоо тэгээд яах ёстой вэ гэхэд Жаргал
- Яах юу байхав. Би дариухан явах хэрэгтэй байна гэхэд хүү Баатар нь
- Би ээжтэй хамт явъя. Та сандарч мэгдээд юу ч болох юм билээ гэхэд Жаргал инээгээд

- Би гайгүй байх аа. Би монголд байхдаа хоёр ч удаа уулзаад бүр гэртээ аваачиж цай хоолоор дайлсан удаатай. Тэр үед мөн бишийг мэдэхийг хүсэж байсан хэрэг. Сая ааваас нь захидал авч мөн болохыг багтай мэдээд та хоёртоо хэлж буй нь энэ. Юуны өмнө би яваад уулзаад аавтай нь сайн ярилцъя. Бас охиныхоо саналыг сонсьё. Одоо сүр бадруулаад хэрэггүй байх гэхэд Баатар

- Ээж ээ та юу яриад байгаа юм. Эгчийг шуудхан аваад ирэх хэрэгтэй. Олоод авснаас хойш хүлээх хэрэг юу байна гэхэд Жаргал

- Тэгэж болохгүй ээ хүү минь. Үнэнийг хэлвэл хамаг буруу биднийх шүү дээ. Энэ сайхан сэтгэлтэй Сагад гуайг бид хүндлэх хэрэгтэй. Ач буяныг нь ч мартаж болохгүй. Шагж ах энэ хүнийг ах гэж хүндэлж очиж золгодог гэж байгаа юм. Би захидалдаа Шагж ахын нэрийг дурьдсан. Гэтэл энэ хүн нэг ч удаа бичээгүй байна билээ. Энд бас л нэг нууц байгаа юм. Асуудлыг яаж шийдвэрлэхэд охины минь санал бодол голлох үүрэгтэй шүү дээ гээд Жаргал цүнхээ уудлан сонин гаргаж ирээд энд “Сагад мэргэн” гэсэн нийтлэл гарсан байна билээ. Энэ нийтлэлд

- Сагад мэргэн аминаасаа ч илүү амин эрдэнэ болсон охин Хөхцэцэгтэйгээ хоёулаа амьдардаг гэсэн байна. Гэтэл энэ Сагад гуай чинь миний охиныг хойт эхийн гар харуулахгүй гэж өөрийнхөө аз жаргалтай амьдралыг золиосолсон гээд бодоод үз дээ. Сагад гуай бол бидэнд аугаа эрхэм хүн маань болох ёстой гэж хэлээд учир жанцангаа ойлголцоод Жаргал эмч охин руугаа явахаар болов.

Хүмүүний амьдрал бүрэн бүтэн найрал хөгжим шиг бие биенийхээ яруу тансаг аялгууг түрэн ертөнц даяар эгшиглэн байдаг билээ.

Хантүшиг инженер захидал хүлээн аваад яаран задлав. Түүний гар бага зэрэг чичирч сэтгэл нь ихэд хөдөлж байлаа. Захидалд

-Сайн байна уу? Таны санал хүсэлтийг сайн ойлгож Сагад мэргэнд дамжуулан хүргэлээ. Тэр

- Сайн санааны үзүүрт сүү гэдэг билээ гэж хэлэв. Та боломжтой үедээ морилон ирвэл би таны зууч болоход бэлэн байна. Манай сум Алтайн өндөр уулсын дунд буйдхан байдаг болохыг та бодолцоорой. Та Сагад мэргэнээс нүүдэлчдийн соёл иргэншлийн давтагдашгүй гайхамшигт ид шидийн нууцаас мэдэж мэдрэх болно. Мөн ертөнцийн бүх эрдэнэс хурсан үзэсгэлэн төгс байгаль, уул ус, цэцэгс, ан амьтан, араатан жигүүртэн, сүрлэг хайрхан, урт нуруудаар нүдээ баясгаж сэтгэлийн цэнгэлийг эдлэх болно. Эрдэмтэн мэргэд алдар цуутнуудтай уулзана. Таныг ирэхээр дэлгэрүүлж толилуулъя. Таны морилон ирэхийг хүлээж баярлан угтъя хэмээсэн байлаа.

Хантүшиг захидлыг уншиж дуусаад айж бэргэх сэтгэл төрөв. Түүнийг орчлонгийн хамаг сайн сайхан бүхэн, халуун дулаан сэтгэл, их хайр хүндэтгэл хүлээж байгааг захидлаас ойлгосон учир тэр биз. Хантүшиг захидал бичсэн цаасыг эргүүлтэл ар талд нь

-Манай Сагад гуайтай уулзаж учран золгохоор Москвагаас зочид гарсан байхад Өвөр монголын Гансу мужийн дээд Цахар хошуунаас ч зочид гарснаа мэдэгдээд байна. Би мартаж

орхиж. Хантүшиг та гарахдаа надад цахилгаан мэдээ илгээгээрэй. Түр баяртай гэсэн байв. Хантүшиг энэ бүгдийг ээждээ хэлэхэд Бадамханд

- Тэр Сагад гэдэг хүн чинь гадаад дотоодын олон хүнийг өөр лүүгээ татсан гайхамшигтай эрдэмтэн байх нь дээ. Миний хүү яахав. Очиж уулзаад танилцаад л ирнэ биз гэлээ.

Хантүшиг газрын зураг, зарим түүхийн бичиг лавлагаанаас Говь –Алтай аймгийн Бугат сумын газар нутгийн байршил, цаг агаарын онцлог, ан амьтад зэрэг олон зүйлийг олж судалж байв. Тэр онгоцны тасалбараа аваад Хөнхийд цахилгаан явууллаа. Одоо Хантүшигт онгоцонд суугаад цэлмэг хөх тэнгэрт хөөрөн нисэх л үлдээд байв.

Харин яг энэ үед Сагадыг зорьж Москвагаас хөдөлсөн эхний зочин болох Жаргалыг тосож аваад байлаа. Жаргал яг хэдний өдөр очихоо тодорхой хэлээгүй ч очно гэдгээ мэдэгдсэн билээ. Сагад хичнээн тайван байсан ч баярлаж бас зарим зүйлд санаа зовж байлаа. Хүн нэрээ тогос өдөө гэдэг шүү дээ. Тэр охиныхоо төрсөн ээжийг нь ирж байхад охин Хөхцэцэг нь эзгүй байгаад тэр билээ. Сагад бусдаар юундаа санаа зовох билээ. Гадаад дотоодын том хотод суудаг их эмч хүн хэдэн хуц ухных нь содон сонин үнэрээс элдэвлэн цээрлэхгүй бол өөр санаа зовох юм алга байлаа.

Сагад бүлэнцэр болох Ширмэнтэйгээ ойртож танилцаад зогсохгүй эмэг эх болох Дэжиднямын гурван ах Гунгааням, Батням, Отгонням нарын дээд нагацуудын үр удам олон ах дүүстэйгээ танилцаж олуулаа болсон билээ.

Москвагаас ирэх Жаргал эмчийг сумын төв дээр Ширмэн угтаж аваад Сагадынд хүргэх ёстой байхад гурав хоногийн дараа Улаанбаатараас ирэх Хөхцэцэгийг Хөнхий захирал хүргэхээр тохирсон байв. Хөнхий Хантүшигийг замын машинаар ирэх юм уу, шуудангаар ирэхийн алиныг тодорхой мэдээгүй байлаа. Хөнхий байнга шахам Шар хадны хоолой руу тоос гарахыг анзаарч ажиглан байлаа.

Харин Жаргал эмч товлосон хугацаанаасаа нэг хоногийн өмнө ирсэн учир түүнийг хэн ч тоссонгүй. Өндөрдүү нуруутай, намбалаг төрхтэй, цагаан царайтай, махлагдуу эмэгтэй сумын төвөөр алхах нь нэн содон харагдана. Хэн боловч гаднын хүн болох нь ялгарч байв. Жаргал сумын дэлгүүрт ороход хот газрын сонин сайхан сүрчигний үнэр агаарт түгэж байв. Жаргал намбалаг инээмсэглэн худалдагчтай мэндлээд

-Сагадынд яаж явж очих вэ? Унаа явах болов уу? гэж асуув. Дэлгүүрт байгаа хүмүүс Жаргалыг эвэртэй туулай үзсэн аятай гайхан нэрэлэх юмгүй ширтэцгээнэ. Гэтэл Сагадыг сурагласан нь бүр ч алмайруулахад хүргэв. Тэд хэсэг чимээгүй байснаа нэг нь

- Ширмэн дарга л мэдэж байгаа байх гээд нэг хүүхдийг гүйлгээд худалдагч

- Та эндээ хүлээж байхгүй юу? Одоохон хүн ирнэ гэлээ. Удсан ч үгүй Ширмэн ирж Жаргалыг сүрдэнгүй маягтай хараад

- Сайн байна уу? Таныг Жаргал гэдэг үү? гэж асуухад Жаргал сайхан инээмсэглээд

- Тийм ээ. Намайг Жаргал гэдэг. Та сайн байна уу? гэж мэндлээд

- Би Сагад мэргэнийд очих ёстой юм аа гэв. Ширмэн дарга их л ёсорхоогоор

- Би Сагадын ойрынх нь ах дүүс болдог хүн байна. Таныг би хүргэх үүрэг даалгавартай юм гэж албархуу маягтай хэлэхэд Жаргал

- Юун сайн юм бэ? Ингээд хөдлөх үү гэхэд Ширмэн

- Танд ачаа бий юу гэж асуув. Жаргал томоохон боловсон алаг цүнхийг заагаад

- Тэр цүнх л байна гэхэд Ширмэн цүнхийг авч тэд хөдлөв.

Сумын төвөөр л нэг цагаан цайлган гэгээ татуулсан яриа өрнөж байв.

-Сагад мэргэний авгай чинь Москвад байж байгаад хүрээд ирлээ. Хөхцэцэг охинтойгоо их адилхан юм байна гэж байхад бас нэг нь

- Зайлуул даа. Охин том болоод Сагадын нэр хүнд өсөөд ирэхээр нөгөө шонхор шар орсоо орхичихоод буцаад ирж байгаа нь энэ. Ийм нуруу туруутай, царай зүстэй, хөөрхөн хүүхнүүд чинь эрчүүдээр тоглодог гэсэн гээд хөхрөлдөж байгаа бол хэн нэгэн

- Манай Сагад ч хүүхнүүдэд гологдоод байх эр биш ээ. Сайхан хүнийг олоод ир гэвэл Сагадыг аваад очиход ямар ч гүнж дагинас огт голохгүй байх аа. Хүний сайхан чинь сэтгэлдээ, эрдэм мэдлэг, оюун ухаандаа л байдаг юм гэнэ лээ. Манай Сагад дээр төрийн сайдаасаа эхлээд Шинжлэх ухааны хүрээлэн гээд гадаад дотоодоос олон хүмүүс ирэх юм даа гэнэ. Сагадад санаархаж битүүхэн атаархаж явдаг зарим бүсгүйчүүд

- Сагадынд ирсэн энэ сайхан эмэгтэй ч удахгүй буцах байх аа даа. Тарвага

- Хар ус уухгүй, хагд өвс идэхгүй, хар нүхэнд амьдарна гэж ам өгсөн юм гэнэ лээ. Манай Сагад чинь

- Хань ижил авахгүй, халуун дулаан өвөрт орохгүй, эхнэр хүүхдээс хол байж, энэ насаа барна гэсэн тангарагтай юм гээ биз дээ гээд тас тас хөхрөх нь цаанаа эгдүүтэй сонсогдож байв. Жаргал Сагад хоёр хүмүүсийн ярьсан шиг хэзээ хэзээний эр эм хоёр шиг тэврэлдэн золгож бие биеэ хүндэтгэн байхад Жаргал эмч уяран нүдээ аргадаж байлаа. Сагад

- За ядарч ирэв үү хөө? Манай нутаг их хол шүү дээ. Манай Гэлэг, Баатар хоёр сайн биз дээ гэхийг сонссон Ширмэн болон бусад хүмүүс дотроо

- Ээ хөөрхий минь бие биеэ хараад бүр сүйд болохыг нь яана. Тэр Жаргал нь Сагадыгаа санаад бүр бэтгэрэх шахсан бололтой үе үе л нүдээ арчаад л нулимсаа нуух юм алга гэж бодно. Сагад

- Охин минь хотод яваа. Нөгөө бэлтгэсэн номоо хүрээлэнд өгөөд хоёр хоногоос ирэх байх гэхэд Жаргал инээмсэглээд

- Охин минь сайн л яваа бол боллоо гээд л Сагадыг хаашаа л хөдөлнө дагуулаад хараад байх юм. Их саначихсан болоод тэр байлгүй гэсэн гэнэн хонгор яриа салхи хөлөглөн гол ус уруудан даваа хөтөл даван уул нурууд дамжин чих мялааж ам халааж хурдалж байлаа. Энэ өдрүүдэд Сагад, Жаргал хоёр цээжиндээ бодож санаж явдаг бүхнээ дэлгэн зовлон жаргалаа уудлан ярилцав. Жаргал цай уух зуураа

- Манай бүл ах Шагж та хоёр ямар учиртай хүмүүс вэ? гэхэд Сагад инээмсэглээд ужиг түүхийг дэлгэрэнгүй яриад

- Шагжийнд очоод Жамцын Сагад болчихоод маргааш өглөө нь эрт шууданд суух тушаал авчихаад бас бид хоёроос өөр хэн ч мэдэх ёсгүй гэсэн нууц даалгавартай явж байгаад охинтойгоо учирсан даа гэхэд Жаргал толгойгоо сэгсрэн

- Юмны ерөөл тавилан гэдэг мөн ч нарийн юм даа гэж байлаа.

Энэ үед Улаанбаатар хотоос Говь –Алтай явах зорчигчид суудлаа эзэлнэ үү гэж чанга яригчаар зарлахад Хөхцэцэг суудлаасаа босов. Түүний нүдэнд нэг сонин дүр төрх зэрвэс үзэгдэв. Тэр

-Энэ чинь юу билээ гэж бодоод цүнхээ аваад харвал алга болсон байлаа. Тэр онгоцны цонхон талын суудалд сууж гадагшаа элдвийг сонирхон харж байлаа. Онгоц хурдлан гүйхэд газар эрээлжилж байснаа дуу нь намдаад газраас тасарч хөөрөхийг бас дугуйгаа эвхэхийг сайн харж байсан Хөхцэцэг дэргэдээ суугаа хүн рүү хараад амандаа

- Ээж ээ гэж аяархан хэлээд огцом хөдөлж цочив. Тэр дотроо

- Энэ чинь юу болоод байна аа? Өмнө зэрвэс харахад аав л зогсож байх шиг болоод алга болчихсон. Гэтэл одоо миний дэргэд сууж байдаг гэж бодоод дахин ажиглавал жаахан залуу л болохоос яг л аав нь сууж байлаа. Тэр дотроо айх шиг болов.

- Энэ аавтай адилхан залуу чинь яахаараа надад харагдаад намайг дагаад миний дэргэд суучихсан байдаг билээ гэж бодоод тайвшрахыг хичээж нүдээ анив. Тэр онгоцны дуунд бүүвэйлэгдэж байгаад нам унтчихсан байлаа. Нэг сэрэхэд Алтай хотын дээгүүр нисэн Онгоцны толгой гэж нэрлэх өндөрлөгийг шүргэх шахам болоод газардав. Хөхцэцэг ч сумынхаа шууданд амжиж суух санаатай тээврийн товчоонд ирээд машинд суухад нөгөө залуу мөн л дагаад байгаа мэт шууданд суув. Хөхцэцэг дотроо

- Ямар сонин юм бэ? Ааваас минь зөрөх юмгүй адилхан ийм хүн байх гэж. Намайг л дагаад байх шиг санагдана. Өнөөдрийн шууданд яагаад ийм цөөхөн хүн явна вэ гэж бодож байснаа тэр залуугаас

- Та хаана хүрэх вэ гэхэд ямар нэг тайлбаргүйгээр

- Бугат гэж хариулав. Дуу нь бас л аавынх нь дуутай адилхан байв. Түүнээс хойш юу ч ярилгүй явсаар Бугат сумын холбооны үүдэнд машинаасаа бууцгаав. Хөнхий Хөхцэцэгийг тосон аваад мэнд усаа мэдэлцээд Хантүшигийг харснаа түүний нүд томроод мэл гайхаж орхив. Тэр

дотроо

- Сагад гуайн залуу настай уулзаж байгаа мэт санагдан манай Сагад гуай ч залуудаа мөн нуруу туруутай сайхан төрхтэй байжээ гэж бодолдоо бурантаглуулан хэсэг болоод

- Та чинь Сагад уу гэж хэлснээ сандран худал инээн булзааруулаад

- Хантүшиг үү гэхэд тэр залуу инээмсэглээд

- Тийм ээ. Би байна гээд гар барив. Хөнхий Хантүшигийн гарыг барьсан хэвээр үг дуугүй мөн л гайхан зогсчихлоо. Тэр цаг хугацаа өнгөрч байгааг мартсан бололтой дотроо дахиад л

- Энэ Хантүшиг чинь байгаа байдлаараа Сагад гуай л байна шүү дээ. Ямар адилхан юм бэ? Хөхцэцэгтэйгээ хамт ирж байдаг. Юу ч мэдэхгүй гээгүй билүү. Эгчтэйгээ ирж байж юун ч нэрэлхүү юм билээ дээ гэж бодоод

- За хаана очно гэлээ гэж мэдэн будилж асуухад Хантүшиг

- Би Сагад мэргэнийд очно. Та Хөнхий захирал уу? гэж асуув. Хөхцэцэг дахиад л гайхав.

- Манайд очно гэв үү дээ? Хөнхийг мэддэг байх нь гээд энэ гурван хүний дунд гурвалжин бодлого бодогдож гурвалжингийн томъёо бичигдэж их тоо зурагдаж байхад эргэн тойрны хүмүүс эвэртэй туулай үзсэн мэт амаа ангайн гайхацгааж байхад бүгдийнх нь сэтгэлийн хойморт Сагад мэргэн сайхан инээмсэглэж үзэгдэв. Хойт хар уулын салхи нэг сэвсхийгээд л

- Манай Сагад мэргэнийх ч өнөр өтгөн болох нь. Эхнэр нь түрүүлээд ирсэн бол охин нь дүүгээ дагуулаад ирлээ. Тэр хүү нь Сагадыг өвчөөд төрчихсөн юм. Эцгийгээ дуурайх нь юуны буруу байхав. Харин ч сайхан хэрэг. Амьдрал ч арвин баялаг юм. Хорвоо чинь ямар уудам саруулхан юм бэ? гээд л эргэлдэн үс гээг хийсгэн сэрүү татуулж байв. Алтайн өндөр уулсын хөх салхины лимбэн аялгуунд уярч хайлсан Хөнхий

- Эгшгэн бүүвэйтэй хүмүүний амьдрал юутай гайхамшигтай төгс төгөлдөр юм бэ? Өндрөөс унах сувдан дусал хэлхэгдэн нам дор гол мөрөн далайг зоримуй. Өргөн дэлгэр өнгө тунамал дэлхийн өнцөг булан бүрээс хүсэл зоригоороо хөтлөлцсөн хүмүүсийн цагаан сэтгэлүүд Сагад мэргэнийд хуран чуулах нь оюун билгийн эрдмийн их сан болмуй гэж дуулав.

Хөнхий, Хөхцэцэг, Хантүшиг нарыг суулгасан хөнгөн тэрэг Хашаатын ам өгсөөд давхихад боссон цагаан тоос нь арилаагүй байхад Шар хадын хоолой руу нэгэн суудлын тэрэг жирийлгэсээр ирээд сумын захиргааны үүдэнд зогсов. Энэ хүн бол сайд Шагж байлаа. Тэр Сагад ахындаа очихоор яваа нь энэ билээ. Сагад ахынхаа нутгийг асуухын далимд Монгол улсын хөдөлмөрийн баатар болсон Хангал дарга, Гавьяат малын эмч Өлзий хоёртоо баяр хүргэж сайны ерөөл дэвшүүлэхийг хүсэж байв. Энэ хоёр эрхэм хүмүүстэй урд өмнийн танил болохоор ингэх нь ч зүй ёсны хэрэг.

Сайд Шагж нэгэн чухал хэргийн төлөө Сагад ахыгаа зорьж яваа билээ. Тэр талийгаач Дондов ахынхаа охин Жимсээ, хүү Жигмэд хоёрыг олон улсын гэрээний дагуу урьж Улаанбаатар

хотод ирүүлээд улмаар Сагад ахтайгаа уулзуулж мөргүүлэхээр ирээд байгаа нь энэ.

Шагжийн ач охин, хүү хоёр нь аавынхаа гэрээсийг заавал биелүүлэх ёстой. Аав минь Монгол руугаа буцахдаа

-Миний охин, хүү хоёр минь. Энэ Бавуу гэдэг хүнийг насан туршдаа дээдэлж хүндэлж яваарай. Хэзээ нэгэн цагт аавынхаа нутагт очвол энэ хүнийг олж уулзаж мөргөөрэй. Ач буяныг нь заавал санаарай. Тэр үед аав чинь тэнгэрээс харж баярлах болно гэсэн гэрээсийг санаж чадаж байгаа нь үнэхээр бахархмаар байлаа.

Сайд Шагж эр хүний жудагаар сайн танил баатар, гавьяат хоёртоо сэтгэлийн мялаалга өргөж баяр хүргээд Сагад ахынхаа нутгийг мэдэж, замыг заалгаж аваад хөдлөв.

Ач хүү Жигмэд, охин Жимсээ нартайгаа уулзахын хүслэн учран золгохын ерөөл өргөсөн Шагж сайдын суудлын тэрэг Хашаатын ам өөд өгсөн өмнөхөн Сагад мэргэний рүү явсан хөнгөн тэрэгний зам хээлсэн шинэхэн мөрийг гишгэн боссон ороо цагаан тоосных нь бүдэг үзүүрээс барьж аваад хөөж хурдлав.

Эргэлийн цэнхэр орчлонгийн эхлэл төгсгөлгүй цагаан замаар мөргөлийн өргөлтэй хүмүүний мөнхийн амьдрал тасралтгүй үргэлжилнэ.

Table of Contents

[Ном дор мөргөмүй](#)

[Нэг](#)

[Хоёр](#)

[Гурав](#)

[Дөрөв](#)

[Тав](#)

[Зургаа](#)

[Долоо](#)

[Найм](#)

[Ес](#)

[Арав](#)

[Арван нэг](#)

[Арван хоёр](#)

[Арван гурав](#)

[Арван дөрөв](#)

[Арван тав](#)

[Арван зургаа](#)

[Арван долоо](#)

[Арван найм](#)

[Арван ес](#)

[Хорь](#)

[Хорин нэг](#)

[Хорин хоёр](#)

[Хорин гурав](#)

[Хорин дөрөв](#)

[Хорин тав](#)

[Хорин зургаа](#)

[Хорин долоо](#)

[Хорин найм](#)

[Хорин ес](#)

[Гуч](#)

[Гучин нэг](#)

[Гучин хоёр](#)

[Гучин гурав](#)

[Гучин дөрөв](#)

[Гучин тав](#)

[Гучин зургаа](#)

[Гучин долоо](#)

[Гучин найм](#)

[Гучин ес](#)